Дэлхийн худалдааны байгууллагын гишүүний хувьд гишүүн бусад орнуудтай хэлэлцээ хийх эрх эдэлдэг бөгөөд манай улсын хувьд ОХУ-тай хэд хэдэн удаа хоёр талын хэлэлцээр хийсэн бөгөөд 2 улсын хоорондын худалдааны саад бэрхшээлийг багасгах боломж бүрдэж байгаа юм. Монголоос ОХУ руу экспортлогдох ХАА-н бүтээгдэхүүний татвар дундаж татвар 22 хувь, ХАА-н бус бүтээгдэхүүний татвар 13 хувь байдаг[16]. Тухайлбал, нэхмэл хувцас 25 хувь, бусад хувцас 26 хувь, хивс 23 хувь, бусад сүлжмэл бараа 23 хувь, гутал 33 хувь, арьсан бүтээгдэхүүн 38 хувь байна.

Монгол улсаас ОХУ руу экспортолдог гол бүтээгдэхүүний нэг бол мах, махан бүтээгдэхүүн юм. ЗХУ Монголоос жилд дунджаар 60 мянган тонн мах импортолдог байжээ. 1990 оноос хойш ОХУ-д экспортлох зөвшөөрлийг 14 үйлдвэр авсан байдаг. ОХУ-д мах экспортлоход хоёр том бэрхшээл учирдаг.

1. Тарифын квот. ОХУ махны импортод тарифын дараах квотыг ашигладаг. Квотын дотор ад валорем зарчмаар буюу барааны үнийн дүнд 15 хувь ноогдуулдаг ба квотоос давсан хэмжээнд 30 хувь болгон өсгөн ноогдуулдаг. Монголоос импортолж байгаа махны квотоос давсан хэмжээнд ноогдох импортын татвар өндөр хэвээр байна. ОХУ-ын Засгийн газрын 2008 оны 1 сарын 19-ний 13-р тогтоолоор импортын квотоос давсан хэмжээний гахай болон тахианы маханд өндөр хураамж тогтоож, үхрийн махны хэмжээг бууруулсан байна. Үхрийн махны бүх төрлийн квотоос давсан импортын татвар нь 2008 оны шинэ махны хувьд 45 хувиас 30 хувь хүртэл /нэг кг-д 0.6 еврогоос доошгүй байх/, хөлдөөсөн махны хувьд 50 хувиас /нэг кг-д 0.5 еврогоос доошгүй байх/ 30 хүртэл /нэг кг-д 0.3 еврогоос доошгүй байх/ тус тус буурчээ.
2. ОХУ-ын Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын албанаас импортын маханд тавьдаг шаардлагууд хатуу чанга байна. 2003 онд гарсан малын шүлхий, 2002 онд гарсан малын өвчний улмаас зарим нэгэн махан бүтээгдэхүүн болон хонины махны импортыг ОХУ зогсоосон байна.

UILMN СУДАЛГААНЫ САН

[16] - "Монгол улсын худалдааны бодлого ба хүний хөгжил" – 2008 он

ОХУ-ын махны хэрэглээ жилээс жилд нэмэгдэж байна. 2007 оны эхний 9 сарын импорт 3.48 тэрбум ам.долларт хүрсэн бол энэ хэмжээ жилийн өмнө 2.84 тэрбум байжээ. Иймээс манай улс өөрийн зүгээс шалтгаалах мах, махан бүтээгдэхүүний чанар болон аюулгүйн стандартыг дээшлүүлэх шаардлага тулгарч байна.







**4.4 Монгол улс ба Европын холбоо**

1993 онд Худалдаа болон хамтын ажиллагааны гэрээ байгуулагдан хүчин төгөлдөр болсноор Монгол Улс болон Европын Холбооны /ЕХ/ хамтын ажиллагаа эхэлсэн. Түүнээс хойш ТАСИС хөтөлбөрийн хүрээнд Европын Коммисын хөгжлийн тусламжаар 60 гаруй сая еврогийн тусламжийг Монгол Улсад үзүүлээд байгаа бөгөөд 2004 оноос эхлэн ЕХ-ны АЛА хөтөлбөрт хамрагдаж эхлээд байна. 1997 онд Монгол Улс Европын Хөрөнгө Оруулалтын Банктай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан ба 2000 онд Европын Сэргээн босголт, хөгжлийн банкны гишүүн болсон. 2000 оноос эхлэн ЕХ-ны тусламжийн хамтын ажиллагаа хөдөөгийн хөгжилд түлхүү чиглэж эхэлсэн. 2004 оноос ЕХ-оос хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны төслийг хариуцах ажлыг Брюксель хот дахь Европын Комиссын төвөөс Бээжин дахь дипломат төлөөлөгчийн газарт шилжүүлсэн. Үүнээс хойш Бээжин дахь ЕХ-ны төлөөлөгчийн газар Монгол Улсад хэрэгжиж буй болон ирээдүйд хэрэгжих төслүүдэд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. “GSP+” буюу Ерөнхий хөнгөлөлтийн систем

UIH.MN

Монгол улс Европын Холбооны ерөнхий хөнгөлөлтийн системд /GSP, General System of Preferences/ 1991 оноос, харин шинэ “GSP+” хөнгөлөлтийн системд 2006 оноос хамрагдаж эхэлсэн. Энэ хөнгөлөлтөнд Монгол улс эхний ээлжинд 2006-2008 оны хооронд, улмаар 2015 он хүртэл хамрагдах төлөвлөгөөтэй байна. Монгол улс энэ хөнгөлөлтөнд хамрагдсанаар олон нэр төрлийн бараагаа гаалийн татваргүй, квотгүй Европын зах зээлд нийлүүлэх эрхтэй болсон. ЕХ-ны хөнгөлөлтийн системийн боломжийг ашиглахын тулд манай үйлдвэр, компани, аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнийхээ чанарыг тус холбооны стандартын шаардлагад нийцүүлж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх хэрэгтэй юм.

ЕХ, 1971 оноос эхлэн дэлхийн хөгжиж байгаа 176 орнуудад худалдааны хөнгөлөлт, өөрөөр хэлбэл импортын тарифын хөнгөлөлтийг дангаараа олгох систем “GSP”-г хэрэглэж байна. ЕХ жижиг, эмзэг эдийн засагтай, далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын худалдаанд учирч байгаа бэрхшээлийг онцлон авч үзэж, хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг дэмжих чиглэлээр худалдааны бодлого явуулж байна.

Тус холбоо нь GSP-г 10 жил тутам хянан шинэчилж, импортын тарифыг тууштай бууруулах бодлого баримталдаг бөгөөд GSP-г хэрэгжүүлэх тодорхой журам, хөнгөлөлтийн схемийг гурав жил тутам гаргадаг.

Хамгийн сүүлд ЕХ, 2005 оны 6 дугаар сарын 27-нд 2006-2008 онд мөрдөх тарифын хөнгөлөлтийн шинэ журмаа баталсан. Энэхүү шинэ журмаар “сайн засаглал, тогтвортой хөгжлийн” болзлыг хангасан эмзэг эдийн засагтай орныг GSP-д хамрагдсан 7200 нэр төрлийн барааны гаалийн татвараас чөлөөлөх шинэ хөнгөлөлт /GSP+/ бий болгожээ. Энэхүү хөнгөлөлтөнд оёмол, сүлжмэл бүх төрлийн бүтээгдэхүүн, арьс шир болон ихэнхи арьс ширэн бүтээгдэхүүн, үслэг эдлэл, мал амьтны гаралтай ноос, ноолуур, ундаа, архи, модон эдлэл, электрон бараа, гутал, хивс, зэс зэсэн бүтээгдэхүүн, төмөр, төмөрөн бүтээгдэхүүн зэрэг манай улсад ач холбогдол бүхий бараа, бүтээгдэхүүн хамрагдаж байна.

Энэхүү хөнгөлөлтөнд хамрагдахын тулд хүний эрх, хөдөлмөрийн эрхийн тухай НҮБ, ОУХБ-ын 16 конвенци, байгаль орчин, засаглалын зарчимтай холбоотой 11 Конвенцийн 7-оос доошгүйд нь нэгдэн орсон байх шалгууртай. Манай улс энэ шалгуурт заасан 27 конвенцэд бүгдэд нь нэгдэн орсон.

ЕХ нь хөгжиж байгаа орнуудаас 14 оронд GSP+ хөнгөлөлт олгохоор шийдвэрлэсний дотор Азийн бүс нутгаас Монгол болон Шри Ланка Улс, ТУХН-ийн орнуудаас Гүрж Улс багтаж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН







**Тав: Дүгнэлт**

Манай улсын экспортын бүтцээс харахад экспорт төрөлжөөгүй, цөөн тооны бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа нь гадаад худалдааны бодлогын тулгамдсан асуудлуудын нэг хэвээр байсаар байна. Иймд, гадаад худалдааны бодлогын стандарт хэрэгслүүдийг ашиглан экспортын бүтцийг өөрчилж, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, экспортод нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний хувийг нэмэгдүүлэх, улмаар экспортыг нэмэгдүүлж гадаад худалдааны тэнцлийн үзүүлэлтүүдийг сайжруулж, эдийн засгийн өсөлтийг бий болгох шаардлага тулгарч байна.

Монгол улсын экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлээд зогсохгүй аль болох удаан хугацаанд олон улсад тогтвортой байр сууриа хадгалж үлдэх зорилгоор экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь тулгамдсан асуудал болж байна. Гадаад худалдаа хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагуудын ажил үүргийн уялдаа холбоог хангуулах, гадаад худалдааны зохицуулалтын механизмуудын үр ашигт дүн шинжилгээ хийх, илүү боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Үйлдвэрлэгч бүр экспортлогч болох боломж бүхий таатай орчинг бий болгосноор экспортыг урамшуулж, гадаад худалдааны тэнцэлийг хангахад ач холбогдолтой алхам болох юм. Гадаад худалдааны үр өгөөжийг дээшлүүлэхэд хамгийн гол анхаарах асуудал бол түүнийг зохицуулж буй механизмуудыг илүү боловсронгуй болгох асуудал юм гэдгийг дээр дурьдсан. Үүнийг дэлгэрүүлбэл юуны өмнө тарифын зохицуулалтын асуудлыг хөндөх

шаардлагатай болно.

Гадаад худалдааны бодлогын хэрэгслүүдийг боловсронгуй болгохын тулд эхний ээлжинд худалдааны процедуруудыг хялбаршуулах шаардлагатай байна. Орчин үеийн дэлхийн худалдааны системд 600 гаруй бичиг баримт мөрдөгдөж байдаг. Эдгээрт бараа бүтээгдэхүүнтэй холбоотой бичиг баримтууд, тээврийн бичиг баримтууд, төлбөр тооцоо болон тухайн бараа бүтээгдэхүүний үүсэл гарал, үнэ өртөг, чанар болон бусад шинж чанарыг илэрхийлсэн бичиг баримтууд ордог. Дэлхийн практикт бичиг баримтыг түргэн шуурхай боловсруулахад цахим техникийг өргөн ашиглаж байна.

Ãàäààä õóäàëäààíû õóóëü, ýðõ ç¿éí íºõöëèéã ñàéæðóóëàõ, óëñ îðíû ýäèéí çàñàã, áèçíåñèéí õºãæèëòýé óÿëäóóëàí ãàäààä õóäàëäààíû öàõèì íýãòîíõîíû ¿éë àæèëëàãààã òºð-õóâèéí õýâøëèéí ò¿íøëýëèéí çàì ààð õýðýãæ¿¿ëýõ ¿éë ÿâöûã ò¿ðãýòãýõ арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Ìàíàé óëñûí õóâüä Äýëõèéí õóäàëäààíû áàéãóóëëàãàä 1997 îíä ýëññýí ýýñ õîéø Ìîíãîë Óëñ îëîí òàëò õóäàëäààíû òîãòîëöîîíû ãèø¿¿íèé õóâüä àìëàëòàà áèåë¿¿ëýõ áîëîìæèéã á¿ðä¿¿ëýõèéí òóëä õóäàëäàà, õóäàëäààíû áîäëîãî, õºðºíãº îðóóëàëòòàé õîëáîîòîé èõýíõи õóóëèéä íýìýëò, ººð÷ëºëò îðóóëàõ çàìààð øèíý÷ëýõ áîëîí øèíýýð áîëîâñðóóëñààð èðñýí.

Ãýâ÷ õóäàëäààíû áîäëîãîòîé õîëáîîòîé õóóëü õîîðîíäûí óÿëäàà õîëáîî ñóë áºãºä, õóäàëäààíû àñóóäëûã çîõèöóóëñàí íýãòгэñýí õóóëü òîãòîîìæ, õóäàëäààíû áîäëîãî áàéõã¿é áàéíà.

×ºëººò á¿ñèéí õóóëèéí òàëààð:

- ×ºëººò á¿ñ äýõ òàòâàð, ãààëü, âàëþòûí òóñãàé æóðìûí òàëààð õóóëüä äóðüäñàí áîëîâ÷ ÷ºëººò á¿ñ äýõ òàòâàðûí õºíãºëºëò¿¿äèéã íàðèéâ÷ëàí çààæ ºãºã¿é áàéíà.[17]
- ×ºëººò á¿ñèéí õºãæèëä äýìæëýã ¿ç¿¿ëýõ, õºðºíãº îðóóëàã÷äûí ýðõ àøèãèéã õàìãààëàõ ¿¿äíýýñ Á¿ñèéí õºðºíãº îðóóëàã÷äûí çºâëºë áàéãóóëæ áîëîõ òàëààð çîõèöóóëñàí áîëîâ÷ óã çºâëºëèéí ã¿éöýòãýõ ¿¿ðýã, íèéãýì ä ¿ç¿¿ëýõ ðîëèéí õóâaaðиëàëòûã õóóëèíä íàðèéâ÷àí òóñãààã¿é.[18]
- ×ºëººò á¿ñ íü áèå äààñàí òºñºâòýé áàéõ õóóëüä òóñãàæýý. Ãýâ÷ òºñâèéí õºðºíãèéã ÷ºëººò á¿ñèéã õºãæ¿¿ëýõýä àøèãëàæ áîëîõ ýñýõèéã çààãààã¿é, çàñãèéí ãàçðààñ þóã ñàí õ¿¿æ¿¿ëýõ áà ýñ ñàí õ¿¿æ¿¿ëýõèéã òîäîðõîé çîõèöóóëàëò áàéõã¿é.[19]

**ЗУРГАА: ÕÀÂÑÐÀËÒ**

**Õàâñðàëò À. Ãàäààä õóäàëäààíû ýðõ ç¿éí çîõèöóóëàëòàíä õàìààðàõ ýðõ ç¿éí àêò**

***A/ Ìîíãîë Óëñûí õóóëü:***

1. Ìîíãîë Óëñûí ¯íäñýí Õóóëü - 1992 îí
2. Ìîíãîë Óëñûí Èðãýíèé õóóëü - 2002 îí
3. Àâòîòýýâðèéí áîëîí ººðºº ÿâàã÷ õýðýãñëèéí àëáàí òàòâàðûí òóõàé – 1992 îí
4. Àâòî áåíçèí, äèçåëèéí ò¿ëøíèé àëáàí òàòâàðûí òóõàé – 1995 îí
5. Àæàõóéí íýãæèéí îðëîãûí àëáàí òàòâàðûí òóõàé – 2006 îí
6. Àæàõóéí ¿éë àæèëëàãààíû òóñãàé çºâøººðëèéí òóõàé – 2001 îí
7. Àëòàí áóëàã õóäàëäààíû ÷ºëººò á¿ñèéí ýðõ ç¿éí áàéäëûí òóõàé – 2002 îí

[17] “×ºëººò á¿ñèéí òóõàé” õóóëèéí 4 ä¿ãýýð ç¿éë
[18] “×ºëººò á¿ñèéí òóõàé” õóóëèéí 9 ä¿ãýýð ç¿éë
[19] “×ºëººò á¿ñèéí òóõàé” õóóëèéí 11 ä¿ãýýð ç¿éë

UIH.MN СУДАЛГААНЫ САН

8. Àì üòàí , óðãàì àë, òÿäãýÿðèéí ãàðàëòàé ò¿¿õèé ýä, á¿òýýãäýõ¿¿í èéã óëñûí õèëýýð íýâòð¿¿ëýõ ¿åèéí õî ðèî öýýðèéí õÿíàëò, øàëãàëòûí òóõàé – 2002 îí
9. Àðáèòðûí òóõàé õóóëü - 2003 îí
10. Áàðààíû òýìäýã, ãàçàð ç¿éí çààëòûí òóõàé – 2003 îí
11. Âàëþòûí çîõèöóóëàëòûí òóõàé – 1994 îí
12. Ãààëèéí òàðèô, ãààëèéí òàòâàðûí òóõàé – 2008 îí
13. Ãààëèéí òóõàé – 2008 îí
14. Ãàäààäûí õºðºíãº îðóóëàëòûí òóõàé – 1993 îí
15. Ãàçðûí òîñíû á¿òýýãäýõ¿¿íèé òóõàé – 2005 îí
16. Ãàçðûí òîñíû òóõàé – 1991 îí
17. Äàìïóóðëûí òóõàé - 1997 îí
18. Æèæèã, äóíä ¿éëäâýðèéí òóõàé – 2007 îí
19. Çàìûí-¯¿ä ýäèéí çàñãèéí ÷ºëººò á¿ñèéí ýðõ ç¿éí áàéäëûí òóõàé – 2003 îí
20. Çàð ñóðòàë÷èëãààíû òóõàé – 2002 îí
21. Çàðèì íèéëýãõ¿¿ëñíèé óóòíû õýðýãëýýãõîî ðèãëîõ òóõàé – 2009 îí
22. Íýìýãäñýí ºðòãèéí àëáàí òàòâàðûí òóõàé – 2006 îí
23. Îíöãîé àëáàí òàòâàðûí òóõàé – 2006 îí
24. Îíöãîé àëáàí òàòâàðûí òýìäãèéí òóõàé – 2000 îí
25. Òàòâàðûí åðºíõèé õóóëü – 2008 îí
26. Òºëáºð òîîöîîã ¿íäñýí ìºíãºí òýìäãýýð ã¿éöýòãýõ òóõàé – 2009 îí
27. Öàãààí óóð õóäàëäààíû ÷ºëººò á¿ñèéí ýðõ ç¿éí áàéäëûí òóõàé – 2003 îí
28. Øóäàðãà áóñ ºðñºëäººíèéã õÿçãààðëàõ òóõàé – 2000 îí
29. ×ºëººò á¿ñèéí òóõàé – 2002 îí

***Á/ Óëñûí Èõ Õóðëûí òîãòîîë***

1. 2002 îíû 38 òîîò òîãòîîë "Àëòàí áóëàã õóäàëäààíû ÷ºëººò á¿ñ áàéãóóëàõ òóõàé"
2. 2003 îíû 15 òîîò òîãòîîë "Àëòàí áóëàã õóäàëäààíû ÷ºëººò á¿ñèéí õèëèéí çààãèéã ººð÷ëºí áàòëàõ òóõàé"
3. 1996 îíû 71 òîîò òîãòîîë "Äýëõèéí õóäàëäààíû áàéãóóëëàãàä ãèø¿¿íýýð ýëññýí òýé õîëáîãäóóëàí àâàõ àðãà õýìжýýíèé òóõàé"
4. 2003 îíû 34 òîîò òîãòîîë "Çàìûí-¯¿ä ýäèéí çàñãèéí ÷ºëººò á¿ñ áàéãóóëàõòàé õîëáîãäóóëàí àâàõ àðãà õýìжýýíèé òóõàé"
5. 2004 îíû 17 òîîò òîãòîîë "Çàìûí-¯¿ä ýäèéí çàñãèéí ÷ºëººò á¿ñ áàéãóóëàõ òóõàé"
6. 1999 îíû 27 òîîò òîãòîîë "Èìïîðòûí áàðààíû ãààëèéí àëáàí òàòâàðûí õóâü, õýìжýý áàòëàõ òóõàé"
7. 1995 îíû 87 òîîò òîãòîîë "Ìîíãîë Óëñàä ýäèéí çàñãèéí ÷ºëººò á¿ñ áàéãóóëàõ ¿çýë áàðèì òëàëûí òóõàé"
8. 2009 îíû 79 òîîò òîãòîîë "Ìîíãîë Óëñûí ýäèéí çàñàã, íèéãìèéí 2010 îíä õºãæ¿¿ëýõ ¿íäñýí ÷èãëýë áàòëàõ òóõàé"
9. 2009 îíû 64 òîîò òîãòîîë "Òºð, õóâèéí õýâøëèéí òϿíøëýëèéí òàëààð òºðººñ áàðèì òëàõ áîäëîãî"

***Â/ Çàñãèéí ãàçðûí òîãòîîë***

1. 2009 îíû 88 òîîò òîãòîîë "Áàðààíû ãàðàë ¿¿ñëèéí ä¿ðýì áàòëàõ òóõàé"
2. 2009 îíû 91 òîîò òîãòîîë "Ãààëèéí òàðèôûí ç¿âëºëèéí ä¿ðýì áàòëàõ òóõàé"
3. 2006 îíû 251 òîîò òîãòîîë "Ãàäààä õóäàëäààíû íýãäñýí öàõèì ¿éë÷èëãýýíèé òóõàé"
4. 2002 îíû 219 òîîò òîãòîîë Æàãñààëò, æóðàì øèíý÷ëýí áàòëàõ òóõàé "Óëñûí õèëýýð ëèöåíçòýé íýâòð¿¿ëýõ ëîëîíñîí áàðààíû æàãñààëò"

UIH.MN СУДАЛГААНЫ САН

5. 2003 îíû 173 òîîò òîãòîîë Æàãñààëò áàòëàõ òóõàé “Óðãàì ëûí ¿ð, ¿ðñëýã, ñóóëãàö, àìüòàí, ò¿¿íèé ¿ð õºâðºë, ¿ð, ò¿¿õèé ìàõ, äàéâàð á¿òýýãäýõ¿¿í áîëîí áè÷èë áèåòíèé өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт”, “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам”, “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”
6. 2005 îíû 214 òîîò òîãòîîë Æóðàì áàòëàõ òóõàé "Аж ахуйн нэгжийн давамгай болон зүй ёсны монополь байдалтай, түүнчлэн давамгай байдлаа алдсаныг тогтоох журам"
7. 2008 îíû 170 òîîò òîãòîîë Æóðàì áàòëàõ òóõàé “Улсын хилээр нэвтрүүлэх байлдааны зориулалттай хэрэгсэл, техникт экспорт, импортын лиценз олгох журам”
8. 2009 îíû 43 òîîò òîãòîîë Æóðàì áàòëàõ òóõàé “Àëòàí áóëàã ÷ºëººò бүсэд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, оршин суух журам”
9. 2009 îíû 89 òîîò òîãòîîë Æóðàì áàòëàõ òóõàé “Гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргах журам"
10. 1999 îíû 104 òîîò òîãòîîë Æóðàì áàòëàõ òóõàé “Озон задалдаг бодисыг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгох журам”
11. 2001 îíû 63 òîîò òîãòîîë Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох аргачлал áàòëàõ òóõàé
12. 1997 îíû 121 òîîò òîãòîîë “Èìïîðòûí çàðèì íýðèéí áàðààíû ¿íäýñíèé êîäûã áàòàëæ, ìºðä¿¿ëýõ òóõàé”
13. 2009 îíû 324 òîîò òîãòîîë “Ìîíãîë Óëñûí Ãààëèéí õàðèëöààã ýäèéí çàñàãæóóëàõ õºòºëáºð” áàòëàõ òóõàé
14. 2009 îíû 87 òîîò òîãòîîë “Íýí òààëàì æóðàé òàðèô õýðýãëýõ óëñûí æàãñààëò áàòëàõ òóõàé”
15. 2008 îíû 32 òîîò òîãòîîë “Îðëîãûí õóâü õýìæýýã òîãòîîõ òóõàé”
16. 2008 îíû 365 òîîò òîãòîîë “ISO 9000 ñòàíäàðò õýðýãæ¿¿ëýõ òºëºâëºãºº áàòëàõ òóõàé”
17. 2001 îíû 54 òîîò òîãòîîë “Óëñûí õèëýýð íýâòð¿¿ëýõèéã õîðèãëîñîí áîëîí ëèöåíçòýé íýâòð¿¿ëýõ áàðààíû êîäëîñîí æàãñààëò, æóðàì áàòëàõ òóõàé”
18. 2010 îíû 22 òîîò òîãòîîë “Óðãàìëûí ¿ð, ¿ðñëýã, ñóóëãàö íýâòð¿¿ëýõ, ¿ðæëèéí ìàë, ò¿¿õèé ìàõ, äàéâàð á¿òýýãäýõ¿¿í ýêñïîðòëîõ áîëîìæòîé òóõàé”
19. 2002 îíû 212 òîîò òîãòîîë “Õèëèéí áîîìòóóäûí òàëààð áàðèìòëàõ ¿éë àæèëëàãààíû ÷èãëýë áàòëàõ òóõàé”
20. 2002 îíû 108 òîîò çàõèðàìæ “Õèëèéí áîîìòûí òàëààð àâàõ àðãà õýìæýýíèé òóõàé”
21. 2006 îíû 264 òîîò òîãòîîë “Íýã öýãèéí ¿éë÷èëãýýã áàéãóóëàõ äóíä õóãàöààíû õºòºëáºð áàòëàõ òóõàé”
22. 2007 îíû 3 òîîò òîãòîîë “Íýã öýãèéí ¿éë÷èëãýýã íýâòð¿¿ëýõ òàëààð àâàõ çàðèì àðãà õýìæýýíèé òóõàé”
23. 1995 îíû 210 òîîò òîãòîîë “Õóäàëäàà, ¿éëäâýð, ¿éë÷èëãýýíèé óëñûí õýíàëòûí ä¿ðýì áàòëàõ òóõàé”
24. 2007 îíû 131 òîîò òîãòîîë “Ãààëèéí õóäàëäààã õºíãºâ÷ëºõ öàõèì íýã öîíõ” õºòºëáºð áàòëàõ òóõàé
25. 2009 îíû 37 òîîò òîãòîîë “×ºëººò á¿ñèéí çºâëºë áàéãóóëàõ òóõàé”

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Õàâñðàëò Á. Ìîíãîë óëñûí íýãäýí îðñîí ãààààä õóäàëäààòàé õîëáîîòîé Îëîí Óëñûí îëîí òàëò ãýðýý**

| ¹ | Ãýðýýíèé íýð | Áàéãóóëñàí îí | Íýãäýí îðñîí îí |
|---|---|---|---|
| 1. | Äàëàéí ãàðöàã¿é îðíû òðàíçèò õóäàëäààíû òóõàé Íüþ-Éîðêèéí êîíâåíö | 1965 | 1966 |
| 2. | Îëîí Óëñûí áàðàà õóäàëäààíä õººí õýëýëöýõ õóãàöààíû òóõàé êîíâåíö | 1974 | 1974 |
| 3. | Îëîí Óëñûí áàðàà õóäàëäààõ, õóäàëäààí àâàõ òóõàé Âåíèéí êîíâåíö | 1980 | 1997 |
| 4. | Îëîí Óëñûí õºðºíãº îðóóëàëòûã áàòàëãààæóóëàõ áàéãóóëëàãûí êîíâåíö | 1985 | 1997 |
| 5. | Äýëõèéí õóäàëäààíû áàéãóóëëàãà áàéãóóëàõ òóõàé Ìàððàêåøèéí êîíâåíö | 1994 | 1997 |
| 6. | Ãààëèéí õàìòûí àæèëëàãààíû õîëáîîíû òóõàé Áðþññåëèéí êîíâåíö | 1953 | 1992 |
| 7. | Áàðààã òîäîðõîéëîõ, êîäëîõ, óÿëäóóëñàí ñèñòåìèéí òóõàé Áðþññåëèéí êîíâåíö | 1988 | 1993 |
| 8. | Ãààëèéí àðáèòðûí øèéäâýðèéã õ¿ëýýí çºâøººð÷ õýðýãæ¿¿ëýõ òóõàé êîíâåíö | 1958 | 1994 |

**Долоо: Ашигласан материалын жагсаалт**


1. Ìîíãîë Óëñûí ¯íäñýí Õóóëü - 1992 îí
2. Ìîíãîë Óëñûí Èðãýíèé õóóëü - 2002 îí
3. Àæàõóéí ¿éë àæèëëàãààíû òóñãàé çºâøººðëèéí òóõàé – 2001 îí
4. Ãààëèéí òàðèô, ãààëèéí òàòâàðûí òóõàé – 2008 îí
5. Ãààëèéí òóõàé – 2008 îí
6. Çàìûí-¯¿ä ýäèéí çàñãèéí ÷ºëººò á¿ñèéí ýðõ ç¿éí áàéäëûí òóõàé – 2003 îí
7. Íýìýãäñýí ºðòãèéí àëáàí òàòâàðûí òóõàé – 2006 îí
8. Îíöãîé àëáàí òàòâàðûí òóõàé – 2006 îí
9. Îíöãîé àëáàí òàòâàðûí òýì äãèéí òóõàé – 2000 îí
10. Òàòâàðûí åðºíõèé õóóëü – 2008 îí
11. Öàãààíóóð õóäàëäààíû ÷ºëººò á¿ñèéí ýðõ ç¿éí áàéäëûí òóõàé – 2003 îí
12. ×ºëººò á¿ñèéí òóõàé – 2002 îí
13. http://www.mongolchamber.mn – Ìîíãîëûí ¯íäýñíèé Õóäàëäàà Àæ ¯éëäâýðèéí Òàíõèì
14. http://www.mta.mn – ¯ндэсний татварын ерөнхий газар
15. www.legalinfo.mn – Ýðõ ç¿éí ñèñòåìèéí íýãäñýí ñ¿ëæýý
16. www.ecustoms.mn- Ãààëèéí Åðºíõèé ãàçàð
17. Äýëõèéí õóäàëäààíû áàéãóóëëàãûí ýðõ ç¿éí çàðèì àñóóäàë 2000 îí Ã.Ñýñýýð
18. Äýëõèéí õóäàëäààíû áàéãóóëëàãà àäõü Ìîíãîë Óëñ /Áàðèìò áè÷ã¿¿äèéí ýìõòãýë/ 1999 îí
19. Îëîí Óëñûí àðèëæààíû àðáèòð áà Îëîí Óëñûí õóäàëäààíû õîëáîîãîîëòîé ýðõ ç¿éí àêòûí ýìõòãýë 2006 îí Ìîíãîëûí ¯íäýñíèé Àðáèòð, Õóóëü Ç¿éí ¿íäýñíèé òº â
20. Ãàäààä Õóäàëäààíû èæèë¿ðýíí ãàðûí àâëàãà 2005 îí Ì¯ÕÀ¯Ò
21. Ãààëèéí õýíàëò, øàëãàëòûí ¿éë àæèëëàãààíä ìºðäºãäºæ áóé ýðõ ç¿éí áàðèì ò áè÷ãèéí ýìõòãýë 2002 îí Ãààëèéí Åðºíõèé Ãàçàð


UIH.MN СУДАЛГААНЫ САН

22. Ì Ó-ûí õóäàëäààíû ÷º ëºº ò á¿ñ õº òº ëáº ðèéí ¿í ýëãýý, ÷º ëºº ò á¿ñèéí áàéäàëòàé òàí èëöñàí ä¿í øèí æèëãýý /Ýäèéí çàñãèéí áî äëî ãûí øèí ýòãýë, º ðñº ëäº õ ÷àäâàðûí ðº ñº ë/
23. YСХороо
24. “Монгол Улсын худалдааны бодлого ба хүний хөгжил”-2008 он.
25. “Олон улс судлал” сэтгүүл
26. Алтны санхүүжилтын зөвлөгөөн 2009 он
27. “МУ-ын валютын зах зээлийн зохицуулалтын тулгамдсан асуудлууд” – судалгаа, УИХ-ын Судалгааны төв
28. БНХАУ, Монгол улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр
29. Дэлхийн Худалдааны Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газар, “Монгол улсын худалдааны бодлогыг хянан үзэх” нь илтгэл, 2005 он
30. Монгол Улсын Гадаад Харилцааны Яам, НҮБ, “Монгол Улсын худалдааны бодлого ба хүний хөгжил” илтгэл, 2008 он
31. Далайд гарцгүй хөгжиж буй болон дамжин өнгөрүүлэгч орнуудын (ДГХБО) “Худалдаа ба худалдааг хөнгөвчлөх” сэдэвт ДГХБО-ын сайд нарын бага хурлаас гаргасан “Улаанбаатарын тунхаглал”
32. Монгол Улсын Хууль Зүй Дотоод Хэргийн Яам, Японы Жайка-гийн Хуулийн шинэчлэлт төсөл, “Худалдааны эрх зүй” Монгол улс дахь өнөөгийн байдал, бусад орны туршлага-уулзалт семинарын материал
33. МУ-ын Засгийн Газар, Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр, 2009 он
34. Монгол Улсын Засгийн Газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр
35. World Trade Organization, “World Trade Report 2009”
36. World Trade Organization, Trade Policy Review, report by Jordan, 2008


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

*/Харьцуулсан судалгаа/*

*Г.Билгээ*

## Оршил

УИХ-ын Нутгийн удирдлагын дэд хорооны дарга Д.Загджавын захиалгаар “Гадаадын зарим улсын орон нутгийн татварын бие даасан хуулиудад хийсэн харьцуулсан судалгаа” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

***Судалгааны зорилго***

Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл шинжтэй зарим улсын орон нутгийн татварын харилцааг зохицуулж буй бие даасан хуулиудыг харьцуулан судлахад судалгааны зорилго оршино.

***Судалгааны арга зүй***

Интернэтээс хайлт хийж цуглуулсан эрх зүйн баримт бичиг, мэдээллийг шинжилж, харьцуулсан дүгнэлт гаргасан.

***Судалгааны хамрах хүрээ***

Дэлхийн улс орнуудыг төрийн байгууламжийн хувьд Холбооны улс, Нэгдмэл улс гэсэн хоёр хэлбэрт ангилан авч үздэг. Төрийн байгууламжийн аль ч хэлбэр нь тухайн улсын хүн ам, үндэстэн, ястны бүтэц, тархалт, шашин, хэл, соёл, зан заншлийн онцлог, төрт ёсны уламжлал зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж Үндсэн хуулийнхаа хүрээнд шийдвэрлэдэг асуудал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлийн 1-д “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна” хэмээн хуульчлан тогтоосон. Харин Нэгдмэл улсын нутаг дэвсгэрийн засаг захиргаанд нь эрх зүйн хэм хэмжээг бие даан дангаараа тогтоох бүрэн эрх байдаггүй тул тэдгээр нь засаг захиргааны төв байгууллагуудад, үүний дотор татварын асуудлаар захирагддаг байна.

Дээр нь орон нутгийн татварын асуудал нь шилжилтийн улс оронд чухал ач холбогдолтой байгаа учраас дараах нэгдмэл улсуудыг сонгон тэдгээрийн орон нутгийн татварын эрх зүйн харилцааг зохицуулж байдаг бие даасан хуулиудыг судлаж үзсэн:

1. Бүгд Найрамдах Болгар Улс
2. Бүгд Найрамлах Польш Улс
3. Бүгд Найрамдах Солонгос Улс

***Судалгааны бүтэц***

Дээрхи улс орнуудын 1) орон нутгийн татварын харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн орчин; 2) Орон нутгийн татварын төрлууд; 3) зарим орны орон нутгийн хураамж зэргийг харьцуулан судалсан. Түүнчлэн Монгол Улсын орон нутгийн татварын хууль, эрх зүйн орчины талаар оруулсан.

Хавсралтад судалгаанд хамрагдсан улс орнуудын товч мэдээлэл, татварын хувь хэмжээ зэргийг багтаасан.

## Судалгааны дүгнэлт

***Хууль, эрх зүйн орчин***

Судалгаанд хамрагдсан гадаад улсын орон нутгийн татварын харилцааг

UIH.MN СУДАЛГААНЫ САН

зохицуулж байгаа бие даасан хууль нь дан ганц татвар бус төлбөр, хураамжийг ч зохицуулж өгсөн байна. Тухайлбал, Орон нутгийн татвар ба хураамжийн тухай хууль (Болгар), Орон нутгийн татвар ба төлбөрийн тухай хууль (Польш), Орон нутгийн татварын тухай хууль (Солонгос). Үндсэн хуульдаа чухалчилж орон нутгийн татварын харилцааны үндсийг нь тусгаж өгсөн байна. Мөн нутгийн удирдлагын байгууллагын харилцааг зохицуулсан хуулийг тусгайлан батлахдаа Польш улс засаг захиргааны нэгж бүрээр гурван тусдаа хуулийг баталжээ.

Монгол Улсын хувьд татвар болон нутгийн өөрөө удирдах ёсыг Үндсэн хуулиараа баталгаажуулсан. Мөн нутгийн удирдах байгууллагын харилцааг зохицуулсан *Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль* (2006), татварын харилцааг зохицуулсан Татварын багц хуулиудын зэрэгцээ төсвийн санхүүгийн харилцааг зохицуулсан *Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг* (2002) мөрдөж байна.

Монголд нутгийн засаг захиргааг өөрчлөн шинэчлэх тухай асуудал 1990-ээд оны сүүлээс эхлэн удаан хугацааны туршид өрнөсөн, дараа нь 2002 онд батлагдсан *Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн* үр дагаварын эргэн тойронд өрнөсөн. *Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар* төрийн бүх мөнгөний урсгалыг хянаж байх зорилго бүхий цахим хэлбэрийн Төрийн нэгдсэн санг ашиглалтанд оруулсан. Энэ тогтолцоо нь улсын төсвийн бүх орлого, зарлагыг эдийн засгийн төрөл, зориулалт болон байгууллага тус бүрээр кодчилсноор Төрийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих бололцоотой болсон.

***Орон нутгийн татвар***

Болгар, Польшид орон нутгийн зургаан татвар, Солонгос улсад ердийн болон тогтоосон нийт 16 татварыг хураадаг байна. Эдгээр улсад орон нутгийн татварын бүрэлдэхүүнд ***үл хөдлөх хөрөнгийн*** болон ***авто тээврийн хэрэгсэлийн*** албан татварыг оруулсан байна. Болгар улсад аль аль татварыг маш нарийн зохицуулж өгсөн байна. тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн хувь хэмжээг тогтоохдоо түүний байрлал, дэд бүтэц, ашиглалт, онцлох шинж, өндөрийн буюу давхарын хэмжээ, элэгдэл, хамрах хүрээ зэргийг тогтоож коэффициэнтээр тооцдог. (Хавсралт 5) Авто тээврийн хэрэгсэлийн татварт адилхан зарчим үйлчилдэг байна. (Хавсралт 6)

Бусад татварын хувьд улс орнууд ялгамжтай өөр өөр төрлийг оруулж өгсөн байна. Тухайлбал, Солонгос улсын орон нутгийн татварууд, тэдгээрийн хувь хэмжээг ажиглахад тус улсын амьдралын хэв маягийг тусгасан татварууд байна.

Орон нутгийн татварын харилцаа нь бие даасан хуулиар зохицуулагдаж байгаа болохоор нутгийн удирдлагын байгууллага нь татварын хувь хэмжээг эрх бүхий төв байгууллагын тогтоосон хязгаар дотор тогтоох эрхтэй бөгөөд татвараа цуглуулан орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг байна.

Орон нутгийн татвар нь төсвийнх нь хэд орчим хувийг эзэлж байдаг тухай сүүлийн үеийн мэдээлэл эх сурвалжуудад байсангүй.

Хуульд заасныар зарим татварын зарцуулалтыг зохицуулсан байна. Тухайлбал, Болгар улсын Орон нутгийн татвар ба хураамжийн тухай хуулиар аялал жуучлалын хураамжийн орлогыг тухайн орон нутгийн аялал жуулчлалыг дэмжих орон нутгийн жил бүрийн хөтөлбөрт зарцуулна гээд хэд хэдэн үйл ажиллагааг тодорхой тогтоож өгсөн байна.

Монгол Улсын хувьд орон нутгийн татварыг Татварын ерөнхий хуулиар зохицуулсан бөгөөд дараах шинжүүд агуулсан байна: 1) Төв засгийн газар улсын төсөвт томоохон татварыг төвлөрүүлдэг бөгөөд орон нутгийн татварын эзлэх хувь нь хязгаарлагдмал; 2) Хуваагдах татварт ихээхэн хэлбэлзэл бүхий орон нутгийн татварын хувь давамгайлдаг; 3) Орон нутгийн удирдах байгуулага нь хуваагдах татварт хариуцлага хүлээдэггүй; 4) Орон нутгийн татварыг ҮТЕГ-ын салбар хураадаг.

***Эцэст нь***

Судалсан эх сурвалжуудаас үзэхэд орон нутгийн татвар нь орон нутгийн төсвийг бүрдүүлэгч чухал орлого бөгөөд түүний дийлэнхи хувийг орон нутгийн татварын орлого хэлбэрээр бүрдүүлэхийг санал болгож байна.

Улс орон бүрийн хувьд орон нутгийн татварын заримыг улсын төсөвт, заримыг нь орон нутгийн төсөвт, нэг хэсгийг нь аль аль төсөвт нь хуваан төвлөрүүлэх (хуваалцах татвар) зарчмыг баримталдаг. Орлого ихээхэн хэмжээгээр төвлөрүүлдэг, улс орны нутаг дэвсгэрт ижил, хувь хэмжээгээр үйлчилдэг татварууд болох бизнесийн орлогын, гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой татваруудыг улсын төсөвт төвлөрүүлэх хандлага давамгай байна. Учир нь эдгээр татвар нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй гэж үздэг. Ялангуяа хямралтай, тогтворгүй, гамшигийн нөхцөлд эдийн засгийн онцгой ач холбогдолтой байдаг. Гэвч зарим улс оронд дээрх татварыг орон нутагтай хуваалцах байдлаар хуваарилсан байдаг.

Нутгийн удирдлагын байгууллага төсвийн эрх мэдлийг, тэр дундаа өөрсдийн гэсэн орлогыг бүрдүүлэх тогтолцоонд орохын тулд дараах асуудалд анхаарах хэрэгтэй:

- бодлогын баримт бичгийн иж бүрэн болгох,
- гол оролцогч субъектуудын оролцоог бүрэн хангах.
- зарим бодлогын асуудлыг тогтвортой байлгах, хөрвөх чадвартай байлгах.
- нутгийн удирдлагын байгууллагын эрх мэдэлд татварын ямар төрлүүдийг төвлөрүүлж байх.
- иргэдийн төлөх чадварыг тооцох.
- орон нутгийн засаг захиргаанд орлогоо бүрдүүлэх эрх мэдэл олгох.
- мониторинг, үнэлгээний тогтолцоог бий болгох.
- орон зайн гажуудлын хуваарилалтыг үр нөлөөтэй хийх.
- татварын хэмжээг тооцохдоо 1) орлогын эх үүсвэрийн төрөлжилт, 2) татварын суурийн тодорхойлолт, 3) татварын хувь хэмжээний бүтэц
- хөрөнгийн ил тод, үр ашигтай ашиглалтыг ч тооцох.
- татварын хувь хэмжээг орон нутгийн эдийн засгийн үндэслэлтэй, нийгмийн хамгааллын зардалыг уялдуулж тогтоох.
- нутгийн захиргааны байгууллагуудын хоорондын харилцааг нарийчлан зохицуулах.

*1. Орон нутгийн татвар*

Олон улсын туршлагаас үзэхэд орон нутгийн төсвийн орлого нь 1) орон нутгийн татварын орлого; 2) төлбөр, хураамж; 3) улсын төсвөөс олгох шилжүүлэг (татаас, тусламж); 4) хуваалцах орлого зэрэг эх үүсвэрүүдээс бүрддэг. Эдгээр төсвийн орлого орон нутгийн эдийн засгийн болоод улс төр, нийгмийн тодорхой үүргийг гүйцэтгэдэг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Орон нутгийн татвар бол нутгийн удирдлагын байгууллагын өөрийнх нь бүрдүүлсэн орлого. Энэ бол хамгийн энгийн ойлголт. Онолын хувьд ***орон нутгийн татвар*** нь орон нутгийн удирдлагын байгууллагаас 1) ногдуулдаг, 2) хувь хэмжээг нь тогтоодог, 3) өөрсдөө хураадаг, 4) орлого нь орон нутгийн төсөвт хуримтлагддаг байх ёстой.[20]

Гэхдээ улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг орон нутгийн татварын орлоготой андуурч болохгүй. Эдгээр татваруудыг ногдуулах, хувь хэмжээг нь тогтоох, хураалт зэргийг төв засгийн газар хариуцдаг байна. Харин орон нутгийн төсвийн орлогын нэг бүрэлдэхүүн

[20] Орон нутгийн төсвийн орлогын хуваарилалтыг зохистой хангах нь. Судалгааны тайлан. ***Нээлттэй нийгэм форум.*** 2009 он. 11 дэх тал.

болдог хуваагдах орлого буюу улсын төсвийн орлогоос тодорхой хэсгийг орон нутагт шилжүүлэх хэлбэр нь дэлхийн олон оронд түгээмэл байдаг.

| Яагаад орон нутаг өөрийн орлоготой байх ёстой вэ? |
|---|
| – төвлөрлийг сааруулах,<br>– хариуцлагыг дээшлүүлэх,<br>– орон нутгийн бие даасан байдлыг хангах,<br>– тасвийн гадуурх орлогыг бууруулах. |

Судалсан эх сурвалжуудаас үзэхэд нийгэм-улс төр, эдийн засагт орон нутгийн татвар буюу орон нутгийн орлогыг дэмжсэн хэд хэдэн баримтыг дурьдая:

- Орон нутгийн төсвийн дийлэнхи хувийг өөрсдийн санхүүгийн эх үүсвэр болох орон нутгийн татвараас бүрдүүлж байгаа нутгийн удирдлагын байгууллага нь иргэдээ дэмжиж ажиллах хариуцлага нь нэмэгдэхийн зэрэгцээ иргэдийн зүгээс тэдний үйл ажиллагаанд оролцох сонирхол нэмэгдэж, тэдэнд ойр засаглалыг бэхжүүлэх үндэс болно. Энэ нь эцсийн дүндээ орон нутгийн ардчиллыг бэхжүүлэх ба иргэдийн эрхийг хамгаална гэсэн үг.
- Татварын бодлого нь орон нутгийн сонголтонд тулгуурлана. Тухайлбал, нэг орон нутгийн иргэд нь өндөр татвар төлж, үр дүнд нь илүү чанартай үйлчилгээг хүртэж байхад өөр орон нутгийн иргэд бага татвар, доогуур чанартай үйлчилгээг илүүд үзэж болох юм.
- Өмнөх баримтуудад хэрэв орон нутаг нь өөрсдийн гэсэн өндөр орлоготой байвал улсын нэгдсэн төсөвт учруулах дарамт буурдаг тогтолцоог санал болгож байсан. Хэрэв орон нутаг нь өөрийн орлогогүй, төв засгийн газрын татаасаар санхүүжигддэг бол орон нутгийн иргэдийн зүгээс орон нутгийн үйлчилгээг илүүтэй шаардана. Энэ үед орон нутгийн засгийн газар юун түрүүнд илүү их татаас авахын тулд төв засгийн газарт дарамт үзүүлнэ.
- Санал болгож байгаа орлогын тогтолцоо нь нутгийн удирдлагын байгууллагын улс төрийн байр суурийг улсын хэмжээнд бэхжүүлнэ. Учир нь нутгийн удирдлагын байгууллага нь санхүү болон бусад тодорхой үүргийг хангадаг. Эсрэг тохиолдолд нутгийн удирдлагын байгууллага нь төвөөс эх үүсвэр шаардаж, хүлээн авдаг байнгын үйлчлүүлэгч байна.
- Орон нутаг өөрийн орлоготой байх нь нутгийн удирдлагын байгууллагын орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх сонирхол ихээхэн өснө.

Сөрөг тал нь татварын орлогод тавих төв засгийн газрын хяналт сулрах эрсдэл, мөн ялгаатай тогтоосон татвараас үүдэн өндөр хөгжилтэй болон ядуу нутгийн ялгаа нэмэгдэж болзошгүй зэрэг орон нутгийн татварын тогтолцоонд сул тал байх боловч дээрхи баримтуудаас харьцангуй цөөн.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 1.

**Татварын төвлөрсөн болон төвлөрсөн бус системд илрэх эерэг, сөрөг нөхцөл байдал**[21]

| Төвлөрсөн | | Төвлөрсөн бус | |
|---|---|---|---|
| Эерэг | Сөрөг | Эерэг | Сөрөг |

[21] Татварын бодлогын үндсэн асуудал. “Мянганы хөгжлийн зорилт-9: Төсвийн үйл явц дахь иргэний нийгмийн оролцоо” сэдэвт сургалт. МХЗ-9 төслийн баг, Удирдлагын академи. 2009.03.23.

| | | | |
|---|---|---|---|
| Эдийн засгийн нэгдсэн бодлого, зохицуулалт | Орон нутгийн нөөц бүрэн дүүрэн ашиглагдахгүй байх | Орон нутгийн нөөцийн ашиглалт | Макро зохицуулалт сулрах |
| Орон нутгаа хянах | Орон нутгийн санаачлага буурах, бэлэнчлэх | Идэвхи санаачлага өрсөлдөөн | Засгийн газрын хяналт |
| Татварын ачаалал орон нутагт жигд | Орлогын дахин хуваарилалтаас үүсэх хүнд суртал, зардал | Уян хатан | Татвар төлөгчид харилцан адилгүй татвар төлөх |
| | Орон нутгийн чанартай бодлого, зохицуулалт | Орлогоо төлөвлөх боломж | Бүс нутаг хоорондын тэгш бус байдал |
| | Зардалын хариуцлага сул | Зардалын хариуцлага өндөр | Шилжилт |
| | Үүрэг, хариуцлагын зөрчил | Орон нутгийн захиргааны шуудхай ажиллагааг нэмэгдүүлэх замаар үр ашгийг дээшлүүлэх | |
| | Тодорхой бус байдал | Иргэдийн оролцоо, ил тод байдал | |

Мөн эх сурвалжуудаас үзэхэд орон нутгийн татварт дараах хэд хэдэн шалгуурыудыг тавьдаг байна:

- ***Татварын орлогын төсөв нь үйл ажиллагааны зардалтай пропорциональ байх.*** Хэрэв орон нутгийн орлогын дийлэнхи хувь нь өөрсдийн эх үүсвэрээс бүрдүүлэхийг хүсэж байгаа бол татварын системийн түвшинд энэ боломжоор хангах хэрэгтэй. Нийт улсын хэмжээнд орон нутгийн татварын суурь нь орон нутгийн хамгийн чухал үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх зардалын ихэнхийг нь өөрсдөө цуглуулах боломжийг олгох ёстой.
- ***Газар зүйн байрлалаар татварыг тогтоох нь чухал.*** Ямар орон нутаг ямар төрлийн татварыг ногдуулж, цуглуулах вэ гэдэг нь нэг талаасаа амархан, нөгөө талаасаа төвөгтэй асуудал. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн татварын хувьд тун энгийн-бүх хөрөнгөтэй холбоотой харилцаа нь нэг эрх зүйд хамааралтай. Хувь хүний орлогын албан татварын тохиолдол ч тун энгийн-бид уг татварыг оршин суугаа газар, эсвэл ажил эрхэлж байгаа газрынхаа аль нэгд төлдөг.

Гэтэл аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувьд төвөгтэй. Зарим компани нь нэг хотод бүртгүүлсэн мөртлөө өөр хотуудад үйл ажиллагаа явуулж, орлого олдог. Аль орон нутгийн удирдлага уг компаниас татвар авах вэ гэсэн асуудал гарч ирнэ. Жишээлбэл Польш энэ асуудлыг шийдвэрлэхдээ нутгийн удирдлагын дунд татварын орлогыг нь тухайн орон нутагт ажиллаж байгаа компаний ажилчдын тоонд тэгш хуваажхуваарилсан байна.

- ***Татварын орлого нь инфляцийн эсрэг уян хатан байх.*** Энэ нь татвар бүрт чухал хамааралтай асуудал, гэхдээ орон нутгийн татварын хувьд онцгой ач холбогдолтой. Татварын хувь хэмжээг доогуур тогтоох нь нутгийн удирдлага санхүүгийн бодлогоо маш болгоомжтой, хянуур хэрэгжүүлэх шаардлагатай. Харин татварын хувь хэмжээ өндөр бол инфляцид нөлөөлснөөр улс төрийн хүндрэл үргэлж бий болдог.

Нөгөө талаар уян хатан татвар бол орон нутгийн үйл ажиллагаа буюу үүргийг хангах санхүүгийн сайн суурийг хангана.

- ***Татварын суурь нь харьцангуй тогтвортой байх.*** Эс бөгөөс татвар төлөгчид орон нутгийн хооронд хялбархан шилжилт бий болсноор хэт их татварын өрсөлдөөн бий болох магадлалтай.
- ***Орон нутгийн татварын систем нь хэтэрхий олон төрөлтэй, бас төвөгтэй байх ёсгүй.*** Зарим улсад орон нутгийн татвар нь олон төрлийн жижиг татвартай байдаг боловч үнэндээ орон нутгийн төсөвт бодит орлого болж чаддаггүй. Ийм системд татвар цуглуулах өртөг нь ихэвчлэн маш үнэтэй тусдаг учир шаардлагагүй хүндрэл болон ил тод бус байдал нь орон нутгийн татварын хариуцлагын үнэлэмжийг бууруулдаг.

Европын орнуудад орон нутгийн татварын хоёр загвар байдаг. ***Нэг дэх загвар:*** үл хөдлөх хөрөнгийн татварт суурилсан орон нутгийн татварын энэ загвар Их Британи, Испани, Польшид хэрэглэдэг. ***Хоёр дахь загвар:*** орлогын албан татварт суурилсан загварыг Скандинавын орнууд, төв болон зүүн Европын зарим оронд ашиглаж байна.

## 2. МОНГОЛ УЛС

### *2.1. Орон нутгийн орлого*

Монгол Улсад аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас баталсан, Засаг даргын бүрдүүлэн, зарцуулах орон нутгийн төсөвтэй байна. Баг, хороо нь бие даасан төсөвгүй сум, дүүргийн төсвөөс санхүүждэг.

Орон нутгийн орлого нь хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, түүний хэвлий, байгалийн нөөц баялаг, орон нутгийн өмч, өмчийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос хуримтлал бий болгох албан татвар, төлбөр, хураамж авах замаар бүрдүүлдэг.

*Татварын ерөнхий хуулиар* (2008) тогтоосон төрөлд орон нутгийн албан татвар, хураамж, төлбөрүүд багтсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын татварын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болдог. Эдгээр нь зөвхөн тухайн засаг захиргааны нэгжийн төсөвт орж түүнээс санхүүжигдэх үйл ажиллагаанд зарцуулагддаг.

| | |
|---|---|
| **Албан татвар** | Хууль тогтоомжийн дагуу хувь хүн, хуулийн этгээдийн орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгө.<br>***Эх сурвалж:*** *Татварын ерөнхий хууль, 8.2.* |
| **Хураамж** | Төрийн зохих байгууллагаас хувь хүн, хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу үйлчилсэний төлөө тэднээс тухай бүр авч улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгө.<br>***Эх сурвалж:*** *Татварын ерөнхий хууль. 8.6.* |
| **Төлбөр** | Төрийн өмчийн газар, түүнчлэн газрын хэвлий, эрдэс баялаг, ой, ургамал, рашаан, усны нөөц ашиглуулсны, агаар, ус, хөрс бохирдуулсны, ан амьтан агнуулсны төлөө хувь хүн, хуулийн этгээдээс авч улс, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө.<br>***Эх сурвалж:*** *Татварын ерөнхий хууль. 8.7.* |

Монгол Улсын хууль болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас тогтоосон, тухайн засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрээс хураан орон нутгийн төсөвт тодорхой

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хугацаанд, тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулан төсөвт заавал төлөгдөх албан татвар, хураамж, төлбөрийг хэлнэ гэж нийтэд нь тодорхойлж болно.

*Татварын ерөнхий хуулийн* 7-р зүйлийн 4-т заасныаар орон нутгийн 16 төрлийн албан татвар байх бөгөөд тэдгээрийн ***хувь хэмжээг УИХ тогтооно***. Гэхдээ Засгийн газар болон аймаг, нийслэлийн ИТХ нь УИХ-аас баталсан хязгаарт багтаан зарим төрлийн татвар, төлбөр, хураамжийг тогтооно.

Мөн хуулийн 8-р зүйлд заасны дагуу ***Засгийн газар*** нь орон нутгийн татваруудаас 1) усны нөөц ашигласны төлбөр, 2) агнуурын нөөц ашигласны төлбөр, 3) газрын төлбөр, 4) ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр зэргийн хувь, хэмжээг, ***аймаг, нийслэлийн ИТХ*** нь 1) рашааны нөөц ашигласны төлбөр, 2) байгалийн ургамал ашигласны төлбөрийн хувь, хэмжээг УИХ-аас баталсан хязгаарт багтаан тогтоохоор зохицуулагддаг. (Хүснэгт 2)

Мөн *Нэгдсэн төсвийн тухай хуулийн* (2002) 10-р зүйлийн 1, 3-т заасны дагуу аймаг, нийслэлийн төсөвт 7 төрөл татварын орлого, сум дүүргийн төсөвт 12 төрөл татварын орлого тус тус төвлөрнө. (Хүснэгт 2)

Ийнхүү орон нутгийн засаг захиргааны байгууллага өөрийнхөө үйл ажиллагааг байнга тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө, санхүүгээ бүрдүүлдэг хуулиар тогтоогдсон татвар, хураамж, төлбөрийн заримыг нь дэлгэрэнгүй үзье.

Хүснэгт 2. **Орон нутгийн татварын хувь, хэмжээг тогтоох субъект**

| УИХ-аас хувь хэмжээг тогтоодог орон нутгийн татварын төрөл | Засгийн газар хувь, хэмжээг тогтоодог орон нутгийн татвар | Аймаг, нийслэлийн ИТХ хувь, хэмжээг тогтоодог орон нутгийн татвар | Орон нутгийн төсвийн татварын орлого | |
|---|---|---|---|---|
| | | | Аймаг, нийслэл | Сум дүүрэг |
| **Татварын ерөнхий хуулийн 7-8-р зүйлүүд** | | | | |
| **албан татвар:** | | | | |
| 1. хувь хүний орлогын, | | | | ✓ |
| 2. орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын, | | | | ✓ |
| 3. бууны, | | | | ✓ |
| 4. үл хөдлөх эд хөрөнгийн, | | | ✓ | |
| 5. авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн, | | | ✓ | |
| 6. хотын, | | | ✓ | |
| 7. нохойны | | | | |
| 8. өв залгамжлал, бэлэглэлийн | | | | |
| **төлбөр:** | | | | |
| 9. газрын, | ✓ | | ✓ | |
| 10. агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж; | ✓ | | | ✓ |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11. ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны, | ✓ | | | ✓ |
| 12. ус, рашааны нөөц ашигласны, | ✓ | ✓ | | ✓ |
| 13. байгалийн ургамал ашигласны, | | ✓ | | ✓ |
| 14. түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны, | | | | ✓ |
| **хураамж:** | | | | |
| 15. ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн, | | | | ✓ |
| 16. улсын тэмдэгтийн хураамж. | | | | ✓ |
| **Нэгдсэн төсвийн хуулийн 10-р зүйлийн 10.1, 10.3 дахь заалт** | | | | |
| 17. ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 20%, | | | ✓ | |
| 18. ашигт малтмалын хайгуулын болон ашиг-лалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25%, | | | ✓ | |
| 19. цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох албан татвар, | | | ✓ | |
| 20. ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25%, | | | | ✓ |
| 21. ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 10%. | | | | ✓ |

*2.2. Орон нутгийн татвар*

*<u>2.3.1. Үл хөдлөх хөрөнгийн татвар</u>*

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар нь тухайн орон нутгийн төсвийн орлогын тогтвортой эх үүсвэр бөгөөд татвар төлөгч субъект нь өөрийн үйл ажиллагаа явуулах баталгаат хөрөнгөтэй, түүнийг дагаж үүсэх эрх зүйн бүх асуудлаар эрх эдэлж, үүрэг хүлээх чадвар бүхий хуулийн этгээд, төр улсынхаа түүний дотор тухайн орон нутагт амьдран суугаа нутгийнхаа хөгжилд тодорхой хувь нэмэр оруулахын тулд хуулиар тогтоосон албан татвар төлөх үүрэгтэй хувь хүн болдог.

Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгөд албан татвар ногдуулах, уг татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцаа нь *Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулиар* (2000) зохицуулагддаг.

Татвар ногдуулах обьект болох үл хөдлөх эд хөрөнгөд газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс хамаарах бөгөөд түүний байгаа газарт орших төрийн эрх бүхий байгууллагад хуульд заасны дагуу бүртгэгдсэн хөрөнгийг хэлнэ.

*"Газар"* гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг хэлдэг. Газрыг эзэмшихэд төлбөр төлдөг бол өмчлөхөөр албан татвар төлдөг. "*Газар өмчлөх"* гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ. *Иргэнд газар өмчлүүлэх* гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэний өмчлүүлж болохоор заасан газраас *Монгол Улсын*

*иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд* заасан хэмжээ, болзол, шаардлага, журам, нөхцлөөр иргэний өмчлөлд шилжүүлэхийг хэлдэг бөгөөд үүний үр дүнд энэ нь тухайн иргэний хувьд түүний үл хөдлөх эд хөрөнгө болдог. Ингэхдээ бэлчээр, нийтийн эдэлбэрийн бус улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлдэг.

*2.3.2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар*

Орон нутгийн төсвийн орлогод автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар нилээд хувийн жинг эзэлдэг төдийгүй төсвийн орлогын тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй байдаг. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг бүх төрлийн ачааны машин, автобус, суудлын автомашин, мотоцикль, тусгай зориулалтын автомашин, трактор өөрөө явагч бусад хэрэгсэлд ногдуулдаг ба хувь хэмжээ нь Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд бусад бүх суманд гэсэн ялгавартайгаар тогтоогдсон байдаг.

Мотоциклийн хувьд дугуйн тооноос хамааралтайгаар төгрөгөөр, суудлын автомашины хувьд цилиндрийн багтаамжийн нэг $см^3$ тутамд төгрөгөөр, микроавтобусны суудлын тооноос хамааралтай төгрөгөөр, автобусанд тогтмол хэмжээгээр, ачааны автомашинд даацын хэмжээгээр ялгавартайгаар, тусгай зориулалтын автомашин, трактор, өөрөө явагч хэрэгсэл, бага оврын тракторын хувьд тогтмол хэмжээгээр чиргүүлд даацын тонн тутамд нь төгрөгөөр тогтоогдсон байдаг. Нэгэнт орон нутгийн ялгавартай тогтоогдсон тул тухайн төсвийн орлогод эзлэх хувийн жин нь харилцан адилгүй байдаг[22].

*2.3.3. Хувь хүний орлогын албан татвар*

*Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар* (2006) ногдуулсан орлогын албан татварын тодорхой хэсгийг Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн орлогод оруулах заалт нь төсвийн орлогын бааз суурийг өргөтгөх нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулагдсан хөрөнгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох боломжийг нэмэгдүүлж өгч байгаа болно.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу албан татвар ногдуулж байгаа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө борлуулах, зохиогчийн шагнал болон уралдаан тэмцээний шагнал, хонжворын орлогод ногдсон албан татвар нь сум, дүүргийн төсвийн орлогын голлох эх үүсвэр болдог.

Бууны албан татвар нь сум, дүүргийн төсвийн татварын орлого бүрдүүлэх нэг эх үүсвэр болдог. Бууны албан татвар нь бууны төрлөөр, ялгавартайгаар, жилээр тогтоогдсон байдаг бөгөөд татварыг жил бүрийн 8-р сарын 1-ний дотор төсөвт төлөх үүргийг буу эзэмшигч хүлээсэн байдаг.

ААН, байгууллага, иргэнтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцэлээр зохицуулагдаагүй төрөл бүрийн ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувиараа ажил, үйлчилгээ эрхлэгч иргэний эдгээр үйл ажиллагаанаас олж байгаа орлогод ногдуулагддаг албан татвар нь сум, дүүргийн төсвийн орлогын бүрэлдэхүүнд багтдаг. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогод ажил үйлчилгээний төрөл оршин суугаа газрын байршлаас нь хамааруулан сар тутам тогтмол хэмжээний, ААН, байгууллага иргэнтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцэлээр зохицуулагдаагүй иргэний орлогод санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишгээр тодорхойлсон орлогод хувь хүний орлогын албан татварын хуулийн 7-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр, улс хооронд зорчигч болон ачаа тээврийн

[22] Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татварын тухай хууль (1992). 4-р зүйл.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

үйлчилгээ хийх тухай бүрд нь боомтын ялгавартайгаар тогтоосон хэмжээгээр албан татвар ногдуулан төсөвт төвлөрүүлдэг. Албан татварын хувь хэмжээ нь орон нутгийн болон боомт, ажил үйлчилгээний төрлөөр ялгавартай тогтоогддог тул тухайн төсвийн орлогод эзлэх хувийн жин нь харилцан адилгүй байдаг.

*2.3. Орон нутгийн хураамж*

Орон нутгийн төсөв болох сум, дүүргийн төсөвт гурван хураамж төвлөрдөг. (Хүснэгт 2.) Хууль тогтоомжийн дагуу төрийн ба орон нутгийн байгууллагуудаас ААН, байгууллага, иргэнд үзүүлж байгаа үйлчилгээний дийлэнхи хэсэг нь төлбөргүйгээр хийгддэг. Орон нутгийн төсвийн орлогын тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн болон орон нутгийн байгууллагууд хуулиар тогтоогдсон хэмжээнд багтаан үйлчилгээний төлбөрийг хураан авч орон нутгийн төсөвт оруулдаг.

Улсын тэмдэгтийн хураамжийг ногдуулах, төсөвт төлөх, хураахтай холбогдсон харилцааг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар (1993) зохицуулдаг. *Улсын тэмдэгтийн хураамж* гэдэг нь төрийн зохих байгууллагаас эрх олгох, сунгах, эрх шилжихтэй холбогдсон баримт бичиг олгох буюу бүртгэх, гэрээ хэлцэл, баримт бичгийг батлан гэрчлэх, иргэний бүртгэл хийх, шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон болон бусад үйлчилгээ үзүүлсний төлөө зохих этгээдээс төлж буй мөнгөн хөрөнгө юм.

Хураамжийг төрөөс үзүүлж буй дараах үйл ажиллагаанд хураадаг:

- шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх;
- нотариатын үйлчилгээ үзүүлэх;
- иргэний гэр бүлийн болон иргэний байдлын бүртгэл хийх, иргэний үнэмлэх, паспорт, зөвшөөрөл, виз олгох;
- консулын үйлчилгээ үзүүлэх;
- тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох эрхийн үнэмлэх олгох;
- буу бүртгэх;
- сонин, сэтгүүл бүртгэх;
- ААН, байгууллагыг бүртгэх;
- гадаадын байгууллагын төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулалттай ААН байгуулах зөвшөөрөл олгох бүртгэх;
- тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зөвшөөрөл олгох;
- шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент, барааны тэмдэгт гэрчилгээ олгох, патентыг хүчинтэй байлгах болон лицензийн гэрээ бүртгэх;
- зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бүртгэх;
- үнэт цаасны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох хураамж төлөхөөр заасан бусад үйлчилгээ;
- үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх.

Ан амьтан агнах, барих, барих зөвшөөрлийн хураамжийг ахуйн зориулалтаар ан амьтныг агнах барих, ахуйн зориулалтаар загас барих үйл ажиллагаанд хураадаг бөгөөд ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барихад нэг удаагийн эрхийн бичгээр, иргэний ахуйн зориулалтаар агнах бусад ан амьтны хувьд тухайн ан амьтны толгой тутмын экологи эдийн засгийн үнэлгээгээр эдгээрээс бусад зориулалтаар ан агнах, барих зөвшөөрлийн хураамжийг тухайн ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээгээр тус тус тооцон ногдуулж сум, дүүргийн төсөвт төвлөрүүлдэг.

Байгалийн баялагийг ашиглахад байгалийн баялаг ашиглах эрхийн бичиг олгоход

UIH.MN СУДАЛГААНЫ САН

төлдөг хураамж нь мөн сум, дүүргийн төсөвт төвлөрдөг.

2.4. Орон нутгийн төлбөр

Аймаг, нийслэлийн төсөвт 4 төрлийн төлбөр төвлөрдөг бөгөөд дэлгэрэнгүйг Хүснэгт 2-оос харна уу. *Төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг дараахь гурван аргачлалаар тооцдог:*

1. Бүтээгдэхүүн экспортонд гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дундажийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан тогтоодог.
2. Дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэдэг.
3. Дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэнэ.

*2.4.1. Ашигт малтмал ашигласны төлбөр*

Ашигт малтмал ашигласны төлбөрийг дотоодод борлуулж байгаа нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувиар эдгээрээс бусад ашигт малтмалын нөөц ашигласны[23] төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувьтай тэнцүү байхаар тогтоогдсон байдаг[24].

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь *Ашигт малтмалын тухай хуулийн* 58 дугаар зүйлд заасны дагуу 10 хувь нь тухайн сум дүүргийн, 20 хувь нь тухайн аймаг, нийслэлийн, 70 хувь нь улсын төсөвт хуваарилагддаг ба орон нутгийн төсөвт хуваарилах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь аймаг, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн төсвийн дүнгээс хэтрэхээргүй хязгаартай байдаг[25].

*2.4.2. Тусгай зөвшөөрлийн төлбөр*

Тусгай зөвшөөрлийн төлбөр нь хайгуулын ба ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэсэн ялгавартайгаар тогтоогдсон байдаг. Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр нь хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 0.1 ам доллар, 2 дахь жилд 0.2 ам доллар, 3 дахь жилд 0.3 ам доллар, 4-6 дахь жилд тус бүр 1.0 ам доллар, 7-9 дэх жилд тус бүр 1.5 ам доллароор тогтоогдсон байдаг бол ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон уурхайн талбайн гектар тутамд 15 америк доллар байх бөгөөд харин нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд гектар тутамд 5.0 ам доллар байдаг.

Тусгай зөвшөөрлийн төлбөр нь Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу улсын болон тухайн хайгуулын талбай, ашигт малтмалын орд байршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт хуваарилагдан төвлөрдөг. Тухайлбал тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25 хувийг тухайн сум, дүүргийн төсөвт, 25 хувийг тухайн аймаг, нийслэлийн

[23] Ашигт малтмалын тухай хууль (2006). 47-р зүйлийн 3.1 дэх заалт.
[24] Ашигт малтмалын тухай хууль (2006). 47-р зүйлийн 3.2 дахь заалт.
[25] Ашигт малтмалын тухай хууль (2006). 58-р зүйлийн 2 дахь заалт.

төсөвт, 50 хувийг улсын төсөвт төлөгдөхөөр хуваарилсан байдаг[26].

*2.4.3. Газрын төлбөр*

Орон нутгийн түүний дотор аймаг, нийслэлийн төсөвт газрын төлбөр төвлөрдөг. Газрын төлбөр ногдуулах гол үзүүлэлт нь газрын үнэлгээ байна.

Газрын суурь үнэлгээг Засгийн газар дараахь зарчмыг баримтлан тогтоодог.

1. Хот, тосгон, бусад суурины үнэлгээг тэдгээрийн зэрэглэл, байршил, инженерийн хангамж, нийгэм эдийн засгийн болон инженер, геологи, байгал орчны нөхцөл, ашиглах зориулалтыг харгалзах

2. Хот, суурин, бусад сууринаас бусад газрын үнэлгээг ашиглах зориулалт, газар зүйн байршил болон газрын үржил шим, өгөөжөөс үүсэх ялгаварт орлого зэргийг харгалзан тойрог бүрээр тогтоох зарчим багтдаг.

Газрын нэгдмэл санг байгаль, нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлөөр хуваасан үнэлгээний тойрог, хот, тосгон, бусад суурины газрын үнэлгээний зэрэглэлийг Засгийн газар тогтооно[27]. ***Газрын төлбөрийн тухай хуулийн*** 6-р зүйлд заасны дагуу Газрын төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжийг Хүснэгт 7-оос харна уу.

Бэлчээрийн газраас авах газрын төлбөрийг хонин толгойд шилжүүлсэн малын толгойн тоонд ногдуулахдаа өмнөх жилийн эцэст тоологдсон адууг 6,0, үхрийг 6,0, тэмээг 5,0, ямааг 0,9 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлж тооцно.

Эзэмшиж, ашиглаж байгаа хот, тосгон, бусад суурин газрын суурь үнэлгээ тогтоосон газрын төлбөрийг инженерийн хангамж, ашиглалтын зориулалт, байршил, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон ногоон бүсийг хамгаалах шаардлагыг харгалзан тооцсон итгэлцүүрээр 0,1-1,0 хувийн хязгаарт багтаан өсгөж бууруулж болно.

Итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг сум, дүүргийн ИТХ тогтооно.

Газрын төлбөрийг эзэмшил, ашиглалтад олгосон газрынх нь нийт хэмжээгээр тооцдог. Газрын төлбөрийг түүний суурь үнэлгээнээс дээр дурьдсан үзүүлэлтээр дараахь хязгаарт багтаан хувь, хэмжээг тогтоосон байдаг.

- нэг хонин толгойд ногдуулах бэлчээрийн газрын төлбөрийн хязгаар 0.01-0.03%,
- эзэмшиж, ашиглаж байгаа нэг га тариалан, хадлангийн газрын төлбөрийн хязгаар 0.01-0.03%,
- эзэмшиж, ашиглаж байгаа хот, тосгон, бусад суурины нэг га газрын төлбөрийн хязгаар 0,1-1,0%,
- зам, шугам сүлжээний газрын километр тутмын газрын төлбөрийн доод хязгаар 1500 төгрөг, дээд хязгаар 7500 төгрөг,
- Дээр дурьдсан 1-4-өөс бусад газрын төлбөрийн хязгаар 0.01-0.03% байна.

Газрын төлбөрийн хэмжээг өмнөх хязгаарт багтаан газрын үнэлгээ, ашиглах зориулалтыг харгалзан хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог, хот, тосгон, бусад суурин газрын үнэлгээний зэрэглэл тус бүрээр Засгийн газар тогтооно.

Газрын төлбөрийн хэмжээг газрын зэрэглэл, байршил, зориулалтаас нь хамааруулж өсгөн, бууруулж хэрэглэдэг. Тухайлбал, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газрын төлбөрийг тухайн нутаг дахь хамгийн ойр орших хот, тосгон, бусад суурины газрын төлбөрийн хэмжээг 2 дахин багасгаж, уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж байгаа хэсгийн газрын төлбөрийг уг газар нь уурхайн эдэлбэрт олгохооос өмнө хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог, хот, тосгон, бусад суурины газрын

[26] Ашигт малтмалын тухай хууль (2006). 59-р зүйлийн 2 дахь заалт.
[27] Газрын төлбөрийн тухай хууль (1997). 5-р зүйл.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

үнэлгээний зэрэглэлийн алинд хамаарч байсныг харгалзан 2 дахин өсгөж, ой болон усан сан бүхий газрын төлбөрийг ойр орших хот, тосгон, бусад суурин газрын төлбөрийн хэмжээг 2 дахин өсгөж тооцно.

Тусгай хамгаалалттай газар нутагт зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН, байгууллагын газрын төлбөрийг уг газар нь хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог, хот, тосгон, бусад суурин газрын үнэлгээний зэрэглэлийн алинд хамаарч байгааг харгалзан гурав дахин өсгөж тооцно.

Аялал, жуулчлалын зориулалтаар ашиглаж байгаа газрын төлбөрийг тухайн тойргийн хамгийн ойр орших хот, тосгон, бусад суурины газрын төлбөрийн хэмжээтэй адилтгаж тооцно.

Эрх бүхий байгууллагын албан ёсны шийдвэргүйгээр атаршуулсан болон өнжөөсөн газрын төлбөрийг тухайн тойргийн тариалангийн талбайн төлбөрийн хэмжээгээр тооцно.

Сум, дүүргийн төсөвт дараах төлбөр төвлөрдөг[28]:

- агнуурын нөөц ашигласны төлбөр,
- байгалийн ургамал ашигласны төлбөр,
- ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр,
- түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр,
- ус, рашааны нөөц ашигласны төлбөр,
- ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25 хувь,
- ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 10 хувь.

Агнуурын нөөц ашигласны төлбөр нь авах, худалдах гэсэн үйл ажиллагаатай шууд холбоотой байдаг. Энэхүү төлбөр нь Татварын ерөнхий хуульд зааснаар орон нутгийн татвар бөгөөд татварын тогтолцооны бүрэлдэхүүн болдог.

Байгалийн ургамлын ашиглалтыг сайжруулах үүднээс ургамал ашигласны төлбөр авах замаар орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, ургамлын талаар хийх судалгаа шинжилгээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох боломжийг ашиглах үүднээс байгалийн ургамлыг ашигласны төлбөрийг тогтоон төсвийн орлого болгож байна. Манай орны нутаг дэвсгэрт байгаа ургамлууд нь нөөц, тархалт, ахуйд ашиглах боломж, хамгаалах шаардлага зэргээрээ төлбөр тогтоох зайлшгүй нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

Төсвийг бүрдүүлэхэд байгалийн баялагийн төрөл болох ой мод чухал нөлөөтэй. Төсвийн орлогыг бүрдүүлэхэд ойгоос хэрэглээний мод түлээ ашигласны төлбөр авах хэлбэрийг хэрэглэдэг. Төлбөр ногдох зүйл нь аливаа зориулалтаар ойгоос бэлтгэж ашигласан бүх хэрэглээний мод, түлээ болно.

Ус, рашаан ашигласны төлбөр нь Монгол Улсын нутаг дэвсгэр дэх нөөцийн төлбөрт үлэмж хэсгийг эзэлдэг. Төлбөр нь ногдуулалт, төлөлтийн хувьд нилээд онцлогтой. Одоогийн байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөрийг:

- Усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамирын зэрэг үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа ус;
- Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан ус;

Иргэн ААН, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усанд ногдуулан хурааж төсвийн орлого болгож байна.

Төлбөр ногдох зүйл нь дараах зориулалтаар ашигласан ус, рашаан, тэдгээрийн орчин байдаг. Үүнд:

1) хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан

[28] Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль (2002). 10-р зүйлийн 2 дахь заалт.



UIH MN СУДАЛГААНЫ САН

ус;

2) эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан;

3) эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин багтдаг. Усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтоодог. Төлбөрүүдийг тооцох үзүүлэлтүүд нь ялгаатай тогтоогддогийг Хүснэгт 3-аас харна уу.

Хүснэгт 3. **Төлбөр тооцох үзүүлэлт**

| | |
|---|---|
| **Газрын төлбөр** | – бэлчээрийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрийг уг бэлчээрийн нэгж талбайн суурь үнэлгээний хувиар хонин толгойд шилжүүлсэн малын толгой тутамд<br>– цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, зам, тээвэр, холбоо мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогддсон зам, шугам сүлжээний газрын километр тутмаас<br>– дээр дурдснаар бусад газрын төлбөрийг нэг га газрын суурь үнэлгээний хувиар. |
| **Агнуурын нөөц ашигласны төлбөр** | – биет хэмжээ (тоо толгой),<br>– борлуулалтын орлого,<br>– ан, амьтаны толгой тутмын экологи эдийн засгийн үнэлгээ,<br>– ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнэ. |
| **Мод, түлээ ашиглах төлбөр** | – ургаа мод огтолж түүний үндсэн хэсгээс бэлтгэсэн хэрэглээний мод, түлээг нягт шоометрээр, үзүүр, мөчрийг сийрэг шоометрээр,<br>– ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг цэвэрлэж түлээ бэлтгэхэд сийрэг шоометрээр,<br>– иргэн заг түүж бэлтгэхэд тонн гэсэн үзүүлэлтээр. |
| **Ус, усан орчин ашигласны төлбөр** | – усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамир зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус, усан орчин ашигласан тохиолдолд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүн,<br>– хүн амын унд, ахуйн болон иргэн, ААН, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усны шоометрээр. |
| **Рашаан ашигласны төлбөр** | – эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашигласан бол эмчлэн сувилуулсан хүн-хоногийн тоо,<br>– үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа бол ашигласан рашааны шоометр,<br>– халаалтын зориулалтаар ашиглаж байгаа бол *халааж* байгаа зүйлийн эзлэхүүн. |

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг орон нутгаас тогтоон мөрдүүлдэг байсныг Ашигт малтмалын тухай хуулиар өөрчилж тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцон хураах журамд шилжүүлсэн.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### 3. Бүгд Найрамдах Болгар Улс

3.1. Хууль, эрх зүйн орчин

1989 онд ардчилалын үйл явцын дараа Болгарт төрийн тоталитар дэглэмээс ардчилсан дэглэмрүү шилжиж, 1991 онд шинэ Үндсэн хуулиа батлан парламентын засаглалтай БНУ болжээ[29]. Үндсэн хуулийнхаа эхний бүлэгт "Бүгд Найрамдах Болгар Улс бол нутгийн өөрөө удирдах байгууллагатай суурилсан нэгдсэн улс байна"[30] хэмээн зааж, долдугаар бүлэгтээ Нутгийн өөрөө удирдах байгууллагыг тодорхойлсон байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай Европын Хартид[31] (1995) заасны дагуу нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулах тухай Үндсэн хуулиндаа нэг бүлэг болгон оруулсан байна.

**Нутгийн удирдлагын тухай Европын Хартаас…**

"Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь нутаг дэвсгэрийн бие даасан хамтлагаас өөрийн хариуцлага дор төрийн хэргийн үлэмж хэсгийг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх, удирдлагыг хэрэгжүүлэх эрх, бодит чадвар юм."

Орон нутгийн засаглалыг зохицуулсан *Орон нутгийн өөрөө удирдах болон орон нутгийн засаг захиргааны тухай хууль* (1991 он), *Орон нутгийн сонгуулийн тухай хууль* (1995), *Орон нутгийн татварын ба хураамжийн тухай хууль* (1997), *Засаг захиргааны тухай хууль* (1998), *Орон нутгийн эд хөрөнгийн тухай хууль* (1996), *Орон нутгийн төсвийн тухай хууль* (1998), Иргэний хүсэлтийн тухай хууль (1996), *Засаг захиргааны хуваарилалтын тухай хууль* (1995), *Орон нутгийн хөгжлийн тухай хууль* (1999) зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг батлан гарсан байна.

3.2. Орон нутгийн татвар

Болгарын Үндсэн хуулийн долдугаар бүлгийн 141-р зүйлд орон нутгийн засаг захиргаа нь өөрийн төсөвтэй байх ёстой[32] бөгөөд орлогын байнгын эх үүсвэрийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно[33] хэмээн заасан бөгөөд 1997 онд ***Орон нутгийн татвар ба хураамжийн тухай хууль***[34] батласан.

Орон нутгийн засаг захиргаа нь бие даан цуглуулсан орон нутгийн татвар, үйлчилгээний хураамж, торгууль, ашгаас олсон орлого, түрээсийн төлбөр болон бусад эх үүсвэрээс гадна төрөөс хуваарилсан төсөв зэрэг эх үүсвэрээс санхүүжигдэнэ.

Орон нутгийн татвар ба хураамжийн тухай хуулиар татваруудыг дараах төрлөөр ангилсан байна:

1. үл хөдлөх хөрөнгийн татвар;
2. өв залгамжлалын татвар;
3. бэлэглэлийн татвар;

---

**29** Constitution of the republic of Bulgaria. Chapter 1, art 1 (1). (1991)
**30** Constitution of the republic of Bulgaria. Chapter 1, art 2 (1). (1991)
31 Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай Европын тунхаг бичиг *(European Charter of Local Self-Government)* – Европын зөвлөлийн орон нутгийн болон бүс нутгийн конгресс батлан гаргасан энэхүү тунхаг бичиг нь нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтцийн сууль зарчмыг тодорхойлсон олон талт баримт бичиг болно.
32 **Constitution of the republic of Bulgaria. Chapter 7, art 141 (1). (1991)**
33 **Constitution of the republic of Bulgaria. Chapter 7, art 141 (2). (1991)**
34 Law for Local Taxes and fees (1997). *Эх сурвалж:* http://portal.nap.bg/?lang=en – National Revenue Agency

UIH.MN СУДАЛГААНЫ САН

4. авто тээврийн хэрэгслэлийн татвар;
5. үйл ажиллагааны татвар;
6. хуульд заасан орон нутгийн бусад татварууд.

Эдгээрээс чухал татвар нь үл хөдлөх хөрөнгийн болон өв залгамжлалын татварууд аж. Хууль заасан журмын дагуу Орон нутгийн зөвлөл нь дээрхи татваруудын хувь хэмжээг тогтоох тухай *Орон нутгийн татвар ба хураамжийн тухай хууль* болон *Үндсэн хуулиар*[35] зааж өгсөн бөгөөд эдгээр татварууд нь бүгд орон нутгийн төсөвт орно.

Татвар төлөгч татвар хураах эхний хугацаа болох 3-р сарын 1-ээс 4-р сарын 30-ны хооронд татвараа бүрэн төлсөн тохиолдолд 5 хувийн хөнгөлөлт буюу урамшуулал үзүүлдэг нь орон нутгийн татварын харилцааны бүхий л субъектэд хамааралтай юм байна.

***Захиргааны хариуцлага:*** Хуульд заасан хугацаанд татварын мэдүүлгээ өгөөгүй, татварын хэмжээг бууруулахын тулд, татвараас чөлөөлөхийн тулд худал мэдүүлсэн зэрэг зөрчилтэй хувь хүн 10-400 хүртэл лев, хуулийн этгээд 100-1000 хүртэл левээр торгоно.

*<u>3.2.1. Үл хөдлөх хөрөнгийн татвар</u>*

Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөгч нь барилга байгууламж, газар эзэмшигч. Хөрөнгө шинээр эзэмших болсон, эсвэл өв залгамжилж авсан, эзэмшилд нь өөрчлөлт орсон бол харьяа татварын албанд 2 сарын дотор мэдэгдэх ёстой. Анх удаа татвар төлөгч нь 5%-ийн хөнгөлөлт үзүүлнэ. Харин татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх хэлбэрүүдийг дараах Хүснэгт 4-өөс харна уу.

Үл хөдлөх хөрөнгийн хувь хэмжээг тогтоохдоо түүний байрлал, дэд бүтэц, ашиглалт, онцлох шинж, өндөрийн буюу давхарын хэмжээ, элэгдэл, хамрах хүрээ зэргийг тогтоож коэффициэнтээр тооцдог бөгөөд тэдгээрийн заримыг нь Хавсралт 5-аас харна уу. Татвар ногдуулах үндсэн хувь хэмжээг Хүснэгт 5-т үзнэ үү.

Хүснэгт 5. **Үл хөдлөх хөрөнгөд ногдох үндсэн хувь хэмжээ,** 1 $м^2$, левээр

| Барилга байгууламж | Амины зориулалттай барилга | | Амины бус зориулалттай барилга |
|---|---|---|---|
| | Орон сууц | Байшин | |
| FB | 4,40 | 3,70 | 4,80 |
| SS | 7,50 | 6,40 | 8,20 |
| S1 | 11,00 | 9,40 | 12,40 |
| S2 | 14,00 | 12,00 | 15,40 |

Үл хөдлөх хөрөнгийн татвар ногдуулах төрөлд хоёр давхар орон сууцнаас эхлээд граж, амбаар, саравч (үүнд: малын болон бусад зориулалттай, эсвэл дээвэртэй, 4 ханатай болон ханагүй) хүртэл хамаарч, 40-100 хувийн татварыг ногдуулсан байна. Барилга байгууламжийг түүний байршил, өндөр буюу давхар, ашиглалт зэргийн коэффициэнтийг хуулийн хавсралтад тодорхой тусгажээ. (Хавсралт 5.)

Хүснэгт 4. **Татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх хэлбэрүүд**

| Татвараас чөлөөлөх хэлбэрүүд | – Улсын болон орон нутгийн, эсвэл гадаадын засгийн газрын мэдэлд байгаа барилга байгууламж, газар,<br>– 1680 BGN хүртэлх үнэтэй үл хөдлөх хөрөнгө,<br>– хуулийн дагуу бүртгэгдсэн сүмийн барилга, |
|---|---|

[35] **Constitution of the republic of Bulgaria. Chapter 7, art 141 (3). (1991)**



UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| | – соёлын төвийн болон сургуулийн барилга,<br>– цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн спортын талбай,<br>– ашгийн бус зорилгоор ашиглаж байгаа соёлын өв болсон барилга,<br>– музей, галерей, номын сан,<br>– олон нийтийн тээврийн хэрэгсэлээр зорчигчдод зориулсан байгууламж,<br>– шинэ барилга барих ажиллагаанд ашиглаж байгаа түр зуурын байгууламж,<br>– хууль, дүрмийн дагуу баригдсан бөгөөд 5 хүртэлх жил ашиглах боломжгүй үл хөдлөх хөрөнгө,<br>– 2005.01.01-ээс өмнө ашиглалтанд орж, *Үр ашигтай эрчим хүчний тухай хуулийн* дагуу гэрчилгээ[36] авсан бол<br>• А зэрэглэлийн гэрчилгээ авсан барилга 7-10 жил,<br>• В зэрэглэлийн гэрчилгээ авсан бол 3-5 жил |
| **Татварын хөнгөлөлт** | – хэрэв үл хөдлөх хөрөнгө нь эзэмшигчийн үндсэн байшин бол 50 хувь,<br>– хэрэв үл хөдлөх хөрөнгө нь 50-100 хувийн хөдөлмөрийн чадвараа алдсан эзэмшигчийн үндсэн байшин бол 70 хувь. |

*3.2.2. Өв залгамжлалын татвар*

Хуулийн дагуу тус улсын нутаг дэвсгэр болон хилийн чандад байгаа Болгарын иргэнд хамаарах эд хөрөнгө, эсвэл тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эд хөрөнгөө хэн нэгэнд өвлүүлэх харилцааг зохицуулахаар тусгасан байна. Өв залгамжлан авсан этгээд болон өв залгамжлалаа өгсөн этгээд аль аль энэ төрлийн татвар төлөгч байхыг хуульд заажээ. Гэхдээ өв залгамжлал хүлээн авагч нь өвлүүлэгчийн амьд байгаа эхнэр, нөхөр болон хүүхдүүд ямар нэгэн хязгааргүйгээр шууд өвлүүлэхийг хуульчилсан байна. Өв нээгдэх үед өвлүүлэх эд хөрөнгийг тогтоож, дараах аргаар үнэлгээ хийгдэнэ:

Хүснэгт 6. **Өвлүүлэх эд хөрөнгө, тэдгээрийг үнэлэх арга**

| Өвлүүлэх эд хөрөнгө | Үнэлгээ хийх арга |
|---|---|
| 1. үл хөдлөх хөрөнгө | – хууль заасан журмын дагуу |
| 2. гадаад валют болон үнэт металл | – Болгарын Үндэсний банкны ханшаар |
| 3. үнэт цаас | – зах зээлийн ханшаар тооцох ба хэрэв үнэлэх боломжгүй бол нэрлэсэн үнээр |
| 4. тээврийн хэрэгсэл | – даатгуулсан үнээр |
| 5. бусад эд хөрөнгө болон эрх | – зах зээлийн ханшаар |
| 6. үйлдвэрийн газар болон компани, хоршооны ногдол хувь | – Зах зээлийн ханшаар тооцох ба хэрэв үнэлэх боломжгүй бол тайлан тооцоогоор |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Ийнхүү өвлүүлэх эд хөрөнгийг тогтоон, үнэлэхдээ өвлүүлэгчийн өрийг тогтоох, үнэлэх ажиллагаа мөн явагддаг байна. Үүний зэрэгцээ хуульд заасан зарим дүнг суутгах

[36] Шинээр баригдсан барилга байгууламжийн эрчим хүчний үр ашиг нь Болгарын Үр ашигтай эрчим хүчний тухай хуульд заасан шаардлагыг хангасан бол түүнийг гэрчлэх гэрчилгээг авна. Тэдгээрийн нэг төрөл болох А, В ангилалын гэрчилгээг дараах тохиолдолд авна: ***А зэрэглэлийн гэрчилгээ***–зарцуулах энергийн хэмжээ нь ECHRB-2005-ийн шаардлагад нийцүүлсэн, эсвэл түүнээс бага бол, эсвэл зарцуулах энергийн хэмжээ нь 1999 оны нормтой тэнцүү, эсвэл түүнээс бага бол; ***В зэрэглэлийн гэрчилгээ*** – зарцуулах энергийн хэмжээ нь 1980-1987 оны нормтой тэнцүү, эсвэл түүнээс бага бол.

аж. Тухайлбал, өвлүүлэгчийн оршуулгын 1000 хүртэх левийн тэтгэмж болон бусад тэтгэмж.

Өвлүүлэх эд хөрөнгийн өв залгамжлах этгээдүүдэд өвлүүлэх хувийг Өв залгамжлалын тухай хуулиар, тэдгээр өвд ногдох татварын хэмжээг нь Татвар, даатгалын процессын хуулиар тус тус зохицуулна.

Хоёр хүн нэгэн зэрэг нас барсан, эсвэл дараалан нас барсан, тэдний нэг нь нөгөөгийнхөө өв залгамжлагч нь бол татвараас чөлөөлнө. Мөн дараах өвлөн авсан эд хөрөнгийг татвараас чөлөөлнө:

1. БНБУ-ын төлөө амиа алдсан, эсвэл ажил үүргээ гүйцэтгэж явахдаа, үйлдвэрийн ослоор, байгалийн гэнэтийн аюулын үед нас барсан этгээдийн эд хөрөнгө,
2. Улсын мэдэлд болон орон нутгийн засаг захиргааны мэдэлд өөрийн хүсэлтээр өвлүүлсэн эд хөрөнгө,
3. Болгарын улаан загалмайн нийгэмлэг, улсад бүртгэлтэй шашны байгууллага, соёлын төв болон бусад ашгийн бус хуулийн этгээдэд өвлүүлсэн эд хөрөнгө,
4. энгийн тавилга,
5. жижиг фермерийн аж ахуйн хэрэгсэл, тоноглол,
6. номын сан болон хөгжлийн зэмсэг,
7. зохиогч нь өв залгамжлагчид, эсвэл бусдад өвлүүлсэн өөрийн урлагийн бүтээл,
8. өвлүүлэгчийн аваагүй тэтгэвэр,
9. гадаад оронд байгаа Болгарын иргэдийн эд хөрөнгө, түүнд ногдох татварыг холбогдох улс нь авсан тохиолдолд.

Өвлүүлэгч нь үл хөдлөх хөрөнгөө нас барахаасаа өмнө 1 жилийн өмнө эзэмшилдээ авсан бол 40 хувийн татвар, 2 жилийн өмнө авсан бол 50 хувийн татвар, 3 жилийн өмнө авсан бол 60 хувийн татвар тус тус ногдоно.

### *3.2.3. Бэлэглэлийн татвар*

Бэлэглэлийн татварт бэлгийн журмаар өвлүүлсэн үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл болон түүнийг эзэмших эрх, мөнгөн гүйвуулга зэрэг хамаарна.

Орон нутгийн зөвлөл нь хөрөнгийг хуульд заасан журмын дагуу үнэлнэ. Үүнд: хэрэв ах, эгч болон тэдний хүүхдүүдийн хооронд бэлэг солилцож байгаа бол 0.4-0.8 хувь, тэднээс өөр хүмүүсийн хооронд солилцож байгаа бол 3.3-6.6 хувийн татварыг төлнө.

| | |
|---|---|
| **Татвараас чөлөөлөх хэлбэрүүд** | – Дараах субъектуудын эзэмшилд байгаа хөрөнгүүд:<br>• улсын болон орон нутгийн,<br>• төсвөөс дэмжлэг авдаг боловсрол, соёл болон шинжлэх ухааны байгууллагууд болон хүүхдийн эрүүл мэндийн байгууллагууд,<br>• Болгарын Улаан загалмайн нийгэмлэг,<br>• хөдөлмөрийн чадваргүй иргэдийн байгууллага болон тэдэнд үйлчилдэг үндэсний байгууллагууд,<br>• байгалийн гамшигт өртсөн хүмүүсийг дэмжих сан,<br>• түүхийн, соёлын өв уламжлалыг хамгаалах, сэргээн болгох сан,<br>• эрүүл мэндийн байгууллага,<br>– Европын холбооны гишүүн улс, эсвэл Европын эдийн засгийн бүсийн тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан улсын иргэд болон хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн эмчилгээнд зориулагдсан тусламж,<br>– хөдөлмөрийн чадвараа 50-100 хувь алдсан этгээд болон ядуу иргэдэд |

UIH MN СУДАЛГААНЫ САН

зориулсан хүмүүнлэгийн тусламж,
- улсын төсвөөс ашгийн бус хуулийн этгээдэд зориулсан хандив,
- энгийн бэлэг,
- хуульд заасан үүргээ хэрэгжүүлэх зорилготойгоор үнэгүй шилжүүлсэн хөрөнгө,
- олон нийтийн соёлын төвд дэмжлэг үзүүлэх хандив,
- хуульд заасны дагуу хувьчлал болон шуудангийн хяналтын хувьчлалаар авсан хөрөнгө,
- арилжааны компани, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг байгууллагын үндсэн хөрөнгөд мөнгөн бус орлого,
- харилцан тохиролцсоны үндсэн дээр гадаадын орны этгээдийн эзэмших хөрөнгө,
- Урлагийн өв санг хамгаалах тухай хуулийн дагуу дэмжлэг үзүүлэх зорилготой үйл ажиллагаа.

### 3.2.4. Авто тээврийн татвар

Авто тээврийн хэрэгсэлийн татварыг БНБУ-д бүртгэгдсэн тээврийн хэрэгсэл, усан онгоц, иргэний нисэх хүчний онгоцонд ногдуулах ба эдгээрийн эзэмшигчид нь татвар төлөх үүргийг хүлээнэ.

Орон нутгийн зөвлөл нь хуульд заасан журмын дагуу бүх авто тээврийн төрөл, тэдгээрийн хөдөлгүүрийн хүчин чадал, овор, даац, тэнхлэг, автобусны суудал зэргийг тооцож ногдох татварын хувь, хэмжээг 0.34-300 хүртэл левээр тогтоосон байна. Тухайлбал, хөдөлгүүрт дугуйнд 10-30 лев, 12 тонн ачааны автомашинд 10-30 лев *(12-оос дээш тонн ачааны автомашинд ногдох татварын хэмжээг Хавсралт-…-аас үзнэ үү)*, тусгай зориулалтын автомашинд 50-150 лев, тусгай зориулалтын барилгын автомашин, автокран зэрэгт 50-150 лев, өөрөө явагч бусад хэрэгсэл 25-75 лев, моторт чарга 50-150 лев ногдуулсан байна. Бусад суудлын машинд ногдох татварын хэмжээг Хавсралт 6.1-ээс дэлгэрүүлж үзнэ үү.

Суудлын автомашины хувьд хөдөлгүүрийн хүчин чадлаас гадна ашигласан жилийг коэффициэнтээр тооцож татварыг тогтооно. Үүнд:

Хүснэгт 7. **Суудлын автомашины ашигласан жилийн коэффициэнт**

| Ашигласан жил, үйлдвэрлэсэн өдрийг оруулаад | Коэффициэнт |
|---|---|
| 5 хүртэлхи жил | 2,8 |
| 5-14 жил | 1,5 |
| 14-өөс дээш жил | 1,0 |

Суудлын ба ачааны чирэгч зүтгүүрийн даацын зөвшөөрөгдсөн дээд хэмжээ, тэнхлэгийн тоо зэргээс хамаарч татварын хэмжээг тогтоох ба дэлгэрэнгүйг Хавсралт 6-аас үзнэ үү.

Усан онгоцны явах газар, түүний төрөл зэргээс хамаарч ногдох татварын доод хэмжээ 0.10-0.30 лев, дээд хэмжээ нь 20-60 лев байна. Тухайлбал, Хар тэнгис, Дунайн мөрөнд хүрэлгүй зөвхөн дотоодын усан замд явдаг, дарвуулгүй, мотороллергүй усан онгоцны тоон тутамд 1-3 левийн татвар ногдоно.

Нисэх онгоцны төрөл, мотороос хамаарч 12-24 болон 30-60 левийн татвар авна. Тухайлбал, нисдэг тэрэг буюу бидний хэлж заншсан ногоон онгоцны тоон тутамд 20-40

UIH.MN СУДАЛГААНЫ САН

левийн татвар ногдуулдаг байна.

| | |
|---|---|
| **Татвараас чөлөөлөх хэлбэрүүд** | – төрийн болон орон нутгийн эзэмшлийн тэрэг,<br>– түргэн тусламж болон галын унтраах тэрэг,<br>– харилцан нөхцөлтэй дипломат болон консулын тэрэг,<br>– Болгарын Улаан загалмайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тэрэг,<br>– ажиллах хүчин чадлыг 50-100 хүртэл хувиар багасгасан, 2000 $см^3$ хөдөлгүүрийн эзэлхүүнтэй, 117,64 хүртэл кВт-ын хүчин чадалтай хувь хүний тэрэг. |
| **Татварын хөнгөлөлт** | – 74 хүртэл кВт-ын хөдөлгүүрийн хүчин чадалтай, идэвхитэй катализын тоног төхөөрөмжтэй тээврийн хэрэгсэлд 50 хувийн хөнгөлөлт,<br>– “Евро 2”, “Евро 3”, “Евро 4” боллон “Евро 5” стандартад нийцсэн “Эко-хөдөлгүүр”-тэй автобус, ачааны тэрэг, зүтгүүр трактор зэрэгт 50 хувийн хөнгөлөлт,<br>– байнгын үйлчилгээний шугаманд гарч байгаа автобус 10 хувийн хөнгөлөлт. |

Тээврийн хэрэгсэлийн татварыг 3-р сарын 31, 9-р сарын 30 хүртэл гэсэн хоёр хуваариар төлөх ёстой. Бүтэн жилийн татвараа хугацаандаа урьдчилан төлбөл 5 хувийн урамшууллыг татвар төлөгчид олгодог байна. Автотээврийн хэрэгсэлийн техникийн жил тутмын үзлэгт хамрагдах нэг гол шаардлага бол тээврийн хэрэгсэлийн татвар төлөх явдал юм.

### *3.2.5. Үйл ажиллагааны татвар*

Үйл ажиллагааны татвар нь 2008 онд шинээр нэмэгдсэн бөгөөд татвар төлөх субъект нь 50,000 левээс хэтрэхгүй эргэлтийн хөрөнгөтэй, Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн дагуу бүртгүүлээгүй зэрэг этгээдүүд байна.

Хэрэв тухайн этгээд дараагийн 12 сард үйл ажиллагаагаа зогсоосон, эсвэл шинэ үйлдвэр, үйл ажиллагаа эрхлэх болсон, энэ хугацаанд эргэлт нь 50 000 левээс илүү гарвал энэ төрлийн татварыг төлөхгүй.

Орон нутгийн зөвлөл патентын татвар ногдох үйл ажиллагааг дараах байдлуудыг харгалзан тодорхойлж, түүнд ногдох татварын хувь хэмжээг тогтооно.

- үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн оршин суугаа газар, бүс,
- хэрэв тухайн газар, бүс нь үндэсний болон бүсийн шинжтэй цаг уурын нөхцөл байдал,
- оршин суугаа газар, бүсийн хэмжээ, түүнд оршин суугаа хүн амын тоо,
- тухайн газар, бүсийн эдийн засгийн ач холбогдол,
- улирлын, эсвэл байнгын шинжтэй үйл ажиллагаа,
- тухайн газрын эдийн засгийн байдал.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| **Татвараас чөлөөлөх хэлбэрүүд** | – ажлын чадвараа 50 болон түүнээс дээш хувь алдсан нэг этгээд нь хэн нэгийг хөлсөлж ажилуулаагүй, үйл ажиллагаагаа өөрөө эрхэлж байгаа нөхцөлд 50 хувийн хөнгөлөлт,<br>– 1-36-т заасан үйл ажиллагааг дангаараа эрхэлж байгаа этгээд 50 хувийн хөнгөлөлт (үйл ажиллагааны жагсаалтыг Хавсгалт 7-оос үзнэ үү),<br>– гар урлал болон үсчин, гоо сайханч, маникур, педикурын сургалт явуулж байгаа этгээд 50 хувийн хөнгөлөлт, |

Татвар төлөгч 1-р сарын 31-нд багтааж татвараа мэдүүлэх бөгөөд хэрэв үүнээс хойш үйл ажиллагаагаа эхэлсэн бол эхлэхээс өмнө холбогдох газар мэдүүлэх ёстой. Хэрэв татвар төлөгч нь 1-р сарын 1-31-ний хооронд татвараа мэдүүлэхээс гадна бүрэн төлж барагдуулсан бол 5 хувийн урамшуулалтай байна. Гэхдээ татвар төлөх хугацаа нь 1-р сарын 31-ыг хүртэл, 4-р сарын 30-ыг хүртэл, 7-р сарын 31-ыг хүртэл, 10-р сарын 31-ыг хүртэл гэсэн 4 үе шаттай байдаг.

*3.3. Орон нутгийн хураамж*

Орон нутгийн засаг захиргаа дараах хурамжийг цуглуулахаар хуульд заажээ:

1. гэр ахуйн хогны,
2. худалдааны газар, зах, яармаг худалдаа, гудамж, талбайн ашиглалтын,
3. хүүхдийн өрөө, хүүхдийн хоол бэлтгэх гал тогооны өрөө, хүүхдийн цэцэрлэгүүд, олон нийтийн үйлчилгээний мэргэшсэн байгууллагууд, их сургуулийн газар нутаг, оюуны байр болон орон нутгийн бусад олон нийтийн үйлчилгээний,
4. техник үйлчилгээний,
5. захиргааны үйлчилгээний,
6. оршуулгын газар эзэмшсний,
7. аялал жуулчлалын,
8. нохойны,
9. хуулиар тогтоосон орон нутгийн бусад хураамж.

Орон нутгийн зөвлөл нь орон нутгийн захиргаанаас үзүүлж байгаа дээр дурьдсанаас бусад бүх үйлчилгээнд хураамжийн хэмжээг тогтоох ба орон нутгийн захиргаа дээр дурьдсан болон бусад хураамжийг цуглуулж орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

Хуульд иргэд нэг жилийн турш, эсвэл хэсэг хугацаагаар үйлчлүүлэхгүй байгаа орон нутгийн үйлчилгээг хураамжгүй болгохоор зохицуулсан байна. Мөн Орон нутгийн зөвлөл нь тодорхой бүлэг иргэдийг төлбөрөөс бүрэн болон хэсэгчлэн хөнгөлөлт үзүүлэх эрхтэй.

Хотын дарга нь иргэний 30,000 хүртэл левийн өр төлбөрийн барагдуулах хугацааг хойшлуулах зөвшөөрөл олгох эрхтэй. Ингэхдээ зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 1 жилийн дотор өр төлбөрийг барагдуулах ёстой. Харин орон нутгийн зөвлөл нь 30,000-ээс дээш левийн өр төлбөрийг 1-ээс дээш жилийн хугацаанд барагдуулах тухай зөвшөөрөл гаргах эрхтэй.

Хураамжийн хэмжээг тогтоохдоо тухайн үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай материал-техникийн болон захиргааны зардлыг тооцох ёстой. Зарим хураамжийг дэлгэрүүлэн авч үзье:

***Худалдааны газар, зах, яармаг худалдаа, гудамж, талбайн хураамжийн хувьд***

Хувь хүн болон хуулийн этгээд орон нутгийн эзэмшилд байгаа эдгээр талбай ямар дүүрэгт байгаагаас хамаарч ашигласны төлбөрийг төлнө. .

***Хүүхдийн өрөө, хүүхдийн хоол бэлтгэх гал тогооны өрөө, хүүхдийн цэцэрлэгүүд, олон нийтийн үйлчилгээний мэргэшсэн байгууллагууд, их сургуулийн газар нутаг, оюуны байр болон орон нутгийн бусад олон нийтийн үйлчилгээний хураамжийн хувьд***

Хураамжийг сар бүр төлөх ёстой, тухайлбал, хүүхдийн өрөө болон хүүхдийн цэцэрлэгийг үйлчилгээний хураамжийг сар бүр хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч төлөх

UIH.MN СУДАЛГААНЫ САН

үүрэгтэй. Олон нийтийн үйлчилгээний мэргэшсэн байгуулгын хураамжийг өдөр тутмын хоол унд, хувцас, ор дэрний хэрэгсэл, угаалгын болон ариун цэврийн хэрэгсэл, хоол хүнс тараах тээврийн зардал, цахилгаан болон халаалтын зардал зэргийг тооцож тогтооно.

***Техник үйлчилгээний хураамжийн хувьд***

Архитектурын байгууламж, барилга барих зөвшөөрөл, кадастр гэх мэт нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж буй техник үйлчилгээний төлбөрийг хүсэлт гаргасан хувь хүн, хуулийн этгээд төлнө. Улсын болон орон нутгийн байгууллага, Болгарын Улаан загалмайн нийгэмлэг зэрэг байгууллагууд уг хураамжийг төлөхгүй.

Техник үйлчилгээг үзүүлэх тодорхой хугацааг олон нутгийн зөвлөл тогтоох ба 1 сараас илүүгүй хугацааг тогтооно.

***Захиргааны үйлчилгээний хураамжийн хувьд***

Гэрлэлт, төрсөний, нас барсныг гэрчилсэн хоёр дахь удаагийн гэрчилгээ, тэдгээрийн албан ёсны хуулбар, мөн түүнчлэн өв залгамжлал, хувь хүний нэр тодорхойлсон, гэр бүлийн байдлын, гэр бүлийн харилцааны, оршин суугаа хаяг зэргийг гэрчилсэн гэрчилгээ, тодорхойлолт, гадаадын иргэний БНБУ-д айлчлах урилга, гадаадын эрх бүхий байгууллагад зориулсан иргэний бичиг баримтын баталгаажуулалт, баримт бичгийн хуулбар болон иргэдийн хүссэн бусад баримт бичгийн гэрчилгээ зэрэгт хураамж төлнө.

| | |
|---|---|
| **Төлбөр төлөхгүй үйлчилгээ** | – төрснийг бүртгэх болон төрсний гэрчилгээний эх хувь,<br>– гэрлэснийг бүртгэх болон гэрлэлтийн гэрчилгээний эх хувь,<br>– нас барсныг бүртгэх болон нас барсны гэрчилгээ, гэрчилгээний хуулбар,<br>– иргэний нийгмийн байдлын тухай баримт бичигт тэмдэглэл, нэмэлт, өөрчлөлт хийх,<br>– асран хамгаалагчийг тогтоох болон томилох,<br>– хүн амын бүртгэлийг хадгалах,<br>– тэтгэврийн, өв залгамжлалын гэрчилгээ. |

***Оршуулгын газар эзэмшисний хураамжийн хувьд***

Оршуулгын газрыг 8-аас илүү жил ашиглаж байгаа бол 15 жил хүртэл, үүрд, гэр бүлийн оршуулганд зориулж ашиглаж байгаа бол орон нутгийн хураамжийг төлөх үүрэгтэй. Хураамжийг оршуулгын газрыг удирдаж байгаа орон нутгийн холбогдох байгууллага хураана.

***Аялал жуулчлалын хураамжийн хувьд***

Аялал жуулчлалын тухай хуулийн дагуу орон байр, сууц, жуулчны бааз ашигласан хураамжийг хүн бүр төлөх ба нутгийн удирдлагын байгууллага нь аялал жуулчлалыг дэмжих орон нутгийн жил бүрийн хөтөлбөрт зарцуулдаг байна:

1. орон нутгийн нутаг дэвсгэр дээр жуулчдад үйлчлэх барилга байгууламж, дэд бүтэц (үүнд: амралтын газрыг нисэх онгоцны болон төмөр замын буудал, тээврийн товчоотой холбосон орон нутгийн чанартай авто замыг хамруулахын зэрэгцээ соёлын үнэт зүйлсийг ч мөн багтаана),
2. жуулчдад зориулсан мэдээллийн төв болон мэдээллээр үйлчлэх байгууллагуудыг байгуулах,
3. ногоон байгууламжийг бий болгох, хамгаалах, хөгжүүлэх,
4. эрүүл ахуй болон ариун цэврийн үйлчилгээ,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

5. аялал жуулчлалын сүлжээг орон нутгийн нутаг дэвсгэр дээр болон гадаадад суртачилах.

**4. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС**

4.1. Хууль, эрх зүйн орчин

Одоогийн орон нутгийн засаглалын бүтэц нь хоёр үе шат бүхий төвлөрлийг сааруулах шинэчлэлийн үр дүнд бий болсон байна. Коммунизмын үед хуваасан 49 засаг захиргааны жижиг нэгжүүдийг 16 муж (*wojewydztwo*), 308 дүүрэг (*powiat*) болон 66 хотын захиргаанд хуваах шийдвэрийг гаргахад Польшийн Засгийн газарт найман жил шаардагдсан байна. Шинэчлэлийн үр дүнд засаг захиргааны нэгж нь босоо тогтолцоотой 3 түвшиний нутгийн өөрөө удирдах байгууллагад хуваагджээ.

Тус улсын орон нутгийн засаглалын тухай “өөрөө удирдах нутаг дэвсгэрийн нэгжүүд нь хуульд заасан журмын дагуу өөрсдийн татвар ба төлбөртэй байх”[37] гэж Үндсэн хуульд (1997) заасныг үндэс болгон орон нутгийн харилцааг зохицуулдаг хэд хэдэн эх сурвалжууд байдаг.

Засаг захиргааны нэгжийн удирдлагын байгууллага тус бүр өөрсдийн бие даасан хуулиар зохицуулагддаг байна: *Мужийн удирдлагын байгууллагын тухай хууль* (1998), *Дүүргийн удирдлагын байгууллагын тухай хууль* (1998), *Хотын захиргааны байгууллагын тухай хууль* (1990).

Орон нутгийн татварын харилцааг *Улсын санхүүгийн тухай хууль* (1998), *Нутаг дэвсгэрийн өөрөө удирдах байгууллагын орлогын тухай хууль* (2003), *Орон нутгийн татвар ба төлбөрийн тухай хууль* (1991), *Газар тариалангийн татварын тухай хууль* (1984) зэрэг эх сурвалжуудаар зохицуулж байна.

4.2. Орон нутгийн татвар

***Орон нутгийн татвар ба төлбөрийн тухай хуулиар*** (1999) дараах төрлийн татварууд нь орон нутгийн төсөвт ордог байна:

1. газар тариалангийн татвар,
2. үл хөдлөх хөрөнгийн татвар,
3. авто тээврийн хэрэгслэлийн татвар,
4. ойн татвар,
5. нохойны татвар,
6. өв залгамжлал болон бэлэглэлийн татвар.

Орон нутгийн татварын дээд хувь хэмжээг тус улсын Парламент тогтоож, харин нутгийн удирдлагын байгууллага эрх мэдлийнхээ хүрээнд тогтоосон хязгаарт багтаан татварын хувь хэмжээг өөрчлөх эрхтэй.

*4.2.2. Газар тариалангийн татвар*

Газар тариалангийн татварыг *Газар тариалангийн татварын тухай хуулиар* (1984) зохицуулдаг бөгөөд орон нутгийн төсвийн чухал орлогын нэг юм. Уг татварын хувь хэмжээний дээд хязгаарыг хууль тогтоох дээд байгууллагаас тогтоож, харин орон нутгийн түвшинд тогтоосон татварын хувь хэмжээг бууруулах эрхтэй.

Газар тариалангийн татвар төлөгч нь газар тариалангийн зориулалтаар ашигладаг, эсвэл хөдөө аж ахуйн зориулалтаар ашигладаг усан сантай барилга зэрэг нь 1 га газраас том талбайтай фермийн аж ахуй эзэмшигч, ашиглагч байна. Уг талбай дээр

[37] Poland Constitution. *Adopted by National Assembly on: 2 April 1997.* **Article 168.**

UIH.MN СУДАЛГААНЫ САН

тариалалт хийгдэж байгаа эсэхээс үл хамааран гектар тутамд татвар төлнө. Гэхдээ татварын суурь нь тухайн газрын гадаргуу болон хэрэглэх боломжтой зэргийг харгалзан үзнэ. Нэг жинэлсэн дундажийн татварыг хувь хэмжээг ногдуулахдаа тухайн жилийн эхний гурван улирлын 250 кг хөх тарианы ханшаар тооцно.

| | |
|---|---|
| **Татварын хөнгөлөлт** | – фермерийн эзэн нь аж ахуйдаа шинэчлэл хийх зорилгоор хөрөнгө оруулалт хийсэн бол хөрөнгө оруулсан дүнгийн 25 хүртэлхи хувь,<br>– фермер нь уулархаг нутагт оршдог, далайн төвшинөөс 350 метрийн өндөрт байрладаг бол 30 хувь, |
| **Татвараас чөлөөлөх хэлбэр** | – фермерийн газар нь хамгийн муу суу хөрстэй бол,<br>– фермерийн газрыг 3 жилээс хэтрэхгүй жил ашигласан бол,<br>– фермер эзэмшигч аж ахуйгаа өргөжүүлэхээр, эсвэл шинээр талбай авсан бол. |

*4.2.1. Үл хөдлөх эд хөрөнгийн татвар*

Нутгийн захиргааны байгууллагын хувьд эд хөрөнгийн татвар нь хамгийн чухал орлогын эх үүсвэр. Хөрөнгө эзэмшиж байгаа хувь, хуулийн этгээдүүд татвар төлөгч байна. Татвар төлөх объектын жагсаалтад барилга байшин, эсвэл тэдний хэсэг, архитектурын байгууламж, тариалан болон ойн татварт хамаардаггүй газар, тариалангийн болон ойн үржүүлгийн аж ахуйгаас бусад ашгийн зорилготой ашиглаж байгаа нуур, нөөц ус, тариалан болон ойн хэсэг зэрэг орно.

Хүснэгт 8. **Үл хөдлөх хөрөнгийн хамгийн өндөр татварын хувь хэмжээ,**

| | 2001 он | 2003 он |
|---|---|---|
| Амины байшин | 0.46 PLN/$м^2$ | 0.51 PLN/ $м^2$ |
| Арилжааны зориулалтаар ашиглаж буй барилга | 15.86 PLN/$м^2$ | 17.31 PLN/ $м^2$ |
| Арилжааны зориулалтаар ашиглаж буй хэсэг газар | 0.56 PLN/$м^2$ | 0.62 PLN/ $м^2$ |
| Архитектурын байгууламж | нийт үнийн 2% | |

Татварын албанаас татвар төлөгч хувь хүнд татвар төлөх талаархи мэдээллийг заавал явуулах ёстой бөгөөд хэрэв хувь хүн мэдээллийг хүлээн аваагүй бол татвар төлөх үүрэг үүсэхгүй онцлогтой. Харин хуулийн этгээд татвар төлөгчийн хувьд ийм ажиллагаагүйгээр татвараа төлөх үүрэгтэй.

| | |
|---|---|
| **Татвараас чөлөөлөх хэлбэрүүд** | – нутгийн захиргааны байгууллагын хөрөнгө,<br>– элчин сайдын яамны эзэмшилд байгаа хөрөнгө,<br>– түүхт дурсгалын шинжтэй хөрөнгө,<br>– дунд болон дээд сургууль, спорт талбай. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*4.2.3. Авто тээврийн татвар*

Өмнө нь бүх авто тээврийн хэрэгслээс татвар авдаг байсан учир 1998 он хүртэл орон нутагт авто тээврийн татварын ач холбогдол маш их байсан. 1998 оноос уг татварын суурь цөөрч, зөвхөн 2-оос их тонн даацтай ачааны машин, трактор, автобус болон 5-аас их тонн даацтай чиргүүл зэргээс татвар авах болсон. Уг татварын субъект нь дээрхи авто тээврийн хэрэгслийг эзэмшигч хувь хүн, хуулийн этгээд байна.

Татварын хувь хэмжээ нь тракторын хувьд хөдөлгүүрийн багтаамж, автобусны хувьд суудлын тоо, ачааны тэрэг, чиргүүлийн хувьд даацын хэмжээ зэргээс хамаарч янз бүр байна.

*4.2.4. Орон нутгийн бусад татвар*

Дээр дурьдсан гурван татвар нь орон нутгийн төсөвт хамгийн их ач холбогдолтой. Харин үйл ажиллагааны татвар, өв залгамжлал болон бэлэглэлийн татвар, жижиг бизнесийн татвар зэрэг бусад орон нутгийн татвар нь ач холбогдолын хувьд бага юм. Эдгээр орон нутгийн татварын хувь хэмжээг нь төв засгийн газар тогтоох бөгөөд нутгийн удирдлагын хэмжээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах эрхгүй.

Жижиг үйлдвэр, таксины жолооч, үсчин зэрэг хувь хүн, хуулийн этгээд нь жижиг бизнесийн татар төлөгч, харин үйл ажиллагааны татварыг үл хөдлөх хөрөнгө болон авто тээврийн хэрэгсэл зэргийг зарж борлуулсны орлогод татвар ногдуулдагаараа энэ хоёр татвар ялгаатай.

Ойн татварын үндсэн зарчим нь газар тариалангийн татвартай төстэй, харин татварын хувь хэмжээ нь м3 ойн талбайг зах зээлийн үнээр тооцдог байна.

## 5. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

5.1. Хууль, эрх зүйн орчин

БНСУ-ын Үндсэн хуульд орон нутгийн өөрөө удирдах ёсны үндсэн зарчмыг тусган заасны дагуу орон нутгийн удирдлагад өөрийн нутаг дэвсгэрт орон нутгийн татвар ногдуулах, хураах эрхийг олгосон байна. ***Орон нутгийн татварын тухай хууль***, Орон нутгийн татварын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар Ерөнхийлөгчийн зарлиг болон Сангийн сайдын шийдвэр зэрэг нь татварын эрх зүйн эх сурвалж болж байна.[38]

5.2. Орон нутгийн татвар

Солонгосын орон нутгийн татварын тогтолцоо нь муж, хот болон дүүрэгт хамаарах ялгамжтайгаар 16 татвараас бүрдэнэ.

Хүснэгт 9. **Орон нутгийн албан татваруудын төрөл**

| | **Мужийн татвар** | **Хот, дүүргийн татвар** |
|---|---|---|
| ***Ердийн татвар*** | 1. үл хөдлөх хөрөнгө болон эрх эзэмшсний татвар,<br>2. бүртгэлийн татвар,<br>3. амралтын татвар,<br>4. лицензийн татвар. | 1. оршин суугчийн татвар;<br>2. үл хөдлөх хөрөнгийн татвар;<br>3. автомашины татвар;<br>4. газар тариалангийн орлогын татвар;<br>5. махны татвар;<br>6. тамхины татвар;<br>7. моторын түлшний татвар; |
| ***Тогтоосон татвар*** | 5. олон нийтэд зориулсан үйлчилгээний татвар;<br>6. орон нутгийн хөгжлийн татвар;<br>7. орон нутгийн боловсролын | 8. орон нутгийн төлөвлөлтийн татвар;<br>9. бизнесийн байрлалын татвар; |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[38] Korean Taxation. ***Эх сурвалж:*** http://www.nts.go.kr/eng/ – National Tax Service

| | | |
|---|---|---|
| | татвар. | |

*5.2.1. Хөрөнгө болон эрх эзэмшсэний татвар*

Үл хөдлөх хөрөнгө болон эрх эзэмшсэний татвар төлөгч нь үл хөдлөх хөрөнгө, автомашин, хүнд тоног төхөөрөмж, мод, усан онгоц, нисэх онгоц, мөн гольфийн гишүүнчлэл, хамтран эзэмшигч, эрүүл мэндийн клубын гишүүнчлэл зэргийг худалдан авсан эсвэл өв залгамжлалаар эзэмшигч болсон этгээд байна.

Үл хөдлөх хөрөнгө болон эрхийг эзэмшилдээ авсан үеийн нэрлэгдсэн үнээр үнэлгээг тогтоох ба 1) үл хөдлөх хөрөнгийн үнийн 2%; 2) зуслангийн харш, өндөр зэрэглэлийн байшин, гольфийн сургалтын эрх, тансаг зэрэглэлийн зугаа цэнгээний газар, тансаг зэрэглэлийн усан онгоц 500%; 3) Сөүлийн хотод хүн амын өсөлт нь хязгаарлагдсан тусгай нэрлэгдсэн газар байрлаж байгаа бол 300%-ийн татвар төлнө.

| | |
|---|---|
| **Татвараас чөлөөлөх хэлбэр** | – улсын, орон нутгийн удирдлага, эсвэл гадаадын засгийн газрын эзэмшилд байгаа бол,<br>– ашгийн бус байгууллага шашны, эсвэл боловсролын үйлчилгээг тохижуулах зорилготой бол,<br>– газрыг албадан хураасан, эсвэл байгалийн гамшигийн дараа засгийн газраас нөхөн олговороор эзэмшсэн бол,<br>– үйлдвэрийн газрыг орон нутаг руу шилжүүлэн нүүлгэж байгаа бол,<br>– хувийн хэрэгцээнд эзэмшиж байгаа суудлын автомашин,<br>– гэр бүл салалтын дараа эд хөрөнгө хуваасны үр дүнд бий болсон хөрөнгө. |

*5.2.2. Бүртгэлийн татвар*

Бүртгэлийн татвар төлөгч нь эзэмшсэн, бүтээсэн, шилжүүлсэн, өөрчилсөн, эсвэл хөрөнгийн эрхийн алдаа болон хуульд заасан бусад төрлүүдийг бүртгүүлэх үүрэг үүссэн этгээдүүд байна. Улсын болон орон нутгийн засгийн газрын бүртгэл, Солонгост байрлаж байгаа гадаад улсын засгийн газрын бүртгэл, шашин болон боловсролын байгууллагыг тохижуулах үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагын аливаа бүртгэлийг татвараас чөлөөлнө.

Хуулийн онцлог зохицуулалт бол байгууллага орон нутаг руу нүүх нь тусгай нөхцөлтэйд орж байгаа тул бүртгэлийн хураамжаас чөлөөлнө. Харин эсрэгээрээ буюу хөдөөнөөс гол хотууд руу нүүх байгууллагын бүртгэлийн татвар гурав дахин нэмэгдэх аж.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*5.2.3. Бусад татвар*

| **Татварын төрөл** | **Объект / Суъект** | **Татвар тооцох үзүүлэлт / хувь хэмжээ** |
|---|---|---|
| **Амралтын татвар** | 1. морины уралдааныг зохион байгуулах болон уралдааны тасалбар борлуулдаг Солонгосын морины холбоо,<br>2. унадаг дугуйн болон завьны уралдаан зохион байгуулдаг Үндэсний спортод дэмжлэг үзүүлэх байгууллага болон орон | Амралтын татварт борлуулсан тасалбараас олсон орлогоос 10 хувийг төлнө. |

| | | |
|---|---|---|
| | нутгийн бие даасан байгууллагууд,<br>3. Уламжлалт бухын тулааны тухай хуульд заасан бухын тулааны зохион байгуулагчид. | |
| **Лицензийн татвар** | Бүх төрлийн лиценз авсан этгээд. | Зөвшөөрөл авсан лицензийн тоогоор. |
| **Олон нийтэд зориулсан үйлчилгээний татвар** | Галын үйлчилгээ, хаг хаягдлын систем, муу усны систем, эсвэл үүнтэй төстэй үйл ажиллагаа явуулж орлого олдог этгээд. | 1. Галын үйлчилгээнээс олсон орлого:<br>6 сая хүртэл вон – 0.05 %,<br>13 сая хүртэл вон – 0.06 %,<br>26 сая хүртэл вон – 0.07 %,<br>39 сая хүртэл вон – 0.09 %,<br>64 сая хүртэл вон – 0.11 %,<br>64 саяас их вон – 0.13 %.<br>2. Нефть хадгалалт, шатахуун түгээх станц, нефть цэвэршүүлэх үйлдвэр, их дэлгүүр, зочид буудал зэргээс олсон орлого нь стандарт үзүүлэлттэй бол 0.023%, харин стандарт үзүүлэлт 200% хүрсэн бол галын үйлчилгээний олсон орлогын хувьтай адил байна. |
| **Орон нутгийн хөгжлийн татвар** | 1. Байгалийн эх үүсвэрээс авч байгаа бол,<br>2. Боомтоор тээвэрлэн оруулж ирж байгаа, гаргаж байгаа бол | 1. Цахилгаан үйлдвэрлэх зориулалттай 10м$^3$ ус тутамд 2 вон,<br>2. Газар доогуур 1м$^3$ ус тутамд 20-200 вон,<br>3. Контейнерт байгаа ус 1 TEU тутамд 15,000 вон,<br>4. Цөмийн хүчний генератор: 1 kwh – 0.5 вон. |
| **Үл хөдлөх хөрөнгийн татвар** | Газар, барилга, байшин, хөлөг онгоцны эзэмшигч. | – улсын, орон нутгийн засгийн газрын болон гадаадын засгийн газрын эзэмшилд байгаа бол,<br>– ашгийн бус байгууллага шашны, эсвэл боловсролын үйлчилгээг тохижуулах зорилготой бол,<br>– хөрөнгийн өртөг нь 2 000 саяас бага бол. |
| **Махны татвар** | Нядалгааны бод мал, гахай. | Зах зээлийн ханшаар |
| **Тамхины татвар** | 1. Тамхны онцгой эрхийн тухай хуулийн дагуу бэлэн тамхи худалдаалагч, | |

UH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | 2. Тамхи импортологч. | |
| **Моторын түлшний татвар** | Авто тээвэр, эрчим хүч, хүрээлэн байгаа орчны татвар төлөгчид хамаарна. | Бензин, дизел түлшны болон бусад ижил төстэй тосонд 26.5%. |
| **Орон нутгийн төлөвлөлтийн татвар** | Тухайн орон нутагтаа газар, эсвэл байшин эзэмшигч. | Стандарт хувь хэмжээ нь тухайн газар, байшингийн өртөгийн 0.15%. Гэхдээ орон нутгийн захирагч нөхцөл байдлаас хамаарч татварын хувь хэмжээг 0.23%-ийн хязгаарт багтаан өөрчлөх эрхтэй. |
| **Бизнесийн байрлалын татвар** | 1. Үйл ажиллагаанnetwork тухай жил бүрийн 7-р сарын 1-нд бүртгүүлдэг худалдаачин,<br>2. Ажилчдыг хөлсөлж ажиллуулдаг худалдаачин. | 1. Хөрөнгийн 1 м2 тутамд 250 вон,<br>2. Ажилтан бүрт 0.5%. |

**Хавсралт 1.**

Болгарын засаг захиргааны нэгж

| *№* | **Мужийн нэр** | **Нутаг дэвсгэр** *(км$^2$)* | **Хүн ам** *(2005 оны байдлаар)* | **Хүн амын нягтшил** *(1 км$^2$)* | **Хотын захиргаа** |
|---|---|---|---|---|---|
| 1. | Blagoevgrad | 6,478 | 334,907 | 51.70 | 14 |
| 2. | Burgas | 7,618 | 418,925 | 55.00 | 13 |
| 3. | Dobrich | 4,700 | 206,893 | 44.02 | 8 |
| 4. | Gabrovo | 2,053 | 135,780 | 66.96 | 4 |
| 5. | Haskovo | 4,033 | 268,335 | 66.53 | 11 |
| 6. | Kardzhali | 4,032 | 159,878 | 39.65 | 6 |
| 7. | Kyustendil | 3,027 | 154,468 | 51.03 | 9 |
| 8. | Lovech | 4,134 | 159,214 | 38.99 | 8 |
| 9. | Montana | 3,595 | 166,775 | 47.35 | 11 |
| 10. | Pazardzhik | 4,393 | 300,092 | 68.31 | 11 |
| 11. | Pernik | 2,377 | 142,251 | 59.84 | 6 |
| 12. | Pleven | 4,216 | 305,025 | 73.64 | 11 |
| 13. | Plovdiv | 5,973 | 707,570 | 118 | 18 |
| 14. | Razgrad | 2,648 | 140,743 | 53.15 | 7 |
| 15. | Ruse | 2,616 | 256,835 | 99.07 | 8 |
| 16. | Shumen | 3,365 | 199,577 | 59.31 | 10 |
| 17. | Silistra | 2,862 | 135,701 | 47.41 | 7 |
| 18. | Sliven | 3,646 | 211,005 | 47.41 | 4 |
| 19. | Smolyan | 3,532 | 133,015 | 37.66 | 10 |
| 20. | Sofia (city) | 1,349 | 1,231,622 | 913 | 24 |
| 21. | Sofia (province) | 7,277 | 262,032 | 36.01 | 22 |
| 22. | Stara Zagora | 4,959 | 362,090 | 73.02 | 11 |
| 23. | Targovishte | 2,735 | 136,806 | 50.02 | 5 |
| 24. | Varna | 3,819 | 457,922 | 120 | 12 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 25. | Veliko Tarnovo | 4,684 | 283,599 | 60.99 | 10 |
| 26. | Vidin | 3,071 | 117,809 | 39.11 | 11 |
| 27. | Vratsa | 4,098 | 209,124 | 51.89 | 10 |
| 28. | Yambol | 4,209 | 147,906 | 35.14 | 5 |

**Хавсралт 2.**

Польшийн засаг захиргааны нэгж

| *№* | *Муж* | *Нутаг дэвсгэр (км$^2$)* | *Хүн ам (2005 оны байдлаар)* | *Хүн амын нягтшил (1 км$^2$)* |
|---|---|---|---|---|
| 1. | Mazowieckie | 35 558,18 | 5 188 488 | 145,9 |
| 2. | Dolnośląskie | 19 946,77 | 2 878 410 | 144,3 |
| 3. | Kujawsko-Pomorskie | 17 971,68 | 2 066 136 | 115,0 |
| 4. | Lubelskie | 25 122,49 | 2 166 213 | 86,2 |
| 5. | Lubuskie | 13 987,88 | 1 008 481 | 72,1 |
| 6. | Łydzkie | 18 218,96 | 2 555 898 | 140,3 |
| 7. | Małopolskie | 15 182,87 | 3 279 036 | 216,0 |
| 8. | Opolskie | 9 411,67 | 1 037 088 | 110,2 |
| 9. | Podkarpackie | 17 845,66 | 2 097 338 | 117,5 |
| 10. | Podlaskie | 20 187,01 | 1 192 660 | 59,1 |
| 11. | Pomorskie | 18 310,36 | 2 210 920 | 120,7 |
| 12. | Swiętokrzyskie | 11 710,20 | 1 275 550 | 108,9 |
| 13. | Śląskie | 12 333,51 | 4 650 300 | 377,4 |
| 14. | Wielkopolskie | 29 826,51 | 3 386 882 | 113,6 |
| 15. | Warmińsko-Mazurskie | 24 173,17 | 1 426 155 | 59,0 |
| 16. | Zachodniopomorskie | 22 892,48 | 1 692 271 | 73,9 |
| | **Rzeczpospolita Polska** | **312 685** | **38 636 157** | **123** |

**Хавсралт 3.**

Солонгосын засаг захиргааны нэгж

| | Нийслэл | **Төрөл** | **Муж** | **Хүн ам** *2000 оны байдлаар* | **Нутаг дэвсгэр** *(км$^2$)* | ***Хүн амын нягтшил*** *(1 км$^2$)* |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Seoul | Special City | Sudogwon | 10,421,782 | 605.25 | 17,219 |
| 2 | Busan | Metropolitan City | Yeongnam | 3,635,389 | 763.46 | 4,762 |
| 3 | Incheon | Metropolitan City | Sudogwon | 2,628,000 | 964.53 | 2,724.6 |
| 4 | Daegu | Metropolitan City | Yeongnam | 2,512,604 | 884.15 | 2,842 |
| 5 | Gwangju | Metropolitan City | Honam | 1,415,953 | 501.36 | 2,824 |
| 6 | Daejeon | Metropolitan City | Hoseo | 1,442,857 | 539.84 | 2,673 |
| 7 | Ulsan | Metropolitan City | Yeongnam | 1,087,958 | 1,056.4 | 1,030 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Gyeonggi | Province | Sudogwon | 10,415,399 | 10,131 | 1,028 |
| 9 | Gangwon | Province | Gwandong | 1,592,000 | 16,894 | 94 |
| 10 | Chungcheongbuk | Province | Hoseo | 1,462,621 | 7,436 | 197 |
| 11 | Chungcheongnam | Province | Hoseo | 1,840,410[5] | 8,352[5] | 220[5] |
| 12 | Jeollabuk | Province | Honam | 1,890,669 | 8,043 | 235 |
| 13 | Jeollanam | Province | Honam | 1,994,287 | 11,858 | 168 |
| 14 | Gyeongsangbuk | Province | Yeongnam | 2,775,890[6] | 19,440[6] | 143[6] |
| 15 | Gyeongsangnam | Province | Yeongnam | 2,970,929 | 11,859 | 251 |
| 16 | Jeju | Special Self-governing Province | Jejudo | 560,000 | 1,845.55 | 303 |

**Хавсралт 4.**

Хүснэгт 4-1. **Үйлдвэр болон фермерийн барилгаас бусад бүх байгууламжийг байрлалын коэффициэнт**

| Category | Zone | | | | | Within constr. bounda-ries | Out of constr. bounda-ries | Villa zone | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I | II | III | IV | V | | | I cat. | II cat. |
| Sofia | 93,6 | 74,9 | 63,2 | 42,1 | 28,1 | 25,7 | 23,4 | 65,5 | 37,4 |
| Varna | 88,9 | 70,2 | 56,2 | 42,1 | 28,1 | 25,7 | 23,4 | 60,8 | 32,8 |
| Burgas | 67,9 | 58,5 | 51,5 | 35,1 | 23,4 | 21,1 | 18,7 | 51,5 | 23,4 |
| Stara Zagora | 63,2 | 53,8 | 44,5 | 33,9 | 23,4 | 21,1 | 18,7 | 44,5 | 23,4 |
| Plovdidv | 58,5 | 49,1 | 37,4 | 32,8 | 23,4 | 21,1 | 18,7 | 37,4 | 23,4 |
| I, 1 group | 49,1 | 37,4 | 30,4 | 23,4 | 21,1 | 18,7 | 16,4 | 28,1 | 21,1 |
| I, 2 group | 31,5 | 22,5 | 15,8 | 11,3 | 0,0 | 9,0 | 6,8 | 13,5 | 11,3 |
| II category | 21,6 | 13,0 | 10,8 | 8,6 | 0,0 | 6,5 | 5,4 | 8,6 | 6,5 |
| III category | 11,9 | 8,6 | 6,5 | 0,0 | 0,0 | 5,4 | 4,3 | 6,5 | 5,4 |
| IV, V | 6,5 | 4,3 | 0,0 | 0,0 | 0,0 | 4,3 | 3,2 | 5,4 | 4,3 |
| VI, VII, VIII | 3,2 | 0,0 | 0,0 | 0,0 | 0,0 | 2,4 | 2,2 | 2,8 | 2,6 |

Хүснэгт 4-2.

**Арилжааны байгууллагын байгууламжийг байрлалын коэффициэнт**

Арилжааны байгууллагад дэлгүүр, эмийн сан, павильон, мухлаг, бөөний борлуулалтын агуулах, шатахуун түгээх станц, диско клуб, ресторан, зуушны газар, бар, уушийн газар, кафе, зочид буудал, буурчийн газар, мөрийтэй тоглоомын газар орно.

| Category | Location | | | |
|---|---|---|---|---|
| | favourable | | unfavourable | |
| | produc-tion | farm | produc-tion | farm |
| Sofia | 23,4 | 16,4 | 17,3 | 10,8 |
| Varna | 22,2 | 15,7 | 16,4 | 10,4 |
| Bourgas | 21,1 | 14,7 | 15,6 | 9,7 |
| Stara Zagora | 20,5 | 14,4 | 15,1 | 9,4 |
| Plovdiv | 19,9 | 14,0 | 14,7 | 9,1 |
| I, 1 group | 16,4 | 11,5 | 12,1 | 7,6 |
| I, 2 group | 14,0 | 9,9 | 10,4 | 6,5 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| II | 11,7 | 8,2 | 8,6 | 5,4 |
| III | 7,0 | 4,9 | 5,2 | 3,2 |
| IV, V | 4,7 | 3,3 | 3,5 | 2,2 |
| VI, VII, VIII | 2,3 | 1,6 | 1,7 | 1,1 |

Хүснэгт 4-3.
**Дэд бүтцийн коэффициент**

Ci = 1 + A + B + C + D + E + F.

| **Elements** | **Value of the elements** | | |
|---|---|---|---|
| | **available** | **not available** | **not in the building but in the quarter** |
| A. Water supply | 0.0 | -0.05 | -0.03 |
| B. Sewerage | 0.0 | -0.05 | -0.03 |
| C. Electricity | 0.0 | -0.07 | -0.05 |
| D. Telephone | 0.0 | -0.02 | -0.02 |
| E. Heating | +0.06 | 0.00 | 0.00 |
| F. Street network | 0.0 | -0.08 | -0.08 |

Хүснэгт 4-3.
**Давхрын коэффициент**
Cc = 1 + k1 + k2 + k3,

| **The site is located on** | **Correction (k1)** | | | |
|---|---|---|---|---|
| | **buildings with 6 and more floors without lift** | | **other buildings** | |
| | **non residential** | **flats** | **non residential** | **flats** |
| 1. First floor | +0.10 | -0.05 | +0.10 | -0.05 |
| 2. Second to fifth floor | -0.03 | +0.03 | 0.00 | +0.03 |
| 3. Sixth and next floors | -0.10 | -0.03 | -0.08 | -0.03 |

Хүснэгт 4-4.
**Биеэт байдлын коэффициент**

- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулü. (2005)
- ХЗХ-ны тухай хуулийн төсөл. Улаанбаатар, Монгол Улс. 2007 он.
- **ÀÍ Ó:** The Federal Credit Union Act, revised 1998. Chapter 14 of Title 12 of the United States Code.
- **ÁÍ ×åõ óëñ:** Act No. 87/1995 Coll. Relating to Savings and Credit Cooperatives, effective January 1, 1996; as amended by Law No. 100/2000 Coll., effective May 1, 2000.
- **ÁÍ Óçáåêèñòàí óëñ:** The law of the Republic of Uzbekistan on Credit Unions, 2002.
- **Èõ Áðèòàí è:** Credit Unions Act, 1979.
- **Ëèòâà óëñ:** Law on the Amendment of the Law on Credit Unions, No I-796 (18 May 2000 No. VIII-1683).
- **Õîí êîí ã:** Credit Unions Ordinance (Chapter 119), amended June 1, 1995.

- Model law. **Developed and recommended by World Council of Credit Unions, Inc.** 2005 Published by World Council of Credit Unions, Funded by USAID
- Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны үйл ажиллагааны тайлан.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны үйл ажиллагааны тайлан.
- Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын 2008 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

- http://exchange-rates.org/Rate/
- http://www.frc.mn/index.php
- http://www.imf.org/external/ns/search.aspx?lan=eng&NewQuery=Savings%20and%20Credit%20Cooperatives&col=SITENG&page=2&sort=Score&Filter_Val=N
- http://www.woccu.org/


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЗАРИМ ХУУЛИУДЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

*Ц.Норовдондог/Ph.D/, Ц.Батбаяр, Ц.Батдорж, Б.Буяндэлгэр, Г.Билгээ, Т.Мягмаржав, Д.Мягмарцэрэн, Б.Мөнхцэцэг, О.Нарантуяа, Ч.Онончимэг, А.Пагма, Ц.Элбэгзаяа*

## ГАРЧИГ

**Нэг.** **Монгол Улсын төсвийн тухай хуулиуд:**

*/Гүйцэтгэсэн судлаач Ц.Батдорж/*

1. Монгол улсын нэгдсэн төсвийн тухай,
2. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай

**Хоёр.** **Татварын холбоотой хуулиуд:**

*/Гүйцэтгэсэн судлаач Г.Билгээ/*

3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
4. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/
5. Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/
6. Хувь хүний орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/

**Гурав.** **Банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хуулиуд:**

*/Гүйцэтгэсэн судлаач Ц.Элбэгзаяа/*

7. Төв банк /Монголбанк/-ны тухай
8. Банкин дахь мөнгөн хадгаламжийн баталгаа гаргах тухай
9. Банкны тухай

Банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хуулиуд, тэдгээрийн үзэл баримтлалын түүвэр, хүснэгт

- Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай
- Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай
- Төв банкны тухай болон Банкны тухай
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай

**Дөрөв.** **Валютын арилжаа, гадаад худалдаа, зээл тусламжийн талаар холбоотой хуулиуд:**

*/Гүйцэтгэсэн судлаач Ц.Батбаяр/*

Валютын арилжаа, гадаад худалдаа, зээл тусламжийн талаарх холбоотой хуулиуд тэдгээрийн үзэл баримтлалын түүвэр, хүснэгт

- Валютын зохицуулалтын тухай
- Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай
- Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай
- 

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Тав.** **Компани, аж ахуйн нэгж, хоршооны талаар холбоотой хуулиуд:**

*/Гүйцэтгэсэн судлаач Т.Мягмаржав/*

- Нөхөрлөлийн тухай
- Хоршооны тухай /шинэчилсэн найруулга/
- Компанийн тухай

**Зургаа.** **Ашигт малтмалын талаар холбогдох хуулиуд**:

*/Гүйцэтгэсэн шинжээч Д.Мягмарцэрэн/*

- Ашигт малтмалын тухай /шинэчилсэн найруулга/
- Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийнүзэл баримтлал, танилцуулгын харьцуулалт

**Долоо.** **Монгол Улсыг хөгжүүлэх сан болон бусад сангийн үйл ажиллагааны талаар холбоотой хуулиуд:**

*/Гүйцэтгэсэн шинжээч А.Пагма/*

- Засгийн газрын тусгай сангийн тухай
- Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай
- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай

Монгол Улсыг хөгжүүлэх сан болон бусад сангийн үйл ажиллагааны талаар холбоотой хуулиуд тэдгээрийн үзэл баримтлалын түүвэр, хүснэгт

- Засгийн газрын тусгай сангийн тухай
- Монгол Улсын хөгжүүлэх сангийн тухай
- Хүний хөгжил сангийн тухай

**Найм.** **Эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын талаар холбоотой хуулиуд:**

*/Гүйцэтгэсэн Ахлах референт Б.Буяндэлгэр, судлаач О.Нарантуяа/*

- Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай
- Замын Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай
- Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай

Эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын талаар холбоотой хуулиуд тэдгээрийн үзэл баримтлалын түүвэр, хүснэгт

- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай
- Чөлөөт бүсийн тухай
- “Алтанбулаг” чөлөөт бүсийн эрхй зүйн байдлын тухай
- “Цагаан нуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай
- “Замын Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Ес. Аудитын /хяналт шалгалт/ талаар**

*/Гүйцэтгэсэн судлаач Б.Мөнхцэцэг/*

- Аудитын тухай
- Төрийн аудитын тухай
- Эрдэнэсийн сангийн тухай

**Арав. Эдийн засгийн харилцааг зохицуулж буй бусад хуулиуд:**

*/Гүйцэтгэсэн судлаач Ч.Ононочимэг/*

- Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/
- Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай

Бусад эдийн засгийн эрх зүйн зохицуулалттай холбоотой хуулиуд тэдгээрийн үзэл баримталын түүвэр

- Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/
- Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай
- Улсын нөөцийн тухай

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИУД:

***Төсвийн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн орчны өнөөгийн байдал, уялдаа холбоо:***

Төсвийн хүрээний харилцааг зохицуулж буй гол хуулиуд, тэдгээрийн хамрах хүрээг ялган тодорхойлсноор төсвийн харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлжээ. Монгол Улсын Үндсэн хуульд (1992) Засгийн газрын бүрэн эрхэд улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, УИХ-д өргөн барьж, гарсан шийдвэрийг биелүүлэх, УИХ-ын бүрэн эрхэд төсөв хэлэлцэн батлахаар тодорхойлсон нь эрх зүйн үндсэн заалт болдог. Энэхүү зохицуулалт нь УИХ-ын тухай, Засгийн газрын тухай хуулиудад давхар хуульчлагджээ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтий тухай болон Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулиуд 2002 онд батлагдснаар төсөв, санхүүгийн тогтолцооны шинэчлэл эрчимжсэн. Доорх баримт бичгүүд нь өнөөгийн төсвийн харилцааг зохицуулж буй голлох эрх зүйн актууд юм. Эдгээрийн үндсэн агуулгыг товчхон дурдахад:

Нэгдсэн төсвийн тухай хууль нь Монгол Улсын нэгдсэн төсөв, түүний бүтэц бүрэлдэхүүн, төсөв захирагчийн эрх, үүрэг, төсвийн орлого, зарлагын ангилалд төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, төсвийн бүртгэлтэй холбогдсон төсвийн ерөнхий харилцааг зохицуулж байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль (ТБУСТХ) нь төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнах үйл явц, төсвийн талаархи төрийн байгууллага,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

албан тушаалтны эрх, үүрэг, төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны удирдлагын зарчим, улсын болон орон нутгийн төсвийн харилцаа, төсвийн хяналт, хариуцлага зэрэг төсвийн үйл явцтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуулиар бүх шатны Засаг даргын хяналт, шалгалт хийх бүрэн эрх, төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийг хуульчилжээ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс, төсөв, ИТХ, Засаг даргын бүрэн эрх, баг хорооны Засаг даргын цалин, бусад зардлын эх үүсвэрийг тодорхойлсон байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (ЗГҮАХ)-т Засгийн газраас бүрэн эрхийнхээ хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжил, төрийн удирдлагын хүрээний асуудлаар хийж гүйцэтгэх ажлын гол зорилт, хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээг тодорхойлохоор Засгийн газрын тухай хуульд заажээ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь Монгол Улсын Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн стратеги, хөтөлбөр, ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэхэд тухайн жилд төреөс баримтлах бодлогыг тодорхойлсон баримт бичиг юм. Үүнтэй агуулгаараа адил ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газраас батлан хэрэгжүүлж байна.

ТБУС тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш төсвийн төлөвлөлтөд баримтлах бодлогод зарчмын өөрчлөлт шинэчлэлт хийгдэж түүнд тулгуурлан боловсруулсан төсвийн байгууллагын хэтийн болон дунд хугацааны төлөвлөгөө, Төсвийн хүрээний мэдэгдэл (ТХМ), холбогдох байгууллагаас гаргасан удирдамж, чиглэл, төсвийн төслийг зохиох үндэс бий болгожээ.

Харин төсвийн төсөл боловсруулах үе шатанд төсвийн ерөнхийлөн захирагч төсвийг зориудаар төсөвт онд бага орлого төлөвлөж батлуулдаг нь төсвийн төлөвлөгөө бодитой биш болдог. Татварын Ерөнхий Газрын харьяа орон нутгийн татварын байгууллагууд орлогын төлөвлөгөөг давуулж, давсан орлогоос нийгмийн арга хэмжээндээ зарцуулах фонд байгуулах, дээр нь өөрсдөө төлөвлөгөө биелүүлсний шагнал авах сонирхолдоо хөтлөгдөн татварын орлогын хэмжээг жил бүр шахуу бус, хялбархан биелэгдэхээр төлөвлөдөг.

*Үзэл баримтлалын агуулга:*

2002 онд "Нэгдсэн төсвийн тухай" хууль, "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай" хуулиуд батлагдсанаар төсвийн харилцааг зохицуулж буй 2 гол хуультай болсон юм. Энэхүү төсвийн харилцааг зохицуулж буй 2 гол хуулийн үзэл баримтлалын агуулгыг тус тусад нь салган авч үзье.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### 1. Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн үзэл баримтлалын агуулга:

*Хуулийг боловсруулах шаардлага үндэслэл*:

Монгол Улсын Их хурлаас 2002 оны 6-р сарын 27-ны өдөр Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг батлан гаргасантай холбогдуулан Монгол улсын төсвийн тухай хуулиар зохицуулагдаж байсан улсын төсөв, санхүүтэй холбогдсон зарим харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулах шаардлагагүй болж, эдгээр хуулиудад давхардаж байгаа заалтуудыг нягтлан үзэж, давхардлыг арилгах шаардлага үүсч байна.

Цаашдаа Монгол улсын Төсвийн тухай хууль нь анхан шатны төсөвт байгууллагатай холбогдсон болон улсын төсвийг боловсруулж батлахтай холбогдсон харилцааг зохицуулахгүй бөгөөд Монгол улсын төсөв, төсвийн бүртгэл, төсвийн орлого, зарлагын ангилал, төсвийн талаар баримтлах зарчим, төсвийн талаархи төрийн захиргааны төв байгууллагуудын эрх, үүргийг тодорхойлох, УИХ-аас батлагдсан төсвийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах юм гэж үзэж Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулжээ.

*Хуулийг боловсруулахад баримталсан зарчим:*

Төсөв санхүүгийн талаархи хууль тогтоомжийг батлан мөрдүүлж байгаа Англи, Герман зэрэг улс орнуудын туршлагаас үзвэл төсвийн талаархи ерөнхий зарчмуудыг тогтоосон Төсвийн тухай хууль, төсөвт байгууллагуудын төсвийн талаархи үүрэг, хариуцлагыг тодорхойлсон нэр бүхий хуулиар тусгайлан зохицуулдаг байна. Энэ жишгээс үзвэл Төсвийн тухай хууль нь Монгол улсын төсөвт тавигдах үндсэн шаардлага, зарчмыг тусгасан тулгуур шинжтэй хууль эрх зүйн акт байх ёстой юм.

Төсвийн тухай хуулиар зохицуулах шаардлагатай асуудлууд:

- Төсвийн талаархи Санхүү, эдийн засгийн төв байгууллагын эрх, үүрэг
- Төсвийн бүртгэл
- Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилж, чөлөөлөх
- Төсвийн орлого, зарлагын ангилал
- Төсвийн гүйлгээг гүйцэтгэх зэрэг асуудлуудыг хамруулав.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн сайдын эрх, үүргийг тусгасан байгаа боловч эдгээр эрх, үүрэг нь санхүү, эдийн засгийн үндсэн зарчмын асуудлыг голчлон хөндөж байгаа тул улсын төсвийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим үүргийг төсвийн тухай хуульд тодорхой тусгах шаардлагатай гэж үзэж хуулийн төсөлд тусгав.

Хуулийн төслийг Монгол улсын Үндсэн хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон бусад хуулиудад нийцүүлэн боловсруулжээ. Төсвийн тухай хууль нь дээрхи үндсэн бүлэг асуудлыг тусган боловсруулагдахаар тусгагдсан байна.

*Хуульд тусгагдсан байдал:*

Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн үзэл баримтлалд тусгагдсан асуудлуудыг хуульд дараах байдлаар суулгаж өгчээ:

- 6 дугаар зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг. Хуулийн үзэл баримтлалд Төсвийн талаархи Санхүү, эдийн засгийн төв байгууллагын эрх үүргийн талаар тусгаж өгсөн бөгөөд хуулийн эцсийн найруулагын 6-р зүйлд шат шатны байгууллагын эрх үүргийг тодорхой заасан байна.
- 7 дугаар зүйл. Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх. Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг шат шатанд нь төсвийн ерөнхийлөн захирагч гэх ба түүнийг томилох чөлөөлөх эрх үүргийн талаар 7.1, 7.1.1, 7.1.2-т тусгасаж өгчээ.
- 8 дугаар зүйл. Төсвийн орлого
- 11 дүгээр зүйл. Төсвийн зарлага. 8 болон 11 зүйлд төсвийн орлого, зарлагийн ангилал тэдгээрийн шат шатны бүрэлдэхүүнийг тусгажээ.
- 14 дүгээр зүйл. Төсвийн өдөр тутмын гүйлгээг гүйцэтгэх. Энэ зүйлд Төсвийн өдөр тутмын гүйлгээг гүйцэтгэх эрх бүхий байгууллагуудын эрх үүргийг тодорхойлж өгсөн байна.

UIH MN СУДАЛГААНЫ САН

- 16 дугаар зүйл. Төсвийн бүртгэл Төсвийн бүртгэлийг олон улсын стандарт болон энэхүү стандартад нийцүүлэн дагаж мөрдөх заавар, аргачлалыг баталж мөрдүүлэх төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий субьектийн эрхийг олгосон байна.

***2. Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн үзэл баримтлалын агуулга:***

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн төслийн талаар Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих хугацаанд нийгмийн амьдралын бүх салбарт ихээхэн өөрчлөлт гарч буй энэ үед төрийн удирдлага, төсвийн санхүүжилтийн шинэчлэлийг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Өнгөрсөн хугацаанд төрийн хариуцах үүрэг болон гүйцэтгэх засаглалын байгууллагуудын эрхлэх ажлын мөн чанар, өмчийн харилцаанд зарчмын өөрчлөлт гарч, төрийн албаны шинэ тогтолцоо бүрэлдэн, хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг, түүний нийгэмд үзүүлэх нөлөө өдрөөс өдөрт өсөн бэхжиж байгаа нь төсвийн харилцааны зохицуулалтыг нийгмийн хөгжлийн өнгө аяст нийцүүлэн өөрчлөх зүй ёсны шаардлагатай болж байна.

Иймээс энэхүү хууль болон түүний үндсэн дээр хийгдэх шинэчлэлийн зорилго нь төсвийн харилцааг боловсронгуй болгож, нэг талаас ард түмнийг төлөөлөн төрийн өмчийг өмчлөгч төр буюу тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нийгмийн өмчийн зүйлсийг өмчлөгч Иргэдийн  төлөөлөгчдийн 1 хурал, нөгөө талаас улсын төсвийн нийт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, мөн тэдгээр өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага хоорондын харилцааг үйл ажиллагааны эцсийн үр дүнд чиглүүлэн цогц байдлаар зохицуулах асуудал юм.

Өөрөөр хэлбэл эдгээр байгууллагын зорилт, үр дүнг төлөвлөх, төсөвлөх, түүнийг хэрэгжүүлэх ажлын явц байдлыг хянан зохицуулж, үр дүнг нь үнэлэн, урамшуулах эсхүл хариуцлага тооцдог санхүү төсөв, удирдлагын иж бүрэн тогтолцоо бий болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

*Хуулийн ач холбогдол гарах үр дүн:*

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлагдсанаар

1. Төсвийн хөрөнгө нэгэнт зарцуулагдсаны дараа тухайн байгууллагын үйл ажиллагааг дүгнэдэг журмыг шинэчилж, ямар зорилт дэвшүүлэн, үйл ажиллагаа хэрхэн явуулж, ямар үр дүнд хүрэх гэж байгааг тодорхойлсны дараа санхүүжүүлдэг журамд шилжинэ.

2. Төсвийн шууд захирагчид төсвийн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тодорхой албан тушаалтны өмнө хүлээж буй үүрэг хариуцлага нь тодорхой бус байгаа журмыг өөрчилж, төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн байгууллагын ерөнхий менежертэй гэрээ байгуулснаар үр дүнг нь үнэлж урамшуулал, хариуцлага тооцдог журамд шилжинэ.

3. Байгууллага, бүтэц, орон тоо бүрийг санхүүжүүлдэг журмыг шинэчлэн, тухайн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагаа нь төрөөс зайлшгүй үзүүлэх ёстой ажил, үйлчилгээ мөн эсэхийг тодорхой шалгуураар тогтоож байж төсвөөс санхүүжүүлэх эсэхийг шийддэг журамд шилжинэ.

4. Төсвийн байгууллагын өмчлөлийн ашиг сонирхлын болон менежментийн асуудлын хүрээ зааг тодорхойгүй байсныг арилгаж өмчлөгч-төр буюу түүнээс эрх олгосон

UIH.MN СУДАЛГААНЫ САН

этгээд өмчлөгчийн ашиг сонирхлыг хөндсөн бодлогын шинжтэй асуудал болон байгууллагын менежментийн асуудлын хүрээ зааг тодорхой болно.

5. Төсвийн байгууллага, албан тушаалтны улсын төсвийн талаархи эрх, үүргийг нарийвчлан зохицуулаагүй байсан 2 хуулийн хийдлийг арилгаж, эрх үүрэг нь хуулиар зохицуулагдах юм.

6. Одоо мөрдөж байгаа Монгол Улсын төсвийн тухай хуульд зөвхөн төсөв зохиох, хянах, батлах, төсвийн орлогыг бүрдүүлэх, хуваарилах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа явцуу байдлыг арилгаж эдгээр харилцааг төдийгүй мөн тэдгээрт тавигдах шаардлагыг хуульчлан баталгаажуулж байгаагаараа төсвийн сахилгыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

7. Төрийн албаны төв байгууллага нь төрийн захиргааны удирдах албан тушаалд томилогдох ажилтны талаар дүгнэлт гаргаж уг ажилтныг томилох эрх бүхий байгууллагад өгч байсан журамд өөрчлөлт оруулж, улмаар төсвийн байгууллагын ерөнхий менежер болон ажилтныг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох журмыг боловсруулж Улсын Их Хурлаар батлуулан, улсын төвлөрсөн төсвийн байгууллагын ерөнхий менежер, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий менежер, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилоход сонголт хийх боломжтой тооны хүмүүсийг нэр дэвшүүлж, томилох эрх бүхий этгээдэд санал болгон, хэрхэн сонгосноо, нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтын хамт нийтэд мэдээлэх, дээрх албан тушаалтны үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг үндэслэн урамшууллынх нь талаархи холбогдох этгээдэд санал оруулах, төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох удирдах албан тушаалтантай, ерөнхий менежер төсвийн байгууллагын албан хаагчидтай байгуулах үр дүнгийн гэрээ, түүнийг дүгнэх заавар, журмыг батлах, биелэлтэд нь хяналт тавих, дүгнэх, төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг хангахтай холбогдсон боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэх үүргийг төсөлд тусгасан болно.

8. Төсвийн байгууллагын албан хаагчдын ижилсгэсэн цалин урамшууллын системийг боловсронгуй болгон байгууллагын бүтээгдэхүүн нийлүүлэхэд болон ажлын үр дүнг сайжруулах талаар тухайн албан хаагчийн оруулсан хувь нэмэр, байгууллагын нийт үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг харгалзан албан хаагчдад ажлын үр дүнгийн урамшуулал олгох эрхийг тухайн байгууллагын дарга эдлэх болно.

9. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бие дааж эрхлэн шийдвэрлэж байх асуудал тодорхойгүй байгаа одоогийн байдлыг арилгаж, тухайн орон нутгийн эрхлэх асуудал буюу орон нутгийн хэрэгцээнд нийлүүлэх үндсэн бүтээгдэхүүний нэр төрлийг тогтоож, ингэснээр төв болон орон нутгийн эрх мэдлийн хуваарилалт тодорхой болж "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэнэ" гэсэн Үндсэн хуулийн заалт хэрэгжиж эхлэх хууль зүйн баталгаатай болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

10. Аймаг, нийслэл болон Засгийн газар хоорондын санхүүгийн харилцааны зааг хүрээ тодорхой бус байсныг арилгаж, орон нутаг өөрийн хэрэгцээт үндсэн бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд шаардлагатай төсөвтэй байх, орон нутаг өөрийн хэрэгцээт үндсэн бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүнийг Засгийн газарт зөвхөн гэрээний үндсэн дээр улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр нийлүүлж байх болно.

11. Улсын Их Хурлын төрийн бодлого болон нийгэмд үзүүлэх ажил үйлчилгээг зөв тогтоох, үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломж, үүрэг нөлөө, чадавхи нэмэгдэнэ.

12. Засгийн газрын үйл ажиллагаа зах зээлийн эдийн засгийн шаардлагад илүү

нийцтэй болж, төсвийн хариуцлага, үр ашиг сайжран, нийтэд нээлттэй, ил тод болсноор Улсын Их Хурал, ард түмний зүгээс түүнийг хянах бололцоо өргөжнө.

13. Төр, засгийн хариуцах үүрэг тодорхой болохын хэрээр хувийн хэвшил, төрийн бус байгууллага, хувь хүний оролцоо хөгжих орон зай, сонирхол бий болон улмаар иргэний нийгэм төлөвшин сайн засаглал бүрдэх нэг үндэс бий болно.

14. Нийт төсвийн байгууллага төрийн бодлого, шийдвэрт захирагдаж шуурхай ажиллах чадвартай болж нийгэмд үзүүлэх үйлчилгээний чанар сайжран, татвар төлөгчдийн хөрөнгийг зарцуулах үүрэг, хариуцлага эрс нэмэгдсэнээр засаглал чадварлаг, мэдрэмжтэй болж төлөвших зэрэг асуудлуудыг зохицуулахаар тусгасан байна.

*Шинэ хуультай холбоотой бусад хуульд орох өөрчлөлт:*

Ажлын хэсэг хүлээсэн үүргийн дагуу Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг дагаж мөрдөхөд шилжих тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Энэхүү хуулийн төслийг дараахь зарчмаар боловсруулсан болно:

1. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн (ТБУСТХ) төсөл УИХ-аар батлагдмагц Засгийн газар болон аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр төвлөрсөн болон орон нутгийн төсөвтэй харилцагч байгууллагууд удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.

2. Зохих бэлтгэл хангасан байгууллагууд шинэ тогтолцоонд шилжих тул шилжсэн болон хараахан шилжээгүй байгууллагуудын ангилал үүсэх болно. Энэ тохиолдолд удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоонд шилжсэн байгууллагын төсөв, санхүү, удирдлагын зарчим ТБУСТХ-иар зохицуулагдах бөгөөд шилжиж амжаагүй байгууллагуудын хувьд одоо мөрдөж байгаа хуулиуд хэвээр үйлчилсээр байх болно. Ийнхүү нэгэн зэрэг хоёр төрлийн хууль үйлчлэх тохиолдолд ямар хуулийн ямар зүйл, хэсэг, заалт шинэ тогтолцоонд шилжсэн байгууллагуудад хэвээр үйлчлэх болон ямар нь түүнд хамаарахгүйг тогтоох шаардлагатай гэж үзсэн.

3. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд улсын төсөвт байгууллагын төсөв, санхүүгийн болон удирдлагын бусад харилцааг зохицуулж байгаа хуулиудыг сонгон авч нийтлэг үйлчилдэг болон тодорхой байгууллагад хамаардаг заалтуудыг ангилж, дээрхи хоёр төрлийн байгууллага зэрэгцээ орших нөхцөлд шаардлагатай өөрчлөлтийг боловсруулж төсөлд тусгав.

Энэ талаар Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Засгийн газрын тухай, Төрийн хяналт, шалгалтын тухай, Төрийн албаны тухай, Татварын ерөнхий хуулийн холбогдох зүйл, заалт улсын төсөвт байгууллагуудад нийтлэг үйлчилж байна. Эдгээрийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн төсөлтэй харьцуулан судалж төсөв, санхүүгийн болон бусад удирдлагын талаархи харилцааг зохицуулж байгаа давхардсан буюу зөрчилдсөн зүйл, заалтыг тодруулж, шинэ тогтолцоонд шилжсэн байгууллагуудад хамаарахгүй тухай төсөлд тусгав.

4. Удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоонд шилжсэн болон шилжээгүй байгууллагууд хэсэг хугацаанд зэрэгцэн орших дээрх шаардлагаас үүдэн УИХ-аас шилжсэн байгууллагын төсвийг шинэ хуулиар, шилжээгүй байгууллагын төсвийг Төсвийн тухай хуулийн одоогийн журмаар хэвээр батлах тухай төсөлд тусгав. Ийнхүү төсвийг хоёр байдлаар батлах болсонтой холбогдоод ТБУСТ хуулийн төсөлд тусгасан төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн байгууллагууд шинэ тогтолцоонд шилжиж эхлэхтэй холбогдон УИХ-

UIH.MN СУДАЛГААНЫ САН

аар хэлэлцэн, зөвшөөрч байх тухай заалт оруулсан болно.

5. ТБУСТХ-ийн төслийн үүднээс үзэхэд хэнийг төрийн албан хаагчаар тогтоох нь тодорхойгүй боловч Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт төрийн жинхэнэ албан хаагчийн тухай болон түүний ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтоохоор заасан тул Төрийн албаны тухай хуулийг бүхэлд нь хамаарахгүйгээр өөрчлөх боломжгүй юм.

Түүнчлэн Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийг улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний гэж ангилсан нь зөвхөн тэдгээрийн цалин хөлс, бусад хөнгөлөлт, баталгааг хангахтай холбоотой гэж үзэх үндэс болохгүй учир хуулийн эдгээр заалтыг хэвээр дагаж мөрдөх нь зүйтэй гэж Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хамтад нь боловсруулжээ.

6. ТБУСТХ-ийн төсөлд орон нутгийн үндсэн бүтээгдэхүүнийг нэлээд хязгаарлагдмал байдлаар тодорхойлж, эрүүл мэнд, боловсрол зэрэг зарим чиг үүргийг Засгийн газрын худалдан авах бүтээгдэхүүн болгон тодорхойлж, нийлүүлэлтийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн тул Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар Засаг даргын бүрэн эрхэд хамааруулсан зарим үүрэг хариуцлагыг нэлээд өөрчлөн хамааруулахаар тусгасан байна.

Хуулийн төслийн талаар нийт яам болон Монгол банкны саналыг авч тусгасны дээр УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийн дагуу Үндсэн хуульд нийцүүлэх талаар онцгой анхааран ажилласан болно. Уг хууль батлагдсанаар нийт 30 орчим хуульд ямар нэгэн хэмжээний өөрчлөлт орохоор тооцоолжээ.

## Хоёр.Татварын холбогдолтой хуулиуд

*Татварын бодлогын асуудлууд:*

Татварын бодлого нь улс орны зайлшгүй хэрэгцээт төсвийн орлогыг бүрдүүлэх, татвар төлөгчдийн үүрэг татварын ачааллыг багасгах, цаашдын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангах, үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийгдэх орчинг бүрдүүлэх татварын албаны бүтэц зохион байгуулалтыг сайжруулах зорилтыг багтааж байдаг албан татвар эдийн засагт хэрхэн нөлөөлөх, түүнтэй салшгүй холбоотойг харуулдаг.

Дэлхийн улс орнууд 50-70-аад онд хувийн бизнесийн үйл ажиллагаа татварын ерөнхий хөшүүргүүдээр дэмжиж байлаа. Ашигт малтмалын олборлох үйлдвэр, тээвэр, нисэх онгоцны үйлдвэр, экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ болон хөрөнгө оруулалтыг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дэмжиж байлаа.

80-аад онд хаа сайгүй хүн амын татварын хувь хэмжээг эрс бууруулахын зэрэгцээ аж ахуйн нэгжийн татварын хувь хэмжээг ч бууруулж эхэлсний зэрэгцээ татварын баазыг өргөжүүлэх, хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах арга хэмжээг зэрэг авч хэрэгжүүллээ. Шууд бус татварыг шинэчлэн өөрчлөхдөө гаалийн татвар болон онцгой татварын хувь хэмжээг бууруулж, нэмэгдсэн өртгийн татварт нийтээрээ гол анхаарлаа тавих болжээ.

XX зууны 80-аад болон 90 оны эхээр дэлхийн өндөр хөгжилтэй улсууд капиталын хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн татварын шинэчлэлт, өөрчлөлтийг хийж, аж ахуйн нэгжийн татварын хувь хэмжээг бууруулсан байна.

Сүүлийн жилүүдэд *татварын системийн зохицол* ба *татварын бодлогын зохицолыг хангах* гэсэн хоёр чиглэл хүчтэй үйлчилж байгаа аж. Эдгээрт өөр өөр хөгжлийн

төвшинтэй улсуудын татварын системийн болон эрх зүйн үндсэн үзүүлэлтүүд, олон улсын давхар татвар ногдуулахтай холбоотой болон татвараас зугтах, зайлсхийхтэй холбоотой асуудлууд, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны татварыг зохицуулах оролдлого хамрагдаж байна.

90-ээд онд төлөвлөгөөт эдийн засагтай байсан нилээд улс зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлснээс үүдэн АНУ-ын Гарвардын Их Сургуулийн эрдэмтэд "Дэлхийн татварын кодекс" боловсруулах оролдлого хийж, түүндээ олон улсуудын туршлага дээр үндэслэж орчин үеийн татварын системийн ойлголтыг нэгтгэн үндэсний татварын хуулийг боловсруулах талаар зөвлөмж болгож, үр ашигтай татварын албыг бий болгох асуудлыг дэвшүүлсэн байна.

Өндөр хөгжилтэй улсууд өөрсдийн татварын түвшин өндөр байгаагаас улбаалан олон улсын татварт *оффшорны механизмыг* ашиглахад хүрсэн байна. Энэхүү механизмын үр дүнд өндөр татвартай улсаас бага татвартай улсад татварын объектыг хуулийн дагуу шилжүүлэх болжээ. Иймээс өндөр хөгжилтэй улсууд өөрийн капитал болон татварын орлогыг алдахгүй байхын тулд ийм үйлдэлд татвар ногдуулах механизм бий болгох, зөвшөөрлийн системийг бүрдүүлэх, өөрсдийн татварын диваажинг бий болгох зэрэг арга хэмжээ авсаар байна.

Татварын бодлого нь улс орны эдийн засагтай хэрхэн холбогдож байгааг тодорхойлохын тулд:

- Татварын ямархүү бүтэц бий болсон
- Татварын хувь хэмжээг засгийн газрын болон татвар төлөгчийн аль алиных нь ашиг сонирхолыг харгалзан тогтоосон эсэх
- Эдийн засгийн хөгжлийн гол шалгуур болсон хөрөнгө оруулалт хийгдэж энэ чиглэлд явуулж байгаа бодлогын шинж байдал
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь эдийн засгийн суурь харилцааг бүрдүүлж байгаа эсэх
- Татварын албаны үйл ажиллагаа нь татварын тогтолцоог хэрэгжүүлэх түвшинд байгаа эсэх
- Зээлийн ба хуримтлагдсан татварын талаар авч явуулж байгаа бодит арга хэмжээ цаашдын чиг хандлагатай холбон авч үзнэ.

*Үндсэн хууль дахь татварын үндэс зохицуулалт:*

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг баталж улс төр, нийгэм, эдийн засгийн томоохон өөрчлөлтийг эхлүүлэн улс төрийн олон намын тогтолцоо болон өмчийн олон хэлбэр бүхий зах зээлийн эдийн засгийн суурийг тавьсан. Өмчийн олон хэвшлийг тунхагласан Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх, эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх шилжилтийг эхлүүлэх ажлын гол үндэс болсон өмч хувьчлалыг эхлүүлэн хийсэн нь ард иргэдэд гарааны нөхцлийг адил тэгш болгох арга хэмжээ болсон.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Шинэ Үндсэн хуулиар Монгол Улсын иргэний эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг тодорхойлсны дотор *"хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шудрагаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлах"* эрхийг нь баталгаажуулж өгсөн. Ийнхүү өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч иргэний эрх, үүргийг тодорхой болгосон нь албан татвар төлөх үүрэг үүсэх үндэслэлийг бий болгосон байна.

Монгол улсын Үндсэн хууль нь улсын тулгуур хууль болохынхоо хувьд Монгол Улсын албан татварын эрх зүйн үндэс болсон зохицуулалтыг зааж өгсөн. Тухайлбал: Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т *"Иргэн бүр хуулиар ногдуулсан албан татварыг*

*төлөх үүрэгтэй".*

Үндсэн хуулин дахь албан татварын эрх зүйн зохицуулалтын үндсийг дараах гурван шаардлагад хуваан үздэг байна[66]:

- улс төрийн шаардлага,
- эдийн засгийн шаардлага,
- зохион байгуулалтын шаардлага.

*Албан татварын үйл ажиллагааны улс төр-эрх зүйн зарчмуудыг* Үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт *"Ардчилсан* ёс, *шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"* болохыг заасан нь албан татварын үйл ажиллагаанд мөрдөгдөх үндсэн зарчим болно.

*Албан татварын харилцааны эдийн засаг-эрх зүйн үндэс* нь Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд заасан *"олон хэвшил бүхий эдийн засагтай байх, өмчийн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах ба гагцхүү хуульд заасан үндэслэлээр тэдний эрхийг хязгаарлах, төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна"* гэсэн заалтуудад тодорхой тусгагдаж төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх чиглэлийг тогтоосон.

Энэхүү зохицуулалт бол Монгол Улсын оршин тогтнох эдийн засгийн чухал суурь юм. Татвар бол эдийн засгийн амьдралын чухал зохицуулагчийн нэг юм. Төрийн татварын үйл ажиллагааны эдийн засгийн үндсийг хууль тогтоогч эрх зүйн зохицуулалттай холбон үзсэн байна.

*Татварын үйл ажиллагааны зохион байгуулалт-эрх зүйн үндсийг* төрийн байгууллагын тогтолцоо, тэдгээрийн харилцааг заасан Үндсэн хуулийн 3 дугаар бүлэгт тусгагдсан заалтуудаар зохицуулсан байна. Энэ нь төрийн бодлого, зорилтыг хэрэгжүүлж байгаа засаглах эрх мэдэл бүхий байгууллагын бүтэц түүний бүрэн эрх, хэрэгжүүлэх чиг үүргээр илэрч гарна.

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.7-д заасан *"төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засгийн үндсэн чиглэлийг тодорхойлж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах"* бүрэн эрхийг УИХ-д олгох эрх зүйн үндсийг тогтоож өгчээ.

*Албан татварын төрөлжсөн хуулиуд:*

Монгол улсад тодорхой төрлийн татварын харилцааг зохицуулсан 25 төрлийн хууль үйлчилж байна. Тухайлбал, Монгол улсын Татварын ерөнхий хуулийн 7-р зүйлд "тодорхой төрлийн татвар нь улсын болон орон нутгийн татварын аль нэгэнд хамаарна" гэж заасан ба эдгээрийн тогтоосон хуулиудыг Монгол улсад татварын багц хууль гэж нэрлэж байна.

Монгол Улсын албан татварын төрөлжсөн хууль нь албан татвар, татвар төлөх, хураах хуулийн залгамж шинжтэй хууль юм. УИХ-аас баталсан *Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн*[67] дагуу татварын ачааллыг бууруулах, татварын дарамтыг арилгах, эрх зүйн орчинг олон улсын жишигт

[66] Монгол улсын албан татварын эрх зүй. *Татварын ерөнхий газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн*. УБ., 2009. 58 дахь тал.
[67] УИХ-ын 2005 оны 26-р тогтоол.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

нийцүүлэн татварын хуулиудыг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага нь:

1. Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад тэгш, шударга зарчмаар хандан дэмжих, ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах, татварын бааз суурийг өргөтгөх, түүний хувь хэмжээг бууруулах талаар Засгийн газрын бодлого, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилтуудтай холбоотой.
2. Хуулийг хэрэглэхэд гарч буй хүндрэлийг арилгах зарим зохицуулалтыг хуульчлах, боловсронгуй болгох нөхцөл байдал бий болсон.
3. Татварын албаны татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг тодорхой болгох, тэдгээрийн хоорондын харилцааг бэхжүүлэх.
4. Бизнес эрхлэгчдийн татварын дарамтыг бууруулах.
5. Татварын бааз суурийг өргөтгөн, далд эдийн засгийг бууруулах.
6. Татварын ялгавартай байдлыг арилгах зэрэг нөхцөл байдлыг харгалзан татварын багц хуулиудад өөрчлөлт оруулснаар үндсэндээ татварын эрх зүйн шинэчлэлтийг явуулсан.

Энэ хүрээнд зарим нэг албан татварын хууль шинээр мөн шинэчлэн найруулсан албан татварын хэд хэдэн хуулийг баталсан. Тухайлбал, Мөн шинэчлэн найруулсан *Татварын ерөнхий хууль* 2008.05.20-ны өдөр, *Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль* 2006.05.12-ны өдөр, шинэчлэн найруулсан *Хувь хүний орлогын албан татварын тухай хууль* 2006.06.16-ны өдөр, *Нэмэгдсэн ертгийн албан татвар, Онцгой албан татварын болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиуд* 2006.06.29-ны өдөр тус тус батлагдсан. Тэдгээрийн заримыг нь доор нэг бүрчлэн авч үзнэ.

2008 оны 2-р сарын 6-ны өдөр *Татварын өршөөл үзүүлэх тухай* хууль анх удаа батлагдсан ба энэ хуулийн зорилт нь зарим этгээдийг албан татвар, нийгмийн даатгалын өр, төлбөрийн тодорхой хувиас болон эрүү, захиргааны хариуцлага, эрүүгийн ялаас нэг удаа чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Хуулийн үйлчлэх хугацаа нь 2007.12.31-ны өдрийн 24 цагаас өмнө эрүүгийн хуулийн 166, 167 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн, захиргааны хариуцлагын тухай хуулийн 44-р зүйлд заасан зөрчил гаргасан этгээдийг хамаарах ба уг хуулийн үйлчлэл 2008.01.01-нээс эхлэн 6-р сарын дотор хэрэгжиж дууссан.

Татварын хуулийн шинэчлэлээр зарчмын шинжтэй олон асуудлыг зохицуулсан бөгөөд ялангуяа далд эдийн засгийг устгаж татвар төлөгчид хөрөнгө орлогоо ил болгон сайн дураар өөрөө орлогоо мэдүүлэх, шударгаар татвараа төлөх татварын ухамсрыг нийгэмд төлөвшүүлэх зорилтыг агуулж бизнесийн таатай орчинг бүрдүүлэхэд нэн ач холбогдолтой татварын хувь хэмжээг бууруулах чиглэлээр томоохон алхам хийгдсэн. Үүний үр дүнд татварын хувь хэмжээгээрээ олон улсын хэмжээнд хамгийн бага татвартай орны нэг болж байгаа нь жижиг дунд үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжсэн, улс орны эдийн засгийн өсөлтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Албан татварын төрөлжсөн хууль нь хуульчилсан актуудаар нарийвчлан зохицуулагдах харилцаануудыг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээний шууд үйлчлэл бүхий акт юм.

Албан татварын эрх зүйн эх сурвалжийн тогтолцоонд татварын ерөнхий хуулийн зэрэгцээ тодорхой татварын төрлүүдийг зохицуулсан хуулиуд хамаарна. Татварын

UIH.MN СУДАЛГААНЫ САН

тодорхой төрлийг зохицуулсан аливаа хууль нь татварын моделийг тогтоосон тодорхой хэм хэмжээнүүдийг агуулдаг. Энэ нь тухайн тодорхой төрлийн татварын мөн чанар түүний зохицуулалтын онцлогийг илэрхийлнэ.

*Албан татварын хэм хэмжээ агуулсан бусад эх сурвалж:*

Төсвийн болон бусад санхүүгийн хуулиуд нь татварын хууль тогтоомжийн үндэс болдог. Тухайлбал, *Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль*[68] нь төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнах, төсвийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны удирдлагын зарчим, төсвийн хяналт, хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулна.

*Нэгдсэн төсвийн тухай хуулийн*[69] зорилт нь Монгол Улсын нэгдсэн төсөв, төсвийн захирагчийн эрх, үүрэг, төсвийн орлого, зарлагын ангилал, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, төсвийн бүртгэлтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг Монгол Улсын нэгдсэн төсөв гэх ба энэ нь улсын, орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Мөн аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргахтай холбогдсон харилцааг зохицуулсан *Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Банкны тухай хууль*[70] зэрэг нь татварын эрх зүйн эх сурвалжид хамаарна.

Татварын эрх зүйн хэм хэмжээ агуулсан татварын бус дараах хуулиудад ихэвчлэн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх талаар заасан байдаг: *Монгол улсын Гаалийн тарифын хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Боловсролын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль* гэх мэт.

Тодорхой салбарын болон төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хуулиуд ч албан татварын эрх зүйн эх сурвалж болно. Тухайлбал, *УИХ-ын тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Яамдын эрх зүйн байдлын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Эрүүгийн болон Иргэний хуулиуд* гэх мэт.

Татварын зохицуулалт нь эдийн засгийн төдийгүй эдийн засгийн бус чиглэлээр төрийн бодлогыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Татварын олон төрлийн зориулалтын чиг үүргийн дагуу эрүүл мэнд, боловсрол, соёлын салбар болон төрийн үйл ажиллагаа гэх мэт нийгэм-эдийн засгийг хөгжүүлэхэд татварын нэмэлт хөнгөлөлтүүдийг тогтоох хэрэгцээ бий болно. Энэхүү хэрэгцээ шаардлага нь татвартай холбогдсон харилцааг татварын бус хуулиудаар зохицуулах шаардлагыг бий болгодог байна. Тухайлбал: *Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль*, *Гаалийн тухай хууль*, *Чөлөөт бүсийн тухай хууль*, *"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль*, *Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль* гэх мэт.

Эдгээр хуулиудад ихэвчлэн татвар, төлбөр, түүний хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар заасан байдаг. Гэхдээ татварын хууль тогтоомжийн дагуу тогтоогдсон хязгаарлалтын хүрээнд татварын харилцааг зохицуулна. 1997 онд баталсан Татварын

[68] 2002.06.27-нд батлагдсан.
[69] 2002.11.20-нд батлагдсан.
[70] 2010.01.28-нд батлагдсан.

UILMN СУДАЛГААНЫ САН

ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “Татвар бий болгох, ногдуулах, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна” гэсэн заалтыг нэмж оруулсан. Үүнтэй уялдуулан татварын тусгай хуульд өөрчлөлт оруулан дээр дурьдсан хуулиудаас зохих заалтуудыг хүчингүй болгох арга хэмжээг авсан.

Мөн норматив гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулж, нэгдмэл ашиг сонирхлыг илэрхийлдэг, гэрээний гол зүйлийн талаар талууд харилцан зөвшилцөж, тэгш эрхтэйгээр оролцдог нийтлэг шинжтэй гэрээг хэлнэ. Норматив гэрээ нь албан татвар ногдуулалтын хүрээнд Монгол улс бусад улстай байгуулсан олон улсын гэрээгээр илэрч байна.

Хуульчилсан акт нь хуулиас бага хүчин чадалтай хэдий ч хуулийн хүчин чадалд үндэслэж, хуульд нийцэж гарсан байхаас гадна хуулиар эрх олгогдсон субъект эрх хэмжээнийхээ хүрээнд гаргаж мөрдүүлдгээрээ онцлог. Тухайлбал, албан татварын хуулиар зохицуулсан заалтыг тодорхой болгон нарийвчлан зохицуулж буй:

- УИХ-ын тогтоол,
- Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр,
- Ерөнхийлөгчийн зарлиг,
- Засгийн газрын тогтоол,
- Сангийн сайдын тушаал,
- Татварын ерөнхий газрын даргын тушаал,
- Монгол Банкны ерөнхийлөгчийн хэм хэмжээ тогтоосон акт,
- Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр.

***Татварын Ерөнхий хууль:***

Улсын Бага хурлаас баталсан БНМАУ-ын *Албан татварын тухай хуулийн*[71] гол үзэл баримтлал нь улс орны эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх талаар авсан анхны арга хэмжээний нэг байсан бөгөөд мөрдөгдсөн 2 жилийн хугацаанд тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болсон. Уг хууль нь албан татварын ангилалыг тогтоон тэдгээрт хамруулах нэр төрлийг тодорхойлон зааглаж өгсөн.

1993 онд УИХ-аар батлагдсан *Татварын ерөнхий хуульд* илүү нарийвчилсан зохицуулалтуудыг анх удаа эрх зүйн томъёоллоор тодорхой тусгаж өгчээ. Үүний дараагаар татварын төрөлжсөн багц хуулиуд гарсан нь зах зээлийн өнөөгийн нөхцөлд төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх гол нөхцөл болсон.

*Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал*

“Татварын ерөнхий хууль”-ийн хуулийн хэргийг авч үзэхэд шинэчилсэн найруулгын хоёр төслийн баримт бичиг байсан. Үүнд:

1) 2006.12.19-нд Засгийн газраас *Монгол Улсын татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг* УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Баримт бичигт хуулийн төслийн танилцуулга болон “Монгол Улсын татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-ыг хавсаргасан байна.

2) 2007.08.14-нд УИХ-ын гишүүн Л.Пүрэвдорж, Н.Батбаяр нар *Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг* УИХ-д өргөн мэдүүлсэн байна. Үүнээс өмнө Засгийн газраас оруулсан татварын багц хуулиудын төсөл дээр ажилласан байжээ.

[71] 1990.12.07-нд батлагдаж, 1991.01.01-нээс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 1992.12.14-нд хүчингүй болсонд тооцсон.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Ингэхдээ хуулийн төслийн танилцуулга болон үзэл баримтлалыг хавсаргасан байна.

Хоёр дахь өргөн барьсан хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 2008.05.20-нд УИХ-аар батлагдсан тул уг төслийн үзэл баримтлал, танилцуулгыг судалгаанд ашигласан болно. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулгыг авч үзэхэд татварын шинэчлэлийн хүрээнд дараах 4 зорилгыг шийдвэрлэхийг чухалчилжээ:

1. Татварын эрх зүйн зохицуулалтын цогц байдлыг хангаж, ойлгон хэрэгжүүлэхэд хялбар болгох,
2. Татварын эрх зүйн харилцаан дахь татвар төлөгч болон төрийн эрх тэгш байдлыг дээшлүүлэх,
3. Татварын харилцааг татвар төлөгчид ашигтай байдлаар зөөлрүүлэх,
4. Татварын албаны үйл ажиллагааны зохицуулалтыг аль болох бүрэн тусган боловсронгүй болгох нь зайлшгүй чухал байна.

Эдгээрт нийцүүлэн Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд татварын эрх зүйн зохицуулалтанд 15 зүйл бүхий өөрчлөлт оруулж өгсөн нь хууль батлагдахад бүгд бүрэн орсон байна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын бүтцийг авч үзвэл дөрвөн хэсэгтэй: 1-р хэсэг болох *Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад* 1) хууль зүйн шаардлага, 2) практик шаардлагыг тусгасан байна.

**1. Хууль зүйн шаардлага**

Татварын ерөнхий хуулийг 1992 онд баталж, хэд хэдэн өөрчлөлт оруулж иржээ. Мөн Монгол улсын татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийг 1996 онд батлан 2002 онд шинэчлэн найруулсан байна. Энэ хоёр хууль хоёулаа татвар бий болгох, ногдуулах, тайлагнах, төлөх, татвар хураахтай холбоотой нийтлэг зохицуулалтыг тусгасан, сүүлчийнх нь өмнөхөө тодотгосон хуулиуд юм. Ийнхүү хоёр хууль болгон гаргах нь зайлшгүй шаардлага байгаагүй тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан хэрэг билээ. Тийм учраас нэгтгэсэн нэг хууль болгон гаргаж, татварын эрх зүйн харилцааны цогц байдлыг дээшлүүлж, уялдаа холбоог нь сайжруулах шаардлагатай байна

Нөгөө талаас эдгээр хуулинд нэмэлт, өөрчлөлт хийж, шинэчлэн найруулж байсан ч 1992 оныхоо хүрээнээс төдийлөн халиагүй байна. Эдийн засаг, нийгмийн амьдралд гарсан ололт өөрчлөлттэй уялдуулан татварын эрх зүйн харилцаанд татвар төлөгч болон төрийн эрх тэгш байдлыг хангаж, татварын эрх зүйн орчинг татвар төлөгчдөд ашигтай байдлаар зөөлрүүлэх, татварын албаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг аль болох бүрэн гүйцэд, боловсронгүй болгох ээлжит алхам хийх цаг болсон байна.

**2. Практик шаардлага**

Эдгээр хуулийг нэгтгэн нэг хууль болгон гаргаснаар татвар төлөгч болон татварын албаны ажилтан нар татварын ерөнхий зохицуулалттай холбоотой асуудлыг нэг дороос харж лавлан хэрэглэхэд хялбар дөхөм болно. Татвар төлөгчдийн эрх ашигт нийцсэн нэлээд өөрчлөлт орсноор татвар төлөгч, татварын албаны хоорондын итгэлцэл, хамтын ажиллагаа дээшилнэ. Татварын албаны үйл ажиллагааг бүхэлд нь хуульчлан зохицуулснаар эрх зүйн чадамж нь дээшлэн ажлын үр өгөөж нь нэмэгдэнэ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***Эх сурвалж:** Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал*

2-р хэсэг болох *Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээнд* хуулийн төслийн 9 бүлэг тус бүрийн харилцааг товч танилцуулжээ.

*Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ* гэсэн 3-р хэсэгт хоёрхон өгүүлбэрээр татварын албаны зардал, орон тоо нэмэгдэх тухай өгүүлсэн байна.

4-р хэсэг *Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах*: "Татварын зөвлөхийн тухай хуулийг шинээр боловсруулж, батлуулахаар бэлтгэл ажилдаа орсон байгаа болно" гэсэн бөгөөд Татварын ерөнхий хуулийн 16.1-д уг харилцааг хуулиар зохицуулахаар заажээ.

*Зохицуулсан харилцаа*

Энэ хуулийн зорилт нь "Монгол Улсад *татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах,* төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар *төлөгч болон татварын албаны* эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн *хооронд үүссэн харилцааг зохицуулахад* оршино." Дараах харилцааг зохицуулна:

- Татварын бүрэлдэхүүн, түүнтэй холбогдсон харилцаа,
- Татвар төлөгчийн эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхэд үүсэх харилцаа,
- Татварын албаны үйл ажиллагаатай холбоотой харилцаа,
- Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан,
- Татвар ногдуулах, төлөх, тайлагнах, татвар хураах, татварын өр барагдуулах хүрээнд үүсэх харилцаа,
- Татварын хяналт шалгалтын хүрээнд үүсэх харилцаа,
- Татварын зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага ногдуулах хүрээнд үүсэх харилцаа,
- Тодорхой төрлийн албан татварын зохицуулалтын хүрээнд үүсэх харилцаа.

Татварын ерөнхий хуулийн 3-т татварыг зөвхөн УИХ хуулиар бий болгож, өөрчлөх, чөлөөлөх, хөнгөлөх, хүчингүй болгох эрхтэй тул төрийн эрх бүхий бусад байгууллагуудаас гаргаж буй хуульчилсан актуудаар хуулиар тогтоосон татвар хураамжийг өөрчлөх, хүчингүй болгох, шинээр татвар хураамж тогтоохгүй байхыг зохицуулсан байна.

*Хуулийн онцлог шинж*: Татварын ерөнхий хуулийг[72] мөрдүүлснээр татварын албыг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь тодорхой болгох, мэргэшсэн алба болох нөхцлийг бүрдүүлж өгчээ. Татварын ерөнхий хуулийн хүрээнд хүн амын орлогын албан татвар, ААН, байгууллагын орлогын албан татвар, худалдааны, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулиуд батлагдан гарсан нь төсвийн орлогын бүрдүүлэлтэнд бодит нөлөөлөл үзүүлэн, голлох татвар болох нь амьдралд нотлогдсон нь эдгээрийн хэлбэрийг одоо хүртэл хадгалсаар байгаа нь харагдаж байна.

*Албан татварын төрөл*

Төсвийн орлогыг бүрдүүлэх үндсэн орлого нь татварын орлого бөгөөд энэ нь *Татварын ерөнхий хуулиар* тодорхойлсон албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэх тул улсын болон орон нутгийн төсөвт орох татварын орлогыг тодорхойлсон.

Татварын ерөнхий хуульд зааснаар нийт 24 татварын тодорхой төрлийг улсын болон орон нутгийн татварт хамааруулж, тэдгээрийн хувь, хэмжээг нь ямар субъект

[72] 2008.05.20-нд батлагдсан.

UILMN СУДАЛГААНЫ САН

тогтоохыг зохицуулсан байгааг дараах Хүснэгтээс харна уу. Эдгээр татварын харилцааг Татварын ерөнхий хууль болон бусад хуулиар зохицуулдаг.

Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтлэг үйлчлэх улсын татваруудад УИХ, Засгийн газраас хувь хэмжээг нь тогтоох бол орон нутгийн төсөвт төвлөрүүлэх эсхүл тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх орон нутгийн татварт УИХ, Засгийн газраас гадна аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас хувь, хэмжээг нь тогтооно.

Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна.

Хүснэгт. **Татварын төрөл ангилал**[73]

| Албан татвар | Улсын татвар | Орон нутгийн татвар |
|---|---|---|
| **АЛБАН ТАТВАР:** | | |
| 22. аж ахуй нэгжийн орлогын | ✓ | |
| 23. гаалийн | ✓ | |
| 24. нэмэгдсэн өртөгийн | ✓ | |
| 25. онцгой албан татвар | ✓ | |
| 26. авто бензин, дизелийн түлшний | ✓ | |
| 27. зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | ✓ | |
| 28. хувь хүний орлогын | | ✓ |
| 29. орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын | | ✓ |
| 30. үл хөдлөх эд хөрөнгийн | | ✓ |
| 31. авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн | | ✓ |
| 32. бууны | | ✓ |
| 33. нийслэл хотын | | ✓ |
| 34. нохойны | | ✓ |
| 35. өв залгамжлал, бэлэглэлийн | | ✓ |
| **ТӨЛБӨР:** | | |
| 1. ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | ✓ | |
| 2. ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | ✓ | |
| 3. ус, рашааны нөөц ашигласны | | ✓ |
| 4. байгалийн ургамал ашигласны | | ✓ |
| 5. түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны | | ✓ |
| 6. газрын | | ✓ |
| 7. ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны | | ✓ |
| **ХУРААМЖ:** | | |
| 1. ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн | | ✓ |
| 2. улсын тэмдэгтийн | | ✓ |
| 3. агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн | | ✓ |

***Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль:***

Татварын хуулиудад хийгдсэн өөрчлөлтүүдийг авч үзэхэд тэдгээрийн гол чиглэл нь татварын баазыг өргөтгөх, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах, татвар төлөгчийн хүрээг өргөтгөх, албан татварт хамруулах орлогын төрлийг нэмэгдүүлэх, шинэ

[73] Татварын ерөнхий хууль, 7-8-р зүйл.



UIH.MN СУДАЛГААНЫ САН

төрлийн татвар бий болгох замаар төсвийн орлогыг нэмэгдүүлж төсвийн урсгал болон нийт тэнцлийг сайжруулахад чиглэгдэж байжээ.

Энэ нь нэг талаас эдийн засгийн ялангуяа санхүүгийн хүрээн дэх төрийн оролцоо нэмэгдэж татварын бодлогоор эдийн засгийг тэнцвэржүүлэх нөгөө талаар татварын тогтолцоонд тэгш, шударга байх нөхцөлийг бүрдүүлэх явдалтай холбоотой. Анх 1993 оноос мөрдөгдөж эхэлсэн *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль* дээр авч үзэхэд хуульд 20 шахам нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд тэдгээрийн заримыг нь товчлон харуулбал дараах байдлаар өөрчлөлт орсон байна.

- 1996 оны өөрчлөлтөөр: хөгжлийн бэрхшээлтэй болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаархи албан татварын чөлөөлөлт,
- 1997 оны өөрчлөлтөөр: мах, сүү, үр тариа, гурилын үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийг дэмжих татварын хөнгөлөлт,
- 1999 оны өөрчлөлтөөр: гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих орлогын албан татварын хенгелелт,

*Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал*

*Аж ахуй нэгжийн орлогын албан татварын хууль*[74] нь анх Засгийн газраас *Хуулийн этгээдийн орлогын албан татварын хууль* нэртэйгээр УИХ-д өргөн барихдаа *Татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, зарим хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн тухай* танилцуулга болон үзэл баримтлалыг нь хавсаргасан байна.

Хуулийн төслийн танилцуулгад “Хуулийн этгээдийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулан татварын тэгш, шударга байдлыг хангах, татварын суурийг өргөтгөх, хувь хэмжээг оновчтой тогтоох, хуулийг энгийн, ойлгомжтой хялбар болгох, татвар төлөгчдөд учирч буй дарамтыг багасгах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлийг баримтлан олон улсын жишигт нийцүүлэн шинэчилэн найруулан боловсрууллаа” гээд 16 заалт бүхий зохицуулалтыг тусгажээ.

Тэдгээрийн талаас илүү хувь нь хуулийн зохицуулалт болон батлагдсан байна. Мэдээж зарим заалт нь хэлэлцүүлэгийн явцад өөрчлөлт орж, өөрчлөгдсөн байдлаар батлагдсан байна. Хууль батлагдахад хулийн төслийн танилцуулгад тусгагдсан зарим зүйл ороогүй байна. Тухайлбал, үнэ шилжилтийн тухай, нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчдөд албан татвар ногдуулах онцлогийн талаар зэрэг юм.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагыг тайлбарлахдаа

1) *“Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”*-д[75] татварын харилцааны эрх зүйн зохицуулалтыг иж бүрэн судалж, татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар, мөн *“Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”*-т[76] макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд ААН, байгууллагын ОАТ-ын тогтолцоог одоогийнхоос илүү боловсронгуй болгох талаар тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд

2) *“Монгол Улсын аж ахуй нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль”*[77]

---

[74] 2006.06.29-нд батлагдсан.
[75] УИХ-ын 2005 оны 26-р тогтоол.
[76] УИХ-ын 2004 оны 24-р тогтоол.
[77] 1992.12.14-нд батлагдсан.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

батлагдсанаас хойш нийт 20 шахам нэмэлт, өөрчлөлт орсон, зарим заалтын хэллэг, нэр томъёо хуучирсан, зарим заалтад хэд хэдэн утга санааг зэрэгцүүлэн тусгасан зэргээс практикт татвар төлөгч, татварын байгууллагад хуулийг ойлгож хэрэглэхэд түвэгтэй байгаа юм. Иймд *Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай* хуульд заасан хуулийн техник, хэл зүй, нэр томъёоны шаардлагад нийцүүлэн бүхэлд нь шинэчлэн боловсруулах шаардлагатай гэсэн байна.

Мөн хуулийн төслийн үзэл баримтлалыг авч үзэхэд хуульд тусгах шаардлагатай зарчмын шинжтэй 5 заалт бүхий өөрчлөлтүүдийг тусгахаар оруулжээ. Танилцуулгад орсон байсан үнэ шилжилтийн тухай, нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчдөд албан татвар ногдуулах онцлогийг мөн дурьсан байсан.

*Зохицуулсан харилцаа*

Хуулийн зорилт нь “аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

*ААН-ийн орлогод албан татвар ногдуулах харилцааг зохицуулна:*

1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар;
2. Удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж;
3. Монгол Улсад орлого олж байгаа гадаадын ААН, тэдгээрийн төлөөний газар.

ААН байгууллагын орлогын албан татвар 6 шатлалтай байсныг 4 шатлалтай болгосноор хүн амд учруулах татварын дарамтыг багасгах, ААН-үүд жижигрэн технологи, зохион байгуулалтын уялдаа холбоо алдагдсан, олон хоршоо, хувиараа эрхлэх аж ахуй, компаниуд нэгдэн хүч хөрөнгөө төвлөрүүлэн хорших боломжийг бий болгосон, албан татвар ногдуулах суурийг зөв тогтоох, хувь хэмжээг оновчтой болгох чиглэлд дэвшилттэй алхам болж чаджээ.[78] Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд 2010.06-р сарын байдлаар 9 удаа нэмэлт өөрчлөлт хийгээд байна.

***Хувь хүний орлогын албан татварын тухай хууль:***

*Хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал*

Анх Засгийн газраас *Хүн амын орлогын албан татварын хууль* нэртэйгээр УИХ-д өргөн баригдаж, УИХ-аас батлахдаа *Хувь хүний орлогын албан татварын тухай хууль*[79] нэртэйгээр батлагдсан байна. Хуулийн төсөл нь *Татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, зарим хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн тухай* танилцуулга болон үзэл баримтлалыг нь хавсаргасан байна.

Хуулийн төслийн танилцуулгад “...хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа хүн амын татварын ачааллыг бууруулах, хүн амын орлогын албан татварыг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр шинэчилэн найруулав” гээд 7 заалт бүхий зохицуулалтыг тусгажээ.

Тэдгээрийн талаас илүү хувь нь хуулийн зохицуулалт болон батлагдсан. Мэдээж зарим заалт нь хэлцэлүүлэгийн явцад өөрчлөлт орж, өөрчлөгдсөн байдлаар батлагдсан байна. Хууль батлагдахад хулийн төслийн танилцуулгад тусгагдсан зарим зүйл огт оруугүй байна. Тухайлбал, үнэ шилжилтийн тухай, нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчдөд албан татвар ногдуулах онцлогийн талаар зэрэг юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[78] Монгол улсын албан татварын эрх зүй. *Татварын ерөнхий газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн*. УБ., 2009.
[79] 2006.06.16-нд батлагдсан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагыг тайлбарлахдаа

1) *"Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"*-д[80] татварын харилцааны эрх зүйн зохицуулалтыг иж бүрэн судалж, татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар, мөн *"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"*-т[81] макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд ААН, байгууллагын ОАТ-ын тогтолцоог одоогийнхоос илүү боловсронгуй болгох талаар тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд

2) *"Монгол Улсын аж ахуй нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль"*[82] батлагдсанаас хойш нийт 20 шахам нэмэлт, өөрчлөлт орсон, зарим заалтын хэллэг, нэр томъёо хуучирсан, зарим заалтад хэд хэдэн утга санааг зэрэгцүүлэн тусгасан зэргээс практикт татвар төлөгч, татварын байгууллагад хуулийг ойлгож хэрэглэхэд түвэгтэй байгаа юм. Иймд *Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай* хуульд заасан хуулийн техник, хэл зүй, нэр томъёоны шаардлагад нийцүүлэн бүхэлд нь шинэчлэн боловсруулах шаардлагатай гэсэн байна.

Мөн хуулийн төслийн үзэл баримтлалыг авч үзэхэд хуульд тусгах шаардлагатай зарчмын шинжтэй 5 заалт бүхий өөрчлөлтүүдийг тусгахаар оруулжээ. Танилцуулагад орсон байсан үнэ шилжилтийн тухай, нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчдөд албан татвар ногдуулах онцлогийг мөн дурьсан байсан.

*Зохицуулсан харилцаа*

Энэ хуулийн зорилт нь "Монгол Улсад *татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах,* төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар *төлөгч болон татварын албаны* эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн *хооронд үүссэн харилцааг зохицуулахад* оршино."

*Зохицуулсан харилцаа:*

- Татварын бүрэлдэхүүн, түүнтэй холбогдсон харилцаа,
- Татвар төлөгчийн эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхэд үүсэх харилцаа,
- Татварын албаны үйл ажиллагаатай холбоотой харилцаа,
- Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан,
- Татвар ногдуулах, төлөх, тайлагнах, татвар хураах, татварын өр барагдуулах хүрээнд үүсэх харилцаа,
- Татварын хяналт шалгалтын хүрээнд үүсэх харилцаа,
- Татварын зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага ногдуулах хүрээнд үүсэх харилцаа,
- Тодорхой төрлийн албан татварын зохицуулалтын хүрээнд үүсэх харилцаа.

Татварын ерөнхий хуулийн 3-т татварыг зөвхөн УИХ хуулиар бий болгож, өөрчлөх, чөлөөлөх, хөнгөлөх, хүчингүй болгох эрхтэй тул төрийн эрх бүхий бусад байгууллагуудаас гаргаж буй хуульчилсан актуудаар хуулиар тогтоосон татвар хураамжийг өөрчлөх, хучингүй болгох, шинээр татвар хураамж тогтоохгүй байхыг зохицуулсан байна. "Хүн амын орлогын албан татварын тухай хуульд" 1992 онд батлагдснаас хойш ний 12 удаа нэмэлт өөрчлөлт орсон бол одоо хүчин төгөлдөр байгаа хуульд 2010.06-р сарын байдлаар 4 нэмэлт, өөрчлөлт ороод байна.

[80] УИХ-ын 2005 оны 26-р тогтоол.
[81] УИХ-ын 2004 оны 24-р тогтоол.
[82] 1992.12.14-нд батлагдсан.

UIH.MN ТӨЛӨӨЛӨГЧДИЙН САН

***Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хууль:***

Гарал үүслийн хувьд 1954 онд Франц улсад анх бараанд ногдуулан хэрэглээний татварын хэлбэрээр нэвтрүүлж эхэлсэнийг эрдэмтэн мэргэд санхүүгийн салбарт гарсан томоохон ололтуудын нэг гэж үздэг.

1968 онд үйлчилгээнд ногдуулж байсан ба үйлчилгээний татвар болон жижиглэн худалдаанд ногдуулдаг байсан орон нутгийн татварыг энэхүү татвартай нэгтгэснээр жижиглэн худалдааг хамарсан өргөн суурьтай нэгдсэн нэг татвар бий болов. НӨАТ-ыг олон улсын практикт хэрэглэх болсон хэд хэдэн шалтгаан бий. Үүнд;

1. Төсвийн орлогыг найдвартай бүрдүүлэх эх үүсвэр болох талаас нь тайлбарласан байдаг. Тухайлбал орлогын болон худалдааны албан татвар нь олон нийтийн зүгээс тодорхой эсэргүүцэлтэй тулгарч байсан бол нэмэгдсэн өртгийн албан татвар нь төсвийн орлогыг бүрдүүлэх талаар илүү үр өгөөжтэй болохыг Индонез, Өмнөд Солонгос, Шинэ Зеланд, Португаль зэрэг улс орны туршлага харуулж байна. НӨАТ нь үндэсний нийт бүтээгдэхүүний 5-10 хувийг хамарч, төсвийн орлогын 30 хувийг бүрдүүлж байна.
2. НӨАТ нь ихэвчлэн үр дүн багатай, гажуудал ихтэй , хяналт шалгалт болон удирдлага нь төдийлөн сайн биш тийм татварын системийг халж чаддагаараа илүү ач холбогдолтой юм. НӨАТ нь урьд хэрэглэгдэж байсан гүйлгээний татвараас татварыг давхардуулан ногдуулдаг байсныг өөрчлөхийн зэрэгцээ экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүнд ногдуулсан татварыг буцааж олгодгоороо давуу талтай юм. Экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүний татварыг буцааж олгох нь экспортын тэгш өрсөлдөөнийг явуулахад чиглэсэн ач холбогдолтой.
3. НӨАТ нь зах зээлийн харилцааны нөхцөлд үйл ажиллагаа явуулахад гажуудал үүсгэдэггүйгээрээ өмнөх татварын системээс давуу талтай.

*Хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал*

УИХ-аас *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг* 1998 онд баталсан[83] бөгөөд түүнээс хойш 17 удаа нэмэлт өөрчлөлт орж, хуулийг татварын алба, татвар төлөгч нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болсноос үүдэн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулла. Шинэчилсэн найруулгын төсөлд нэмэгдсэн өртгийн татварын тухай хуулийн заалтыг нэг мөр ойлгох, татварын дарамтыг бууруулах, татварын суурийг өргөтгөх, хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах, хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай 8 нэмэлт өөрчлөлтүүдийг тусгаснаас дийлэнхи нь хуулийн зохицуулалт болон батлагджээ.

НӨАТ-ын тухай хуулийн төслийн үзэл баримтлалы бүтцийг авч үзвэл дөрвөн хэсэгтэй: 1-р хэсэг болох *Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад* 1) хууль зүйн шаардлага, 2) практик шаардлагыг тусгасан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| Хууль зүйн шаардлага: | Практик шаардлага: |
|---|---|
| Улсын Их Хурлын 2005 оны 26 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 34-д татварын харилцааны эрх зүйн зохицуулалтыг иж бүрэн судалж, Татварын бащ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар заасан.<br>Энэхүү ажлын хүрээнд 2005-2006 онд | 1. "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хуульд (1998) нийт 17 удаа нэмэлт, өөрчлөлт орж, нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэлтэй болсон.<br>2. Татварын бааз, суурийг нэмэгдүүлэх, хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах, зорилгоор зарим төрлийн бараа, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татварт |

[83] 1998.01.08-ны өдөр батлагдсан.

| | |
|---|---|
| татварын бааз суурийг өргөтгөх, татварын дарамтыг аль болох багасгах, татвар тэгш шударга байх зарчмыг хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, салбараар ялгаварласан алив хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгахад чиглэсэн өөрчлөлтүүд оруулах чиглэл өгсөн байна.<br><br>***Эх сурвалж:*** *Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал* | хамруулах, нэмэгдсэн өртгийн татвар төлөгчөөр сайн дураараа бүртгүүлэх нөхцлийг хангахад чиглэсэн зохицуулалт шинээр тусгах шаардлагатай гэсэн чиг баримталж байна.<br>3. Татварын ачааллыг багасгах, дотоодын хөрөнгө оруулалтыг татвараар дэмжихтэй холбоотой зарим зохицуулалт төсөлд нэмж өгөх шаардлагатай байна.<br>4. Татварын хууль тогтоомжийг нэг мөр, ойлгомжтой болгох зорилгоор холбогдох дүрэм журмаар зохицуулагдаж байгаа зарим харилцааг хуульчлах шаардлагатай байна.<br>5. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль тогтоомж зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагыг одоогийнхоос илүү тодорхой болгох шаардлагатай гэсэн чиг баримталж байна. |

2-р хэсэг болох *Хуулийн зохицуулалтын хамрах хүрээ, зохицуулах харилцаа, хуулийн ерөнхий бүтцэд* төслийн 15 бүлгийг тавч танилцуулсан байна. Энэхүү хуулийн зохицуулалтын хүрээнд зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах, төсөвт төлөх, төсвөөс буцаан олгохтой холбогдсон харилцаа хамаарна.

*Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагаварын тухай* 3-р хэсэгт хуулийн төсөл батлагдсанаар татвар энгийн ойлгомжтой байх зарчим хэрэгжиж, энэ төрлийн эрх зохицуулалт одоогийнхоос илүү боловсронгуй болох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасган, суурийг өргөжүүлсэнээр төсвийн орлого нэмэгдэх боловч нөгөөтэйгүүр зарим нэг бараа, ажил үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлснөөр орлого буурах магадлалтай боловч татварын дарамт буурч, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд зохих нөлөө үзүүлэхийг заасан байна.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай 4-р хэсэгт уг хуулийн төслийг боловсруулж, батлуулахтай холбогдон нэмэлт өөрчлөлт орох хууль тогтоомж байхгүй гэсэн байна.

*Зохицуулсан харилцаа*

НӨАТ-ын тухай хуулийн зорилт нь нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, төсвөөс буцаан олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Шууд бус уг татвар үйлчлэх хүрээ нь иргэн, хуулийн этгээдийн импортолсон буюу экспортолсон бараа, түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд НӨАТ ногдуулна.

Шууд бус татварын эерэг, сөрөг талыг судлах замаар аль болох нийгэм, хүн амд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарах нь татварын бодлогын хүрээнд шийдвэрлэх нэн чухал асуудал юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хүснэгт. **Шууд бус татварын эерэг, сөрөг тал**

| Эерэг тал | Сөрөг тал |
|---|---|
| – Төсвийн орлогын тогтвортой эх үүсвэр,<br>– Үйлдвэрлэгчдэд дарамт учруулахгүй,<br>– Импортлогчдын орлогод шууд нөлөөлөхгүй,<br>– Үйлдвэрлэлийг урамшуулахад нөлөөлнө. | – Хэрэглэгчийн орлогоос төлдөг,<br>– Хүмүүсийн харгалзахгүй,<br>– Нийт хэрэглээг бууруулахад нөлөөлнө,<br>– Үнэ, тариф өсөх нэг зүйл болно,<br>– Хүн амын орлого багатай хэсгийн амьжиргаанд хүнд дарамт болдог.<br>– Хүн амын хуримтлал буурдаг. |

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд 2010.06-р сарын байдлаар 9 удаа нэмэлт өөрчлөлт оруулжээ.

*Эцэст нь* Улс орны нийгэм, эдийн засгийн улс төрийн дэглэм өөрчлөгдөж байсан ч төрийн сан хөмрөг бүрдүүлэх үндсэн арга хэрэгсэл болсон албан татвар хуримтлуулах үйл ажиллагаа өөрчлөгддөггүй билээ. Харин улс орны улс төр, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг янз бүрийн объектив, субъектив хүчин зүйлээс болж татварын бодлого байнга өөрчлөгдөж түүний үйлчлэл нь татварын хууль тогтоомжид нөлөөлдөг нь тодорхой юм.

Хэдийгээр татварын бодлого үргэлж өөрчлөгддөг боловч манай улсын хувьд цөөн биш хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж байгаа түгээмэл тохиолдох болсон байна. Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, НӨАТ-ын тухай хуулиуд батлагдснаас хойш 4 жилийн дотор 9 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна. Үүнийг хоёр талаас авч үзэхэд, ***нэгд***, төрийн бодлого уян хатан байгаа сайн талтай ч, ***нөгөө талаас нь авч үзвэл,*** хуулийн төслийг боловсруулах явцад тухайн асуудлаар бодит байдалд мэргэжлийн, туршлагатай багаар судалгаа хийлгэх нь дутмаг байгааг харуулж байна.

Татвар нь макро түвшинд эдийн засгийн харилцааг зохицуулах үр ашиг бүхий арга хэрэгслүүдийн нэг төдийгүй төрийн мөнгөний нэгдсэн сан бий болгох сонгомол хэлбэрийг өөртөө агуулсан байдаг

1996-2009 оны хооронд татварын хуулиудад хийгдсэн өөрчлөлтүүдээс харахад тэдгээрийн гол чиглэл нь татварын баазыг өргөтгөх, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах, татвар төлөгчийн хүрээг өргөтгөх, албан татварт хамруулах орлогын төрлийг нэмэгдүүлэх, шинэ төрлийн татвар бий болгох замаар төсвийн орлогыг нэмэгдүүлж төсвийн урсгал болон нийт тэнцлийг сайжруулахад чиглэгдсэн.

### Гурав. Банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хуулиуд

***"Банкны тухай болон Төв банкны тухай" хуулийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, хуулийн үзэл баримтлалд тусгасан асуудлын талаар:***

Улс орны эдийн засгийн чухал секторуудын нэг бол банк санхүүгийн сектор юм. Банк санхүүгийн системийн гол зорилго нь хөрөнгийн илүүдэлтэй талаас хөрөнгийн дутагдалтай талруу аль болох эрсдэл болон өртөг багатай хэлбэрээр үр өгөөжтэй дамжуулахад оршдог.

Хэдийгээр банк ашиг олохын тулд үйл ажиллагаа явуулж байдаг боловч энэ цэвэр харилцан итгэлцэл дээр тулгуурлаж байдаг. Арилжааны банкуудын үйл ажиллагаа, түүний үр дүн нь тус банкны төдийгүй тухайн улсын эдийн засагт маш чухал байр суурийг эзэлж байдаг.

Тиймээс банк санхүүгийн салбарын эрх зүйн орчныг зохистойгоор бүрдүүлэх шаардлагатай байдаг бөгөөд манай улс 1991 оноос хойш банкны 2 шатлалт тогтолцоог бий болгосноос хойш эрх зүйн орчныг боловсронгүй болгох тал дээр анхаарсаар ирсэн.

UIH.MN СОЁЛЫН САН

Манай улсын банк, санхүүгийн салбарын харилцааг зохицуулж буй дараахь гол хуулиуд үйлчилж байна. Үүнд:

- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 1995 он;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай 2002 он;
- Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай 2008 он;
- Банкны тухай (Шинэчилсэн найруулга) 2010 он;
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай 2005 он;
- Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай 2006 он;
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай 2009 он;
- Үнэт цаасны зах зээлийн тухай 2002 он;
- Төв банк /Монголбанк/-ны тухай 1996 он;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай 2006 он;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2001 он;
- Аудитын тухай хууль 1997 он;
- Дампуурлын тухай хууль 1997 он;
- Валютын зохицуулалтын тухай хууль 1994 он;
- Компанийн тухай хууль 1999 он;

Манай улсын эдийн засаг, банк санхүүгийн салбарын хөгжлийг даган хууль эрх зүйн орчныг байнга шинэчлэн өөрчлөх шаардлага тулгарсаар ирсэн бөгөөд Төв банкны тухай хууль 1996 онд батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш түүнд 1998, 1999, 2001, 2003, 2005, 2010 онд нийтдээ 8 удаа, банкны тухай хуульд нийт 9 удаа, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд 6 удаа, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд 3 удаа, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд 2 удаа, Үнэт цаасны зах зээлийн тухай болон Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулиудад тус бүр 1 удаа нэмэлт, өөрчлөлт ороод байна.

Банк санхүүгийн салбарын харилцааг зохицуулж байгаа дээрх хуулиудаас хамгийн их өөрчлөлт орсон буюу Төвбанкны тухай болон Банкны тухай хуулийн үзэл баримтлалыг судалж үзлээ. Ингэж судлахдаа ямар нөхцөл шалтгааны улмаас уг хуулиудад өөрчлөлт оруулах болсон, тухайн үеийн нөхцөл байдлын талаар тодруулахыг зорилоо.

Хэдийгээр төв банк болон банкны тухай хуульд нэг онд давтагдсан байдлаар нийтдээ 10 орчим удаа нэмэлт өөрчлөлт орсон хэдий ч хувийн хэргийн бүрдэл дутуу, зарим хууль хувийн хэрэггүй, зарим нь бусад хуулийг дагалдах байдлаар нэмэлт өөрчлөлт орсон зэрэг шалтгаанаар доорх нэмэлт өөрчлөлтүүдийг авч үзсэн болно.

***1996 оны Төвбанкны болон Банкны тухай хуулийн үзэл баримтлалын талаар:***

1996 онд батлагдсан Төвбанкны болон Банкны тухай хуулийн хувийн хэрэгтэй танилцахад хуулийн үзэл баримтлал байхгүй бөгөөд 2 хууль нь нэг танилцуулгатай байлаа. Тухайн үед 1991 онд батлагдсан Банкны хууль, 1993 онд УИХ-ын тогтоолоор батлагдсан Монголбанкны дүрмээр банкны үйл ажиллагаа үндсэндээ зохицуулагдаж байжээ.

Төвбанк нь бие даасан хуультай байх нь Төвбанкнаас үндсэн зорилгоо хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахад нь хөндлөнгөөс нөлөөлөх нөлөөллийг арилгаж, төв банкны бие даасан байдлыг хангаж өгөх ач холбогдолтой тул эрх зүйн үндсийг бүрдүүлэх явдлыг чухалчилж байсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Мөн судалгаагаар банкны системийн хэмжээгээр :*

- Нийт активт эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ сүүлийн 3 жилд 7 дахин буурч, цаашид санхүү, банкны системийн ашигт ажиллагааны түвшин буурах хандлагатай болсон,

- 1995 оны жилийн эцсийн дүнгээс үзэхэд: өөрийн хөрөнгийн хэмжээ 17.4 тэрбум төгрөг байгаа нь өөрийн хөрөнгө, нийт активын зохистой харьцааг хангахад 15.5 тэрбум төгрөгөөр дутагдалтай байгаа,

- Алдагдлын хэмжээ 2.3 тэрбум төгрөгт хүрсэн,

- Хугацаа хэтэрсэн зээлийн үндсэн өр (шилжиж ирсэн болон Засгийн газрын шийдвэрээр олгосон зээлээс төлөгдөөгүй үндсэн өрийг оруулан тооцвол) 27.1 тэрбум төгрөг, хүүгийн хамт 30.6 тэрбум төгрөг байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 40.7 хувь, нийт активын 13.7 хувийг эзэлж байгаа,

- Зээлийн болзошгүй алдагдлаас хамгаалах санд жилийн эцсийн байдлаар дөнгөж 3.6 тэрбум төгрөг байгаа нь шаардлагатай хэмжээнээс 15.1 тэрбум төгрөгөөр дутуу байгаа,

- Зээлийн болзошгүй алдагдлаас хамгаалах зорилгоор Монголбанкнаас тогтоосон хязгаарлалтуудыг хэтрүүлэн хувь нийлүүлэгчиддээ их хэмжээний зээл олгосон нь хугацаа хэтэрч, улмаар тухайн банкны санхүү төлбөрийн чадвар, цаашдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж эхэлсэн зэрэг нөхцөл байдлууд үүсээд байсан байна.

Төрийн мөнгөний бодлогын чиглэлийг хэрэгжүүлэх, банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийх, мөнгөний удирдлагын шинэ арга хэрэгслүүдийг үр дүнтэй ашиглахтай уялдаж цаашид банкны үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг улам боловсронгуй болгох шаардлагатай байсан бөгөөд ялангуяа олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй банк санхүүгийн системд хийх бүтцийн өөрчлөлтийн төслийн үр дүн нь хууль эрх зүйн хэр зэрэг найдвартай орчинг бүрдүүлснээс ихээхэн шалтгаалах учраас уг төслийг хэрэгжүүлэх эхний шатанд одоо үйлчилж буй Банкны хуулийг шинэчлэн боловсруулах шаардлага тавигдсаны зэрэгцээ дээр дурьдсан хүчин зүйлүүдийн улмаас банкны тухай хуулийг зайлшгүй шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон байна.

Банкны нэг хувь нийлүүлэгч, захирал ажилтан болон холбогдох этгээдэд олгох зээл, төлбөрийн баталгааны дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 5.0 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20.0 хувиас хэтрэхгүй байх, мөн дээрх хүмүүст тавигдах шаардлагыг 1996 оны Банкны хуульд тусгайлан оруулж өгснөөрөө тухайн үед банкуудад бий болоод байсан хувь нийлүүлэгчиддээ дүрмийн сангийнхаа 33,0-94,5 хүртэлх хувиар, зарим нь дүрмийн сангаасаа бүр хэтрүүлэн зээл олгосон явдлыг таслан зогсоох төдийгүй харилцагчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн ач холбогдолтой заалт болж чадсан.

Төвбанкны тухай болон Банкны тухай хуулийн төслийн аль алинд харилцагчдын эрх ашгийг хамгаалах талаар заалт ороогүй бөгөөд банкны нууцыг чандлан хадгалах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүргийг банк хариуцах ёстой. Банкны нууцыг хадгалах талаар заалт байгаа боловч хүлээх хариуцлага нь мөнгөн торгууль, зарим хохирлыг иргэний хуулиар шийдвэрлэхээр тухайн үеийн хуульд тусгагдсан байна.

Мөн банк, банктай төстэй санхүүгийн байгууллага, төрийн сан, төрийн өмчийн хороо, үнэт цаасны хороо, хөрөнгийн биржийн үйл ажиллагааны хоорондын уялдаа холбооны талаар ямар нэгэн зохицуулалт 1996 оны хуульд тусгагдаагүй байна.

Банкны тухай 1996 оны хууль мөрдөгдөж эхэлснээр банкны бүтцийн өөрчлөлтийг

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хэрэгжүүлэн банкны тогтолцоог боловсронгуй болгож эрүүлжүүлэх, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, тэдний итгэлийг бэхжүүлэх, санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлэхэд чухал алхам болсон.

*1998 оны 08 сарын 20-нд Төвбанкны болон Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар:*

Улс орон зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц өрнөж, банк санхүүгийн хямрал зэрэг шинэ нөхцөл байдал үүсч, тухайн үеийн улс төр эдийн засгийн үзэл баримтлалд тулгуурлаж боловсруулсан банкны хуулиар шинэ харилцааг зохицуулахад бэрхшээл гарч, хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгох шаардлага гарсан.

Тиймээс банкны удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захиралд тавигдах шаардлагыг өндөрсгөж, өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үүднээс дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх, банкны санхүүгийн тайлан мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэх, мөн аудитаар баталгаажуулах, олон нийтэд мэдээлэх, зар сурталчилгаа, харилцагчдын мэдээллийн нууцыг чанд хадгалахад чиглэгдсэн зарим нэмэлт өөрчлөлтийг оруулахаар хуулийн төсөл боловсруулсан байна.

Банкны үйл ажиллагааг найдвартай, тогтвортой байлгах харилцагчдийн итгэлийг алдахгүй байж, бэхжүүлэх нөхцөл нь банкны нууцлалын асуудал бөгөөд нууцлалыг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэх асуудлыг тус нэмэлт өөрчлөлтөөр оруулж ирсэн байна.

Мөн Төвбанк нь хуулийн этгээд бөгөөд өөрийн санхүүгийн үйл ажиллагаанд гарах эрсдэлийг өөрөө хариуцах ёстой бөгөөд төвбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг ЗГ-аас буюу татвар төлөгчдийн хөрөнгөд түшиглэсэн үнэт цаасаар нөхөх нь зохимжгүй бөгөөд энэ талаархи хуулийн зүйл заалтыг хүчингүй болгож, төвбанкны үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлыг тусгах шаардлагатай болсон байна.

Санхүүгийн тайлан мэдээг санаатай болон санамсаргүйгээр худлаа гаргах, зориудаар хуурамч гаргаж өгөх, түүнд тохирох хариуцлага тухайн үеийн хууль тогтоомжид байгаагүй бөгөөд Эрүүгийн хуулийн заалт хэт хуучирсан, практикт бараг хэрэглэгддэггүй байсан байна.

Тиймээс санхүүгийн тайлан нь ямар бүтэц, хэлбэртэй байх, түүнийг нийтэд мэдээлэх, Монголбанкинд ирүүлж байх, санхүүгийн тайланд аудит хийлгэх, түүнчлэн санхүүгийн тайлан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв ирүүлэхгүй бол түүнд хүлээлгэх хариуцлага, хариуцлагын субъектыг тодорхой болгож өгсөн.

Бизнесийн ертөнцөд зар сурталчилгааны гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байгаа өнөө үед банкны зар сурталчилгаа нь үнэн зөв, бодитой байснаар харилцагчдыг банкинд ойртуулах, банкны үйлчилгээг анхнаас нь зөв горимоор явуулах онцгой үүрэгтэй.

Банкны тухай хуульд банкны зар сурталчилгаа гэсэн тусдаа зүйл оруулж өгч, улмаар илт худлаа ташаа зар сурталчилгаа явуулсан, нийтэд мэдээлсэн тайлан мэдээлэлтэй зөрчилдсөн, хууль тогтоомжид нийцээгүй бол монголбанк хориглох эрхтэй, мөн худлаа ташаа зар сурталчилгаа тараасан банк, холбогдох ажилтанд хүлээлгэх хариуцлагыг тус нэмэлт өөрчлөлтөөр оруулж өгсөн.

Сүүлийн үед зээлийн хөрөнгийг хуурамч баримт бичиг үйлдэж авах, зээлээ төлөхөөс санаатайгаар зайлсхийж ашиглах, удирдсан банкаа санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох зэрэг эрүүгийн шинж чанартай үйлдлүүд гарах болсон нь зээл, түүнтэй холбоотой харилцааг зөвхөн иргэний хуулийн хүрээнд шийдвэрлэх аргагүй болж, Эрүүгийн хуульд ийм төрлийн гэмт хэргийг зүйлчлэх шаардлага гарсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үүднээс 1996 оны хуулиар банкны дүрмийн сангийн доод хэмжээг 400 сая төгрөг байсныг, 1998 оны нэмэлт өөрчлөлтөөр 1 тэрбум төгрөг болгож байсан байна.

1998 оны 8 сарын 20-нд батлагдсан төвбанкны тухай хуульд ерөнхийлөгч хориг тавьж, уг асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцэн хоригийг хүлээн авсан байна.

*2001 оны 12 сарын 28-нд Төвбанкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар:*

1996 оны Төвбанкны тухай хуулиар Монголбанкны дүрмийн сангийн хэмжээг 1 тэрбум төгрөгөөс доошгүй байхаар тогтоосон бөгөөд түүнээс хойш дүрмийн санд өөрчлөлт хийгээгүй байна.

Монголбанкны дүрмийн сангийн хэмжээ арилжааны банкныхаас 2 дахин бага, банкны системд Монголбанкны дүрмийн сангаараа эзлэх хувь 3.8%, Монголбанкны өөрийн хөрөнгөд эзлэх дүрмийн сангийн хэмжээ 2.4 хувьтай болж хэт бага түвшинд хүрсэн байна.

Манай улсын эдийн засгийн байдал, төгрөгийн ханш, банк санхүүгийн хөгжил, төлбөрийн чадвар, төв болон арилжааны банкны эрхлэх үйл ажиллагаанд ихээхэн өөрчлөлт орж, гадаадын банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах цар хүрээ өсөн нэмэгдсэнтэй холбогдуулан, олон улсын банк санхүүгийн байгууллага, хандивлагч орны засгийн газар, түншлэгч, харилцагч банк, санхүүгийн байгууллагуудын өмнө хүлээх Монголбанкны санхүүгийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, нэр хүндийг өсгөх, өөрийн хөрөнгийн зохистой бүтцийг бүрдүүлэх шаардлагатай байсан тул Төвбанкны дүрмийн сангийн доод хэмжээг 5 тэрбум төгрөгөөс доошгүй байхаар нэмэлт өөрчлөлт оруулж баталсан байна.

*2001 оны 02 сарын 02-нд Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар:*

1991 оноос хойш 27 банк байгуулагдсанаас төлбөрийн чадваргүй болсон, дүрмийн сангийн доод хэмжээ хангаагүй зэрэг шалтгаанаар 15 банкны зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Банкууд дампуурах, татан буугдахад хүрч байсан гол шалтгаан нь зээлийн чанар муугаас их хэмжээний алдагдал хүлээж байна. Татан буугдсан банкуудын нийт активын 36-100 хувийг зээл, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 70 гаруй хувийг муу зээл эзэлж байжээ.

Холбогдох хуулиудыг шинэчилж, бусад хуулиутай нийцүүлсэн хэдий ч хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг шуурхай болгох талаар эрх зүйн зарим зохицуулалтыг хийх шаардлагатай байна.

Зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаагийн гол шалтгаан нь:

- Зээлийн гэрээний хугацаа хэтэрсэн тохиолдолд банкнаас барьцаа эд хөрөнгийг шууд захиран зарцуулах эрхгүй, заавал шүүхийн шийдвэр гаргуулах шаардлагатай. Бодит байдал дээр шүүхийн шийдвэр гаргуулах, биелүүлэх ажиллагаа хангалтгүй байгаа,
- Банкны болон хууль шүүхийн ажилтнууд зээлийн хэргийг шийдвэрлэхдээ салбарын хуулийн зүйл заалтыг баримталдаггүй, иргэний болон процессийн хуулийн цөөн ерөнхий заалтыг баримталдаг,
- Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээлийн хуульд заасан дээд хэмжээг зөрчдөг, зээлийг судалгаа шинжилгээгүйгээр олгодог, зээл олгох эцсийн шийдвэрт тавих хяналт сул зэрэг зөрчил банкуудад гарсаар байна.

Зээлийн үйл ажиллагаанд гарч байгаа дээрх гажуудлыг арилгахтай холбогдуулан арилжааны банкны зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд

UIH.MN СУДАЛГААНЫ САН

төвлөрүүлсэн хөрөнгийг татвар ногдох орлогоос хасч тооцож байхаар Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд, зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны эд хөрөнгийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд тусгайлан заасан бол тухайн эд хөрөнгийг гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн банк ба банк бус санхүүгийн байгууллага захиран зарцуулж байхаар Иргэний хуульд тус тус нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Мөн банкны худалдан авах үнэт цаасны эзэмшлийн нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10 хувиас дээшгүй байна.

Энд Засгийн газар болон төвбанкнаас гаргасан үнэт цаас хамаарахгүй байхаар тусгасан байна.

*<u>2003 оны 6 сарын 20-нд Төвбанкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар:</u>*

Монголбанкны үйл ажиллагааны ил тод нээлттэй байх зарчмыг төвбанкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар төвбанкны бие даасан байдлыг бэхжүүлэх зорилтыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах үндсэн чиглэл”-д тусгаж өгчээ.

Мөн Токиод болсон ОУВС, Монгол улсын төлөөлөгчдийн хооронд болсон уулзалтын санамж бичигт тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагыг харгалзаж үзэж тус нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна. ОУВС-аас тавьсан шаардлага нь:

1. Төвбанкны захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааг өргөтгөх:
2. Захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн болон дотоодын болон хөндлөнгийн хяналт шалгалтын тогтолцоо, санхүүгийн тайланг тайлагнах үйл явцад хяналт тавьж байх Хяналтын зөвлөлийг УИХ-аас томилж ажиллуулах:
3. УИХ Төвбанкны тайланг хэлэлцэхдээ хяналтын зөвлөлийн тайланг цуг хэлэлцэж байх:
4. Төвбанкны үйл ажиллагаанд хориглох хэм хэмжээг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хийхийг санал болгосон байна.

ОУВС-аас өгсөн дээрх зөвлөмжийг судалж, Төвбанкны бие даасан байдлыг бэхжүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй байлгах, үйл ажиллагааны үр дүнг нийтэд мэдээлж байх зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж Төвбанкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон байна.

Энэ удаагийн Төвбанкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт нь зөвхөн ОУВС-аас өгсөн зөвлөмжийн дагуу Хяналтын зөвлөлийг шинээр бий болгох, тэдний үйл ажиллагаа, эрх үүрэг, тавигдах шаардлагыг тодорхойлох явдал байсан гэж ойлгож болохоор байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***Дүгнэлт***

Улс орны эдийн засгийн хөгжлийг даган манай орны санхүү, эдийн засгийн салбарын хууль эрх зүйн орчин байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж хууль, тогтоомж, дүрэм журамууд шинээр бий болсоор байна.

Банк, Төвбанкны тухай хуулийн үзэл баримтлал болон тус хуулиудад оруулсан нэмэлт өөрчлөлтүүдээс үзэхэд ирээдүйг төдийлөн харсан бус ихэвчлэн тухайн үед үүсээд байгаа нөхцөл байдлыг намжаах, зохицуулах бус тухайн нөхцөл байдалд тохируулсан нэмэлт өөрчлөлтийг хийж байжээ.

Мөн Олон улсын байгууллагуудаас төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, гадны тусламжийн

байгууллагаас хандив, зээл тусламж авахын тулд дээрх байгууллагуудаас тавьсан шаардлагын дагуу хуулиудад нэмэлт өөрчлөлтийг хийж байсан дүр зураг харагдаж байна.

Тухайлбал: 1996, 2003, 2010 онуудад хийсэн нэмэлт өөрчлөлтууд бүгд Олон улсын валютын сан-Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан гэрээний хүрээнд манай улсын урьдчилан биелүүлэх ёстой нөхцөл, манай улсад тавьсан шаардлагын хүрээнд хийгдсэн байна.

Сүүлийн үед дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон банкуудын бүх л хариуцлагыг Монголын төр хүлээж байна. Хэдийгээр Монголын төр хүлээж байна гэж байгаа боловч цаана нь татвар төлөгчдийн мөнгөөр зохицуулж байна.

Өөрийнхөө хөрөнгийг хаана байршуулах, хаана хөрөнгө оруулах гэдгийг тухайн хувь хүн өөрөө шийдэж байгаа асуудал юм. Мөнгөө тэр банкинд хадгалуул гэж заагаагүй байтал төр хариуцдаг буруу хандлага бий болоод байна.

Санхүү, эдийн засгийн хямралын улмаас төрөөс арилжааны банкуудын харилцах данс, хадгаламжид баталгаа гаргасан. Хадгаламж эзэмшигчдийн хохирлыг төрөөс хариуцах нь ихээхэн сөрөг үр дагавартай бөгөөд зарим банк ямарч хамаагүй өртгөөр, хадгаламжийн хүүгээ өсгөн эх үүсвэр татчихаад хохирол гарвал Засгийн газар, төр хариуцна гэдэг хуулийн цоорхойг ашиглан хариуцлагагүй, хууль бус үйл ажиллагаа явуулах магадлалтай юм.

Тиймээс Хадгаламжийн даатгалын тухай хуулийг яаралтай батлан гаргаж банкны эрсдэлийн хариуцлагын сонгодог тогтолцоог бий болгох шаардлагатай юм.

Хадгаламжийн даатгалын тухай хуулийг гаргаснаар ямар үүргийг төр хүлээх, ямар хэмжээний эрсдлийг арилжааны банкууд болон хувь нийлүүлэгчид, хадгаламж эзэмшигчид хариуцах вэ? гэдгийг тодорхой болгох, санхүүгийн даатгалын системийг бий болгож системийн эрсдэлээс хамгаалах боломж бүрдэх юм.

Төр, засгийн үүрэг бол зах зээлийн харилцаанд оролцогч бүх талуудын эрх ашигт нийцсэн хууль эрх зүйн орчинг бүрдүүлж өгөх явдал юм.

Түүнээс бус бизнесийн зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн дотоод үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, төрөөс мөнгө гаргаж арилжааны банкуудын хохирлыг барагдуулах нь төдийлөн үр дүнтэй арга бус, гал унтраах төдий арга юм гэдгийг шинжээчид хэлж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хуулиуд,**
**тэдгээрийн үзэл баримтлалын талаархи түүвэр хүснэгт**

*/Хуулиудын хувийн хэргээс авав/*

| **№** | ***Хуулийн нэр, батлагдсан огноо*** | ***Хуулийн төсөл боловсруулах шаардлага*** | ***Зохицуулах харилцаа, хамрах хүрээ*** | ***Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар*** | ***Өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зарим асуудал*** | ***Батлагдсан хуульд тусгагдсан байдал*** |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай**<br><br>2008.11.25<br><br>1 удаа нэмэлт өөрчлөлт орсон | Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, ОУ-ын санхүүгийн зах зээлийн хямралын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжийн баталгааг гаргах шаардлага тавигдаж байна.<br>Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хамгаалах, хадгаламжийн гадагшлах урсгалыг зогсоох зорилгоор банкуудад байршиж байгаа хадгаламжид төрийн баталгаа гаргах шаардлагатай байна. | Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор арилжааны банкин дахь мөнгөн хадгаламжинд төрөөс баталгаа гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | Энэ хууль батлагдаж хэрэгжсэнээр үндэсний банкны болон санхүүгийн салбарын тогтвортой байдал хадгалагдаж, тэр хэмжээгээр улсын эдийн засгийн аюулгүй байдал хангагдаж, олон улсын санхүүгийн хямралын нөлөөллөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ гэж Засгийн Газар тооцсон байна. | Баталгаа нь хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн хугацаанд хүчинтэй гэж орсныг 4 жилийн хугацаанд хүчинтэй байхаар баталсан байна. | Хуульд нэг удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд Энэ хуулийн 2.1-д заасан баталгаанд иргэн, хуулийн этгээдийн банкин дахь харилцах дансны үлдэгдэл нэгэн адил хамаарна гэж заажээ. Мөн нэмэлт өөрчлөлтөөр энэ хуульд хамаарагдахгүй мөнгөн хадгаламжуудыг нэмж тусгасан байна.<br>$2^{1}$.1. Дараахь төрлийн мөнгөн хадгаламж энэ хуульд заасан баталгаанд хамаарахгүй:<br>$2^{1}$.1.1. Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан “холбогдох этгээд”-ийн банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж;<br>$2^{1}$.1.2. банкинд хоёрдогч өглөг хэлбэрээр буюу тодорхой хугацааны дараа банкны хувьцаанд хөрвөх нөхцөлтэй байршуулсан мөнгөн хадгаламж болон тухайн мөнгөн хадгаламж эзэмшигчийн бусад мөнгөн хадгаламж;<br>$2^{1}$.1.3. Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэгт заасан банк, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг, 28 дугаар бүлэгт заасан албан тушаалын гэмт хэрэг, түүнчлэн терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр нотлогдсон |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | этгээдийн өөрийн болон бусдын нэр дээр байршуулсан мөнгөн хадгаламж. |
| *2* | **Санхүүгийн түрээс/лизинг/-ийн тухай**<br><br>**2006.6.22** | Одоо үйлчилж буй Иргэний хууль болон Нягтлан бодох, бүртгэлийн тухай хуульд санхүүгийн түрээсийн гэрээ, түүний хэлбэр, нөхцөл, хариуцлагын талаар тусгасан зохицуулалт байгаа боловч тэдгээр нь эд хөрөнгө хөлслөх, зээлээр худалдах, үйл ажиллагааны түрээсийн гэрээнээс ялгагдах онцлог нь тодорхой бус байгаа.<br>Мөн түүний бусад түрээсээс ялгагдах онцлог нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад заасан шалгуураар тодорхойлогдох тул хуулийн төслийг түүнтэй нийцүүлэн боловсруулах шаардлагатай байна.<br>Өнөөгийн зах зээл дэх санхүүгийн түрээсийг хөгжүүлэх, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох, санхүүгийн түрээсийн онцлогийг тодруулах шаардлагатай байна. | Тус хуулийн зорилт нь санхүүгийн түрээсийн төрөл, санхүүгийн түрээсийн гэрээг тодорхойлж, түүнийг байгуулах, гэрээний талуудын эрх үүрэг, хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.<br>Хуулийн төсөл нь 3 бүлэг, 19 зүйл бүхий бүтэцтэй байхаар боловсруулагдсан байна. | Санхүүгийн түрээс /Лизинг/-ийн тухай хууль батлагдсанаар лизингийн үйлчилгээ нь олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэх бөгөөд энэ нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах нөхцөл болж, жижиг дунд үйлдвэрүүдэд зориулсан тоног төхөөрөмжийн борлуулалт болон эдийн засагт оруулж буй нийт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг бий болгоно. Санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, банкны тухай, банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаар өргөн баригдсан байна. | Иргэний хуульд санхүүгийн түрээсийн харилцааг ерөнхий тойм байдлаар зохицуулсан бөгөөд үүнийг нарийвчлан зохицуулах тухайлбал талуудын эрх үүрэг хариуцлага, түрээсийн зүйлийг аль талын балансад бүртгэх зэрэг болон бусад асуудлуудыг хамарсан нарийвчилсан зохицуулалт дутмаг байна. Иймээс тус хуулийн төсөлд санхүүгийн түрээсийн гэрээ түүний онцлог, бусад гэрээнээс ялгагдах шалгуурыг тодорхойлж, санхүүгийн түрээсийн зүйл түүнтэй холбоотой өмчийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох, эрх үүрэг хариуцлагыг нарийвчлан зохицуулсан асуудлуудыг тусгасан гэжээ. | Дээрх хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийн төсөл бэлтгэх үүрэг бүхий 6 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллажээ.<br>Гадаад орнуудын эрх зүйн уян хатан шинэлэг хандлага гэх түрээсийн эд зүйлийг түрээслэгч болон түрээслүүлэгч нар аль талын балансад бүртгэх асуудлаа өөрсдөө гэрээгээр шийдвэрлэдэг байхаар зохицуулах нь зүйтэй гэж үзэл баримтлалд тусгагдсан нь хуулийн төслийг хэлэлцэх явцад дэмжигдэж батлагдсан байна.<br>Мөн санхүүгийн түрээсийн үйлчилгээг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу явуулах, мөн энэ хуулиар санхүүгийн түрээсийн илүү нарийвчилсан зохицуулалтыг оруулж өгчээ.<br>Хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө, байгалийн баялаг түрээсийн зүйлд хамаарахгүй гэж тусгасаныг хэлэлцүүлгийн явцад эдийн бус хөрөнгө, галт зэвсэг цацраг идэвхит бодис, химийн хорт бодис зэрэг хэрэглэх хадгалах үйлдвэрлэхэд хязгаарлал тогтоосон эд хөрөнгийг нэмж тусгасан байна.<br>Санхүүгийн түрээсийн гэрээнд түрээсийн төлбөрийн хэмжээ, түүнийг шилжүүлэх журмыг нэмж тусгасан байна.<br>Хуулийн төслийн 10-р зүйлд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гуравдагч этгээдийн эрх үүргийг багтаасныг тусад нь 11-р зүйл болгон нэмж оруулжээ. |
| *3* | **Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай**<br><br>2005.11.17<br><br>2 удаа нэмэлт өөрчлөлт орсон. | Хууль зүйн шаардлага:<br>-Улсын Их Хурлын 2004 оны 23 дугаар тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.<br>- Даатгалын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд даатгалын үйл ажиллагаар зохицуулах, хяналт тавих эрхийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр тусгагдсан.<br>*Практик шаардлага:*<br>Төрийн зүгээс банк санхүүгийн салбарын үйл ажиллагааны зохицуулалтыг олон улсын өнөөгийн чиг хандлага, өөрийн орны онцлогт тохируулан улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.<br>Сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон үнэт цаас, даатгал, лизинг зэрэг санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын тоо эрс нэмэгдэж байна. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд Монгол банк, Үнэт цаасны хороо, Улсын | Санхүүгийн зохицуулах хорооны удирдлага зохион байгуулалт үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, хорооны үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцаар зохицуулна. Хуулийн төсөл нь 13 бүлэг 41 зүйлтэйгээр өргөн баригдсан байна.<br>Хуулийн үйлчлэх хүрээнд:<br>-ББСБ-ын ББС-ийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа<br>-Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үйл ажиллагаа<br>-Даатгагчийн даатгалын тухай хуульд заасан үйл ажиллагаа<br>-даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийн даатгалын мэргэжлийн оролцогчын тухай хуульд заасан үйл | СЗХ байгууллагдан үйл ажиллагаагаа зохих журмын дагуу явуулж эхэлснээр дараахь үр дүнд хүрэх нөхцөл бүрдэнэ.<br>• санхүүгийн үйлчилгээний салбарт итгэх итгэлийг бий болгох<br>• санхүүгийн үйлчилгээний бүтээгдэхүүн, зах зээл, зуучлалын үйл ажиллагаа олон нийтэд таниулан ойлгуулах ажиллагаар дэмжих<br>• хэрэглэгчийн хамгаалалтыг зохих түвшинд хүргэх<br>• бизнесийн зохистой практик ББС-ийн үйлчилгээний зах зээлийн хөгжлийг дэмжих<br>• санхүүгийн үйлчилгээний салбар дахь гэмт хэрэг, зохисгүй үйлдлийн гаралтыг багасгах<br>1. ББСБ-ын зохицуулалт, хяналтын олон улсын жишигт нийцсэн нэгдмэл тогтолцоо бүрэлдэн тогтож, нэгдмэл удирдлагаар хангагдсанаар: | СЗХороо нь Төвбанкнаас арилжааны банкуудын үйл ажиллагаанд тавьж буй хяналтын хэмжээнд банкнаас бусад санхүүгийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй УИХ-аас батлсан байгууллага байх талаар төслийн үзэл баримтлалд тусгасан байна.<br>СЗХ-ны үйл ажиллагааны санхүүжилтын эх үүсвэрийг зөв тогтоох, санхүүгийн үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрлийн хураамжийн шалгуур, үндэслэлийг тодорхой болгох, ББС-ийн үйл ажиллагаа эрхлэгч иргэдэд хохирол учруулсан тохиолдолд маргааныг хэрхэн шийдвэрлэх, СЗХ, Төвбанк, ЗГ, СЗХ-ны хяналтын зөвлөл хоорондын харилцааны уялдааг зохистой болгох, эрх | Эдийн засгийн байнгын хорооноос үг хуулийг УИХ-ын нэгдсэн болон ЭЗБХороогоор хэлэлцэхтэй холбогдуулан бэлтгэл хангах, байнгын хорооны санал дүгнэлтийн төсөл бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг 8 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан байна.<br>Хорооны даргад УИХ-ын дарга, гишүүдэд санхүүгийн асуудал эрхэлсэн ЗГ-н гишүүн, МБ-ны ерөнхийлөгч тус бүр 2, Эдийн засгийн болон хууль зүйн байнгын хороо тус бүр 1 хүний нэр дэвшүүлж, УИХ-аас томилохоор хуулийн төсөлд тусгасныг хууль батлагдахад эдийн засгийн байнгын хороо 2, Хууль зүй, Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн, МБ-ны ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлэхээр баталсан байна.<br>ББСБ, даатгал, үнэт цаасны компаниуд, хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хяналт тавьж, зохицуулж байх үүргийг тус бүрд нь өөр өөр байгууллагууд хариуцаж байсан бол шинэ хуулиар дээрх бүгдэд 1 субъект буюу СЗХ хяналт тавьж байхаар зохицуулалт хийгдсэн.<br>СЗХ нь санхүүгийн зах зээлийг тогтворжуулах чиг үүргийг Төвбанктай хамтран хэрэгжүүлэх бөгөөд банкнаас бусад санхүүгийн байгууллагын үйл ажиллагаар хянаж зохицуулж байхын тулд төсвөөс 100 хувь санхүүжүүлэх нь оновчтой биш |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Мэргэжлийн хяналтын газар, Үндэсний татварын Ерөнхий газар зэрэг төрийн байгууллага холбогдох хуулийн хүрээнд хяналт тавьж байгаа бөгөөд Банкны бус санхүүгийн үйлчилгээ, түүний хяналтын өнөөгийн байдал, хяналтыг нэгтгэх шаардлагатай юм.<br>-ББСБ-ын нөөцийн сан, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, болзошгүй эрсдлээс хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоож, үйл ажиллагаанд нь хяналт тавьж байна.<br>-Үндэсний татварын ерөнхий газрын дэргэд хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт тавих хяналтын түр нэгж ажиллаж байна. Харин хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаанд мөрдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, түүнд хяналт тавих үүргийг Монгол банк хэрэгжүүлж байна.<br>-Үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах хяналт тавих эрхийг Үнэт цаасны хороо хэрэгжүүлж байна.<br>-Засгийн газрын тохируулагч агентлаг - Улсын мэргэжлийн хяналтын газрын харъяанд ажиллаж буй Даатгалын | ажиллагаа<br>-хоршооны тухай хуульд заасан хадгаламж зээлийн үйл ажиллагаа<br>- хуульд заасан санхүүгийн бусад үйл ажиллагаа | • санхүүгийн байгууллагууд эрсдэлээс хамгаалагдана.<br>• үйлчлүүлэгчдийн эрх ашиг хамгаалагдах нөхцөл бүрдэнэ.<br>• санхүүгийн салбарын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна.<br>• төсвийн хөрөнгийг хэмнэнэ.<br>• банк санхүүгийн системд эерэгээр нөлөөлж, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны цаашдын хөгжилд чухал түлхэц болно. | үүргийн давхардлыг арилгах, ХЗХ-дын үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрт тавих шаардлага нормыг тогтоох асуудлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай талаар гишүүд санал гаргаж шийдвэрлэсэн байна.<br>Тус улсын зах зээл тийм ч том биш, түүнчлэн төсөв хөрөнгө хэмнэх, зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах үүднээс ББСБ, даатгал, үнэт цаасны компаниуд, хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд нэг субъект хяналт тавьж, зохицуулж байх нь зохимжтой байгаа болно. Мөн банкны бус санхүүгийн нийт байгууллагуудын дунд зөрчил дутагдал бага биш байгаа нь түүнд тавьж байгаа хяналт шалгалт зохих түвшинд хүрээгүй, нөгөө талаар зохицуулалт, хяналтын уялдаа холбоо хангалтгүй байгаатай холбоотой юм. | гэж үзэж санхүүжилтын эх үүсвэр эхний ээлжинд төсвийн хөрөнгө болон үйлчилгээний хөлс гэсэн холимог хэлбэртэй байх, цаашид өөрийгөө санхүүжүүлдэг болох ингэснээр бие даасан байдал нь хангагдана гэж үзсэн байна.<br>Хуулийн төсөлтэй холбогдуулан дараахь хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгасан байна.<br>1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,<br>2. Төрийн албаны тухай хууль,<br>3. Зар сурталчилгааны тухай хууль,<br>4. Компанийн тухай хууль,<br>5. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль,<br>6. Хоршооны тухай хууль,<br>7. Төвбанкны тухай хууль,<br>8. Банкны тухай хууль,<br>9. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль,<br>10. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд тус тус нэмэлт өөрчлөлт орсон байна.<br>Монголбанкны тухай хуульд дараах агуулгатай өөрчлөлт орсон байна.<br>МБ нь СЗХ болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах 3 талт харилцан ойлголцлын санамж бичиг үйлдэж, МБанк СЗХ-той харилцахдаа энэ санамж бичгийг удирдлага болгоно. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хяналтын алба даатгалын үйл ажиллагаанд хяналт тавьж байна. | | | | |
| *4* | **Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай**<br><br>2002.12.12<br><br>3 удаа нэмэлт өөрчлөлт орсон | Монгол Улсад Банк бус санхүүгийн үйл ажиллагаааг зохицуулсан хууль эрхийн акт гараагүй байгаа бөгөөд харин Банк бус санхүүгийн байгууллага байгуулах, түүнд хяналт тавих, зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 1999 оны 668 тоот тушаалаар баталсан "Банк бус санхүүгийн байгууллагад банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах, хяналт тавих журам"-аар зохицуулж байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгаа бөгөөд үүнтэй холбогдон үүсэх харилцаар зохицуулсан тусгай хууль гаргах шаардлагатай байна. Мөн УИХ-аас 2004 он хүртэл хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тус хуулийн төслийг 2001 онд багтааж боловсруулж батлуулахаар заасан. Банк санхүүгийн системийн хэмжээнд нийт активын 60 хувийг зээл эзэлж байгаагаас харахад санхүүгийн зуучлалын үйлчилгээ нийтэд хүртээмжтэй биш байна. Мөн санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа хөдөө орон нутагт хангалтгүй | Хуулийн зорилт нь банк бус санхүүгийн эрх зүйн үндсийг тодорхойлж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх хүчингүй болгохтой холбогдуулан үүсэх харилцааг зохицуулахаар заажээ. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн төсөл нь бүтцийн хувьд 6 бүлэгтэй байна. Уг хуулийн төсөлтэй холбогдуулан захиргааны хариуцлагын тухай хууль, аж ахуйн үйл ажиллагааны тухай тусгай зөвшөөрлийн тухай хуульд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна. | Тус хуулийн төсөл батлагдсаны дараа банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг эрхлэх удирдлага, зохион байгуулалтын хэлбэр тодорхойлогдож, тэдэнд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавих, өөрчлөн байгуулах, татан буулгах, арга хэмжээ авах зэрэг тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулах, мөн тавигдах шаардлага, хориглох зүйлсийг тодорхой болгосноор хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх боломжтой болно. Түүнчлэн тус хуулийн төсөл батлагдсаны дараа иргэн, хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа санхүүгийн үйлчилгээг хуульд заасан нөхцөл, журмын дагуу банк бус санхүүгийн байгууллагаас авах болон Банк бус санхүүгийн байгууллагууд өөрийн бизнесийг тодорхой эрх зүйн орчны хүрээнд явуулах, өөрийн хөрөнгө болон санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх | Хуулийн төсөлд банк бус санхүүгийн байгууллага ашиг олох зорилгоор тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно гэж тусгасан.<br>-ББСБ-с гаргах баталгаа, батлан даалтын нийт дүн нь өөрийн хөрөнгийн хэмжээнээс ихгүй байхаар хуулийн төсөлд тусгасныг өөрийн хөрөнгийн 70 хувиас ихгүй байхаар өөрчлөн баталсан байна. | УИХ-ын гишүүн Ж.Наранцацралт, ажлын хэсгийн саналаар хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 1 дэх заалтыг задалж ББСБ дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор баталсан байна.<br>- Тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх<br>- Өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх<br>- Иргэн, хуулийн этгээдээс хадгаламж авах, хадгаламжийн данс нээх<br>- Чек, карт, вексель зэрэг төлбөрийн хэрэгслээр хадгаламж авах<br>- ББСБ-ын тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байна. Хэдийгээр банк бус санхүүгийн байгууллагын зөвшөөрлийг олгож буй эрх бүхий байгууллагаас тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа ч хяналтыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх, тэдгээр хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгохын тулд санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлага гарч байна. | | хууль, эрх зүйн таатай орчин бий болохоос гадна монгол улсын төрөөс явуулж байгаа мөнгөний бодлогыг зөв зүйтэй хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний нөлөө үзүүлэх юм.<br>Орлогын албан татварын хуулинд банк бус санхүүгийн байгууллагын болзошгүй эрсдлийн зардлыг татвар ногдох орлогоос хасаж тооцох тухай заалт байхгүйгээс болж банк бус санхүүгийн байгууллага нь өөрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдлийн зардлуудыг тооцохгүй байх, дутуу тооцох зэрэг асуудлууд гарч болох бөгөөд улмаар эрсдэл үүсэх магадлалыг бий болгон өөрийн орлогын тайланг буруу тооцох, орлогоо нуун дарагдуулах зэрэг сөрөг үр дагавар гарч болзошгүй тул орлогын албан татварын хуулинд энэ талаар өөрчлөлт оруулах шаардлагатай юм. | | |
| ***5*** | **Төв банкны тухай болон Банкны тухай хууль**<br><br>1996.09.03 | Төрийн мөнгөний бодлогын чиглэлийг хэрэгжүүлэх, банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийх, мөнгөний удирдлагын шинэ арга хэрэгслүүдийг үр дүнтэй ашиглахтай уялдаж цаашид банкны үйл | Уг хуулийн төсөл нь хуулийн үзэл баримтлал гэсэн тодорхой хэсэг байхгүй бөгөөд хуулийн төслийн танилцуулгадаа үзэл | Энэ талаар тодорхой зүйл тусгаагүй байна. | Банкны хуульд Төв банкны үйл ажиллагаатай холбогдсон асуудал нилээд ерөнхий тусгагдсан, Монголбанкны дүрэм | Банкны хуулийн төсөл нь 8 бүлэг 50 зүйлтэй,<br>**1-р бүлэгт,** хуулийн зорилт болон хэрэглэгдэх нэр томьёог тодорхойлж, банк ямар төрөл хэлбэрээр байгуулагдаж болох болон аливаа этгээдээс банкны хараат бус байдлыг |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 7 удаа нэмэлт өөрчлөлт орсон | ажиллагааны эрх зүйн үндэслэлийг улам боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна. Ялангуяа олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй банк санхүүгийн системд хийх бүтцийн өөрчлөлтийн төслийн үр дүн нь хууль эрх зүйн хэр зэрэг найдвартай орчинг бүрдүүлснээс ихээхэн шалтгаалах учраас уг төслийг хэрэгжүүлэх эхний шатанд одоо үйлчилж буй Банкны хуулийг шинэчлэн боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм. Зохистой харьцааны үзүүлэлтээ хангаж ажиллаагүй нөхцөлд ногдол ашиг хуваарилахгүй байх, түүнчлэн арилжааны банкны төлөөлөн удирдах зөвлөл болон дүрмийн санд хөрөнгө нийлүүлсэн хувь нийлүүлэгчдын эрх үүрэг, хүлээх хариуцлагын эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох, түүний биелэлтэд Засгийн газар Монголбанкнаас тавих хяналтыг хүчтэй болгох, арилжааны банк байгуулах шаардлагыг чангатгах, банкны үйл ажиллагаа явуулахыг түдгэлзүүлэн зогсоох буюу цуцлах, банкыг өөрчлөн байгуулах | баримтлалаа тусгаж өгсөн байна. Төвбанкны тухай хуулийн төсөл нь 8 бүлэг 45 зүйлтэй, Банкны хуулийн төсөл нь 8 бүлэг 50 зүйлтэйгээр анх өргөн баригдаж байжээ. | | нь банкны хуулийн ихэнхи заалтуудыг давтсан, тодотгосон шинж чанартай боловч хуультай адил түвшинд тооцогдохгүй байгаа нь Төв банкнаас мөнгөний бодлого явуулах эрх зүйн баталгааг бууруулж байна. Төв банкны эдийн засагт гүйцэтгэх үүрэг онцгой бөгөөд хэсэг бүлгийн ашиг сонирхол, улс төрийн хүчний нөлөөлөл нь түүний гүйцэтгэх үүрэгт сөргөөр нөлөөлөх нь түгээмэл байх тул Төв Банкны бие даасан байдлын эрх зүйг хангах явдал чухал болж байна. Төв Банкны тухай бие даасан хуультай байх нь Төв банкнаас үндсэн зорилтоо хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх бөгөөд энэ нь зах зээлийн эдийн засагтай орнуудад хэрэгжсэн түгээмэл бөгөөд сонгодог хувилбар юм. Зээлийн болзошгүй алдагдлаас хамгаалах зорилгоор Монголбанкнаас | хүндэтгэж, тусгай эрх олгогдсоноос бусад тохиолдолд банкны үйл ажиллагаанд оролцох, удирдлагад аливаа хэлбэрээр нөлөөлөхийг оролдох явдлыг хориглох талаар, **2-р бүлэгт,** зөвшөөрөл авсан банкнаас явуулах үйл ажиллагааг тодорхойлон, тэдгээрийг явуулах зөвшөөрөлийг банк байгуулах зөвшөөрөл авсанаас хойш 6 сарын дотор дүрмийн сангийн тогтоосон доод хэмжээг хангасан нөхцөлд тогтоосон журмын дагуу тухай бүр олгохоор, **3-р бүлэгт,** Банк байгуулахад зөвшөөрөл олгох, бүрдүүлэх баримт бичиг, тэдгээрийг хянаж шийдвэр гаргах, зөвшөөрөл олгохоос татгалзах, банкыг бүртгэх талаар, **4-р бүлэгт,** Банкны удирдлага, бүтэц, зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй тусгав. Банкны үйл ажиллагаа нь түүний удирдлагаас шууд шалтгаалах учраас банкны хувь нийлүүлэгч, удирдлагын эрх, үүргийг тодорхойлох, өөрийн хөрөнгийн шаардлага, зорилтыг илүү найдвартай хангахад чиглэсэн заалтууд, **5-р бүлэгт,** Монголбанкнаас хууль тогтоомж зөрчсөн банкны талаар шат дараалан авах арга хэмжээ болон банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлийг тодорхой тусгав. Түүнчлэн банкыг сайн дураар татан буулгах, өөрчлөн байгуулах үндсэн нөхцлүүдийн талаар, **6-р бүлэгт,** Банкинд онцгой дэглэм тогтоох үндэслэл, санхүүгийн хувьд хүндэрсэн банкийг удирдах түр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | үндэслэлүүд, үйл ажиллагааны зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хуулиар нарийвчлан тогтоох нь зүйтэй байна. | | | тогтоосон хязгаарлалтуудыг хэтрүүлэн хувь нийлүүлэгчиддээ их хэмжээний зээл олгосон нь хугацаа хэтэрч улмаар тухайн банкны санхүү төлбөрийн чадвар, цаашдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Иймд банкны нэг хувь нийлүүлэгч, захирал ажилтан болон холбогдох этгээдэд олгох зээл, төлбөрийн баталгааны дээд хэмжээ нь дүрмийн сангийн тодорхой хувиас хэтрэхгүй байх тухай заалтыг Банкны хуульд тусгах шаардлагатай байна. | зөвлөл буюу төлөөлөгчийг томилох зарчим, түүний эрх үүрэг, онцгой дэглэмийн үе дэх банкны удирдлагын үйл ажиллагаа, Төв Банкны хяналт, онцгой дэглэмийг зогсоох зэрэг үйл ажиллагаар хуульчлахтай холбогдсон заалтууд,<br><br>**7-р бүлэгт**, Банкны эрх хүлээн авах, татан буулгах үйл ажиллагаатай холбогдон үүсэх бүхий л харилцаар зохицуулах заалтууд:<br><br>**8-р бүлэгт,** Монголбанкны хянан шалгагчаас хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, ногдуулах торгуулийн хэмжээг тусгажээ. |

**Дөрөв. Валютын арилжаа, гадаад худалдаа, зээл тусламжийн холбоотой хуулиуд, тэдгээрийн үзэл баримтлалын түүвэр хүснэгт**

*/Хуулиудын хувийн хэргээс авав/*

| **№** | ***Хуулийн нэр, батлагдсан огноо*** | ***Хуулийн төсөл боловсруулах шаардлага*** | ***Зохицуулах харилцаа, хамрах хүрээ*** | ***Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар болон хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдал*** | ***Өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зарим асуудал*** | ***Батлагдсан хуульд тусгагдсан байдал*** |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | **“Гадаад валютын үйл ажиллагаар зохицуулах тухай”**<br><br>1994.05.12 | Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа өнөөгийн нөхцөлд гадаад валютаар хийх төлбөр тооцоо, гүйлгээг зохицуулах, чөлөөт валютын нөөцийг | Улсын валютын нөөцийг тодорхойлох, зарцуулах асуудлыг олон улсын практикд тогтсон зарчимд нийцүүлэн, гадаад валютын активаас | • 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. 8 дугаар зүйлийн 6, 14 дүгээр зүйлийн 6 заалтуудыг өөрчилсөн.<br>1. 8.6 дахь заалт:<br>6/ байнга оршин суугчид | 1. Төгрөгийн тогтвортой байдлыг хангах тухай, ханш тогтоох ерөнхий байдлыг хуульчлан тогтвортой мөрдөх<br>2. Монгол улсын нутаг дэвсгэр дээрх төлбөр тооцоог зөвхөн үндэсний валютаар гүйцэтгэх<br>3. Валютын харилцаар | 1. Төгрөгийн ханшийн тухай уг хуулийн 5 дугаар зүйлд тусгаж өгсөн. 5.2; 5.3; 5.4-т тусгаж өгсөн.<br>2. Уг хуулийн Хоёрдугаар бүлэгт валютын зохицуулалтын талаар төрийн байгууллагуудын эдлэх бүрэн эрхийн талаар тусгаж өгсөн. Үүнд: УИХ, Засгийн газар, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сэргээн гадаад төлбөрийн чадварыг сайжруулах, төгрөг, гадаад валютын ханшийг чөлөөт тогтолцоонд оруулж зүгшрүүлэн төгрөгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авах шаардлага тулгарч байна.<br><br>Засгийн газраас өргөн барьсан хууль | гадна, мөнгөжсөн алт, түүнтэй адилтгах бусад үнэт металл, олон улсын хэмжээнд төлбөр тооцооны хэрэгсэл болж чадах үнэт цаас, вексель, баталгаа бичиг зэргийг валютын нөөцийн хүрээнд хамааруулан зохицуулах. | гадаад төлбөр, тооцоо хийх болон гадаад бэлэн валютаар гүйлгээ эрхлэхэд хяналт тавих;”<br>2. 14.6 дахь хэсэг:<br>"6. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрсдийн гадаадаас авсан валютын зээлийг Монгол банкинд бүртгүүлнэ."<br>• 2009 оны 7 дугаар сарын 9-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон.<br>1. 5.6-д шинээр заалт нэмж оруулсан.<br>2. 18 зүйлийн 1-д 6,7 зүйлийг нэмсэн.<br>3. 15, 16, 5 дугаар зүйлийг шинэчлэн найруулсан. | зохицуулах байгууллагын эрх хэмжээ, үүрэг хариуцлагыг зааглаж өгөх, түүний биелэлтэд хяналт тавих.<br>4. Монгол банк өөрийн мэдлийн валютын нөөц, Засгийн газрын эзэмшлийн гадаад валютын нөөцийг зарцуулах эрхийг Засгийн газартай зөвшилцөн УИХ-д оруулж шийдвэрлүүлэх<br>5. Арилжааны банкны ханш Монгол банкны тогтоосон ханшаас 5-с дээш хувиар хэлбэлзэж болохгүй.<br>6. Гадаадаас авах зээлийн хувьд түүнийг эргүүлж төлөх, дотоод эх үүсвэрийг төсөвт хуримтлуулах, нэгдсэн бүртгэл хөтлөх асуудлыг Сангийн яам хариуцах, үүнтэй холбогдуулан гаднаас авах зээлд Сангийн сайд баталгаа гаргаж байх, ийм баталгаагүй зээлийн төлбөрийг Засгийн газар хариуцахгүй байхаар тусгав. | Монгол банкудын эрхийг тусгажээ. Хяналт тавих асуудлыг Дөрөвдүгээр бүлэгт оруулж өгсөн.<br>3. Засгийн газрын шугамаар авах гадаад зээлийн баталгааг Засгийн газрын зөвшөөрсөнөөр Сангийн сайд гаргах, Сангийн сайдын баталгаагүй авсан зээлийн төлбөрийг Засгийн газар хариуцахгүй байхаар 14 зүйлийн 2-т тусгаж өгсөн. |
| 2 | **“Олон улсын валютын сан, Шинэчлэл хөгжлийн олон улсын банк, Олон улсын санхүүгийн корпораци, Олон улсын хөгжлийн ассоциацид БНМАУ гишүүнээр элсэх тухай”** | БНМАУ ОУВС, ДБ-д гишүүнээр элсэх хүсэлтээ 1990 оны 7 дугаар сард тавьсан байна. Дээрхи байгууллагуудад элсэн орсноор гадаад эдийн засгийн харилцаанд нэлээттэй бодлого явуулах, дэлхийн эдийн засгийн нийтлэг зүй тогтолд тулгуурлан тус улсыг зах зээлийн системд шилжүүлэхэд шаардлагатай мэдээлэл зөвлөгөө | БНМАУ ба Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Шинэчлэл хөгжлийн олон улсын банк, Олон улсын санхүүгийн корпораци, Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын харилцааг зохицуулахад оршино. | Сангийн үйл ажиллагааны онцлог нь гишүүн орнуудын валютыг зээлдэх биш, харин зээлжүүлэх тусгай эрх буюу өөрийн үндэсний валютаар худалдаж авахад оршиж байгаа юм.<br>Эдгээр байгууллагууд элсэн орсноор гадаад эдийн засгийн харилцаанд нэлээттэй бодлого явуулах, дэлхийн эдийн засгийн нийтлэг зүй тогтолд тулгуурлан тус улсыг зах зээлийн системд шилжүүлэхэд шаардлагатай мэдээлэл зөвлөгөө авах, | | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1991.01.22 | авах, үндэсний боловсон хүчин бэлтгэх, шинжлэх ухаан техникийн дэвшлийн ололтыг өөрийн оронд нэвтрүүлэн ашиглах таатай нөхцлийг бүрэлдүүлэх ач холбогдолтой юм. Мөн дээрхи байгууллагуудаас хөнгөлттэй нөхцлөөр зээл тусламж авах, олон улсын төлбөр тооцоо, валютын системийг боловсронгуй болгох, гадаадын хөрөнгө оруулагчдаас манайд тавих итгэл, сонирхлыг дээшлүүлж, гадаад орнуудтай хамтран ажиллах ажиллагаар өргөжүүлэх боломжийг нээх юм.<br><br>БНМАУ-ын Засгийн газраас өргөн барьсан хууль | | үндэсний боловсон хүчин бэлтгэх, шинжлэх ухаан техникийн дэвшлийн ололтыг өөрийн оронд нэвтрүүлэн ашиглах таатай нөхцлийг бүрэлдүүлэх ач холбогдолтой юм. Мөн дээрхи байгууллагуудаас хөнгөлттэй нөхцлөөр зээл тусламж авах, олон улсын төлбөр тооцоо, валютын системийг боловсронгуй болгох, гадаадын хөрөнгө оруулагчдаас манайд тавих итгэл, сонирхлыг дээшлүүлж, гадаад орнуудтай хамтран ажиллах ажиллагаар өргөжүүлэх боломжийг нээх юм.<br><br>Хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй байна. | | |
| 3 | **“Ховордсон амьтан ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай”** | Амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдуулах харилцаар 1975 онд хүчин төгөлдөр болсон Вашингтоны “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай” конвенциор | Энэ хуулиар Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн олон улсын худалдааг | - Хууль батлагдаж гарснаар Конвенцийн хавсралтанд орсон амьтан ба ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн хууль бус худалдаа хязгаарлагдаж, экспорт, импортын болон ре-экспортын зөвшөөрөл авах тогтолцоо боловсронгуй болж, Монгол улс конвенцид заасан үүргээ | Уг хууль нь Үндсэн хууль болон бусад хуультай нийцэх болно. “Амьтны аймгийн тухай”, “Ан агнуурын тухай”, “Байгалийн ургамлын тухай” зэрэг Монгол улсын хуулиудаар нэн ховор, ховор амьтан, ургамлын жагсаалтад орсон Конвенцийн хавсралтад ороогүй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг гадаадад гаргах, оруулах асуудлыг зохицуулж байна. | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2002.11.07 | зохицуулж байна. Эгнээндээ 150 гаруй орныг нэгтгэсэн уг Конвенцид Монгол улс 1996 онд элсэн орсон. Конвенцийн дагуу амьтан ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалагдах харилцааг хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай байна. | зохион байгуулах, иргэн аж ахуйн нэгж, байгууллагад олон улсад худалдаалах зөвшөөрөл олгох, Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах юм. | хэрэгжүүлснээр улс орны нэр хүнд өсөх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас Конвенцийн хавсралтанд орсон амьтан ба ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн худалдаа эрхлэх хууль эрх зүйн орчин бүрдэх, олон улсын худалдааны хоригоос зайлсхийж чадах ач холбогдолтой.<br>- Хамгийн гол нь ийнхүү хууль гарснаар олон улсын зүгээс амьтан, ургамлыг хамгаалах дэмжлэг туслалцаа нэмэгдэж олон улсын хэмжээнд ховордсон амьтан, ургамлыг хамтын хүчээр хамгаалах чухал үр дагавартай болох юм.<br>- Эдийн засгийн хувьд Конвенцийн хавсралтанд орсон амьтан ба ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн олон улсын худалдаа нь жил бүр Монгол улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт 1.5 тэрбум гаруй төгрөг оруулж байгаа ба цаашид өсөх хандлагатай юм.<br>Хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй байна. | Гэхдээ уг хуулийн төсөлтэй "Амьтны аймгийн тухай", "Байгалийн ургамлын тухай" хуулиудын зарим заалтуудыг нарийвчлан уялдуулах шаардлагатай. | |
| 4 | **"Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай"**<br>2003.06.12 | Засгийн газраас 1993 онд 132, 1996 онд 247 дугаар тогтоол гаргаж Засгийн газрын шугамаар авах зээл, тусламжын асуудлыг зохицуулж ирсэн | Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар зээл, тусламж авах, түүнийг ашиглах, | Энэ хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй. Харин ч гадаадын зээл тусламуйн асуудлыг иж бүрэн зохицуулж, ингэснээр зээл, | Төсөл нь Үндсэн хууль болон өнөөдөр /2003.06.12/ хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуулиудтай зөрчилдөхгүй. Харин Нэмэгдсэн өртгийн албан татварын, Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах | - Гадаадын зээлээр хэрэгжүүлэх төслийг боловсруулах ажлыг салбарын яам хариуцан гүйцэтгэх бөгөөд олон улсын байгууллага, хандивлагч орнуудад санал болгох төслийг Засгийн газар эцэслэн шийдвэрлэж байх юм. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бөгөөд одоогоор Засгийн газрын 1999 оны 93 дугаар тогтоолоор баталсан Гадаад орон, олон улсын байгууллагаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар авах хөгжлийн албан ёсны зээл, тусламжийг зохицуулах журам үйлчилж байна. Уг журамд зөвхөн гадаадын зээд тусламжийн асуудалд оролцогч байгууллагуудын чиг үүргийг тодорхойлсон байдаг. Нийт зээл, тусламжийн ашиглалт, зарцуулалтын бүртгэл, түүнд тавих хяналт шаардлагатай түвшинд хийгдэж чадахгүйгээс зээлийн төлбөрийг төрийн санд эргэн төвлөрүүлэх асуудал хангалтгүй, тусламжийн барааг зохих хуваарийн дагуу хүргэхгүй, худалдан борлуулж орлого хөөцөлдөх, дансанд тусгахгүй үрэгдүүлэх зэрэг зөрчил гарсаар байна. Гадаадын зээл, тусламжийг эдийн засгийн шинэчлэлт болон бүтцийн өөрчлөлт, гадаад | хэрэгжүүлэх төсөл боловсруулах, зээл, тусламжийн орлогыг төвлөрүүлэх, бүртгэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна. | тусламжийн ашиглалтын үр ашиг дээшилж, эдийн засгийн өсөлт, төсвийн орлогын бүрдүүлэлтэд тодорхой хэмжээгээр эерэг нөлөө үзүүлэх болно.<br><br>Хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй байна. | тухай хуулийн төслийг боловсруулна. Тухайн зээлийн гэрээнд дотоодод төлөх татварыг албан татвараас чөлөөлөхөөр шууд заагаагүй тохиолдолд төслийн хөрөнгөөр импортлох, дотоодоос худалдаж авах бараа, тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх чиглэлээр нэмэлт оруулна. | - Гадаадын зээлийн хөрөнгийг гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Санхүү эдийн засгийн яамтай хамтран холбогдох салбарын яам хүлээн авна. Мөнгөн хэлбэрээр олгосон зээлийг Монгол банкин дах төрийн сангийн дансанд төвлөрүүлнэ. Бараа бүтээгдэхүүний хэлбэрээр авч байгаа зээлийн хөрөнгийг Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирэх тухай бүр нь бүртгэж байх бөгөөд энэхүү бүртгэлийн журмыг Санхүү, эдийн засгийн сайд батлах юм. Зээлээр хэрэгжиж буй төслийн хэрэгжилтийн тайланг улирал жилээр гаргаж, аудит хийлгэн Санхүү, эдийн засгийн яаманд ирүүлж байхаар журам тогтоосон.<br>- Гадаадын зээл тусламжийн асуудлаар төрийн байгууллагуудын эрх мэдлийг ялгаварлан тогтоосон.<br>- Гадаадын зээлийн дотоод эх үүсвэрийг зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банкинд нээсэн дансанд төвлөрүүлнэ. Гадаадын зээлийн орлогын дансны гүйлгээг гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр Монгол банк гүйцэтгэнэ. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төлбөрийн баланс, төсвийн тэнцэлтэй уялдуулан зохицуулахын тулд дээрх бүх ажиллагааг зангидаж хуулийн зохицуулалтад оруулах шаардлага тулгарч байна. | | | | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## Тав. Компани, аж ахуйн нэгж, хоршооны холбоотой хуулиуд

***Нөхөрлөл, компанийн тухай хууль*** /1995.05.11/

*Хуулийн төслийн боловсруулах шаардлага:*

1991 онд батлагдсан Аж ахуйн нэгжийн тухай хууль нь төрийн өмч дээр үндэслэсэн улсын үйлдвэрийн газруудыг хувьчилж, компанийн бүтцэд шинэ хэлбэр, маяг бүхий бизнесийн нэгжүүд олноор үүсч бэхжихэд ихээхэн түлхэц болж ирсэн. Уг хууль нь анхнаасаа шилжилтийн үеийн харилцааг зохицуулах бодлогоор нилээд товч байдлаар боловсруулагдсан байна.

*Зохицуулсан харилцаа, хамрах хүрээ:* Уг хууль нь 10 бүлэг 96 зүйлтэй. Зохицуулах харилцаа: Энэхүү хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт нөхөрлөл, компани байгуулах, бүртгүүлэх, тэдгээрийн удирдлага, хяналтын бүтцийг тогтоох, үйл ажиллагаа явуулах, өөрчлөгдөн зохион байгуулах, татан буулгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино

*Өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зарим асуудал:*

- Ерөнхий зүйл гэсэн эхний хэсэгт бүртгэх байгууллагын үүргийг өмнөхөөс тодруулж тусгасан. Америк, Канад зэрэг орнуудад бүртгэлийн үүргийг бие даасан “бүртгэлийн байгууллага /худалдааны бүртгэл/ гүйцэтгэдгийн гадна зарим оронд /Итали, Герман, Унгар/ шүүх гүйцэтгэдэг боловч илүү орон тоо, зардал нэмэгдүүлэхгүйн тулд татварын алба бүртгэдэг журмыг хэвээр үлдээв.

- Мөн хэсэгт “нөхөрлөл, компани хэлбэр, зохион байгуулалтаа өөрчлөх”, оршин байгаа газрыг нь тогтоох, өөрчлөх, бүртгүүлэх”, “салбар байгуулах”-тай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зүйл заалтуудыг нэмж тусгав.

- Компани гэсэн 3-р хэсэгт “хувьцаа”, “хөндлөнгийн хяналт”, компанийн бүртгэл, тайлан, “өөрчлөн байгуулагдах” гэсэн 4 бүлэг 40 гаруй зүйл шинээр нэмж оруулав.

- Одоогийн хуульд байгаа дотоодын хяналтын үүрэг бүхий ач холбогдол багатай хяналтын зөвлөлийг шаардлагагүй гэж үзэж төсөлд тусгаагүй ба компанийн болон удирдлагын үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагаас эрх олгогдсон мэргэшсэн хянан шалгагч /ня-бо/ хөндлөнгөөс хяналт тавихаар болгож тэдгээрийн эрх хэмжээ, үүрэг хариуцлагыг илүү тодорхой болгов.

- Түүнчлэн захирлуудын эрх хэмжээ, гүйцэтгэх үүргийг тодорхойлж тэдгээрт хүлээлгэх хариуцлагыг шинээр нэмж түүнийг тайлан балансын үр дүнтэй уялдахаар тусгав.

- Шинээр тусгасан бүлэг зүйлүүдэд “хувьцаа, облигаци гаргах”, “эд хөрөнгө үнэлэх”, “үүсгэн байгуулагчдад давуу эрх олгох”, “компани нийлж, нэгдэх, салж тусгаарлах”, харилцан хувьцаа эзэмших зэрэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах асуудлыг дэлгэрүүлж тусгав.

*Хуулийн зарим хэсэг хүчингүй болсон байдал:* 1999.07.16

Нөхөрлөл, компанийн тухай хуулийн зарим хэсэг, зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай.

1 дүгээр зүйл: Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 3-р хэсэг, 6 дугаар зүйлийг тус тус

2 дугаар зүйл: Нөхөрлөл компанийн тухай хуулийн нэр, нэгдүгээр бүлгээс

UIH.MN СУДАЛГААНЫ САН

"компани", "салбар" гэсэн үгийг тус тус хасаж хүчингүй болгосон.

***Хоршооны тухай хууль*** /1995.05.16/

*Хуулийн төслийн боловсруулах шаардлага:*

Олон улсын хэмжээнд тогтоосон хоршооллын зарчимд нийцэхгүй, энгийн нөхөрлөлийг бүрэн хариуцлагатай хоршоо, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг бүрэн бус хариуцлагатай хоршоо гэж ташаа нэрлэснээс аж ахуйн нэгж буюу хуулийн этгээдийн эрхгүй, удирдлагын зохион байгуулалтгүй иргэд тодорхой үйл ажиллагаа явуулахад хөрөнгө, хөдөлмөрөөрөө хоршиж хоршоо байгуулдаг, хоршоо өсч өндийхөөрөө компани болон өөрчлөгддөг гэсэн буруу ойлголтыг бий болгосон.

- Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "бүрэн бус хариуцлагатай гишүүн хоршоог удирдан, төлөөлөх эрхгүй" гэж заасан нь хоршооны ардчилалтай зөрчилдөж байна.

- Хоршоо нь сайн дурын үндсэн дээр өөрсдийн нийтлэг ашиг сонирхолыг хангахын тулд хөдөлмөрөө хоршиж, эд хөрөнгөө нэгтгэх замаар аж ахуй эрхлэн, үйл ажиллагаагаа өөрөө удирдах зарчимд үндэслэн явуулж, хүн бүрийн идэвхитэй хөдөлмөрийн үр дүнд бий болсон ашгийг шударгаар хуваан, оногдох хариуцлагыг тэнцүү хүлээхээр эвлэлдэн нэгдсэн хувь хүмүүс, хуулийн этгээдийн нэгдэл юм.

Дэлхийн улс оронд өнөөдөр төр, засгийн газар нь өөрөө бүрэн дүүрэн шийдэж чадахгүй байгаа болон том үйлдвэр, компаниудын төдийлөн анхаардаггүй нийгэм, эдийн засгийн олон тулгамдсан асуудлыг хоршооны тусламжтайгаар шийдвэрлэж байна.

*Зохицуулсан харилцаа, хамрах хүрээ:* Уг хууль нь: 8 бүлэг 31 зүйлтэй. Зохицуулах харилцаа: Энэхүү хуулийн зорилт нь Монгол Улсын Хоршооны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, хоршоог үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах, удирдлагын зохион байгуулалт, гишүүний эрх, үүрэг, хоршооноос холбоонд нэгдэх болон хоршоодын холбооны үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

*Өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зарим асуудал:*

1991 онд батлагдсан Аж ахуйн нэгжийн тухай хуулинд хоршооны талаархи буруу ойлголтыг засаж залруулж, хоршоог аж ахуйн нэгжийн нэг төрөл бус, харин хувь хүмүүс тэрчлэн хуулийн этгээдүүдийг нэгтгэсэн хуулийн этгээдийн нэг хэлбэр мөн болохыг тодорхойлсон.

- Хоршоо нь өөрөө ашиг олох явдлыг гол зорилгоо болгодоггүй, хувь хүн болон хуулийн этгээдүүдийн үүсгэл санаачилгаар байгуулагдан тэдний хамтран тодорхой зорилтыг шийдэх, ашиг олох, аж ахуй эрхлэх арга хэлбэр болохыг хуульчлав.

- Хоршооны өмч нь иргэдийн дундын хэсгээр өмчлөх хувийн өмчийн хэлбэр юм. Энэ нь хоршоонд эзэнгүй өөрөөр хэлбэл дундын үл хуваагдах өмч байхгүй гэсэн ойлголт.

Хоршооны гишүүн нь ямар ч үед, ямар ч хугацаа өнгөрсөн байх тохиолдолд, хоршооны эд хөрөнгөнд оруулсан өөрийн өмчөө /хувь хөрөнгөө/ тодорхой мэддэг, түүнийгээ аваад хоршооноос хэзээд ч гарах эрхтэй байдаг. Хоршоо дундын хоршооны болон, хоршоодын холбооны өмч ч мөн адил ийм журмаар гишүүн хоршоодод хуваагддаг байхаар тусгалаа.

- Хоршооны төрөл тэдгээрийн ялгааг тодорхойлов. Ингэснээр хэрэглээний хоршоонд эд хөрөнгөө нэгтгэн гишүүн болсон этгээд нь заавал хоршоонд ажиллах албагүй ба хоршоонд ажиллаагүй тохилдолд хоршооны хүлээх хариуцлагыг зөвхөн хоршоонд оруулсан өөрийн эд хөрөнгийн хэмжээнд хүлээхээр зааж өглөө.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Харин үйлдвэрлэлийн хоршоонд бүх гишүүд нь хоршооны үйл ажиллагаанд эд хөрөнгөө нийлүүлэн биечлэн оролцох үүрэгтэй ба хэрэв хоршооны эд хөрөнгө тухайн үүрэгтэй холбоотой төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол гишүүд өөрийн эд хөрөнгөөр төлбөрийг хариуцна.

- Хоршоонд нэг гишүүнээс оруулах хувь хөрөнгийн хэмжээ хоршооны нийт эд хөрөнгийн гуравны нэгээс илүүгүй байхаар хуулийн төсөлд тусгасан нь хоршоонд гишүүн бүр оруулсан хувь хөрөнгөнөөсөө үл хамааран саналын нэг эрхтэй байдагтай холбоотойгоос гадна хоршоонд аль болохоор гишүүд тэгш эрхтэй байх хоршооны өөрийнх нь шинж чанарыг тодруулахыг зорьсон юм.

- Хоршоонд эвлэлдэн нэгдэж хоршоодын холбоог байгуулан эрх ашгаа хамгаалуулах, үйл ажиллаагаа нэгтгэх, төрөөс хоршоодтой харьцах зарчмыг тусгаж өглөө.

*Батлагдсан хуульд тусгагдсан байдал:*

6 дугаар зүйл:

Хоршоог байгуулах. Хоршоог иргэн, хуулийн этгээдүүд санаачилж 3-аас доошгүй хүнтэйгээр байгуулж болно.

7 дугаар зүйл. Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг, түүнийг бүрдүүлэх журам.

1. Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг нь хоршооны дүрэм байна.

8 дугаар зүйл: Хоршоог бүртгүүлэх журам.

1. Хоршоог үүсгэн байгуулагчид дүрмээ баталсанаас хойш 30 хоногийн дотор бүртгэх байгууллагад бүртгүүлэх өргөдөл гаргана. Өргөдөлд дүрмийг хавсаргана.

2. Бүртгэх байгууллага өргөдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

***Компанийн тухай хууль*** /1999 .07. 02/

*Хуулийн төслийг боловсруулах шаардлага:*

Зах зээлийн харилцаанд шилжин орсоноор манай оронд дэлхий нийтийн жишгийн дагуу аж ахуй эрхлэх янз бүрийн хэлбэр өргөн нэвтэрч байгаагийн дотроос компани нь олон хүний эрх ашиг, сонирхлыг хөндсөн улс орны эдийн засагт гүйцэтгэх үүргийн хувьд бусад аж ахуйн нэгжээс илүү нөлөө бүхий хэлбэр юм.

1990 оноос хойшхи хугацаанд компанийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн бөгөөд энэ хугацаанд аж ахуй эрхлэхтэй холбоотой хуулийг 3 удаа өөрчлөн одоо Нөхөрлөл компанийн тухай хуулиар компанийн үйл ажиллагааг зохицуулж байна.

Одоогийн мөрдөж буй хуулийг бусад орнуудын энэ чиглэлийн хуулийн зохицуулалттай харьцуулж үзэхэд нарийвчлан авч үзэх, тодруулах болон компанийн өөрчлөн байгуулалт, үнэт цаас, хувь нийлүүлэгчдийн эрх үүрэг ялангуяа томоохон хувийн хувьцаа эзэмшигчдийн үүрэг хариуцлагын талаар хуулинд нэмэлт зохицуулалт зайлшгүй хэрэгтэй байгаа юм.

Иймээс 1997 оны эцсээр компанийн хуулийг шинэчлэх зорилгоор Сорсын Сангийн шугамаар хамтарсан төсөл хэрэгжүүлж Колумбын Их Сургуулийн профессор Б.Блэк компанийн сонгодог загвар жишигт нийцсэн Монгол улсын компанийн тухай хуулийн төслийг анхлан боловсруулсан.

Энэхүү төслийг үндэслэн Улсын Их Хурлын Эдийн Засгийн Бодлогын Байнгын

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хороо, Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Түр Хорооноос санаачлан Засгийн Газрын болон бизнесийн холбогдох газруудыг оролцуулсан тусгай семинар зохион байгуулж уг хуулийн төслийн талаар дэлгэрэнгүй ярилцаж санал бодлоо нэгтгэн Компанийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан байна.

*Зохицуулсан харилцаа, хамрах хүрээ:* Уг хууль нь 14 бүлэг 98 зүйлтэй. Энэ хуулийн зорилт нь компанийг үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөн байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувь нийлүүлэгчдийн эрх үүргийг тогтоох болон татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*Хуулийн үйлчлэх хүрээ:*

- Энэ хууль болон Монгол Улсын бусад хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулж буй бүх компани өмчийн хэлбэр, эд хөрөнгө, дотоод зохион байгуулалтаас үл хамааран энэхүү хуулийг мөрдөнө.

- Банк, санхүү, даатгал, үнэт цаасны салбарт компани байгуулан ажиллуулах нийтлэг асуудал нь энэ хуулиар зохицуулагдаж үйл ажиллагааны онцлогтой холбогдсон асуудлыг бусад хуулиар зохицуулж болно.

- Төрийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчлах замаар байгуулагдсан компанийн үйл ажиллагааг энэ хуулиар, эдгээрийг үүсгэн байгуулахтай холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулагдана.

- Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн ба орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

- Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн өмчит компанийн үйл ажиллагааг энэхүү хуулиар зохицуулна. Энэ тохиолдолд өмчлөгч нь төр байх бөгөөд хувь нийлүүлэгчид нь Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага байна.

*Өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зарим асуудал:* Одоогийн мөрдөж буй хуулинд хуулийн үйлчлэх хүрээний тухай тодорхойлолт байхгүйгээс компанитай холбогдсон харилцааг зохицуулах нь тодорхой бус байв.

Шинэ төсөлд компаний тухай хууль материаллаг салбарт байгуулагдсан компаниас гадна мөнгө, санхүү, даатгал, үйлчилгээ, жуулчлалын салбарт байгуулагдсан компанийн нийтлэг харилцааг зохицуулахын зэрэгцээ компаний хэлбэрээр ажиллах төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь энэ хуулиар зохицуулагдаж байхаар төсөлд тусгав. .

- Компанийн хэлбэрийг тодорхой болгож хувьцаат компанийг нээлттэй, хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хаалттай компаний хэлбэр юм гэдгийг хуульчилж, тэдгээрийн эрх зүйн үндсэн заагийг тогтоолоо. Мөн хараат болон охин компанийн эрх зүйн тодорхойлолтыг өгөв.

- Компанийн дүрэм нь компанийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг бөгөөд үүнийг үүсгэн байгуулагчдын хурлаар баталж байхаар тусгалаа.

- Компанийг шинээр болон өөрчлөн байгуулах гэсэн 2 аргаар байгуулж болохоор заагаад, компанийг байгуулах, бүртгүүлэх ажиллагаа аль болох хялбар байх зарчмыг баримталсан.

- Практикаас урган гарсан шаардлагын үүднээс компануудын нэгдэж нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх, өрийг хувьцаагаар солих гэх мэт компанийн өөрчлөн

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

байгууллалттай холбогдсон харилцааны зохицуулалтыг энэхүү хуулийн төсөлд тусгай бүлэг болгож нарийвчлан заалаа.

- Хуулийн төсөлд нягтлан бодох бүртгэлийн стандарт болон дэлхийн нийтийн ерөнхий жишигт нийцүүлэн өмнөх хуулиудад байсан дүрмийн сан гэдэг ойлголтыг хасч, компанийн өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө гэсэн ойлголтуудыг оруулж тэдгээрийн байх доод хэмжээг компануудын төрлөөр нь зааж өгсөн.

- Хянан шалгах зөвлөл болон аудиторыг байлгах эсэх асуудлыг хаалттай компанийн хувьд дүрмээрээ зохицуулах, нээлттэй компанийн хувьд аудиторын хяналт заавал байх, Хянан шалгагчийн зөвлөл байлгах эсэхээ дүрмэндээ заахаар төсөлд оруулсан.

- Компанийн эрх барих байгууллага болох хувь нийлүүлэгчдийн хурлын талаар одоогийн мөрдөж буй хуулинд тодорхой бус байгааг олон улсын нийтлэг жишгээр зохицуулсан

<u>*Батлагдсан хуульд тусгагдсан байдал:*</u>

11 дүгээр зүйл. 11.1. Компанийг шинээр буюу байгаа хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах /нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, хувьчлах, өөрчлөх/ замаар байгуулж болно.

12 дугаар зүйл. Компанийг үүсгэн байгуулагч нь Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харъяалалгүй хүн байж болно.

12.5.4 хуульд заасан бусад

12.6. Компанийн үүсгэн байгуулагчид компанийг бүртгэхээс өмнө үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг хамтран хариуцна. Үүсгэн байгуулах хурлын буюу Төлөөлөн удирдах зөвлөлийн, хэрэв нэг үүсгэн байгуулагчтай бол энэхүү үүсгэн байгуулагчийн шийдвэрээр зардлыг компани хариуцаж болно.

12.7. Компанийг үүсгэн байгуулахтай холбогдож гарсан зардлыг төлсөн этгээд нь үүсгэн байгуулагчдаас энэхүү зардлыг нэхэмжлэн авах эсвэл гаргасан зардлын хэмжээнд ноогдох хувьцаа, ноогдол эзэмших эрхтэй.

## Зургаа. Ашигт малтмалын холбогдолтой хуулиуд

***Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын талаар:***

<u>*Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага*</u>

Ашигт малтмалын тухай хуулийг дараахь үндэслэл, шаардлагаар шинэчлэн найруулна.

Ашигт малтмалын тухай хууль хэрэгжиж ирсэн 9 жилд анхаарч үзвэл зохих олон асуудал хуримтлагдаж үүнийг засаж залруулах нийгмийн зайлшгүй шаардлага тулгарч энэ хуулийг эрх зүйн шинэ цагийн шаардлагад нийцүүлэх хойшлуулашгүй зорилт тулгарч байна.

Геологи, уул уурхайн салбар нь улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг тодорхойлох гол цөм нь бөгөөд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллага лицензийг олон тоогоор эзэмшдэг, лиценз бүхий талбайдаа геологи хайгуулын ажлыг тэр бүр хийдэггүй, лицензээ бусдад шилжүүлэх нь

UIH.MN СУДАЛГААНЫ САН

дасал болсон гаж үзэгдэл болж улмаар татварын гадна оршиж лиценз нь арилжааны хэрэгсэл болж байгаа сөрөг үзэгдлийг холбогдох эрхийн актаар зохицуулж ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз олгох, шилжүүлэх үйл ажиллагааг зөв гольдиролд нь оруулж ил тод, шударга байдлыг тогтоох шаардлага бий болсон байна. Уул уурхайн салбарын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, лиценз эзэмшигч аж ахуйн нэгж, иргэдийг лицензтэй талбайдаа хайгуул, судалгааны ажил хийх, ашигт малтмал олборлох үйл ажиллагааг эрчимжүүлэх эдийн засгийн болон зохицуулалтын механизмыг бий болгох, өмнө нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологийн судалгааны үр дүнд илэрсэн орд газруудыг улсын эрх ашиг, хэтийн бодлогод нийцүүлэн дэс дараатай ашиглалтад оруулах нь чухал байна.

Ашигт малтмалын хайгуул, олборлолтын бодлого, түүний хэрэгжилтийг хангах талаар төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагын эрх, үүргийг тодорхой болгох, лиценз эзэмшигчдийн хариуцлагыг чангатгах шаардлага нэгэнт бий болсон байна.

Ашигт малтмалын хайгуул, олборлолтын явцад орон нутгийн захиргаа, иргэд болон лиценз эзэмшигчдийн хооронд гарч буй зөрчлийг арилгахтай холбогдсон харилцааг боловсронгуй болгох эрх зүйн зохицуулалт шаардагдаж байна.

Байгаль орчны нөхөн сэргээлтийг шинэ шатанд гаргаж, энэ талаархи лиценз эзэмшигчдийн хариуцлагын тогтолцоог эрс дээшлүүлэх шаардлагатай байна.

*Хоёр. Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ*

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараахь харилцааг зохицуулсан нэмэлт, өөрчлөлтийг тусгана.

1. Улсын эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах, гадаад, дотоодын зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх ашигт малтмалын ордыг "Хөгжлийн стратеги ач холбогдол бүхий ашигт малтмалын орд" гэж нэр томъёоны хэсэгт нэмэлт оруулна.

2. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул нь хийгдсэн хөгжлийн стратегийн ач холбогдол бүхий ордуудад 50-иас доошгүй хувиар төр оролцож байхаар хуульд нэмэлт оруулна.

3. Монгол Улсын Үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг харгалзан хүнд элементүүдийн изотопын ордуудыг төр өөрийн хяналтанд авч байхаар хуульд нэмэлт оруулна.

4. Эрдэс баялгийн зөвлөл байгуулж ажиллуулах эрхийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгохоор нэмэлт оруулна.

5. Геологи, уул уурхайн кадастрын алба нь ашигт малтмал ашиглах лиценз олгосон, ашигт малтмал ашиглах лицензийн хугацааг сунгасан, ашигт малтмал ашиглах лиценз шилжүүлсэн, ашигт малтмал ашиглах лицензээр олгогдсон талбайг хэсэгчлэн шилжүүлсэн талаархи мэдээллийг ажлын 7 өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн болон татвар, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн лицензээр олгосон талбай оршиж буй аймаг /нийслэл/-ийн Засаг дарга, геологи, уул уурхайн мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж, албан ёсоор нийтэлж, нийтэд мэдэгдэж байхаар хуулийн холбогдох заалтуудад нэмэлт оруулна.

6. Лицензийн төлбөрийн болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг тухайн лицензийн талбай оршиж буй аймаг, сум, улсын нэгдсэн төсөвт хуваарилж байхаар хуулийн төсөлд нэмэлт оруулна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

7. Лицензтэй холбогдсон маргаантай асуудал нь шүүхэд хянагдаж байгаа бол шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэл шилжүүлэхийг хориглох тухай заалт нэмж оруулна.

8. Хөрөнгө оруулалтын босгыг 10 дахин нэмэгдүүлж, ашиглалт явуулах ордынхоо нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, тухайн ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл хийсэн ашигт малтмал ашиглах лиценз эзэмшигч нь хүсэлт гаргавал Монгол Улсын Засгийн газар эрх олгосноор Сангийн болон Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд тогтвортой байдлын гэрээг байгуулж байхаар, хөрөнгө оруулалтын хэмжээ 20,0 сая америк доллараас 50,0 сая ам. доллар бол Засгийн газар, 50,0 сая америк доллараас дээш бол Улсын Их Хурлаар тус хэлэлцэж шийдвэрлэх, тухайн төслийн эхний 5 жилд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацааг тодорхойлсон техник, эдийн засгийн үндэслэлийг өргөдөлтэй хамт ирүүлэхээр хуулийн холбогдох зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулна.

9. Уул уурхайн салбараас төсөвт орж буй орлогыг нэмэгдүүлэх, орлогын хуваарилалтыг оновчтой болгох зорилгоор хайгуулын лицензийн эхний 3 жилийн төлбөрийг 5 дахин нэмэгдүүлж, ашиглалтын лицензийн төлбөрийг нэмэгдүүлж га тутамд 15 ам.доллар болгохоор хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулна.

10. Лиценз эзэмшигч нь уг лицензийг эзэмших эрх бүхий этгээдтэй Иргэний хуульд нийцүүлэн гэрээ байгуулсан, эсхүл өв залгамжлах, аж ахуйн нэгжүүд нэгдэж нийлэх, дампуурах зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдлуудад лицензийг шилжүүлж болно. Лицензийг шилжүүлсэн тухай бүр Геологи, уул уурхайн кадастрын албанд энэ зүйлд заасны дагуу бүртгүүлэх ба ийнхүү бүртгүүлснээр лицензийг шилжүүлсэн нь хүчин төгөлдөр болохоор хуулийн төсөлд нэмэлт оруулна.

*Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар*

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар гарахгүй гэж үзэж байгаа бөгөөд хуулийн дагуу олгогдсон тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг бүрэн биелүүлэн ажиллаж буй хөрөнгө оруулагчдын эрх ашиг улам бүр хамгаалагдаж, хөрөнгө оруулалтад нөлөөлөх сөрөг нөлөө гарахгүй болно.

Лиценз эзэмшигчийн эрх үүрэг тодорхой болж, хуулиар хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх механизм боловсронгуй болно.

Лиценз олголтод оршиж буй өнөөгийн сөрөг үзэгдэл арилж, лиценз олгох, шилжүүлэх үйл ажиллагааны ил тод байдал дээшлэхийн хамт шударга нээлттэй тогтолцоо бий болно.

Ашигт малтмалын лицензийн төлбөрийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлснээр тус салбараас улс орны эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр өсч, төлбөрийн зарим хэсгийг зохистой хуваарилах механизм бий болгож, орон нутгийн эдийн засгийн хөгжилд түлхэц болохын дээр нутгийн иргэд, уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн хоорондын ойлголцол, хамтын ажиллагаа бэхжиж дээшлэх болно.

Эдийн засгийн энэ механизм нь нэг аж ахуйн нэгж, иргэн лиценз олноор нь эзэмшиж, лицензтэй талбайд геологи, хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулахгүй арилжааны хэрэгсэл болгож байгаа сөрөг үзэгдлийг таслан зогсоох хөшүүрэг болно. Лиценз эзэмшигчдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх механизмыг бүрдүүлснээр геологи хайгуулын болон ашиглалтын ажлын цар хүрээ тэлж, эрчимжихийн хамт байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил шинэ шатанд гарах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай уялдах,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа болно.

Уул уурхайн салбараас төсөвт орж буй орлогыг нэмэгдүүлэх, орлогын хуваарилалтыг оновчтой болгох зорилгоор хайгуулын болон ашиглалтын лицензийн төлбөрийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх, лицензийн төлбөрийн зарим хэсгийг орон нутгийн төсөвт хуваарилах асуудлыг зохицуулахаар Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Байгаль орчныг эвдэн сүйтгэсэн, бохирдуулсан этгээд нь нөхөн сэргээдэг олон улсын зарчмыг нэвтрүүлэх, энэ талаархи хариуцлагын тогтолцоо, лиценз эзэмшигчдийн хүлээх хариуцлагыг эрс дээшлүүлэх зорилгоор байгаль орчныг нөхөн сэргээх журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэнд, мал амьтан, байгаль орчинд үлэмж хэмжээний хохирол, эсхүл их хэмжээний хохирол учирсан тохиолдолд тус бүрт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг судална.

***Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тухай танилцуулга:***

Ашигт малтмалын тухай хууль нь геологи, уул уурхайн салбарт гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтыг өргөнөөр татах, ялангуяа геологийн судалгаа болон эрэл хайгуулын ажилд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд багагүй үүрэг гүйцэтгэж байна.

Энэ хууль хэрэгжиж ирсэн 9 жилд анхаарч үзвэл зохих олон асуудал хуримтлагдаж, үүнийг засаж залруулах нийгмийн зайлшгүй шаардлага тулгарч энэ хуулийг шинэ цагийн шаардлагад нийцүүлэх хойшлуулшгүй зорилт тулгарч байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага лицензийг олон тоогоор эзэмшдэг, лиценз бүхий талбайдаа геологи хайгуулын ажлыг тэр бүр хийдэггүй, лицензээ бусдад шилжүүлэх нь дасал болсон гаж үзэгдэл болж, улмаар татварын гадна оршиж лиценз нь арилжааны хэрэгсэл болж байгаа сөрөг үзэгдлийг холбогдох эрхийн актаар зохицуулж ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз олгох, шилжүүлэх үйл ажиллагааг зөв гольдролд нь оруулж ил тод шударга байдлыг тогтоох шаардлага бий болсон байна.

Уул уурхайн салбарын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, лиценз эзэмшигч аж ахуйн нэгж, иргэдийг лицензтэй талбайдаа хайгуул, судалгааны ажил хийх, ашигт малтмал олборлох үйл ажиллагааг эрчимжүүлэх эдийн засгийн болон зохицуулалтын механизмыг бий болгох, өмнө нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологийн судалгааны үр дүнд илэрсэн орд газруудыг улсын эрх ашиг, хэтийн бодлогод нийцүүлэн дэс дараатай ашиглалтад оруулах нь чухал байна.

Иймд Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн явцад гарсан эерэг, сөрөг үр дагаварыг харгалзан практик амьдралд гарч буй зарим харилцааг боловсронгуй болгох чиглэлээр Ашиг малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөл нь дараахь зарчимд тулгуурлаж байгаа болно.

Үүнд: Геологи, уул уурхайн салбарын улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулах цаашдын хувь хэмжээг нэмэгдүүлэх;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул нь хийгдсэн хөгжлийн стратеги ач холбогдол бүхий ордуудын жагсаалтыг баталж ордыг ашиглахад төрийн оролцооны хувь хэмжээг тогтоох асуудлаар лиценз эзэмшигчтэй гэрээ байгуулж болох;

- Ашигт малтмалын тухай хуулийн одоо үйлчилж буй үндсэн үзэл баримтлалыг хэвээр хадгалж, практик амьдралтай зөрчилдөж буй харилцааг өөрчлөн шинэчлэх;

- Лиценз олголтын ил тод, шудрага, хөнгөн шуурхай байдлыг хангах, аливаа маргаан шудрага бус үйлдлээс сэргийлсэн тогтолцоог бүрдүүлэх;

- Лицензийн арилжааг татварын тогтолцоонд оруулж, далд наймааг зогсоох эдийн засаг, санхүүгийн механизмыг бий болгох;

- Хөрөнгө оруулагч тухайн төсөлд 50,0 сая америк доллараас багагүй хөрөнгө оруулсан тохиолдолд тодорхой хугацаанд татварын орчинг тогтвортой байлгах асуудлаар хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болох;

- Лиценз авсан талбайдаа геологи хайгуулын ажил хийх, олборлолт явуулах, байгаль орчныг нөхөн сэргээх талаар хүлээх хариуцлагыг эрс дээшлүүлэх;

- Ашиглалтын лиценз авахад тухайн ордын нөөцийг Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байх, хөгжлийн стратеги ач холбогдол бүхий ордын хувьд тухайн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулсан байх, хайгуулын лицензийн эхний 3 жилийн хугацаанд хайгуулын ажил хийгээгүй тохиолдолд лицензийг цаашид сунгахгүй байх;

- Лиценз эзэмшигч, нутгийн захиргааны байгууллагын хоорондын харилцааг боловсронгуй болгох, нутгийн захиргааны байгууллагын эрх, үүргийг дээшлүүлэх, ашигт малтмалын орлого, хураамжийн зохих хэсгийг орон нутагт төвлөрүүлэх зэрэг болно.

Хувийн хөрөнгөөр судалгааны ажил хийж нөөц нь тогтоогдсон орд газрын хувьд төрийн оролцоо байхгүй, төр өөрөө хүсвэл холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хувьцаа худалдан авах эрх нээлттэй байгаа болно.

Зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөц нь тогтоогдсон хөгжлийн стратеги ач холбогдол бүхий ордуудад төрийн оролцооны талаар лиценз эзэмшигчтэй гэрээ байгуулахаар хуулийн төсөлд тусгав.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз олгох үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа хийсэн талбайд дуудлага худалдааны аргаар лиценз олгож байхаар хуулийн төсөлд тусгаж байна.

Дуудлага худалдааны хэлбэр нь лиценз олгох үйл ажиллагааг шударга болгож, лиценз тойрон гардаг аливаа маргаан, үл ойлголцлыг таслан зогсооно гэж үзэж байна.

Лиценз эзэмшигч нь уг лицензийг эзэмших эрх бүхий этгээдтэй Иргэний хуульд нийцүүлэн гэрээ байгуулсан, эсхүл өв залгамжлах, аж ахуйн нэгжүүд нэгдэж нийлэх, дампуурах зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолуудад лицензийг шилжүүлж болохоор хуулийн төсөлд тусгав. Ингэснээр лиценз худалдан авсан зардал ил тод болж, лиценз зарсан хуулийн этгээдээс татварын байгууллага холбогдох татвараа авч байх эдийн засгийн механизм бий болох юм.

Нутгийн захиргааны байгууллага, лиценз эзэмшигчдийн хоорондын харилцааг боловсронгуй болгох, газрын талаар гарч байгаа маргаан, зөрчлийг арилгах зорилгоор аймаг, нийслэл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрынхаа тухай мэдээллийг шийдвэр гарснаас хойш 1 сарын дотор Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын Геологи, уул уурхайн кадастрын газарт ирүүлж байх,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

аймаг, нийслэлийн Засаг дарга нар ашигт малтмалын лиценз олгох тухай саналаа 30 хоногийн дотор ирүүлээгүй бол зарчмын зөрүүтэй саналгүй гэж үзэн санал өгсөнд тооцох харилцааг хуулийн төсөлд тусгав.

Хайгуулын лицензийг эхний 3 жилийн төлбөрийг 5 дахин нэмэгдүүлж, ашиглалтын лицензийн төлбөрийг га тутамд 15 ам.доллар болгохоор хуулийн төсөлд тусгаж байна.

Лицензийн төлбөрийг ингэж нэмэгдүүлснээр хайгуулын ажил хийх санхүүгийн болон мэргэжлийн чадавхитай хуулийн этгээдэд лиценз эзэмших механизм бий болгож, лицензийг олноор авч арилжааны хэрэгсэл болгож байгаа өнөөгийн байдлыг хязгаарлах эдийн засгийн механизм болж үйлчилнэ.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг ашигт малтмалын төрөл, боловсруулалтын түвшин, үнийн өсөлттэй харгалзуулан ялгавартайгаар тогтоохоор төсөлд тусгав.

Орон нутгийн хөгжил, нутгийн иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд геологи, уул уурхайн салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор лицензийн төлбөр болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг орон нутгийн төсөвт оруулж байх, энэ хөрөнгөөр орон нутгийн хөгжлийн сан байгуулж үйлдвэрлэл, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлэхэд зарцуулж байх нь зүйтэй гэж үзэв.

Байгаль орчныг эвдэн сүйтгэсэн, бохирдуулсан этгээд нь нөхөн сэргээдэг олон улсын зарчмыг нэвтрүүлэх, энэ талаархи хариуцлагын тогтолцоо, лиценз эзэмшигчдийн хүлээх хариуцлагыг эрс дээшлүүлэх зорилгоор байгаль орчныг нөхөн сэргээх журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэнд, мал амьтан, байгаль орчинд үлэмж хэмжээний хохирол, эсхүл их хэмжээний хохирол учирсан тохиолдолд тус бүрт Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг өргөн мэдүүлж байна.

Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулснаар ашигт малтмалыг хайх, ашиглах харилцаанд оролцогч этгээдийн эрх зүй, эдийн засаг, нийгмийн харилцаа улам боловсронгуй болж, лицензийн татварын гаднах арилжаа устаж, лиценз тойрсон маргаан зөрчил арилна гэж үзэж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, түүнтэй нийцүүлэн холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хуулийн үзэл баримтлал, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, бусад материалыг хавсаргасан болно.

**Дүгнэлт**

Дараахь харьцуулалтаас харахад Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулахдаа урд нь мөрдөгдөж байсан хуулийн алдаа дутагдал болон шинээр бий болсон

UIH.MN СУДАЛГААНЫ САН

зарим төрлийн харилцаануудыг зохицуулахын тулд асуудлаа шийдэх арга замаа тодорхойлсон үзэл баримтлалыг гаргасан бөгөөд хуулийн заалтуудад энд тусгагдсан санаанууд бүгд биелэлээ олж чадсан байна.

Гэвч зарим нэг асуудал дээр хуулийнхаа заалтанд тухайн асуудлынхаа мөн чанарыг сайн гаргаж, дэлгэрэнгүй зохицуулаагүйгээс ерөнхий утгатай зохицуулалт болсон байна. Ингэснээр хууль бодит амьдрал дээр хэрэгжихдээ гажуудах тохиолдлууд гарч байна.

Иймээс харьцуулалтын хүснэгтэд байгаа сөрөг үр дүн үзүүлж буй заалтуудыг дахин нарийвчилж сайжруулан боловсруулах шаардлагатай байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, зарим зүйл заалтуудын харьцуулалт***

| Дд | Чиглэл | Хуулийн үзэл баримтлал | Хуулийн заалт | Тайлбар дүгнэлт |
|---|---|---|---|---|
| 1. | Ашигт малтмалын нөөцийн ангилал | **1.** Улсын эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах, гадаад, дотоодын зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх ашигт малтмалын ордыг "Хөгжлийн стратеги ач холбогдол бүхий ашигт малтмалын орд" гэж нэр томъёоны хэсэгт нэмэлт оруулна. | 4.1.11."стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд" гэж үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг; | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан байна. |
| 2. | Ашигт малтмалын олборлолт дахь төрийн оролцоо | **2.** Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул нь хийгдсэн хөгжлийн стратегийн ач холбогдол бүхий ордуудад 50-иас доошгүй хувиар төр оролцож байхаар хуульд нэмэлт оруулна.<br>Хувийн хөрөнгөөр судалгааны ажил хийж нөөц нь тогтоогдсон орд газрын хувьд төрийн оролцоо байхгүй, төр өөрөө хүсвэл холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хувьцаа худалдан авах эрх нээлттэй байгаа болно. Зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөц нь тогтоогдсон хөгжлийн стратеги ач холбогдол бүхий ордуудад төрийн оролцооны талаар лиценз эзэмшигчтэй гэрээ байгуулахаар хуулийн төсөлд тусгав. | 5.4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно.<br>5.5.Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно.<br>8.1.4.Засгийн газраас өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачлагаар тухайн ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах;<br>8.1.7.Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачлагаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн эрдэс баялгийн хэмжээ, энэ хуулийн 5.5, 5.6-д заасан хэмжээг харгалзан тогтоох.<br>9.1.4. тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;<br>9.1.5. стратегийн ач холбогдол бүхий ашигт | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан байна. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;<br>9.1.6. стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах хамтарсан үйлдвэрт Монгол Улсаас оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх; | |
| 3. | Цацраг идэвхит ашигт малтмалын талаарх зохицуулалт | **3.** Монгол Улсын Үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг харгалзан хүнд элементүүдийн изотопын ордуудыг төр өөрийн хяналтанд авч байхаар хуульд нэмэлт оруулна. | 8.1.6.цацраг идэвхт ашигт малтмал олборлох, тээвэрлэх, хадгалахтай холбогдсон тусгай дэглэм тогтоох;<br>11.1.15.цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх, шилжүүлэх ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлэх;<br>11.1.16.цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх; | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан байна. |
| 4. | Ашигт малтмалын салбар дахь төрийн зохицуулалт | **4.** Эрдэс баялгийн зөвлөл байгуулж ажиллуулах эрхийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгохоор нэмэлт оруулна. | 10.1.9.Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайланд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрмийг батлах.<br>25.1.5.хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээж авсан Эрдэс баялгийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэр; | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан байна. |
| 5. | Лиценз олголтын ил тод байдлыг хангах | **5.** Геологи, уул уурхайн кадастрын алба нь ашигт малтмал ашиглах лиценз олгосон, ашигт малтмал ашиглах лицензийн хугацаа сунгасан, ашигт малтмал ашиглах лиценз шилжүүлсэн, ашигт малтмал ашиглах лицензээр олгогдсон талбайг хэсэгчлэн шилжүүлсэн талаархи мэдээллийг ажлын 7 өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн болон татвар, | 19.3.Энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн бол төрийн захиргааны байгууллага нь энэ талаар тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд энэ хуулийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зургийг хавсаргана.<br>19.10.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан байна.<br>Гэвч бодит амьдрал дээр хэрэгжилтийн явцдаа алдаа дутагдал гардгаас энэ чиглэлийн зохицуулалтуудыг дахин боловсронгуй болгон сайжруулах хэрэгтэй гэж |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн лицензээр олгосон талбай орших буй аймаг /нийслэл/-ийн Засаг дарга, геологи, уул уурхайн мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж, албан ёсоор нийтэлж, нийтэд мэдэгдэж байхаар хуулийн холбогдох заалтуудад нэмэлт оруулна.<br>Лиценз олголтод орших буй өнөөгийн сөрөг үзэгдэл арилж, лиценз олгох, шилжүүлэх үйл ажиллагааны ил тод байдал дээшлэхийн хамт шударга нээлттэй тогтолцоо бий болно.<br>Лиценз олголтын ил тод, шудрага, хөнгөн шуурхай байдлыг хангах, аливаа маргаан шудрага бус үйлдлээс сэргийлсэн тогтолцоог бүрдүүлэх;<br>Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз олгох үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа хийсэн талбайд дуудлага худалдааны аргаар лиценз олгож байхаар хуулийн төсөлд тусгаж байна. Дуудлага худалдааны хэлбэр нь лиценз олгох үйл ажиллагааг шударга болгож, лиценз тойрон гардаг аливаа маргаан, үл ойлголцлыг таслан зогсооно гэж үзэж байна. | дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.<br>26.7.Төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 7 өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.<br>24.2.Энэ хуулийн 53.1.1-д заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд уг тусгай зөвшөөрлийг эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаагүй бол уг талбайд сонгон шалгаруулалтын журмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоно. | үздэг. |
| 6. | Ашигт малтмалын салбар дахь нутгийн захиргааны байгууллагын оролцоо ба уг салбараас орон нутагт орох орлого | **6.** Лицензийн төлбөрийн болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг тухайн лицензийн талбай орших буй аймаг, сум, улсын нэгдсэн төсөвт хуваарилж байхаар хуулийн төсөлд нэмэлт оруулна.<br>Лиценз эзэмшигч, нутгийн захиргааны байгууллагын хоорондын харилцааг боловсронгуй болгох, нутгийн захиргааны байгууллагын эрх, үүргийг дээшлүүлэх, ашигт малтмалын орлого, | 12.1.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;<br>19.3.Энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн бол төрийн захиргааны байгууллага нь энэ талаар тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд энэ хуулийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зургийг хавсаргана. | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан байна.<br>Гэвч бодит амьдрал дээр хэрэгжилтийн явцдаа алдаа дутагдал гардгаас энэ чиглэлийн зохицуулалтуудыг дахин боловсронгуй болгон сайжруулах хэрэгтэй гэж үздэг. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хураамжийн зохих хэсгийг орон нутагт төвлөрүүлэх,<br>Нутгийн захиргааны байгууллага, лиценз эзэмшигчдийн хоорондын харилцааг боловсронгуй болгох, газрын талаар гарч байгаа маргаан, зөрчлийг арилгах зорилгоор аймаг, нийслэл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрынхаа тухай мэдээллийг шийдвэр гарснаас хойш 1 сарын дотор Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын Геологи, уул уурхайн кадастрын газарт ирүүлж байх, аймаг, нийслэлийн Засаг дарга нар ашигт малтмалын лиценз олгох тухай саналаа 30 хоногийн дотор ирүүлээгүй бол зарчмын зөрүүтэй саналгүй гэж үзэн санал өгсөнд тооцох харилцааг хуулийн төсөлд тусгав.<br>Орон нутгийн хөгжил, нутгийн иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд геологи, уул уурхайн салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор лицензийн төлбөр болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг орон нутгийн төсөвт оруулж байх, энэ хөрөнгөөр орон нутгийн хөгжлийн сан байгуулж үйлдвэрлэл, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлэхэд зарцуулж байх нь зүйтэй гэж үзэв. | 19.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.<br>19.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга зөвхөн хуульд заасан үндэслэлээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу өгч болно.<br>58.1.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын болон тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.<br>58.2.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 10 хувийг тухайн сум, дүүргийн, 20 хувийг тухайн аймаг, нийслэлийн, 70 хувийг улсын төсөвт тус тус хуваарилах бөгөөд орон нутагт хуваарилах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь аймаг, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн төсвийн дүнгээс хэтрэхээргүй байна.<br>59.1.Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг улсын болон тухайн хайгуулын талбай, ашигт малтмалын орд байршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ.<br>59.2.Тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25 хувийг тухайн сум, дүүргийн төсөвт, 25 хувийг тухайн аймаг, нийслэлийн төсөвт, 50 хувийг улсын төсөвт тус тус хуваарилна. | |
| 7. | Лицензтэй холбогдсон маргаан | **7.** Лицензтэй холбогдсон маргаантай асуудал нь шүүхэд хянагдаж байгаа бол шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэл шилжүүлэхийг хориглох тухай заалт нэмж оруулна. | 49.10.Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон маргаан шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа бол шүүхийн шийдвэр гарах хүртэл тухайн тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг хориглоно.<br>56.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэр гартал тухайн талбайд шинээр тусгай зөвшөөрөл олгохгүй. | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан байна. |
| 8. | Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам | **8.** Хөрөнгө оруулалтын босгыг 10 дахин нэмэгдүүлж, ашиглалт явуулах ордынхоо нөөцийг Улсын нөөцийн | 29.1.Үйл ажиллагааныхаа эхний 5 жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт 50 саяас дээш америк доллартой тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийх ашиглалтын | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан |

UIH.MN

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, тухайн ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл хийсэн ашигт малтмал ашиглах лиценз эзэмшигч нь хүсэлт гаргавал Монгол Улсын Засгийн газар эрх олгосноор Сангийн болон Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд тогтвортой байдлын гэрээг байгуулж байхаар, хөрөнгө оруулалтын хэмжээ 20,0 сая америк доллараас 50,0 сая ам. доллар бол Засгийн газар, 50,0 сая америк доллараас дээш бол Улсын Их Хурлаар тус тус хэлэлцэж шийдвэрлэх, тухайн төслийн эхний 5 жилд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацааг тодорхойлсон техник, эдийн засгийн үндэслэлийг өргөдөлтэй хамт ирүүлэхээр хуулийн холбогдох зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулна. | тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болох бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:<br>29.1.1.татварын орчинг тогтвортой байлгах;<br>29.1.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн үнээр борлуулах;<br>29.1.3.олсон орлогоо захиран зарцуулах эрхийг нь баталгаажуулах;<br>29.1.4.хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа;<br>29.1.5.ашигт малтмалыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хохирол багатай олборлох;<br>29.1.6.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх;<br>29.1.7.бусад төрлийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;<br>29.1.8.бүс нутгийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох;<br>29.1.9. учирсан хохирлыг нөхөн төлөх.<br>29.2. Энэ хуулийн 29.1-д заасан гэрээг Монгол Улсын Засгийн газрын эрх олгосноор санхүү, геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран хөрөнгө оруулагчтай байгуулна.<br>29.3.Эхний 5 жилийн хөрөнгө оруулалтын хэмжээ 50 саяас дээш америк доллартой тэнцэх бол 10, 100 саяас дээш америк доллартой тэнцэх бол 15, 300 саяас дээш америк доллартой тэнцэх бол 30 жилийн хугацаагаар энэ хуулийн 29.1-д заасан гэрээ байгуулна.<br>29.4.Хөрөнгө оруулалтын хэмжээ 50.0 сая америк доллароос 100.0 сая америк доллар бол Засгийн газар, 100.0 сая америк доллароос дээш бол Улсын Их Хурал тус тус хэлэлцэнэ.<br>30.1.Хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 29.1-д заасан гэрээ байгуулах тухай хүсэлт, гэрээний төслийг энэ хуулийн 29.2-т дурдсан төрийн захиргааны төв байгууллагуудад ирүүлэх бөгөөд түүнд дараахь баримт бичгийг хавсаргана:<br>30.1.1.эхний 5 жилд оруулах хөрөнгийн хэмжээ, | байна.<br>Гэвч бодит амьдрал дээр хэрэгжилтийн явцдаа алдаа дутагдал гардаг ба мөн түүнчлэн өнөөгийн эдийн засаг нийгмийн амьдралын өөрчлөлттэй тэр бүр зохицохгүй байгаа тул энэ чиглэлийн зохицуулалтуудыг дахин боловсронгуй болгон сайжруулах хэрэгтэй гэж үздэг.<br>Тухайлбал, Оюутолгойн ордыг ашиглах гэрээг ТЭЗҮ гарахаас өмнө батласан. Уг гэрээгээр тухайн цаг үед хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын орчныг зөвхөн тогтворжуулах бус, зарим төрлийн татварыг хүчингүй болгох, тэглэх зэргээр эдгээр заалтуудыг зөрчсөн. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хугацаа, үйлдвэрийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрөл, орд ашиглах арга, технологийн талаархи мэдээлэл, техник, эдийн засгийн үндэслэл;<br>30.1.2.тухайн ордын нөөцийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тухай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн тэмдэглэл.<br>30.2.Энэ хуулийн 30.1-д заасан төрийн захиргааны төв байгууллагууд нь хөрөнгө оруулагчийн хүсэлт, гэрээний төсөл, хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 29.3, 30.1-д заасан шаардлага хангасан эсэхийг хянаж ажлын 10 өдөрт багтаан хүсэлт гаргасан этгээдэд мэдэгдэнэ.<br>30.3.Энэ хуулийн 30.1-д заасан төрийн захиргааны төв байгууллагууд хөрөнгө оруулагчийн хүсэлт, гэрээний төсөл, хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 3 сарын дотор хянах бөгөөд шаардлагатай тохиолдолд зохих байгууллага, мэргэжилтний санал, дүгнэлтийг үндэслэн дахин 3 сар хүртэлх хугацаагаар нэмэлт тодруулга хийсний үндсэн дээр энэ хуулийн 29.1-д заасны дагуу хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулна. | |
| 9. | Лицензийн төлбөр | **9.** Уул уурхайн салбараас төсөвт орж буй орлогыг нэмэгдүүлэх, орлогын хуваарилалтыг оновчтой болгох зорилгоор хайгуулын лицензийн эхний 3 жилийн төлбөрийг 5 дахин нэмэгдүүлж, ашиглалтын лицензийн төлбөрийг нэмэгдүүлж га тутамд 15 ам.доллар болгохоор хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулна.<br>Лицензийн төлбөрийг ингэж нэмэгдүүлснээр хайгуулын ажил хийх санхүүгийн болон мэргэжлийн чадавхитай хуулийн этгээдэд лиценз эзэмших механизм бий болгож, лицензийг олноор авч арилжааны хэрэгсэл болгож байгаа өнөөгийн байдлыг хязгаарлах эдийн засгийн механизм болж үйлчилнэ. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг ашигт малтмалын төрөл, | 31.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 32, 33 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд зөрчвөл мөн хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцална.<br>32.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг энэ хуулийн дагуу жил бүр төлнө.<br>32.2.Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 0,1 ам.доллар, 2 дахь жилд 0,2 ам.доллар, 3 дахь жилд 0,3 ам.доллар, 4-6 дахь жилд тус бүр 1,0 ам.доллар, 7-9 дэх жилд тус бүр 1,5 америк доллар байна.<br>32.3.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон уурхайн талбайн гектар тутамд 15 америк доллар байх бөгөөд харин нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд гектар тутамд 5 ам.доллар байна.<br>33.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон тухайн талбайн гектар тутамд | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан байна.<br>Гэвч бодит амьдрал дээр хэрэгжилтийн явцдаа алдаа дутагдал гардгаас энэ чиглэлийн зохицуулалтуудыг дахин боловсронгуй болгон сайжруулах хэрэгтэй гэж үздэг. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | боловсруулалтын түвшин, үнийн өсөлттэй харгалзуулан ялгавартайгаар тогтоохоор төсөлд тусгав. | дараахь хэмжээнээс багагүй зардал бүхий хайгуулын ажлыг жил бүр хийж гүйцэтгэнэ:<br>33.1.1.тусгай зөвшөөрлийн 2 - 3 дахь жилд 0,5 америк доллар;<br>33.1.2. тусгай зөвшөөрлийн 4 - 6 дахь жилд 1,0 америк доллар;<br>33.1.3. тусгай зөвшөөрлийн 7 - 9 дэх жилд 1,5 америк доллар.<br>33.2.Хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн геологи хайгуулын ажлын жилийн тайлан болон санхүүгийн тайлан тэнцэлд тулгуурлан төрийн захиргааны байгууллага баталгаажуулна.<br>33.3.Төрийн захиргааны байгууллага шаардлагатай тохиолдолд хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг газар дээр нь шалгана.<br>56.1.Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр цуцална:<br>56.1.4.тухайн жилд гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардал нь энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс бага бол | |
| 10. | Лиценз шилжүүлэх | **10.** Лиценз эзэмшигч нь уг лицензийг эзэмших эрх бүхий этгээдтэй Иргэний хуульд нийцүүлэн гэрээ байгуулсан, эсхүл өв залгамжлах, аж ахуйн нэгжүүд нэгдэж нийлэх, дампуурах зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдлуудад лицензийг шилжүүлж болно. Лицензийг шилжүүлсэн тухай бүр Геологи, уул уурхайн кадастрын албанд энэ зүйлд заасны дагуу бүртгүүлэх ба ийнхүү бүртгүүлснээр лицензийг шилжүүлсэн нь хүчин төгөлдөр болохоор хуулийн төсөлд нэмэлт оруулна.<br>Ингэснээр лиценз худалдан авсан зардал ил тод болж, лиценз зарсан хуулийн этгээдээс татварын байгууллага холбогдох татвараа авч байх эдийн засгийн механизм бий болох юм. | 49.1.Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу нэгдэх, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон эрх хүлээн авагчид, түүнчлэн хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлж болно.<br>49.2.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрэл, хайгуулын талаархи анхдагч материал, тайлан зэрэг мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлж болно.<br>49.3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, баримт бичгийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлж | Хуулийн энэ заалтанд үзэл баримтлалд тусгагдсан санааг бодит шууд утгаар нь тусгасан байна.<br>Гэвч бодит амьдрал дээр хэрэгжилтийн явцдаа алдаа дутагдал гардгаас энэ чиглэлийн зохицуулалтуудыг дахин боловсронгуй болгон сайжруулах хэрэгтэй гэж үздэг. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | болно.<br>51.1.Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт олох, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхийн тулд тусгай зөвшөөрлийг эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, геологийн судалгааны мэдээлэл, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг холбогдох баримт бичиг болон хууль тогтоомжоор барьцаалахыг хориглоогүй эд хөрөнгийн хамтаар банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаалж болох бөгөөд тусгай зөвшөөрөл нь дангаараа барьцааны зүйл болохгүй.<br>52.1.Барьцаалуулагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцаалагч нь хүсвэл барьцаалагдсан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг эрх бүхий өөр этгээдэд шилжүүлэх тухай өргөдлийг энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу төрийн захиргааны байгууллагад гаргаж түүнд дараахь баримт бичгийг хавсаргана | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## Долоо. Монгол Улсыг хөгжүүлэх сан болон бусад сангийн үйл ажиллагаатай холбоотой хуулиуд

### *Засгийн газрын тусгай сангууд-онцлог, төрөл хэлбэр*

Засгийн газрын тусгай сангууд нь улс орнуудын санхүүгийн системийн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог бөгөөд улсын төсвөөс тусдаа байж, тусгай зориулалтын хөрөнгийн сан болж байдаг. Эдгээр сангууд нь нийгмийн өмнө тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэх, эдийн засгийн хямралын үед зориулагдах нөөцийн зориулалтаар ашиглагддаг ба улс орон бүр өөр өөрийн онцлогтой, өвөрмөц зорилготой тул засгийн газрын тусгай сангийн нэгдсэн ангилал гэж байдаггүй. Засгийн газрын тусгай сангууд өөр хоорондоо үйлчлэх хугацаа, зориулалт, эрх зүйн байдлаараа ялгагддаг байна.

Ихэнхи сангууд цаг хугацааны хязгаарлалттай, тодорхой зорилтыг шийдвэрлэсний дараа тэдгээрийг татан буулгадаг, ийм сангуудыг түр сан гэж нэрлэдэг ба харин урт хугацаагаар байгуулагдсан сангуудыг байнгын сан гэх бөгөөд ийм төрлийн сангуудад жишээ нь замын сан, нийгмийн даатгалын сан хамаарна.

Шийдвэрлэж буй зорилгынх нь үүднээс сангуудыг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- Шинжлэх ухаан техникийн сан
- Эдийн засгийн сан
- Нийгмийн даатгалын сан
- Хувийн болон өмчийн даатгалын сан
- Цэргийн сан
- Хөрөнгө оруулалтын сан гэх мэт.

Тусгай сангууд нь онцгой ач холбогдол бүхий арга хэмжээнд төсвөөс зарлага гарган байгуулах, тодорхой зориулалтын тусгай санг хууль тогтоох байгууллагын онцгой шийдвэрээр байгуулах гэсэн хоёр замаар байгууллагддаг.

Барууны өндөр хөгжилтэй орнуудад 30-80 ийм тусгай сангууд үйл ажиллагаа явуулдаг ба тухайлбал, Францад засгийн газрын тусгай сангуудын хөрөнгийн хэмжээ улсын төсвийн хэмжээтэй ойролцоо байдаг бол Японд ийм сангуудаас нийт улсын зарлагын талаас илүү хувийг, Их Британид 1/3-ийг санхүүжүүлдэг байна[84].

Түүнчлэн газрын тосны үйлдвэрлэл ихтэй орнуудад эх үүсвэр нь уул уурхайн орлогоос бүрддэг баялгийн сангуудыг байгуулсан ба эдийн засгийг макро түвшинд, түүний дотор улсын төсвийг дунд, урт хугацаанд тогтворжуулах, үндэсний санхүүгийн хуримтлалыг бий болгон арвижуулж, эдийн засгийн хараат бус байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн мэдлийн нийт **56** хөрөнгийн сан байна[85].

Эрдэс баялгийн салбараас орж ирэх орлогыг захиран зарцуулахад дараах шалтгаануудын улмаас тусгайлан сан байгуулдаг байна. Үүнд:

[84] Жук И.Н Международные финансы. www.exsolver.narod.ru
[85] Эх үүсвэр нь уул уурхайн орлогоос бүрддэг баялгийн сангуудын зарчим, үйл ажиллагаа. Харьцуулсан судалгаа. УИХ-ын ТГ-ын СШОНХТөв. 2009 он.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- ***Ил тод байдлыг хангахад тохиромжтой.*** Баялгаас орох орлого хэрхэн зарцуулагдаж байгааг баялгийн эзэн болсон ард түмэн мэдэх боломжтой.

- ***Хяналт тавихад тохиромжтой.*** Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэхэд хяналт тавих боломжийг төр засаг, иргэний нийгэм, хувийн хэвшил, иргэдэд олгодог. Төсвийн гадуур хяналтгүй зарцуулахаас сэргийлэхэд ач холбогдолтой.

- ***Тогтворжилт.*** Газрын тос, зэс, алт зэрэг байгалийн баялгийн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр ихээхэн хэлбэлздэг. Уг хэлбэлзлээс шалтгаалан улсын төсөвт үүсэх хүндрэл, хомсдлоос сэргийлэх зорилгоор олонхи сан байгуулагддаг. Бүтээгдэхүүний үнэ өндөр байхад санд төвлөрүүлсэн хөрөнгөд хүрэхгүйгээр улам баяжуулах, үнэ унасан тохиолдолд улсын төсвийг нөхөх зорилгоор сангаас хөрөнгө татах зарчмаар сан үйл ажиллагаагаа явуулдаг. Ингэсээр үнэ өндөр байх үед төсвийн зарлагыг хэт нэмэгдүүлж, дараа нь үнэ буурахад зарлагаа санхүүжүүлэх боломжгүй болохоос сэргийлэх юм.

- ***Хуримтлал, хадгаламж.*** Хуримтлал үүсгэх зорилгоор сан байгуулснаар нөөц баялгийг мөнгөн хэлбэрт шилжүүлж, тодорхой хэмжээгээр хадгалснаар үнэ цэнийг нь хойч үедээ зориулан хадгалах буюу нэмэгдүүлэх зорилготой. Харин санд хуримтлуулсан хөрөнгөөс олох ашгийг энэ үеийнхэнд зориулан зарцуулах боломжтой.

- ***Бусад хүчин зүйлс.*** Дотоодын үнийн хөөрөгдлийг хязгаарлах, валютын ханшийг өсгөхгүй байх зарчмаар Голланд өвчнөөс урьдчилан сэргийлэх, төсвийн үйл явцыг илүү хариуцлагатай болгох, орлогыг илүү хариуцлагатай зарцуулах сонирхлыг бэхжүүлэхэд эерэг үр дагавар авчирдаг байна.

- **Монгол Улсын Засгийн газрын тусгай сангуудын зохицуулалт**

Засгийн газрын нөөц хөрөнгө болон болзошгүй эрсдлийн санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, улсын төсвийн хуваарилагдаагүй зардлыг зарцуулахтай холбогдсон харилцааг Санхүү, эдийн засгийн сайдын "Түр журам батлах тухай" 2002 оны 207 дугаар тушаалаар батлагдсан журмаар зохицуулж байжээ. Харин 2002 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуульд Засгийн газрын нөөц хөрөнгө, болзошгүй зардлын эрсдлийн санг бүрдүүлэх, зарцуулах, хуваарилагдаагүй зардлыг зарцуулах журмыг хуулиар зохицуулахаар заасны дагуу 2006 онд **Засгийн газрын тусгай сангийн тухай хууль** батлагджээ.

Өнөөгийн байдлаар Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хүний хөгжил сан, Улсын авто замын сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас бусад тусгай сантай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулж байгаа ба дээрх сангуудыг оролцуулаад нийт 27 засгийн газрын тусгай сан ажиллаж байна. Эдгээр санг дараахь ангилалд хуваана. Үүнд:

- Тусгай хуулиар зохицуулах сан;
- Эх үүсвэрийг нь 100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан;
- Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан;
- Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг буцалтгүй тусламж, хандиваар бүрдүүлэх сан.

Тусгай хуулиар зохицуулах санд дараахь тусгай сан хамаарч байна:

1. Нийгмийн даатгалын сан;
2. Нийгмийн халамжийн сан;
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

4. Улсын авто замын сан;
5. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан;
6. Хүний хөгжил сан.

Эх үүсвэрийг нь 100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх санд дараахь тусгай сан хамаарч байна:

1. Засгийн газрын нөөц сан;
2. Эрсдэлийн сан.

Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх санд дараахь тусгай сан хамаарч байна:

- Аялал жуулчлалын сан;
- Байгаль хамгаалах сан;
- Дархлаажуулалтын сан;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;
- Соёл, урлаг хөгжүүлэх сан;
- Сургалтын төрийн сан;
- Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан;
- Хүүхдийн төлөө сан;
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан;
- Шинжлэх ухаан, технологийн сан;
- Эрүүл мэндийг дэмжих сан;
- Сэргээгдэх эрчим хүчний сан;
- Зэвсэгт хүчний хөгжлийн сан;
- Орон сууц хөгжүүлэх сан.

Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг буцалтгүй тусламж, хандиваар бүрдүүлэх санд дараахь тусгай сан хамаарч байна:

- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан;
- Мал хамгаалах сан;
- Тариаланг дэмжих сан;
- Олон улсын гэрээний дагуу байгуулагдсан сан. Эдгээр сан нь үйл ажиллагаагаа өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар явуулдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Тусгай хуулиар зохицуулсан сангуудын хувьд үйл ажиллагаа нь дараах хуулиудаар тус тус зохицуулагдаж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сан нь Нийгмийн даатгалын тухай хуулиар /1994/,
2. Нийгмийн халамжийн сан нь Нийгмийн халамжийн тухай хуулиар /2005/,
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар /2001/,

4. Улсын авто замын сан нь Авто замын тухай хуулиар /1998/,
5. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар /2009/,
6. Хүний хөгжил сан нь Хүний хөгжил сангийн тухай хуулиар /2009/ зохицуулагдаж байна.

“Хүний хөгжил сангийн тухай” хууль нь дээр дурьдсан баялгын сангуудад тавигддаг шаардлагуудаас тогтворжилтын буюу үнийн хэлбэлзлээс шалтгаалан улсын төсөвт үүсэх хүндрэл, хомсдлоос сэргийлэх, төсвийн хомсдлийг нөхөхөөс бусад шаардлагыг хангаж байна.

Тухайлбал, хуримтал, хадгаламж үүсгэх шаардлагын үүднээс тус хуулийн 5 дугаар зүйлд сангийн хөрөнгийг арвижуулах зорилгоор дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр дараахь санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулна: үнэт цаас, өрийн бичиг, хадгаламж гэж хуульчилсан ба сангийн ил тод байдлыг хангах үүднээс тус хуулийн Мэдээллийн нээлттэй байдал гэсэн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, компаний удирдлагатай холбоотой мэдээллийг өдөр тутмын хэвлэлээр хагас жил тутам нийтэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлнэ гэж заасан.

Хяналтын тухайд “Хүний хөгжил сангийн тухай” хуульд компанийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих чиг үүргийг хяналтын зөвлөл хэрэгжүүлэхээр заасан ба сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж, дүгнэлт гаргана. Мөн хөндлөнгийн аудитыг жилд нэгээс доошгүй удаа олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар хийлгэж, дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулахаар хуульчилсан байна.

Эх үүсвэрийг нь 100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сангууд болох засгийн газрын нөөц сан, эрсдэлийн сангийн талаар Нэгдсэн төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд Засгийн газрын захиран зарцуулах эрхийн хүрээнд Засгийн газрын нөөц хөрөнгө, болзошгүй зардлын эрсдэлийн санг улсын төсвийн бүрэлдэхүүн хэлбэрээр, Улсын Их Хурлын зөвшөөрлөөр байгуулан зарцуулж болно гэж заасан ба Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд бүрдүүлэх эх үүсвэр, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмыг хуульчилжээ.

Дээрхи тусгай сангуудаас эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сангуудын зохицуулалтын хувьд эдгээр нь дангаараа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулагддаг ба тусгай сангийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг Засгийн газар тогтоож, хөрөнгийг хуулийн дагуу төрийн сангийн тусгай дансанд байршуулж, түүнийг захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргадаг байна.

Судалгааны явцад Дархлаажуулалтын сан, Эрүүл мэндийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Соёл урлагыг хөгжүүлэх сан, Авто замын сан, Байгаль хамгаалах сан, Аялал жуулчлалын сан зэрэг сангуудыг хариуцан үйл ажиллагааг нь явуулж байгаа зарим хүмүүстэй уулзаж ярилцан саналыг авсан болно.

- **Судалгааны дүгнэлт, санал, зөвлөмж**

Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааны эрх зүйн орчинд хийсэн шинжилгээний дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль нь анх 2006 онд батлагдан хэрэгжиж эхлэхдээ олон задгай, өөр өөрийн удирдлагатай байсан сангуудыг нэгтгэн төвлөрүүлж, улсын төсвөөс болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх эх үүсвэрийг хуульчилсан нь зөв арга хэмжээ байсан. Тухайлбал, аялал жуулчлалын сан,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

дархлаажуулалтын сан, соёл урлагыг хөгжүүлэх сан зэрэг сангуудын үйл ажиллагаа баталгаатай эх үүсвэртэй болж жигдэрсэн байна.

- Сэргээгдэх эрчим хүчний сан, Орон сууц хөгжүүлэх сан, Зэвсэгт хүчний хөгжлийн сан зэрэг байгуулагдаад удаагүй байгаа сангуудын хувьд ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагааныхаа журам, зааврыг боловсруулах, батлуулах түвшинд ажиллаж байна.

- Эдгээр сангуудаас зарим онцлог сангуудыг бие даалган тусгай хуулиар зохицуулах шаардлага байгаа нь ажиглагдлаа.

Тухайлбал, Байгаль хамгаалах сангийн хувьд Байгаль орчин, аялал жуулчлалын Яам “Байгаль орчны сангийн тухай” хуулийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Хуулийн төсөл батлагдсанаар байгаль орчны санхүүгийн бие даасан нөөц бүрдэж байгаль орчны татварын орлогын суурь сан бий болно. Мөн байгаль орчны салбарт дорвитой хөрөнгө оруулалт төвлөрч шууд УИХ-ын харьяанд бие даасан хараат бус санхүүгийн боломж бүрдэж байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах гол хөрөнгийн эх үүсвэр бий болно гэж хуулийн төслийг санаачлагчид үзжээ.

- Монгол улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийг хүчингүй болгосноор улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, хөгжилд хөрөнгө оруулалт хийх тусгай сан байхгүй болсон байна.

**Судалгааны санал, зөвлөмж:**

- Монгол Улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, хөгжилд хөрөнгө оруулах зорилго бүхий Хөгжлийн санг байгуулах боломжийг судлах, энэ санд төвлөрүүлсэн эх үүсвэрээс тухайлбал, “Утаагүй Улаанбаатар” зэрэг хөтөлбөрийг санхүүжүүлэх, дотоодын үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааг дэмжих, гэр хорооллыг барилгажуулах, дэд бүтцийг шинэчлэн сайжруулах боломжтой юм.

- Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах, эдгээр санд буцалтгүй тусламж, хандив олгосон олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлөөллийг уг хяналтанд оролцох эрх зүйн боломжийг олгох шаардлагатай байна.

- Цаашид Засгийн газрын тусгай сангуудын төлөөлөл оролцсон уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж Засгийн газрын тусгай сангийн хууль хэрхэн хэрэгжиж байгаа байдалд дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох нь зүйтэй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Монгол Улсыг хөгжүүлэх сан болон бусад сангийн үйл ажиллагаатай холбоотой хуулиуд тэдгээрийн үзэл баримтлалын түүвэр**

/Хуулийн хувийн хэргээс авав/

| | ***Хуулийн нэр батлагдсан огноо*** | ***Хуулийн төсөл боловсруулах шаардлага*** | ***Зохицуулах харилцаа, хамрах хүрээ*** | ***Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар болон хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдал*** | ***Өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зарим асуудал*** | ***Батлагдсан хуульд тусгагдсан байдал*** |
|---|---|---|---|---|---|---|
| **1.** | **Засгийн газрын тусгай сангийн тухай хууль** /2006.06.29/ | 2002 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 13.3-т Засгийн газрын нөөц хөрөнгө, болзошгүй зардлын эрсдлийн сан бүрдүүлэх, зарцуулах, хуваарилагдаагүй зардлыг зарцуулах журмыг хуулиар зохицуулахаар заасан бөгөөд уг заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.<br>Мөн улсын төсвөөс болон зээл, тусламж зэрэг улсын төсөвтэй адилтгах эх үүсвэрээс бүрдүүлж байгаа сангуудыг байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих нэгдсэн зохицуулалт бий болгох шаардлагатай байна. | Хуулийн төсөл нь 6 бүлэг 33 зүйлтэй байх бөгөөд энэхүү хуулийн төслөөр Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулна. | Засгийн газрын тусгай сангийн хууль батлагдсанаар төсвийн хөрөнгийн ашиглалтын үр ашиг дээшилж, зарцуулалтад хяналт тавих сайжрах нэг нөхцөл бүрдэнэ.<br>Хуулийг хэрэгжүүлэх шатанд ямар нэг нэмэгдэл зардал, бусад хөрөнгийн эх үүсвэр тусгайлан шаардахгүй юм.<br>Энэхүү хууль нь 2006 онд батлагдсанаас хойш 2007, 2008, 2009 онуудад нийт 47 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. | Энэхүү хуулийн төсөлд дараахь хэд хэдэн асуудлыг тусгасан байна.<br>- Засгийн газрын тусгай санг тодорхойлж, түүний төрлийг нь тогтооно.<br>- Санг бүрдүүлэх эх үүсвэр, сангийн хөрөнгийг бүрдүүлэхдээ харгалзан үзэх нөхцлүүд болон зарцуулах зориулалтыг сан тус бүрээр нарийвчлан зааж, уг сангаас хөрөнгө гаргах шийдвэртэй холбогдсон харилцааг зохицуулна.<br>- Засгийн газрын тусгай сангуудад санхүүжилт олгох хэлбэр, түүнийг гүйцэтгэх журмыг тусгана.<br>- Засгийн газрын тусгай сангийн гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна. | Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд бүрэн дүүрэн туссан гэж үзэж болно. Харин хуулийн төслийг төсвийн байнгын хороогоор хэлэлцэх үед гишүүдийн зүгээс зарим нэр төрлийн сангуудыг хасах, зарим сангуудыг нэмэх санал гарсаны дагуу 2 дугаар бүлгийн Засгийн газрын тусгай сан, түүний төрөл гэсэн 5 дугаар зүйлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Засгийн газрын өргөн барьсан хуулийн төслөөс Бусийн хөгжлийг дэмжих сан, Орон сууц хөгжүүлэх сан, Гаалийн хөгжлийн сан, Татварын хөгжлийн сан, Улсын төсвийн хуваарилагдаагүй зардлын сан, Тогтворжуулалтын сангуудыг хасч, нэр бүхий гишүүдийн саналаар Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн сан, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангуудыг нэмсэн байна. Мөн 2 дугаар бүлэгт Тусгай сангийн ангилал гэсэн 6 дугаар зүйлийг нэмсэн ажээ. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **2.** | **Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль** /2007.02.06/ **Уг хууль 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсон.** | Засгийн газрын тусгай сангийн хуулийн 26.6-д заасны дагуу Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ батална гэж заасны дагуу эхлээд уг журмыг боловсруулсан байна. Улмаар энэ журмын төслийг төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед тус журмын төслийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг байна. | Журмын төсөл нь сангийн удирдлага, зохион байгуулалт, сангийн хөрөнгийг зарцуулах журам, сангаас хөрөнгө гаргах төсөл, арга хэмжээний төрөөл, сангаас хөрөнгө гаргах шийдвэртэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгажээ. Уг сангийн хөрөнгийн эх үүсвэр, түүний зарцуулах зориулалт, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгасан тул давхардуулан тусгахгүй гэж үзэж байжээ. | Хуулийн төсөл батлагдсанаар төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулж, оновчтой хуваарилах, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн төсвийн орлогын дутагдлыг нөхөх, хүүхэд, гэр бүлийг дэмжих, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх, улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэгдсэн оновчтой дэд бүтцийг байгуулах замаар эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ. 2007 онд батлагдсанаас хойш 2008, 2009 онд нийт 9 удаа нэмэлт өөрчлөлт орсон. | Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн төсөл болгон өөрчилсөнөөр дараах асуудлыг зохицуулсан. Үүнд:<br>-Сангийн эх үүсвэр, зориулалт<br>-Сангийн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах<br>-Сангийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах, хяналт тавих | Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмын төслийг УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэд Монгол Улсыг хөгжүүлэх санг МУ-ын нэгдсэн төсвийн орлогоос тусгаарлан төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзсэний үндсэн дээр уг журмын төслийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн төсөл болгон өөрчилжээ. Төсөлд Засгийн тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн заалтуудыг шууд тусгасан байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсыг хөгжүүлэх сантай холбоотой заалтуудыг авсан. |
| **3.** | **Хүний хөгжлийн сангийн тухай хууль** /2009.11.18/ | Энэ хуулийг батлахын өмнө Монгол Улсын Засгийн газраас 2008 оны 4 дүгээр сарын 4-ны өдөр "Эх орны хишиг сангийн тухай" хуулийн төсөл, УИХ-ын нэр бүхий гишүүд 2009 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Эрдэнийн хувийн /Баянмонгол корпораци/ тухай хуулийн төслийг Улсын Их Хурлд өргөн мэдүүлсэн байна. УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2008 оны 5 дугаар сарын 29-ны өдөр болон 2009 7 дугаар сарын 21-ний өдрүүдийн хуралдаанаараа Эх орны хишиг сангийн тухай хуулийн | "Эх орны хишиг сангийн тухай" хуулийн төсөл, Эрдэнийн хувийн /Баянмонгол корпораци/ тухай хуулийн төслүүд нь тус тусдаа хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлсон байна.<br><br>Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл | Стратегийн ач холбогдол бүхий ордоос төсөвт төвлөрөх орлогыг зүй зохистой хувиарлан зарцуулж, хуримтлал бий болгон үр ашгийг нь иргэддээ оновчтой хэлбэрээр тэгш хүртээх хууль эрх зүйн орчныг бий болгосноор эдийн засгийн хөгжлийг зөв залах, төсвийн гэнэтийн орлогыг дагалдан Засгийн газрын зардал нэмэгдэж, үнэ өсөхөөс урьдчилан сэргийлэх, дотоодын зах зээл дээрх мөнгөний | Өргөн баригдсан хоёр хуулийн төслийг нэгтгэн "Хүний хөгжил сангийн тухай" хуулийн төсөл болгон өөрчилсөнөөр дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:<br><br>-Хүний хөгжил сан, түүнийг бүрдүүлэх арвижуулах<br><br>-Сангийн хөрөнгийн удирдлага, зохион байгуулалт<br><br>-Сангаас хишиг, хувь хүртээх<br><br>-Сангийн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, тайлагнах | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 16.4 дүгээр зүйлд "Нэг асуудлаар хоёр болон түүнээс дээш төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг нэгтгэн нэг төсөл болгож Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар, хэрэв ийнхүү нэгтгэхийг зөвшөөрөөгүй бол тус тусад нь санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ" гэж хуульчилсаны дагуу ажлын хэсэг төслүүдийг нэгтгэж |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төсөл болон Эрдэнийн хувийн /Баянмонгол корпораци/ тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцээд Эх орны хишиг сангийн тухай хуулийн төсөл болон Эрдэнийн хувийн /Баянмонгол корпораци/ тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзээд уг хоёр хуулийн төслийг нэгтгэн хэлэлцүүлэхээр шийдвэрлэжээ.<br>Төсөл санаачлагчдаас ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор сан байгуулах, түүнийг бүрдүүлэх, зарцуулах шаардлагатай гэж үзсэн байна. | нь 7 бүлэг, 26 зүйлтэй ба уг хуулийн төсөл нь "Эх орны хишиг сангийн тухай" хуулийн төслийн бүтэц, хамрах хүрээг үндэс болгон авсан байна.<br><br>Энэ хуулийн төсөл нь ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор хүний хөгжил сан байгуулах, түүнийг бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн. | нийлүүлэлтийг багасгаж, инфляцийг бууруулахад эерэг нөлөө, нийгмийн хөгжил, айл өрхийн амьжиргаанд зохих дэмжлэг үзүүлэх болно. Түүнчлэн энэ орлогоос иргэддээ хишиг хүртээх нь төр, иргэний хоорондын харилцааг бэхжүүлэхэд тодорхой түлхэц болно.<br>Хууль батлагдсанаас хойш нэмэлт, өөрчлөлт ороогүй байна. | -Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт | "Хүний хөгжил сангийн тухай" хуулийн төсөл болгон өөрчилсөн байна.<br>Хүний хөгжил сангийн тухай хуулийн хүний хөгжил сан, түүнийг бүрдүүлэх, арвижуулах, сангаас хишиг, хувь хүртээх, сангийн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, тайлагнах, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зацуулалтад тавих хяналтын талаархи зохицуулалтыг хуульчилсан бүлгүүдэд Эх орны хишиг сангийн тухай хуулийн төслийн зохих бүлгүүдийг үндэс болгон авч харин сангийн хөрөнгийн удирдлага, зохион байгуулалт гэсэн 3 дугаар бүлэгт сангийн хөрөнгийн удирдлага, компаний үйл ажиллагааны үндсэн зарчим, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох, хяналтын зөвлөл, мэдээллийн нээлттэй байдал гэсэн зүйлүүдийг хуульчилахдаа Эрдэнийн хувийн /Баянмонгол корпораци/ тухай хуулийн төслийн зохих зүйлүүдийн гол санааг үндэс болгон хуульчилжээ. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## Найм. Эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалттай холбоотой хуулиуд

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Чөлөөт бүсийн тухай хууль”-д худалдааны чөлөөт бүсүүдийг Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын гэрээнүүдтэй уялдуулах асуудал, чөлөөт бүсэд явагдах үйл ажиллагааны төрлүүд, гаалийн татвараас чөлөөлөх, аж ахуй нэгжүүдийг бүртгэх хялбаршуулсан журам зэрэг хөнгөлөлтүүд болон газрын өмчлөл, чөлөөт бүсэд мөрдөх орлогын албан татварын хувь хэмжээний талаархи заалтууд багтжээ.

Энэхүү хуультай уялдуулан “Замын Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль, “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Цагаан нуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль”-уудыг батлан гаргаж худалдааны чөлөөт бүсүүдийг байгуулан ажиллаж байна.

**Чөлөөт бүсийн тухай хуулинд тавигдах шаардлага, харьцуулалт**

| Хуулийн заалт | Агуулга | Олон улсын шилдэг туршлага | Зөвлөмж |
|---|---|---|---|
| Худалдааны ЧБ-ийн тухай Монгол улсын хууль, 1-р зүйл | Хуулийн зорилго | ХЧБ-ийн талаархи хуулийн зорилгод бүсийн хөгжил, үйл ажиллагаанд хувийн хэвшлийг түлхүү оролцуулах тухай тусгайлан дурьддаг. | Хувийн хэвшлийн болон төрийн үүрэг ролийн тухай хуулинд нэмж тусгах шаардлагатай. |
| Худалдааны ЧБ-ийн тухай Монгол улсын хууль, 2-р зүйл | Монгол улсын ХЧБ-д хамаарах олон улсын хууль тогтоомж, гэрээний талаар дурьдсан. | ХЧБ-ийн засаг захиргааны бүсэд явагдаж буй үйл ажиллагаануудыг зохицуулж, зарим тохиолдолд хийж гүйцэтгэх тухай асуудлыг нэг л хуулинд заасан байдаг. Бусад асуудлыг Засгийн газар тогтоол гаргах замаар зохицуулдаг. | Монгол улс дах ХЧБ-үүдийн үйл ажиллагааны чиглэл, хөгжилтэй холбогдуулан нарийвчилсан зохицуулалт хийх хэрэгтэй. |
| Худалдааны ЧБ-ийн тухай Монгол улсын хууль, 3.4-р зүйл | ХЧБ-д явагдах үйл ажиллагаанууд. ХЧБ-ийн ажиллагаа нь экспортын чиглэлтэй байх тухай заасан. | ДХБ-ын шаардлагын дагуу ХЧБ-д экспортын чиглэл зэрэгтэй холбогдсон тусгай журам үйлчлэх ёсгүй. ХЧБ-үүд нь экспортын чиглэл зэрэг нөхцөлөөр ялгаварлан гадуурхах байдал гаргаж болохгүй | “Экспортын чиглэл”-тэй холбогдсон заалтыг ХЧБ-ийн тухай хууль тогтоомжоос хасах нь зүйтэй. |
| Худалдааны ЧБ-ийн тухай Монгол улсын хууль, 4-р зүйл | ХЧБ дэх татвар, гааль, валютын тусгай журмын талаар өгүүлсэн. Татварын хөнгөлөлтүүдийг нарийвчлан зааж өгөөгүй. | ХЧБ-д үйлчлэх компаний орлогын татварын хэмжээг бага байлгаж, барааг тухайн улсын нутаг дэвсгэрт импортлох хүртэл импортын татварыг түдгэлзүүлж, валютын зохицуулалтыг таатай болгож, төрийн зохицуулалт, хяналтыг үр дүнтэй ил тод байлгахад анхаардаг. | Орлогын татвар, валютын зохицуулалт, гаалийн үйлчилгээний нөхцлүүдийг хуулинд нарийвчлан зааж өгөх хэрэгтэй. |

| | | | |
|---|---|---|---|
| Худалдааны чөлөөт бүсийн тухай Монгол улсын хууль, 5-р зүйл | ХЧБ байгуулах, татан буулгах | Шийдвэр гаргах этгээдэд чиглэл өгөх үүднээс ХЧБ-д явуулах үйл ажиллагааны чиглэлийн үндсэн шалгуурууудыг хуулинд тусгасан байдаг. | Шалгуур үзүүлэлтүүдийг хуулинд нэмж оруулах. |
| Худалдааны чөлөөт бүсийн тухай Монгол улсын хууль, 8-р зүйл | ХЧБ-ийн Ерөнхий менежер нь төрийн албан хаагч байж, захирагчид тайлагнана. | Менежментийн чиг үүргийг гол төлөв хувийн хэвшилд шилжүүлдэг. | Менежиентийг хувийн хэвшилд шилжүүлэхийг зөвшөөрч, дэмжих нь зүйтэй. |
| Худалдааны чөлөөт бүсийн тухайн Монгол улсын хууль, 13-р зүйл | ХЧБ-д үйл ажиллагаа явуулах компаниудын бүртгэл | Бүртгэлийн журмыг гол төлөв тусгай тогтоолоор зохицуулдаг. Бүртгэлийн журамд тусгагдах шалгуур үзүүлэлтүүд, хориотой үйл ажиллагааны жагсаалт, бүртгэл хийгдэх хугацаа зэргийг хуулинд заадаг | Бүртгэлийн ажиллагаанд холбогдох шалгуур үзүүлэлтүүд болон журмыг тодруулах |

*/Эдийн засгийн бодолгын шинэтгэл, өрсөлдөх чадварын төслийн "Монгол улсын худалдааны чөлөөт бүс хөтөлбөрийн үнэлгээ, чөлөөт бүсийн байдалтай танилсан дүн шинжилгээ" тайлангаас авав. 2004 оны 3 дугаар сар./*

**Дүгнэлт:** Худалдааны чөлөөт бүсийн хөтөлбөрийн эрх зүй, зохицуулалтын хүрээ нь гол төлөв гурван түвшиний хууль тогтоомжоос бүрддэг. Үүнд: худалдааны чөлөөт бүсийн тухай хууль, худалдааны чөлөөт бүсийн зохицуулалтууд болон үйл ажиллагааны журам.

Эдгээр эрх зүйн механизмыг бий болгох нь худалдааны чөлөөт бүсэд хөрөнгө оруулагчдын хэрэгцээ шаардлага болон олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэхэд ач холбогдолтой байдаг байна.

Ази-Номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын 2005 оны илтгэлд чөлөөт бүсийн байршилд нөлөөлөх хүчин зүйлүүдийг гаргасан бөгөөд нийгэм, улс төр, хууль эрх зүйн орчин тогтвортой байх нь хамгийн чухал хүчин зүйл /64%/-ийн нэг гэж үзсэн байна.[86]

"Өрсөлдөөнт орчныг бүрдүүлэхэд шаардлагатай, олон улсын шилдэг туршлагаар нотлогдсон элементүүдтэй харьцуулахад МУ-ын худалдааны чөлөөт бүсийн хөтөлбөр нь өрсөлдөх чадварын хувьд нэлээд дутмаг байна. Уг худалдааны чөлөөт бүсийн хөтөлбөрийг олон улсын өрсөлдөх чадварын стандартад хүргэхийн тулд эдийн засгийн чөлөөт бүсийн тухай МУ-ын хуулийг өөрчлөх шаардлагатай" гэж "Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадварын төсөл"-өөс хийсэн судалгаагаар дүгнэсэн байна.

- **Гадаадын зарим орнуудын худалдааны чөлөөт бүсийн талаар:**

*Доминиканы Бүгд Найрамдах улсын Худалдааны чөлөөт бүсийн тогтолцоо:*

Доминиканы Бүгд Найрамдах улс нь олон улсын шилдэг туршлагыг ашиглаж Худалдааны чөлөөт бүсийг хэрхэн амжилттай байгуулж болохыг харуулсан жишээ болсон. Гэсэн хэдий ч эдийн засгийн хувьд үр ашигтай болж чадаагүй байна.

[86] Д.Ганбаатар-Чөлөөт бүсийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Худалдааны чөлөөт бүсийн хөтөлбөр нь 1969 онд улс оронд шинэ ажлын байр бий болгох, гадаад валют солилцоог бий болгох, экспортын бус бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилготойгоор ямар нэгэн зардал үр ашгийн тооцоогүйгээр хэрэгжиж эхэлсэн байна.

Доминиканы Бүгд Найрамдах Улс 2004 оны байдлаар 53 ХЧБ-ийн хөтөлбөрөөр 520 компанийг бий болгож, 171,000 хүнийг ажлын байраар хангаж, нийт 1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг хийгээд байна. Доминиканы ХЧБ-ийн хөтөлбөр нь эрс ялгаатай 2 өөр үе шатад хуваагдах ба энэ нь хөтөлбөрийн орчныг бүрдүүлэхтэй шууд холбоотойгоор үр дүнгээ өгсөн байна.

1-р үе: 1969-1980

Энэ үеийн үр дүнд нийт 3 худалдааны чөлөөт бүсийн хөтөлбөр хэрэгжиж, 71 компани үйл ажиллагаа явуулж эхлэн нийт 16,000 ажлын байр бий болсон. Уг үеийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг ихэнхийг буюу 95 гаруй хувийг АНУ эзэлж байжээ.

2-р үе шат: 1980-2002

Энэ үе шатанд тус хөтөлбөр нь эдийн засгийн шинэчлэлтийг нийт орон даяар хийхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хамгийн чухал нь валютын ханшийг чөлөөлсөн явдал юм. Энэ үед 50 худалдааны чөлөөт бүс, 449 компани, 155,000 ажлын байруудыг шинээр бий болгож чадсан байна.

Доминиканы худалдааны чөлөөт бүс нь урт хугацаанд үргэлжлэн байсан ажилгүйдлийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж чадсан байна.

*Орос дахь эдийн засгийн чөлөөт бүсийн тогтолцоо:*

1990-ээд оны дунд үеэс Оросын дээд зөвлөл нь 13 чөлөөт эдийн засгийн бүс байгуулах шийдвэр гаргасан. Үүний дагуу чөлөөт эдийн засгийн бүс бүрийн аж ахуйн эрх мэдлийг бүс бүрээр тус бүрд нь Оросын сайд нарын зөвлөл тогтоол гаргаж баталж өгсөн байна. Татварын хөнгөлөлт нь гадаадын хөрөнгө оруулагч Оросын нутаг дэвсгэр дээр 50% хүртэл, газар ашиглалт ба бусад байгалийн баялаг ашигалахад төлбөр нь хөнгөлөлттэй.

Чөлөөт эдийн засгийн бүсэд газар ашиглах хугацаа 70 жил хүртэл харин чөлөөт эдийн засгийн бүсийн гадна гадаадын хөрөнгө оруулагчид 50 хүртлэх жилээр хөнгөлөлт үзүүлэхээс гадна бараа бүтээгдэхүүн оруулах, гаргахад гаалийн хөнгөлөлт, гадаадын хил гарах, орох журам дүрмийн хүнд суртлыг аль болох хялбар болгох, гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай үйлдвэр ба 30 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компани экспорт, импортын үйл ажиллагааг лицензгүй болгохыг хуулиар зохицуулж өгсөн.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Эдийн засгийн чөлөөт бүсийн хуулиуд, тэдгээрийн үзэл баримтлалын түүвэр хүснэгт**

*/Хуулиудын хувийн хэргээс авав/*

| | Хуулийн нэр, батлагдсан огноо | Хуулийн төслийн боловсруулах шаардлага | Зохицуулах харилцаа, хамрах хүрээ | Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар болон хуульд нэмэлт өөрчлөлт орсон байдал | Өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зарим асуудал | Батлагдсан хуульд тусгагдсан байдал |
|---|---|---|---|---|---|---|
| | **Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль**<br><br>2003.05.30 | Улсын Их Хурал 2001 оны 57 дугаар тогтоолоор "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтал"-ыг баталж, Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлсон билээ.<br>Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд юуны түрүүнд эдгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан зохион байгуулах удирдлагын тогтолцоог бий болгох, засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын болон салбар хоорондын шинжтэй эдийн засаг, нийгмийн иж бүрэн харилцааг зохицуулах үндсэн зарчмуудыг тогтоох, бүс нутгийн хөгжлийн асуудлаархи төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг тодорхойлох шаардлага болон Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх санал боловсруулж өргөн барихыг даалгасан УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолыг үндэслэн энэхүү хуулийн төслийг боловсруулна. | Бүс нутгийн удирдлагын тухай хуулиар зохицуулах зүйлийн хүрээг дараахь чиглэлүүдээр тодорхойлно:<br>1/ бүс нутгийн зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо;<br>2/ Монгол Улсын хууль тогтоомжоор нарийн зохицуулагдаж ирээгүй аймаг, хот, тосгон хоорондын, салбар хоорондын шинжтэй эдийн засаг, нийгмийн харилцааг бүс нутгийн хүрээнд зохицуулах үндсэн зарчмууд;<br>3/ бүс нутгийн удирдлагын талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг. | Энэ хууль батлагдсанаар Улсын Их Хурлаас баталсан "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д заасан зорилтуудыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, улмаар бүс нутгаар дамжуулан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа арилгаж хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, дэд бүтэц, үйлдвэрлэлийн хөгжлийг хөдөө орон нутагт чиглүүлэх таатай орчинг бүрдүүлэх суурь тавигдана. | - Бүс нутгийн удирдлагын үйл ажиллагаар эдийн засгийн бүсийн хүрээнд болон аймаг, орон нутгийн түвшинд зохион байгуулах үүрэг бүхий Засгийн газрын төлөөллийн байгууллага /Бүсийн зохицуулах зөвлөл/-ын ажиллах журмыг зохицуулах<br>- Бүсийн зохицуулах зөвлөлүүд нь бүс нутгийн хөгжлийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд, түүнчлэн тухайн бүсэд багтдаг аймгуудын Засаг дарга нарын үйл ажиллагаар уялдуулах<br>- бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлох, эдийн засгийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвч, бүсийн хөгжлийн тулгуур төвүүдийг тогтоох, бүс бүрийн хөгжлийн стратегийг батлах | - 6.1 дугаар зүйл.<br>Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаар уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хороо МУ-ын Ерөнхий сайдын дэргэд ажиллана.<br>-7.1 дугаар зүйл.<br>Бүсийн зөвлөл нь бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага мөн.<br>Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулиар үндсэн зарчим, Үндэсний хороо, Бүсийн зөвлөл, төрийн байгууллагуудын бүрэн эрх, санхүүжилт болон бүсийн хэлэлцээрийн талаар зохицуулсан хууль болсон. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Чөлөөт бүсийн тухай хууль** 2002.06.28 | Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үндэслэл нь: 1/ эдийн засгаа нээлттэй аргаар хөгжүүлэх зохион байгуулалтын нэг шинэ хэлбэр болсон эдийн засгийн чөлөөт бүсийг сонгон авч хэрэгжүүлж байгаа дэлхийн олон орны нийтлэг жишиг. 2/ манай орны тодорхой бүс нутагт хөрөнгө оруулах эрмэлзэл бүхий гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхолыг өөрийн орны эрх ашигтай зөв хослон, тухайн бүс нутгийн болон улс орны эдийн засгийн хөгжилд тус дөхөм үзүүлэх | Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулж хөгжүүлэх үйл ажиллагаар энэ үзэл баримтлалд дурдсан зарчим, онцлог, бодит хүчин зүйл, угтвар нөхцөл, шалгуурыг үндэслэн сонгож авсан тодорхой бүсүүдийн статусыг тухай бүрт нь хуулиар тогтоон мөрдүүлэх замаар хэрэгжүүлнэ. | Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн холбоо, эрчим хүч, зам тээвэр зэрэг үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэхэд тусална. Чөлөөт бүсийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид, аж ахуй нэгж, байгууллага чөлөөтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлснээр эдийн засагт таатай нөхцөл бүрдэнэ. | -Эдийн засгийн чөлөөт бүсийг үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ дагнасан ба хосолсон хэлбэрээр явуулах - Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх, сайжруулах - Гадаадын хөрөнгө оруулагчид, аж ахуй нэгж, байгууллага чөлөөтэй, итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчинг бүрдүүлэх | |
| | **Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль** **2002.06.28** | /Хуулийн төслийн танилцуулга/ УИХ-аас 1995 онд баталсан "Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал"-ын дагуу бэлтгэж боловсруулав. Тус үзэл баримтлалд "Монгол улсад чөлөөт бүс байгуулах зорилтыг эхний ээлжинд хил орчмын нутагт "худалдааны чөлөөт бүс" байгуулах, тодорхой бүсүүдийн статусыг тухай бүрт нь хуулиар тогтоож мөрдүүлэх замаар хэрэгжүүлэх нь зүйтэй" гэж тодорхойлсон юм. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулагт эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрхзүйн орчинг бүрдүүлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулжээ. | Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт тус улсын бусад нутаг дэвсгэрт байгуулах худалдааны чөлөөт бүсийг хамарч, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, худалдаа, наймаа чөлөөтэй эрхэлж харилцан үр ашигтай, хамтран ажиллах, улс хоорондын ачаа барааг баталгаатай хадгалах, шуурхай мэдээлж, тээвэрлэн дамжуулах эрхзүйн илүү таатай орчин бүрдүүлж, түүнд нийцүүлэн удирдлагын болон аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм тогтоохол | Энэ хуулийг батлан мөрдүүлснээр, Монгол улсад дэлхийн нийтлэг жишгийн дагуу олон улсын худалдаа, наймаа чөлөөтэй хөгжиж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, дэвшилтэт технологи, зохион байгуулалт, үйлчилгээний соёл, бизнесийн тэргүүний ололт, туршлага нэвтрэх эрхзүйн таатай орчин бүрдэх эхлэл тавигдах юм. | Дараахь зарчмын чанартай асуудлыг шийдвэрлэхэд онцлон анхаарсан болно.Үүнд: 2/ чөлөөт бүс нь оршин байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгждээ харъяалагдахгүй бөгөөд төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас хараат бус үйл ажиллагаа явуулах бие даасан удирдлагатай байх; 3/ чөлөөт бүс нь улсын төвлөрсөн төсөвтэй харьцах бие даасан төсөвтэй байх, төсвийн ерөнхийлөн захирагч нь Бүсийн захирагч байх; 4/ Бүсэд, Бүсийн захирагч болон дээд шатны байгууллагадаа давхар харъяалагдах цагдаа, | Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль нь анх 23 зүйлтэй өргөн баригдсан бөгөөд батлагдахдаа 5 зүйлтэй батлагдан гарсан. - Иргэн, ААН, байгууллагыг үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш эхний 5 жилд үл хөдлөх эд хөрөнгийн татвараас чөлөөлөх, - эрчим хүчний шугам сүлжээ, цэвэр усны хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто, төмөр зам, харилцаа холбооны салбарт...албан татвар ногдуулах орлогоос хасч тооцох - ...ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчийг орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө - Бүсэд 10 болон түүнээс дээш |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | чиглэгдэж байна. Энэ хуулиар тогтоож буй эрхзүйн таатай нөхцөлийг дагалдан Алтанбулагийн бүс нутагт гадаадын шууд хөрөнгө оруулалт орж, байршин, манай дотоодын аж ахуйн нэгж, байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулагчидтай харилцан ашигтай хамтран ажиллах өргөн боломж нээгдэх юм. | | гааль, татвар болон мэргэжлийн хяналтын бусад албад ажиллах, тэдгээрийн урсгал зардлыг бүсийн төсвөөс санхүүжүүлэх; 5/ Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, хөрөнгө оруулалт, гааль, албан татвар, газрын төлбөрийн илүү хөнгөлөлттэй нөхцөлд ажиллах; 7/ чөлөөт бүсийн тогтвортой, үр ашигтай ажиллах баталгааг хангах, | хугацаагаар үйл ажиллагаа явуулахаар эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчийг орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө. - Мөн худалдаа, нийтийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгжийг 3 жилд газрын түрээсийн төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө. -Бүсийн дэд бүтцийг бүрдүүлэх ажил эрхэлж байгаа аж ахуй нэгжийг эхний 5 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 30 хувиар хөнгөлнө. |
| | **Цагаан нуур" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль** | 1995 онд УИХ-аар баталсан "Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал"-д тус улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэгт чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг тогтоож, хэрэгжүүлж эхлэх зорилтыг дэвшүүлсэн юм. Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоныг түшиглэн худалдааны чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж болон Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг үндэслэн энэхүү үзэл баримтлалыг боловсруулав. | Энэхүү хуулийн төслийг баталж мөрдүүлснээр Улаанбайшинтын боомтоор хийгдэж буй худалдаа, ачаа бараа, зорчигчдын урсгалыг нэмэгдүүлэх, алслагдсан бүс нутагт ажлын байр бий болгох, баруун бүс нутагт барааны хангамжийг сайжруулах, байгалийн болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нөөц бололцоог нээн ашиглах, олон улсын зах зээлд гарах шинэ гарцтай болох, улмаар Төв Азийн орнуудын худалдаа, жуулчлал, | -Цагааннуур" худалдааны чөлөөт бүсэд олон улсын стандарт шаардлагад нийцсэн авто замын зангилаа бий болгох, түүнийг дагасан үйлчилгээний иж бүрэн цогцолбор байгуулах г.м асуудлын эрх зүйн үндсийг бүрдүүлэх; - Баруун бүсийн аймгуудын малын гаралтай түүхий эд бэлтгэлийг төвлөрүүлж, худалдаа, үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагыг татвар, төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх зэрэг хуулийн механизмыг | - Төв Ази болон Зүүн Европын орнуудтай холбох авто замын хамгийн дөт гарц болох нөхцөл бүрдэнэ. - Баруун бүсэд худалдааны чөлөөт бүс байгуулснаар хөдөөнөөс төв суурин газар руу чиглэсэн их нүүдлийг багасган хүн амын нягтралыг тодорхой түвшинд барьж, хилийн бүс нутгийг эзгүйрэх аюулаас сэргийлэх бодлоготой уялдсан стратегийн ач холбогдолтой - Нутаг дэвсгэрийн байршлын хувьд Цагааннуур нь ОХУ, Казакстан болон БНХАУ-ын нутгийн хилийн | Хууль нь анх өргөн баригдсанаараа батлагдан гарсан. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн сүлжээнд холбогдон орчин үеийн үйлчилгээний соёл, дэвшилтэт арга, технологи нэвтрэх бололцоо нээгдэнэ. | тогтоох; | уулзварт харьцангуй ойр байдаг онцлогийг ашиглан эдгээр улс орнуудын хооронд, цаашилбал тухайн бүс нутгийн орнуудын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх гарц болгох хэтийн зорилго агуулж байна. | |
| | **“Замын үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль**<br><br>2003.06.20 | Дараах үндсэн нөхцөл байдлыг харгалзан үзэж чөлөөт бүсийн эрх зүйн орчинг тус бүс нутагт бүрдүүлэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:<br>1/ Замын-Үүд нь Монгол Улсын эдийн засгийг БНХАУ, улмаар Азийн орнуудтай холбосон тээвэр-газар зүйн тохиромжтой байрлалтай, авто ба төмөр зам, холбоо, мэдээлэл, эрчим хүчний хангамж харьцангуй сайн бүрдэж байгаа;<br>2/ Замын-Үүд нь одоогийн байдлаар, Монгол Улсын гадаад худалдаа, зорчигч тээврийн зонхилох хэсгийг нэвтрүүлдэг гол боомт болж байгаа бөгөөд цаашид энэ байдал улам өргөжин гүнзгийрэх хандлагатай байгаа. Улс хооронд дамжин өнгөрч буй ачаа, зорчигч тээврийн их урсгал, түүнчлэн валютын солилцоог чөлөөт бүс байгуулах замаар тус улсын эдийн засгийн чадавхи, экспорт, импортыг нэмэгдүүлэхэд улам үр өгөөжтэй ашиглах боломжтой;<br>3/ Монгол Улсын Замын-Үүд, | Хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг тогтоохдоо Чөлөөт бүсийн тухай, "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиар тогтоосон нийтлэг үндэслэлийг баримталсны зэрэгцээ, Замын-Үүдийн байршлын онцлог, дэд бүтцийн багтаамж, худалдааны эргэлт, цаашдын хандлага эдийн засгийн хөгжлийн чадавхи, хоёр орны сонирхол зэргийг харгалзан үзсэн болно. Үүнд:<br>1/ Замын-Үүд чөлөөт бүсэд олон улсын стандарт шаардлагад нийцсэн зочид буудал, соёл үйлчилгээний болон цэнгээнт тоглоомын газар, нисэх буудал, мэдээлэл холбоо, банк | - Дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, хамтарсан үйлдвэрлэл байгуулах, тэдгээрийн хүч хөрөнгийг Замын-Үүд бүс нутгийн хөгжлийг түргэтгэх зорилгод чиглүүлэх эдийн засгийн таатай орчин бүрдэх юм. Замын-Үүдийн боомтоор хийгдэж буй худалдаа, ачаа бараа, зорчигчдын урсгалыг журамтай, цэгцтэй болгож, Монгол Улс, БНХАУ-ын хоорондын гадаад худалдааг цаашид нэмэгдүүлэх, улмаар Азийн орнуудын худалдаа, жуулчлал, мэдээллийн сүлжээнд холбогдон орчин үеийн үйлчилгээний соёл, дэвшилтэт арга, технологи нэвтрэх бололцоотой.<br><br>- Монгол Улсын Замын-Үүд, БНХАУ-ын Эрээнд | - Монгол Улсын өмнөд хилийн гарц болох Замын-Үүд боомтын газарзүйн байрлал, сүүлийн жилүүдэд бий болсон худалдаа, эдийн засгийн онцлог байдлыг харгалзан үзэж, тэнд эдийн засгийн чөлөөт бүс байгуулахтай холбогдсон харилцааг хуулиар тусад нь зохицуулах шаардлагатай байгаа<br>- Замын-Үүдээр хийгдэж байгаа гадаад худалдаа улам өсч байгаа, гаалийн хяналт, хамгаалалт хангалтгүй, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг дотооддоо боловсруулалт хийхгүйгээр их хэмжээгээр экспортод гаргаж байгаа, дотоодын болон гадаадын худалдаачид, зорчигчдыг боловсон үйлчлэх дэд бүтэц, үйлчилгээ бүрдэл болоогүй зэрэг<br>- Замын-Үүдийг эрчимтэй хөгжүүлэхэд байгаль орны доройтол, түүний | - Бүсэд гадаад, дотоодын бизнес эрхлэгчид, жуулчдад үйлчлэх өндөр зэрэглэлийн зочид буудал, үйлчилгээний цогцолбор байгуулах шаардлага тавигдаж байгаатай уялдуулж, хилийн хяналтын бүсэд байрлах онцлогийг харгалзан цэнгээнт тоглоомын үйлчилгээ буюу казино байгуулж, ажиллуулах боломжтой гэж үзэж хуулийн 3.3-т ***“Замын-Үүд” бүсэд казино байгуулж болно***.<br>- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон боловсруулах үйлдвэр, худалдаачид болон зорчигчдыг боловсон үйлчлэх дэд бүтэц, үйлчилгээг бүрдүүлэх асуудлыг хуулийн 5 дугаар зүйл. “Замын-Үүд” бүсийн татвар, төлбөр, түүний хөнгөлөлт, чөлөөлөлт хэсэгт зохицуулж өгсөн байна. Тухайлбал:<br>- Иргэн, ААН, байгууллагыг үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш эхний 5 жилд үл хөдлөх эд хөрөнгийн татвараас чөлөөлөх,<br>- эрчим хүчний шугам сүлжээ, цэвэр усны хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | БНХАУ-ын Эрээн хотын хооронд худалдаа, гааль, тээврийн үйлчилгээний тогтвортой хэлхээ, холбоо харилцан түншлэл нэгэнт тогтож байгаа, цаашид энэ харилцаанд түшиглэн Хятад Улсын чөлөөт бүсийн туршлагыг Монголд нэвтрүүлж, улс хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн үр ашигтай хөтлөхийг хоёр тал адилхан сонирхож байгаа. | санхүүгийн салбараас бүрдсэн аялал жуулчлалын цогцолбор байгуулах асуудлын эрх зүйн үндсийг бүрдүүлэх;<br>2/ Замын-Үүд орчмын байгаль орчныг нөхөн сэргээх /элсний нүүлтийг зогсоох/, усны хүрэлцээ, хангамжийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дотоод болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагыг татвар, төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх зэрэг хуулийн механизмыг тогтоох;<br>3/ Худалдаа, аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэн, байгууллагыг татвар, төлбөрөөс хөнгөлөх болон чөлөөлөх талаар тодорхой заалт оруулах. | чөлөөт бүс байгуулах явцыг түргэтгэх, хоёр талын харилцан итгэлцэл, түншлэлийг бэхжүүлэх эрх зүйн таатай уур амьсгал авчирна. | дотор элсний нүүлт, усны хангамж, хүрэлцээ муу зэрэг асуудлыг шийдвэрлэхэд эдийн засгийн чөлөөт бүс нээх замаар дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчид, ажил хэрэгч хүмүүсийн хүчээр шийдвэрлэх боломж нөхцөл бий болоод байна.<br>- Энэ зорилгоор дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, тэдгээртэй харилцан ашигтай, хамтран ажиллах үр нөлөөтэй арга механизмыг нэн даруй бүрдүүлэх шаардлагатай байна. | төмөр зам, харилцаа холбооны салбарт...албан татвар ногдуулах орлогоос хасч тооцох<br>- ...ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчийг орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө<br>- Бусэд 10 болон түүнээс дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулахаар эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчийг орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.<br>- Мөн худалдаа, нийтийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгжийг 3 жилд газрын түрээсийн төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.<br>-Бусийн дэд бүтцийг бүрдүүлэх ажил эрхэлж байгаа аж ахуй нэгжийг эхний 5 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 30 хувиар хөнгөлнө. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## Ес. Аудит, хяналт шалгалтын холбоотой хуулиуд

***Төрийн Аудитийн тухай хууль***

"Төрийн аудитын хараат бус байдал, түүний үндсэн зарчим", "Төрийн захиргаа" сэтгүүлийн 2010/01 №11 хуудас 55-62, Б.Батбаяр, доктор, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч

Энэ хуулийг боловсруулахдаа 1977 онд Перугийн Лима хотноо болсон ИНТОСАИ[87]-ийн IX Их хурлаас баталсан "Аудитийн үндсэн зарчмын талаархи Лимагийн тунхаглал" нь Аудитийн дээд байгууллага[88], НҮБХХ-ийн Хариуцлага, нягт тунгалаг байдлын хөтөлбөрөөс боловсруулсан Вестминстерийн тогтолцооны Аудитийн дээд байгууллагын загвар хуулийг ашигласан учраас энэ хууль олон улсын стандарт, шилдэг туршлагад бүрэн нийцсэн гэж үзэх үндэстэй. Үүний зэрэгцээ Төрийн хяналт шалгалтын тухай өмнөх хуулиас холбогдох заалтуудыг агуулгынх нь хувьд өвлөн авсан нь олон улсын загвар хуулийн агуулгыг баяжуулж, өөрийн орны онцлог нөхцөлтэй уялдуулахад тус дөхөм болжээ.

Өөрөөр хэлбэл төрийн аудитийн байгууллага чиг үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн байна.

Монгол Улсын төрийн аудитийн байгууллагын хараат бус байдлын түвшинг Лимагийн болон Мексикийн тунхаглалуудын зарчмуудтай харьцуулж үзэхэд Монгол Улсын төрийн аудитийн байгууллагын хараат бус байдал харьцангуй сайн хангагдаж гэж дүгнэж болохоор байна.

Гэхдээ 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд төрийн аудитийн байгууллагын чиг үүрэг, бүрэн эрх, хараат бус байдлыг Үндсэн хуулиар баталгаажуулах, аудитийн зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авах үр нөлөөтэй механизмтай болох шаардлагууд хараахан хэрэгжээгүй байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд төрийн аудитийн байгууллагын талаар тусгах, аудитийн зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авах үр нөлөөтэй механизмтай болох шаардлагатай юм. Энэ тохиолдолд Монгол Улсын төрийн аудитийн байгууллагын хараат бус байдлын түвшин олон улсын жишигт хүрч, Лимагийн болон Мексикийн тунхаглалын зарчмуудыг бүрэн хангах юм.

***Аудитийн тухай Монгол улсын хууль***

Энэ хуулийн төслийг боловсруулахдаа АНУ, Япон, БНСУ-ын хуулийг судалжээ. Аудитийн тухай энэхүү хууль нь аудитийн онолын хэлбэрүүдийн дотроос гадаад гэж нэрлэгддэг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой харилцааг зохицуулах болно.

Гадаад орнуудад санхүүгийн тайлангийн аудитийг энэ хуулиар харин төрийн аудитийн асуудлыг төсвийн хяналт шалгалтын хуулиар зохицуулдаг. Харин компанийн дотоод аудитийн асуудлыг төрийн хуулиар зохицуулдаггүй байгууллага өөрөө шийддэг.

Харин арилжааны банкны аудитийн асуудлыг гадаад орнуудад янз бүрээр зохицуулсан байдаг. Зарим оронд аудитийн хуулиар зохицуулагддаг байхад, зарим оронд Төв банк тусгай эрх эдлэн зохицуулдаг. Арилжааны банкны нягтлан бодох бүртгэл бизнесийн байгууллагынхтай ижил учраас энэ хуулинд арилжааны банкны аудитын

[87] INTOSAI- International Organization of Supreme Audit Institutions
[88] Supreme Audit Institution – Аудитийн дээд байгууллага – " Аудит, баталгаажуулалт ба ёс суртхууны олон улсын тунхаглалуудын гарын авлага-2005 он, 139 дэх нүүр

UIH.MN СУДАЛГААНЫ САН

асуудлыг хамруулсан болно.

Энэ хууль нь аудитор ба аудитийн байгууллагаас аж ахуйн нэгж, компанийн санхүүгийн баримтыг хэрхэн баталгаажуулах, зөвлөх тухай, мөн аудитийн үйл ажиллагаа эрхлэгчдийн удирдлага, зохион байгуулалт, ёс зүйн харилцааг зохицуулдаг байхаар боловсруулагдсан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Аудит, хяналт шалгалтын талаархи хуулиудын үзэл баримтлалын түүвэр хүснэгт**

*/Хуулиудын хувийн хэргээс авав/*

**Монгол Улсын Эрдэнэсийн сангийн тухай хууль** /1994.12.09/

| № | *Хуулийн төсөл боловсруулах шаардлага* | *Зохицуулах харилцаа, хамрах хүрээ* | *Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар болон хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдал* | *Бусад хууль тогтоомжтой холбогдох нь* | **Төрийн оролцоо буюу дагалдаж бий болсон бүтэц** |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хуулийн зохицуулалт үгүйгээс улсын нөөцөд орвол зохих үнэт зүйлсийн чөлөөтэй худалдаа явагдаж түүнийг нөөцлөх, дамлах, гоёл чимэглэлийн зүйл үйлдвэрлэхээр Засгийн газрын тогтоолын дагуу Эрдэнэсийн сангаас авсан алт, мөнгөө дамлан худалдах явдал Зоос гоёлын үйлдвэр болон зарим аж ахуйн нэгжид гарах болов. Мөн олборлосон алтаа улсад болон Монгол банкинд заавал худалдаж байх талаар нэгдсэн чиглэл байхгүй учраас алтны зарим үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ өөрсдөө мэдэж зарцуулан , гадаад, дотоодод худалдан борлуулах боллоо. | Монгол Улсын эрдэнэсийн эх нөөцийг хамгаалах, төрийн эрдэнэсийн санг бүрдүүлэх, хамгаалах, арвижуулах, уул сангаас хөрөнгө гүйлгээнд оруулах, захиран зарцуулах талаар үүссэн харилцааг зохицуулахад оршино. Эрдэнэсийн санд хуримтлуулсан эрдэнэсийг хадгалах, хадгалуулах, худалдан авах, худалдах, цэвэршүүлэх, байршуулах, үзэсгэлэн гаргах, үзмэр зохион байгуулах, эрдэнэсийн санг нэмэгдүүлэх, тэдгээрийг хамгаалах, сэлбэн тордох, сэргээн засварлах зэрэг ажил, үйл ажиллагааг хамаарна. | Улсын эрдэнэсийг сангийн нөөцийг зузаатгах зорилгоор Монгол банкинд Худалдах болон Эрдэнэсийн сангаас гадаадад гарган цэвэршүүлэх, хадгалуулах, байршуулах, худалдах үнэт металлын хэмжээг жил бүр УИХ-аас тогтоож байхаар тусгасан. Тус улсын нутаг дэвсгэрээс олдсон цул алт, дарагдмал үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, түүх, соёлын дурсгалт ховор нандин зүйлсийг олсон ААН, байгууллага, иргэд олдворыг Монгол банкнаас тогтоосон урамшилтай үнээр Улсын эрдэнэсийн санд тушааж байхаар хуульд оруулав. Улсын Эрдэнэсийн сан нь нарийн бүртгэл, хяналт, найдвартай хамгаалалттай байх шаардлагын дагуу бүртгэл хяналтын ерөнхий зарчим, хариуцлага хүлээлгэх чиглэлийг зааж, цагдаагийн хамгаалалтад байна гэдгийг хуулинд тусгав.<br>**1995 оны 4 сарын 17** 14-2 заалтыг **өөрчлөн** найруулсан.<br>**1997 оны 6 сарын 05 Хуулийн 15-1 заалтыг хүчингүй болгосон.**<br>**2002 оны 12 сарын 06 3**-6 заалтыг **нэмсэн,** 2 дугаар зүйл, 3-2,5 заалт, 4-3-2, 5-4, 5 заалт, 6-1, 7-3,4 заалт,12-1,3 заалт, 15-2,3 заалтыг **өөрчлөн найруулсан.**<br>**2003 оны 1 сарын 02** 9-3 заалт **нэмж,** 9-2 заалтыг **өөрчлөн найруулсан.**<br>**2008 оны 12 сарын 19** 15-1-2, 17-1, 18-3 заалтуудыг **өөрчилсөн.** | Үндсэн хууль, Банкны тухай хууль, Валютын зохицуулалтын болон ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалт тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. | Эрдэнэсийн санг Монголбанк эрхэлнэ. Монголбанкны Ерөнхийлөгч нь эрдэнэсийн санг эрхлэх нэгжийн бүтцийг тогтооно. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Монгол Улсын Аудитийн тухай хууль**

/ 1997. 05.22/

| № | *Хуулийн төсөл боловсруулах шаардлага* | *Зохицуулах харилцаа, хамрах хүрээ* | *Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар болон хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдал* | *Бусад хууль тогтоомжтой холбогдох нь* | Төрийн оролцоо буюу дагалдаж бий болсон бүтэц |
|---|---|---|---|---|---|
| 1. | Санхүүгийн бүртгэл, аудитийн үйл ажиллагаа дэлхий нийтээр нэг зарчимтай байх ерөнхий хандлага бий болсон учраас Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн агуулга, зохион байгуулалт олон улсын нийтлэг хэв маягт нийцүүлэх үүднээс хуулийн төслийг боловсруулав. | Энэ хууль нь аудитор ба аудитын байгууллагаас аж ахуйн нэгж, компанийн санхүүгийн баримтыг хэрхэн баталгаажуулах, зөвлөх тухай, мөн аудитын үйл ажиллагаа эрхлэгчдийн удирдлага, зохион байгуулалт, ёс зүйн харилцааг зохицуулдаг байхаар боловсруулагдсан. Энэхүү хууль нь аудитын онолын хэлбэрүүдийн дотроос гадаад гэж нэрлэгддэг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой харилцааг зохицуулах болно. Арилжааны банкны нягтлан бодох бүртгэл бизнесийн байгууллагатай ижил учраас энэ хуулинд арилжааны банкны аудитын асуудлыг хамруулж болно. | **2001оны 11сарын30** Аудитийн тухай хуулийн 17 дугаар зүйлд 5,6,7,8 дахь хэсгийг, 26 дугаар зүйлд 3,4 дэх хэсгийг нэмсэн. 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулсан, 8 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 1,2, 14 дүгээр зүйлийн 1,2, 19 дүгээр зүйлийн 6 дахь заалт, 22-3, 26-2, 30-1, 31-1,2, 32-3,6,9,, 32-,35-3 заалтыг өөрчилсөн. **2003 оны 5 сарын 15** 8 дугаар зүйлийг өөрчилсөн **2005 оны 1 сарын 28** 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 10 дахь заалт нэмсэн **2006 оны 1 сарын 12 нд 3** зүйлд 10,11,12,13 дахь заалт , 4-2, 5-8, 7-1-11,7-3, 12-2, 14-5,6, 24-2, 25-7,6 заалтууд **нэмж,** 3-1,3,7, 7-1-3,4,6,9, 8 дугаар зүйл,13, 14-3, 17, 26, 29-3 заалтуудыг **өөрчлөн найруулж, 3**-5, 8, 4-1-1 дэх заалтуудыг **өөрчилж,** 14-1-4, 15-1, 14-1,2, 15-4-2 дахь заалтыг **хасаж,** 4-1-2, 15-2, 19-6, 22-3 дахь заалт, 4 дүгээр бүлгийг **хүчингүй** болгосон. **2006 оны 12 сарын 15 11** үгээр зүйлд 5 дахь заалт **нэмсэн** | Үндсэн хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. | Монгол Улсын хэмжээнд нягтлан бодох бүртгэл, аудитийн үйл ажиллагаар мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор Мэргэжлийн зөвлөлийг төрийн ба төрийн бус байгууллагын төлөөлөлтэйгээр дарга, 6 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 5 жилийн хугацаагаар Сангийн сайдын тушаалаар томилдог. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт нь мэргэшсэн нягтлан бодогч, аудиторуудын мэргэжлийн ёс зүйг баталж, үндэсний хэмжээнд мөрдүүлэх эрх бүхий нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага байна гэж 2006 оны 1 сарын 12-ны өөрчлөлтөөр нэмсэн. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Төрийн аудитийн тухай хууль** / 2003.01.03 /

| № | *Хуулийн төсөл боловсруулах шаардлага* | *Зохицуулах харилцаа, хамрах хүрээ* | *Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар болон хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдал* | *Бусад хууль тогтоомжтой холбогдох нь* | Төрийн оролцоо буюу дагалдаж бий болсон бүтэц |
|---|---|---|---|---|---|
| 1. | **Т**өсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлагдснаар төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнах, төсвийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг, төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны удирдлагын зарчим, % төсвийн хяналт, хариуцлагын тогтолцоог шинэчлэн тогтоосон учраас энэ харилцааг зохицуулж байсан хуулиудыг нэр томъёоны болон агуулгын хувьд нийцүүлэх үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. | Төрийн аудитийн тогтолцоо, төрийн аудитийг хэрэгжүүлэх байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн аудитийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Төрийн аудитын байгууллагаас улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргахад дагаж мөрдөнө. **/2006,12,15-ны хуулиар нэмэлт орсон/** | Хавсралтад дурдсан хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлт нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нийцүүлэх үүднээс гол төлөв нэр томъёоны болон агуулгын бусад өөрчлөлтийг оруулж байгаа тул ямар нэгэн сөрөг үр дагавар гарахгүй. Харин эдгээр хуулиудын холбогдох зүйл, заалтуудыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай нийцүүлэн нэр томъёо болоод агуулгыг нэг мөр болгох зорилготой.<br><br>Төрийн Аудитийн тухай хуулийн 28 дугаар зүйлд төрийн аудитийн тухай хууль, тогтоомж зөрчсөн этгээдэд хэн ямар шийтгэл ноогдуулахыг хуульчлан тогтоох нь зүйтэй гэж **Ерөнхийлөгч хориг тавьсан.**<br>**2003 оны 1 сарын 10** Энэ хуулийн 28 дугаар зүйлийг өөрчлөн найруулж хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тогтоосон.<br>**2006 оны 12 сарын 15** Хуулийн 8-2, 10-2, 12-3, 12-5, 14-9, 15-3,4 заалты**г нэмсэн.** | Үндсэн хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. | Төрийн аудитийн байгууллагын тогтолцоо нь төрийн аудитийн төв /Үндэсний аудитийн газар/ болон орон нутгийн байгууллагаас /аймаг нийслэлийн аудитийн газар/ бүрдэнэ. Үндэсний аудитийн газар нь МУ-ын Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогч, бусад ажилтнаас бүрдэнэ. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Төрийн хяналт шалгалтын тухай хууль** / 2003.01.03/

| № | *Хуулийн төсөл боловсруулах шаардлага* | *Зохицуулах харилцаа, хамрах хүрээ* | *Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар болон хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдал* | *Бусад хууль тогтоомжтой холбогдох нь* | **Төрийн оролцоо буюу дагалдаж бий болсон бүтэц** |
|---|---|---|---|---|---|
| 1. | **Т**өсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлагдснаар төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнах, төсвийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг, төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны удирдлагын зарчим, % төсвийн хяналт, хариуцлагын тогтолцоог шинэчлэн тогтоосон учраас энэ харилцааг зохицуулж байсан хуулиудыг нэр томъёоны болон агуулгын хувьд нийцүүлэх үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. | Энэ хуулийн зорилт нь төрийн хяналт шалгалтын тогтолцоо, төрийн захиргааны хяналт шалгалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Засгийн газар, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны, Засаг даргын хяналт шалгалт, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон мэргэжлийн хяналт, түүнчлэн нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна. | Хавсралтад дурдсан хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлт нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуульд нийцүүлэх үүднээс гол төлөв нэр томъёоны болон агуулгын бусад өөрчлөлтийг оруулж байгаа тул ямар нэгэн сөрөг үр дагавар гарахгүй. Харин эдгээр хуулиудын холбогдох зүйл, заалтуудыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай нийцүүлэн нэр томъёо болоод агуулгыг нэг мөр болгох зорилготой **2006 оны 12 сарын 22** 10 дугаар зүйлийн 11 дэх заалтыг нэмсэн. | Үндсэн хууль, Төрийн аудитийн тухай хууль, Аудитийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. | Төрийн хяналт шалгалтын тогтолцоо нь УИХ, Ерөнхийлөгч, Төрийн аудитын байгууллага болон төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалт/ цаашид “мэргэжлийн хяналт” гэх/, Үндсэн хуулийн Цэц, шүүх прокурорын хяналт, нутгийн өөрөө удирдах байгууллагаас хийх хяналт шалгалтаас бүрдэнэ. Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь Мэргэжлийг хяналтын ерөнхий газар юм. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## Арав. Эдийн засгийн харилцааг зохицуулж буй бусад хуулиуд

### Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай Монгол Улсын хууль

*Казино байгуулах, ажилуулахыг хориглох тухай хуулийн зохицуулалт, хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан асуудлын талаар:*

Монгол Улсын Их Хурал 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Казиногийн тухай хуулийг батлан гаргаж Монгол улсад казиногийн бүхий үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн.

Гэвч Казиногийн тухай хуулийг батлан гаргахдаа тухайн үеийн нийгэм, эдийн засгийн байдал нь шилжилтийн үеийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж эхлэж байсан, түүнчлэн Казиног байнга дагаж байдаг бусад гэмт хэрэг, зөрчил, мафийн сүлжээ, мөнгө угаалт, хар тамхины наймаа, рэкет /сүрдүүлэн заналхийлж мөнгө нэхэх/ зэрэг сөрөг үр дагаварыг нийгэмд үүсгэх, батлагдсан казиногийн хуульд ямар нэг хязгаарлалтыг тогтоогоогүй нь улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөөлж болзошгүй зэргийг харгалзан үзээгүй байна.

Энэ хуультай холбоотойгоор тухайн үед нийгэмд хүчтэй шүүмжлэл өрнөж байсан төдийгүй хууль батлагдсанаас хойш нэг жилийн дараа нэр бүхий 10 гаруй Монгол Улсын Их Хурлын гишүүд Казино байгуулахыг хориглох тухай болон казиногийн тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн барьж дэмжүүлсэнээр Казиногийн тухай хууль хүчингүй болж, 1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай Монгол улсын хууль батлагдсан байна.

Энэ хууль нь нэг зүйлтэй, хууль батлагдсанаас хойш нэг удаа нэмэлт орсон байна. Хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт казино байгуулах, ажиллуулахыг хориглохоор заасан болно.

*Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийн холбогдох эрх зүйн зохицуулалтын талаар:*

Казино-рулет, хөзрийн тоглоомийн ширээ ба түүнчлэн тоглоомын бусад тоног төхөөрөмжөөр тоноглогдсон мөнгө ба бусад эд хөрөнгийн хонжвор зарладаг мөрийтэй тоглоом эрхлэн явуулдаг тоглоомын газар.

Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй эрсдэл бүхий тоглоом тоглуулдаг зориулалтын өрөө, танхим бүхий газар хэлнэ.[89]

Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуультай шууд холбогдох хуулийн холбогдох заалтуудыг гаргавал:

| № | Хуулийн нэр | Холбогдох хуулийн заалт |
|---|---|---|
| 1 | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль<br>/2001.02.01/ | 8 дугаар зүйл. Хориглох аж ахуйн үйл ажиллагаа<br>8.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:<br>8.1.3. казиногийн үйл ажиллагаа эрхлэх;<br>8.2. Энэ хуулийн 8.1.3 дахь заалт нь чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжид хамаарахгүй |

[89] Эрх зүйн эх толь бичиг С.Нарангэрэл хуудас 246

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | /Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн/ |
| 3 | "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай<br>/2003.06.20/ | 3.3. "Замын-Үүд" бүсэд казино байгуулж болно. |
| 2 | Эрүүгийн хууль<br>/2002.01.03/ | 243 дугаар зүйл. Мөрийтэй тоглох<br>243.1. Хуулиар хориглосон мөрийтэй тоглоом /казино/ тоглосон, түүнийг зохион байгуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавааc тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.<br>*/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/*<br>243.2.Энэ хэргийг давтан үйлдсэн бол эд хөрөнгийг хураах хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br>*/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/* |

Улсын Дээд Шүүхийн 2003.06.20-ны өдрийн 36 тоот тогтоолоор Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсгийн "Казиногийн үйл ажиллагаа эрхлэх"-ийг хориглох гэдэгт мөнгө буюу түүнийг орлогч металл /токенс/ хэрэглэн тоглодог электрон хэрэгсэл, слот машин, мөн тоглоомын үйл ажиллагаанд мөнгийг орлуулан хэрэглэх зориулалтын тусгай хуванцар зоос /чип/ буюу шоо, хөзөр, тэдгээрт зориулсан тоглоомын тусгай ширээ зэрэг казиногийн зориулалтаар өрөө, тасалгаа, тоног, төхөөрөмжийг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй аз туршсан тоглоом тоглуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж ойлгоно гэж тайлбарласан байдаг.

*Дүгнэлт:* Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.3 дахь хэсэгт казиногийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон, бөгөөд энэ нь Монгол улсад чөлөөт бүсээс бусад газарт казино байгуулах, ажиллуулахыг хориглосон заалтууд юм.

Казино байгуулах, ажилууллахыг хориглох тухай хуулийн заалт нь Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиуд нь хоорондоо агуулгын хувьд давхардаж байна. Цаашид казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хууль байх шаардлагагүй юм. Учир нь аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тодорхой заасан байна.

Мөн Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд казиногийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон байх бөгөөд хэрэв зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулсан тохиолдолд Эрүүгийн хуульд хариуцлага хүлээлгэхээр заасан болно.

**Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай**

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, хуулийн үзэл баримтлалд тусгасан асуудлын талаар:*

Манай улсын аж ахуйн нэгжүүдийн хувьд өрсөлдөөний талаархи ойлголт, эрх зүйн орчин 1993 онд "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай" хууль батлагдсанаар бүрэлдэн тогтсон гэж болно.

Гэвч энэ хуулийн хэрэгжилт нь хангалтгүй байсан, хуулийг хэрэгжүүлэх тогтолцоог хэт задлаж, эрх, үүргийг олон байгууллагуудын дунд бүрхэгдүүлсэнээс гадна аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналтын талаархи заалтууд нь практикт хэрэгжүүлэхэд төдийлөн ойлгомж муутай байснаас өрсөлдөөнт зах зээлийн нийгмийн эрх зүйн орчинг боловсронгуй болгон 2000 оны 5 дугаар сарын 12-нд хуулийг шинэчлэн найруулсан.

Шинэчлэн найруулсан "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай" хууль нь 6 бүлэг 18 зүйлтэй бөгөөд энэхүү хуулиар аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагааг хориглон хязгаарлах, урьдчилан сэргийлэх эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг тодорхойлж хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Энэхүү хуулиар зах зээлийн эдийн засгийн нийгэм дэх аж ахуйн нэгж байгууллагын өрсөлдөөнийг хязгаарлах, өрсөлдөөнд харш үйл ажиллагаанд хяналт тавих, таслан зогсоох, монополь байдалтай этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог улам боловсронгуй болгосон.

Нэмэлт, өөрчлөлт орсон байдал:

| **Д/д** | **Нэмэлт өөрчлөлт орсон зүйл заалт** | **Нэмэлт, өөрчлөлт орсон байдал** |
|---|---|---|
| 1. | 1 дүгээр зүйл. 7.1.4 | Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 7.1.4-ийн заалтанд 2002 оны 7дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон. |
| 2. | 2 дугаар зүйл. 12.1 | 12.1-ийн заалтанд 2008 оны 12 дүгээр сарын 19-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан. |
| 3. | 3 дугаар зүйл. 12.5 | Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль 12.5-ийн заалтанд 2005 оны 1 дүгээр сарын 27-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон. |
| 4. | 4 дугаар зүйл. 14.1 | Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль14.1-ийн заалтанд 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар хассан. |
| *Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 7.1.4-ийн заалтанд 2002 онд өөрчлөлт орсон,12.1-ийн заалтыг 2008 онд өөрчлөн найруулсан. 12.5 дахь хэсэгт 2005 онд өөрчлөлт орсон, хууль14.1 дэх хэсэгт 2008 онд өөрчлөн хассан.* | | |

2000 онд батлагдсан хууль нь олон улсын практикт ийм төрлийн хуулиар зохицуулдаг ерөнхий жишиг асуудлуудыг өөрийн орны онцлогт нийцүүлэн дараахь байдлаар системчлэн, хуулийн төслийн үзэл баримтлалдаа авч үзсэн.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Нэг. Зах зээлийг шударга байлгах талаар:

Зах зээлд оролцогч этгээдүүдээс энэхүү хуулийн хүрээний зохицуулалтад хамаарагдах гол этгээдээр тухайн бараа, үйлчилгээний зах зээлд нөлөө үзүүлж чадах, тухайн зах зээлд давамгай байдал эзлэгч аж ахуйн нэгжийг, гадна талаас нь нөлөө үзүүлэгч төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудыг авч тэдгээрээс зах зээлийн өрсөлдөөнд саад болох доорхи ажиллагааг явуулахыг хориглох байдлаар төсөлд тусгасан. Үүнд:

*а/ Давамгай байдалтай аж ахуйн нэгж дангаараа:*

- хомсдол үүсгэх зорилгоор нийлүүлэлтээ багасгах, зогсоох.

- өөрийн бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгжүүдэд ялгавартай үнээр борлуулалт хийх.

- зардлаасаа доогуур үнээр борлуулалт хийх.

- зарим аж ахуйн нэгжтэй үндэслэлгүйгээр гэрээ байгуулахаас татгалзах нөхцөл тавих.

- өрсөлдөгчийнхөө барааг авахгүй байх, элдэв бараа дагалдуулах, хамтарч ажиллахаас татгалзах.

- өрсөлдөгчийнхөө хувьцаа хөрөнгийг худалдан авах замаар эрхшээлдээ оруулах гэх мэт.

*б/ Давамгай байдалтай аж ахуйн нэгж бусад аж ахуйн нэгжтэй хамтран:*

- үнээ тохиролцох, ялангуяа үнээ бууруулах.

- үйлдвэрлэлийн хэмжээг барих, бууруулах.

- зах зээлээ янз бүрээр хуваах.

- худалдаа, дуудлаганд тохиролцон орох.

- бусад этгээдэд барааг худалдах, худалдан авах замаар эрхшээлдээ оруулах гэх мэт.

*в/ Төрийн захиргааны багууллага дангаараа:*

- аж ахуйн нэгжийг хуульд зааснаас бусад тохиолдолд нэг зах зээлээс нөгөөд бараагаа борлуулах.

- аль нэг аж ахуйн нэгжид илүү нөхцөл бүрдүүлэх эсвэл ялгаварлан гадуурхах.

- аливаа зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглох гэх мэт.

*г/ Төрийн захиргааны байгууллага бусадтай хамтран:*

- үнийг бууруулсан буюу нэг хэмжээнд барих.

- зах зээлийг хуваах.

- зах зээлд орох, гарах саад болсон.

Давамгай байдалтай аж ахуйн нэгж дангаараа болон бусад аж ахуйн нэгжтэй хамтран өрсөлдөөнт зах зээлд хориглох үйл ажиллагааг хуулийн 6-р зүйлд “Давамгай байдлаа шударга өрсөлдөөнд харшаар ашиглан, дангаараа үйл ажиллагаа явуулах” талаар 11 зүйлийг хориглосон байна.

Хоёр: Аж ахуйн нэгжүүд нэгдэх, нийлэх, өөрчлөн байгуулах талаар:

Аж ахуйн нэгжүүдийн нэгдэх, нийлэх нь зах зээлд давамгай байдалтай аж ахуйн нэгж үүсэн улмаар тухайн барааны зах зээлд өрсөлдөөнд харш үзэгдэл үүсэх нөхцөл үүсч болдог.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Практикт аж ахуйн нэгжүүдийн нийлэх 3 үндсэн хэлбэр байдаг бөгөөд эдгээрт улс орнууд өөрийн онцлог байдалтай уялдуулан янз бүрээр ханддаг.

Эдгээрээс өрсөлдөөнд хамгийн их саад болж болзошгүй хэлбэр нь хэвтээ буюу нэг төрлийн бүтээгдэхүүнийг нийлүүлэлт явуулдаг өрсөлдөгч аж ахуйн нэгжүүдийн нийлж, нэгдэх явдал юм.

Манай орны хувьд аж ахуйн нэгжүүд нь бусад орнуудынхтай харьцуулахад төдий л том биш жижиг, дунд үйлдвэр ихтэй учраас тэдгээрээс олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс аж ахуйн нэгжүүдийн нэгдэж нийлэхэд төрийн бодлогын хувьд аль болох дэмжих нь зүйтэй юм.

Ингэхдээ өрсөлдөөнийг аль болох ихэсгэх үүднээс өрсөлдөөнд хамгийн их сөрөг нөлөө үзүүлдэг хэвтээ хэлбэрийн нэгдэл ихэссэн учраас давамгай байдалтай этгээд өрсөлдөгч аж ахуйн нэгжтэйгээ нэгдэх, нийлэх шууд хориглоод бусад хэлбэрийг нь хянан зохицуулж болно гэж үзэж хуулийн 15 дугаар зүйлд тусгасан байна.

<u>Гурав: Зүй ёсны монополийн үйл ажиллагааг зохицуулах талаар:</u>

Зүй ёсны монополь аж ахуйн нэгж нь одоогоор тухайн бүтээгдэхүүний зах зээлд дангаараа үйл ажиллагаа явуулж буй этгээд бөгөөд ийм зах зээл нь өрсөлдөөнтэй болох буюу өөр аж ахуйн нэгж уг зах зээлд орох нь эдийн засгийн хувьд ямар ч ашиггүй байдаг.

Иймд ганцаараа тухайн зах зээлийг бүрэн эзэмшихээс өөр боломжгүй. Ийм зах зээлийг өрсөлдөөнд орох боломжоо бүрэлдэх хүртэл нь төрөөс үйл ажиллагааг нь шууд хянан зохицуулдаг практик дэлхийн бүх улс оронд байна.

Зохицуулалт хийдэг гол чиглэл нь уг ноёрхогчийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээ, борлуулалтын үнийн өөрчлөлт, нөхцөл нь бүрэлдсэн тохиолдолд өрсөлдөөнд оруулах зэрэг билээ. Энэ талаар өрсөлдөөнийг хянан зохицуулах албанаас зохицуулалт хийх эрхийг хуулийн төслийн 16 дугаар зүйлд зааж өгсөн байна.

<u>Дөрөв. Өрсөлдөөнийг хянан зохицуулах алба:</u>

Энэхүү хуулийн заалтыг амьдралд хэрэгжүүлэх байгууллагыг Улсын Их Хурлын 1996 оны 40 дүгээр тогтоолын дагуу бие даасан байдалтай үйл ажиллагаа явуулах эрх бүхий хянан зохицуулах албыг Засгийн газрын тохируулагч агентлагийн статустай байхаар хуулийн төсөлд тусгаж түүнтэйгээ уялдуулан уг байгууллагыг эрх үүрэг, гүйцэтгэх ажлын чиглэл, удирдлагыг томилох, ажлаа тайлагнах хэлбэрүүдийг хуулийн холбогдох заалтуудад оруулсан байна.

Бусад орнуудын туршлагаас үзэхэд зах зээлийн системийн орнууд ийм төрлийн байгууллагыг Засгийн газраас аль болох хамааралгүй бие даасан шинжтэй байгуулан ажиллуулж байхад харин хуучин социалист системд байсан орнуудын хувьд эдийн засгийн чиглэл хариуцсан яамны дэргэд Ерөнхийлөгчийн шийдвэрээр байгуулсан практик байсан.

Хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хуулийн хэрэгжилтийн талаар гомдол, саналыг хэрхэн шийдвэрлэх талаар Монгол Улсад мөрдөгдөж байгаа энэ чиглэлийн журмыг үндэслэн шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын эрх хэмжээг зааж өгсөн байна.

*<u>Шударга бус өрсөлдөөнийг хориглох талаархи гадаад орны туршлагын талаар:</u>*

- Оросын Холбооны Улсын туршлага: ОХУ-ын "Өрсөлдөөнийг Хамгаалах тухай Холбооны хууль" нь 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр 9 бүлэг 52 зүйлтэйгээр батлагдсан болно.

UIH.MN СЭДАЛГААНЫ САН

Өрсөлдөөнийг Хамгаалах тухай Холбооны хуулийн хувьд дараахь хэд хэдэн онцлогтой болно.

1/ ОХУ-ын энэхүү хууль нь нэр томъёоны хувьд нэлээд задлан тодорхойлж өгсөн. Жишээ нь: Хуулийн 4 дүгээр зүйлд “харилцан орлох бүтээгдэхүүн”, “ялгаварлан үзэх нөхцөл”, “санхүүгийн үйлчилгээний үндэслэлгүй хэт өндөр болон бага үнэ”, “өрсөлдөөнийг хязгаарлах шинж тэмдэг”, “босоо тохиролцоо”, “эдийн засгийн үйл ажиллагааны зохицуулалт”, “төрийн болон нутгийн захиргааны тусламж” зэрэг нэр томъёог нарийвчлан тодорхойлж өгсөн.

2/ Энэхүү хуулиар ОХУ-ын төрийн байгууллага болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд 19-р зүйлд заасан зорилгоор тусламж үзүүлэхдээ Монополийн эсрэг байгууллагаас заавал зөвшөөрөл авах талаар заасан байдаг. Харин хуулийн 20-р зүйлд ОХУ-ын Монополийн эсрэг байгууллагаас урьдчилан зөвшөөрөл заавал авахгүйгээр улсын болон нутгийн захиргааны байгууллагаас тусламж үзүүлэх тохиолдолуудыг заасан байдаг.

3/ ОХУ-ын Монополийн эсрэг байгууллагын үүрэг, бүрэн эрхийн талаар нарийвчлан зааснаас гадна иргэдээс Монополийн эсрэг байгууллагад мэдээлэл өгөх, монополийн эсрэг байгууллага хууль тогтоомж зөрчсөн эсэх талаар хэрэг үүсгэх процессыг нарийвчлан заасан байдаг.

4/ Арилжааны байгууллагууд дараахь тохиолдолд үүсгэн байгуулагдах, нэгдэх, нийлэх тохиолдолд заавал Монополийн эсрэг байгууллагаас зөвшөөрөл авах талаар хуульчилсан байдаг.

5/ Давамгай байдалтай аж ахуйн нэгжийн талаархи ойлголтыг маш нарийвчлан зохицуулсан байдаг. Жишээлбэл: Дараахь нөхцөлд аж ахуй эрхлэгч (санхүүгийн байгууллагаас бусад)-ийг давамгай байдалтай гэж үзнэ.

- хэрэв гурван аж ахуй эрхлэгч (тус бүрийнх нь эзлэх хувь тухайн зах зээл дэх бусад аж ахуй эрхлэгчээс илүү)-ийн нийт хувь зах зээлийн тавин хувиас дээш, эсвэл таван аж ахуй эрхлэгч (тус бүрийнх нь эзлэх хувь тухайн зах зээл дэх бусад аж ахуй эрхлэгчээс илүү)-ийн нийт хувь зах зээлийн далан хувиас дээш байвал (хэрэв эдгээр субъектүүдийн аль нэгнийх нь эзлэх хувь найман хувиас бага байвал энэхүү зүйл үйлчлэхгүй);
- урт хугацааны туршид (нэг жилээс багагүй хугацаанд эсвэл тухайн барааны зах зээл үргэлжилсэн хугацаанаас жил орчим хугацаанд) аж ахуй эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь өөрчлөгдөөгүй, эсвэл өөрчлөлтөнд бага өртсөн, мөн тухайн зах зээлд шинэ өрсөлдөгч ороход бэрхшээлтэй бол;
- аж ахуй эрхлэгчийн борлуулж эсвэл худалдан авч буй барааг өөр бараагаар орлуулах боломжгүй, (ялангуяа: үйлдвэрлэлийн зорилгоор хэрэглэж байгаа үед), үнийн өсөлт, эрэлт буурахаас үл хамаарах, тухайн зах зээл дээрхи барааны үнэ, худалдах, худалдан авах нөхцлийн талаархи мэдээллийг тодорхой бүлэг этгээд л мэдэж болох нөхцөл байдалтай бол.
- Аж ахуй эрхлэгч өөрийг нь барааны зах зээлд давамгай байдалгүй болохыг батлах нотолгоог монополийн эсрэг байгууллага болон шүүхэд гаргах эрхтэй.
- Аж ахуй эрхлэгч барааны зах зээлд ердийн монополийн байр суурь эзэлж байгаа бол түүнийг давамгай байдалтай гэж үзнэ.
- Хэрэв аж ахуй эрхлэгч тодорхой барааны зах зээлд гучин таваас багагүй хувь эзэлдэг бол түүнийг Холбооны хуулиар давамгай байдалтай гэж тогтоож болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Энэхүү хуульд заасан хязгаарлалтыг тооцсоны үндсэн дээр Засгийн газар санхүүгийн байгууллага (зээлийн байгууллагаас бусад)-ыг давамгай суурьтай гэж үзнэ. Засгийн газар энэхүү хуульд заасан хязгаарлалтыг тооцсоны дараа Төв банктай зөвшилцсөний үндсэн дээр зээлийн байгууллагыг давамгай байр суурьтай гэж үзнэ. Санхүүгийн байгууллага (зээлийн байгууллагаас бусад)-ын давамгай байдлыг Засгийн газрын баталсан журмын дагуу Монополийн эсрэг байгууллага тогтооно.

Зээлийн байгууллагын давамгай байдлыг тогтоох журмыг Засгийн газар Төв банктай зөвшилцсөний үндсэн дээр батална. Хэрэв зах зээлд эзлэх хувь нь арван хувиас дээшгүй, хэд хэдэн зах зээлд эзлэх хувь нь хорин хувиас дээшгүй бол тухайн санхүүгийн байгууллагыг давамгай байдалтай гэж үзэхгүй.

- ***Бүгд Найрамдах Солонгос Улсын туршлага:*** 1980-аад онд Солонгосын Засгийн газар төрийн зохицуулалт, дэмжлэг, хамгаалалт бүхий эдийн засгийн удирдлагын тогтолцооноос өөрийгөө зохицуулах, нээлттэй өрсөлдөөний зарчимд тулгуурласан зах зээлийн эдийн засаг руу шилжих эхлэлийг тавьсан юм.

БНСУ 1980 онд Үндсэн хуулийнхаа 8 дугаар нэмэлтээр төр нь зах зээлд давамгай байдал бий болгох, түүнийгээ буруугаар ашиглах явдлаас сэргийлж эдийн засгийг зохицуулж, удирдаж болно” гэж заасан. Түүнээс гадна 1980 оны эцсээр “Монополийг зохицуулах ба шударга худалдааны хууль” /Monopoly Regulation and Fair Trade Act/ -ийг баталж, 1981 оноос эхлэн хэрэгжүүлсэн байна.

Монополийг зохицуулах ба шударга худалдааны хууль нь Солонгосын эдийн засгийг төрийн зохицуулалттай системээс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжүүлэх зорилготой боловсруулагджээ.

1980-аад оны дунд хүртэл хуулийг боловсруулж хэрэгжүүлсний үр дүнд юуны өмнө, зах зээл дээр шударга бус худалдааны үйлдлүүд болох шударга бус туслан гүйцэтгэх гэрээ байгуулах, шударга бус шошго хэрэглэх, сурталчилах, хэрэглэгчдийг хууран мэхлэх зэрэг явдлуудтай эн тэргүүнд тэмцэж эхэлсэн байна. Жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжихийн тулд туслан гүйцэтгэгчийн тухай гэрээг хуулийн заалтаас салгаж тусад нь “Туслан гүйцэтгэх шударга үйл ажиллагааны хууль”-ийг 1984 онд баталсан байна.

- ***Бүгд Найрамдах Хятад Ард Улсын туршлага***: БНХАУ-ын “Шударга бус өрсөлдөөний эсрэг” хууль нь 1993 оны 9 сарын 2-ны өдөр Үндэсний бүх нийтийн 8-р хурлын Байнгын хорооны 3-р чуулганаар хэлэлцэж, БНХАУ-ын Ерөнхийлөгчийн №10 зарлигаар тунхаглагдан, 1993 оны 12 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон байна.

Энэ хууль нь зах зээлийн эдийн засгийн эрүүл хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэх, шударга өрсөлдөөнийг хамгаалах, идэвхижүүлэх, шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх, зах зээлд оролцогч болон хэрэглэгчдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах зэрэгт үйлчилнэ. Энэ хуулиар “Шударга бус өрсөлдөөн“ гэж тус хуулийн заалт зөрчсөн өрсөлдөгчийн үйл ажиллагаа, өрсөлдөгчийн ашиг сонирхол болон хууль ёсны эрхийг зөрчсөн зөрчил, нийгэм эдийн засгийн эрх ашгийг алдагдуулах үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

БНХАУ-ын Шударга бус өрсөлдөөний эсрэг хуулиар зах зээлд оролцогчийн бизнесын нууц, нэр хүндийг хамгаалах талаар болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар нарийвчлан зохицуулсан байхаас гадна хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан заасан байна. Тухайлбал хуулийн 20 дугаар зүйлд “Энэ хуулиар зохицуулсан заалтыг зөрчин, бусдад хохирол учруулсан зах зээлд оролцогч нь хохиролыг

UIH.MN СУДАЛГААНЫ САН

барагдуулан нөхөн төлбөр өгөх хариуцлага хүлээнэ. Хохирсон этгээдийн хохирлыг тооцоолоход хэцүү үед хохирлын нийт хэмжээ нь тухайн зөрчилтэй үйл ажиллагааны үед зөрчлийн хугацааны туршид олсон ашиг орлого байх болно.

Хууль ёсны эрх ашиг сонирхолыг нь зөрчсөн шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаанд тооцогдох зөрчил гаргасан этгээд нь хохирсон этгээдийн улирлын бүх зардлыг төлнө" гэж заасан байдаг. Мөн энэхүү хуулиар Зах зээлд оролцогч этгээд бусдийн бүртгэлтэй барааны тэмдгийг хуурамчаар хийх, зөвшөөрөлгүйгээр хэн нэгний бизнесийн нэр болон хувийн нэрийг хэрэглэх, алдартай болон сайн чанарын бараа бүтээгдэхүүний эмблем, гэрчилгээ зэрэг чанарын тэмдгийг буруугаар ашиглах, дууриалган хийх, бараа бүтээгдэхүүний үүсэл гарлыг гуйвуулах, бичиг баримтыг хуурамчаар хийх, бараа бүтээгдэхүүний чанарыг төөрөгдүүлэн буруу мэдээлэл хийх зэрэг хууль бус үйлдэл үйлдсэн тохиолдолд БНХАУ-ын Бүтээгдээхүүний чанарын тухай хууль болон Барааны тэмдэгтийн тухай хуулийн заалтын дагуу шийтгэл хүлээлгээр заасан байна.

***Дүгнэлт:*** Нийгэм, эдийн засагт Өрсөлдөөний бодлого гурван үндсэн үүрэг гүйцэтгэдэг.

1. Компаниудын өрсөлдөх чадвар сайжирдаг.
2. Өрсөлдөөнөөр дамжин барааны үнэ буурч, чанар сайжирдаг учраас хэрэглэгчдэд таатай нөлөө үзүүлдэг.
3. Эдийн засгийн тогтвортой өсөлтөд сайн нөлөө үзүүлдэг.

2000 онд батлагдсан Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг амьдралд хэрэгжүүлэх явцад дараахь үндэслэлээр хуульд зайлшгүй өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа болно.

1/ Хуулийн үйлчлэх хүрээ зөвхөн ашгийн төлөөх хуулийн этгээдэд болон төрийн захиргааны байгууллагад үйлчлэхээр заасан байдаг. Гэвч амьдрал дээр улсын бүртгэлд хуулийн этгээдээр бүртгэгдээгүй боловч бизнесийн тодорхой ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн, ашгийн төлөө бус хуулийн этгээд нь зах зээлд нөлөөлөх, бизнесийн харилцааг хязгаарласан, өрсөлдөөнд харшилсан үйл ажиллагаа явуулах боломжтой байгаа тул хуулийн үйлчлэх хүрээг өргөтгөх шаардлагатай байгаа болно.

2/ Хуулийн 5.1-д "Зах зээлд тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын гуравны нэгээс дээш хувийг дагнан буюу бусад этгээдтэй хамтран хийж байвал давамгайлах байдалтай гэж үзнэ" гэж заасан байдаг.

Гэвч зах зээлийн өрсөлдөөнт өнөөгийн нийгэмд зөвхөн зах зээлд борлуулалтын хэмжээний эзлэх хувиар давамгай байдлыг тогтоох нь ихээхэн учир дутагдалтай гэж үзэж болох юм. Гадаад улсуудын хувьд давамгай байдлаар тухайн зах зээлд бараа бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээнээс хамаарах, ямар тохиолдолд давамгай байдалтай гэж үзэхгүй болох талаар нарийвчлан заасан байдаг.

Хэдийгээр зах зээлийн 1/3-д хүрээгүй ч зах зээлд давамгайлах байр суурьтай эсвэл зах зээлийн 1/3-аас их хэмжээг эзлэж байсан ч зах зээлд нөлөө үзүүлэх чадваргүй байх тохиолдол байдаг ч одоо мөрдөж байгаа хуулиар энэ асуудал зохицуулагдахгүй байна.

3/ Хуулийн 15.1-т давамгай байдалтай аж ахуй нэгж өрсөлдөгч аж ахуйн нэгжтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдахыг шууд хориглосон байдаг.

Өөрөөр хэлбэл шударга бус өрсөлдөөний эсрэг аж ахуйн нэгж, байгууллага

UIH.MN СУДАЛГААНЫ САН

нэгдэн нийлэх үйл ажиллагаанд хяналт тавина гэсэн боловч яг ямар үйл ажиллагааг нэгдэн нийлэх гэх, яг ямар нөхцөлд энэхүү нэгдэн нийлэх нь шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх вэ гэдгийг тодорхой зааж өгөөгүй болно.

4/ Одоо мөрдөж байгаа хуульд өрсөлдөөнд харш гэрээ, хэлцэл, картелийн талаархи ойлголт, өрсөлдөөнд харш хэлцэл, гэрээ байгуулах талаархи эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл энэхүү хууль нь давамгай байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулаад бусад аж ахуйн нэгж картелийн үйл ажиллагаа явуулахыг хориглох талаар зохицуулаагүй болно.

5/ Зүй ёсны монополийн үйл ажиллагаанд хяналт тавихдаа зөвхөн үнэ болон нийлүүлэлтийн өөрчлөлтөд анхаарсанаас бус, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад анхаараагүй байна.

Монополь байдалтай аж ахуйн нэгж, компаниуд тэр байдлаа ашиглан зохиомлоор хэт өндөр үнэ тогтоох, бууруулах боломж их байдаг учир монополь аж ахуйн нэгж бараа бүтээгдэхүүний үнийг хэт өсгөх явдалд төрийн хяналтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

6/ Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, хэмжээ, бүтэц, зохион байгуулалт, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэх, олон нийтэд хуулийг сурталчилах ажлыг хангалтгүй хийдэг.

7/ Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээ нь тухайн хууль зөрчсөн этгээдэд шийтгэл болж өгдөггүй. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх захиргааны хариуцлага нь аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох, хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураах, үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоох, тусгай зөвшөөрлийн эрхийг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, албан тушаалтанг 30000-60000 төгрөгөөр торгох, зөрчил гаргахаас өмнөх байдлыг сэргээн тогтоох шийтгэлийг ногдуулдаг.

Хэдийгээр хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураах, үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоох, тусгай зөвшөөрлийн эрхийг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх зэрэг захиргааны шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр хэрэглэхээр хуульчилсан байдаг ч энэхүү хуулийн заалт нь огт хэрэгждэггүй гэж хэлж болох юм.

8/ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар нь зөвхөн баримт бичгийн шалгалтаас гадна аж ахуйн нэгжийг бие даасан санхүүгийн хараат бус үйл ажиллагаатай хуулийн этгээд гэдэг талаас нь шалгадаггүй. Үүнээс гадна хариуцлага хүлээлгэхдээ зөвхөн захиргааны хариуцлага хүлээлгэхээс эрүүгийн хариуцлага буюу Эрүүгийн хуулийн 168, 169 дугаар зүйлүүдийг[90] баримтлах нь бага байдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[90]- **Эрүүгийн хуулийн 168 дугаар зүйл, Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашиглах**
168.1.Өөрийн болон гадаад улсын ижил нэр төрлийн бүтээгдэхүүний **барааны тэмдгийг хуурамчаар үйлдсэн**, **барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашигласны улмаас** бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ./
**169 дүгээр зүйл. Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх**
/169.1.Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан буруу жинлэх буюу хэмжих, үнэ, тарифыг өсгөх, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан жин, хэмжүүр

Иймд 2000 онд батлагдсан “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хуулийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, энэхүү бие даасан хуулийг шинэчлэх бус түүнтэй нийцүүлэн гарах хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бусад хууль тогтоомжтой сайтар уялдуулан боловсруулах шаардлагатай юм.

**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай**

*Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн танилцуулга болон хуулийн үзэл баримтлалд тусгагдсан асуудлын талаар:*

Монгол Улс 2001.11.12-нд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай" ОУ-ын Конвенцид гарын үсэг зурсан бөгөөд улмаар 2004.12.18-ны өдөр Улсын Их Хурлаас уг Конвенцийг соёрхон баталсан. Энэхүү Конвенцид оролцогч гишүүн улс бүр терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар холбогдох арга хэмжээ авах чиглэлээр үүрэг хүлээхээр заасан байна.

Мөн МУ-ын Ерөнхиийлөгч "Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай" 2001 оны 60 дугаар зарлиг гаргасан бөгөөд түүнийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2001 онд "Терроризмын эсрэг олон улсын эвслийн үйл ажиллагааг дэмжих тухай" 226 дугаар тогтоолыг баталсан болно.

Эдгээр эрх зүйн шаардлага, үндэслэлийн дагуу Монгол Улс 2006 оны 7-р сарын 8-ны өдөр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий ***“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай”*** хуулийг 4 бүлэг 21 зүйлтэйгээр баталсан болно.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн үзэл баримтлалд дараахь хэд хэдэн чиглэлээр тусгасан байна.

1. *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэжигтэй гүйлгээ болон харилцагчийн талаархи мэдээллийг шалган тогтоох, холбогдох арга хэмжээний талаар хэрэгжүүлэх байгууллагын эрх үүргийн талаар хуульчлах;*

Хуулийн 4-р зүйлд дурьдсан санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий 8 байгууллага нь сэжигтэй гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд заавал мэдээлэх үүргийг хуульчлан өгсөн.

Мөн дээр нэр бүхий 8-аас гадна хуулийн этгээд, иргэн тодорхой гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзсэн, эсхүл 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлж болно.

2. *Мэдээлэх үүрэгтэй байгууллага, түүний ажилтнууд сэжигтэй гүйлгээний талаар холбогдох байгууллагуудад мэдээлсэнийхээ төлөө ямар нэг хариуцлага хүлээхгүй байхаар хуульчилна.*

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд тусгайлан хянах гүйлгээ болон сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэх журам,

---

ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатай өөрчлөх, **бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх**, **хуурамч зар сурталчилгаа явуулах** зэргээр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ./

UIH.MN СУДАЛГААНЫ САН

харилцагчийн талаархи бичиг баримт, материалыг хадгалах, дансанд хяналт тавих журам, мэдээллийн нууцлалыг хадгалах зэргийн талаар хуульчилсан.

Заавал мэдээлэл өгөх этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсан нь тогтоогдсон ч тухайн мэдээлэл өгсөн этгээдийг захиргааны болон эрүүгийн хариуцлагад татахыг хориглохоор хуульд заасан байна.

Санхүүгийн мэдээллийн алба, Мэдээлэл үүрэгтэй этгээд, тэдгээрийн ажилтны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирол, эдийн бус гэм хорыг арилгах асуудлыг Иргэний хуульд заасан журмын дагуу шийдвэрлэхээр хуулийн 12.4-т хуульчилсан байна.

3. *Бэлэн мөнгөний гүйлгээний үнийн дүнгээс хамаарч гүйлгээг хянах, холбогдох байгууллагад мэдээлэхтэй холбогдуулан босго үнийг тогтоох;*

Хуулиар 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн тохиолдолд Санхүү мэдээллийн албанд мэдээлэхээр тусгасан байна.

4. *Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх тухай хууль тогтоомжийг биелүүлэх, хяналт тавих чиглэлээр Монгол банкны бүтцэд Санхүүгийн мэдээллийн албыг байгуулан ажиллуулах;*

Хуулийн Гуравдугаар бүлэгт Санхүү мэдээллийн албаны бүтэц, чиг үүрэг, мэдээллийн сан болон гадаад улсын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах талаар хуульчилсан байна.

Хууль батлагдсанаас хойш нэмэлт, өөрчлөлт оруулаагүй байна.

*Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаархи ерөнхий ойлголт, зарим улсын туршлага:*

“Мөнгө угаах” гэдэг нь хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл банк санхүүгийн байгууллага, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан хууль бусаар олсон бохир мөнгийг цэвэршүүлэх үйл ажиллагаа юм.

Хууль бус ажиллагаанаас олсон орлогыг тээвэрлэх, шилжүүлэх, хөрвүүлэх, хувиргах ба хууль ёсны дагуу олж авсан бусад мөнгө, хөрөнгөтэй нийлүүлэх замаар эдгээр орлогын мөн чанар, эх үүсвэр, зарцуулалт, шилжилт хөдөлгөөн, өмчлөлийн талаархи мэдээллийг нуун далдлах, төөрөгдүүлэх үйл ажиллагаа юм.

Мөнгө угаах нь дараахь үе шаттай: байршуулах /хууль бус ажиллагаанаас олсон мөнгийг тээвэрлэх, шилжүүлэхэд хялбар бөгөөд хүний анхаарал хамгийн бага татах актив хөрөнгөд хөврүүлэн санхүүгийн системд шилжүүлэх/; давхардуулах /олон тооны санхүүгийн гүйлгээний тусламжтайгаар хөрөнгө, мөнгөний гарал үүслийг нуун ддадлах/; интеграц /гарал үүслийг нь хангалттай дадлаж нуусан хөрөнгө мөнгийг хууль ёсны үйл ажиллагаанд оруулах, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах/.[91]

“Терроризмыг санхүүжүүлэх”–гэдэг нь террорист байгууллага болон террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж аливаа хэлбэрээр эд хөрөнгө хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулахыг хэлнэ.

Мөнгө угаах гэмт хэргийг сүүдрийн эдийн засгийн орчинд, татвараас зугтаалгасан

[91] Эрх зүйн эх толь бичиг С.Нарангэрэл 2007 он

UIH.MN СУДАЛГААНЫ САН

мөнгөө хуурамч дансанд шилжүүлэн үржүүлэх замаар үйлдэх нь их бөгөөд өмнө нь мөнгө угаах гэдгийг гол төлөв зохион байгуулалттай гэмт хэргийн төрөл гэж үздэг байна.

Мөнгө угаахтай тэмцэх комисс буюу The Financial Action Task Force /FATF/ байгууллагыг байгуулж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын асуудлыг зохицуулах үүргийг хүлээжээ.

- ***Оросын Холбооны Улсын туршлага:***

ОХУ нь 1999 онд "Гэмт хэрэг үйлдэн олсон орлогыг хураах, мөрдөн шалгах, түүнийг угаахтай тэмцэх" Европын Зөвлөлийн конвенцид нэгдэж, Мөнгө угаахтай тэмцэх үндэсний хууль тогтоомжийг баталсан. 2001 онд ОХУ нь "Хууль бус орлогыг угаахтай тэмцэх" хуулийг баталсан. ОХУ-ын хувьд мөнгийг гол төлөв санхүүгийн байгууллагаар дамжуулан угааж байсан тул энэ хууль тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд чиглэж байсан. Их хэмжээний мөнгөөр гүйлгээ хийвэл хянах, энэ талаар мэдэгдэх үүргийг санхүүгийн байгууллагууд хүлээж байсан.

Хуулийн дагуу 600 000 рубль /$21413 буюу 17549 евро/-ээс дээш хэмжээний гүйлгээ хийсэн тохиолдолд хяналтанд орох ёстой байдаг. Холбооны санхүүгийн хяналтын алба мөнгө угаахтай тэмцэх асуудлыг хариуцаж, их хэмжээний мөнгөөр гүйлгээ хийсэн худалдаа арилжааг хянаж дүн шинжилгээ хийдэг байна.

Мөн ОХУ нь 2002 онд Засгийн газрын харьяа Санхүүгийн мониторингийн хороог байгуулсан бөгөөд энэ хороо нь санхүүгийн ямар ч үйл ажиллагааг улс орон даяар хянах онцгой үүрэгтэй бөгөөд ОХУ-ын мөнгө угаахын эсрэг хуулийн дагуу 600 000 рублиэс дээш хэмжээний гүйлгээ хийсэн тохиолдолд энэ байгууллагад мэдэгдэх үүрэгтэй байдаг байна.

***Бүгд Найрамдах Хятад Ард Улсын туршлага:***

2006 онд Мөнгө угаахын эсрэг хуулийг баталж, мөнгө угаах гэмт хэрэгт авилга, хээл хахуулийг мөн оруулан тооцох болсноос гадна ийм төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, мөнгө угаахтай тэмцэх ажлыг удирдан чиглүүлэх үүргийг Хятадын Төв банк хүлээн хэрэгжүүлдэг байна.

Мөнгө угаахтай тэмцэх хууль нь 2007 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэхүү хуулиар санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагуудыг харилцагчийнхаа мэдээлэл цуглуулж, их хэмжээний мөнгөөр хийгдсэн буюу сэжигтэй арилжааны талаар мэдээлэхийг үүрэг болгожээ.

Энэ хуулиар санхүүгийн байгууллагууд хувь хүн бэлнээр 10.000 ам доллараас дээш, бэлэн болон бэлэн бус тооцоогоор 100 000 ам доллараас дээш, компани 500.000 ам доллараас хэмжээний гүйлгээ хийсэн бол төв банкинд мэдэгдэх ёстой байдаг байна.

*Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаархи Олон Улсын гэрээ, конвенци болон зөвлөмжийн талаар:*

Терроризмыг санхүүжүүлэх нь террорист чиглэлтэй олон улсын шинжтэй гэмт хэргийн нэг. Олон Улсын түвшинд терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагыг терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Олон Улсын конвенцид заажээ. /НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1999 оны 12 сарын 54/109 дүгээр тогтоолоор баталж, 2002 оны 04 сарын 10-нд хүчин төгөлдөр болсон./[92]

Сүүдрийн эдийн засагтай тэмцэх ажлыг Олон улсын хэмжээнд мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хяналтын комисс буюу FATF хэрэгжүүлдэг бөгөөд мөнгө угаахын эсрэг

[92] Мөн тэнд

UIH.MN СУДАЛГААНЫ САН

40+9 зарчмыг баталсан байна.

Олон Улсын хамтын нийгэмлэгээс дэлхийн улс түмэнд нэгдэхийг уриалсан терроризмын холбогдолтой дараахь гэрээ, конвенцид манай улс нэгдэн орсон. Тухайлбал,[93]

1/ Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн хууль зүйн зөрчил болон тодорхой бусад үйлдлийн тухай Токиогийн 1963 оны конвенцид 1990 онд,

2/ Алан хядах зорилгоор бөмбөг хэрэглэхтэй тэмцэх тухай НҮБ-ын 1999 оны конвенцид 2000 онд,

3/ Барьцаанд хүмүүсийг авахтай тэмцэх тухай Нью-Йоркийн 1979 оны конвенцид 1992 онд,

4/ Далайн навигацын аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Ром хотноо 1988 онд баталсан конвенци, түүний нэмэлт Эх газрын хормойд байрлуулсан суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протколд 2005 онд,

5/ Иргэний агаарын тээврийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус явдалтай тэмцэх тухай Монреалын 1971 оны коонвенцид 1972 онд,

6/ Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцийн нэмэлт болох Олон Улсын иргэний нисэхэд үйлчилж буй нисэх буудалд хүчирхийллийн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай Монреалийн 1988 оны протоколд 1999 онд,

7/ Нисэх онгоцыг хууль бусаар булаан аваачих явдалтай тэмцэх тухай Гаагийн 1970 оны конвенцид 1971 онд,

8/ Олон Улсын хамгаалалтын хүлээх хүмүүсийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шүүн цээрлүүлэх тухай НҮБ-ын 1973 оны конвенцид 1975 онд,

9/ Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор тэмдэглэл хийх тухай Монреалийн 1991 оны конвенцид 1999 онд,

10/ Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай Венийн 1980 оны конвенцид 1986 онд,

11/ Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай НҮБ-ын 1999 оны конвенцид 2004 онд

12/ Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг хориглох тухай НҮБ-ын 2001 оны конвенид тус тус Монгол Улс нэгдэн орсон байна.

Олон Улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага болон Базелын хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу банкинд мөнгө угааж байгааг харуулах гол үзүүлэлтүүдийн тоонд дараахь зүйлс ордог байна.

- Харилцагч данс нээхгүйгээр бага хэмжээний төлбөрийн баримтыг их хэмжээний төлбөрийн баримтаар солих хүсэлт гаргах,
- Харилцагчийн зүгээс данс нээлгүйгээр их хэмжээний валют бэлнээр солиулах хүсэлт гаргах,
- Харилцагчийн зүгээс данс нээлгүйгээр мөнгөний чек гэх мэт баримтуудыг хадгалан авах хүсэлт гаргах,

[93] www.legalinfo.mn

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Харилцагчийн зүгээс данс нээлгүйгээр өөр улс руу сүлжээгээр шилжүүлэг хийх хүсэлт гаргах,
- Харилцагчийн зүгээс тодорхой шалтгаангүйгээр хэд хэдэн банкинд данс нээлгэх,
- Үнэт цаас, банкны баримтууд, чек, аялалын чек ашиглан банкинд данс эсхүл хадгаламж нээх ба данс эзэмшигч нь төлбөр хийх эрхгүй байх,
- Банкны зарим нөхцөлүүдийн талаар өөртөө хэрэгцээгүй мэдээллийг хүсэх,
- Харилцагчийн хадгаламж болон төлбөрийн баримт нь түүний эрхэлж байгаа ажил, үйлчилгээтэй харьцуулахад харьцангуй их байх,
- Мансууруулах бодис худалдагч, гэмт хэргийн бүлэгтэй холбоотой болох нь илэрхий харилцагч банкинд хадгаламж нээлгэх,
- Гадаадын харилцагч данс нээлгэн мөнгөө хадгаламжийн хугацаа дуусахаар гадаад улс руу илгээх хүсэлт тавих,
- Харилцагч үнийн дүн бага хэмжээний олон данс нээлгэх,
- Харилцагч их хэмжээний бэлэн мөнгийг валют бусад төлбөрийн хэрэгсэлээр солиулах хүсэлт гаргах зэрэг байдаг байна.

*Дүгнэлт:* Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг тэмцэх асуудлаар эрх зүйн орчин бүрдээгүй, манай улсын эдийн засгийн чадавхиас шалтгаалан гарсан хууль, эрхийн актууд өнөөгийн нөхцөлд шаардлага хангахгүй байгаагийн улмаас дээрхи гэмт хэрэгтэй тэмцэх хэрэгсэл болж чадахгүй байгааг анхаарч, үйлчилж буй хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай хууль тогтоомжийг шинээр батлан гаргах.

Сэжигтэй эх үүсвэр бүхий мөнгөний ялгарах онцлог, тэдгээрийн үйлдлийн хэлбэр, илрэх тохиолдолд авах арга хэмжээний цогц бүтэц, тогтолцоог буй болгоход энэхүү хууль гол анхааралаа хандуулсан байна.

- **Нягтлан бодох бүртгэлийн тухай**

*Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн үзэл баримтлалд тусгасан асуудлын талаар:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль нь анх 1993 онд батлагдан гарсан бөгөөд үүнээс өмнө улсын бүртгэл тооцооны ажил нь “Тайлан балансын дүрэм”, “Ерөнхий /ахлах/ нягтлан бодогчийн эрх, үүргийн дүрэм” зэрэг дүрмүүдээр зохицуулагдаж байсан байна.

Энэхүү дүрмүүд нь төрийн өмчид тулгуурласан байгууллагын бүртгэл, тооцооны ажлыг улсын хэмжээнд зохицуулах зориулалттай байсан учраас дагаж мөрдөх боломжгүй болсон зэргийг үндэслэн бүртгэлийн шинэ тогтолцоог тусгасан нягтлан бодох бүртгэлийн ажиллагааг зохицуулсан хууль батлан гаргах шаардлага зүй ёсоор гарсан байна.

1993 онд батлагдан мөрдөгдөж байсан Нягтлан бодох бүртгэлийн хууль нь Олон улсын стандарт жишигт нийцээгүй, нягтлан бодох бүртгэлийн ихэнхи харилцааг Засгийн газрын тогтоол, Сангийн яамнаас гаргасан эрх зүйн акт, заавар, журмаар зохицуулж ирсэн нь энэхүү хууль ерөнхий шинжтэй байсантай холбоотойгоор хуулийг шинэчлэн найруулах шаардлага гарсанаар 2001 оны 12 дугаар сарын 13-ны өдөр УИХ-аас шинэчлэн найруулсан “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийг 5 бүлэг 24 зүйлтэйгээр баталсан.

Энэхүү хуулиар нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчилсан. Бизнес эрхлэгчдэд Нягтлан бодох бүртгэлийн хуулийн ижил орчин бүрдүүлснээр аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн хувьд нэг ижил зарчмаар, зэрэгцүүлэх боломжтойгоор бэлтгэдэх, мэдээлэл

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хэрэглэгчдийн эрэлтийг хангах, олон улсын жишигт нийцэх зэрэг боломжийг бий болгосон юм.

Төсвийн сахилга бат зөрчигдөн, өр авлагын сүлжээ багасгах, улсын хэмжээнд нягтлан бодох бүртгэл хөтлөлт жигд тууштай болох, аж ахуйн нэгж байгууллагад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартыг нэвтрүүлэх зэрэг үр дагавар гардаг байна.

Энэхүү хууль нь 2001 онд батлагдсанаас хойш 2002.07.10, 2003.05.15, 2006.12.15 тус тус нэмэлт, өөрчлөлт орсон болно.

Өргөн баригдсан хуулийн төслийн танилцуулгад дараахь зүйлийг хуульд тусгахаар заасан.

- нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд;
- бүртгэл хөтлөх аккруэл суурь;
- дотоод хяналт /аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт, дотоод хянан шалгагчийн эрх, үүрэг/;
- аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хориглох зүйл;
- аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан

3.1.1.-т “нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь” гэж мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ. Мөн хуулийн 4.1-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлд баримтлах 6 зарчмыг зааж өгсөн.

Энэхүү хуулиар анхан шатны баримт бичиг, нягтлан бодох бүртгэл хөтлөх болон хөрөнгө өр төлбөрийг үнэлэх, бүртгэх үйл ажиллагааг зохицуулсанаас гадна аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан гаргах ажлын зохион байгуулалтыг нарийвчлан хуульчилан өгсөн.

Нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг хуульчилсанаас гадна нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын нэмэгдэл, урамшуулалыг тусгасан.

Энэхүү хуулийн хүрээнд:

- санхүүгийн тайлан гаргах хугацаа, хариуцлага
- улсын хэмжээгээр аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцлийн стандартыг тусгах
- бүх төрлийн компани, улсын үйлдвэрийн газарт заавал мэргэшсэн нягтлан бодогч байх
- бүртгэл хяналтын хөндлөнгийн байгууллага
- нягтлан бодогчийн эрх, үүрэг, эрх олгох зэрэг асуудлуудыг тусгаж өгчээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*__Дүгнэлт__*: Нягтлан бодох бүртгэлийн нийгмийн өмнө хүлээсэн нэг гол үүрэг нь санхүүгийн үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж байх явдал юм. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг өөрийн оны бүртгэлийн тогтолцоонд нэвтрүүлж, ингэснээр Олон Улсын байгууллага, гадаад улс орны эдийн засгийн нээлттэй байдлыг тухай мэдээллийн орчинг бүрдүүлэх боломж олгох юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд дараахь дүгнэлтийг гаргаж байна.

1/ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан нэр томъёо болон хуулийн үйлчлэх хүрээг тодорхой зааж өгөөгүй учраас гадаадын аж ахуйн нэгж, байгууллагууд нэгэн адил мөрдөх эсэх, төсвийн байгууллага, санхүүгийн бусад байгууллагууд энэхүү хуулийг

хэрхэн мөрдөх зэрэг асуудлыг бүрхэг тусгасан.

2/ Манайд болон бусад олон орнуудад санхүүгийн тайлан нь юуны өмнө олон улсын стандартад нийцсэн байх ёстой. Тиймээс IFRS/IAS нэвтрүүлэхийг хүсэж буй байгууллага нь 2 бүртгэл хийх шаардлагатай болж байна. Үүнд: Татварт зориулж өөрийн улсын хууль тогтоомжоор, хөрөнгө оруулалт татах болон дотооддоо ашиглах зорилгоор олон улсын стандартаар.

3/ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль нь 2001 онд батлагдан гарснаас хойш Улсын дээд шүүхээс ямар нэгэн тайлбар гаргаж байгаагүй хууль юм.

4/ Хэдийгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа холбогдох байгууллагад өгч харин холбогдох байгууллага нь татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийдэг хуулийн зохицуулалттай. Гэвч өнөөдрийн амьдрал дээр аж ахуйн нэгж, байгууллагууд татварын албанд болон харилцах санхүүгийн байгууллагад өөр өөр тайлан тушаадаг практик тогтоод байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд үүнийг тодорхой зааж өгсөн боловч энэ заалт нь хэрэгжихгүй байна. Энэ нь тэдгээр татварын байгууллага болон санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоо байхгүй, санхүүгийн тайлангийн нэгдсэн систем байхгүй байгаатай холбоотой юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Эдийн засгийн харилцааг зохицуулж буй бусад хуулиуд тэдгээрийн үзэл баримтлалын түүвэр**

*/Хуулиудын хувийн хэргээс авав/*

| № | Хуулийн нэр батлагдсан огноо | Хуулийн төсөл боловсруулах шаардлага | Зохицуулах харилцаа, хамрах хүрээ | Эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар болон хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байдал | Өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зарим асуудал | Батлагдсан хуульд тусгагдсан байдал |
|---|---|---|---|---|---|---|
| **1.** | **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль** /2006.07.08/ | МУ 2001.11.12-нд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай" ОУ-ын Конвенцид гарын үсэг зурсан бөгөөд улмаар 2004.12.18-ны өдөр УИХ-аас уг Конвецийг соёрхон баталсан. Энэхүү Конвенцид оролцогч гишүүн улс бүр терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар холбогдох арга хэмжээ авах чиглэлээр үүрэг хүлээхээр заасан байна. Мөн МУ-ын Ерөнхийлөгч "Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай" 2001 оны 60 дугаар зарлиг гаргасан бөгөөд түүнийг хэрэгжүүлэх зорилгоор МУ-ын Засгийн газраас 2001 онд "Терроризмын эсрэг олон улсын эвслийн үйл ажиллагааг дэмжих тухай" 226 дугаар тогтоолыг баталсан болно. | Хуулийн төслөөр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан байна. Хуулийн төслийн ерөнхий бүтэц нь 4 бүлэг, ойролцоогоор 25 зүйлтэйгээр өргөн баригдсан байна. | Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийг батлан гаргаснаар гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийг гүйлгээнд оруулан угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг урьдчилан сэргийлэх, илрүүлэх боломжтой болохоос гадна банк, санхүүгийн систем эрүүлжих нөхцөл бүрдэнэ гэж заасан байна.<br><br>Хууль батлагдсанаас хойш нэмэлт, өөрчлөлт оруулаагүй байна. | Энэхүү хуулийн төсөлд дараахь хэд хэдэн асуудлыг тусгасан байна.<br>1/ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэжигтэй гүйлгээ болон харилцагчийн талаархи мэдээллийг шалган тогтоох, холбогдох арга хэмжээний талаар хэрэгжүүлэх байгууллагын эрх үүргийн талаар хуульчлах<br>2/ Бэлэн мөнгөний гүйлгээний үнийн дүнгээс хамаарч гүйлгээг хянах, холбогдох байгууллагад мэдээлэхтэй холбогдуулан босго үнийг тогтоох<br>3/ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх | Хууль нь 4 бүлэг 21 зүйлтэйгээр батлагдсан болно.<br>1/ Хуулийн 4-р зүйлд дурьдсан санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий 8 байгууллага нь сэжигтэй гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд заавал мэдээлэх үүргийг хуульчлан өгсөн.<br>Мөн дээр нэр бүхий 8-аас гадна хуулийн этгээд, иргэн тодорхой гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзсэн, эсхүл 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлж болно.<br>2/ Тусгайлан хянах гүйлгээг хуулийн 6.1-т нэг бүрчлэн заасан бөгөөд сэжигтэй гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх журам, дансанд хяналт тавих, гүйлгээг түдгэлзүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт зэргийг хуульчлан өгсөн.<br>3/ Монголбанкны бүтцэд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай хууль тогтоомжийг биелүүлэх, хяналт тавих чиглэлээр Монгол банкны бүтцэд Санхүүгийн мэдээллийн албыг байгуулан ажиллуулах | Санхүүгийн мэдээллийн албыг байгуулах бөгөөд энэхүү албаны бүтэц, чиг үүргийг хуульчлан өгсөн. Мөн хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй зүйл нь Санхүүгийн мэдээллийн алба нь энэ хуульд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сантай байх, мэдээллийн санд мэдээлэл хадгалах, түүнийг ашиглах журмыг Монголбанкны Ерөнхийлөгч батална талаар хуулийн 18 дугаар зүйлд тусгасан байна. |
| **2.** | **Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль** /2000.05.12/ | 1993 онд батлагдсан "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай" хууль нь манай улсын хувьд монопольт зах зээлээс өрсөлдөөнт зах зээлийн харилцаанд шилжсэнийг хуульчилсан юм. Гэвч энэхүү хуулийг хэрэгжүүлэх тогтолцоог хэт задлаж, эрх, үүргийг олон байгууллагуудын дунд бүрхэгдүүлсэнээс хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй байсан болно. Үүнээс гадна аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналтын талаархи заалтууд нь пратикт хэрэгжүүлэхэд төдий л ойлгомж муутай байснаас гадна өрсөлдөөнт зах зээлийн нийгмийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс уг хуулийг шинэчлэн найруулах шаардлага гарсан. | Хуулийн төсөл нь 6 бүлэг 19 зүйлтэй бөгөөд энэхүү хуулийн төслөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх талаар эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна. | Зах зээлийн эдийн засгийн нийгэмд дэх аж ахуйн нэгж байгууллагын өрсөлдөөнийг хязгаарлах, өрсөлдөөнд харш үйл ажиллагаанд хяналт тавих, таслан зогсоох, монополь байдалтай этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоо боловсронгуй болно. Өрсөлдөөнийг хянан зохицуулах албыг Засгийн газрын тохируулагч агентлагийн статустай байхаар хуулийн төсөлд тусгасанаар байгууллагын эрх, үүрэг болон гүйцэтгэх ажлын чиглэл, удирдлагыг томилох, ажлаа тайлагнах хэлбэрүүд зэрэг хуульчилсан. | Энэ хуулийн төслөөр: 1/ Давамгай байдалтай аж ахуйн нэгж дангаараа болон бусад аж ахуйн нэгжтэй хамтран өрсөлдөөнт зах зээлд хориглох зүйлүүд 2/ Төрийн захиргааны байгууллага дангаараа болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхийг хориглох үйл ажиллагаануудыг тусгасан *3/* ААН-үүдийн өрсөлдөөнийг аль болох ихэсгэх үүнээс өрсөлдөөнд хамгийн их нөлөө үзүүлдэг хэвтээ буюу давамгай байдалтай өрсөлдөгч ААН-үүдийн нэгдэж, нийлэхийг шууд хориглоод бусад хэлбэрийг нь хянан | Хуулийн 6-р зүйлд Давамгай байдлаа шударга өрсөлдөөнд харшаар ашиглан, дангаараа үйл ажиллагаа явуулах 11 зүйлийг хориглосон байна. Мөн хамтдаа давамгай байдалтай өрсөлдөгч аж ахуйн нэгжүүд өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор шийдвэр, хэлцэл, тохиролцоо байгуулахыг хориглосон зурган тохиолдлыг хуулийн 7-р зүйлд тусгасан байна. Хуулийн үзэл баримтлалд тусгагдсан зүйлийг хуульд бүрэн тусгасанаас гадна энэхүү батлагдсан хуульд<br>- Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн өрсөлдөөнд харш хориглох үйл ажиллагааг хуульд нэг бүрчлэн зааж өгсөн.<br>- Зохиогч, патент эзэмшигч, шинжлэх ухаан, оюуны өмчийн талаархи |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ингэсэнээр аж ахуй эрхлэгчид зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөл бүрдэх, тэдний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, улмаар дэлхийн зах зээлд Монгол Улсын өрсөлдөх чадвар нэмэгдэх зэрэг үр дагавартай юм.<br>2002.7.4<br>2005.1.27<br>2008.12.19 –нд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон болно. | зохицуулах боломжтой байх.<br>*4/* Зүй ёсны монополь, ноёрхогч ААН-ийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээ, борлуулалтын үнийн өөрчлөлт, нөхцөл нь бүрэлдсэн тохиолдолд өрсөлдөөнд оруулах зэргийг хуулийн төсөлд тусгасан. | өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтыг хуулийн 10.1.7-т зааж өгсөн |
| **3.** | **Нягтлан бодох бүртгэлийн тухай** /2001.12.13/ | 1993 онд батлагдан мөрдөгдөж байсан Нягтлан бодох бүртгэлийн хууль нь Олон улсын стандарт жишигт нийцээгүй, нягтлан бодох бүртгэлийн ихэнхи харилцааг Засгийн газрын тогтоол, Сангийн яамнаас гаргасан эрх зүйн акт, заавар, журмаар зохицуулж ирсэн нь энэхүү хууль ерөнхий шинжтэй байсантай холбоотойгоор хуулийг шинэчлэн найруулах шаардлага гарсан. | Энэхүү хуулиар нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргахтай холбогдсон харилцааг зохицуулна. Хуулийн төслийн ерөнхий бүтэц нь 5 бүлэг, ойролцоогоор 24 зүйлтэйгээр өргөн баригдсан байна. | Бизнес эрхлэгчдэд Нягтлан бодох бүртгэлийн хуулийн ижил орчин бүрдүүлснээр аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн хувьд нэг ижил зарчмаар, зэрэгцүүлэх боломжтойгоор бэлтгэдэх, мэдээлэл хэрэглэгчдийн эрэлтийг хангах, олон улсын жишигт нийцэх зэрэг боломжийг бий болгоно. Төсвийн сахилга бат зөрчигдөн, өр авлагын сүлжээг багасгах, улсын хэмжээнд нягтлан бодох бүртгэл хөтлөлт жигд тууштай болох, аж ахуйн нэгж байгууллагад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын | Өргөн баригдсан хуулийн төслийн танилцуулгад дараахь зүйлийг хуульд тусгахаар заасан.<br>- нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд<br>- бүртгэл хөтлөх аккруэл суурь<br>- дотоод хяналт /аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт, дотоод хянан шалгагчийн эрх, үүрэг/<br>- аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хориглох зүйл | 3.1.1.-т “нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь” гэж мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ. Мөн хуулийн 4.1-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлд баримтлах 6 зарчмыг зааж өгсөн.<br><br>Энэхүү хуулиар анхан шатны баримт бичиг, нягтлан бодох бүртгэл хөтлөх болон хөрөнгө өр төлбөрийг үнэлэх, бүртгэх үйл ажиллагааг зохицуулсанаас гадна аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан гаргах ажлын зохион байгуулалтыг хуульчлан өгсөн.<br>Нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг хуульчилсанаас гадна нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын нэмэгдэл, урамшууллыг тусгасан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Стандартыг нэвтрүүлэх зэрэг үр дагавар гарна.<br>Энэхүү хууль нь 2001 онд батлагдсанаас хойш 2002.07.10, 2003.05.15, 2006.12.15 тус тус нэмэлт, өөрчлөлт орсон болно. | - аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан | |
| **4.** | **Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль** /2005.07.07/ | УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.6-д “Гэр бүлд зориулсан үл хөдлөх хөрөнгө, ялангуяа орон сууцны зээлийн тогтолцоог бүрдүүлнэ” гэж, мөн хөтөлбөрийн 3.2.6-д “Урт хугацааны зээл, ипотекийн аргыг нэвтрүүлэх замаар иргэдийг орон сууцаар хангах ажлыг эрчимжүүлнэ” гэж заасан байдаг.<br>Эдгээр эрх зүйн актуудад тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд ипотекийн анхдагч зах зээлийн тогтолцоог боловсронгуй болгох, ипотекийн хоёрдогч зах зээлийн тогтолцоог бий болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага бий болсон. | Энэхүү хуулийн төслөөр банк, банк бус санхүүгийн байгууллагатай зээл болон барьцааны гэрээ байгуулсан зээлдэгч гэрээний үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.<br>Харин банк, банк бус санхүүгийн байгууллагаас бусад этгээдтэй зээлийн барьцааны гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн гэрээний үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулсантай холбогдсон харилцааг зохицуулахгүй юм.<br>Энэхүү хуулийг 2009.07.09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон. | - Ипотекийн зүйл болох үл хөдлөх хөрөнгийг зардал багатайгаар, хямд өртгөөр худалдан борлуулах зохицуулалт бий болно.<br>- Банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлийн хэмжээ нэмэгдэнэ.<br>- Зээлийн зардал болон эрсдэл багасах тул үүнийг дагаад зээлийн хүү буурч, хугацаа уртасна.<br>- Иргэдийн орон сууцны санхүүжилтийг орон сууцны урт хугацаат зээлээр шийдсэнээр орон сууцны эрэлт нэмэгдэхийн зэрэгцээ орон сууцнаас шууд хамааралтай бусад дэд бүтэц хөгжинө.<br>- Иргэд их хэмжээний мөнгө хөрөнгө хуримтлуулалгүйгээр орон сууц худалдан | Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа нь зээлдэгчид зээл болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх шаардлага гардуулах, ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар борлуулах тухай хүсэлт гаргах, уг хүсэлтийг шийдвэрлэж шүүхийн бус журмаар худалдан борлуулах зөвшөөрөл олгох, ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахдаа дуудлага худалдааны журмаар явуулах, дуудлага худалдааны онцлог, ипотекийн зүйлийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх зэрэг хэд хэдэн үе шаттай байхаар хуулийн төсөлд тусгасан.<br>Мөн хуулийн төслийн нэг онцлог нь тодорхой үндэслэлээр өөрийн хууль ёсны эрх ашгийг | 2009.07.09-ний өдрийн Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль батлагдсанаар хүчингүй болсон. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | авах боломж нээгдэнэ.<br>- Ипотекийн анхдагч зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлээр баталгаажсан үнэт цаасны зах зээл буюу ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ. | хамгаалахаар шүүхэд нэхэмжлэл гаргах зээлдэгчийн эрхийг нээлттэй байлгах явдал юм. | |
| 5. | **Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хууль** /1999.01.22/ | УИХ-аас 1998.01.15-ны өдөр Казиногийн тухай хуулийг батлан гаргаж, МУ-ын нутаг дэвсгэр дээр казиногийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн болно. Гэвч энэхүү хуулийг батлан гаргахдаа асуудалд нухацтай хандаагүй, МУ-ын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа явуулсанаас нийгэмд үүсэх сөрөг нөлөөлөлийг тооцоогүй, казиногийн үйл ажиллагаа явуулахад тодорхой хязгаарлалтуудыг тогтоогоогүй, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг үр дагаварыг тооцоогүй зэргийг харгалзан хуулийн төслийг боловсруулан гаргасан. | МУ-ын нутаг дэвсгэр дээр казино байгуулах, казиногийн үйл ажиллагаа явуулахыг хориглохоор зохицуулсан. | МУ-д казиногийн үйл ажиллагаа явуулсанаар хар тамхины наймаа, рэкет /сүрдүүлэн заналхийлж мөнгө нэхэх/, порно бизнес, зэвсгийн наймаа, бохир мөнгө угаах зэрэг нийгмийн сөрөг байдаг үүсэх нөхцлийг бүрдүүлэх боломжтой юм. Энэ нь эдийн засгийн эрүүл бус тогтолцоог бий болгож, гадаадын хөрөнгө оруулагчдыг холтгох болзошгүйгээс гадна улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөөлж болзошгүй юм. Хууль батлагдсан өдрөөсөө хойш нэмэлт, өөрчлөлт ороогүй болно. | 1998 онд Казиногийн тухай хууль батлагдаж, МУ-д казиногийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн болно. Энэхүү хуулийг УИХ-аас батлан гаргахдаа нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тооцоогүйгээс улс орны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Иймд энэхүү хуулийн төслөөр МУ-ын нутаг дэвсгэр дээр Казиногийн үйл ажиллагаа явуулахыг хориглохоор тусгагдсан болно. | Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт казино байгуулах, ажиллуулахыг хориглохоор заасан болно. |
| 6. | **Улсын нөөцийн тухай** /2007.07.05/ | Хуулийн төсөл боловсруулах дараахь шаардлага байсан болно.<br>1/ МУ-ын хууль тогтомжийг | Энэ хуулийн төслөөр улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, | Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, | Азийн хөгжлийн банкнаас санал болгосон Монгол Улсад зайлшгүй гаргах хуулийн | 3.1.1.“улсын нөөц” гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Улсын нөөцийн тухай хуулийн төсөл боловсруулахыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүний хүрээнд зохион байгуулахыг даалгасан.<br>2/ Монгол Улсын УАБЗ-ийн 1999 оны №9 зөвлөмжөөр хуулийн төсөл боловсруулахыг тухайн үедээ ХААҮ-ийн сайдад даалгасан.<br>3/ УИХ-ын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн Байнгын Хорооны 1999 оны 01 тоот тогтоолоор Улсын нөөцийн тухай хуулийн төслийг боловсруулахыг тухайн үедээ Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яаманд даалгасан.<br>4/ Гамшгаас хамгаалах тухай" хуульд гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгахад зориулагдсан улс, аймаг, нийслэл болон бүх шатны гамшгаас хамгаалах алба, аврах анги, отряд, салбар, нэгж, мэргэжлийн ангид нөөц байхаар тусгагдсан. | захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Хуулийн төсөл нь 4 бүлэг, 19 зүйл бүхий бүтэцтэй байх бөгөөд хуулийн төслийн хүрээнд Улсын нөөц, түүний бүтэц, нөөцийн бараа материалыг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх зэрэг зохицуулалт болон улсын нөөцийн санхүүжилтийг тусгасан болно.<br>Мөн улсын нөөцийн талаархи УИХ, Засгийн газрын гишүүн, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны улсын нөөцийн салбарт хэрэгжүүлэх бүрэн эрх болон улсын нөөцийн салбарын хүлээх үүргийг тусгасан болно. | захиран зарцуулахтай холбогдсон харилцаа бүрэн зохицуулагдаж, улсын нөөцийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн хор уршгийг шуурхай арилгах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үндэсний аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой болно.<br>Мөн орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулахтай холбогдсон харилцаа хуулийн зохицуулалттай болно. Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдож хөрөнгө санхүүгийн хувьд нэмэгдэл зардал гарахгүй.<br>Энэхүү хуулийн төсөл нь батлагдсанаас хойш нэмэлт, өөрчлөлт ороогүй болно. | жагсаалтанд Улсын нөөцийн тухай хуулийг тусгасан, хуулийн төсөл боловсруулах хууль зүйн шаардлага зэргийг харгалзан хуулийн төслийг гаргасан.<br><u>Улсын нөөц нь</u><br>- стратегийн,<br>- гамшгийн<br>- орон нутгийн нөөцөөс бүрдэхээр тусгасан.<br>Тэрчлэн нөөцийн бараа, материалыг хадгалах, шинэчлэх, сэлгэх гэдгийг тодорхойлж, нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, нөөцийн бараа, материалын зориулалт, зарцуулах нөхцөл, санхүүжилттэй холбоотой асуудлыг тусган байна. | гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед энэ хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу ашиглахаар нөөцлөн хадгалж буй бараа, материалыг хэлнэ гэж хуульчилсан байна.<br><u>Улсын нөөцийг энэхүү хуульд</u><br>- стратегийн нөөц<br>- цэргийн дайчилгааны нөөц<br>- гамшгийн нөөц<br>-орон нутгийн гэж ангилан тодорхойлсон бөгөөд энэхүү хуулиар нөөцийн бараа, материалын зориулалт, нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах нөхцөл, нөөцийн бараа, материалын чанар, аюулгүй байдалд тавих хяналт зэргийг хуульчилсанаас гадна нөөцийн бараа, материалын талаар авах төрийн захиргааны байгууллагын эрх, хүлээх үүрэг болон нөөцийн бараа, материалын гэрээт хадгалагчийн хүлээх эд хөрөнгийн хариуцлагийн талаар тодорхойлсон байна. |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ЧИГЛЭСЭН ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН САНАЛ ЗӨВЛӨМЖ

/Бодлогын судалгаа/

*Д.Мягмарцэрэн*

## ОРШИЛ

Судалгааг Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газрын тайлан, Үндэсний Аудитын Газрын тайлан, Авилгатай Тэмцэх Газрын тайлан, Нээлттэй Нийгэм Форумын судлаач О.Мөнхбат болон бусад судлаачдын хийсэн суурь судалгаанууд дээр үндэслэн боловсруулав.

Судалгаанд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох талаар эдгээр эх сурвалжуудад тусгагдсан дүгнэлт, бодлогын санал зөвлөмж зэргийг нэгтгэн товч байдлаар харуулахыг зорьсон. Ингэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа буюу товчоор, тендер шалгаруулалтын онолын түвшний ойлголт болон өнөөдөр манай улсад тулгамдаж буй асуудлууд, үүнийг шийдвэрлэх ямар арга замууд байгаа тухай бодлогын санал зөвлөмжүүд гаргасныг нэгтгэн харуулсан.

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ

Товчхондоо, худалдан авагчийн шаардсан нөхцөл болзлыг хүлээн зөвшөөрч, нийлүүлэгчээс хариу болгосон санал буюу төрийн байгууллагуудын худалдан авахыг хүссэн бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэхээр бизнес эрхлэгчдийн тэдэнд ирүүлж буй саналыг тендер гэж нэрлэдэг. Эдгээр саналуудыг өрсөлдүүлэх ажиллагаа нь “тендер шалгаруулалт” юм. Худалдан авагч тавьсан шаардлагад нь нийцсэн, эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай байх үнэ буюу “үнэ цэнэ”-ийг санал болгосон нийлүүлэгчийг сонгон гэрээ байгуулдаг.

Тендер болон ердийн зах зээл хоёрын гол ялгаа нь үнэ тогтох зарчимд суурилдаг. Хэрэв зах зээлд үнэ эрэлт, нийлүүлэлтээр тогтоогдож байвал тэр нь эдийн засгийн онолын хувьд бол “өгсөн авсан өлзийтэй, шударга үнэ“ гэсэн үг. Харин тендер бол тендерийн орчноос буюу тендерийг явуулах загвараас болон оролцогч талуудын тухайн барааг үнэлэх үнэлэмж, тус бүрийнх нь мэдээлэл, оролцогчдийн төлөв байдлаар тодорхойлогдоно.

Өөрөөр хэлбэл, барааг эзэмшигч буюу тендер зарлагч тухайн хувьд ямар загвар хэрэглэвэл хамгийн зөв буюу барааг нь хамгийн их үнэд хүргэх бол гэсэн асуулт тулгарна. Оролцогч талуудын хувьд бол аль хэр үнэ амлахаа шийдэх хэрэгтэй болно. Харин тендер явуулах загварын хувьд нэлээд өргөн хэрэглэгддэг дөрвөн өөр боломжийн загвар байдаг.

- -Англи маягийн буюу ил нэмэгдэх тендер,
- -Голланд маягийн буюу ил хасагдах тендер,
- -Эхний үнийн нөөц тендер,
- -Хоёр дахь үнийн нөөц тендер.

*Англи маягийн тендерт* зарлагдсан эхний үнээс эхлээд талууд үнийг ил байдлаар ихэсгэдэг. Үнэ ихэсгэх явц оролцогчдоос сүүлийн нэг оролцогч үлдэх хүртэл үргэлжилдэг бөгөөд хамгийн сүүлд үлдсэн оролцогч бүтээгдэхүүний эзэн болно. Голланд

UIH.MN СОЦИАЛ АЛХЫ САН

маягийнх нь үүний эсрэг нь. Эхний үнэ нэлээд өндөр зарлагдана. Тэгээд үнэ алхам алхмаар буурна. Хамгийн түрүүнд авъя гэж хэлсэн оролцогч тал тухайн үнээ төлөөд барааны шинэ эзэн болно. Харин эхний үнийн нууц тендерт болохоор талууд амлах үнээ нууцаар мэдэгдэнэ. Хэн өндөр үнэ амласан байна, тэр тал нь амласан үнээ төлөөд эзэн болно. Хоёр дахь үнийн нууц тендер гэхээрээ талуудын амлах үнэ бас л нууц. Эхний үнийн нууц тендерийн нэгэн адил хамгийн өндөр үнэ амласан тал эзэн болох боловч энэ удаад өөрийн амласан үнийг биш, хоёр дахь өндөр үнийг төлнө.

Тендерт оролцогч талуудын хувьд голланд тендер болон эхний үнийн нууц тендер хоёр ер нь бол бүх талаараа адилхан. Өөрөөр хэлбэл, оролцогч талуудын мөрдвөл зохих стратегууд энэ хоёр загварт адилхан байдаг гэсэн үг. Харин Англи тендер болон хоёр дахь үнийн тендер ихэнх тохиолдолд адилхан байдаг боловч зарим үед өрсөлдөгч талууд энэ хоёр тендерт оролцохдоо өөр өөр стратеги мөрдөх хэрэгтэй болдог.

Тийм болохоор, тендер зохиогчийн хувьд ер нь бол Англи тендер, Голланд тендер, аль эсвэл хоёр дахь үнийн нууц тендер гэсэн загваруудын аль нэгийг нь сонгох хэрэгтэй болж байна. Англи тендер болон хоёр дахь үнийн нууц тендер хоёрын гол давуу тал нь тендерт оролцогч талууд зөв стратеги мөрдсөн нөхцөлд, тухайн барааг хамгийн ихээр үнэлж байгаа тэр тал нь ялагч болох магадлал хамгийн өндөртэй тал байдагт оршдог. Харин энэ хоёр загварын гол дутагдалтай тал нь зарим тохиолдолд тендерт тогтсон үнэ нэлээд бага байх боломжийг бий болгодогт байгаа юм. Жишээ нь, тендерт оролцогч талууд бараа бүтээгдэхүүнийг үнэлэх хувийн үнэлэмжийн хувьд болон бэл бэнчингийн хувьд том ялгаатай байх үед, тендерт тогтсон үнэ талуудын үнэлгээнүүдийн хамгийн багатай нь, аль эсвэл төлөх чадваруудын аль доодтой нь ойролцоо байдлаар тогтох магадлал тун өндөр байдаг. Түүнээс гадна иймэрхүү тохиолдолд, хүчтэй оролцогчтой гэдгээ мэдсэн харьцангуй хүч султай оролцогчид нэгэнт ялах боломж муутай гэж бодсоны үүднээс тендерт оролцохоос татгалзах явдал бас гарч мэднэ. Мэдээж цөөхөн оролцогчидтой байх нь тендер зарлагчдын хувьд муугаар нөлөөлдөг.

Голланд маягийн тендер болон нэг дэх үнийн хаалттай тендер англи тендерээс нэлээд хэдэн давуу талтай. Судалгаанаас үзэхэд энэ тендер ихэнх тохиолдолд илүү олон оролцогчтой байдаг. Гэхдээ энэ загварт дутагдалтай тал бас бий. Гол нь энэ загварын тендерт оролцогч талууд бүгд стратеги хэрэглэсэн ч гэсэн ялагч нь тухайн барааг хамгийн их үнэлж байгаа тал байх болно гэсэн баталгаа тун бага байдаг учир гарсан үр дүн нь зарим талын хувьд харамсалтай байх боломж өндөр.

Их Британийн Засгийн газрын 2000 онд тун амжилттай явуулсан тендерийн тухай жишээ дурьдахад, Засгийн газарт зөвлөхөөр ажилласан багийнхан санал болгосон загвартаа, аль аль загваруудын давуу талуудыг нь ашиглахын хажуугаар муу нөлөөг нь бууруулахыг хичээж "Их Британи-Голланд" буюу холимог загвар гаргажээ.

Хүйтэн дайны үед Засгийн газрын мэдэлд байсан радио спектрум ашиглах эрх энэ холимог загварын дагуу явуулсан тендерт зарагдсан бөгөөд, тухайн тендерт оролцогч талуудын дунд эхний шатанд англи маягийн буюу ил үнэ өсгөх тендер явагдаж, үнэ хоёр оролцогчоос бусад бүх оролцогч хасагдах хэмжээний өндөр болсны дараа хоёр дахь шат эхэлсэн байна. Хоёр дахь шатанд, эхний шатнаас үлдсэн хоёр оролцогч талуудын санал болгох үнэ нь эхний шатанд тогтсон үнээс доош байж болохгүй гэсэн дүрэм бас мөрдөгдсөн байна.

Энэ жишээнээс харахад, туршлагатай оролцогчдоос бүрдсэн багийн зохиосон холимог тендерийн загвар нэлээд амжилтад хүрсэн гэдэг нь илт байгаа боловч холимог загварыг Их Британийн дараа хэд хэдэн Европын орнуудад бас хэрэглэсэн бөгөөд энэ загвар тэр бүр онцгой амжилттай байгаагүй байна. Зөвлөх багийн гишүүн, Оксфордын Их

сургуулийн профессор Паул Клэмпепер “Бүх төрлийн тендерт тохирсон тийм ганцхан сайн загвар гэж байдаггүй. Тийм болохоор тодорхой орчинд амжилтанд хүрсэн загвар өөр орчинд бас адилхан амжилт үзүүлнэ гэж итгэх нь буруу хэрэг болно“ гэж дүгнэжээ*.

Тэгвэл ийм асуудлууд байсаар байтал төрийн байгууллагууд яагаад тендер шалгаруулалтаар нийлүүлэгчээ сонгох шаардлагатай вэ гэдэг асуултад хариулахын тулд хувь хүн болон хувийн байгууллагуудын худалдан авалт ба төрийн байгууллагуудын худалдан авалт нь хоорондоо хэр ялгаатай болохыг тодорхойлъё.

Хувийн байгууллагуудын хувьд эрхэлж буй үйл ажиллагаанаасаа ашиг орлого олох нь үндсэн зорилго нь байдаг бөгөөд тэд хэрэгцээтэй байгаа зүйлсээ худалдан авахдаа үр ашигтай байх талаас нь байнга анхаарч, сонголтоо маш нямбай хийдэг. Өөрөөр хэлбэл, хэрэгцээт зүйлээ өөрийнхөө мөнгөөр өөртөө худалдан авч буй болохоор тэд хамгийн сайн үнэ цэнийг олохын төлөө зорьдог. Нөгөө талаас хэрэв үр ашиггүй худалдан авалт хийсэн бол хувийн байгууллагуудад нөлөөлөл нь шууд буюу хүлээгдэж байсан ашиг нь буурах, тухайн худалдан авалтыг хийсэн ажилтантай удирдлага нь хариуцлага тооцох зэргээр илэрч байдаг.

Харин төрийн байгууллагуудын худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээний эцсийн хэрэглэгч нь яг үнэндээ тухайн байгууллага нь өөрөө бус “ард түмэн” байдаг. Тиймээс хувийн хэвшлийн байгууллагуудын худалдан авалтаас өөр, бүр эсрэгээр байх магадлал өндөр. Үр ашигтай, хэмнэлттэй худалдан авалт хийхэд нь хангалттай хөшүүрэг тэдэнд байдаггүй. Иймээс энэхүү эргэлзээтэй, тодорхой бус, зөрчилтэй байдлыг арилгахын тулд тухайн харилцааг зохицуулсан эрхзүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай болдог.

***ТЕНДЕР* ШАЛГАРУУЛАЛТЫН *ЭРХ ЗҮЙН ОРЧИН***

Монгол улс 2000 оноос хойш төрийн байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохицуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨХБАҮХАТХ), тендерийн жишиг баримт бичгүүдийг хэрэглэж байгаа бөгөөд эдгээр нь тендер шалгаруулалтанд ирүүлсэн саналуудаас “хамгийн сайн” гэж үнэлэгдэх үнэ цэнэ бүхий саналыг сонгон гэрээ байгуулснаар тухайн хүссэн зүйлээ үр ашигтай, хэмнэлттэй худалдан авахад чиглэгдсэн байдаг.

Засгийн газар, төрийн байгууллагууд нь тухайн жилд батлагдсан төсөв, өөрийн хөрөнгө, олон улсын зээл тусламж зэрэг эх үүсвэрээр богино болон дунд хугацааны зарцуулалт, хөрөнгө оруулалтыг хийхдээ тендерт оролцогчдыг өрсөлдөх тэгш боломжоор хангаң, хамгийн сайн, нийгэм, эдийн засгийн хувьд үр ашиг, хэмнэлт бүхий санал ирүүлсэн нийлүүлэгч, гүйцэтгэгч нарыг сонгон гэрээгээ амжилттай хэрэгжүүлснээр эцсийн хэрэглэгч болох ард түмэндээ тустай. Тиймээс ч энэ нь олон улсын хэмжээнд Засгийн газрын хэрэгжүүлдэг үндсэн дөрвөн ажиллагааны тэргүүлэх зэргийн ач холбогдолтойд тооцогддог билээ. Ядуурлыг бууруулах, хувийн секторoo дэмжин хөгжүүлэх Төрийн бодлого, цаашилбал Мянганы хөгжлийн зорилт зэрэг олон асуудлыг нэгэн зэрэг шийдвэрлэх “боломж”-ийг олгож байдгаараа Засгийн газрын худалдан авах ажиллагаа нь тухайн улс орны хөгжилд маш том үүрэг гүйцэтгэж байдаг юм.

Иймээс төрийн үйлчилгээний энэ онцгой салбарыг авилгал, хээл хахууль зэрэг гаж, сөрөг хүчин зүйлсээс хамгаалах арга замуудын нэг бол шударга, ил тод, нээлттэй, хариуцлага тооцох механизмтай, олон нийтийн оролцоог дэмжин тэтгэсэн тогтолцоо, түүний бодит орчинг бүрдүүлэх явдал юм.

---

[*] *Стокголмийн Эдийн засгийн сургуулийн докторант Нинжбатын Ууганбаатар.Тендерийн онол буюу тендер зохиох ухаан., ММJ. 2009.Feb*



UILI.MN СУДАЛГААНЫ САН

*Тендер шалгаруулалтын ил тод байдлыг эрхзүйн орчны хүрээнд авч үзэхэд:*

- Худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин нь мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх эрмэлзлэл бүхий иргэний нийгмийн үзэл санааг удирдлага болгоогүй, зөвхөн тендерийг явуулах техник горим журмыг хуульчилсан зохицуулалтын шинжтэй тул ил тод, нээлттэй байдлыг хөгжин дэвжихэд үр өгөөжтэй байж чадахгүй байна.

- Худалдан авах ажиллагааны талаархи мэдээллийн хүртээмжит байдлыг дан ганц тендерийн урилга тараах хүрээнд ойлгох нь төлөвлөх, шалгаруулах, хянах, үнэлэх зэрэг эл ажиллагааны дийлэнх гол үе шатуудыг олны хараа хяналтаас ангид байлгах нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

- Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг тараах хэлбэрүүд нь оновчтой бус, хариуцсан албан тушаалтан тодорхойгүй, зориулалтын хэвлэмэл эх сурвалж байдаггүй, вэб хуудасны ашиглалт муу зэрэг нь мэдээллийн хүртээмжтэй байдлыг хязгаарлаж байна.

- Худалдан авах ажиллагаанд иргэдийн оролцох оролцоо нь эрх зүйн баталгаа, нэгэн мөр заасан зохицуулалт байхгүй зэргээс үүдсэн обьектив шалтгаан хийгээд иргэдийн өөрсдийн идэвхи зүтгэл гэх мэт субьектив хүчин зүйлсээс үүдэн маш доогуур түвшинд байна.

- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх тухайд төр, түүний албан тушаалтнууд хойрго ханддаг нь худалдан авах ажиллагааны орон зайд иргэд олон нийтийн төлөөлөл болох иргэний нийгэм, ТББ-уудыг тоглох боломжийг хязгаарлаж байна*.

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*(2008 оны тайланд тусгагдснаар)*

Засгийн газрын хөрөнгө оруулалтыг дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувийн жингээр нь авч үзвэл 2001 онд 22.9 хувь байснаа 2005 он хүртэл буурч, 2006 оноос 4.1-6.9 хувь хүртэл өсч, 2008 онд ДНБ-ний 15.6 хувийг эзэлж байна. Сүүлийн 4 жилд хөрөнгө оруулалтын санхүүжилт 8,7 дахин, шинээр болон шилжих обьектын тоо 7,2 дахин өссөн дүн мэдээтэй байна.

Гэвч аудитаар ихээхэн хэмжээний зөрчил дутагдал илэрсэн байна. Үүнд,

*<u>Нэг. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогогүйгээс төлөвлөлт үндэслэл муутай хийгдэж, тодотголоор нэмэгдсэн зарим төсөл, арга хэмжээний тооцоо, баримт алга байна.</u>*

Улс, орон нутаг, салбарын уялдаа холбоо бүхий хөрөнгө оруулалтын бодлого, хэтийн төлөвлөгөө, хөтөлбөргүйгээс хөрөнгө оруулалтын жилийн төлөвлөгөө үндэслэл муутай зохиогдож, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зөвхөн улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн (МУХС)-ийн хөрөнгө батлагдаж, харин зээл, тусламж, өөрийн хөрөнгийн эх үүсвэрүүд бүрэн тусгагдахгүй байна. Яамдын 46 хувь нь салбарын хөрөнгө оруулалтын дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулсан, 54 хувь нь батлуулаагүй байна. ХЗДХЯ, ЭМЯ, НХХЯ, БСШУЯ, СЯ, ГХЯ хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиггүй байна.

Хөрөнгө оруулалтын талаархи орон нутгийн ба салбарын бодлогын уялдаа хангалтгүйгээс инженерийн шугам сүлжээ, автозамыг өргөтгөх, шинэчлэх, хот байгуулалт, эрчим хүч, боловсрол, эрүүл мэндийн зэрэг асуудал цогц байдлаар шийдэгдэхгүй, төсвийн

* Нээлттэй Нийгэм Форумын судлаач О.Мөнхбат (Ph.D). "Төрийн худалдан авах ажиллагааны ил тод байдал" илтгэл



UIH.MN СУДАЛГААНЫ САН

ерөнхийлөн захирагчид (ТЕЗ)-ын эрхлэх асуудлын чиглэлээр салангид хэрэгжиж байна.

Өөрөөр хэлбэл, Сангийн яамны тооцоолсон санхүүгийн эх үүсвэрийг салбар бүрт хүртээх зарчмаар хуваарилж, ТЕЗ нар түүнд нь таарсан төсөл, арга хэмжээ төлөвлөн батлуулж иржээ.

Үүнээс гадна ТЭЗҮ болон хайгуул, зураг төслийн ажил бүрэн хийгдээгүй, инженерийн шугам сүлжээ, хангамжийн асуудал нь шийдэгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулж байгаагаас хугацаандаа хийгдэхгүй сунжрах, нэмэлт хөрөнгө шаардлагатай болох, халаалт, цахилгаан, цэвэр бохир ус, дэд бүтэцгүй барилга баригдах, улмаар төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах явдал тохиолдож байна.

Ихээхэн хөрөнгө шаарддаг дэд бүтцийн салбарын зарим барилга байгууламжийг хүчин чадал, ТЭЗҮ, зураг төсвийг харгалзалгүй төлөвлөснөөс 36,7 тэрбум төгрөгийн ажлын ашиглалт хангалтгүй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2008 онд санхүүжүүлсэн эрчим хүчний 40.0 гаруй тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 25 сумын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын барилгын ажил эрчим хүчний эх үүсвэргүй Тайширын УЦС ашиглалтад ороогүй гэсэн шалтгаанаар хүлээгдэж байна.

Сонгуулийн өнөөгийн тогтолцоо ч хөрөнгө оруулалтын бодлогод сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, 2008 онд Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг УИХ-аар хэлэлцүүлэн батлах явцад УИХ-ын гишүүдийн зүгээс зураг, төсөлгүй 15.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 100 объектод 12.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор нэмж батлуулжээ.

Зарим төсөл арга хэмжээг олон жижиг хэсэг болгон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь хөрөнгө тарамдах, үр дүн буурах нөхцөл бүрдүүлж байна. Тухайлбал, инженерийн байгууламж, гүүр, авто замын гэмтэлтэй хэсгийг хэсэгчлэн солих бус нөхөх хэлбэрээр засварлах, Агропарк байгуулах зорилгоор бүх суманд хөрөнгө жигд хуваарилах, 21 аймагт булаг ус хамгаалах зорилгоор нэг булагт 1,5 сая төгрөг тооцож төлөвлөх, сургууль, эмнэлгийн барилгыг капиталжуулах байдлаар бус хана, шал, дээвэр будах төдийхнөөр хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна.

Эрчим хүчний салбарт он дамжин хэрэгжиж байгаа 2.2 тэрбум төгрөгийн ажлыг тодотгосон төсөвт оруулж баталсан боловч санхүүжүүлээгүй нь төсвийн тодотголд оруулах шаардлагагүй байсныг харуулж байна.

Барилга, байгууламж шинээр эхлүүлэхээр төсвийн тодотголд оруулж батлуулахгүй байх нь зүйтэй байна. 2008 оны 4 дүгээр улиралд хийгдсэн төсвийн тодотголоор нэмж батлагдсан БСШУ-ны сайдын багцын 28, БХС-ын 3, ЗГХЭГ-ын 1 барилга обьектуудын ихэнх нь он дамжин хэрэгжжээ.

*Хоёр. Худалдан авах ажиллагааны бэлтгэл үе шатны ажлыг бүрэн хийгээгүй, тендерийн урилга, түүний үр дүнг цахим хуудаст нийтлэх ажил хангалтгүй байна.*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Тендер зарлах хугацааг оройтуулснаас зарим худалдан авах ажиллагаа зарлагдаж амжихгүй, он дамжин сунжрах, тендер шалгаруулах журмыг өөрчлөн зарлах зэрэг тохиолдол гарсан байна.

Тухайлбал, 48 сум, суурин газрыг цахилгаан эрчим хүчээр хангах 7 төсөл арга хэмжээний тендер хугацаа оройтсоноос зарлагдаагүй, замын сангийн хөрөнгөөр авч хэрэгжүүлэх 2 тендер ажлын зураггүй болон тоо хэмжээг дахин нягтлан шалгах шаардлагын улмаас хүчингүй болсон, 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсөвгүй батлагдсан 216 барилга байгууламжийн ажлын зураг төсвийг дахин боловсруулснаас тендер шалгаруулалт хагас жилээр хойшлогдсон бөгөөд нийслэлд 203

ажил 5 дугаар сараас хойш зарлагдсан байна.

БХЯ, УЕПГ, АТГ, УДШ, ЦЭК, УМХЕГ бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Хуульд заасны дагуу тухайн жилийн эхний сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй байна.

Хуулийн дагуу захиалагч цахим хуудаст тендерийн урилгыг нийтэлж, шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлж байх ёстой боловч энэ нь бүрэн хэрэгжихгүй байна. 2008 онд 778 тендер шалгаруулалтын урилга, үр дүн нийтлэгдэх ёстой байснаас захиалагч байгууллагууд 414 тендер шалгаруулалтын урилгыг нийтэлж, эдгээрээс тендер шалгаруулалтын 181 үр дүнг цахим хуудаст мэдээлсэн байна. Цахим хуудаст тендерийн урилга, үр дүнг нийтэлбэл зохих нийт 46 ТЕЗ-даас 14 нь тендерийн урилгаа, 35 нь үр дүнгээ огт нийтлээгүй байгаагаас үзвэл тендерийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод, тэгш өрсөлдөх зарчмаар явагдахгүй байгааг анхаарах хэрэгтэй болжээ.

*Гурав. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах аргыг буруу сонгож, шууд гэрээ байгуулдаг, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна.*

ТЕЗ-дын худалдан авах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байдлыг авч үзэхэд хуулиар тогтоосон босго үнээс дээш төсөвт өртөгтэй буюу нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар хэрэгжүүлэх шаардлагатай байсан худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулан худалдан авсан зөрчил илэрч байна.

Тухайлбал, 2008 оны нийт худалдан авалтын 22.0 хувьд шууд гэрээ байгуулах аргыг ашигласан бөгөөд ХХААХҮЯ, БОЯ, НХХЯ, ТЕГ, ОБЕГ, БХЯ, УЕПГ, ГИХАЭГ, Ховд аймгийн Шүүх, Орхон аймгийн Прокурор зэрэг байгууллагууд гүйцэтгэгч сонгон шалгаруулах аргыг буруу сонгожээ.

Худалдан авах ажиллагааны Үнэлгээний хороог мэргэжлийн сургалтад хамрагдсан, мэргэшсэн хүмүүсээр бүрдүүлж чадаагүй, хөрөнгө оруулалтын гэрээг хэт ерөнхий хийж байгаагаас гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нартай хариуцлага тооцох боломжгүй байна.

ТЕЗ бүр гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг Сангийн яаманд хүргүүлж, эргэн хянаж, нэгтгэн дүгнэж чадахгүй байна. Гэрээ байгуулсан байдал, түүний хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, дүгнэлт хийх ажил хангалтгүй байгаагаас гэрээний хэрэгжилт жигд биш байна.

2008 онд төсвийн ерөнхийлөн захирагчдын зүгээс гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний биелэлтийг тооцож үзэхэд 5.7 тэрбум төгрөгийн ажил огт хийгдээгүй бөгөөд 6.7 тэрбум төгрөгийн дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон, зарцуулагдаагүй үлдэгдлийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Дээрх байдал нь хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, техникийн болон улсын комисс хариуцлагагүй ажилласныг харуулж байна.

ТЕЗ-дын төсвийн багцаас орон нутагт эрх шилжүүлэн хуваарилсан хөрөнгө оруулалтын үр дүнд аймаг, орон нутаг болон ашиглагчаас тавих хяналт бараг алга байна.

Тендерт оролцож байгаа компаниудын мэдээллийн сан бий болгож, өмнө нь үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчийн жагсаалт гарган дараагийн тендерт оролцох эрхийг хасах, хариуцлага тооцох ажил хангалтгүй хийгдэж байна. Гэрээний гүйцэтгэл хангалтгүй байгаа зөрчил жил бүр давтагдаж байгаа боловч өнөөг хүртэл ганц ч гүйцэтгэгч "найдваргүй" жагсаалтад бүртгэгдээгүй байна.

UILMN СУДАЛГААНЫ САН

*Дөрөв. Тендер шалгаруулалтын баримт материал бүрэн бус байна.*

Захиалагчид төсвийн тухай хуульд тусгагдсан төсөл, арга хэмжээ бүрээр мэдээлэл гаргах, цахим хуудаст тендерийн урилга, үр дүнг нийтлэх, холбогдох баримт материалын хавтаст хэргийг бүрэн бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах ажил хангалтгүй байна.

Нийт худалдан авах ажиллагааны 60 орчим хувьд архивын баримт бүрдсэн, бусад нь үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга, гишүүдэд хадгалагдаж байна. Түүнчлэн зарим гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан баримт материал архивт байхад гэрээний хэрэгжилт, улсын комисс хүлээн авсан баримт алга байх жишээтэй байна.

*Тав. Хяналтын үр нөлөөтэй тогтолцоо дутагдаж байна.*

Захиалагчийн зүгээс гүйцэтгэгчид тавих хяналт, Сангийн Яамны хөрөнгө оруулалтын хэлтсээс захиалагч, гүйцэтгэгчид тавих хяналт, МХЕГ-ын хяналт нь хоорондоо уялдаагүй, үр дүн муутай байна.

Сангийн Яам, Төрийн санд ТЕЗ бүрээр санхүүжилтийн эрх нээлтийг нэгтгэн бүртгэх программ, нэгдсэн судалгаа байхгүйгээс эрх нээсэн дүнг санхүүжүүлсэн дүнтэй сар сараар тулган баталгаажуулах боломжгүй байна.

Сангийн Яамны газар, хэлтэс, аймаг, нийслэлийн Төрийн сангийн газар, ТЕЗ-дын холбогдох ажилтнуудын ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс хөрөнгө оруулалтын санхүүжилт удаашрах, баримт материал, судалгаа олдохгүй байх, тайлан мэдээ алдаа, зөрүүтэй гарах дутагдал илэрч байна.

2008 онд улсын төсөв, МУХС болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 11.6 хувь буюу 53,9 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлд тусгагдаагүй буюу өөрөөр хэлбэл хариуцах эзэнгүй байна.

"Атрын III аян", "Ногоон хувьсгал" зэрэг хөтөлбөрийн хүрээнд хувийн хэвшлийн газар тариалан, хүнсний ногооны аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалтаар 46,5 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмж олгогдож, тухайн аж ахуйн нэгжийн данс бүртгэлд тусгагдсан байна. Хувийн хэвшилд бүртгэгдсэн хөрөнгийн 35,6 хувийг трактор, 28,9 хувийг үр тарианы техник, 15,7 хувийг услалтын төхөөрөмж, 12,5 хувийг комбайн, 5,4 хувийг хүнсний ногооны төхөөрөмж, үлдэх хэсгийг хадлангийн техник тус тус эзэлж байна. Татвар төлөгчдийн мөнгийг хувийн хэвшлийн зарим байгууллагад хөрөнгө оруулалт хэлбэрээр ийнхүү олгож байгаа нь хэр зохистойг эргэн харж, төрөөс дэмжих оновчтой арга замыг эрэлхийлэх шаардлагатай байгаа нь аудитаар харагдлаа.

Хөрөнгө оруулалтын хэмжээ өссөнөөр ажлын байр шинээр бий болсон, нэмэгдсэн, ядуурал буурсан, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан гэх мэт хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр нөлөөний талаар судалгаа, тооцоог аудитад хамрагдсан байгууллагууд хийгээгүй байлаа.

*(2009 оны тайланд тусгагдснаар)*

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2009 оны худалдан авах ажиллагааны тайлангаас үзэхэд дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч нар сүүлийн 4 жилд худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Сангийн яаманд тайлагнаж байгаа хэдий ч өнөөдрийг хүртэл ирүүлж байгаа тайлан нь иж бүрдэл дутуу тухайлбал журмын Маягт 2-ын дагуу бичмэл тайлан ирүүлдэггүй, төсөл арга хэмжээ болон санхүүжилтийн эх үүсвэр бүрээр тайлагнадаггүй зөрчил байсаар байна;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

2. Босго үнээс дээш төсөвт өртөгтэй буюу нээлттэй тендер шалгаруулалтын журмыг баримтлах шаардлагатай худалдан авах ажиллагааг хязгаарлагдмал тендер шалгаруулалт, харьцуулалтын арга болон гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан зөрчил нийтлэг байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2009 оны худалдан авах ажиллагааны тайлангаас үзэхэд босго үнээс дээш төсөвт өртөгтэй буюу нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар хэрэгжүүлэх шаардлагатай байсан 48,3 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын арга болон шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан зөрчилтэй байна;

3. Хуулийн 8.1.4-т заасан босго үнээс давсан үнэ бүхий бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг зарлан мэдээлэх, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын өмнө Сангийн яамнаас зөвшөөрөл авалгүй зохион байгуулсан зөрчил зарим яамдад гарсан байна;

4. Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд /www.e-procurement.mn/ тендерийн урилга, үр дүнг мэдээлэх чиглэлээр хангалтгүй ажиллаж байна. 2009 оны байдлаар нийт 140 байгууллага худалдан авах ажиллагааны цахим хуудаст нэвтрэх эрх, 1478 тендерийн урилга, 397 тендер шалгаруулалтын үр дүн цахим хуудаст нийтлэгдсэн байгаагаас үзэхэд тендерийн урилгыг олон нийтэд зарлан мэдээлсэн боловч үр дүнг мэдээлэх чиглэлээр хангалтгүй ажиллаж байна;

5. Тендер шалгаруулалтын үнэлгээний явцыг үндэслэлгүйгээр хэт сунжруулж, хууль журмын дагуу үнэлгээ хийгээгүйн улмаас гомдол гарах, улмаар төсөл арга хэмжээний биелэлт удааширч байна;

6. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд болон чанарын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавиагүйн улмаас тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашírдаг төдийгүй хэрэгжсэн ч чанарын шаардлага хангахгүй байна;

*Нэг. Худалдан авах ажиллагааны холбогдох журмыг баримталсан байдал*

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 42 тоот тогтоолоор баталсан худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийн дагуу харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг барааны хувьд 30 сая төгрөг, ажлын хувьд 50 сая төгрөг, зөвлөхөөс бусад үйлчилгээний хувьд 30 сая төгрөг, шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, үйлчилгээний хувьд 1 сая төгрөг байхаар заасан. Төсвийн ерөнхийлөн захирагчдын худалдан авах ажиллагааны тайлангаас үзэхэд эдгээр босго үнээс дээш төсөвт өртөгтэй буюу нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар хэрэгжүүлэх шаардлагатай байсан худалдан авах ажиллагааг харьцуулалтын арга болон шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан зөрчил нийтлэг байна. /Зураг 1/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Зураг 1: Хуулийн дагуу явагдаагүй томоохон худалдан авалтын дүн

/2006, 2007, 2008, 2009 онуудын харьцуулалт/




*Хоёр. Тендер шалгаруулалтын урилга, үр дүнг худалдан авах ажиллагааны цахим хуудаст нийтэлсэн байдал*

Хуулийн 21.4 дэх хэсэг, Цахим сүлжээнд тендерийн зар, үр дүнг зарлан мэдээлэх тухай журамд зааснаар 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил, 50 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтын урилга, үр дүнг худалдан авах ажиллагааны цахим хуудаст олон нийтэд нээлттэй мэдээлэх шаардлага тавигдсан.

2009 оны 12 дугаар сарын байдлаар нийт 140 байгууллага худалдан авах ажиллагааны цахим хуудаст нэвтрэх эрх, 1478 тендерийн урилга, 397 тендер шалгаруулалтын үр дүн цахим хуудаст нийтлэгдсэн байгаагаас үзэхэд тендерийн урилгыг олон нийтэд зарлан мэдээлэх тухайд тодорхой ахиц ажиглагдаж байгаа боловч үр дүнг мэдээлэх чиглэлээр хангалтгүй ажиллаж байна.

*Гурав. Тендерийн баримт бичгийн боловсруулалт, үнэлгээний талаар*

Хуулийн 8.1.4 дэх заалтад Засгийн газраас төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл олгох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаарыг тогтоохоор заасны дагуу Засгийн газрын 42 дугаар тогтоолоор 1 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, 3 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 500 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий зөвлөхийн үйлчилгээ, 1 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий зөвлөхийн бус үйлчилгээний тендер шалгаруулалтыг зарлан мэдээлэх болон гэрээ байгуулахын өмнө Сангийн яамнаас зөвшөөрөл авахаар батлагдсан.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

2009 онд нийт 15 захиалагч байгууллагаас хуулийн 53.1-т заасны дагуу тогтоосон босго үнээс давсан нийт 463.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний 65 тендер шалгаруулалтыг зарлан мэдээлэх, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын өмнө зөвшөөрөл авах хүсэлтээ Сангийн яаманд ирүүлж, зохих хариуг тус яамнаас захиалагчид албан бичгээр хүргүүлсэн байна.

Судалгааны дүгнэлтээс үзэхэд зарим захиалагч (БСШУЯ, БОАЖЯ) дээрх босго үнээс давсан үнэ бүхий бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг зөвшөөрөл авалгүйгээр зарласан, эсвэл тендер шалгаруулалтыг зарлах зөвшөөрөл авсан боловч уг тендер шалгаруулалтын үнэлгээний дүгнэлтийг ирүүлж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын

өмнө зөвшөөрөл аваагүй зөрчил гаргасан байна.

***<u>Дөрөв. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2009 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны төсөв, түүний бодит гүйцэтгэл</u>***

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2009 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт 305 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн ба үүнээс 84 хувь буюу 256,0 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 5,8 хувь буюу 17,6 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар, 2,6 хувь буюу 7,8 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар 7,6 хувь буюу 23,6 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлсэн байна. Эдгээр бараа, ажил, үйлчилгээний батлагдсан нийт төсөвт өртөг нь 314,4 тэрбум төгрөг, гүйцэтгэл нь 305 тэрбум төгрөг байгаа бөгөөд нийтдээ 9,4 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Зураг 2: Улсын хэмжээнд хийгдсэн нийт худалдан авалтад тендер шалгаруулалтын журмыг хэрэглэсэн байдал




UIH.MN СУДАЛГААНЫ САН

Зураг 3: 2006, 2007, 2008 болон 2009 оны нийт худалдан авалтын харьцуулсан зураг




Зураг 4: Улсын хэмжээнд 2009 онд хийгдсэн нийт худалдан авалт /яам/






Улсын хэмжээнд 2009 онд хийгдсэн нийт худалдан авалт /аймаг/

**Хавсралт 1.** Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2009 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний нэгдсэн дүн

| **№** | **Төсвийн ерөнхийлөн захирагч** | **2006 оны үнэлгээ /хувиар/** | **2007 оны үнэлгээ /хувиар/** | **2008 оны үнэлгээ /хувиар/** | **2009 оны үнэлгээ /хувиар/** |
|---|---|---|---|---|---|
| | **Яамд** | | | | |
| 1 | Батлан хамгаалахын сайд | 71 | 71 | 71 | 76 |
| 2 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | 71 | 81 | 60 | 61 |
| 3 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд | 71 | 51 | 67 | 54 |
| 4 | Сангийн Сайд | 71 | 65 | 64 | 60 |
| 5 | Эрдэс баялаг, эрчим хүчний сайд | 59 | 53 | 71 | 51 |
| 6 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | 51 | 43 | 34 | 9 |
| 7 | Эрүүл мэндийн сайд | 48 | 10 | 86 | 45 |
| 8 | Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд | 40 | 70 | 65 | 42 |
| 9 | Хууль зүй, дотоод хэргийн сайд | 39 | 68 | 49 | 60 |
| 10 | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд | 36 | 51 | 76 | 67 |
| 11 | Гадаад харилцааны сайд | 14 | 39 | 46 | 0 |
| | *Дунджаар* | ***53*** | ***54*** | ***63*** | ***48*** |
| | **Аймгууд** | | | | |
| 12 | Өмнөговь аймгийн Засаг дарга | 72 | 67 | 61 | 55 |
| 13 | Дархан-Уул аймгийн Засаг дарга | 71 | 63 | 74 | 83 |
| 14 | Хөвсгөл аймгийн Засаг дарга | 70 | 15 | 40 | 33 |
| 15 | Сэлэнгэ аймгийн Засаг дарга | 68 | 73 | 43 | 31 |
| 16 | Орхон аймгийн Засаг дарга | 68 | 52 | 53 | 46 |
| 17 | Говь-Алтай аймгийн Засаг дарга | 61 | 70 | 70 | 41 |
| 18 | Завхан аймгийн Засаг дарга | 61 | 49 | 58 | 63 |
| 19 | Нийслэлийн Засаг дарга | 61 | 0 | 84 | 43 |
| 20 | Архангай аймгийн Засаг дарга | 60 | 43 | 49 | 60 |
| 21 | Төв аймгийн Засаг дарга | 55 | 55 | 74 | 65 |
| 22 | Дорноговь аймгийн Засаг дарга | 52 | 94 | 100 | 53 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 23 | Говьсүмбэр аймгийн Засаг дарга | 39 | 54 | 93 | 83 |
| 24 | Хэнтий аймгийн Засаг дарга | 49 | 35 | 49 | 48 |
| 25 | Ховд аймгийн Засаг дарга | 49 | 51 | 82 | 53 |
| 26 | Өвөрхангай аймгийн Засаг дарга | 48 | 31 | 60 | 37 |
| 27 | Сүхбаатар аймгийн Засаг дарга | 46 | 36 | 47 | 53 |
| 28 | Баян-Өлгий аймгийн Засаг дарга | 45 | 47 | 63 | 49 |
| 29 | Баянхонгор аймгийн Засаг дарга | 43 | 4 | 26 | 51 |
| 30 | Дорнод аймгийн Засаг дарга | 42 | 54 | 78 | 61 |
| 31 | Дундговь аймгийн Засаг дарга | 40 | 37 | 62 | 41 |
| 32 | Булган аймгийн Засаг дарга | 37 | 36 | 76 | 73 |
| 33 | Увс аймгийн Засаг дарга | 0 | 57 | 78 | 61 |
| | *Дунджаар* | ***54*** | ***47*** | ***65*** | ***54*** |
| | **Бусад төсвийн ерөнхийлөн захирагч** | | | | |
| 34 | Үндэсний статистикийн газрын дарга | 95 | 43 | 70 | 72 |
| 35 | Улсын Ерөнхий прокурор | 94 | 70 | 80 | 100 |
| 36 | Шадар сайд | 79 /ОБЕГ/ | 0 | 0 | 75 |
| 37 | Тэргүүн Шадар сайд | | | 43 | 0 |
| 38 | Санхүүгийн зохицуулах хорооны дарга | 43 | 64 | 75 | 0 |
| 39 | Монгол Улсын Их Хурлын дарга | 43 | 60 | 85 | 96 |
| 40 | Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга | 36 | 0 | 85 | 86 |
| 41 | Монгол Улсын Ерөнхий сайд | 33 | 69 | 78 | 61 |
| 42 | Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч | 35 | 66 | 92 | 0 |
| 43 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга | 24 | 45 | 60 | 65 |
| 44 | Төрийн албаны зөвлөлийн дарга | ** | 72 | 92 | 0 |
| 45 | Сонгуулийн ерөнхий хорооны дарга | ** | 92 | 60 | 70 |
| 46 | Хүний эрхийн Үндэсний комиссын дарга | ** | 84 | 76 | 0 |
| 47 | Үндэсний ерөнхий аудитор | ** | 35 | 0 | 52 |
| 48 | Үндсэн хуулийн цэц | ** | 60 | 85 | 93 |
| 49 | Төрийн өмчийн хороо /УҮГазрууд/ | 0 | 0 | 36 | 58 |
| 50 | Авлигатай тэмцэх газрын дарга | ** | 30 | 62 | 58 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | *Дунджаар* | ***53*** | ***48*** | ***63*** | ***52*** |
| | *Нийт дундаж хувь* | ***53*** | ***50*** | ***64*** | ***51*** |

** 2006 онд худалдан авах ажиллагаа хэрэгжүүлээгүй.

**Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний тухай**

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс харахад хуульд заасны дагуу орон нутагт эрх шилжүүлэх босго үнээс давсан төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааны задаргааг гаргаагүй, ихэнхи төсвийн ерөнхийлөн захирагч нар зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ирүүлээгүй зэргээс шалтгаалан улсын хэмжээнд 2010 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээний төсвийн нийт дүнг нарийн тооцоолон гаргах боломжгүй байна.

Нийт 52 төсвийн ерөнхийлөн захирагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ирүүлэх ёстойгоос Гадаад хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний комисс, Санхүүгийн зохицуулах хороо, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах газар төлөвлөгөөгөө ирүүлээгүй тул тэдгээр төсвийн ерөнхийлөн захирагчдын худалдан авах ажиллагааны дүн ороогүй болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын Сангийн яаманд ирүүлсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс үзэхэд улсын хэмжээнд 2010 онд нийт 504,5 тэрбум төгрөгийн төсөв бүхий худалдан авалт хийгдэхээр байгаагаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 80,5%-ийг, сангуудын хөрөнгөөр 3.4%-ийг, орон нутгийн хөрөнгө /өөрийн хөрөнгө/-өөр 4.2%-ийг, урсгал зардлаас 4.5%-ийг, зээл, тусламжийн хөрөнгөөр 7.4%-ийг тус тус санхүүжүүлэхээр байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг худалдан авах ажиллагааны журмын ашиглалтаар гарган үзүүлбэл нийт 1137 худалдан авах ажиллагааны 92.6%-ийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 3%-ийг харьцуулалтын аргаар, 0,5%-ийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар, 3,9%-ийг шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлэхээр байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөндөө хуулийн дагуу эрх шилжүүлэх төсөл, арга хэмжээний задаргааг гаргаж ирүүлээгүй тул нийт хэдий хэмжээний төсөл, арга хэмжээ орон нутагт эрх шилжих талаар дэлгэрэнгүй харуулах боломжгүй байв.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Зураг1:** Яамдын 2010 онд төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны нийт төсөв /санхүүжилтийн эх үүсвэрээр/




**Зураг 2:** Улсын хэмжээнд 2010 онд төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны нийт дүн /санхүүжилтийн эх үүсвэрээр/



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Зураг 3**: Улсын хэмжээнд 2010 онд төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны нийт дүн /худалдан авах ажиллагааны журмаар/




**2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний явц**

Засгийн газрын 2009 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 03 дугаар албан даалгаврын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2010 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг төсөл, арга хэмжээ бүрээр 2009 оны 12 дугаар сард багтаан баталж, 2010 оны 2 дугаар сарын 1-ний дотор улсын хэмжээнд бүх тендерийг зарлан, улмаар 4 дүгээр сарын 1-ний дотор тендер шалгаруулалтыг дүгнэж дуусган гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажлыг нь эхлүүлсэн байх үүрэг өгөгдсөн юм.

*Засгийн газрын тус албан даалгаврын биелэлтийн талаар товч танилцуулбал:*

**1.** Засгийн газрын албан даалгаврын дагуу 2010 оны худалдан авах ажиллагааг цаг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх үүднээс Сангийн яамны зүгээс 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор 2010 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг төсөл, арга хэмжээ бүрээр гаргаж тус яаманд ирүүлэх тухай мэдэгдлийг нийт 52 төсвийн ерөнхийлөн захирагч нарт албан тоотоор хүргүүлсэн байна.

2010 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 46 төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий төлөвлөгөөгөө ирүүлсэн бөгөөд дор дурдсан төсвийн ерөнхийлөн захирагч нар 2010 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө ирүүлээгүй байна. Үүнд:

- Гадаад хэргийн яам;
- Авилгатай тэмцэх газар;
- Улсын дээд шүүх
- Хүний эрхийн үндэсний комисс;
- ЦАУЗБГ;
- Санхүүгийн зохицуулах хороо.

**2.** Яамдын ирүүлсэн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу 2010 онд нийт 351,3 тэрбум төгрөгийн 380 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг

UIH.MN

зохион байгуулж хэрэгжүүлэх бөгөөд 2010 оны 2 дугаар сарын 1-ний дотор 230,9 тэрбум төгрөгийн 267 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

Харин зураг төсөл хийгдээгүй болон бусад шалтгаанаар 2010 оны 2 дугаар сарын 1-нээс хойш 120,4 тэрбум төгрөгийн 113 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулахаар ерөнхий төлөвлөгөөнд тусгасан нь Засгийн газрын албан даалгавраар өгөгдсөн үүргийн хэрэгжилтийг удаашруулах, улмаар зарим төсөл, арга хэмжээ амжилтгүй хэрэгжих нөхцөл үүсч болзошгүй байна.

**3.** Яамдын төлөвлөсөн худалдан авах ажиллагааны цахим хуудас /www.e-procurement.mn/-т нийтлэн олон нийтэд зарлах ёстой 385 тендерийн урилгаас 2010 оны 3 дугаар сарын 22-ны байдлаар 275 урилга зарлагдсан байгаа нь төлөвлөсөн худалдан авалтын 71 хувь байна.

| | Яамны нэр | Нийт зарлах | 2.1-ний байдлаар | Хувиар | 2.1-нээс хойш 3.22-ны байдлаар | Хувиар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | БОАЖЯ | 25 | 3 | 12% | 21 | 96% |
| 2 | БСШУЯ | 49 | 19 | 39% | 22 | 84% |
| 3 | БХЯ | 15 | 7 | 47% | 0 | 47% |
| 4 | ГХЯ | 0 | 0 | 0% | 1 | 0% |
| 5 | ЗТБХБЯ | 34 | 29 | 85% | 5 | 100% |
| 6 | НХХЯ | 36 | 5 | 14% | 0 | 14% |
| 7 | СЯ | 13 | 5 | 38% | 5 | 77% |
| 8 | ХЗДХЯ | 38 | 18 | 47% | 3 | 55% |
| 9 | ХХААЯ | 57 | 31 | 54% | 2 | 58% |
| 10 | ЭБЭХЯ | 42 | 17 | 40% | 16 | 79% |
| 11 | ЭМЯ | 76 | 51 | 67% | 15 | 87% |
| | НИЙТ | **385** | **185** | **48%** | **90** | **71%** |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Аймгуудын төлөвлөсөн худалдан авах ажиллагааны цахим хуудас /www.e-procurement.mn/-т нийтлэн олон нийтэд зарлах ёстой 315 тендерийн урилгаас 2010 оны 3 дугаар сарын 22-ны байдлаар 138 урилга зарлагдсан байгаа нь төлөвлөсөн худалдан авалтын 40 хувь байна.

| № | Аймгийн нэр | Нийт зарлах | 2.1-ний байдлаар | Хувиар | 2.1-нээс хойш 3.22-ны байдлаар | Хувиар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Архангай | 10 | 0 | 0% | 1 | 10% |
| 2 | Баян-Өлгий | 7 | 6 | 86% | 0 | 86% |
| 3 | Баянхонгор | 15 | 2 | 13% | 1 | 27% |
| 4 | Булган | 13 | | 0% | 3 | 23% |
| 5 | Говь-Алтай | 21 | 3 | 14% | 5 | 43% |
| 6 | Говьсүмбэр | 4 | 1 | 25% | 1 | 50% |
| 7 | Дархан-Уул | 4 | 4 | 100% | 0 | 100% |
| 8 | Дорноговь | 8 | 8 | 100% | 0 | 100% |
| 9 | Дорнод | 10 | 10 | 100% | 0 | 100% |
| 10 | Дундговь | 2 | 0 | 0% | 0 | 0% |
| 11 | Завхан | 9 | 2 | 22% | 0 | 22% |
| 12 | НЗДТГ | 78 | 17 | 22% | 7 | 31% |
| 13 | Орхон | 14 | 3 | 21% | 0 | 21% |
| 14 | Өвөрхангай | 11 | 1 | 9% | 0 | 9% |
| 15 | Өмнөговь | 13 | 2 | 15% | 0 | 15% |
| 16 | Сүхбаатар | 10 | 1 | 10% | 1 | 20% |
| 17 | Сэлэнгэ | 7 | | 0% | 0 | 0% |
| 18 | Төв | 10 | 5 | 50% | 5 | 100% |
| 19 | Увс | 16 | 10 | 63% | 2 | 81% |
| 20 | Ховд | 24 | 22 | 92% | 1 | 96% |
| 21 | Хөвсгөл | 15 | 2 | 13% | 3 | 33% |
| 22 | Хэнтий | 19 | 2 | 11% | 7 | 53% |
| | | **320** | **101** | **32%** | **37** | **44%** |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**ДҮГНЭЛТ**

Төр, орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа бол Төр, Хувийн хэвшлийн хамтран хийдэг бизнес бөгөөд түүний оролцогч талууд бол 1. Улстөрчид, улс төрийн намууд, 2.Төрийн албан тушаалтан, эрх мэдэлтэн, 3. Тендерт оролцогч нар (нийлүүлэгч, гүйцэтгэгч, зөвлөх компани) ба туслан гүйцэтгэгч, Банк санхүүгийн байгууллагууд ордог байна. Эдгээр талууд худалдан авах ажиллагааг шударга, хэмнэлттэй, үр өгөөжтэй явагдах үндсэн нөхцлийг хангахын сацуу хууль бус хэлцэлд орох эрсдэл, магадлал өндөр байдаг ажээ.

Үндэсний пүүс компаниуд гадаад зах зээлд өрсөлдөх чадваргүй тул дотоодын зах зээлд баримжаалсан бодлого барьдаг. Хүн амын дийлэнх олны ядууралд нэрвэгдсэн манай орны хувьд гол худалдан авагч нь төр болон хувирдгаас үндэсний томоохон пүүс компаниуд төр засагтай хамтран бизнес хийхийн тулд улс төрийн шийдвэр гаргагчтай хууль бус "түншлэл"-ийг үүсгэн улс төр-эдийн засгийн бүлэглэлүүд үүсэх үндсэн нөхцлийг бүрдүүлжээ.

Төсвийн мөнгө орлогын үндсэн суваг болсноос төр орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хяналтанд авах, өрсөлдөгчдийг бүхий л аргаар шахан зайлуулах эрмэлзлэл хувийн хэвшлийн тодорхой хэсэгт үүсч эл хүслээ төрийн эрх мэдэлд хүргэх, үүний тулд авлига хээл хахууль, эрх баригчдын ашиг сонирхлын зөрчлийг ашиглах явдал гүнзгийрдэг байна.

Зах зээл монопольчлогдож жижиг дунд бизнес шахагдан, ядуурлын түвшин нэмэгдэж, нийгмийн бүтцэд дунд давхрааны эзлэх хувь улам бүр буурч, улстөр-эдийн засгийн бүлэглэлүүдийн нөлөө өсч байна. Монголд хийгдэж байгаа худалдан авах ажиллагааны эдийн засгийн орчин нь чөлөөт өрсөлдөөн хязгаарлагдан монопольчлогдож, ашиг сонирхлын зөрчлийн улмаас улс төр-эдийн засгийн бүлэглэлүүд хүчирхэгжсэн, авлига, хээл хахууль өргөн тархаж, бизнесийн хүрээлллийнхэн хууль бус давуу байдал олж авахыг эрмэлзсэн, жижиг дунд бизнесийн зүгээс худалдан авах тендерийн үйл ажиллагаанд шударгаар өрсөлдөх боломжгүй зэрэг нөхцөл байдлаар тодорхойлогдож байна.

Худалдан авалтын эрх зүйн үндсийг бүрдүүлдэг “Төр болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль бол Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон НҮБ зэрэг нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудын арга зүй, аргачлал, жишиг хуулийн загвараар боловсруулагджээ. Гэсэн хэдий ч 2007 оны хуулийн нэмэлт өөрчлөлт нь энэ сайн туршлагын үр өгөөжийг бууруулсан арга хэмжээ болсон байна.

Худалдан авах ажиллагаанд цахим технологи нэвтрүүлэх ажлын эхлэл Монголд нэгэнт тавигдсан боловч тендерийн урилга, шалгаруулалтын тоон тайлан, захиалагчдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг статистик тоо баримт төдий байгаа бөгөөд тендер шалгаруулалтын явц, үр ашиг, хуулийн хэрэгжилт зэрэгт чанарын шинжтэй дүн шинжилгээ хийх боломж хомс хэвээр байна.

Худалдан авах ажиллагааны удирдлага, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, сүлжээ байгуулах ажил эхэлсэн боловч хуримтлуулах мэдээллийн жагсаалт, тэдгээрт тавигдах техникийн болон төлөөлөх чадварын шалгуур, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнг бодлогын болон гүйцэтгэх түвшинд хэрэглэх горим журам байхгүй хэвээр байна.

Цахим худалдан авах ажиллагааг хөгжүүлэх талаар Сангийн яамны ХАА-ны бодлого зохицуулалтын газар тодорхой амжилтанд хүрч байгаа нь “e-procurement.mn” цахим хуудасны ажиллагаанаас харагдаж байна.

Монголд нийт 5000 гаруй худалдан авах эрх бүхий төв, орон нутгийн төр засгийн байгууллага, хуулийн этгээдэд худалдан авах ажиллагааны чиглэлээр нийт 3300 орчим хүн ажиллаж байна.

Түүнчлэн худалдан авах ажиллагааг төвлөрүүлэн зохион байгуулах буюу аливаа нэг худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд шууд оролцохгүй, зөвхөн хэрэгжүүлэгч байгууллагуудыг мэргэжлийн арга зүй, шаардлагатай журам заавраар хангаж, тэдгээрийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилтэд хяналт тавьдаг Худалдан авах ажиллагааны Бодлого зохицуулалтын газар Сангийн яамны бүтцэд үндсэн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

болон төслийн 15 ажилтантай ажиллаж байна.

Монгол улсад жилдээ 100.000 гаруй худалдан авах ажиллагаа хийгдэж байгаагийн тал орчим хувь тендер шалгаруулалтын журмын дагуу явагдаж байна.

Худалдан авалтыг хэрэгжүүлж байгаа Захиалагчийн чадавхи дорой, хариуцлага, сахилга бат сул байгаа нь энэ ажиллагааны үр өгөөж, чанар, хэмнэлттэй байдалд сөргөөр нөлөөлж, авлига хээл хахууль гарах нөхцлийг бүрдүүлж байна.

Хуульд заасан ёсоор томоохон захиалагч бүр худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн мэргэжилтэн байх ёстой авч энэ чиг үүргийг хавсарсан байдлаар хийх хандлага давамгайлж байгаа нь байдалд улам муугаар нөлөөлж байна.

Сангийн яамны ХАА-ны бодлого зохицуулалтын газар нь худалдан авах ажиллагааны бодлого, эрх зүйн орчинг сайжруулах, захиалагчийн чадавхийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааны бүх шатанд тавих хяналт шалгалтыг сайжруулах, цахим технологийг нэвтрүүлэх зэргээр шинэ тулгар тогтолцоог төлөвшүүлэн бэхжүүлэхэд идэвхитэй үүрэг гүйцэтгэж байна.

Чухамдаа төрийн эрх барих дээд байгууллага болон гүйцэтгэх засаглалын зүгээс шийдвэртэй алхам хийхгүй байгаагаас тендер зохион байгуулах ажиллагаанд хуулийн заалтыг санаатайгаар гуйвуулах, нээлттэй, шударга байдлыг гажуудуулах байдал газар авч байна. Худалдан авах ажиллагаанд хариуцлагын тогтолцооны тодорхой бус байдал, хяналтын оновчгүй механизм, захиалагчын алдаатай ажиллагаа зэрэг нь худалдан авах ажиллагааны үр ашигтай байдалд сөргөөр нөлөөлөх төдийгүй, төрийн өмч хөрөнгийг хувийн ашиг сонирхолд нийцүүлэн завших, хуйвалдаан зохиох, авлига өгч авах зэрэг ноцтой байдлууд үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

## ЗӨВЛӨМЖ

**1.** Сүүлийн 3 жилийн худалдан авах ажиллагаанд хийсэн судалгаанаас үзэхэд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй нийт худалдан авалтын 80 гаруй хувь нь яамдын түвшинд зохион байгуулагддаг. Хууль, журмын дагуу аливаа тендер шалгаруулалтыг 60-70 хоногт багтаан явуулах бүрэн боломжтой хэдий ч төсвийн ерөнхийлөн захирагч нарын зохион байгуулсан томоохон худалдан авах ажиллагаанаас харахад дунджаар 109 хоногт худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Үүнээс зөвхөн үнэлгээний шатанд дунджаар 45 хоног зарцуулж байгаа нь тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах нөхцөлийн нэг болж байна. Иймд төсөл, арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулах зорилгоор үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг аль болох богино хугацаанд үнэлж, зөвлөмж гаргаж байх шаардлагатай байна.

**2.** Худалдан авах ажиллагааны цахим хуудаст 2009 онд 476 тендерийн урилга нийтэлж, 188 тендер шалгаруулалтын үр дүнг нийтэлсэн байгаагаас үзэхэд тендерийн үр дүнг олон нийтэд мэдээлэх чиглэлээр захиалагч байгууллагууд маш хангалтгүй ажиллаж байна. Иймд захиалагч байгууллагууд тендер шалгаруулалтын урилга, үр дүнг өдөр тутмын 2 сонинд зарлан мэдээлж, худалдан авах ажиллагааны цахим хуудас /www.e-procurement.mn/-д тогтмол нийтлэж хэвших шаардлагатай байна.

**3.** Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн ажилтнууд худалдан авах ажиллагааг зохион байгуулах нь тендер шалгаруулалтыг хууль, журмын дагуу үр дүнтэй, чанартай зохион байгуулах болон тендерт оролцогч нарын зүгээс гарах гомдол маргааныг бууруулах ач холбогдолтой. Үнэлгээний хорооний бүрэлдэхүүнд орсон албан тушаалтны 50-аас дээшхи хувь /олонхи/ нь худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж сертификат авсан байх шалгуур хуулийн дагуу тавигддаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хуулийн дээрх шалгуурыг хэрэгжүүлэх үүднээс Сангийн яамны зүгээс худалдан авах ажиллагааны анхан шатны үндсэн мэдлэг олгох 1- 3 өдрийн сургалтыг 2006 оноос эхлэн зохион байгуулсан бөгөөд эхний сертификат авсан зарим ажилтны сертификатын хүчинтэй байх хугацаа дуусч байгаа тул худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтныг давтан сургалтад хамруулж сертификатын хүчинтэй байх хугацааг сунгуулж, үнэлгээний хорооний бүрэлдэхүүнд орсон албан тушаалтны 50-аас дээшхи хувь /олонхи/ нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх шалгуур үзүүлэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч байгууллагууд хангаж ажиллах шаардлагатай байна.

**4.** Захиалагч байгууллагууд тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд байнгын хяналтыг тавьж, гэрээг хугацаанд нь дүгнэж дуусгахад анхаарч ажиллах нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрахгүй байх, амжилттай хэрэгжих нөхцөл болно.

**БОДЛОГЫН САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Төр болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2007 оны нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгох нь эн тэргүүний зорилт болж байна. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Азийн сан зэрэг нэр хүнд бүхий олон улсын байгууллагууд болон үндэсний төрийн болон төрийн бус байгууллагуудаас хийсэн судалгааны дүн энэхүү нэмэлт өөрчлөлт нь чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлаж, шууд гэрээ байгуулах замаар тендерийн ил тод байдлыг үгүйсгэн авлига хээл хахууль гаарах нөхцлийг бүрдүүлж байгааг нотолж байна.

1. Худалдан авах ажиллагааг шударга, үр өгөөжтэй явагдах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд Албан тушаалтны ашиг сонирхлын тухай болон Төрийн албан хаагчдын ёс зүйн хууль, Төсвийн хариуцлагын тухай хуулийг батлах,
2. Нөлөө үзүүлэхийг санал болгох, шүүн таслах ажиллагаанд саад учруулах, олон улсын байгууллага болон гадаадын төрийн албан хаагчийг хахуульдах, хувийн хэвшил дэхь хээл хахууль, төрийн албан тушаалтан хөрөнгө хувьдаа завших, хууль бусаар баяжих, авлигатай холбоотой гэмт хэргээс олсон орлогыг угаах, хууль бус эд хөрөнгийг нуун дарагдуулах, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага тооцох зэрэг асуудлыг багтаасан нэмэлт өөрчлөлтийг Эрүүгийн хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуульд оруулах,
3. Авлигын нийгэмд учруулж байгаа ёс суртахуун, сэтгэл зүй зэрэг материаллаг бус хохирлыг гэмт хэрэгт тооцон хариуцлага тооцох талаар судалгаа хийж, Эрүүгийн болон ЭБШХ-д тусгах саналыг боловсруулах,
4. Нөлөө үзүүлэхийг санал болгох, олон улсын байгууллагын, гадаадын төрийн албан хаагчийг хахуульдах, хувийн хэвшил дэхь хээл хахууль, төрийн албан тушаалтан хөрөнгө хувьдаа завших, хууль бусаар баяжих, авлигатай холбоотой гэмт хэргээс олсон орлогыг угаах, хууль бус эд хөрөнгийг нуун дарагдуулах, шүүн таслах ажиллагаанд саад учруулах зэрэг авлигатай холбоотой хэрэг зөрчилд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах эрхийг Авлигатай тэмцэх Газарт олгоход чиглэсэн нэмэлт өөрчлөлтийг Эрүүгийн хууль тогтоомжид оруулах,
5. Хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулах зэрэг авлигын хэрэг зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэх чиглэлээр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах,
6. Гэмт этгээдийг гадаад оронд шилжүүлэх, өгөх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, авлигаас олсон орлогыг нөхөн сэргээх буцаан олгохтой холбоотой олон

UIH.MN СУДАЛГААНЫ САН

улсын хамтын ажиллагааны талаар үр ашигтай зүйл заалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулах

7. Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг цуцлан, өнөөгийн хууль эрх зүйн орчинд нийцэж, худалдан авах ажиллагаа зэрэг авлигад өртөх өндөр эрсдэлтэй салбаруудыг онцгой анхаарсан, сонирхогч талуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааг уялдан зохицуулсан Авлигын эсрэг Үндэсний Стратегийг боловсруулан хэрэгжүүлэх,

8. Худалдан авах ажиллагаанд зарцуулагдаж байгаа их хөрөнгийг ажлын байр бий болгох, жижиг дунд бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэсэн төрийн бодлоготой уялдуулан, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх асуудлыг бодлогоор дэмжих,

9. Худалдан авах ажиллагаанд оролцох үндэсний компаниудын чадавхийг нэмэгдүүлэх үүднээс хувийн хэвшилд зориулсан худалдан авах ажиллагааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, энэ ажиллагаанд бизнесийн холбоод, төрийн бус байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулах,

10. Томоохон худалдан авах ажиллагааны төсөвт өртөгт иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс хийх бие даасан хараат бус хяналт, мониторингийн зардалд зориулсан хөрөнгийг суулгаж өгөх,

11. "Хармааны" төрийн бус байгууллагуудыг хязгаарлах үүднээс томоохон худалдан авах ажиллагааны хяналт мониторинг хийх ТББ-ын сонгон шалгаруулалтанд ТББ-ын сүлжээг ашиглах, обьектив шалгуурыудыг тогтоон, ил тодоор явуулах,

12. Томоохон захиалагчдын дэргэд худалдан авах ажиллагааны мэргэжилтний орон тоо баталж, мэргэших, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулахын зэрэгцээ хариуцлагын тогтолцоо болон албан тушаалтныг сэлгэх зарчмыг үр өгөөжтэйгээр хэрэгжүүлэх,

Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газрын бие даасан байдал, үйл ажиллагааны үр өгөөжийг хангах үүднээс өнөөгийн статусыг өргөжүүлэн, Засгийн газрын агентлаг болгон өөрчлөн өргөжүүлэх,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# АШИГТ МАЛТМАЛЫН ЛИЦЕНЗ ОЛГОЛТЫН ТАЛААРХИ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

*(Харьцуулсан судалгаа)*

*Д.Мягмарцэрэн/МА/, С.Дорждагва*

**Оршил**

Судалгааг Ц.Шинэбаяр гишүүний ирүүлсэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтын харилцааг боловсронгуй болгох арга замын тухай захиалгын дагуу нийт 10 гаруй улсын энэ талаархи тэргүүний туршлагаас Монгол улсад авч хэрэгжүүлж болохуйц жишээг түүвэрлэн харьцуулах байдлаар бэлтгэв. Өнөөдөр тус улсад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтын асуудал хэт замбараагүй явж ирснээс ихээхэн бэрхшээлүүд үүсгэж эхэлсэн бөгөөд энэхүү судалгаа нь уг асуудлыг зохистойгоор шийдвэрлэх арга замыг тодорхойлоход тус дөхөм болж болох юм.

**Судалгааны зорилго**

Судалгаанд бусад улс орнуудын туршлагыг жишээ болгон авахдаа тухайн улсын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох процессыг бүгдийг нь дурьдахыг зориогүй бөгөөд зөвхөн өнөөдөр тус улсад үүсээд буй бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэж чадахуйц онцлог зохицуулалтуудыг сонгон авсан.

**Судалгааны үр дүн**

Судалгааны үр дүнгээс үзэхэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтод дараах зарчмуудыг баримтлах нь асуудлыг нааштайгаар шийдвэрлэх гарц болж болох юм гэж дүгнэж байна.

1. Тусгай зөвшөөрөл хүсэгчид нарийн тодорхой шалгуур тавих,
2. Тусгай зөвшөөрлийг олгохдоо тодорхой үүрэг амлалт бүхий гэрээ байгуулах,
3. Ашигт малтмалыг олборлуулахад өмчийн эзний хувиар Төрд ашигтай байж болох төрөл бүрийн арга хэрэгслийг бий болгох,
4. Үйл ажиллагаагаа явуулах бүх шатанд нь төрийн эрх бүхий байгууллагаас чиглэл чиглэлийн хяналтын тогтолцоо бий болгох,

Эдгээрийг дэлгэрүүлэн дүгнэлт зөвлөмжийн хэсэгт харуулав.

**Ерөнхий зүйл**

Ашигт малтмал, байгалийн нөөц баялаг нь дийлэнх улс орнуудын хувьд тухайн улсынхаа Төрийн өмчлөлд байдаг учраас ашигт малтмалын хайгуул, олборлолт, уг нөөц баялгийг ашиглах үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нь дэлхийн аль ч улс оронд байдаг нийтлэг зохицуулалт юм.

Ашигт малтмалын хайгуул, олборлолт, ашиглах үйл ажиллагаа нь ихэнхи тохиолдолд хувийн хөрөнгө оруулалт дээр тулгуурлан явагдаж байдаг ба гэхдээ хэн хүссэн нь бус төрөөс хуульчлан тогтоосон тусгай нөхцөл, болзлыг хангаж буй этгээд л эрхлэх боломжтой гэдгээр тодорхойлогдоно. Тухайн тохиолдолд болзол хангасан олон этгээд байвал сонголт хийх эрх нь төрд байдаг бөгөөд шалгуур нь тодорхой, шалгаруулалт нь шударга байхыг урьдчилсан нөхцөл гэж үздэг. Өөрөөр хэлбэл, төр өөрийн өмчийн байгалийн нөөц баялагт хэзээ, хэнээр, хаана, ямар нөхцлөөр хайгуул болон олборлолтыг хийлгэх, тусгай зөвшөөрлөөр дамжуулан ашигт малтмалын өмчлөлийн эрхээ шилжүүлэх эсэх асуудлыг шийдэх бүрэн эрхтэй.

Тусгай зөвшөөрлөөр хэлбэржсэн үйл ажиллагаа явуулах эрх нь тухайн тусгай

UIH.MN СУДАЛГААНЫ САН

зөвшөөрлийг эзэмшигч этгээдийн төрмөл бус тодорхой болзлоор нөхцөлдсөн олдмол эрх тул тусгай зөвшөөрлийг олгоход тавьсан шаардлага, оногдуулсан үүргийг зохих ёсоор биелүүлэх нь тусгай зөвшөөрөл буюу уг баялгийг эзэмших, ашиглах эрхээ хадгалах үндсэн нөхцөл болох бөгөөд үүргээ биелүүлээгүй тохиолдолд уг эрхээ хэзээ ч алдах боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрлөөр дамжуулан төрөөс өгсөн "хүлээсэн үүргээ л биелүүлээд байвал тухайн нөөц баялгийг эзэмших ашиглах бүрэн эрхтэй" гэсэн баталгааны үндсэн дээр хүмүүс хөрөнгөө тэр үйл ажиллагаанд оруулдаг, бусадтай гэрээ хэлцэл хийдэг, орлого ашгаа тооцож, зардал гаргадаг. Харин тусгай зөвшөөрөл авах үедээ хүлээсэн үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулахгүй буюу хөрөнгө оруулахгүйгээр тусгай зөвшөөрлийг шууд дамжуулан худалдах, шилжүүлэх тохиолдолд тухайн нөөц баялгийн талаарх тохиролцоо, эрх эзэмшигч этгээдэд тавигдах болзол, шаардлагыг зөрчсөн гэж үзэж төрөөс уг эрхийг буцаан хураах авах боломжтой юм.

Иймээс энэ салбарт хөрөнгө оруулагч компаниуд улс төрийн болон хууль эрх зүйн тогтвортой байдлын үнэлгээг өөрсдийн бизнесийн эрсдлээ үнэлэх суурь болгон ашигладаг тул ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл нь тухайн улсын хуулиар ямар эрх үүргийг өөртөө агуулж байгаа болон тэдгээр эрх үүргүүд нь хэр тогтвортой болох нь тэдний хувьд ихээхэн чухал асуудал юм.

**<u>Франц</u>**

Францын Уурхайн хууль (Code Minier) нь 1810 онд батлагдсан бөгөөд Баруун Европын ихэнх улсын уурхайн хуулиудын үндэс болсон. 1956, 1995 онд энэхүү хуулийг шинэчилж найруулсан, 1992 онд усны тухай, 1993 онд ил уурхайн тухай, 1995 онд Байгаль орчныг хамгаалах тухай зэрэг нэмэлт хуулиудыг оруулж эрх зүйн нормыг баталсан аж.

Энэ хуулинд байгалийн нөөц баялгийг хоёр үндсэн хэсэгт хуваасан.

I. Ашигт малтмалын орд. Энэ бүлгийн ордыг газар өмчлөгч болон лиценз эзэмшигч зөвхөн Засгийн газартай хийсэн концессын гэрээгээр ашиглахаар хуульчилсан байна.

II. Барилгын материалын орд. Энэ төрлийн ордыг ашиглахад зөвхөн газар эзэмшигчийн зөвшөөрлийг авч ашигладаг юм байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшихээр хүсэлт гаргагч нь заавал тус улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, тус улсад татвар төлөгч хуулийн этгээд байхыг шаарддаггүй, хамгийн гол нь уул уурхайн үйл ажиллагаагаа хуульд заасан журмын дагуу явуулах санхүүгийн болон техник технологийн чадвартай байхыг шаарддаг. Энэ нь нөхөн сэргээлт, бусдад учруулсан хохирол зэрэгт ч хамаатай юм.

Тусгай зөвшөөрлийг санхүүгийн амлалт буюу концессын гэрээгээр олгохдоо орон нутгийн болон олон нийтийн саналыг үндэслэн шийдвэрлэдэг байна. Зөвшөөрлийн хугацааг сунгахдаа энэхүү амлалтын биелэлтийг үндэслэдэг. Концессээр орд ашиглагч дампуурсан тохиолдолд газрын хэвлийг ашиглах бүх эрх, үүрэг улсын мэдэлд шилждэг.

Концессын гэрээнд тусгай зөвшөөрөл хүсэгч нь:

- ашигт малтмалыг хүн ам, байгаль орчинд хохирол багатай олборлох,
- байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх,
- бусад төрлийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх,
- бүс нутгийг хөгжүүлэх, эдийн засагт нь бодитой хувь нэмэр оруулах,
- дээд зэргийн үр ашиг бүхий тэргүүний дэвшилтэт технологи ашиглах,
- учирсан хохирлыг нөхөн төлөх гэсэн үүргүүдийг хүлээдэг байна.

Үүнээс бүс нутгийг хөгжүүлэх, эдийн засагт нь бодитой хувь нэмэр оруулах, байж болох дээд зэргийн үр ашиг бүхий тэргүүний дэвшилтэт технологи ашиглах, учирсан хохирлыг нөхөн төлөх гэсэн хэсэгт онцгой анхаардаг бөгөөд үүний тулд тусгай зөвшөөрөл хүсэгч нь санхүүгийн хангалттай хэмжээний чадавхитай байхыг шаардахын зэрэгцээ үйл

UILMN СУДАЛГААНЫ САН

ажиллагаанаас нь хохирол учрах болзошгүй тохиолдолд урьдчилан уг хохирлыг бүрэн барагдуулах барьцаа тавина.

Франц улс нь орд бүр дээр концессын гэрээ байгуулснаар тухайн ордыг ашиглах явцад бий болох экологийн болон бусад хохирол, эрсдлээс урьдчилан сэргийлэх найдвартай арга зам бий болгосон ч хэрэв хариуцлага хүлээгч нас барах, дампуурах зэргээр үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Төр энэ үүргийг нь шилжүүлж авч байгаа нь үүнийгээ улам баталгаажуулж байна.

**Перу**

Тусгай зөвшөөрөл эзэмшихээр хүсэлт гаргагч нь орон нутгийн засаг захиргаа ба Геологи уул уурхай, төмөрлөгийн институтэд /ГУУТИ/ өргөдлөө гаргана. Өргөдлын маягтанд мөн эхний жилийн уул уурхайн бүтээгдэхүүний төлбөр (*Mining good standing fee)*, үйл ажиллагааны төлбөр (*proceeding fee*) буюу татварын нэгжийн 10%-тай тэнцэх төлбөр төлсөн баримтуудыг хавсаргана.

Тухайн өргөдлийг ажлын 7 өдөрт хянаж, ямар нэгэн зөрчилтэй эсэхийг шалгаж үзсэний дараа хуулийн мэдэгдлийг хэвлэлтэнд бэлэн болгоно. Үүний дараа ажлын 30 хоногийн дотор багтаан өдөр тутмын **“El Peruano”** сонин дээр нийтлэнэ. Хэрвээ тухайн орон нутагт дээрх мэдээлэл хүрэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд ГУУТИ, орон нутгийн засаг захиргааны байранд 7 хоногийн хугацаатай байршуулна. Уг мэдээлэлд уул уурхай эрхлэх зөвшлөөрлийн өргөдөл болон Уул уурхайн дүрэм журмын 19 дүгээр хэсэгт заасан зүйлүүдийг тусгаж өгсөн байна. Өргөдөл гаргагч нь хэвлэлд материалаа хэвлүүлснээс хойш 60 хоногт ГУУТИ болон орон нутгийн засаг захиргаанд олон нийтэд мэдээллээ хүргэсэн гэсэн баталгааныхаа хуудсуудыг өгдөг байна. Үүний дараа ГУУТИ-ын уул уурхайн зөвшөөрлийн товчооны дарга эсвэл орон нутгийн засаг захиргааны Уул уурхай, эрчим хүчний товчоо хэвлэгдсэнээс хойш уг асуудалтай холбоотой ямар нэг сөрөг эсэргүүцэл гараагүй тохиолдолд техник, хууль эрх зүйн мэдэгдлийг ажлын 30 хоногийн дотор багтаан гаргана. Улмаар ГУУТИ-ын дарга, орон нутгийн засаг захиргааны Уул уурхай, эрчим хүчний товчооны дарга Ашигт малтмалын хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу батламжилдаг байна.

ГУУТИ-ээс сар бүрийн эхний 15 хоногт багтаж өнгөрсөн сард уул уурхайн зөвшөөрөл олгогдсон лиценз эзэмшигчдийн нэрсийг **“El Peruano”** сонинд нийтэлдэг байна.

Дээрхи арга замаар тус улс нь лиценз олголтын ил тод байдлыг хангадаг бөгөөд ингэснээр аливаа нэг уул уурхайн үйл ажиллагаа, лиценз олголт нь байгаль орчин болоод бусдын эрх ашгийг хөндөхөөс найдвартай хамгаалж чаддаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**АНУ**

АНУ-ын газрын хэвлийн баялгийг хайгуулдах, олборлож, ашиглах уурхай байгуулах эрх зүйн зохицуулалтыг 1872 онд гаргасан Уурхайн тухай (*Mineral lands and mining*) хуулиар зохицуулдаг бөгөөд энэхүү хуулиар 1872 оноос өмнө газраа өмчилж авсан иргэдэд газрын доорх баялгийг салгахгүйгээр өмчлөх эрх олгож, харин 1872 оноос хойш газар өмчлөх эрхтэй иргэдийн газрын доорх хэвлийн баялгийг тухайн муж улс буюу АНУ-ын өмч гэж хуульчилсан байна. Тийм учраас АНУ-д газрын хэвлийн баялгийг ашиглах эрхийг тус тусдаа гурван хуулиар зохицуулдаг байна.

Холбооны улсын өмчлөлийн газрын хэвлийн баялгийг АНУ-ын Уурхайн тухай (*Mineral lands and mining*) хуулиар, муж улсын өмчлөлийн ашигт малтмалыг тухайн муж улсын уурхайн тухай хуулиар, 1872 оноос өмнөх газар өмчлөлийн эрхтэй иргэдийн газрын доорх баялгийг ашиглах эрхийг газар өмчлөлийн харилцааны тухай хуулиар тус тус эзэмших, ашиглах эрх зүйн зохицуулалт хийжээ.

Америкийн хувийн газар өмчлөлийн үндсэн хэлбэр нь өмчийн эзэн нь газраа өвлүүлэх, зарах, түрээслэх, бусад хэлбэрээр ашиглах үндсэндээ хязгаарлалтгүй эрхтэй

байдаг ба уурхай, орон сууц зэрэг эзэмшлийн төрөлд энэ хэлбэр зонхилдог байна. Ер нь Америкийн газрын эрх нь газрыг эдийн засгийн эргэлтэд чөлөөтэй оруулах бололцоог хангахад чиглэсэн уян хатан шинжтэй байдаг. Дээрх эрхүүд бүгд тус тусдаа зарж арилжих, шаардлагатай хэлбэрээр нийлүүлэн салгах, хослуулах бололцоотой байдаг. Ашигт малтмал илэрсэн газрын эзэн эдгээр эрхээ гол төлөв уул уурхайн компанид удаан хугацаагаар түрээсэлж, хайгуулын хугацааны төлбөр, олборлосон ашигт малтмалын хувь буюу роялть, шаардлагатай бол газарт учруулсан хохирлын төлбөр, мөн гэрээ байгуулсны шагнал гэж авдаг байна. АНУ-д газрын 75 хувь нь хувийн өмчлөлд байдаг. Хувийн өмчлөлд байгаа байгалийн баялаг эзний хүсэл зоргоор чөлөөт зах зээлийн хуулиар эргэлтэд орж байдаг ба үүнийг америкчууд “уурхайн чөлөөт эрх” гэж нэрлэдэг.

Харин Холбооны улс, муж улсын өмчийн газрын хэвлийн баялгийг хайгуулдах, ашиглах тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтаар, өрсөлдүүлж олгодог байна. Газрын тос, байгалийн хий, нүүрс, эрдэс бордоог 1920 оны Конгрессын шийдвэрээр зөвхөн түрээсээр ашиглуулдаг бөгөөд нүүрсэн дээр тус улсад LBA гэдэг аргыг хэрэглэдэг.

Энэ арга нь Холбооны улс, муж улсын өмчийн газар доор байгаа баялгийг тухайн Засгийн газрын өмч гэж үздэг бөгөөд уг ордыг ашиглах гэсэн компаниуд уг нүүрснээс худалдаж авах санал тавих замаар ордыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, аль нэг компани хайгуул хийгээд нүүрсний орд газрыг илрүүлсэн бол түрээсийн тендер зарлаж өгөөч ээ гэж Засгийн газарт хүсэлт тавьдаг. Тендерт хайгуул хийсэн компаниас гадна хайгуул хийгээгүй компаниуд ч оролцдог. Тендерт орохдоо 20 хувийн урьдчилгаа төлдөг ба тендерт шалгуур болгож байгаа гол үзүүлэлт нь газар доор байгаа нэг тонн нүүрсийг хэдээр худалдаж авах вэ? л гэдэг асуудал. Хамгийн өндөр үнэ санал болгосон нь ялдаг бөгөөд хэрэв тэнд нь дэд бүтэц байхгүй бол түүнийг байгуулах өртгөө нүүрсний үнэндээ оруулж тооцох гэх мэтээр компаниуд өөр өөрсдийнхөөрөө үнээ тогтоодог.

Хайгуул хийсэн компани тендерт шалгарч чадаагүй тохиолдолд хайгуул хийсэн зардлыг нь төр эргүүлж өгөхгүй. Өөрөө хайгуул хийсэн, хамгийн их мэдээлэлтэй байгаа хэрнээ сайн үнэ өгч чадаагүй бол өөрсдийнх нь буруу болдог.

**<u>Англи</u>**

1568 онд анх Англид “royal metals” буюу алт, мөнгө нь хэний эзэмшлийн газраас олдсноос үл хамааран Эзэн хааны өмч болох тухай хууль гарсан нь эрдэс баялгийг эзэмших эрхийг газар өмчлөлийн эрхээс салгах үзэл баримтлалын үндэс болжээ.

Эдүгээ дээрхи хуулийн дагуу тус улсад алт мөнгөний уурхайнууд бүгд Английн эзэн хааны хувийн өмчлөлд байдаг. Мөн уранаас бусад төрлийн газрын хэвлийн баялаг хувийн өмчлөлд байдаг байна. Хувийн өмчлөлд байгаа газрын хэвлийн баялгийг ашиглах эрх газар эзэмшлийн тухай хуулиар зохицуулагддаг.

Нүүрсний уурхайн тухай хууль нь нэлээд эрт гарсан ашигт малтмалын тухай анхдагч хууль бөгөөд энэ хуулиар ажил гүйцэтгэгчид нүүрсийг хайгуулдах, олборлох, уулын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл олгодог бөгөөд энэхүү тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон нүүрсийг худалдан борлуулах, захиран зарцуулах эрх эзэмшихгүй харин түрээсийн гэрээгээр уурхайн түрээс төлсөн уурхайн түрээслэгчдэд захиран зарцуулах эрх олгодог байна.

XIX зууны дунд үед ид өрнөсөн “алтны халуурлыг” зохицуулахын тулд Английн колони байсан улсууд, тэр дундаа Австралид алтны хайгуулчдад зориулсан тусгай дэглэм тогтоосон нь эдүгээгийн тусгай зөвшөөрлийн эхлэл байв. Зөвшөөрлийг эхэндээ орон нутгийн захиргааны буюу захирагчийн шийдвэрээр олгодог байсан нь орон нутгийн захиргааны эрх мэдлийг гааруулж, захирагчдын хэт дарамтыг тэсвэрлэхээ больсон уурхайчид 1854 онд уурхайчдын бослого дэгдээсэн юм. Үүнээс сургамж авсан Засгийн газар зөвшөөрлийг захиргааны эрх мэдэлд бус уурхайчдын эрхэд үндэслэн олгох шинэ дэглэм нэвтрүүлсэн байна. “Free miner” буюу Чөлөөт уурхайчин гэх энэхүү дэглэм нь

UIH.MN СУДАЛГААНЫ САН

тодорхой хэмжээний төлбөр төлсний үндсэн дээр тогтоосон хугацаанд уурхай руу орох, энэ хугацаанд хэр хэмжээний, юу олсноо өөрөө авах эрхэд үндэслэгдсэн, зөвшөөрлийн харьцангуй шударга систем байв. Өнөөдөр манай улсад гар аргаар алт олборлогч “нинжа” нарын дунд энэ тогтолцоо нэлээн дэлгэрэнгүй хэрэглэгддэг.

**Канад**

Тус улсад Холбооны улсын болон муж улсын Засгийн газрын өмчлөлд байгаа газрын хэвлийн баялгийг олон нийтийн эзэмшлийн төрийн өмч байхаар хуульчилжээ. Холбооны улсын уурхайн хууль нь зөвхөн холбооны улсын шүүх эрх мэдэлд хамааргдах газар болон далай тэнгисийн доорх газрын хэвлийн ашигт малтмалыг ашиглах харилцааг зохицуулдаг байна.

Муж улсууд өөр өөрсдийн газар нутгийн газрын хэвлийг ашиглах уурхайн хуультай ба хайгуул хийх эрхийг хязгаарлагдмал талбайд олон хувь хүн, хуулийн этгээдийг дундын өмчлөлийн хөрөнгийн биржийг ашиглан санхүүгийн хэрэгслээр (*хувьцаа, бонд*) дамжуулан оролцуулахаар хуульчилсан байна. Ашигт малтмалын орд нээн илрүүлэгчдэд тухайн ордын хэсэгхэнийг ашиглах эрх олгох ба үлдсэн хэсгийг олон нийтийн өмчлөлд биржээр дамжуулан хувьцаа гаргаж худалдах замаар эзэмшүүлдэг байна.

Хайгуулын болон орд ашиглах эрхийг зөвхөн Канадын иргэд хяналтын багц хувьцааг эзэмшдэг уул уурхайн компани болон Канадын хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргасан гадаадын хөрөнгө оруулалттай компанид олгодог. Цөөн тохиолдлоос бусад үед ашигт малтмалыг хайх, олборлох эрхийг орон нутгийн Засгийн газар компаниудад олгоно. Өөрөөр хэлбэл, энэ нь тухайн муж, эсвэл нутаг дэвсгэрт бага хэмжээний хураамж төлж авсан ашигт малтмалын зөвшөөрөл эзэмшигчид уул уурхай эрхлэх эрх олгогдоно гэсэн үг юм. Энэхүү эрхийг гол төлөв нэг жилийн хугацаагаар олгох ба энэ хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн газартаа бага ч гэсэн ямар нэгэн ажил хийсэн байх ёстой.

Ашигт малтмалын эрэл хайгуулын ажиллагаа байгаль орчинд их хохирол үзүүлэх, газар нутгийг сүйтгэх магадлалтай тул зарим муж хайгуул хийгдэхийн өмнө тодорхой шаардлагууд тавьдаг байна. Тухайлбал, Ньюфаундлэнд гэхэд аюулгүй байдлын урьдчилгаа төлбөр авдаг бол Юконд 2 ба 3 дугаар шатны хайгуулын зөвшөөрөл авдаг.

Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхэд газар, ус, байгаль орчин, аюулгүй байдал, ажиллах хүч зэрэгтэй холбоотой маш олон төрлийн зөвшөөрлийг орон нутгийн болон холбооны засаг захиргаанаас авах шаардлагатай, энэ нь муж бүрт харилцан адилгүй байна. Жишээ нь Онтарио мужид гэхэд л 23 төрлийн зөвшөөрөл шаарддаг. Дээрхи зөвшөөрлүүдийг олгохын өмнө холбооны, мужийн болон нутаг дэвсгэрийн бүх хууль журам хүрээлэн буй орчны үнэлгээг шаарддаг. Энэ үнэлгээг тусгай хуулийн (*Environmental Assessment Acts)* дагуу хийнэ.

Хувийн эзэмшлийн газрын хэвлийг эзэмших эрхтэй иргэдийн газрын хэвлийн баялгийг хайгуулдах, ашиглах эрхийг АНУ-ын адил газар өмчлөлийн хуулиар зохицуулдаг байна.

**Австрали**

Австралийн муж улсууд нь тус тусдаа “Mineral law” буюу ашигт малтмалын хуультай, эдгээр нь хоорондоо зохицуулалтын нарийн ялгаатай боловч ашигт малтмалын хуулийн үйлчлэх ерөнхий хүрээ нь ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа, түүнтэй шууд хамаатай байгаль орчныг нөхөн сэргээх, хаягдал зайлуулах, тээвэрлэх харилцааг зохицуулахаар хязгаарлагддаг тул агуулгын хувьд үндсэндээ хайгуулын болон олборлолтын гэсэн 2 төрлийн тусгай зөвшөөрөл олгогдож байна. (*Зарим муж улсад, тухайлбал, Баруун Австрали мужид эрэх, хайх, хадгалах, олборлох гэсэн 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгодог бол Квинсланд мужид техникийн бус аргаар ашигт малтмал олборлох зөвшөөрлийг тусад нь олгохоор хуульчилсан байдаг*).

Австралийн муж улсуудын ашигт малтмал, газрын тосны хуульд байдаг нийтлэг зохицуулалтуудын нэг нь, хэрэв тусгай зөвшөөрөл олгогч “боломжгүй” л гэж үзсэн бол тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлт гаргагч нь хуульд заасан болзол шаардлагуудыг хэдий хангаж байсан ч тусгай зөвшөөрөл олгогдохгүй байх явдал юм. Захиргааны эрх мэдлийн “хэтийдсэн хэлбэр” хэмээн судлаач мэргэжилтнүүд нь шүүмжилдэг бөгөөд магадгүй энэ нь XIX зууны дунд үед хэт их эрх мэдэл бүхий орон нутгийн захиргааны буюу захирагчийн шийдвэрээр олгодог байсан алтны тусгай зөвшөөрлийн улбаа байж болох юм.

Австралийн Ашигт малтмалын болон Газрын тосны хууль *(Petroleum Law)* дахь хайгуул олборлолтын тусгай зөвшөөрлийн эрх зүйн зохицуулалтад хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсноос хойш нэг жилийн дотор түүнийг шилжүүлэх, барьцаалахыг хориглодог нийтлэг зохицуулалт бий. Энэ хугацаанд лиценз эзэмшигч өөрийн хөрөнгөөр хайгуулаа хийх ёстой. Тэгж чадахгүй бол лицензийг нь буцаан хураан авдаг. Учир нь хайгуулын лиценз анх олгохдоо санхүүгийн чадавхийг гол болгон шалгаруулах бөгөөд эхний жилд хайгуулын ажилд зарцуулах хөрөнгийн доод хэмжээ, заавал хийж гүйцэтгэх ажлыг яг тохирдог тул үүнийг биелүүлээгүй нь тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болдог байна.

**<u>БНХАУ</u>**

1993 оны Ашигт малтмалын хуулиар *(Mineral resources law)* алт, зэс, мөнгө, нүүрс гэсэн голлох нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн ашиглалтын лицензийг хайгуул хийж нээсэн компанид нь давуу эрхтэйгээр олгодог. Ингэхээр сонгон шалгаруулалт өрсөлдөөн байхгүй болох ба тухайн ордоос ашиглах бүтээгдэхүүний үнийг нь Засгийн газар шууд тогтоодог. Ингэж тогтоохдоо алт тийм үнэтэй, зэс ийм үнэтэй гэж нийт ордод баримтлах хатуу тогтоосон заалт байхгүй, тухайн орд болгон дээр нь үнэ тогтоодог. Тухайлбал, уг бүс нутагт дэд бүтэц хөгжсөн, хөгжөөгүйгээс болон нөөцийн агуулга гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалаад өөр өөр үнэтэй байдаг.

Мөн өөр нэг онцлог зохицуулалт нь ашигт малтмалын лицензийг олгохдоо талбайн хэмжээнээс гадна нөөцийн хэмжээг үнэлж олгодог. Тухайлбал, 500 сая тонны нөөцтэй орд нээгээд ашиглалтын лиценз авсан тохиолдолд тэр 500 саядаа л ашиглалт явуулдаг. Уг лиценз бүхий талбайгаасаа дахиад 200 сая тонныг нээвэл түүндээ дахиад лиценз авдаг. Өөрөөр хэлбэл, талбай+нөөц гэсэн бодит хэмжээстэй байдаг байна.

**ДҮГНЭЛТ**

Эдгээр жишээнүүдээс харахад улс орон бүрд ашигт малтмалыг хайх, олборлох, ашиглах процессууд нь тус тусдаа технологитой, бие даасан болохын хувьд тэдгээрт өөр өөр эрх зүйн үр дагавар бүхий тусгай зөвшөөрлүүд олгогддог бөгөөд эдгээрийн агуулга нь тухайн улсынхаа Ашигт малтмалын хуулийн үйлчлэх хүрээнээс хамаарч ялгаатай тогтоогддог байна.

Өнөөдөр манай улсад ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олголт нь хэт замбараагvй шинжтэй болсон бөгөөд тэр тусгай зөвшөөрөл нь ялангуяа, хайгуулын зөвшөөрөл нь ор нэрийн төдий тэр талбайд зөвхөн ганц хоёрхон (*уг зөвшөөрөл эзэмшигчийн бизнесийн сонирхол татсан)* алт, зэс, нvvрс мэтийн ашигт малтмал эрж хайхад чиглэгдэж байна.

Авсан талбайн геологийн, бvтцийн, ашигт малтмалын зэрэг зураг зохиох бусад ашигт малтмалыг илрvvлж иж бvрэн судлах ажил огт хийгддэггvй байна. Зvй нь тэр том талбайд дунд масштабын зургуудыг манай улсад мөрдөгддөг дvрэм зааврын дагуу хийхээс гадна тэнд геофизикийн, геохимийн, уул өрмийн ажлын бvрэн судалгааг хийж геологийн тайлан бичиж тус улсад мөрддөг журмын тусгай зөвшөөрөл өгсөн төрийн захиргааны төв байгууллагын өмнө тайлагнадаг байх ёстой. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрлөөр эрлийн vе шатны маш том талбай авчихаад эрлээ зөвхөн алт, зэсэн дээр хийж байгаа юм. Энэ бол

UIH.MN СУДАЛГААНЫ САН

тусгай зөвшөөрлийн талбайд геологийн судалгааны төрийн бодлого алдагдахын хамт нэг хэсэг талбайд геологийн судалгааны иж бvрэн ажил хийгдэхгvй байгаагаас гадна тэр талбайд өөр ашигт малтмалын судалгаа явуулах сонирхолтой бусад аж ахуйн нэгж төрийн байууллагын судалгаа явуулахыг гадаадын компаниуд зөвшөөрөхгvй байгаа юм.

Үүнээс гадна тусгай зөвшөөрлийг ил тод биш өрсөлдөөнгvйгээр өгч байгаа өнөөгийн процесс нь уг зөвшөөрлийг нэг хvн, аж ахуйн нэгжид хэдэн арав, хэдэн зуугаар нь авахад хvргэжээ. Уг нь хайгуулын тусгай зөвшөөрлийг их хэмжээгээр олгох нь тийм муу явдал биш бөгөөд өнөөдөр олгогдоод байгаа тусгай зөвшөөрлийн дийлэнх нь хайгуулын лиценз байгаа юм. Хайгуулын лицензтэй компаниуд тэр газрыг шууд л ухаж төнхөөд, хөрсийг нь эргүүлчихгүй. Ямар баялаг байгааг тогтооно, хайна, өрөмдөнө. Үүний хүчинд Монгол улсад хэдий хэмжээний, баялаг байгааг тогтоож, мэдээллийн санг бүрдүүлж байна.

Харин ашиглалтын лиценз олголтын хувьд анхаарах асуудлууд нэлээд хэмжээгээр байгаа юм. Өөрөөр хэлбэл, алив нэг этгээд *(хувь хүн, хуулийн этгээд)* өөрийн хүчин чадал бололцооноос хэт давсан ашиглалтын тусгай зөвшөөрлүүд эзэмшиж байгаа нь уг ордод хөрөнгө оруулж олборлож ашиглах ямарч эрмэлзэлгүй, шууд дамлан худалдаж ашиг олох сонирхолтой байгааг нь харуулж байна. Энэхүү нарийн тодорхой шалгуургүй лиценз олголт нь лицензийн наймаа гэх асар их мөнгөний далд бизнесийг цэцэглүүлж байгаа ба манай улс үүнээс ямар нэг үр ашиг хүртэхгүй байна.

Лиценз шилжүүлэлтийг дагасан өөр нэг анхаарал татаж байгаа асуудал нь уул уурхайн, ялангуяа, алтны компаниуд эхний хэдэн жилд ашгаа авчихаад үлдсэн жаахан нөөцтэй лицензэт талбайгаа бусдад шилжүүлчихдэг. Энэ нь байгаль орчны нөхөн сэргээлтээс бултах нэг арга байдаг.

Өнөөдрийн хуульд улсын зардлаар хайгуул хийсэн ордын 51 хүртэл, хувийн хөрөнгө оруулалтаар хайгуул хийсэн ордын 34 хүртэл хувийг төр өмчилнө гэж байгаа нь жишээнд авсан улс орнуудад баримталж буй “ашигт малтмал бол төрийн өмч” гэсэн үзэл баримтлалтай адилтгаж үзэж болох боловч газар доорх баялаг газар дээр гараад ирэхээрээ лиценз авсан аль нэг компанийн өмч болж байгаа нь уг нийтлэг зарчимтай сөргөлдөж байна. Төрийн өмч хувьд шилжиж болно, гэхдээ тэр нь хуулийн хүрээнд байх ёстой. Өнөөдөр тэгвэл манай улсад байгалийн баялаг, ашигт малтмалын талаархи энэ төрлийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж өгөөгүйгээс Монгол улс ихээхэн хэмжээний баялагаас хангалттай үр ашиг хүртэж чадахгүй байгаагийн зэрэгцээ далд бизнес, авилга болон бусад хууль бус сөрөг үр дагаваруудыг бий болгож байна.

## ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд өмнөх хэсэгт дурдсан гадаад орнуудын Ашигт малтмалын хуулиудад буй авууштай зохицуулалтууд болон судалгааны явцад олдсон мэдээллүүдийг нэгтгэн дараах зөвлөмжийг санал болгож байна.

1.Тусгай зөвшөөрлийг олгохдоо эрх хүсэгчдэд уул уурхайн үйл ажиллагаа явуулах санхүү эдийн засгийн болон техник технологийн маш өндөр шалгуур тавих нь зүйтэй юм. **(Франц)** Тухайлбал, байгаль орчны эрсдлээс хамгаалж тусгай эрсдлийн сан байгуулах чадвартай эсэхийг нь харгалзах.

2.Тусгай зөвшөөрлөөр олборлох, ашиглах эрх олгогдож буй орд дээр заавал Концессын гэрээ байгуулах. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, хугацаанаас өмнө цуцлах зэрэгт энэ гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг харгалзан үздэг байх.

3.Тусгай зөвшөөрлөөр өгөх гэж байгаа талбай, ордоо тодорхой хугацааны өмнө урьдчилан зарлаад, тvvнийгээ өрсөлдөөнөөр шалгаруулж олгодог тогтолцоог бий болгох. **(АНУ)**

UIH.MN СУДАЛГААНЫ САН

4. Тусгай зөвшөөрлийг олгохдоо аж ахуйн нэгж, хувь хvнд талбайн болон нөөцийн хэмжээ, тусгай зөвшөөрлийн тоо, тvvнийг эзэмших хугацаагаар нь хязгаарладаг байх. **(БНХАУ)**

5.Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд зохих дvрэм заавар болон гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхийг нь төрийн захиргааны байгууллагууд чиглэл чиглэлийнхээ дагуу хянаж үүнийгээ зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг шууд цуцладаг байх. **(Австрали, Канад)**

6.Тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө буцааж өгөх, борлуулах, шилжvvлэх, цуцлах зэрэг тохиолдлуудад, уг ордыг олборлох ашиглах эрхийг зөвхөн ашигт малтмалын биржээр дамжуулан хөрөнгийн биржийн дvрэм журмаар vнэ хаялцуулах юм уу акци гарган борлуулж байх. **(Канад)**

7.Орд болон нөөцийн төрлөөс хамаарч тусгай зөвшөөрлийг олгох өөр өөр аргуудыг ашиглах. Тухайлбал, байгалийн баялгийг газар дээр гаргах буюу эсвэл борлуулаад мөнгийг нь өмчлөгчид өгдөг ба тэр мөнгөнөөс нь зардлыг нь тооцож хасаад ашгийг нь буцааж өгдөг түрээсийн гэрээний хэлбэрээр ашигт малтмалаа олборлуулах арга. Энэ нь төр байгалийн баялагийн хувьд ямагт өмчлөгч нь байх эрхийг баталгаажуулж буй хэлбэр юм. **(Англи)**

8.Тусгай зөвшөөрлийн харилцааны процессыг ил тод болгох бүх талын арга хэмжээг авах, үүнээс тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл ажиллагааг ил тод, хяналттай байлгах эрх зүйн орчинг бүрдүүлэн улсын төсөвт татварын хэлбэрээр нэмэлт орлого олох боломжийг бий болгох.

**ОХУ болон Төв Азийн зарим орнууд (хуучин социалист орнууд)**[94]
Харьцуулсан улс орнууд: ОХУ, Казахстан, Киргизстан, Тажикистан, Туркменистан, Узбекистан

Энэхүү мэдээлэл нь Британийн The University of Dundee-ийн судлаачид Marla Valdez, Serik Baimagambetov, Denton Wilde Sapte нарын гүйцэтгэсэн судалгааны ажил[95] бөгөөд судлаач миний бие англи хэлнээс орчуулан хүргэж байна.

Эдгээр улс орнууд нь холбооны улс байсан тул хууль, эрх зүйн үндэс суурь ижил төстэй юм. Тусгаар тогтносоноосоо хойш ч төстэй байдлаар хөгжиж байна. Ийм учраас, хуулиудыг нь авч үзэхэд төдийлөн бие биенээсээ онцгойлон ялгардаггүй байна. Хөгжлийн явцыг нь харахад төв Азийн эдгээр орнууд хууль эрх зүйн шинэчлэлийн ажилдаа ОХУ-ын туршлагыг үндэслэн хөгжиж иржээ.

### Төв Азийн улсуудын Уул уурхайн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт

#### 1. Газрын доорх баялагийг ашиглах эрх зүйн ерөнхий зохицуулалт

Тус орнуудын газрын доорх баялагийг ашиглах эрх зүйн зохицуулалт нь төр баялагийн эзэн болохын хувьд ашиглах, олборлох, эрэх хайх зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгждэг. Төр нэгэнт зөвшөөрөл олгосон бол түүнд ямар нэгэн өөрчлөлт, хөдөлгөөн оруулахгүй байх баталгаа гаргадаг байна. Эдгээр орнуудаас Казахстан улсад энэ ажлыг гэрээний үндсэн дээр зохицуулдагаараа онцлог байна[96].

[94] *International and Comparative Mineral Law and Policy: Trends and Prospects. by Bastida, Thomas W. Walde (Editor), Elizabeth Bastida (Editor). Pub. Date: March 2005*
[95] *http://www.dundee.ac.uk/cepp/journal/html/Vol15/article5_2.html. Comparative mineral law of the russian federation and central asian republics. By Marla Valdez and Serik Baimagambetov, Denton Wilde Sapte*
[96] *http://www.orielresources.com/mininglaw.asp*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

2. **Газрын доорх баялагийн эзэн**

Төв азийн бүх орнуудын Үндсэн хуулинд тодорхойлсоноор Төр нь газрын доорх баялагийнхаа эзэн байдаг. Газрын доорх баялагийг ашиглах эрх нь зөвхөн баялагийг олборлох асуудлаар хязгаарлагддаг бөгөөд олборлосон баялагаа борлуулах эрхийг улсаас тусгай зөвшөөрлийн эрх зүйн зохицуулалтыг үндэслэн олгодог.

3. **Газрын доорх баялагийг ашиглуулахад төрийн оролцооны эрх хэмжээ**

Эдгээр орнуудад, газрын доорх баялагийг эрж хайх, олборлох үйл ажиллагаанд төрөөс лиценз олгох, түүнд баталгаа гаргах замаар дэмждэг байна. Харин, орон нутгийн захиргаа газрын доорх баялагийн ашиглалт, хайгуулын ажил болон байгаль орчны асуудалд хяналт тавих эрх эдэлдэг.

4. **Тогтвортой байдлын гэрээ**

Тогтовортой байдлын гэрээгээр хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгө болон тогтвортой үйл ажиллагааг хамгаалдаг. Ерөнхийдөө, энэ асуудлыг хөрөнгө оруулалтын хууль (investment law)-иар зохицуулдаг байна. ОХУ, Киргизстан, Туркменистан болон Узбекстан улсуудын Гадаадын хөрөнгө оруулалтын хуулинд зааснаар тогтвортой байдлын гэрээний хугацааг 7-10 жилээр тогтоосон байдаг. Казахстан улсын хувьд хөрөнгө оруулагч болон төрийн байгууллагын хооронд тогтвортой байдлын ерөнхий нөхцлийг харилцан тогтоодог.

5. **Эзэмших эрхийн хамгаалалт**

Эзэмших эрхийн хамгаалалтад уул уурхайн компаниудын хайгуул хийх, олборлох, боловсруулах, борлуулах бүхий л шатны үйл ажиллагаанд хууль ёсны эрх ашгийг бүхэлд нь цогц байдлаар хамгаалах үйл ажиллагаа хамаарна. Тус орнуудад, газрын доорх баялагийг ашиглагч нь өөрийн олборлосон ашигт малтмалаа борлуулахад давуу эрх эдэлдэг ба гагцхүү татвар болоод хяналтын үйл ажиллагаанд ил тод, шударгаар оролцохыг шаарддаг байна.

6. **Газар доорх баялагийг ашиглах болзол, нөхцөл**

Ерөнхийдөө, судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх эрхийг лиценз эзэмшигчийн оруулсан хөрөнгө, тухайн ашигт малтмалын ач холбогдол зэргийг эрэмбэлсэний үндсэн дээр хоёроос зургаан жилийн хугацаатай олгож, нөөцийг тогтоолгодог. Гэвч, зарим орнуудад бүтээгдэхүүн болон нөхцөл байдлаас шалтгаалж ажил гүйцэтгэгчийн хүсэлт, үүссэн нөхцөл байдал зэргийг харгалзан болзол шаардлагыг өөрчлөх, хугацааг сунгах боломжууд байдаг.

7. **Газар доорх баялагийг ашиглах эрх олгох үндэслэл**

Казахстанаас бусад бүх улсад газрын доорх баялагийг ашиглах эрх үүсэх үндэслэл нь төрийн тусгай зөвшөөрөл буюу лиценз юм. Харин Казахстанд гэрээгээр олгодог[97].

8. **Газар доорх баялагийг ашиглах эрх олгох болон сонгон шалгаруулалтын ажиллагаа**

Туркменистанаас бусад орнуудад газар доорх баялагийг ашиглах эрх олгох үйл ажиллагаа нь сонгон шалгаруулалт болон үнэ хаялцуулах зарчмаар явагддаг.

9. **Эрх шилжүүлэх**

Газар доорх баялагийг ашиглах, эрж хайхтай холбоотой эрхийг шууд шилжүүлэх эрхийг эдгээр улс орнуудын аль нь ч зөвшөөрдөггүй.

10. **Олборлосон түүхий эдийг худалдан авах төрийн давуу эрх**

Зарим улсад нь уул уурхайн компаниудын олборлосон түүхий эдийг төр нь давуу эрхээр (эхний ээлжинд) худалдан авах эрхийг баталгаажуулсан байдаг.

[97] http://www.orielresources.com/mininglaw.asp

UILMN СУДАЛГААНЫ САН

**11. Газар доорх баялагийг ашиглах эрхийг цуцлах, түр зогсоох**

Эдгээр улс орнуудад давагдашгүй нөхцөл байдлын зэрэгцээ орон нутгийн иргэдийн эрх ашгийг хязгаарласан, ноцтойгоор зөрчсөн тохиолдолд төрөөс түр зогсоох эрхийг олгосон байдаг. Харин түр зогсоосон хугацаанд алдаа дутагдал болон үүссэн нөхцөл байдлыг засварлах шаардлагатай. Хэрэв, ингэж чадахгүй бол лиценз ашиглалтын эрхийг зогсоодог.

## II. Дүгнэлт

Эдгээр бүх орнууд нь 1990-ээд оноос хойш эрх зүйн шинэчлэл хийх явцдаа уул уурхайн салбарт ажиллаж байгаа бүх төрлийн хөрөнгө оруулагчдын газрын доорх баялагийг эрэх, хайх, олборлох, ашиглах, борлуулах үйл ажиллагаанд лиценз олгох, ашиглахтай холбоотой харилцааг аль болох тогтвортой, ойлгомжтой байлгах чиглэлд анхаарч ирсэн байна. Нөгөө талаар, уул уурхайн үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтын тогвортой байдлыг хангах, урамшуулах, дэмжих бодлогыг ч баримталж ирсэн байна.

ОХУ нь ирээдүйд лицензийн болон тогтвортой байдлын гэрээний тогтолцоо, дэглэмийг халж концессийн гэрээнийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулахад анхаарлаа хандуулахаар төлөвлөн ажиллаж байна.

**Мэдээллийн эх үүсвэр:**


- http://books.google.mn/books?id=CbBNvKVNrjgC&printsec=frontcover&hl=en#v=onepage&q&f=false
- http://www.orielresources.com/mininglaw.asp
- http://www.dundee.ac.uk/cepp/journal/html/Vol15/article5_2.html.


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ТАВАН ТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ БОДЛОГЫН ХУВИЛБАР
(Бодлогын шинжилгээ)

*Д.Мягмарцэрэн/MA/, Ч.Базар/Ph.D/, С.Дорждагва,*
*Н.Түвшинтөгс, Б.Ариунжаргал/MA/*

## СЭДВИЙН АГУУЛГА

Оршил
1. Үндсэн хэсэг
2. Дүгнэлтийн хэсэг
   2.1. Хөрөнгө оруулалт, орд ашиглалтын хувилбарууд
   2.2. Хувь эзэмшлийн хэмжээ,талуудад ногдох ашиг орлого
   2.3. Үйлдвэрлэлийн явцад гарч болох эрсдэлүүд, зайлсхийх арга зам
3. Судалгааны хэсэг
   3.1. Таван толгойн ордыг ашиглахад шаардагдах дэд бүтцийн асуудлын талаар
   3.2. Оюу толгойн ХОГ болон Таван толгойн ордыг ашиглах ХОГ-ний төслийн байгаль орчныг хамгаалах асуудлын харьцуулалт
   3.3. Таван толгойн уурхайг ашиглах болон Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлагын талаарх харьцуулалт

## ОРШИЛ

Засгийн газраас өргөн барьсан Таван толгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээ УИХ-аар хэлэлцэгдэх гэж буйтай холбогдуулан тус Төвөөс уг асуудлыг судлаж, Ордыг үр ашигтай ашиглах бодлогын хувилбар боловсруулахыг зорьсон.

Судалгаанд орд ашиглахтай холбоотой асуудлуудыг чиглэл бүрээр нь тодорхойлж, тус бүрд нь дүгнэлт, санал зөвлөмж гаргасан ба эдгээрийг нэгтгэн шинжилж Таван толгойн нүүрсний ордыг ашиглах боломжит бодлогын хувилбарыг тодорхойлов. Судалгаа хийгдэж байх явцад Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Таван толгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд орсон ба судалгааны үр дүнг яаралтай гаргах шаардлагатай болсон тул судлаачдын зарим нэг хийсэн ажил анхны гэрээний төсөл дээр суурилсныг анхаарна уу.

Судалгааны багийн ахлагчаар референт-шинжээч Д.Мягмарцэрэн, судлаачаар референт-шинжээч Ч.Базар, референт-шинжээч С.Дорждагва, референт-шинжээч Н.Түвшинтөгс, референт-судлаач Б.Ариунжаргал нар ажиллав.

## 1. <u>ҮНДСЭН ХЭСЭГ</u>

Таван толгойн нүүрсний орд нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос зүүн тийш 100 км-т, Цогтцэций сумын төвөөс баруун урагш 18 км-т, Их Шанхай уулын ойролцоох Цэций уулын баруун хойд тал, Улаан нуурын хөндийд таван жижиг толгойн хэлбэрээр байрласнаас Тавантолгой хэмээх нэртэй болжээ. Нийтдээ 80 мянган га газрыг хамрах уг

орд дээр долоон А буюу ашиглалтын лиценз байгаа.

Тавантолгойн ордын нөөц 6.4 тэрбум тонн. Үүний 1.495 сая тонн нь коксжих нүүрс бөгөөд нөөцөөрөө дэлхийд эхний 10-т багтана. Харин үлдсэн 4.6 тэрбум тонн нь эрчим хүчний нүүрс ажээ. Ордын дөрөвдүгээр давхаргын коксжих нүүрсний баяжмалын гарц нь 67 хувьтай байгаа нь Канад, Австралийн нүүрснээс коксжих чанараараа давуу. Коксжих нүүрсний илчлэг нь 7500-8100 ккал/кг бол эрчим хүчний нүүрсний илчлэг 4900 ккал/кг. Одоогоор эдгээрийн хоёр ордод “Тавантолгой” ХК, “Энержи рессурс” компани олборлолт хийж байгаа. Харин үндсэн таван ордыг ашиглаж эхлэх талаар асуудал яригдаж байгаа юм.

Урьдчилсан байдлаар энэ ордоос жилд 20-40 сая тонн нүүрс ашиглана гэж тооцож байгаа ба энэ нь ойролцоогоор уг ордыг 100 гаруй жил ашиглах боломжит нөөцтэй гэж дүгнэж болох юм. Геологийн судалгааны явцад ордын нүүрсний давхарга бүхий талбайн хил, цар хүрээ бараг бүрэн тогтоосон.

Таван толгойн нүүрсний ордын 4 хэсэгт харьцангуй сайн гүйцэтгэсэн хайгуулын ажил хийсэн. Нэмэгдэх нөөц гарвал математик алдааны хэмжээнээс нүүрсний нөөц нэмэгдэж чадахгүй. Харин доод зэрэглэлээс /C-B, B-A/ түүний дээд зэрэглэлд шилжүүлэх тийм ажил байж болно. Одоогоор судлагдсан ордын бодогдсон нөөц, судалгаа хийсэн үр дүн үйлдвэр байгуулахад ямар ч саад байхгүй.

Нөөцийн хувьд зөв баталгаатай, ордын хэмжээнд хоёр сайн найдвартай хэсэг бий. Тэр нь Цанхи, Ухаа худаг хоёр. Ухаа худаг бол бүх коксжих нүүрсний нийт бодогдсон нөөц, түүний дотор чанараараа шууд коксжих сайн нүүрсний 20%, эрчим хүчний нүүрсний 9,5 % буюу 8,5 сая тн нөөцтэй. Цанхийн хэсэг бол техникийн шинжилгээний үзүүлэлт, нөөцийн хэмжээ, уул-техникийн нөхцлөөрөө дээрхээс дутахгүй. Геологийн тогтоцын хувьд аль аль нь ил аргаар, хамгийн хялбар өртгөөр ашиглах , хамгийн өгөөжтэй хэсэг нь энэ хоёр мөн.

## 2. <u>ДҮГНЭЛТИЙН ХЭСЭГ</u>

### 2.1. Хөрөнгө оруулалт, орд ашиглалтын хувилбарууд

Ордыг ашиглахад эхний ээлжинд ойролцоогоор 1.184 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай ба дэд бүтцийн асуудалд ойролцоогоор 2 тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалтын шаардагдах тооцоо байна. Энэ хөрөнгө оруулалтыг хэрхэн босгох талаар олон янзын саналууд байгаа бөгөөд үүнээс дараах саналыг хамгийн боломжит хувилбар гэж үзэж байна.

Энэ нь нүүрс олборлолт, борлуулалтын чиглэлээр дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, хөрөнгө санхүүгийн өндөр чадавхитай компани болон олон улсын хамтарсан консорциумтай Монгол улсын Засгийн газрыг төлөөлөх “Эрдэнэс MGL” компани хамтарсан үйлдвэр байгуулах замаар хөрөнгө оруулалтаа босгох асуудал болно.

Энэ хувилбараар дэлхийн зах зээл дээр хөрөнгө зээл олох буюу гарсан бүтээгдэхүүнээ борлуулах баталгаа илүү найдвартай. Мөн Монгол Улсын ашиг сонирхол, тусгаар тогтнол олон улсын хэмжээнд давхар хамгаалагдана.

Монгол улс дангаараа дэлхийн санхүүгийн зах зээл дээрээс хөрөнгө босгож, өөрсдөө олборлолт явуулах бүрэн боломжтой гэж үздэг хэсэг байгаа ч бодит байдал дээр энэ нь олон тооны эрсдэл агуулж байгаагаас боломжгүй зүйл юм. Учир нь, хөрөнгө оруулалтад шаардагдах мөнгөний хэмжээ манай улсын ДНБ-тэй тэнцэж байгаа ба дэлхийн санхүүгийн зах зээл дээрээс хангалттай хэмжээний хөрөнгө босгох найдвар бага байна. Үүнд туршлага, нэр хүнд болон бусад асуудлууд хамаарна.

Мөн үүнээс гадна хэрэв боломж байгаад үйлдвэрлэлээ эхлүүлэх хөрөнгөө бий болгоход геополитик, геостратегийн бодлоготой холбоотой тээвэрлэлт, борлуулалтын эрсдлүүд байж болох юм. Эдгээрийг дараагийн хэсэгт тусад нь авч үзэв.

Харин үндэсний аж ахуйн нэгжээ дэмжих замаар эдийн засгийн олон тулгуурт

UHMIN СУДАЛГААНЫ САН

бодлогоо хэрэгжүүлэхэд, монгол улсын ААН, хувийн хэвшлийг нүүрсний олборлолт, баяжуулалт зэрэг үйлдвэрлэлийн ажиллагаа болон уул уурхайг дагалдан гарч ирдэг хот байгуулалт, дэд бүтэц, ХАА, хүнсний үйлдвэрлэл зэрэг бусад маш олон салбар үйлдвэрлэлд 100 хувь оролцуулах боломжтой. Учир нь энэ орд ашиглалтыг дагаад ойролцоогоор 500-800 орчим төрлийн бизнес бий болно гэсэн тооцоо байдаг. Ингэснээр, манай улсын эдийн засаг дан ганц уул уурхайн бүтээгдэхүүний түүхий эдийн үнийн орлогоос бүрдэх эдийн засгийн хэврэг тогтолцоо, түүний нөлөөллөөс ангижрах боломжтой.

Өөрөөр хэлбэл, Тавантолгойн ордыг ашиглахдаа үндэсний компаниудаас бүрдсэн корпораци байгуулан, олборлолтыг гүйцэтгэх, үүнтэй холбоотой бусад нэмүү өртөг бий болгох баяжуулах болон коксын үйлдвэрийг байгуулан ажиллуулах ба харин борлуулалтын болон хөрөнгө босгох асуудлыг олон улсын зах зээл дээр ажиллах туршлага, чадамж бүхий томоохон **Commodity Trader** компанид хариуцуулах хэлбэрээр ажиллах нь нэлээд оновчтой хувилбар юм. Жишээлбэл, ОХУ-ын **"СУЭК"** гэж дэлхийд томд тооцогдох эрчим хүч, нүүрсний салбарын компани байна. Энэ компани байгуулагдаад удаагүй ч дэлхийд эрчим хүч үйлдвэрлээр долоод, нүүрс олборлолтоор тавд орж байна. ОХУ төрийн бодлогоор хувийн болон улсын мэдэлд байсан томоохон хэмжээний ордуудыг нэгтгэж, нэгдсэн нэг том компанийн зохион байгуулалтад оруулсан. Энэ шийдэл нь дээрх компанийг дэлхийд эрчим хүч, нүүрсний салбарын тэргүүлэх хэмжээний томоохон компани болгосон.

Энэхүү үйлдвэрлэлийг явуулахын тулд нэгдсэн нэг удирдлагатай байх ёстой. **"Эрдэнэс МГЛ"** ХХК нь 2009 оны 9 сард *"Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тухай"* гэрээг Норвест компанитай байгуулсан бөгөөд Норвест компаниас Таван толгойн ордыг ашиглахад нүүрсний нөөц нь нэгээс илүү уурхайн үйл ажиллагаа явуулах боломжтой, Цанхийн талбайг бие даасан блокуудад хуваан ашиглах боломжтой гэж дүгнэсэн байна. Харин үүнийг ордыг хэдэн компани консорциумд хуваан эзэмшүүлэх бололцоо гэж үзэж болохгүй юм. Хэд хэдэн уурхай байж болох ч хамгийн гол нь эдгээрийн борлуулалт менежментийн асуудлыг ганц компани хариуцан хэрэгжүүлэх ёстой.

Таван толгойн ордын онцлог нь томдоо байгаа аж. Нэг дороос ийм том ордыг ашиглах нь урт удаан хугацаанд бага зардлаар маш ихийг олзворлоно гэсэн үг. Тавантолгойн хамгийн том давуу чанар энэ. Таван толгойг 10 хуваагаад хаячих юм бол ямар ч үнэ цэнэгүй болно. Аравны нэг шиг нь орд дэлхийд энд тэндгүй, Монголд ч цөөнгүй бий. Нөгөө талаар, ордыг зэрэгцэн эзэмшиж, ашиглаж бй компаниудыг хооронд өрсөлдүүлэх замаар бүтээгдэхүүний үнэ ханшийг эрс буулгах, улмаар нийтэд нь чадавхийг нь бууруулах боломжтой болно.

Ингэж ажилласнаар дотоодын ААН, компаниудад ордоос хэрхэн, хэр хэмжээтэй хувь эзэмшүүлэх тухай бэрхшээлтэй асуудал шийдэгдэн эдгээр ААН-үүд харин ч хувь эзэмшснээсээ илүү их орлого олох боломжтой юм.

Ийнхүү хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүн борлуулалтыг бусдад шилжүүлснээр тухайн хамтарсан компанийн хувь эзэмшил болон ашиг орлого хуваарилалтын асуудал үүснэ.

### 2.2. Хувь эзэмшлийн хэмжээ, талуудад ногдох ашиг орлого

Таван толгойн ордыг ашиглах, хөрөнгө оруулалт хийх сонирхолоо илэрхийлж гадаадын арав гаруй дэлхийн хэмжээний нэр хүнд бүхий том компаниуд, улс орнуудын консорциумууд оролцох саналаа өгсөн байна.

Эдгээртэй хамтарч ордыг ашиглахад хамгийн түрүүнд Монгол улсын хувь эзэмшлийн хэмжээ, хэрхэн хувь эзэмшлийнхээ хөрөнгө оруулалтыг тооцох тухай асуудлууд яригдах учиртай. Үүний дараа эдгээр субъектууд оролцох эсэх нь бодитоор тодорхой болно. Учир нь, Монгол улс уг ордыг ашиглахад оролцох бол хувь эзэмшлийн асуудлыг Оюутолгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээгээр төсөөлж болох талтай. Энэ гэрээн дээр Монгол улс оносноосоо алдсан нь илүү бөгөөд одоо эдгээр алдаануудаас зайлсхийх шаардлагатай. Гэхдээ энэ нь хувь эзэмшилдээ ногдох хөрөнгийг Монгол улс гаргахгүй гэсэн үг биш юм.



UIH.MN СУДАЛГААНЫ САН

Тодорхой хэлэхэд, Монгол улс Таван толгойн ордыг ашиглахад оролцож хувь эзэмшихдээ Оюу толгойн ордыг ашиглах гэрээнд тусгасан шиг хувь эзэмшилдээ ногдох хөрөнгө оруулалтыг шууд мөнгөн хөрөнгө оруулах байдлаар тооцох бус, үүнээс тэс өөр арга замаар оролцох хууль эрх зүйн болоод эдийн засгийн бүрэн эрхтэй.

Энэ нь тухайн нөөц баялгийг Төр 100 хувь өмчилж буй тохиолдолд нүүрс олборлолтон дээр хэрэгжиж буй АНУ-ын **LBA** аргыг Английн ижил төстэй зохицуулалттай холимог байдлаар гаргасан хувилбар юм. Үүнийг дэлгэрүүлэн тайлбарлахад, АНУ-ын газрын хэвлийн баялгийг хайгуулдах, олборлож, ашиглах уурхай байгуулах эрх зүйн зохицуулалтыг 1872 онд гаргасан Уурхайн тухай *(Mineral lands and mining)* хуулиар зохицуулдаг бөгөөд энэхүү хуулиар 1872 оноос өмнө газраа өмчилж авсан иргэдэд газрын доорх баялгийг салгахгүйгээр өмчлөх эрх олгож, харин 1872 оноос хойш газар өмчлөх эрхтэй иргэдийн газрын доорх хэвлийн баялгийг тухайн муж улс буюу АНУ-ын өмч гэж хуульчилсан байна.

Холбооны улс, муж улсын өмчийн газрын хэвлийн баялгийг хайгуулдах, ашиглах тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтаар, өрсөлдүүлж олгодог байна. Газрын тос, байгалийн хий, нүүрс, эрдэс бордоог 1920 оны Конгрессын шийдвэрээр зөвхөн түрээсээр ашиглуулдаг бөгөөд нүүрсэн дээр тус улсад **LBA** гэдэг аргыг хэрэглэдэг.

Энэ арга нь Холбооны улс, муж улсын өмчийн газар доор байгаа баялгийг тухайн Засгийн газрын өмч гэж үздэг бөгөөд уг ордыг ашиглах гэсэн компаниуд уг нүүрснээс худалдаж авах санал тавих замаар ордыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, аль нэг компани хайгуул хийгээд нүүрсний орд газрыг илрүүлсэн бол түрээсийн тендэр зарлаж өгөөч ээ гэж Засгийн газарт хүсэлт тавьдаг. Тендэрт хайгуул хийсэн компаниас гадна хайгуул хийгээгүй компаниуд ч оролцдог. Тендэрт орохдоо 20 хувийн урьдчилгаа төлдөг ба тендэрт шалгуур болгож байгаа гол үзүүлэлт нь газар доор байгаа нэг тонн нүүрсийг хэдээр худалдаж авах вэ? л гэдэг асуудал. Хамгийн өндөр үнэ санал болгосон нь ялдаг бөгөөд хэрэв тэнд нь дэд бүтэц байхгүй бол түүнийг байгуулах өртгөө нүүрсний үнэндээ оруулж тооцох гэх мэтээр компаниуд өөр өөрсдийнхөөрөө үнээ тогтоодог.

Англид Нүүрсний уурхайн тухай хууль нь нэлээд эрт гарсан ашигт малтмалын тухай анхдагч хууль бөгөөд энэ хуулиар ажил гүйцэтгэгчид нүүрсийг хайгуулдах, олборлох, улын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл олгодог бөгөөд энэхүү тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон нүүрсийг худалдан борлуулах, захиран зарцуулахдаа орлого нь шууд тухайн компанийн ашиг болдоггүй. Борлуулалтын орлогыг нөөцийн өмчлөгчид өгдөг ба тэр мөнгөнөөс нь зардлыг нь тооцож хасаад ашгийг нь буцааж өгдөг түрээсийн гэрээний хэлбэрээр ашигт малтмалаа олборлуулдаг байна.

Эдгээр аргууд нь Төр байгалийн баялагийн хувьд ямагт өмчлөгч нь байх эрхийг баталгаажуулж буй хэлбэр юм.

Манай улсын хувьд ашиглалтын ба хайгуулын тусгай зөвшөөрлийг буруу ойлгоод тогтсон хэвшил байгаа ба энэ нь өнөөг хүртэл хуулиудын зөрчилдөөн байдлаар илэрдэг.

Тухайлбал, **“Газрын хэвлийн тухай”** хуулийн 3 дугаар зүйлд *Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар газрын хэвлий нь төрийн өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө мөн. Газрын хэвлийг зөвхөн ашиглуулахаар олгоно. Газрын хэвлийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг хориглоно.*

Харин **“Газрын тухай”** хуулийн *5.1-д Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн. 5.2. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.*

*6.3. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харъяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу газар ашиглагч байж болно.*

*17.1. Улсын Их Хурал газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:*



UIH.MN СУДАЛГААНЫ САН

*гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, концессын гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах;*
**"Ашигт малтмалын тухай"** хуулийн *5.1-д Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн.*

Эдгээр заалтуудаас харахад газар ба түүний хэвлий дэх баялаг Төрийн өмч бөгөөд хэрэв өмчлүүлэх бол үүнээс газрыг зөвхөн Монгол улсын иргэнд өмчлүүлэх ба газрын хэвлийн баялаг Төрийн өмчлөлд байхаар байна. Хэрэв гадаад улсын субъектэд газар ашиглуулах бол зөвхөн УИХ шийдвэрлэх эрхтэй байна. Гэтэл **"Ашигт малтмалын тухай"** хуулийн хэт ерөнхий, бүрхэг зохицуулалтын улмаас *7.1-д Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.*
*26.3-т Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26.1, 26.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан дараахь шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:*
*26.3.3.хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй бол уурхайн талбай олгож, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлүүлэх; 27.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 27.1.4.уурхайн эдэлбэрээс олборлосон цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах;* гэсэн заалтуудаар тусгай зөвшөөрөл олгож, уг зөвшөөршлийг эзэмшигч нь олборлосон бүтээгдэхүүнээ чөлөөтэй худалдан борлуулж буй нь гадаадын хөрөнгө оруулалт бүхий, ашиг орлого нь Монгол улсын хилээс гадна хадгалагдах ААН-д газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг олгох ёстой УИХ-ын бүрэн эрхийг, мөн түүнчлэн газрын хэвлий дэх баялгийн өмчлөгч Төрийн бүрэн эрхийг шууд зөрчиж байна.

Товчоор хэлэхэд, энэхүү тусгай зөвшөөрөл бол ажил, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэхийг зөвшөөрсөн зөвшөөрөл болохоос газар нутгаа, ашигт малтмалыг нь эзэмшүүлэх, өмчлүүлэх эрхийг огт олгох ёсгүй юм.

Иймээс Төр баялгийн өмчлөгч болохын хувьд дээр дурьдсан АНУ, Англи улсад мөрдөгддөг журмыг баримтлан нүүрсийг олборлохоос борлуулах хүртэл бүх шатанд өмчлөгчийн эрхтэй байж, баялаг зөвхөн худалдан борлуулсны дараа ашиг орлого хувааснаар талуудын өмчлөлд очдог зохицуулалттай байх нь зүйтэй.

Ингэснээр, газрын доорх баялаг Төрийн өмч болон баталгаажсныхаа хувьд тодорхой үнэ цэнэтэй болох бөгөөд энэ үнийг ашигт малтмалын **"суурь үнэ"** гэж нэрлэх ба үүнийг тооцон тогтоож анхны хөрөнгө оруулалтад Монгол улсын хувь эзэмшилд ноогдох хөрөнгө болгох нь зүйтэй юм.

Суурь үнийг тогтоохдоо тухайн бүтээгдэхүүний зах зээлд борлогдох үнээс шалтгаалан итгэл үнэмшил бүхий үнийг хувиар буюу шууд тоо заах хэлбэрээр байх нь илүү зохимжтой юм. Жишээлбэл, Таван толгой сайн чанарын коксжих нүүрсний тонн тутам газрын гүнд байхдаа 5,0 ам.доллар, эрчим хүчний нүүрс 3,0 ам. доллар гэх мэт үнэлээд нийт ашиглах нөөцийн хэмжээгээр үнэлж Монгол Улсын хөрөнгө оруулалт гэж өртөгт шингээх ёстой. Энэ бол монголчуудын орд газрыг ашиглахад төрөөс баримтлах хатуу зарчим байлгах хэрэгтэй. Энэ зарчим төрөөс хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй харьцахад барих зарчим юм.

Зэс, алт мэтийн бусад ашигт малтмалын хувьд харилцан адилгүй гарал үүсэл бүхий ордод зориулан харилцан адилгүй үнэлгээг техник-эдийн засгийн үндэслэлээр тодорхойлж төрийн эрх бүхий байгууллага баталгаажуулбал зөв зохистой байх болно. Ашиглах нөөцийн хэмжээнээс шалтгаалан анхны хөрөнгө оруулалтад оруулсан хувь

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хандив нь илүү гарвал тэнцүүлэх буюу бусдад мөнгөөр шилжүүлэх, дутвал нэмж хөрөнгө оруулах шаардлагатай болно.

Ашиглалтын явцад нөөцийн хэмжээ нэмэгдэх, хасагдахад тэр хэмжээгээр монгол талын оруулсан хөрөнгөнд өөрчлөлт орох нь ойлгомжтой.

### 2.3. Үйлдвэрлэлийн явцад гарч болох эрсдлүүд, зайлсхийх арга зам

Үйлдвэрлэлийн явцад гарч болох эрсдэлүүд нь дараах хэсгүүдэд илүү их анхаарал татаж байгаа юм.

a) Олборлолт
b) Ус ашиглалт
c) Тээвэр
d) Борлуулалт

#### *a) __Олборлолт__*

Тухайн орд газрын нүүрсийг үүсгэсэн эх материал болон нүүрсжилт явагдсан геологи, цаг уурын нөхцөл нь өөр байдгаас найрлага шинж чанараараа яг адилхан хоёр орд гэж дэлхийд байхгүй аж. Тавантолгойн ордын тухайд газрын их гүнд нүүрсжин тогтсон боловч газрын гадаргын хөдөлгөөнөөр дээшээ ил гарч ирсэн. Мэдээж хэрэг, гүний уурхайгаас олборлолт хийхэд зардал хөрөнгө их гарна. Харин ил уурхайн олборолт нь аюулгүй ажиллагаа, хөрөнгө хэмнэлт гээд олон давуу талтай. Бусад оронд чанартай, олон жилийн турш бүрэлдэн тогтсон, наалдамхай чанартай нүүрсний орд байгаа ч тэр нь газрын хэт гүнд байгаагаас олборлолт явуулахад зардал их шаардагддаг байна. Энэ нь Тавантолгойн ордын нүүрсийг олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадвар сайтай болгож байгаа аж.

Ийнхүү Тавантолгойн ордыг ашиглахад ил аргаар хамгийн амархан байдлаар олборлолтоо хийнэ, үүнд бэрхшээл байхгүй гэж одоогоор дүгнэж байгаа бол, гол ашиг олох коксжих нүүрсийг олзворлоход түүний дээд өнгөн хэсэгт байх хүрэн нүүрс буюу эрчим хүчний нүүрсийг ашиглах нь зайлшгүй юм. Хэдийгээр энэ төрлийн нүүрсийг гадаад зах зээлд өрсөлдөх чадвар бүхий сайн чанарын экспортын бүтээгдэхүүн. Одоогийн зах зээлийн ханшаар энэ төрлийн нүүрсний үнэ нь нэг тн нь 80-110 ам.доллар байна гэж үзэж байгаа ч биет байдлаар нь экспортод гаргах нь төдийлөн ашигтай биш. Учир нь, хүрэн нүүрс илчлэг муутайгаасаа болоод олон улсын зах зээлд үнэ багатай, удаан хадгалах, хол зөөхөд өөрөө шатах магадлалтай, овор хэмжээнээс болоод тээвэрлэхэд зардал их, учир экспортлоход эдийн засгийн хувьд үр ашиг муутай байдаг.

Иймээс олборлолтын явцад гарах хүрэн нүүрсний үр ашгийг дээшлүүлэх санаа нь Тавантолгойн орд газар дээр энэхүү хүрэн нүүрсэнд түшиглэсэн цахилгаан станц байгуулж, эрчим хүчний үйлдвэрлэл явуулснаар жилдээ ойролцоогоор 200 сая ам долларын нэмэлт ашиг бий болгох гэж тооцоолж байна. Энэ нь одоогийн байдлаар хамгийн оновчтой хувилбар болж байгаа боловч ингэснээр асуудал шийдэгдсэн гэж үзэж болохгүй юм.

Манай улсын хувьд одоогоор ашиглагдаж буй бүх эрчим хүчний станцууд нүүрсэн дээр суурилсан байдаг. Тэгвэл нүүрсний станцуудаас ялгаруулах хүлэмжийн хий нь *(хүрэн нүүрсэнд цацраг идэвхит бодис агуулагддаг)* дэлхий дахинд нүүрлэж буй дулаарал, амьсгалын замын өвчлөл, экологийн тэнцвэрийг алдагдуулдаг тул Киотогийн протоколоор хөгжингүй улс орнуудын хүлэмжийн хийн хэмжээг бууруулах хувийг хуульчлан тогтоосон байдаг байна.

Манай орон нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн хэмжээгээр дэлхийн дунджаас хоёр дахин их гэсэн баримт байдаг байна. Ядуу буурай хэмээн манай улсыг хүлэмжийн хийн торгуулиас чөлөөлсөн байдаг ч цаашид эдийн засгийн нөхцөл сайжрах үед хүлэмжийн хийн торгууль төлдөг болох магадлалтай юм. Мөн Европын улсуудад нэвтрүүлээд буй

UIH.MN СУДАЛГААНЫ САН

нүүрсхүчлийн хийн татвар төлөхөд хүрэх төдийгүй нүүрсний эрчим хүчний өөрийн өртөг үүнийг даган нэмэгдэж болзошгүй юм.

Мөн сүүлийн жилүүдэд дэлхийн тэргүүлэгч улс орнууд Хятадын Засгийн газрыг агаар мандал дахь хүлэмжийн хийг ихээр нэмэгдүүлж, дэлхийн дулааралд шууд нөлөөлж байна хэмээн шүүмжлэх болсноор Хятад улс нүүрсний хэрэгцээгээ мэдэгдэхүйц багасгах зорилт тавин сэргээгдэх эрчим хүч ашиглахыг илүүд үзэх болсон байна. Бүр ойрын таван жилд Хятадын Засгийн газраас байгальд ээлтэй технологиос эрчим хүч гаргах зорилт тавиад байна. Өнгөрсөн оны 9-р сард болсон НҮБ-ын хурлын үеэр Хятадын дарга Ху Жинтао сэргээгдэх эрчим хүч ашиглахыг улс орнуудад уриалж өөрсдөө ч ашиглахаа мэдэгдсэн нь үүнийг баталж байна.

Тэгэхээр, Таван толгойн ордын хүрэн нүүрсийг эрчим хүч гаргахад ашиглах нь ойрын ирээдүйд л ашигтай байхаас цаашдаа энэ нь эргээд дарамт учруулж эхлэх магадлал өндөр байгаа тул одооноос өөр хувилбарын талаар бодож эхлэх нь зүйтэй юм.

Үүнээс гадна энэхүү хүрэн нүүрсийг ашиглах өөр нэг хувилбар нь нүүрсний салбарын томоохон нийлүүлэгчид нүүрсийг угаах, баяжуулах, ангилан ялгаж баяжуулах, мөн түүнчлэн төрөл бүрийн нүүрсийг хооронд нь хольж баяжуулах зэрэг олон төрлийн баяжуулалтын технологийг ашиглан хэрэглэгч, худалдан авагчдынхаа хэрэглээний онцлог, шаардлагад нь тааруулан төрөл бүрийн чанар үзүүлэлт бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Жишээлбэл, БНХАУ-ын нүүрсээр баялаг хойд мужуудын нэг болох Шаньсид олон төрлийн нүүрсийг холин баяжуулж, хэрэглэгчддээ сайн чанарын, тогтмол үзүүлэлт бүхий нэлээд олон төрлийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын болон зүүн өмнөд Азийн зах зээлд нийлүүлж, өндөр хэмжээний ашиг олж байгаа практик ч бий.

Үүний адил Тавантолгойн ордын нүүрсийг Сайншандад тээвэрлэн авчирч, тухайн бүс нутагт байгаа бусад сайн чанарын нүүрстэй хольж баяжуулан, эрчим хүчний брэнд нүүрс болгон экспортод гаргах нь эдийн засгийн хувьд үр ашигтай байхыг дээрх жишээнээс харж болно.

Олборлолтын үе шатан дахь бас нэг анхаарах зүйл нь нүүрс олборлогч буюу оператор компани нь хэн байх вэ гэдэг асуудал.

Юуны өмнө тухайн тухайн оператор компани нь тухайн нүүрсний Худалдан авагч болон хэрэглэгчийн төлөөлөл биш байх ёстой. Ийм компани, консорциум нь тухайн уурхайн олборлолтын зардлыг байж болох хамгийн өндөр төвшинд өсгөж, борлуулах үнийг хамгийн доод хэмжээнд барих бодлого явуулах нь гарцаагүй. Учир нь энэ субъект өөрөө хэрэглэгч учраас Монголоос импортлох нүүрсээ өндөр үнээр худалдан авахыг хүсэхгүй нь ойлгомжтой. Тавантолгойн төсөлд шалгарах компани маань бүтээгдэхүүнээ өндөр үнээр борлуулан ашиг олох сонирхолтой байх ёстой болохоос өөрөө хэрэглэх сонирхолтой байх нь бизнесийн үндсэн утга санаа, зорилгыг алдагдуулах билээ.

Мөн аливаа улс төр, геополитикийн бодлогоос ангид, хөрш орнууд ба бусад компаниудын нөлөөлөлд ороогүй. Өнөөдөр дэлхийд түүхий эдийн төлөөх дайн хаа сайгүй явагдаж байна. Тэргүүлэгч гүрнүүд түүхий эдийн бааз болон эх үүсвэрүүд дээр хяналтаа тогтоох сонирхол их болсон бөгөөд энэ нь улс төрийн бодлогоор халхавчлагдан хэрэгжиж байна. Энэхүү бодлогодоо үндэстэн дамнасан томоохон компаниудыг ашиглаж байгаа нь сүүлийн үед олон жишээн дээр харагдаж байгаа билээ. Ингэж хяналтаа тогтоосноор хямд үнэ бүхий түүхий эдийн эх үүсвэрээр зөвхөн өөрсдийгөө хангах дагавар бааз болгоод зогсохгүй тухайн түүхий эдийн өрсөлдөх чадвар, олзворлолтын хэмжээ, үнийн бодлогод нөлөөлөх, дампууруулах, цаашилбал улс төржүүлэн ашиглалтанд оруулахгүй байх зэрэг сөрөг бодлогуудыг авч хэрэгжүүлэх магадлалтай юм.

Энэ үе шатанд буюу зөвхөн нүүрс олборлоход манай улс өөрөө уг ажлыг гүйцэтгэх 100 хувийн боломжтой бөгөөд дотоодын компаниудын өнөөгийн туршлага, боломж нь ордоос нүүрс олборлох, ашиглах бүрэн боломжтой.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***b) Ус ашиглалт***

Одоогоор ордыг ашиглахад эхний ээлж буюу 2009-2012 онд Балгасын улаан нуур, Наймантын хөндийн усны ордыг ашиглаж болох бөгөөд 75 км шугам хоолойг Тавантолгой руу татаж, хоногт 204 литр секунд буюу 17642 метр куб ус ашиглаж болох тооцоо гаргажээ. Харин 2012-2014 онд Борзонгийн говь, Таван-Алд, Гурамсан, Зайрмагтайн усны ордоос хоногт 39744 метр куб ус татаж болох аж. Гуравдугаар шат болох 2014-2019 онд Мандал-Овоо, Мандах, Бумбатаас хоногт 10627 метр куб ус татахаар төлөвлөжээ.

Тэгвэл саяхан болсон эрдэмтдийн хэлэлцүүлгээр тэрбум гаруй жилийн турш хөрсөнд хуримтлагдсан, гадагш урсац байхгүй говийн усыг хамаагүй хэрэглэвэл дэлхийн дулаарлын энэ үед говийг элсэн цөл болгох аюултай хэмээн анхааруулсан байна. Учир нь, Монгол Улсын нутаг дэвсгэр сүүлийн жилүүдэд Хүннүгийн үеэс хойших хамгийн дулаан үедээ оржээ. Тиймээс 1980-1990-ээд онд хийсэн усны судалгаа өнөөдөр тохирохоо больж байгааг ч эрдэмтэд сануулж байна.

Тийм учраас усны нөөц, эх үүсвэрийг ашиглахдаа орчин үеийн шилдэг техник, технологи хэрэглэхийг хөрөнгө оруулагчдад шаардах, одоогоос 20-иод жилийн өмнө тогтоосон нөөц нь сүүлийн жилүүдэд гарч буй уур амьсгал болон экологийн өөрчлөлтийн улмаас багассан гэсэн эрдэмтдийн тооцоог үндэслэн дахин нөөцийг зөв тогтоох нь шаардлагатай.

Нөгөө талаар нуур гэдэг нь гадаргын усны хуримтлагдсан нөөц бөгөөд энэ нь уур амьсгалаас шууд хамааралтай, хамгийн хэврэг, эрсдэл ихтэй усны нөөц юм. Газрын гүний усны хэмжээ хязгаартай, хөрсний суулт, ан цаваас шалтгаалах эрсдэл ихтэй, өөрөө даралт vvсгэн хөрс, шороогоо тогтоон барьж байдаг нь тvvнийг ашиглахаас татгалзах vндэслэл болдог байна.

Тийм учраас усны нөөц, түүний байгаль орчин, хүн ам, мал амьтанд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг сайтар хийх шаардлага урган гарч байна.

***c) Тээвэр***

Ордоос гарсан бүтээгдэхүүнийг олон улсын зах зээл дээр хүргэхэд тээвэрлэлтийн асуудал ихээхэн анхаарал татаж байна. Гэхдээ энэ нь техник технологийн утгаараа биш геополитикийн бодлоготой нягт уялдаж байгаа юм.

Нүүрсний аж үйлдвэрлэлд олзворлолтоосоо илүү тээвэрлэлт нь чухал байдгаараа бусад ашигт малтмалаас ялгаатай. Энэ нь бүтээгдэхүүний овор хэмжээнээс болж буй хэрэг, зэс шиг баяжуулах, цэвэрлэх гэх мэтээр хэмжээг нь багасгах аргагүй, олзворлосон болгоноо тэр чигээр нь зөөнө. Иймээс тээвэрлэлтэнд хяналтаа тогтоох нь үндсэндээ тухайн ордод хяналтаа тогтоосноос ялгаагүй болдог.

Нөгөөтэйгүүр энэ ордын бүтээгдэхүүн зөвхөн Номхон далайн эрэг хүрч л байж үнэ цэнэтэй болно. Учир нь гол хэрэглэгч нь тэнд бий. Иймээс Тавантолгойн нүүрсийг тээвэрлэх нь олзворлохоосоо хавьгүй илүү ач холбогдолтой, илүү өртөгтэй, илүү хүнд юм.

ОХУ, Монголын хооронд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт хийхэд “Восточный”, “Ванино” боомтуудыг ашиглана хэмээн тохиролцсон. Энэ хоёр боомтын тухайд тээвэрлэлтийн өртөг нь харьцангуй ялгаа багатай юм. “Восточный” боомтын төмөр зам өвөлдөө хөлддөг сул талтай. Гэтэл “Ванино”-г ашиглавал тарифийн хөнгөлөлт эдлэх боломжтой. Эцсийн дүндээ өртгийн зөрүү бага гэж судлаачид тайлбарлаж байна. Нөгөө талаас Орос бол экспортлогч орон. Тиймээс тэнд ямар ч зах зээл байхгүй гэсэн үг. Тус улс жилд ойролцоогоор 300 сая тонн нүүрс олборлож, түүнийгээ Алс Дорнодын дээрх боомтуудаар Хятад, Япон, Өмнөд Солонгос руу нийлүүлдэг. Үүнээс өөрсдөө дангаараа зах зээлээ эзэгнэх боломжтой байтал яагаад заавал манай нүүрсийг нутаг дээгүүрээ тээвэрлэх сонирхолтой байгаа юм бэ гэсэн асуулт ургаж ирнэ. Энэ нь Хятадын өсөн нэмэгдэж буй эрэлт, тээвэрлэлтээс олж болох ихээхэн орлогын хэмжээтэй холбоотой байж болох юм. Нөгөө талаас Тавантолгойн орд газраас зөөвөрлөх нүүрсийг Хятад руу гаргах урсгалыг



UILMN СУДАЛГААНЫ САН

өөрийн хяналтад байлгах, Монголын эдийн засагт, тэр дундаа төмөр замын тээвэрлэлтийн салбарт Хятадын нөлөөллийг хязгаарлах стратегийн ашиг сонирхол бас байж болох юм. Ойролцоогоор 1.5 тэрбум ам.доллараар төмөр зам барьж, Монголын нүүрсийг өөрийн нутгаар тээвэрлэх нь төмөр замын ачааллаа бууруулахгүй, идэвхтэй үйл ажиллагаатай байлгахаас гадна магадгүй Хятадын эдийн засгийг түүхий эд, эрчим хүчний нөөцийн хувьд Оросоос хараат байлгах гэсэн цаад сонирхол байж болох талтайг зарим хүн онцолдог. Манай улсын хувьд нүүрсээ урагшаа, хойшоо хаашаа ч тээвэрлэсэн эцсийн эцэст Хятадын зах зээл рүү л ордог байна. Монгол, Хятад хоёр орны тухайд дамжин өнгөрөх тээвэрлэлтийн асуудлыг зохицуулах тухай тодотгосон 1991 оны хэлэлцээрээс өөр зүйл байхгүй. Тус хэлэлцээрт ч нарийн зүйлсийг тусгаагүй. Саяхан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Хятадад төрийн айлчлалаар очихдоо транзит тээврийн асуудлыг хөндсөн ч бас л тодорхойгүй шийдэлд хүрээгүй байна. Гэтэл Тавантолгойн нүүрсийг хилийн чанадад гаргахын тулд эн тэргүүнд транзит тээврийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

Хятад ба ОХУ-аас транзит тээврийн хөнгөлөлттэй үнэ авч тохиролцохгүйгээр Тавантолгойн бүтээгдэхүүн баялаг болохгүй. Хоёр хөршийн төмөр замын тээврийн сүлжээний графикт албан ёсоор ороогүй цагт нүүрс үнэ цэнтэй эд биш. Яг энэ гол асуудал дээр Засгийн газрын түвшинд яриа хэлэлцээр ямар нэг ахиц олоогүй байна. Шалтгаан нь, ОХУ ба БНХАУ Тавантолгойн сонгон шалгаруулалтаас операторын эрх авах үндсэн болзлоо өнөөх манай талын санал болгосон угтуулан тавих нөхцөлүүдээр эргүүлээд илэрхийлж байгаа юм. Хэрвээ Оросын компанийг сонгохгүй бол Алс Дорнодын уудам замаар Тавантолгойн нүүрсийг дотоодын тээврийнхээ тарифыг гурав дахин нугалсан өндөр үнээр зөөнө. Хятадын компани оператор болоогүй нөхцөлд тус улсын төмөр замын тээврийн маш их ачаалалтай график Тавантолгойн нүүрстэй вагон хэзээ ч нэвтэрч чадахгүй. Далайн боомт ашиглах боломжийг ч Монголын нүүрсэнд тийм амархан олгохгүй.

Иймээс тээвэрлэлтийн хувьд шийдэх хамгийн гол асуудлууд нь Тавантолгойн нүүрсний транзит тээврийн үнийг бууруулах буюу тогтвортой хямд байх эсэх, Тавантолгойн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд нэвтрүүлэх боомтуудын зөвшөөрөл авах тухай явдал юм. Үүнийг ойрын хугацаанд яаралтай шийдэхгүй орд ашиглалтын асуудал тодорхойгүй болох ч аюултай байна.

### ***d) <u>Борлуулалт</u>***

Бүтээгдэхүүн борлуулалтын асуудлыг шийдэхэд хэрхэн борлуулах вэ гэхээсээ илүү хэнээр хийлгэх вэ гэдэг нь хамгийн чухал анхаарал татаж байна.

Энэ субъектэд тавигдах наад захын шалгуур нь Орос, Хятад болон түүнчлэн гурав дахь зах зээлд нэвтрэн нүүрсээ хамгийн сайн буюу дээд үнээр борлуулах чадвар туршлагатай байх явдал юм. Мөн тухайн зах зээлийн нөхцөл байдлын талаар сайтар мэдээлэлтэй, борлуулалтын сувагтай байхаас гадна ялангуяа худалдааны томоохон компаниуд буюу Commodity Trader-үүдтэй сайтар холбогдон ажиллах чадвартай байх ёстой. Commodity Trader нь мэдээлэл судалгаан дээр тулгуурлан дэлхийн аль ч зах зээлд түүхий эдийн үнийг хамгийн өндрөөр тогтоон борлуулдаг мэргэшсэн байгууллагууд юм.

Хэдийгээр Хятад улс гол зах зээл гэдгийг хүн бүхэн ойлгож байгаа ч энэ нь Хятадын компани л заавал хятадын зах зээлд борлуулах ёстой бас чадвартай гэсэн үг биш. Хятадын зах зээлд дэлхийн уул уурхайн олон компаниуд амжилттай ажиллаж, түүхий эдээ нийлүүлж байгааг бодолцож үзэх ёстой.

Таван Толгойн төсөлд өрсөлдөж байгаа компаниудын аль нь ч гэсэн уул уурхайн салбарт туршлагатай, нэр хүндтэй бөгөөд дэлхийн өнцөг булан бүрт төрөл бүрийн уул уурхайн төслүүдийг янз бүрийн техник технологи, аргачлал ашиглан хэрэгжүүлж байгаа. Гэхдээ аль нь хамгийн өндөр үр ашигтай ажилладаг вэ гэдгийг нь харьцуулсан байдлаар үзэх хэрэгтэй. Тухайлбал, өрсөлдөж буй хоёр компанийн нэг компани нь нөгөө компанийхаа ашиглаж байгаад ашиггүй гэж үзээд орхисон уурхайг авч өндөр ашигтай

ажиллуулах тохиолдлуудаас үзэхэд зөвхөн техник технологид бус менежментийн асуудалд бас гол анхаарлаа хандуулах.

Засгийн газартай харьцуулахад компани нь олон улсын зах зээл дээр бүтээгдэхүүнээ зарж сурсан туршлагаар илүү байх нь ойлгомжтой. Засгийн газар аж ахуйн чанартай үйл ажиллагаа буюу борлуулалт хийх үр ашиггүй байж мэднэ. Компаниар бүтээгдэхүүнээ борлуулуулаад мөнгийг авах нь байж болох хувилбар. Гэхдээ ямар үнээр зарахаа гэрээн дээр нарийн зааж өгөх хэрэгтэй. Хэрвээ цаад тал нь нэг талаар олборлогч, нөгөө талаас хэрэглэгч байх юм бол зах зээлээс өөр үнэ хэрэглэх магадлалтай. Зах зээлийн үнэ гэдэг нь нийтэд ил, хэн ч хараад мэдэх боломжтой байвал илүү оновчтой. Нүүрсний хувьд үнэ нэг бус олон зах зээлд тодорхойлогддог. Тиймээс хянах механизм байх хэрэгтэй. Ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй нөхцөлтэйгээр хөрөнгө оруулагчаа сонговол энд нэг их асуудал үүсэхгүй байх. Мөн ашиг орлогоо хуваахдаа компани зардлаа нөхсөний дараа үлдсэн хэсгийг хуваах зарчим баримталж байгаа энэ тохиолдолд зардлыг хянах ёстой. Компани зардлаа хэт өсгөвөл Засгийн газарт ногдох хувь багасах талтай.

Зах зээлийн үнээр борлуулах, зах зээлийн үнэ гэж юу болох, нүүрсийг урьдчилан борлуулж болох эсэх, барьцаалж болох эсэх, Засгийн газарт ногдох нүүрсийг урьдчилан зарах, барьцаалж болох уу гэсэн асуудлуудыг гэрээн дээр нарийн тусгаж өгөх хэрэгтэй юм. Манайд байгуулж байгаа гэрээнүүдэд зарчмын хувьд зөв заалт зөндөө байгаа ч эцсийн дүндээ татвар авна гээд бичсэн байдаг ч тэр татвараа яаж авахыг нарийн зааж өгдөггүй. Хуульд ч тодорхой биш туссан болохоор татварын алба нэг журам гаргаад явдаг. Эргээд журам яаж гарахаас тухайн төслийн үр өгөөж яаж гарах, ямар байх нь хамаардаг. Хуульд заагдаагүй бол гэрээнд нарийн зааж өгөх ёстой. Гэрээнд нарийвчлан тусгаад явбал хэрэгжүүлэхэд аль аль талдаа амар байх болно.

Борлуулагчийг энэ байдлаар сонгон борлуулалтын асуудлыг шийдвэрлэж болох ч энэ асуудал дээр хамгийн их санаа зовох зүйл нь одоогоор цаг хугацааны асуудал байна.

Өнөөдрийн байдлаар манайх Хятадын зах зээлд нүүрсээ гаргаж байна. Тэгвэл энэ зах зээл дээр манай улс нүүрсээ борлуулахад эрсдэл бий болох нөхцөлүүд бүрдээд байна.

2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэглээ 47%-иар өснө. Жил бүр 1.89%-иар их эрчим хүч зарцуулна гэсэн үг. Хятад, Энэтхэг зэрэг OECD-ийн гишүүн биш орнуудын хувьд жилийн өсөлт 3%-иас илүү байх аж. Хятад улс эрчим хүчний хэрэгцээгээрээ 2030 он гэхэд АНУ, ОХУ, Энэтхэг, Япон улсын дараа орох төлөвтэй байна. Тиймээс хятадууд ойрын ирээдүйд атомын цахилгаан станцынхаа тоог 12-оор нэмэгдүүлэхээр зорьж байна.

Хятадын Цөмийн эрчим хүчний корпораци Хятадын цөмийн хүчин чадлыг ашиглан эрчим хүчээ 2020 он гэхэд 5 дахин, 2030 он гэхэд дахин 3-4 дахин нэмэгдүүлнэ хэмээн зарлаж байна. Уг байгууллагын Дэд Ерөнхийлөгч Lui Xuehong 2007 онд явагдсан "Алтернатив эрчим хүчний Лондонгийн уулзалт" дээр ураны нийлүүлэлтийн асуудлаар Монгол түүнчлэн Намиби, Өмнөд Африк, Мозамбик, Ботсван, Чад болон Төв Африкийн БНУ-уудтай идэвхтэй хамтран ажиллахаа мэдэгджээ.

Цөмийн реакторууд барьж, ажиллагаанд оруулахад Хятад улс 52 тэрбум ам доллар зарцуулах төлөвтэй байна. Ингэснээр эрчим хүчний нүүрсийн хэрэглээ нь эрс багасах нь тодорхой юм.

Харин коксжих нүүрсийн хувьд, Хятадын нүүрсний ассоциацийн тэргүүн саяхан нэг илтгэлдээ “2010 онд Хятад улс нийт дүнгээрээ 3,6 тонн нүүрс хэрэглэнэ. Хятадын Засгийн газар 7-8 жилийн өмнөөс 13 нүүрсний ордыг сонгож хөрөнгө оруулалт хийсэн. Үүний үр дүнд өнөө жил 3,6 тэрбум тонн нүүрс олборлоно. Үүгээрээ дотоодын зах зээл, гадаадын экспортоо бүрэн хангах боломжтой” гэж ярьсан. Ингэхээр 2011 оноос эхлээд Хятад манайхаас нүүрс авах асуудал эргэлзээтэй болж байна. Одоо яагаад аваад байна гэхээр нэгдүгээрт манай нүүрсний үнэ хямд, хоёрдугаарт дотоодын байгалийн баялгаа яаравчлан нээх бодолгүй байна гэсэн үг.

UILMN СУДАЛГААНЫ САН

Тавантолгойн ордод хөрөнгө оруулалт хийхээр санал **“Шиньхуа Энержи”** бол Хятадын төрийн мэдлийн компани. Хятад улсын хувьд сүүлийн жилүүдэд нүүрсний жижиг уурхайнуудаа түр хугацаагаар хааж, төрийн мэдэлд авах нь ихэсч байгаа. Тус улс энэ оны эцэс гэхэд нийт нүүрсний уурхайнх нь 80 хувийг бүрдүүлдэг жижиг уурхайнуудын тоог 10 мянгаас доош болгож цөөлөх зорилт тавьсан ба саяхан 7000 орчим уурхайг хаах мэдэгдэл гаргасан. Жижиг уурхайнууд нь чанар муутай нүүрс гаргадаг, нөхөн сэргээлт хийхэд хөрөнгө зардаггүй, зөвхөн ашгийг нэгдүгээрт тавьдаг зэрэг олон сөрөг талтай аж. Үүний цаана нуугдаж байгаа хамгийн гол санаа нь коксжсон нүүрсний нөөцөө хадгалж үлдэх явдал юм. Ингэж үзэх үндэс нь 2008 онд коксжсон нүүрсний импортод 40 хувийн татвар ногдуулах шийдвэр гаргасантай холбоотой. Тухайн үед Хятад дэлхийн коксжсон нүүрсний нийлүүлэлтийн тал хувийг гаргадаг байсан бол энэ хэмжээ эрс буурсан байна. Тодорхой хугацааны дараа илүү шилдэг техник технологиор жижиг уурхайнуудаа сайжруулсан Хятад нүүрсний зах зээлд түрэн орж ирнэ.

Нүүрсний үйлдвэрлэл нь зах зээлийн үнэ ханшаас их хамааралтай, асар их хөрөнгө оруулалт, дэд бүтэц шаардсан эмзэг төсөл. Хятадын аварга зах зээл хажууд байнаа гэж ярьдаг. Гэтэл хятадууд өөрсдөө жилд ойролцоогоор 400 сая тонн коксжих нүүрс олборлож байгаа. Жилд мөн л 400 орчим сая тонн коксжих нүүрс хэрэглэдэг. Тэгэхээр манай нүүрсгүйгээр тэд амьдрахгүй, эдийн засаг нь уначихгүй гэдэг нь тодорхой. Хятадад дотоодын нөөцөөс гадна олон тооны боомттой учир гаднаас бас нүүрс экспортлох бололцоо тэдэнд бий. Ганцхан манайхаас хамаарахгүй гэдгийг маш сайн ойлгох ёстой. Хэрэгцээ өндөр байгаа цагт Австрали болоод бусад улсын үйлдвэрлэгчээс нийлүүлэлт хангалттай ирж л таарна.

Тиймээс үнэ ханш нь гайгүй байгаа дээр бид бүтээгдэхүүнээ борлуулж эхлэхгүй бол эргээд зардлаа нөхнө гэдэг тун ч амаргүй байх болно. Хамгийн болгоомжлох зүйл бол дэд бүтцэд их хөрөнгө хаячихаад хэдэн жил баталгаатай нүүрсээ авах вэ, үнэ нь ямар байх вэ гэдэг чинь уялдаатай, нарийн тооцож хөдлөхөөс аргагүй асуудал. Өнөөдөртөө сүүлийн 2-3 жилд коксжих нүүрсний ханш сайн байсан болохоор BHP, Мицуи гээд дэлхийн томчууд сонирхоод байна. Үргэлж ийм байхгүй гэдгийг бодож үзэх хэрэгтэй.

Хэрэв үнэ ханшийн таатай мөчлөгтэй уралдан бизнес хийж чадвал монголчууд мөнгө босгоно. Эрэлт хэрэгцээ нь хумигдсан үед яаж ч зүтгээд нэмэргүй. Нөгөө талаас, 20-30 жилийн дараа байдал ямар болохыг өнөөдөр хэлэхэд хэцүү юм. Өнөөдрийн хувьд бий болсон энэ тааламжтай нөхцөл байдлыг маш ухаалаг ашиглаж хөрш орнууд болон гуравдагч түнш нартайгаа хамтран эдийн засгаа эрчимтэй хөгжүүлж үндэсний аюулгүй байдлын баталгаагаа материаллаг гэж хэлж болох үндэс суурьтай болгож амжих хэрэгтэй байна. Эдийн засгаа хөгжүүлж, олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны интеграцид бүрэн эрхэт гишүүнээр орж байж манай орны эдийн засгийн аюулгүй байдлын олон улсын баталгаа бий болно. Эдийн засгийн аюулгүй байдал хангагдсанаар улс орны үндэсний аюулгүй байдал баталгаажна.

UIL.MN СУДАЛГААНЫ САН

## 3. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### 3.1. Тавантолгойн ордыг ашиглахад шаардагдах дэд бүтцийн асуудлын талаар

Судлаач: С.Дорждагва референт-шинжээч

Тавантолгойн орд газрыг ашиглах нь нэгэнт тодорхой болсон гэж болно. Одоо зөвхөн хэрхэн ашиглах вэ? гэдэг хувилбараа тогтох асуудал үлдээд байгаа гэж ойлгож болно.

Тус орд газрыг ашиглахад хамгийн эхэнд хийгдэх ажлууд бол дэд бүтцийн асуудал. Түүн дотроо цахилгаан, усны асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй байна.

Дэд бүтэцтэй холбоотой үндсэн гурван том асуудал байгаа юм. Үүнд:

1. Төмөр зам, авто зам
2. Цахилгаан болон дулаан хангамж
3. Усан хангамж

*Төмөр зам*

Тавантолгойн ордыг ашиглахад хамгийн эхний шаардлагатай дэд бүтэц нь төмөр зам бөгөөд УИХ-аас энэ талаар баримтлах бодлогын үндсэн суурийа баталж гаргаад байгаа. Гэхдээ царигийн асуудлыг нэг мөр хараахан шийдээгүй байгаа.

Олон улсад, тэр дундаа манай орны газар нутгийн орчмын бүсэд Транс-Азийн төмөр замын олон улсын хэлэлцээр мөрдөгдөж байдаг. Уг хэлэлцээрт заасан олон улсын ач холбогдолтой транс шугамыг тус хэлэлцээрийн Хавсралт №1-д тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол улсын говийн бүс нутгаас гарах ашигт малтмалыг тээвэрлэх хамгийн ойр замууд нь дараах байдлаар тодорхойлогдсон байдаг. Үүнд:

Тус хэлэлцээрийн Хавсралт №1-д зааснаар Монгол улсын олон улсын ач холбогдолтой төмөр замын шугамыг Сүхбаатар-Замын Үүд чиглэлийн замыг гэж тодорхойлсон байдаг. Энэ зам дараах чиглэлээр явна.

(Наушк, ОХУ)
Сүхбаатар (хилийн өртөө)
Улаанбаатар
Замын Үүд (хилийн өртөө ба өөр царигтай төмөр замтай холбогдох газар)
(Эрээн хот, Хятад)

Манай хоёр хөршийн хувьд олон улсын ач холбогдолтой төмөр замыг тус баримт бичигт дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

*Бүгд Найрамдах Хятад Ард Улс:*

- Алашанку (Казахстан) – Льяньюган (Хятадын зүүн өмнөд эрэг)
  - *Энэ сүлжээ нь Казахстаны хилээс Хятадын баруун хойд хэсгээр (Бээжингээс урдуур) урагшлан төв хэсгээр явaад зүүн өмнөд эрэгт хүрдэг. Монгол улсын хилд хамгийн ойр очих цэг нь Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт орших Бургастайн боомтын орчим юм. Харин энэ сүлжээний туслах сүлжээ замууд нь Монгол улсын өмнөд хилийн дагуу явж байгаа. Гэхдээ энэ зам нь тус хэлэлцээрт тусгагдаагүй болно.*
- Эрээн хот – Дандон (Хятадын зүүн хэсэг, БНАСАУ-тай залгаа хэсэг)
  - *Энэ зам нь Монголын төмөр замын сүлжээний үргэлжлэл, манай улсын урд хилээс Бээжин хотоор дамжин Тяньжин хүрээд зүүн тийш эргээд БНАСАУ-ын хил хүрнэ*
- Манжури – Дальян
  - *Энэ зам нь ОХУ-ын хил залгаа Манжуураас Дальяны далайн боомт хүрдэг ба БНАСАУ-ын хилтэй ойролцоо байдаг. Энэ сүлжээнд манай улсын Дорнод аймгаас эхлэсэн төмөр зам холбогддог.*

*Оросын Холбооны Улс:*

- Красное – Находка
  - *Энэ зам нь Монголын хойд хилийн дагуу явсаар Находка төмөр замын зангилаа болон Владивосток, Восточный далайн боомтуудад хүрдэг*

Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 2 дугаар зүйлд зааснаар *"Хэлэлцэн тохирогч талууд ... олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамыг хөгжүүлэх үүрэгтэй ..."* гэжээ. Мөн Хавсралт №2-

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ын 4 дүгээр зүйл-Авцалдан зохицох байдал гэсэн хэсэгт *"...Талууд хөрш зэргэлдээ орнуудын болон олон улсын ач холбогдолтой төмөр замын шугам дайран өнгөрч байгаа бусад орнуудын техникийн шаардлагыг харгалзан үзэх бөгөөд төмөр замын хоорондын техникийн саад хязгаарыг арилгах болон авцалдан зохицох байдлыг хангахын тулд шугамыг сайжруулахад хүчин чармайлт гаргана..."* гэжээ. Үүнээс үзвэл Монгол улс энэ хэлэлцээрт оролцогч улс болохын хувьд дээр дурьдсан төмөр замын шугамаа ачаа тээвэрлэлтэд учирах аливаа саад бэрхшээлийг арилгах, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх үүрэг хүлээнэ гэсэн үг. Хэдийгээр энэ нь үүрэг болovч нөгөө талаараа энэ ажлыг хийснээр Монгол улсад тусах ашиг өндөрсөнө гэсэн үг.

Монгол улсын Төмөр замын салбарын гол эрх зүйн баримт бичиг нь Төмөр замын тээврийн тухай хууль[98] юм. Уг хуулиар төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Төмөр замын сүлжээг өргөтгөх, суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтоодог. Энэхүү төмөр замын шугамын чиг нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2.-т заасанаар "*Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно*" гэж тодорхойлсон байна. Үүнээс үзвэл одоогийн байгуулахаар төлөвлөж байгаа говийн бүсэд хамаарах стратегийн ордуудаас гарах ашигт малтмалыг олон улсын зах зээлд экспортлоход шаардагдах төмөр зам нь дотоодын нийт бүтээгдэхүүнийг эрс өсгөх ач холбогдлоороо "*Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтэц*" мөн юм.

Монгол Улсын Их Хурлаас баталсан Төмөр замын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлоход Засгийн газраас анх санал оруулж ирэхдээ дээрх хуулийн заалтын дагуу "үндсэн чиглэлийг" тогтоож оруулж ирсэн. Нэгдсэн сүлжээ нэгдсэн нэг царигтай байх ёстой гэсэн зарчмыг судлаачид тавьдаг. Энэ нь "Төмөр зам бол бизнес биш улс орны бодлогын салбар юм. Иймд царигийн асуудал бол үндэсний эрх ашиг юм" гэсэн зарчмаас үүдэлтэй хэмээн тайлбарлаж байна. (Энэ тухай интернетэд тавигдсан мэдээллүүд, тэдгээрт өгсөн үнэлэмжүүдээс тодорхой харагдаж байна)

УИХ-аас саяхан Төмөр замын талаар ямар бодлого баримтлахаа үндсэндээ тогтлоо. Гагцхүү царигийн асуудлаа цаашид яаж явахаа л шийдэх үлдсэн гэж болно. Дэлхийн банк зөвлөхдөө "Нүүрсний уурхайн үнэ цэн төмөр замын зардлаас хамаарна. Монголын өмнөд бүсийн Тавантолгой, Нарийн сухайт, Оюу толгой, Цагаан суваргын уурхайн үйлдвэрлэл жилд таван тэрбум долларын нүүрс, зэсийн борлуулалт хийх боломжтой тооцоо гарчээ. Үүний тулд дэд бүтцийн хөгжилд наад зах нь тав орчим тэрбум долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. "Өнөөдөр Монголын эдийн засгийн жилийн нийт үйлдвэрлэл нь ойролцоогоор тав орчим тэрбум доллар байгаа нөхцөлд дэд бүтцийн хөгжлийн эхний хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх нь нүсэр асуудал. Тиймд үүнийг ажил хэрэг болгохын тулд чухам аль хөрөнгө оруулалтыг чухалчлах, хэн төлөвлөгөө бэлтгэх, хөрөнгө оруулалтыг хэрхэн санхүүжүүлэх зэрэг асуудал тодорхой байх хэрэгтэй" гэжээ[99].

<u>*Цахилгаан болон дулааны хангамж*</u>

Ямар ч нөхцөлөөр энэ ордыг ашиглах болсон гэсэн цахилгаан дулаан нь шийдэгдээгүй бол хугацаа алдах томоохон эрсдэл учирна. Цахилгаан станц барих ажил бол нэг барилга барихтай ижил ажил биш бөгөөд түүнд наад зах нь 3 жил, түүнээс илүү хугацаа шаардагдах тул одооноос ажлыг эхлүүлэх хэрэгтэй. Тавантолгойн ордыг

[98] 2007 оны 07 сарын 05-ны өдөр батлагдсан
[99] http://www.mongolia-investment.com/index.php?option=com_content&task=view&lang=mn&id=1595



UB.MN СУДАЛГААНЫ САН

ашиглахаар төлөвлөж байгаа уурхайн хүчин чадлын хэмжээг тооцож үзэхэд 600 МВт-аас багагүй хүчин чадалтай байх хэрэгцээ байгаа гэсэн тооцоог хийсэн байдаг.

Үүний тулд эхний ээлжинд дулааны цахилгаан станц ба түүнд шаардагдах усны нөөцийн асуудлыг шийдэх хэрэгтэй байна. Үүний тулд эдгээр ажлыг гүйцэтгэх зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, түүнд шаардагдах төсвийг баталж өгөх хэрэгцээ байна.

Усны хувьд Тавантолгойн ордоос 80 км-ийн зайтай Балгасын улаан нуураас ус татах байгууламжийг барих боломжтой гэдэг нь үндсэндээ тогтоогдсон.

Энэхүү Цахилгаан станцын хүчин чадлын хувьд үндсэн 2 бүтээгдэхүүн болох цахилгаан болон дулаан хоёрын гарцыг тооцож үзвэл цахилгаан нь угаас тус уурхайн хэрэгцээг хангах хэмжээнд хийгдсэн бол нөгөө нэг бүтээгдэхүүн болох “дулааны эрхчим хүч”-ийг бүрэн ашиглах асуудал тулгарна.

Тус бүс нутаг, уурхайн орчимд алс хэтдээ 40-50 мянган хүн хамгийн багадаа ажиллаж амьдрах магадлалтай. Өөрөөр хэлбэл нэгэн томоохон суурин хот бий болно. Гэхдээ эдгээр оршин суугчдын дулааны хэрэглээ энэ хэмжээнд хүрэхгүй. Үүнээс гадна нэгэн боломж байна.

Энэ бол хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, түүнийг дулаанаар 4 улирлын турш хангаж байх боломж. Гэхдээ, энд яригдаж байгаа хүлэмж бол өнөөгийн манайд байгаа бичил хүлэмж бус хэдэн зуун га талбайгаар хэмжигддэг, дотроо газар тариаланд зориулсан трактор гэх мэт техникүүд нь чөлөөтэй явж байдаг тийм том хэмжээний хүлэмж юм. Үүнийг хөгжүүлсэнээр уурхайн гол нөөц болсон ажиллах хүчээ баталгаатай, найдвартай хүнсээр хангах бүрэн боломж олгож өгнө.

Цахилгаан станцаа газар дээр нь барихаас өөр аргагүй юм. Учир нь тодорхой үе давхрагуудад эрчим хүчний нүүрс, хагас коксжих нүүрс, коксжих нүүрс гэж хуваагдсан байгаа. Коксжих болон хагас коксжих нүүрсийг авахад дээд өнгөн давхаргад байгаа эрчим хүчний нүүрсийг зайлшгүй авах хэрэгцээтэй. Үүнийг хаягдал болгож хувиргахгүйн тулд хүссэн хүсээгүй ашиглах болно. Энэ байдлаас үзвэл Цахилгаан станцын хүчин чадлыг дээр төлөвлөснөөс ч илүү их байлгах хэрэгцээ гарах магадлалтай. Энэ нь цахилгаан-эрчим хүчийг экспортлох боломжийг ч бүрдүүлэх магадлалтай.

Өнөөдрийн байдлаар Ухаа худагийн уурхайд зориулж Энержи ресурс консорциум 12МВт-ын цахилгаан станцыг байгуулж энэ ондоо багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөж ажиллаж байгаа. Энэ станцын нэг онцлог бол говийн нөхцөлд, хөргөх ус бага хэрэглэдэг технологитой ажээ. Тодруулбал, хөргөлтийн систем нь хуурай, агаарын хөргөлтийн системтэй бөгөөд хөргөлтийн ус үндсэндээ шаарддаггүй технологитой. Энэ бол говийн ус ховортой нөхцөлд хамгийн тохиромжтой байж болох технологийн шийдэл юм.

Оюутолгой, Тавантолгойн ордуудыг эрчим хүчээр хангах төсөл хэдий бэлэн болсон ч санхүүжилтийн асуудлаа шийдвэрлэж чадаагүй байна. 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын зураг төсөл хийх, барьж байгуулах гүйцэтгэгч нь тодорсон ч Засгийн газар баталгаа гаргаагүйтэй холбогдон ажлаа эхлээгүй байна. Төлөвлөж байгаа эрчим хүчний эх үүсвэрийг байгуулж цахилгаан дамжуулах агаарын шугамыг төвийн эрчим хүчний системд холбох нь цаашдаа өнөөдөр бий болоод байгаа төвийн бүсийн эрчим хүчний хомсдлыг ч давхар шийдэх бүрэн боломж байгааг судлаачид тодорхойлж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Усан хангамж*

Тус районд усны нөөцийн талаар багагүй судалгаа хийгдсэн байдаг. Тус ордоос 80 км зайтай Балгасын улаан нуур гэдэг газраас ус татах боломжтой ба үүнийг эхний хувилбар гэж үздэг. Нөгөө талаар “Даланзадгад” гэдэг нэр нь “Далан задгай нуур” гэдэг үгнээс гаралтай ба энэ орчимд усны нөөц хангалттай байгаа гэж геологичид үздэг.

Гэхдээ говийн бүс усан хангамж тийм ч сайн биш тул Дулааны цахилгаан станцын

зэрэгцээ хэрэглэсэн усаа цэвэршүүлээд дахин ашиглах технологийг давхар шийдвэрлэх хэрэгцээг бий болгох нь гарцаагүй байгаа юм.

Нөгөө талаар цахилгаан станцын хөргөлтийн хуурай технологийг сонгож байгуулж чадвал усны хэрэглээг эрс багасгах боломж байгааг Ухаа худагт байгуулж байгаа цахилгаан станцын жишээнээс харж болох юм.

Тус бүсэд хийсэн хайгуулын ажлаар илрээд байгаа усны нөөц нь хэдий боломжийн байгаа ч цаашид хайгуулын ажлыг хийх хэрэгцээ байсаар байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

### 3.2. Оюу толгойн ХОГ болон Таван толгойн уурхайг ашиглах ХОГ-ний төслийн байгаль орчныг хамгаалах асуудлын харьцуулалт

| № | Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан байдал | Таван толгойн уурхайг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан байдал | Тайлбар, дүгнэлт /Дүгнэлт нь голчлон Таван толгойн ХОГ-ний төсөл дээр үндэслэгдсэн болно/ |
|---|---|---|---|
| **Нэг. Нөхөн сэргээлт, нөхөн төлбөрийн чиглэлээр** | | | |
| 1.1 | | Энэхүү гэрээний 2.6-д заасан хугацаанд Хөрөнгө оруулагч нь уурхайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол Үндсэн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан хохирлыг арилгаж, нөхөн сэргээлтийг тухайн үед үйлчилж буй Монгол улсын болон олон улсын стандарт, нормын дагуу хийж гүйцэтгэнэ. | Байгаль орчны нөхөн сэргээлт болон нөхөн төлбөрийн хэмжээг ямар байгууллага тогтоох талаар Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд тодорхой тусгасан боловч<br>Таван толгойн гэрээний төсөлд энэ талаар огт дурдаагүй байна.<br><br>Тийм учраас Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөрөнгө оруулагчийн саналыг харгалзан байгаль орчны хараат бус, шинжээчдийн багийн тодорхойлсноор нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлно гэсэн агуулга бүхий заалтыг оруулах шаардлагатай. |
| 1.2. | Оюу толгой төслийн үйл ажиллагаанаас шууд шалтгаалан урьдчилан тооцоолоогүй болон нөхөж болшгүй байгаль, экологийн сөрөг нөлөөлөл, хохирол учирвал уг хохирлыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд тодорхойлсон хэмжээ, экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн хөрөнгө оруулагч нөхөн төлнө. /Гэрээний 6.11/ | | |
| 1.3 | Энэхүү гэрээний 6.11-д заасан нөхөн төлбөрийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөрөнгө оруулагчийн саналыг харгалзан томилсон байгаль орчны хараат бус, шинжээчдийн багийн тодорхойлсноор тогтоох ба Хөрөнгө оруулагч хохирлын хэмжээг тодорхойлоход шинжээчдийн багтай хамтран ажиллана. | | |
| **Хоёр. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах чиглэлээр** | | | |
| 2.1 | Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон газрын хэвлийд аливаа материаллаг сөрөг нөлөөлөл үзүүлсэн нь тогтоогдвол | Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрөөр агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон газрын хэвлийд аливаа материаллаг сөрөг нөлөөлөл үзүүлсэн | Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлснийг арилгасан эсэхэд хэн хяналт тавих вэ гэдэг асуудал хоёр гэрээнд хоюуланд нь орхигдсон. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | Хөрөнгө оруулагч уг нөлөөллийг арилгах шаардлагатай арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ. | нь тогтоогдвол Хөрөнгө оруулагч уг нөлөөллийг арилгах шаардлагатай арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ. | Иргэд болон иргэний нийгмийн хяналтыг дэмжих бодлого өнөөдөр уул уурхайн баялагаа ашиглаж буй орнуудад чухлаар тавигдаж байна.<br><br>Гэрээний төсөлд Байгал хамгаалах тухай Монгол улсын хуулийн 4-р зүйлд заасан иргэдийн байгаль хамгаалах талаар заасан эрх, үүргийг гэрээнд онцлон оруулах шаардлагатай юм. Энэхүү 4-р зүйлдИргэн байгаль орчныг хамгаалахдаа Байгаль орчны сөрөг нөлөөллөөс болж эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх, хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх, хариуцлага хүлээлгэхийг шаардах, холбогдох байгууллагаас байгаль орчны чиглэлээрх үнэн зөв мэдээлэл авах, байгаль орчинд аливаа хортой нөлөө үзүүлж буй үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг холбогдох байгууллагаас шаардах, байгалийн баялагийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх зэрэг эрх эдлэх юм.<br>Иргэдийн оролцоог дэмжих замаар байгаль орчин, иргэдийн амь нас, эд хөрөнгөд учруулж буй болон учруулж болзошгүй үйлдэлтэй тэмцэхдээ иргэд, иргэний нийгмийн байгууллагын хяналт хариуцлагыг өндөржүүлж, тэдэнтэй хамтран ажиллах нь хамгийн оновчтой, үр ашигтай шийдэл юм. |
| 2.2. | Оюу толгой төслийн үйл ажиллагаанаас шууд шалтгаалан урьдчилан тооцоологүй болон нөхөж болшгүй байгаль, экологийн сөрөг нөлөөлөл, хохирол учирвал уг хохирлыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд тодорхойлсон хэмжээ, экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн Хөрөнгө оруулагч нөхөн төлнө. | Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанаас шууд шалтгаалан урьдчилан тооцоологүй болон нөхөж болшгүй байгаль экологийн сөрөг нөлөөлөл, хохирол учирвал уг хохирлыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд тодорхойлсон хэмжээ, экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн Хөрөнгө оруулагч нөхөн төлнө. Нөхөн төлбөрийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөрөнгө оруулагчийн саналыг харгалзан томилсон байгаль орчны хараат бус, шинжээчдийн багийн тодорхойлсноор тогтоох ба Хөрөнгө оруулагч хохирлын хэмжээг тодорхойлоход шинжээчдийн багтай хамтран ажиллана. | |
| **Гурав. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний чиглэлээр** | | | |
| 3.1 | Хөрөнгө оруулагч нь Оюу толгой төслийн хэрэгжилттэй холбоотой Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах жил бүрийн бүх зардлыг хариуцана. | Тусгагдаагүй | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, түүнд тусгагдсан асуудал хэрхэн хэрэгжиж буйд тавих шинжилгээ, хяналт, хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгийн талаар Таван толгойн гэрээний төсөлд огт дурьдаагүй байна.<br><br>Харин өмнөх Оюу толгойн ХОГ-нд мөн л төлөвлөлт болон түүний гүйцэтгэлд оролцох |
| 3.2 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд дурдсан арга хэмжээг хэрхэн биелүүлж байгаа | Тусгагдаагүй | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | тухай хараат бус, мэргэшсэн, эрх бүхий хөндлөнгийн шинжээчийн тайланг 3 жил тутам Байгаль орчны яаманд хүргүүлнэ. | | иргэдийн оролцоо хяналтыг орхижээ. Иргэд уул уурхайн төслийн агуулга болон байгаль орчны талаар баримталж буй бодлогын талаар мэдлэг мэдээлэлтэй байх нь уул уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөлтийг илүү үр дүнтэй болгодог нь олон улсын практикаас харагдаж байна. Иргэдийн оролцоо нь Тусгай зөвшөөрөл олгох, улмаар тухайн орон нутагт хийгдэх уул уурхайн үйл ажиллагааны талаар яриа хэлэлцээр өрнүүлэн төлөвлөлтийн явцад уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчидтэй зөөлөн, үр дүнтэй харьцаа бий болгох хамгийн үр дүнтэй арга болно. Төлөвлөлт нь зөв мэдээлэл дээр үндэслэгдэх бөгөөд зөв мэдээлэл, төлөвлөлт хоёр нь иргэдийн хяналтыг бий болгодог. |
| 3.3 | Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн төлөвлөгөөг бодит байдлаар бүрэн хэрэгжүүлсний дараа баталгаа болгож байршуулсан мөнгөн хөрөнгийг жил бүр Хөрөнгө оруулагчид буцаан өгнө. | Тусгагдаагүй | |
| 3.4 | Хөрөнгө оруулагч нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан тухайн жилийн арга хэмжээг бодитойгоор бүрэн биелүүлээгүй бол энэхүү гэрээний 6.6-д заасан хөрөнгийг уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулна. Хэрэв уг хөрөнгө хүрэлцэхгүй бол Хөрөнгө оруулагчийн авах шаардлагатай нэмэлт арга хэмжээ, санхүүжилтийн хэмжээг тодорхойлохын тулд энэхүү гэрээний 6.12-д заасны дагуу шинжээчдийг томилох бөгөөд ийнхүү тодорхойлсныг Талууд заавал биелүүлнэ. | Тусгагдаагүй | Иргэдийн хяналтыг байгаль орчныг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллага, иргэдийн нөхөрлөлүүдэд гэрээгээр гүйцэтгүүлж болно.<br><br>Түүнчлэн урт хугацааны зорилго, зорилтоо хэлэлцэх чиглэл бүхий орон нутаг нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан зөвлөл, хороо байгуулж, иргэд, ИНБ-ийг оролцуулан ажилладаг олон улсын туршлагыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. |
| **Дөрөв. Уурхайн хаалтын үйл ажиллагааны чиглэлээр** | | | |
| 4.1. | Хөрөнгө оруулагч нь уурхайг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хаахдаа Үндсэн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан хохирлыг арилгаж, нөхөн сэргээлтийг тухайн үед үйлчилж буй Монгол улсын болон олон улсын стандарт, нормын дагуу хийж гүйцэтгэнэ. | Гэрээнии заасан хугацаанд /30 жил/ Хөрөнгө оруулагч нь уурхайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол Үндсэн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан хохирлыг арилгаж, нөхөн сэргээлтийг тухайн үед үйлчилж буй Монгол улсын болон олон улсын стандарт, нормын дагуу хийж гүйцэтгэнэ. | Аль аль гэрээнд уурхайг хэсэгчлэн болон бүрэн хаах үеийн тайлан мэдээлэл, хяналтын чиг үүрэг орхигдсон.<br><br>Уурхайг хаахад зарцуулах хөрөнгийг хаалтаас 10 жилийн өмнөөс эхлэн төвлөрүүлэхээр гэрээний төсөлд заасан байгаар /ХО10,15/ өөрчилж, хөрөнгө оруулагч ашигтай ажиллаж эхлэх хугацаа нь |
| 4.2 | | Хөрөнгө оруулагч нь уурхайн хаалтын менежментийн хөтөлбөрийг | |

UIH.MN

| | | | |
|---|---|---|---|
| | | боловсруулж, уурхай хаах үед тавигдах шаардлагыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу бүрэн биелүүлэх үүрэгтэй бөгөөд уурхай хаахтай холбогдолтой зардлыг Хөрөнгө оруулагчийн хяналтын бус төрийн сангийн дансанд байршуулна. /Гэрээний 4.8/ | түүнээс өмнө байвал тэр үеэс эхлэн хуримтлуулахаар зааж болох юм. Ингэснээр уурхайг гэнэт хаах тохиолдолд санхүүгийн тодорхой эх үүсвэр бүрдэнэ. |
| 4. 3 | | Хөрөнгө оруулагч нь уурхайн хаалтын үеийн байгаль орчны нөхөн сэргээлтэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор энэхүү гэрээний 4.8-д заасны дагуу уурхай хаахаас 10 жилийн өмнөөс байршуулж эхэлнэ. | |
| **Тав. Байгаль хамгаалахад зарцуулах санхүүжилт** | | | |
| 5.1. | Хөрөнгө оруулагч нь байгаль орчныг хамгаалах тухайн жилийн зардлынхаа 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нээсэн банкны дансанд тухайн жил эхлэхээс өмнө байршуулна. | Тодорхой асуудал тусгагдаагүй | Таван толгойн уурхайг ашиглах гэрээнд байгаль орчныг хамгаалах чиглэлд хийгдэх ажлын санхүүжилтийг хэрхэн яаж хийх талаар тодорхой зүйл дурдагдаагүй бөгөөд уг асуудлыг тодорхой болгох, |
| 5.2. | Хөрөнгө оруулагч нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан тухайн жилийн арга хэмжээг бодитойгоор бүрэн биелүүлээгүй бол энэхүү гэрээний 6.6-д заасан хөрөнгийг уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулна. Хэрэв уг хөрөнгө хүрэлцэхгүй бол Хөрөнгө оруулагчийн авах шаардлагатай нэмэлт арга хэмжээ, санхүүжилтийн хэмжээг тодорхойлохын тулд энэхүү гэрээний 6.12-д заасны дагуу шинжээчдийг томилох бөгөөд ийнхүү тодорхойлсныг Талууд заавал биелүүлнэ. | Тодорхой асуудал тусгагдаагүй | |
| | **Зургаа. Ил тод, нээлттэй байдал ба тайлагнах үйл явц** | | |
| 6.1 | Хөрөнгө оруулагч нь байгаль орчныг хамгаалах | | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | төлөвлөгөө болон хөндлөнгийн шинжээчдийн тайланг олон нийтэд нээлттэй байлгаж, орон нутгийн иргэдийг зохих мэдээллээр хангаж, төслийн үйл ажиллагаа тухайн орон нутгийн байгаль орчинд хэрхэн нөлөөлж буй талаар орон нутгийн иргэдтэй тогтмол зөвлөлдөнө. | Тухайн асуудал тусгагдаагүй | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг гаргахдаа иргэд, тэдний төлөөлсөн ИНБ-ын оролцоог бий болгох, хамтран төлөвлөх эрх зүйн орчныг бүрдүүлсэн тохиолдолд тайлан үнэн зөв гарч, иргэдийн хяналт сайжирна гэдэгт анхааралаа хандуулах шаардлагатай байна. Мөн үүний зэрэгцээ нөхөн сэргээлтийн салшгүй хэсэг болох хяналтын үйл ажиллагааг мониторингийн хэлбэрээр хийж, мэдээллийг эхнээс нь тасралтгүй баримтжуулах шаардлага бий. Мониторинг нь уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, нөхөн мсэргээлтийн менежмент болон хөтөлбөрийн үр дүнг үнэлдэг. Орон нутаг, нутгийн иргэд, ИНБ-ыг оролцуулсан мониторингийн хөтөлбөр нь ажлын байрыг бий болгоно. |
| | Хөрөнгө оруулагч нь Үндсэн үйл ажиллагаатайгаа холбоотой байгаль орчны шинжилгээ, мониторингийн иж бүрэн үнэлгээний хөтөлбөрийн тайланг жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ | Хөрөнгө оруулагч нь Үндсэн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны шинжилгээ, мониторингийн иж бүрэн үнэлгээний хөтөлбөрийн тайланг жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. | |
| **Долоо. Ус ашиглалтын чиглэлээр** | | | |
| 7.1. | Оюу толгой төслийг хэрэгжүүлэх хугацаанд барилга, байгууламж барих, хүлээлгэн өгөх, ашиглах, байгаль орчныг нөхөн сэргээх зэрэг үйл ажиллагаанд шаардагдах усны нөөцийг Хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгөөр олж илрүүлбэл түүнийг /Ус ашиглах зөвшөөрөл бүхий усны нөөцийг оролцуулан/ ашиглах эрхийг Хөрөнгө оруулагчид олгоно. | | Усны эх үүсвэрийн талаар тодорхой дурьдсан ТЭЗҮ байхгүй учраас тодорхой дүгнэлтэд хүрч болохгүй байна. Өмнөговьд судалгаагаар ус ашиглаж болох 20 цэг тогтоогджээ. Эхний ээлж буюу 2009-2012 онд Балгасын улаан нуур, Наймантын хөндийн усны ордыг ашиглаж болох бөгөөд 75 км шугам хоолойг Тавантолгой руу татаж, хоногт 204 литр секунд буюу 17642 метр куб ус ашиглаж болох тооцоо гаргажээ. Харин 2012-2014 онд Борзонгийн говь, Таван-Алд, Гурамсан, Зайрмагтайн усны ордоос хоногт 39744 метр куб ус татаж болох аж. Гуравдугаар шат болох 2014-2019 онд Мандал-Овоо, Мандах, Бумбатаас хоногт 10627 метр куб ус татахаар төлөвлөжээ. Гэвч эрдэмтэд тэрбум гаруй жилийн турш хөрсөнд |
| 7.2. | Хөрөнгө оруулагчийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны нөөцийн баталгаажуулсан хэмжээ нь /Усны зөвшөөрөлд заасанчлан/ зөвхөн Оюу толгой төслийн усны хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц байгааг харгалзан уг усны нөөцийг ашиглах эрхийг бусад аж ахуйн | | |

НЭЭЛТТЭЙ СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | нэгжид давхардуулан олгохгүй байх | | хуримтлагдсан, гадагш урсац байхгүй говийн усыг хамаагүй хэрэглэвэл дэлхийн дулаарлын энэ үед говийг элсэн цөл болгох аюултайг сануулж байгаа. Монгол Улсын нутаг дэвсгэр сүүлийн жилүүдэд Хүннүгийн үеэс хойших хамгийн дулаан үедээ оржээ. Тиймээс 1980-1990-ээд онд хийсэн усны судалгаа өнөөдөр тохирохоо больж байгааг ч эрдэмтэд сануулж байна.<br>Тийм учраас усны нөөц, эх үүсвэрийг ашиглахдаа орчин үеийн шилдэг техник, технологи хэрэглэхийг хөрөнгө оруулагчдад шаардах, түүнийг гэрээндээ хариуцлагатайгаар тусгавал зохино.<br>Таван толгойн уурхайн усан хангамжийн цогцолборыг Балгасын Улаан нуурын усны нөөцид түшиглэн байгуулахаар ярьж байгаа хэдий ч одоогоос 20-иод жилийн өмнө тогтоосон нөөц нь сүүлийн жилүүдэд гарч буй уур амьсгал болон экологийн өөрчлөлтийн улмаас багассан гэсэн эрдэмтдийн тооцоог үндэслэн дахин нөөцийг зөв тогтоох нь шаардлагатай.<br>Нөгөө талаар нуур гэдэг гадаргын усны хуримтлагдсан нөөц бөгөөд энэ нь ур амьсгалаас шууд хамааралтай, хамгийн хэврэг, эрсдэл ихтэй усны нөөц юм. Газрын гүний усны хэмжээ хязгаартай, хөрсний суулт, ан цаваас шалтгаалах эрсдэл ихтэй, өөрөө даралт үүсгэн хөрс, шороогоо тогтоон барьж байдаг нь түүнийг ашиглахаас татгалзах үндэслэл болдог байна.<br>Тийм учраас усны нөөц, түүний байгаль орчин, хүн ам, мал амьтанд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг сайтар хийх шаардлага урган гарч байна. |
| 7.3. | Гэрээг баталсан өдрөөс хойш Хөрөнгө оруулагчийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн буюу баталгаажуулсан усны нөөц нь өөрийнх нь үйл ажиллагааны хэрэгцээг бүрэн хангаж илүү гарах нөхцөлд усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай Хөрөнгө оруулагч тай тохиролцож, усны нөөцийн илүү гарсан хэсгийг бусад аж ахуйн нэгжид ашиглуулж болох бөгөөд усны хайгуулын ажилд гаргасан зардлын тухайн аж ахуйн нэгжид ногдох хэсгийг Хөрөнгө оруулагч уг аж ахуйн нэгжээр нөхөн төлүүлнэ. | | |
| 7.4. | Хөрөнгө оруулагч нь өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны нөөцийг тухайн сум, орон нутгийн ахуйн хэрэгцээнд, малчин өрхүүдэд болон хөдөө аж ахуйн үйл ажиллагааны зориулалтаар ашиглуулна. | | |
| 7.5. | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр Оюу толгой төсөл шууд нөлөөлж буй гэж тогтоогдсон сумын төвийг ундны цэвэр усаар хангахад Хөрөнгө оруулагч нь Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. | Байгаль орчны нарийвчилсан байдлын үнэлгээгээр тогтоосон усны нөөцийн талбайн хүрээнд энэхүү Гэрээг байгуулсан өдөр хэрэглэгдэж байгаа ундны болон мал аж ахуйн хэрэгцээний усны хэмжээ, чанарыг одоогийн хэмжээнээс бууруулахгүй байх | |
| 7.6. | Усны чанар нь ихээхэн хэлбэлзэж болох тул усны нөөцийг тухайн сум орон нутгийн ахуйн болон ХАА-н зориулалтаар дахин боловсруулах, цэвэршүүлэх болон ус дамжуулах байгууламжийг зөвхөн тухайн орон нутгийн ахуйн хэрэглээнд зориулан барихад Хөрөнгө оруулагч Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. | Хаягдал усыг үр ашигтай ашиглах арга хэмжээ авч, далан суваг шуудуу барьж тоосжилтыг бууруулах, мал аж ахуй, газар тариаланд ашиглах нөхцлийг бүрдүүлнэ. | |
| 7.7. | Оюутолгойн орд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамрагдсан тул Хөрөнгө оруулагчтай ус ашиглах гэрээг Усны | | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | тухай хуулийн дагуу 30 жилээр байгуулж, уг гэрээг 20 жилийн хугацаагаар тухай бүр сунгаж болно. | | |
| 7.8. | Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, Ус ашиглах гэрээ болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд заасан ус ашиглахад тавигдах бүхий л нөхцөл, шаардлагыг бодитойгоор ханган ажиллаж эдгээр нөхцөл шаардлагын биелэлтийг 5 жил тутамд нэг удаа тухайн жил дууссанаас хойш 3 сарын дотор хараат бус, эрх бүхий, мэргэжлийн байгууллагаар шалгуулж, шалгалтын үр дүнг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, хувийг Хөрөнгө оруулагчид тус тус хүргүүлэх | Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, Ус ашиглах гэрээ болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд заасан ус ашиглахад тавигдах бүхий л нөхцөл, шаардлагыг бодитойгоор ханган ажиллаж эдгээр нөхцөл шаардлагын биелэлтийг ... жил тутамд нэг удаа тухайн жил дууссанаас хойш.... сарын дотор хараат бус, эрх бүхий, мэргэжлийн байгууллагаар шалгуулж шалгалтын үр дүнг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, хувийг Хөрөнгө оруулагчид тус тус хүргүүлэх | |
| 8.9. | | Хөрөнгө оруулагч нь төсөлд хэрэглэх усны хэрэглээг аль болох бууруулах, усны нөөцийг зохистой ашиглах, боломжтой бол усыг дахин ашиглах зорилгоор ижил төрлийн уурхайн үйл ажиллагаанд ашигласан дэвшилтэт технологи, горимыг хэрэглэнэ. | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Дүгнэлт, зөвлөмж:**

***Нэг. Иргэдийн оролцоог хангах тал дээр эрх зүйн шинэтгэл хийх нь цаг үеийн тулгамдсан асуудал болж байна.***

Байгаль хамгаалахад чиглэгдсэн иргэдийн оролцоо нь доорх гурван хэлбэрээр мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээх үйл ажиллагаагаар илэрхийлэгдэх бөгөөд энэхүү оролцоог хангахад хууль эрх зүйн таатай орчин чухал юм. Хууль эрх зүйн таатай орчин бүрдэх нь түүн дээр тулгуурласан Хөрөнгө оруулалтын болон бусад гэрээг хийхэд хялбар болно.

1.1. **Мэдээлэл авах эрх ба байгаль орчны хуулиуд.** Байгаль орчны мэдээллийг авах эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн ч тэдгээрийг хэрэгжүүлэх болон дагаж мөрдөх тал дээр ихээхэн дутагдалтай байна. Мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэх нэг арга нь “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”, “Усны тухай Монгол улсын хууль”, “Ойн тухай Монгол улсын хууль”-д заасан байгаль орчны мэдээллийн санг нэн даруй олон нийт болон орон нутгийн иргэдэд нээлттэй болгох нөхцлийг бүрдүүлэх юм. Дээрх мэдээллийн санд тухайн орон нутагт явагдаж байгаа үйлдвэр, үйлчилгээний БОНБҮ-ний тайлан, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, газар, ус, мод, ашигт малтмал зэрэг байгалийн баялгийг бусдад эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарах гэж байгаа болон гарсан шийдвэрийг байршуулах замаар орон нутгийн иргэд хэн ямар үйлдвэр, үйлчилгээг орон нутагт нь эрхэлж байгаа, үр дагавар нь юу болох, байгаль орчныг хамгаалах үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар дэлгэрэнгүй мэдээллийг саадгүй авч, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг олгох нь чухал байна.

1.2. **Шийдвэр гаргахад оролцох эрх ба байгаль орчны хуулиуд.** Байгаль орчны чиглэлээр аливаа шийдвэр гаргахад иргэд, олон нийт, ТББ-ийн саналыг харгалзан үзэж, олон нийтийн оролцоог хангах талаархи эрх зүй тодорхой хэмжээнд бүрдсэн гэж үзэж болно. Гэвч түүний хэрэгжилт болон даган мөрдөлт нь төрийн бүх шатны байгууллагуудад доголдож байгаа нь энэ чиглэлийн баримт бичгийн болон аман эх сурвалжуудаар баталгааждаг. Тиймээс одоо мөрдөж буй хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавихын хажуугаар цаашид эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох чиглэлээр “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”-д Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах үйл явц дахь олон нийт, орон нутгийн иргэдийн оролцоог хангах заалтуудыг оруулах, ялангуяа хөрөнгө оруулалтын гэрээний төслийг нээлттэй болгон, орон нутгийн иргэдэд танилцуулан санал авах механизмыг тогтоон хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутгийн захиргаатай байгуулах гэрээтэй холбоотой заалтуудыг нарийвчлах, орон нутгийн иргэд гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох, хэрэгжилтэд хяналт тавих, нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар гэрээний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухал байна.

1.3. **Иргэдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх ба шүүхээр хамгаалуулах эрхийн хууль зүйн үндэслэл.** Монгол улсын Үндсэн хууль болон бусад хуулиудад иргэд, олон нийтийн байгаль орчны талаарх эрхийг тодорхой заажээ. Харин зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах асуудалд нилээд зөрчил үүсдэг байна. Байгаль орчны зөрчлийн талаар иргэн хүн нэхэмжлэл гаргахад түүнээс гарах бүхий л зардлыг хувиасаа гаргадаг нь гол бэрхшээл болдог байна. Мөн нэхэмжлэх хугацааг хуулиар тогтоосон нь хүндрэл учруулж байна. Цаашид Байгаль орчны зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлан хэрэгжилтэд хяналт тавих тусгай чиг үүрэг бүхий Байгаль орчны комиссыг

UILMN СУДАЛГААНЫ САН

байгуулан, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, (Ийм комисс Австри зэрэг оронд бий) Байгаль орчны холбогдолтой иргэний хэрэгт прокурор зөвхөн төрийн байгууллагын хүсэлтээр бус өөрийн санаачилгаар болон иргэд, ТББ-ын хүсэлтээр нэхэмжлэл гарган оролцох эрх зүйн боломжийг бий болгох, ТББ-уудад байгаль орчин, нийтийн эрх ашгийн хэрэгт бие даан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон эрх зүйн орчинг бүрдүүлэх, Байгаль орчны асуудлаар гомдол, нэхэмжлэл гаргахад хөөн хэлэлцэх хугацаагүй болгох, Байгаль орчны хэргийг иргэний болон захиргааны журмаар хянан шийдвэрлэхэд улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг төрөөс хариуцдаг болгох, Байгаль орчны зөрчлийн улмаас олон нийтийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд өмгөөллийн зардлыг төрөөс хариуцах зэрэг эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага байна.

**Хоёр.** ***Монгол улсын хууль тогтоомжид байгаль орчны шудрага ёсыг хангахад чиглэсэн заалтууд тодорхой хэмжээгээр байгаа ч оролцоог хангахтай холбоотой хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх тодорхой механизм аль ч хуульд байхгүй байгаагаас амьдралд хэрэгжихгүй байна.***

Түүнчлэн “Ашигт малтмалын тухай”, “Газрын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” зэрэг хуулиудын заалт нь хоорондоо зөрчилтэй, уялдаа холбоо муу байгаа нь хэрэгжилтэнд саад болж байна. Түүнээс гадна хуулийн хэрэгжилт, хуулийг дагалдан гарах дүрэм, журам, түүний биелэлт, зохион байгуулалтын үйл ажиллагаа ч холбогдох яамд, төрийн байгууллагуудын зохих түвшинд хийгдэхгүй байгаа нь уул уурхай болон байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг зөрчилд хүргэж байна.

- ✓ Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар буюу “Мэдээ, тайлан гаргах” зүйлийн 48.8-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт болон тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ” гэжээ. ***Энэхүү заалтад “нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны тайлан” гэж нэмэх шаардлага бий.***

- ✓ Мөн хуулийн 56-р буюу “Тусгай зөвшөөрлийг цуцлах” зүйлийн 56.1.5-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргах”. ***Энэхүү заалтад “дүгнэлтийг олон нийтэд мэдээлэх” гэж нэмэх шаардлага бий. Ийм дүгнэлт хэд гарсан вэ? Түүнчлэн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл олгохоос өмнө хийдэг байх, үүнд иргэдийн төлөөлөл, ИНБ-ийг оролцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.***

- ✓ Мөн хуулийн 57.4 - д “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаарх мэдээллийг байгаль орчны болон геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээнэ. ***Энэхүү заалтад мэдээлээгүй тохиолдолд хэн, ямар хариуцлага хүлээх вэ гэдгийг нэмэх шаардлага бий. Мөн зөвхөн цахим хэлбэрээр мэдээлэх нь мэдээллийн хүртээмж талаасаа нилээд хязгаарлагдмал, иргэний мэдээлэл авах эрхэд халдсан заалт биш үү гэдгийг эргэн харах.***

- ✓ “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”-д ***Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах үйл явц дахь олон нийт, орон нутгийн иргэдийн оролцоог хангах заалтуудыг оруулах. Ялангуяа хөрөнгө оруулалтын гэрээний төслийг***

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***нээлттэй болгон, орон нутгийн иргэдэд танилцуулан санал авах механизмыг тогтоон хэрэгжүүлэх***

- ✓ Мөн хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутгийн захиргаатай байгуулах гэрээтэй холбоотой заалтуудыг нарийвчлах. ***Орон нутгийн иргэд гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох, хэрэгжилтэд хяналт тавих, нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар гэрээний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэх;***

- ✓ “Ашигт малтмалын тухай хууль”-ийн “Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх” буюу 12.1.3-д “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих”. ***Хяналт тавих нь зөвхөн нутгийн захиргаа болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх төдийгээр хязгаарласныг өөрчлөх, нутгийн иргэдийн нөхөрлөл хамтлаг болон ТББ-үүдэд хяналтын эрх олгох;***

- ✓ “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”-ийн зорилт нь (1995.03.30) “Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүй үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зүй зохистой ашиглах, **жам ёсны боломжтойг** нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэжээ. ***Энд жам ёсны боломжтой гэж чухам юуг томьёолсон вэ, энэ нь нөхөн сэргээх үүрэг, хариуцлагаас мултрахад шалтаг болох заалт биш үү гэдгийг анхаарах***

- ✓ Мөн хуулийн 3.7-д “Байгаль орчныг хамгаалах” гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна” . ***Дээрхтэй адил “байгалийн жам ёсоороо нөхөн сэргэх боломж” гэж чухам юуг томьёолсноо анхаарах***

- ✓ Мөн хуулийн Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх үүрэг буюу 4.1.3-д “Байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх, нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх (энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон). ***Байгаль орчин болон түүний зөрчилтэй холбогдох мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, санал бодлоо хэлэх, зөрчилтэй холбоотой асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй гэж нэмэх.***

- ✓ Мөн хуулийн 12.1.2-д “Байгаль орчны мэдээллийн сан нь… нөлөөллийн үнэлгээ… бүрдэнэ”. ***Асуудал хариуцсан төрийн төв байгууллага байгаль орчны мэдээллийн санг олон нийтэд нээлттэй ажиллуулдаг эсэх. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай, Ойн тухай хуулиудад заасан байгаль орчны мэдээллийн санг нэн даруй байгуулан хөдөө орон нутгийн иргэдэд нээлттэй болгох нөхцлийг бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл, хуулийн энэ заалтын хэрэгжилт ямар байгаа дээр мониторинг хийлгэх. Түүнчлэн Байгаль орчны мэдээллийг ил тод болгох, байгаль орчинтой холбоотой шийдвэр гаргах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих талаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хүлээх үүрэг, үйл ажиллагааны зааг хүрээг тодорхой болгон,***

***үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг бий болгох;***

**Нэгтгэн дүгнэхэд,** Монгол улсын хууль тогтоомжид оролцоог хангахтай холбоотой тодорхой механизм байхгүй байна. Байгаль орчны үнэлгээ хийх, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл өгөх, байгаль орчны чиглэлийн аливаа шийдвэр гаргахад төрийн байгууллага, нутгийн иргэд, ИНБ-ийн тэгш оролцоог хангах эрх зүйн зохицуулалт дутагдаж байна. Энэ чиглэлийн үйл ажиллагааг ганц төрийн байгууллага хариуцан, аливаа зохицуулалтыг дангаар гүйцэтгэх нь өрөөсгөл зүйл бөгөөд тэгш оролцооны асуудал нь байгаль орчин дахь шударга ёс, эрхийн хэрэгжилтэнд эерэгээр нөлөөлж, уул уурхайн баялагаа байгаль орчинд ээлтэй, эдийн засагтаа ашигтай байдлаар ашиглахад ихээхэн ач холбогдолтойг бусдын туршлага, арга барил харуулж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## 3.3. ТАВАН ТОЛГОЙН УУРХАЙГ АШИГЛАХ БОЛОН ОЮУ ТОЛГОЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХИ ХАРЬЦУУЛАЛТ

| | **Таван толгойн уурхайг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан байдал** | **Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан байдал** | **Санал, тайлбар, дүгнэлт** |
|---|---|---|---|
| ***ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА*** | | | |
| **1.** | **5.1**. Хөрөнгө оруулагч нь энэ Гэрээ, ТӨК-тай байгуулах нүүрсний олборлолтын гэрээний үндсэн дээр Гэрээт талбайд олборлолт явуулах, нүүрс баяжуулах (угаах), борлуулах, экспортод гаргах, олсон орлогоо гадаад улсад шилжүүлэх болон захиран зарцуулах эрхтэй. | **9.4.** Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын болон бусад улсын арилжааны банкинд данс нээж сонгосон валютаараа чөлөөтэй, саадгүйгээр олон улсын гүйлгээ хийх эрхтэй. | Нүүрсний борлуулалтаас олсон орлогыг гадаадад чөлөөтэй гаргаж, тэнд нь хадгалах боломжтой байгаа нь гадаад гүйвуулгад ногдуулдаг суутгал татварыг төлөхгүй байх, төлөхөөс өмнө орлогыг зарцуулах боломжийг давхар бүрдүүлж болзошгүй байна. |
| **2.** | **5.3.** Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээг байгуулсан өдөр мөрдөж байсан Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийг ТӨК-д төлж, ТӨК төсөвт төлнө. | | Нөөц ашигласны төлбөрийг төрийн өмчит компаниар дамжуулан төсөвт төлөхөөр заасныг эргэн харах саналтай байна.<br>Нөөц ашигласны төлбөрийг тодорхой хэмжээгээр өөр зорилгод ашиглах, дайчлах нөхцөл үүсч болзошгүй хязгаарлах шаардлагатай. |
| **3.** | **5.4.** Хөрөнгө оруулагч нь бүс нутгийг хөгжүүлэх, орон нутагт туслалцаа үзүүлэх, ажлын байр, бизнесийн боломжийг шинээр бий болгоход энэхүү Гэрээнд заасныаас гадна, бусад бололцоотой туслалцаа үзүүлнэ. | **9.9.** Хөрөнгө оруулагч нь бүс нутгийг хөгжүүлэх, орон нутагт туслалцаа үзүүлэх, ажлын байр, бизнесийн боломжийг шинээр бий болгоход бололцоотой туслалцаа үзүүлнэ. | Тавантолгойн гэрээний 5.4 нь Оюутолгойн гэрээний 9.9-ийг нэмж сайжруулсан зүйлгүйгээр оруулсан байна. |
| **4.** | **4.10.** Хөрөнгө оруулагч Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэр, цахилгаан станц болон дотоодын бусад хэрэгцээнд зориулж бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр тэргүүн ээлжинд нийлүүлэх үүрэгтэй. | | Хөрөнгө оруулагч дотоодын хэрэгцээнд бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр нийлүүлэх үүргийг заасан. “Зах зээлийн үнэ” гэдгийг тодорхойлж өгөх шаардлагатай. |
| ***ТӨК-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА*** | | | |

UILI.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| **5.** | **6.1.** ТӨК Гэрээт талбайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд, энэ Гэрээ, Нүүрс олборлолтын гэрээнд заасан нөхцөлийн хүрээнд Хөрөнгө оруулагчийн Үндсэн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.<br>**6.4.** ТӨК Ашигт малтмалын тухай хууль, холбогдох дүрэм, журам, энэхүү Гэрээг Хөрөнгө оруулагч хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавина. | | Эрдэнэс МГЛ нь хөрөнгө оруулагчийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахаар заасан байна.<br>Уурхайн эдэлбэрт нэвтрэх, үйл ажиллагааг хянах эрхийг Эрдэнэс МГЛ-ийн төлөөлөгч эдлэхээр заасан байгаа ч Засгийн газар энэ эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой болохыг гэрээнд нэмж тусгаж өгөх. |
| **6.** | **6.3.** ТӨК өөрт ногдох Бүтээгдэхүүний борлуулалтын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ. | | Ордын тодорхой хэсгийг төрийн өмчит компани олборлох, ашиглах нь төдийлөн оновчтой бус байна. Хэрэв ийм компани байх шаардлагатай бол тэр нь Эрдэнэс МГЛ-ээс тусдаа байх нь зохимжтой.<br>Эрдэнэс МГЛ нь оператор бус зөвхөн холдинг компани байснаар ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлнэ. |
| **7.** | **6.5.** ТӨК Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэр, цахилгаан станц болон дотоодын бусад хэрэгцээнд зориулж нүүрсийг зах зээлийн үнээр тэргүүн ээлжинд нийлүүлэх үүрэгтэй. | | Эрдэнэс МГЛ-ийн хувьд хөрөнгө оруулагч аль болох ашигтай ажиллаж, илүү бүтээгдэхүүн түүнтэй хуваалцах сонирхол нь давамгайлж болох тул төрийн хяналтын чиг үүргийг бүгдийг нь тус компанид шилжүүлэх нь зохимжгүй юм. Хяналтын болон эрх олгох (орлого олох) чиг үүргийг салгаж өгөх |
| ***ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЭРДЭС БАЯЛАГИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА*** | | | |
| **8.** | 2.2. Хөрөнгө оруулагч нь Таван толгойн төсөлтэй холбоотойгоор шаардагдах тусгай зөвшөөрөл, гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, гаалийн бүрдүүлэлт, бусдын өмчийн газар дээгүүр нэвтрэх болон авто замын зурвас газар, замын байгууламжид ашиглах газрын зөвшөөрөл, эрх бүхий байгууллагын шийдвэр болон түүнтэй адилтгах бусад эрх олгосон баримт бичгийг (цаашид “Зөвшөөрөл” гэх) авах хүсэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу холбогдох байгууллагад гаргах, авах эрхтэй бөгөөд Засгийн газар Хөрөнгө оруулагчийн хүсэлтийг үндэслэн дэмжлэг үзүүлж хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. | | Үндсэн үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн зөвшөөрлийг төрийн байгууллагуудаас авахад нь төр, засгаас хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэхээр гэрээний төсөлд заасан байна. Энэ бол хөрөнгө оруулагчид тусгайлан хандаж, бусад компанийг ялгаварлаж буй хэлбэр гэж ойлгогдож байна.<br>Аливаа зөвшөөрлийг хууль журмын дагуу бусадтай адил олгох нь төр засгийн хувьд зохимжтой болов уу. |
| **9.** | Монгол Улсын Засгийн газраас төлөөлж Сангийн | Монгол Улсын Засгийн газраас төлөөлж | Засгийн газрыг төлөөлж гурван сайд гарын |

| | | | |
|---|---|---|---|
| | сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Төрийн өмчит "Эрдэнэс МГЛ", ................ хөрөнгө оруулагч нарын хооронд гэрээ байгуулагдахаар | Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;<br>Айвенхоу Майнз Монголия Инк ХХК, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед-ын хооронд гэрээ байгуулагдсан. | үсэг зурж байгаа нь хариуцлагыг эзэнгүйдүүлж болох талтай.<br>ЗГ өөрийнхөө сайдыг удирдаж чаддаггүй, сайд нь Засгийн газрыг төлөөлж чадахгүй байнагэж ойлгогдож байна. Хууль эрх зүйн орчиноороо төрийг хүчгүй болгож байна. |
| **10.** | **7.1.** Засгийн газар нь ТӨК, Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа явуулах Тогтворжуулсан татварын орчинг энэхүү гэрээний хугацааны туршид тогтвортой хангах үүргийг хүлээнэ.<br>**7.2.** Хөрөнгө оруулагч Гэрээт болон Туслан гүйцэтгэгийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, тэдгээртэй холбоотой эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн эрхийг Засгийн газар хууль бусаар хураан авахгүй.<br>**7.3.** Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу аливаа зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллага нь энэхүү Гэрээ болон Монгол Улсын бусад хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу ТӨК, Хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй аливаа зөвшөөрлийг хууль бусаар хүчингүй болгох буюу цуцлахгүй.<br>**7.4.** Хөрөнгө оруулагч нь давтагдашгүй хүчин зүйлийнхээс бусад шалтгаанаар энэхүү Гэрээнд заасан Үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй зургаан (6) сарын хугацаа өнгөрсөн, эсхүл Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг ноцтойгоор зөрчсөн бол эрдэс баялагийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн түүнд зөрчил гарсан тухай болон гарсан зөрчлийг засах тухай мэдэгдлийг (мэдэгдэл) бичгээр өгнө. Хөрөнгө оруулагч нь уг | **10.1.** Засгийн газар нь Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаагаа явуулах татварын болон тогтворжуулсан татварын орчинг энэхүү Гэрээний хугацааны туршид тогтвортой хангах үүргийг хүлээнэ.<br>**10.3.** Хөрөнгө оруулагч, түүний Хамааралтай этгээд, Гэрээт болон Туслан гүйцэтгэгчийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, тэдгээртэй холбоотой эд хөрөнгийн эрх болон оюуны өмчийн эрхийг Засгийн газар хууль бусаар хураан авахгүй<br>**10.4.** Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу аливаа зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллага нь энэхүү Гэрээ болон Монгол Улсын аливаа бусад хууль тогтоомж, дүрэм журмын дагуу Хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй аливаа зөвшөөрлийг хууль бусаар хүчингүй болгох буюу цуцлахгүй.<br>**10.7.** Хөрөнгө оруулагч нь давагдашгүй хүчин зүйлийнхээс бусад шалтгаанаар энэхүү Гэрээгээр хүлээсэн үндсэн болон | Эдгээр зүйл заалтууд нь Оюутолгойн гэрээг шууд хуулбарласан нь харагдаж байна.<br>Эндээс харахад Засгийн газрын хүлээх үүрэг их. Харин эрхийн талаас хязгаарлагдмал болсон байгаа нь харагдаж байна.<br><br>Засгийн газрын эрх үүргийг тодорхойлохдоо татвар, байгаль орчин, хөдөлмөр эрхлэлт зэрэгтэй холбоотой харилцааг шууд хянах боломжийг зааж өгөөгүй нь хяналтын чиг үүргээ зөвхөн төрийн өмчит компаниар дамжуулан хэрэгжүүлэхээр ойлгогдож байна.<br>Уурхайн үйл ажиллагааг хянах, уурхайн эдэлбэрт нэвтрэх, эрхийг Засгийн газар өгөхийг гэрээнд нэмж тусгаж өгөх. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | Мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш ажлын жар /60/ хоногийн дотор түүнд заасан үүргийг биелүүлэх талаар зохиох арга хэмжээ аваагүй тохиолдолд Засгийн газар энэхүү Гэрээг цуцлах эрхтэй.<br>**7.5.** Засгийн газар нь энэхүү Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах болон Тавантолгой төслийн үйл ажиллагаатай холбоотой ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж, үйл ажиллагаар үр дүнд хүргэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч ажиллана. | ач холбогдол бүхий үүргээ биелүүлэлгүй 6 /зургаа/ сарын хугацаа өнгөрсөн, эсхүл Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг санаатайгаар болон ноцтойгоор зөрчсөн бол эрдэс баялгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн түүнд зөрчил гарсан тухай болон гарсан зөрчлийг засах тухай мэдэгдлийг /"Мэдэгдэл"/ бичгээр өгнө. Хөрөнгө оруулагч нь уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш ажлын 60 /жар/ хоногийн дотор түүнд заасан үүргийг биелүүлэх талаар зохих арга хэмжээ аваагүй тохиолдолд Засгийн газар энэхүү Гэрээг цуцлах эрхтэй. Хөрөнгө оруулагч аливаа ийм мэдэгдлийн талаар энэхүү Гэрээний 14 дүгээр бүлэгт заасны дагуу маргаан гаргах эрхтэй.<br>**10.8.** Засгийн газар нь энэхүү Гэрээний хэрэгжилт болон Оюу толгой төслийн барилгын ажил, үйл ажиллагаар хэрэгжүүлэхэд Хөрөнгө оруулагчтай хамтран ажиллаж, энэхүү Гэрээнд заасан хамтын зорилтуудад хүрэхийн тулд өөрийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авч ажиллана. | |
| **11.** | 16.1.4. Эрх бүхий этгээд Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаар дампуурсан гэдэг үндэслэлээр зогсоосон бөгөөд эрдэс баялгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн үйл ажиллагаагаа сэргээхийг шаардсан мэдэгдэл бичгээр өгснөөс хойш ажлын ... хоногийн Хөрөнгө оруулагч үйл | **10.10.2.** Хяналтын багцыг бусдаас хараат этгээдэд шилжүүлэх үед Рио Тинто Группын гишүүн бус тал Оюу толгой төслийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа бол энэхүү Гэрээг дуусгавар болгоно. | Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд уг гэрээ дуусгавар болох нөхцөлийг заасан ч зарим нэгэн асуудал нээлттэй хэвээр байна. Гэрээний төслийн дагуу уурхайн үл хөдлөх өмч нь хөрөнгө оруулагчийн мэдэлд байхаар заажээ. Бүтэн 30 жилийн хугацаанд хүчинтэй байх гэрээний хувьд хөрөнгө |

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллагаагаа сэргээгээгүй бол<br>16.1.6. Хөрөнгө оруулагчийн Хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлсэн бол, | | оруулагчаас хамааран үйл ажиллагаа гэнэт зогсвол түүний үүргийг хэн биелүүлэх талаар дэлгэрэнгүй зааж өгөх.<br>Тухайлбал, үйл ажиллагаа гэнэт зогсвол үйлдвэрийн үл хөдлөх өмч төрд шилжих, Монголын тал хөрөнгө оруулагчийн аливаа нэхэмжлэгч, зээлдэгчээс давуу эрхтэй байх нөхцөл тавьснаар олборлолтын үйл ажиллагааг хэвийн хангах юм. Түүнчлэн хөрөнгө оруулагч үл хөдлөх хөрөнгийг барьцаалах, бусдад шилжүүлэх зэрэгт хязгаарлалт тогтоох. |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ДҮГНЭЛТ**

Энэ бүхнээс дүгнэхэд Таван толгойн нүүрсний ордыг ашиглах гэрээг Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээнээс загвар авч хийсэн нь харагдаж байна. Засгийн газрын эрх үүргийг тодорхойлохдоо татвар, байгаль орчин, хөдөлмөр эрхлэлт зэрэгтэй холбоотой харилцааг шууд хянах боломжийг зааж өгөөгүй нь хяналтын чиг үүргээ зөвхөн төрийн өмчит компаниар дамжуулан хэрэгжүүлэхээр ойлгогдож байна. Таван толгойн хөөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын Засгийн газраас эрх олгосноор түүнийг төлөөлж МУ-ын сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хийж байгаа нь хариуцлагыг бүдгэрүүлж байна. Тиймээс нэг л сайд төлөөлөх нь зүйтэй.

Дараах саналуудыг анхааран үзэх:

- Хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгө, ашиглах технологи, мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайг хаах талаарх үүргүүдийг толгой компани нь давхар хариуцахаар баталгаажуулах асуудлыг гэрээнд тусгаснаар эрсдлээс хамгаална.
- Уурхайн эдэлбэрт нэвтрэх, үйл ажиллагааг хянах эрхийг Эрдэнэс МГЛ-ийн төлөөлөгч эдлэхээр заасан байгаа ч Засгийн газар энэ эрхийг хэрэгжүүлэх боломжтой болохыг гэрээнд нэмж тусгаж өгөх.
- Хөрөнгө оруулагч дотоодын хэрэгцээнд бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр нийлүүлэх үүргийг заасан (ХО 4.10) нь сайшаалтай ч “зах зээлийн үнэ” гэдгийг тодорхойлж өгөх шаардлагатай. Тухайлбал, Хятад улс руу экспортлохдоо нэг үнэ ашиглаж, дотоодын хэрэгцээнд нийлүүлэхдээ Австрали ч юмуу аль нэгэн орны зах зээлийн үнийг ашиглах нөхцөлийг үүсгэхгүй байх нь чухал юм.
- Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд зарим татварыг тогтворжуулахаар, мөн бусад аливаа хууль тогтоомжоор илүү таатай нөхцөл бүрэлдвэл түүнийг хөрөнгө оруулагч эдлэх боломжтой (ХО 19.7) гэсэн нь үндсэндээ нэг талын тогтворжилт бөгөөд хууль дүрэм таатайгаар өөрчлөгдвөл уг нөхцлийг хөрөнгө оруулагчид эдлэх боломжтой, харин хууль дүрэм илүү хатуу нөхцөлтэй болвол түүнд хамаарахгүй байхаар ойлгогдож байна. Иймд цөөн тооны санхүүтэй холбоотой хууль журмаас бусдыг тогтворжуулахгүй байх нь зүйтэй. Учир нь манай улсад уул уурхайн стандартууд олон улсын хэмжээнд хүрч чадаагүй байгааг харгалзан үзэх. Хэрэв тогтворжуулахдаа хоёр талын үйлчлэлтэй байхаар заалт оруулах саналтай байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# "ОЮУ ТОЛГОЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ", " ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ГЭРЭЭ" БОЛОН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААРХИ ӨДӨР ТУТМЫН СОНИНУУДЫН НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН КОНТЕНТ АНАЛИЗ

(2009.07-2010.04)

*Ч.Базар (PhD), Б.Ариунжаргал, С.Дорждагва, О.Нарантуяа, Б.Мөнхцэцэг, Ө.Мөнхтунгалаг, Д.Мягмарцэрэн, Н.Түвшинтөгс*

**Судалгааны зорилго:**

Энэхүү судалгааны зорилго нь "Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ"-г УИХ-аар соёрхон батлахын өмнөхөн буюу УИХ-ын 57, 40 дүгээр тогтоолын хүрээнд Засгийн газрын ажилласан байдал, улмаар УИХ-аас гэрээг соёрхон батлах явц болон түүний дараах үе, тус гэрээний ТЭЗҮ-ийг Засгийн газар болон Хөрөнгө оруулагч тал үзэглэхийн өмнөх, дараах үеийн цаг хугацаанд энэхүү үйл явцын талаархи бодлого, шийдвэр гаргагчид болон олон нийтийн санаа бодол ямар байсныг тандах, үүний үр дүнд ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэнд оруулах төрийн бодлого, шийдвэрт тус дэм үзүүлэхэд оршино. Бодлого шийдвэр гаргагчид гэдэгт УИХ, Засгийн газрын гишүүд, түүний харьяа төрийн байгууллагын төлөөлөл хамрагдах бол олон нийт гэдэгт иргэн, ИНБ, эрдэмтэн судлаачид, хөндлөнгийн шинжээчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон улсын байгууллагын төлөөллийг хамруулан ойлгоно. Төлөөллүүдийн санаа бодлыг тандахдаа өдөр тутмын сонины нийтлэл мэдээлэлд тулгуурласан болно. Судалгааны зорилго нь Гэрээ болон ТЭЗҮ-ийн ямар асуудлууд дээр төлөөллүүд шүүмжлэл өрнүүлж, түүнийг сайжруулах талаар ямар санал зөвлөмж гаргаж байгааг нэгтгэхэд чиглэгдсэн болно. "Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ" нь хүчин төгөлдөр болсон нөхцөл, цаг хугацааны хувьд олон, олон шүүмж, зөвлөмжийг дагуулсан боловч цаашид Монгол улсын хуулиар стратегийн хэмээн жагсаагдсан ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулахад бодлого, шийдвэр гаргагчдад тус хүргэхүйц мэдээлэл агуулж байгаараа энэхүү судалгаа нь ач холбогдолтой юм.

**Судалгааны арга зүй:**

Судалгаанд өдөр тутмын хэвлэл "Ардын эрх", "Зууны мэдээ", "Монголын мэдээ", "Нийгмийн толь", "Өдрийн сонин", "Үнэн", "Үндэсний шуудан", "Өнөөдөр" зэрэг нийт 8 сонинг сонгон авч, эдгээр хэвлэлийн 2009 оны 7 дугаар сараас 2010 оны 05 хүртэлх дугаарын "Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ", "Хувь нийлүүлэгчдийн гэрээ", "Техник эдийн засгийн үзүүлэлт" - тэй холбоотой нийтлэл, мэдээллийг түүвэрлэв.

Судалгааг хэвлэлийн нийтлэлийн агуулгын задлан шинжлэл буюу контент анализын аргаар хийлээ. Задлан шинжилгээ хийхдээ тухай нийтлэлийн үнэн худал, эерэг сөрөг агуулгыг тодорхойлох бус судалгааны удирдамжид заасны дагуу "шүүмжилсэн асуудал, үндэслэл, дэвшүүлсэн санал, зөвлөмж" зэргийг тоон мэдээллээр гаргаж нэгтгэсэн болно. Судалгааны үр дүнд олж авсан мэдээлэлд тулгуурлан төлөөллүүдийн зарим санал зөвлөмжийг тэр чигээр нь тусгаж, давтагдсан асуудлууд дээр дүгнэлт хийхдээ өмнө нь Судалгааны төвийн судлаачдын 2009 онд Оюу толгойн гэрээний төсөлд анализ хийсэн багц судалгаануудыг ашигласан болно.

Судалгааг УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн 8 судлаач 2 сарын хугацаанд хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Б.Ариунжаргал – "Үндэсний шуудан"
2. Ч.Базар - "Өнөөдөр" сонин
3. С.Дагвадорж – "Монголын мэдээ" сонин
4. О.Нарантуяа – "Ардын эрх" сонин

UIH.MN СУДАЛГААНЫ САН

5. Б.Мөнхцэцэг – “Өдрийн сонин” сонин
6. Ө.Мөнхтунгалаг – “Нийгмийн толь” сонин
7. Д.Мягмарцэрэн – “Зууны мэдээ” сонин
8. Н.Түвшинтөгс – “Үнэн” сонины нийтлэл, мэдээлэлд задлан шинжилгээ хийсэн бөгөөд нэгдсэн дүнг референт- шинжээч Ч.Базар боловсруулав.

**Нэг. Сонины нийтлэл, мэдээлэлд тусгагдсан асуудлууд**

Энэхүү судалгаагаар “Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ”-нд тусгагдсан Монгол улсын эзэмших хувь хэмжээ, хөрөнгө оруулагч талын ордыг эзэмших хугацаа, Монгол улсад төлөх татвар, гэнэтийн ашгийн татварыг тэглэсэн байдал, орд газар эзэмших орчны дэд бүтэц, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл тэр дундаа ус ашиглалтын хугацаа, Монголын талын ажиллах хүчин, тэдгээрийн баталгаа, гэрээнд хяналт тавих зэрэг асуудлуудад хэвлэлийн нийтлэл мэдээллийн агуулга төвлөрсөн нь ажиглагдлаа. Дээрхи асуудлаар судалгаанд хамрагдсан хугацаанд бүх сонинд 625 материал нийтлэгдсэнээс шүүмжлэлт байр суурьтай 460 нийтлэл байгаа нь нийт мэдээллийн 73.6 %-ийг эзэлж байна. Үүнд:

а/. “Ардын эрх” сонинд нийт 62 нийтлэл мэдээлэл, үүнээс шүүмжлэлт 25

б/. “Зууны мэдээ” сонинд нийт 145 нийтлэл, мэдээлэл, үүнээс шүүмжлэлт 123

в/. “Монголын мэдээ” сонинд нийт 74 нийтлэл, мэдээлэл, үүнээс шүүмжлэл 74

г/. “Нийгмийн толь” сонинд нийт 54 нийтлэл, мэдээлэл, үүнээс шүүмжлэлт 35

д/. Өдрийн сонинд нийт 88 нийтлэл, мэдээлэл, үүнээс шүүмжлэлт 70

е/. “Үнэн” сонинд нийт 60 нийтлэл, мэдээлэл, үүнээс шүүмжлэлт 47

ё/. “Үндэсний шуудан” сонинд нийт 102 нийтлэл, мэдээлэл, үүнээс шүүмжлэлт 67

ж/. “Өнөөдөр” сонинд нийт 40 нийтлэл, мэдээлэл, үүнээс шүүмжлэлт 19 материал тус тус нийтлэгджээ.

**Хоёр. Шүүмжлэгдсэн асуудлууд**

***2.1. Монгол улсын төрийн эзэмшлийн хувь***

**Гэрээнд тусгагдсан байдал:** Гэрээний 1.6-д “Төр нь хөрөнгө оруулагчийн энгийн хувьцааны 34 /гучин дөрөв/ хувийг өмчлөх ба энэхүү Гэрээний хугацааг Гэрээний 15.11-д заасны дагуу сунгасан бол ийнхүү сунгаснаас хойш 1 /нэг/ жилийн дотор Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр харилцан тохиролцсон нөхцөлөөр Хөрөнгө оруулагчийн энгийн хувьцааны 16 /арван зургаа/ хувийг нэмж өмчлөх сонголт хийх эрхтэй. Энэхүү гэрээний 1.6 дахь заалт нь Хөрөнгө оруулагчийн хувьцаанаас Төрд хувьцаа нэмж гарган өмчлүүлэх, эсхүл шилжүүлэх талаар хуулийн болон УИХ-ын тогтоолын дагуу үүсч болох бүх үүргийг хангаж байгааг Засгийн газар баталгаажуулав.” гэжээ.

***2.1. Монгол улсын төрийн эзэшлийн хувь (34) бага байна гэж***

а/. “Ардын эрх” сонинд 4

б/. “Зууны мэдээ” сонинд 18

в/. “Монголын мэдээ” сонинд 21

г/. “Нийгмийн толь” сонинд 4

д/. “Өдрийн сонин” сонинд 12

е/. “Үнэн” сонинд 6

ё/. “Үндэсний шуудан” сонинд 4

ж/. “Өнөөдөр” сонинд 2 нийт 71 материал нийтлэгдэж, эдгээр нь нийт мэдээллийн 15.43 %-ийг эзэлж байна.

**2.1.1. Шүүмжилсэн гол асуудал:**

- МАХН-ын “Уламжлал, шинэчлэл, шударга ёс жигүүр”-ийн ил захидалд “Гэрээний төсөлд төр энгийн хувьцааны 34 хувийг эзэмшиж, 9 хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ-д 3 хүний төлөөлөлтэй оролцохоор байгаа нь 30 жилийн турш ард түмний өмчийг гадагш гаргах нь”;
- УИХ-ын гишүүн Х.Жекей “УИХ-ын тогтоолын 1-р заалтад Монголын эзэмших хувийг 34%-иас эхэлж тогтоосугай гэсэн байна. Хуульд 34% хүртэл гэсэн заалт бий. Энэ нь хууль зөрчсөн байна”;
- Эдийн засагч Д.Жаргалсайхан “Төрийг том байлгаж, улс оронд байгаа бүх хөрөнгийг төр эзэмших гэсэн хандлага сүүлийн жилүүдэд хүчтэй болж байна”;
- Д.Болд “Ийм хууль дэлхийн аль ч улс оронд байдаггүй. Төрийн оролцоо 34% байна гэдэг бол өндөр хувь”;
- “Өнөөдөр” сонин “Төр 34 хүртэл хувийг эзэмшиж болно” гэсэн Ашигт малтмалын хуульд байдаг заалтыг хэдэн жил мөрдсөн. Гэтэл 34 гэсэн тоог эхлэх цэг болгоод цааш нь 50 хувь болго гэсэн хууль дээгүүр алхсан гэрээ хийх үүргийг УИХ нь Засгийн газартаа өглөө”.
- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун “Уул уурхайн оронд тухайн улс өндөр хувь эзэмшээд байх нь оновчтой бодлого бус. Тэр хэмжээгээр хөрөнгө оруулалтын эрсдэл, зардлыг даах ёстой болдог. Ирээдүйд дэлхийн зах зээл дээр зэсийн үнийн өсөлт бууралт бий болж болзошгүй. Ийм тохиолдолд манайх хэтэрхий өндөр хувь эзэмшвэл тэр чинээгээр эдийн засаг савлана. Тэгэхээр эрсдлийг аль болох хөрөнгө оруулагчдад ногдуулаад улс өөрөө баталгаатай хэсгээ авах”

Шүүмжлэлийн гол агуулга нь Монголын төрийн эзэмших хувь бага гэдэг дээр төвлөрч байгаа ч нөгөө талд зарим эрдэмтэн, судлаач төр 34 хувийг эзэмшиж байгаа нь өндөр хувь, тэр хэмжээгээр эрсдэл зардлыг даах болдог, төр бүх хөрөнгийг эзэмших гэсэн хандлага сүүлийн жилүүдэд хүчтэй байна гэж нөгөө талаас нь дүгнэн хэлжээ.

**2.1.2. Гаргасан санал, зөвлөмж**

*а/. Төрийн эзэмшлийн хувийг нэмэгдүүлэх*

- УИХ-ын нэр бүхий гишүүд “Эзэмших хувийг 50 ба түүнээс дээш болгох”;
- 34%-ийг үнэ төлбөргүйгээр шууд эзэмших;
- УИХ-ын гишүүн Ш.Сайхансамбуу “Эрдэнэт үйлдвэрийн жишгээр 49:51 гэсэн харьцаагаар эзэмших хувийг тогтоох”;
- Ж.Бямбаа “Төр нөөцийн эзний хувьд 4 тэрбум ам.доллароор үнэлэн хөрөнгө оруулалт хэмээн тооцож, 51%-ийг шууд эзэмших”;

*б/. Үндэсний корпораци байгуулж, өөрсдөө эзэмших*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- МАХН-ын “Уламжлал шинэчлэл, ардчилал, шударга ёс жигүүр”-ийн гаргасан ил захидалд “Үндсэн хуульд заасны дагуу төр, ард түмний өмч болсон Оюутолгойн нөөцдөө тулгуурлаж Монголын ард түмний Үндэсний корпорацийг яаралтай байгуулах”;

- МУИС-ийн багш, Др.С.Авирмэд “Монголын компаниуд, эрдэмтэд инженерүүд нийлж корпораци байгууль. Бидэнд 205 тэрбум төгрөг л хэрэгтэй. Засгийн газар орцоо барьцаалж мөнгө босговол бидэнд боловсон хүчин байна, тоног төхөөөрөмжийг нь худалдаад авчихна”;

**УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн хийсэн судалгаанд:** 30 жил болоод гэрээ сунгагдана. 31 дэх жилээс 16%-ийг нэмж өмчлөх эрхтэй гэж заасан нь Монголын талын эзэмшлийг анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа 50% болгох тухай заасантай авцалдахгүй байна. ОХУ-д мөрдөгдөж байгаа концессийн гэрээгээр, хөрөнгө оруулагч нь 25-30 хувийг 5 жилд, 50 хувийг 15 жилд, 70-100 хувийг 20 жилд тус тус төрийн эзэмшилд шилжүүлдэг. Тийм учраас, энэ жишгээр, дурдсан 50 хувийг 15 жилд багтаан төрийн эзэмшилд шилжүүлэх нь зүйтэй.
***Эх сурвалж: Н.Түвшинтөгс, Г.Чулуун “Оюу толгойн ордыг ашиглах гэрээний төслийн талаархи судлаачдын шүүмж, зарим харьцуулалт”. 2009 он***

### 2.2. Гэрээний хэлбэрийг өөрчлөх

**Гэрээнд тусгагдсан байдал:** Энэхүү гэрээний зорилгод хөрөнгө оруулагчийн татварын болон үйл ажиллагааны орчинг тодорхой хугацаанд тогтвортой байлгах...зэргээс үзэхэд тогтортой байдлын хэлбэрээр хийжээ.

#### 2.2.1. Гаргасан санал зөвлөмж:

*а/ Хөрөнгө оруулагчтай гэрээг Тогтвортой байдлын хэлбэрээр бус бүтээгдэхүүн хуваах зарчмаар хийх.*

- Доктор, профессор Г.Пүрэвбаатар “Тус ордод эхний 10 жилд (2010-2019) Монгол улсын тал 65-70, хөрөнгө оруулагч 35-30 хувиар тус тус бүтээгдэхүүн хуваахаар тохиролцож хийх. Эхний хөрөнгө оруулалтыг нөхсөний дараа өргөтгөж болох ба техник, технологийн шинэчлэл хийхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын 51-75 хувийг Монголын тал, 49-25 хувийг хөрөнгө оруулагч тал гаргах зарчмаар Оюутолгойн ордод хөрөнгө оруулалтын гэрээ хийх”;

- Эдийн засагч Д.Жаргалсайхан “Хөрөнгө оруулагч тал хөрөнгөө оруулаад, эрсдлээ өөрсдөө хүлээх, орлогынхоо дийлэнхи хэсгийг Монгол улсад өгөх зарчмаар ажиллахын тулд гэрээг Бүтээгдэхүүн хуваах замаар хийж, олборлох бүтээгдэхүүний 70 хувийг Монгол улс авах;

*в/ Концессын гэрээ хийх.*

- Монголын уул уурхайн инженерүүдийн холбооны тэргүүн, Др. Ч.Владимир “Олон улсын практикт төрийн өмч болох ашигт малтмалыг эзэмших, ашиглах, захиран зарцуулах гэрээний эрх зүйн хэлбэр болох концессын гэрээ хийх”-ийг санал болгожээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн судалгаанд** “Тогтвортой байдлын гэрээ нь үндсэндээ, хэрэв илүү таатай байхаар өөрчлөөгүй л бол, татварын хувийг тухайн гэрээнд гарын үсэг зурах үеийн төвшинд тогтоон царцаах болно гэсэн хөрөнгө оруулалтын талаар энгийн үгээр илэрхийлэгдсэн байж болно. Гэтэл компаниуд нь тогтвортой байдлын гэрээг илүү өргөн хүрээнд тодруулбал, бодит болон хүлээгдэж буй эрсдлүүдийг хянах, улмаар Засгийн газрын зүгээс үзүүлж болох аливаа нөлөөллөөс хамгаалах зорилгоор хэрэглэн,

төслөө улс орны үйлчилж буй хуулийн хүрээнээс ангид авч үзэхийг чармайдаг. Тогтвортой байдлын гэрээнд дараах заалтуудыг нэмж оруулах нь компаниудын дунд нийтлэг байдаг. Үүнд:

- Татвараас чөлөөлөх хугацааг нь сунгах
- Татварын хувь хэмжээг бууруулах
- Импортын татвараас чөлөөлөх хугацааг сунгах
- Одоо хийгдэж буй гэрээнд ирээдүйд хэрэгжүүлэх төслүүдийг хамруулах
- Усны эрх болон байгаль орчинтой холбоотой асуудлууд зэрэг өөр төслийн параметрүүдийг баталгаажуулах
- Гол нөлөөлөх хүчин зүйлсийн хугацааг өөрчлөх
- Бусад хуулиудын үйлчлэх хүрээг хязгаарлах
- Мөрдөгдөж буй хуулиар олгогдоогүй эрхийг баталгаажуулах
- Ерөнхийдөө, тухайн төслийг одоогийн үйлчилж буй хууль эрх зүйн хүрээнээс салангид авч үзэх зэрэг болно.

Уул уурхайн компаниуд нь хувь эзэмшигчид, төслийг санхүүжүүлэгч банк, санхүүгийн байгууллага зэрэг олон субъект, гадаад хүчин зүйлийн дарамтад ажилладаг бөгөөд тэдгээр нь мөн бодит болон болзошгүй эрсдлүүдээ боломжит бага хэмжээнд байлгахыг зорьдог гэдгийг анхаарах нь зүйтэй. Энэ зорилгоор компаниуд нь, ялангуяа Монгол шиг хуулиараа зөвшөөрөгдсөн оронд, аль болох тогтвортой байдлын гэрээ байгуулахыг зорьдог. Тогтвортой байдлын гэрээ нь хөрөнгө оруулагчдын хүлээж байгаагүй тийм явдлаас ч зарим тохиолдолд хамгаалж чаддаг тул уул уурхайн компаниуд нь уг гэрээг байгуулахыг ихэд хүсэмжилдэг байна. Хэрэв илүү таатай хууль батлагдвал тогтвортой байдлын гэрээгээ орхин ердийн татварын системд захирагдах тухай заалтыг ихэнхи тогтвортой байдлын гэрээнд оруулдаг" гэжээ. ***Эх сурвалж: Ч.Базар, С.Дорждагва "Ашигт малтмалын орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний талаархи харьцуулсан судалгаа, бусад орны туршлага". 2009 он***

**2.3. Хувьцааг арилжаалах тухайд**

**Гэрээнд тусгагдсан байдал:** Гэрээний 1.8-д ... хөрөнгө оруулагчийн нийт энгийн хувьцааны 34 /гучин дөрөв/ хувьтай тэнцэх энгийн хувьцааг Хувь нийлүүлэгчдийн гэрээний дагуу шинээр гарган Төрд шилжүүлснээр Хөрөнгө оруулагч нь Ашигт малтмалын тухай хуулийн 5.5.5-д заасны дагуу Хөрөнгө оруулагчийн хүлээх бүх үүргийг хангаж байгааг зөвшөөрч байна"

**2.3.1. Гаргасан санал, зөвлөмж:**

- Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал, Др. Р.Содхүү "Гэрээний 1.8, 15.2,3 гэсэн заалтад Монголын талын эзэмших хувийн 10-ыг нь арилжаалах мэтээр оруулчихсан байгааг Ашигт малтмалын тухай хуулийн 5.5.6 дахь заалт буюу "ашигт малтмалын ордыг ашиглаж байгаа компани нийт хувьцааныхаа 10 хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах" гэсэн заалт энэ гэрээгээр хэрэгжих ёстой. Энэ нь Засгийн газрын эзэмших хувиас ангид байх ёстой гэдгийг Гэрээгээр өөрчилж өгвөл Монголын ард түмэн хэдэн арван жилээр энэ ордоос хувь хүртэнэ";

- Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Л.Цэвээнравдан "Монголчууд Канадад бүртгэлтэй Айвенхоу Майнз Инк компанийн хувьцаанаас



UIH.MN СУДАЛГААНЫ САН

бусад хөрөнгийн биржээр дамжуулан худалдан авах, эсвэл цаашдаа МХБ-д давхар листингээр бүртгүүлэх ажлыг зохион байгуулан ард олон нийтээрээ хувьцааг нь худалдан авах. Эсвэл Айвенхоу Майнз Инк компанийг Монголын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй болгох;

- МАХН-ын "Уламжлал шинэчлэл, ардчилал, шударга ёс жигүүр"-ийн ил захидалд "Киргизийн Засгийн газар 740 тн алтны нөөцтэй Кумторын ордыг эзэмших гэрээг 2003 оноос 6 жил үргэлжилсэн хэлэлцээрийн үр дүнд Канадын "Камеко" компанитай хамтран ажиллах гэрээ хийж, Киргизийн Засгийн газар "Камеко" компанитай хамтран Торонтогийн бирж дээрх хувьцааны 33 хувийг эзэмшихээр болсон нь энэ хувьцааны өнөөгийн зах зээлийн үнэлгээ 1.5 тэрбум ам.доллартай тэнцэж, үүнээс 15 хувийг нь үнэгүй эзэмшихээр тохиролцож чадсан. Манайд ийм замаар хийх боломж бий".

**2.4. Хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа**

**Гэрээнд тусгагдсан байдал:** Гэрээний 3.1-д Хөрөнгө оруулагч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл тус бүрийг олгосноос хойш эхний ээлжинд 30 /гуч/ жилийн хугацаагаар эзэмшиж, уг хугацааг Ашигт малтмалын тухай хуулийн 27.17, 28.1-д заасны дагуу 2 /хоёр/ удаа тус бүр 20 /хорин/ жилийн хугацаагаар сунгуулах эрхтэй"

***Гэрээний хугацааг 30 жил гэж хатуу заасан нь буруу буюу хэтэрхий урт гэж***

а/. "Ардын эрх" сонинд нийт 4

б/. "Зууны мэдээ" сонинд 10

в/. "Монголын мэдээ" сонинд 9

г/. "Нийгмийн толь" сонинд 3

е/. "Үнэн" сонинд 1 /эх сурвалж ИНБ/

ё/. "Үндэсний шуудан" сонинд 4

ж/. "Өнөөдөр" сонинд 1 нийт 41 материал нийтлэгдэж, эдгээр нь нийт мэдээллийн 8.9 %-ийг эзэлж байна.

тус тус нийтлэгджээ.

**2.4.1. Шүүмжилсэн гол асуудал:**

- Т.Балжинням "Гэрээг 30 жилээр хийх нь маш их эрсдэлтэй. Эрдэнэт үйлдвэрийн Засгийн газрын хоорондын гэрээг 5 жилээр хийдэг жишгийг ашиглах хэрэгтэй";

- МУ-ын Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр "Гэрээг 30 жилийн хугацаатай хийж, 20, 20 жилээр сунгасаар байгаад 70 жилийн гэрээ болчихож байна. Уг нь 15 жилийн гэрээ хангалттай, үүнийг засах хэрэгтэй";

- УИХ-ын гишүүн Ц.Нямдорж "Гэрээний хугацааг 15 жил болговол Монголд хөрөнгө оруулагч олдохгүй";

- УИХ-ын гишүүн З.Энхболд "Гэрээний хугацааг 15 жилээр хийе гэж Эдийн засгийн байнгын хорооноос чиг өгсөн. Парламент алдаа гарлаа гэхэд бидний хойч үе засах боломж бололцоог гаргаж өгөх ёстой. Хэрэв 30 жилээр гэрээ хийвэл юу ч үгүй болсон хойно алдаагаа засья гэх магадлал өндөр"

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Нийгмийн толь “1997 оны Ашигт малтмалын тухай хуульд 34 хувь, 30 жилийн хугацаа гэж байгаагүй. Ийм удаан хугацаагаар “айлд” үнэ төлбөргүй шахуу ашиглуулах гээд байна.

**2.4.2. Гаргасан санал, зөвлөмж**

- УИХ-ын гишүүн Ш.Сайхансамбуу “Гэрээ байгуулах хугацааг 15 жил болгож, 5, 5 жилээр үр дүнг нь тооцох”;
- Гэрээний хугацааг 15-20 орчим жил болгох;
- Нөөцийн тодорхой хувийг ашигласны дараа гэрээг шинэчлэх;
- 30 жилийн хугацаатай байгуулахын оронд нөөцийн тодорхой хувийг ашигласны дараа гэрээг шинэчлэх;
- Ашигт малтмалын тухай хуулийн 5,24, 29, 47, 69-р зүйлийг өөрчлөх;

**УИХ-ын Судалгааны төвийн судалгаанд:** Хугацааны хувьд тухайн ордын хэмжээ, улс орны нөхцөл байдлаас шалтгаалан харилцан адилгүй байдаг. Олон улсын туршлагаас харахад хугацаа тийм ч чухал биш. Судлаачид, иргэний нийгмийн санал гагцхүү хугацааг чухал болгож байгаа гол нөхцөл байдал нь гэрээний хугацаанд Монгол улсын эзэмших хувь өсөх боломжгүй байгаад л төвлөрч байна. Иймд төслийн хугацаанд Монгол улс хугацаанаас хамаарахгүйгээр 15-20 жилийн дараа эзэмших хувиа өсгөх боломжтой байх нь хугацааг богино болгохоос илүү хэрэгцээ юм. Бусад нөхцөл байдлыг гэрээний хугацаанд тогтвортой байлгах хувилбараар оруулж болно. Магадгүй хугацаа урт байх тусмаа их хэмжээний хөрөнгө оруулалтыг дотооддоо урт хугацаанд тогтвортой байлгаж үр өгөөжийг нь илүү хүртэх боломжийг бий болгож болно. Өөрөөр хэлбэл, зөвхөн бүтээгдхүүнээс ашиг хүртэх бус ажилчдын цалингаас эхлээд бусад дотоодод зарцуулагдах хөрөнгийг удаан хугацаанд тогтоон барих хэрэгтэй юм. ***Эх сурвалж: Ч.Базар, С.Дорждагва “Ашигт малтмалын орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний талаархи харьцуулсан судалгаа, бусад орны туршлага”. 2009 он***

**2.5. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль**

Гэрээнд тусгагдсан байдал: “Гэрээний 2.1.8-д Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн дагуу 2011 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болох”

***Гэнэтийн ашгийн 68 хувийн татварыг хүчингүй болгох нь Буруу гэж***

а/. “Ардын эрх” сонинд 3

б/. “Зууны мэдээ” сонинд 16

в/. “Монголын мэдээ” сонинд 8

г/. “Нийгмийн толь” 3 сонинд

д/. “Өдрийн сонин” 8 сонинд

е/. “Үнэн” сонинд 3

ё/. “Үндэсний шуудан” сонинд 3

ж/. “Өнөөдөр” сонинд 2 нийт 46 материал нийтлэгдэж, эдгээр нь нийт мэдээллийн 10.0 %-ийг эзэлж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**2.5.1. Шүүмжилсэн гол асуудал:**

- МАХН-ын “Уламжлал шинэчлэл, ардчилал шударга ёс жигүүр “Энэ татварыг тэглэх нь бусад орны хамтарсан үйлдвэрүүдийг ялгаварлан гадуурхсан, зэсийн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төрийн стратегийн бодлогоос татгалзсан, байгалийн баялгийг ямар ч боловсруулалтгүй гадагшаа зөөх болж байна.

- МАХН-ын “Уламжлал шинэчлэл, ардчилал шударга ёс жигүүрийнхний “Гэнэтийн ашгийн 68%-ийн татварыг тэглэх хувилбарыг гэрээний төсөлд оруулж ирсэн нь бусад орны хамтарсан үйлдвэрүүдийг ялгаварлан гадуурхсан” гэжээ.

- УИХ-ын гишүүн Д.Энхбат “68%-ийн татвараас чөлөөлснөөр 18 тэрбум ам.доллар алдаж, 36 жилд олох мөнгөө “татвараас чөлөөлөх” нэрээр алдаж байна.

**2.5.2. Гаргасан санал, зөвлөмж:**

- УИХ-ын гишүүн Р.Раш “68 %-ийн татварыг талаар нь буюу 3 4%-иар авъя”;

- Сэтгүүлч А.Баатархуяг “68%-ийн татварыг хөнгөлдөг юм гэхэд энэ татвараас орох ёстой мөнгөөр боловсруулах үйлдвэр барих ёстой гэдгийг хөрөнгө оруулагч талаас шаардах”;

- Хүчингүй болгохгүйгээр хувь хэмжээг нь бууруулах;

- Эдийн засагч Н.Дашзэвгэ “Гэнэтийн ашгийн татвар төлөх боломжгүй гэдгээ эдийн засгийн тооцоогоор харуулах”;

- УИХ-ын гишүүн С.Бямбацогт “Гэнэтийн ашгийн татвараа авч эх орондоо эцсийн бүтээгдэхүүн боловсруулах ёстой. Гэнэтийн ашгийн татвар нь ашигт малтмалын үнэ өндөр байхад ахиу, унасан үед бага гэх зэргээр уян хатан байх боломжтой”.

**УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн судалгаанд:** Нэг гэрээнд зориулж хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийг өөрчлөх нь шийдвэр гаргагчдыг элдэв төрлийн хардлага сэжигт өртүүлнэ. Гэнэтийн ашгийн албан татвар бол эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлого зорилтоос үүдэлтэй алхам байсан. Тийм учраас металлургийн үйлвэр байгуулах чиглэл рүү бид шахалт хийх ёстой. Гэрээнд зориулж хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг үл хэрэгсэх, эсвэл өөрчлөх нь зохимжгүй юм. Зарим шинжээчид үүнийг “лобби” гэж нэрлэсэн. Энэ хуулийн зорилго нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтыг дэмжихэд чиглэгдсэн бөгөөд энэхүү зорилтынхоо хүрээнд металлургийн үйлдвэр байгуулах заалт оруулж хуулинд хязгаарлалт хийх саналыг эрдэмтэд дэвшүүлж байна. ***Эх сурвалж: Н.Түвшинтөгс, Г.Чулуун “Оюу толгойн ордыг ашиглах гэрээний төслийн талаархи судлаачдын шүүмж, зарим харьцуулалт***

UILMN СУДАЛГААНЫ САН

**2.5. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль /Гэнэтийн ашгийн 68 хувийн татвар/-ыг хүчингүй болгох нь Зөв гэж**

а/. “Ардын эрх” сонинд 1

б/. “Зууны мэдээ” сонинд 0

в/. “Монголын мэдээ” сонинд 2

г/. “Нийгмийн толь” 3 сонинд

д/. “Өдрийн сонин” 3 сонинд

е/. “Үнэн” сонинд 5

ё/. “Үндэсний шуудан” сонинд 3

ж/. “Өнөөдөр” сонинд 1 нийт 18 материал нийтлэгдэж, эдгээр нь нийт мэдээллийн 4.0 %-ийг эзэлж байна.

**2.5.1. Шүүмжилсэн гол асуудал:**

- ОУВС “Энэ татварын хэмжээ хэт өндөр. Монголд авч буй бусад татвартай хамтатган тооцвол тус улс уул уурхайн салбартаа дэлхийд хамгийн их татвар тогтоосон орон болж байна. Гэнэтийн ашгийн татвар нь хэсэгхэн хугацаанд ашгаа өгөөд цаг хугацаа өнгөрөх тутам ач холбогдолоо алддаг”
- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун “Уул уурхайн компаниудын нэг нь ч 68%-ийн татварыг дэмжээгүй. Энэ татвар бий болсноор олон улсын зах зээлд тухайн салбарын нэр хүнд буурсан. Хэдийгээр төсвийн орлогыг нэмэгдүүлсэн ч тухайн салбарыг хөгжихөд саад болсон”.

**2.5.2. Гаргасан санал, зөвлөмж**

- Уг татвараар олж байсан орлогыг орлох өөр хэлбэрийн татвар, бусад эх үүсвэрийг бий болгох;

- УИХ-ын гишүүн Д.Ганхуяг “68%-ийн татварыг шаталсан нөөцийн татвар хэлбэрээр өөрчлөх боломж байна. Босгыг ч нэмэгдүүлж болно”;

- Ерөнхий сайд асан Д.Содном “68%-ийн татварыг 20-30% хүртэл багасгах боломжтой”;

- УИХ-ын гишүүн С.Бямбацогт “Энэ татварыг Монгол улсад ашигтай нөхцөлд тохиролцож гэрээг сайжруулах нь чухал” ;

- ОУВС “Судалгаанаас үзэхэд Гэнэтийн ашгийн татвар нь түүнийг хуульчилсан бараг бүх орон, төр засгийн урмыг хугалж байсан байдаг. Тиймээс хэсэг хугацааны дараа хүчингүй болгож байжээ. Иймд Гэнэтийн ашгийн татварыг үргэлжлүүлэн мөрдөж, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад тааламжгүй нөхцөл байдлыг хэвээр үлдээх нь МУ-ын эдийн засгийн шинэчлэл хөгжлийг олон жилээр хойш татаж болзошгүй”;

- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун “Төсвийн орлогыг бууруулахгүйн тулд нөөц ашигласны төлбөрийг бий болгох”;

**2.6. Гэрээ нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль зөрчсөн гэж:** */Үүнд: Ашигт малтмалын тухай хууль Үндсэн хуультай зөрчилддөг, Орд ашиглах лиценз олгохдоо хууль зөрчсөн, ТЭЗҮ-гүй Хөрөнгө оруулалтын гэрээ батлаж хууль зөрчсөн, Хөрөнгө оруулалтын гэрээг эрх зүйн чадамжгүй субьектүүд байгуулсан, Гэрээнд буюу ганц компанид нийцүүлж АМТХ-ийг өөрчилсөн нь Үндсэн хууль зөрчсөн гэсэн асуудлууд багтана/*

а/. “Ардын эрх” сонинд 5

б/. “Зууны мэдээ” сонинд 72

в/. “Монголын мэдээ” сонинд 13

г/. “Нийгмийн толь” сонинд 1

д/. “Өдрийн сонин” сонинд 4

е/. “Үнэн” сонинд 3

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ё/. “Үндэсний шуудан” сонинд 6

ж/. “Өнөөдөр” сонинд 3 нийт 109 материал нийтлэгдэж, эдгээр нь нийт мэдээллийн 23.69 %-ийг эзэлж байна.

**2.6.1. Шүүмжилсэн гол асуудал:**

*а/. Ашигт малтмалын тухай хуулийн 29, 30-р зүйл заалтыг зөрчиж гэрээ байгуулсан*

- Др. С.Авирмэд, Судлаач н.Балжинням “Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох зүйл заалтыг засч залруулахгүйгээр гэрээг баталбал Монголын эрх ашиг ноцтой зөрчигдөнө;
- УИХ-ын 57-р тогтоолын зүйл заалтыг Засгийн газар, ажлын хэсэг биелүүлээгүй;
- Одоогийн Ашигт малтмалын тухай хуульд стратегийн ордод төр хяналтаа хэрэгжүүлэх, төр хяналтын багц хувьцаа эзэмших эрх зүйн зохицуулалт байхгүй;
- Төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг тогтоосон орд газрын 50%-ийг төр эзэмших, хувийн хөрөнгөөр бол 34% гэсэн хуулийн заалт хэрэгжихгүй байна;
- ТЭЗҮ-ийг хянаж хэлэлцээгүй байхад ХОГ-нд гарын үсэг зурсан нь Ашигт малтмалын тухай хуулийн зүйл заалтыг зөрчсөн;
- Хөрөнгө оруулалтын гэрээг эрх зүйн чадамжгүй субьектүүд байгуулсан;
- Гэрээнд буюу ганц компанид нийцүүлж хуулиудын зүйл заалтыг өөрчилсөн нь Үндсэн хуулийн тэгш байх зарчмыг алдагдуулсан;

**2.6.2. Гаргасан санал, зөвлөмж:**

- “Монголын уул уурхайн инженерүүдийн хөдөлгөөний тэргүүн, доктор Ч.Владимир, МАХН-ын “Уламжлал шинэчлэл, ардчилал, шударга ёс” жигүүр “Ашигт малтмалын тухай хуулийн 5.4, 5.5 дахь заалтыг Үндсэн хуулийн 6.1, 6.2 заалтуудад нийцүүлэн шинэчлэх”;
- УИХ-ын гишүүн З.Энхболд “Айвенхоу Майнз Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд бусад хөрөнгө оруулагчидтай ижил эрх хэмжээнд ажиллах”;
- Мэргэжилтэн Б.Батсайхан “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг ямар нэгэн байдлаар бусдад шилжүүлэх, худалдахыг хориглох” гэж Ашигт малтмалын хуулинд оруулах;
- Хөрөнгө оруулалтын гэрээг цуцлах;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**УИХ-ын тамгын газрын Судалгааны төвийн судалгаанд** “Тогтвортой байдлын гэрээний талаархи Монгол улсын хуулиуд дахь зөрчлүүд:

“Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хууль”-ийн 19-р зүйл буюу Тогтвортой байдлын гэрээ /энэ зүйлийг 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар нэмсэн/ гэсэн заалтын нэгд “Монгол улсад 20 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс доошгүй хэмжээний хөрөнгө оруулах оруулагч хүсэлт гаргавал түүний үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах эрх зүйн баталгаа болгож Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж татварын бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг хөрөнгө

оруулагчтай тогтвортой байдлын гэрээг байгуулж болно. /Энэ хэсэгт 2008 оны 5-р сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

"Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хууль"-ийн 19.2-д "Гадаадын хөрөнгө оруулагчийн анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь 20 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх хөрөнгө байхаар бол тогтвортой байдлын гэрээг 10 жил, 50 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байхаар бол 15 жилээр тус тус байгуулна. /Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль"-ийн 29.1-д "Үйл ажиллагааныхаа эхний 5 жилд Монгол улсын нутаг дэвсгэрт 50 саяас дээш ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийх ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана" гэжээ.

"Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль"-ийн 29.3-д "Эхний 5 жилийн хөрөнгө оруулалтын хэмжээ 50 саяас дээш ам.доллартой тэнцэх бол 10, 100 саяас дээш ам.доллартой тэнцэх бол 15, 300 саяас дээш ам.доллартой тэнцэх бол 30 жилийн хугацаагаар энэ хуулийн 29.1-д заасан гэрээ байгуулна. Хөрөнгө оруулалтын гэрээний талаархи хоёр хуулийн заалтыг харьцуулан үзэхэд дараах зөрчлүүд илэрч байна:

1. Хөрөнгө оруулалтын хэмжээ
2. Лиценз эзэмших буюу гэрээний хугацаа
3. Хэн Засгийн газрыг төлөөлж хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах зэрэг асуудлууд байгаа бөгөөд үүний уршиг нь хуулийн хүрээнд гэрээ байгуулах эрхийн баталгаа ойлгомжгүй, аль хуулийг мөрдлөг болгох нь ойлгомжгүй гэх мэт зөрчлүүд гарч ирж байгааг хооронд нь уялдуулах шаардлагатай байна" гэжээ. ***Эх сурвалж: Ч.Базар, С.Дорждагва "Ашигт малтмалын орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний талаархи харьцуулсан судалгаа, бусад орны туршлага". 2009 он***

### 2.7. Ус ашиглалт

**Гэрээнд тусгагдсан байдал:** Гэрээний 6.17-д Оюу толгойн орд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамрагдсан тул Хөрөнгө оруулагчтай Ус ашиглах гэрээг Усны тухай хуулийн дагуу 30 /гуч/ жилээр байгуулж, уг гэрээг 20 /хорь/ жилийн хугацаагаар тухай бүр сунгаж болно.

***Ус ашиглалтын гэрээ нь байгаль орчинд сөргөөр нөлөөлнө гэж:***

а/. "Ардын эрх" сонинд 4

б/. "Зууны мэдээ" сонинд 10

в/. "Монголын мэдээ" сонинд 5

г/. "Нийгмийн толь" сонинд 4

д/. "Өдрийн сонин" сонинд 0

е/. "Үнэн" сонинд 4

ё/. "Үндэсний шуудан" сонинд 4

ж/. "Өнөөдөр" сонинд 3 нийт 34 материал нийтлэгдэж, эдгээр нь нийт мэдээллийн 7.39%-ийг эзэлж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**2.7.1. Шүүмжилсэн гол асуудал:**

- Ус ашиглах гэрээг 50 жилээр хийх нь хэтэрхий урт хугацаа байна;
- УИХ-ын гишүүн Д.Энхбат "250 метрийн гүнд байгаа усны 50 хувийг буюу 100 метрийг нь ашиглахаар гадаргын усанд нөлөөлж багасахыг хүлээн зөвшөөрөх, байгаль орчны гамшиг үүсвэл тухайн компаниас нөхөн төлбөр авах ч усны хэрэглээг зогсоох эрхгүй байх нь  50 жилийн турш Засгийн газар усандаа хяналт тавьж чадахгүй боллоо. Гүний ус жилд 1 мм-ээр нөхөгддөг учир 10 мянган жилийн дараа л сая хуучин шигээ болох нь";
- Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд усны үнийг тогтворжуулаагүй;
- Үнэн сонин "Усыг нэг компанид давуу эрхтэйгээр ашиглуулах нь. Говийн энэ том төсөлд гүний усыг ашигласнаар гадаргын ус, байгаль орчинд сөргөөр нөлөөлнө";

**2.7.2. Гаргасан санал, зөвлөмж:**

- УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ "Оюутолгойг онцлохгүйгээр өнөө мөрдөж буй усны хуулийн дагуу 20 жилээр гэрээ хийх"
- Усны тухай хуулийн өөрчлөлтийг хүчингүй болгож шинэчлэх;
- ТЭЗҮ болон гэрээнд байгаль орчин экологийн талаархи хариуцлагын асуудлыг тодорхой болгох;
- УИХ-ын гишүүн Ш.Сайхансамбуу "Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг гаргах";
- Х.Владимир "Ордыг ашиглахад усны нөөц хүрэлцээтэй эсэх талаархи үнэлгээнд олон улсын шинжээчдийг оролцуулах";
- Х.Владимир "Гүний устай холбоотой байгаль орчны нөлөөллийг судлах";
- УИХ-ын гишүүн Р.Раш "Үйлдвэрийнхээ ашигласан усыг цэвэршүүлээд хэрэглэх";
- УИХ-ын гишүүн Ж.Ганбямба "Манай улсын усны байгууллагууд дүгнэлт гаргах ёстой";
- Др.проф.Г.Пүрэвбаатар "Байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг 15 жилээр тогтоож, жил бүрийн зардлыг /мөнгийг/ 3Г-ын тусгай дансанд төвлөрүүлж, хөндлөнгийн компаниар нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх

**2.8. Зэс хайлуулах, боловсруулах  үйлдвэр**

**Гэрээнд тусгасан байдал:** Гэрээний 3.21-23-р зүйл заалт бүхэлдээ хайлуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд  чиглэгджээ. Тухайлбал 3.23-д "Хөрөнгө оруулагч нь Оюу толгой төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хайлуулах үйлдвэр барих бол уг үйлдвэрийг Монгол улсад барина."

***Үйлдвэр барихгүйгээр баяжмалаа дангаар нь экспортлох нь буруу гэж***

а/. "Ардын эрх" сонинд 2

б/. "Зууны мэдээ" сонинд 0

в/. "Монголын мэдээ" сонинд 2

г/. "Нийгмийн толь" сонинд 4

UIH.MN ЗӨВЛӨЛДӨХ САН

д/. “Өдрийн сонин” сонинд 5

е/. “Үнэн” сонинд 4

ё/. “Үндэсний шуудан” сонинд 3

ж/. “Өнөөдөр” сонинд 2 нийт 22 материал нийтлэгдэж, эдгээр нь нийт мэдээллийн 4.78 %-ийг эзэлж байна.

### 2.8.1. Гаргасан санал, зөвлөмж:

*а/ Зэс хайлуулах үйлдвэр барих*

- Зэс хайлуулах үйлдвэрийг Монгол улс дангаараа эсвэл өндөр технологи бүхий гадныхантай хамтран байгуулах

- Ерөнхий сайд асан Д.Бамбасүрэн “Зэс хайлуулах үйлдвэр баривал 40 орчим ам.доллар, баяжмалаар гаргавал 19 ам.долларын ашиг л Монголын талд ноогдоно”.

- МАХН-ын “Уламжлал, шинэчлэл, ардчилал шударга ёс” жигүүр ”Оюутолгойн зэсийн баяжмал доторх алт, мөнгийг олон улсын практикт байдаг нэвтэрсэн Толлингийн хэлэлцээрээр хайлуулах үйлдвэрээс алт зэсээ хайлшаар нь эргүүлэн авч Монгол банкинд тушаах ашигтай хувилбарыг гэрээний төсөлд тусгах”

## 2.9. Татварын орчин

**Гэрээнд тусгагдсан байдал:** Гэрээний хоёрдугаар бүлэг бүхэлдээ татварын орчинг тодорхойлжээ. 29.1.1-д Талууд дараахь татварыг тогтворжуулахаар харилцан тохиров. Үүнд: ААН-ийн орлогын албан татвар /10-25%/, Гаалийн албан татвар, НӨАТ, гэрээний 2.23-д зааснаас бусад тохиолдолд Онцгой албан татвар, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /роялти/, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар /2%/ зэргийг тогтворжуулахаар гэрээнд тусгагджээ. Түүнчлэн Татварын ерөнхий хуулийн /энэхүү гэрээг байгуулсан өдөр хүчин төгөлдөр үйлчилж байсан /7 дугаар зүйлд заасан, дээр дурьдсанаас бусад төрлийн татвар /цаашид “Үл тогтворжуулсан татвар” гэх/-ыг Монгол улсад тухайн татварын жилд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын дагуу төлнө.”

***Татвар, тэдгээрийг тогтворжуулах тухайд:***

а/. “Ардын эрх” сонинд 0

б/. “Зууны мэдээ” сонинд 0

в/. “Монголын мэдээ” сонинд 6

г/. “Нийгмийн толь” сонинд 0

д/. “Өдрийн сонин” сонинд 2

е/. “Үнэн” сонинд 1

ё/. “Үндэсний шуудан” сонинд 6

ж/. “Өнөөдөр” сонинд 1 нийт 16 материал нийтлэгдэж, эдгээр нь нийт мэдээллийн 3.47 %-ийг эзэлж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### 2.9.1. Шүүмжилсэн гол асуудал:

- Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн “Өөрсдөө боловсруулж хайлуулахгүй баяжмалаар нь гаргахад дагалдах баялагаас /алт, мөнгө/ олох ашгийн тооцоог хийгээгүй байна”;

- ННФ "Уг гэрээгээр Монголын талд орох орлого цаг хугацааны хувьд нилээд цаашилж, төслийн үр ашиг их өндөр байхад хөрөнгө оруулагч тэр ашгаас илүү хувиар хүртэх байдал ажиглагдаж байна. Тухайлбал, алдагдлыг ирээдүйд шилжүүлэн татвар ноогдох ашгаас хасч тооцох, хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт тооцох, давуу эрхтэй хувьцааг зөвхөн Айвенхоу майнзд гаргах ба түүнд илүү тооцох, энгийн хувьцаанд ноогдол ашиг тооцсон ч нийт хуваарилж болох ашгийн 50-аас дээш хувийг тараах бол Удирдах зөвлөл буюу Айвенхоу майнз шийдэх зэрэг заалт нь бүгд Монголын талд орох орлогыг цаг хугацааны хувьд холдуулж эрсдлийг шилжүүлж байгаа хэрэг юм";

- ННФ "Оюутолгойн бүхий л бүтээгдэхүүн түүний дотор экспортлох баяжмалд НӨАТ-ыг "тэг" хувиар тооцно гэж заасан байна. /ХОГ-2.19. 2/";

- МАХН-ын "Уламжлал шинэчлэл, шударга ёс, ардчилал" жигүүр "Татварын тогтвортой байдлыг гэрээний хугацаатай адил байхаар заасан нь 7 төрлийн татварыг 30 жилийн хугацаатай царцааж, Монгол улсын төсөвт орох бодит орлогыг хэт багасгажээ".

**2.9.2. Гаргасан санал, зөвлөмж:**

- УИХ-ын гишүүн З.Энхболд "Хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлэх ёсгүй";

- Ерөнхийлөгчийн зөвлөх П.Цагаан "Татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэхгүйгээр татварын орчинг тогтвортой байлгах зарчим баримтлан, уурхайгаа байгуул, татвараа шударгаар төл, байгаль орчноо нөхөн сэргээх гэсэн уул уурхайн бизнесийн сонгодог зарчмыг баримтлах";

- Монгол улсын Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн "Шаталсан татвараа төл, олборлоод баяжмал болгон, түүнийгээ Монгол улсад өгөх ёстой гэсэн заалттай гэрээ байгуулбал илүү ашигтай";

- ННФ "ХОТ-ын хөнгөлөлтийг төслийн эхний үе шатанд, харин НӨАТ-ын буцаан авалтыг төслийн үргэлжлэх хугацааны турш эдлэх боломжтой ба хөрөнгө оруулагчид давхар ашигтай нөхцөл үүсч болзошгүйг санах";

- ННФ "НӨАТ буцаан авч болох заалтууд гэрээний бусад /ХОГ-2.27, 2.28/ хэсэгт байгааг өөрчлөх шаардлагатай";

- Д.Лхагважав "Гэрээ байгуулсны дараа татварын хуулиараа дамжуулан хяналт тавих тул татварын системээ шинэчлэх, татвараа зөв авах асуудал чухал байна";

УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн хийсэн судалгаанд "1. НӨАТ-ын 6 төрлийг Гэрээнд тусгасан байгаагийн нэгд нь 10 хувийн татвар ногдож, бусад төрлийг холбогдох хуулийн дагуу тэглэсэн. Үүнд НӨАТ-ыг төлөхдөө хуульд зааснаас экспортолсон бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд тэглэж, Гэрээнд зөвхөн алтанд татвар ногдуулахаар өөрчилсөн нь Монгол Улсын НӨАТ-аас ашиг олох гол бараа зэсийг экспортод гаргахад татвар төлөхгүй хэвээр үлдэж байна.
2. АММтХуулийн 32.2-дахь заалтыг Гэрээнд тусгаагүй орхигдуулсан байна: 32.2. Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 0,1 америк доллар, 2 дахь жилд 0,2 америк доллар, 3 дахь жилд 0,3 америк доллар, 4-6 дахь жилд тус бүр 1,0 америк доллар, 7-9 дэх жилд тус бүр 1,5 америк доллар байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

3. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу ногдуулахаар оруулсан боловч хайгуулын төлбөрийг орхидуулсан байна” гэсэн дүгнэлтийг хийв.
**Эх сурвалж: Референт-судлаач Г.Билгээ. “Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан татварын төрөл, хувь хэмжээ”. 2010.05**

**2.10. Техник эдийн засгийн үзүүлэлт**

а/. “Ардын эрх” сонинд 4

б/. “Зууны мэдээ” сонинд 9

в/. “Монголын мэдээ” сонинд 3

г/. “Нийгмийн толь” сонинд 5

д/. “Өдрийн сонин” сонинд 5

е/. “Үнэн” сонинд 7

ё/. “Үндэсний шуудан” 3 сонинд

ж/. “Өнөөдөр” сонинд 3 нийт 39 материал нийтлэгдэж, эдгээр нь нийт мэдээллийн 8.47%-ийг эзэлж байна.

**2.10.1. Шүүмжилсэн гол асуудал:**

- Хөрөнгө оруулагч тал уурхай барих зардлыг 5 тэрбум ам.доллар байсныг 1 тэрбумаар бууруулсан нь ТЭЗҮ-г нарийн тооцож гаргаагүйг харуулж байна. Энэ нь манай мэргэжилтнүүдийн ордыг 2.5 тэрбум ам.доллараар уурхай барьж болно гэсэн нь үнэний ортой байж болно;

- ТЭЗҮ-г хянаж хэлэлцээгүй байхад ХОГ-нд гарын үсэг зурсан нь Ашигт малтмалын тухай хуулийн зүйл заалтыг зөрчсөн;

- С.Авирмэд, Ч.Хурц, М.Дамдинсүрэн “ТЭЗҮ-г боловсруулахад ашигласан анхдагч өгөгдөл, үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо зарчмын хэд хэдэн алдаа гаргасан”;

- Р.Эрхэмбаяр “ТЭЗҮ нь Монгол улсын холбогдох хууль, стандарт, шаардлагыг баримтлаагүй, тусгасан тоо, үзүүлэлтүүд нь өөр хоорондоо зөрчилтэй, тооцоог хийхдээ наад захын алдаа гаргасан”;

- УИХ-ын гишүүн Х.Бадамсүрэн “Техник, эдийн засгийн үндэслэлийг хугацаанд нь хийчих боломж байсан. Гэрээг хэлэлцэх явцад энэ асуудал яригдаж л байсан”.

**2.10.2. Гаргасан санал, зөвлөмж:**

- Зэсийн үйлдвэрлэлийн инженер металлург С.Дамбадаржаа “ТЭЗҮ-д хийх нарийвчилсан шинжилгээ хэрэгтэй байна. Шинжээчдийн багт дотоодын шилдэг мэргэжилтэнг оруулья”;

- Эдийн засагч Н.Дашзэвгэ “ТЭЗҮ-г үндэсний шинжээчдийн 2-оос доошгүй баг хянаж, санал дүгнэлт хийвэл хэнд ямар ашиг өгөх вэ гэдэг нь тодорхой болно”;

- Уул уурхайн чиглэлээр олон жил ажилласан чадварлаг мэргэжилтнүүдээр баг бүрдүүлэн яаманд судалгааны институт бий болгох;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- С.Авирмэд, Ч.Хурц, М.Дамдинсүрэн "Үйлдвэрийн оновчтой бүтэц, байгуулах хэлбэр, хүчин чадлыг тодорхойлсны дараа, зөвхөн үйлдвэрийн хөрөнгө оруулалт нь 2.5-2.7 тэрбум ам.доллароос хэтрэхгүй байх, гадаад дэд бүтцийг оруулбал 5 тэрбумаас хэтрэхгүй байх. Үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрсэн үед төсөвт орох ашиг жилд доод тал нь 400-500 сая доллароос дээш байх нөхцлүүдэд л ордыг ашиглах;

**2.11. Эдийн засгийн тооцоог тодорхой болгох**

**2.11.1. Шүүмжилсэн асуудал:**

- УИХ-ын гишүүн Д.Ганхуяг "2-3 хуудсанд багтсан энэ тайланд нийт нөөц, агууламж, борлуулах үнэ, нийт борлуулалт, нийт зардал, нэгж бүтээгдэхүүний өртөг, татвар төлөхийн өмнөх ашиг, татвараар улсын төсөвт орох орлого, авах ашиг, энэ ашгаас Монгол улс болон хөрөнгө оруулагч тал ямар хэмжээний ашиг авах зэргийг тодорхой болгох ёстой";

- Ж.Бямбаа "Гэрээнд нэг жил олборлох зэсийн баяжмалын дээд хэмжээг зааж өгөх, илүү олборлосон тохиолдолд хариуцлага хүлээлгэх";

**2.11.2. Судалгааны үр дүн:**

УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв нь 2009 оны 4-р сард "Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төсөлд үндэслэн уг ордыг ашиглах явцад Монгол улсад оногдох эдийн засгийн үр ашгийг тооцоолсон судалгааг хийж байхад гэрээний тоон үзүүлэлтүүд нь тодорхойгүй байв. Гэвч судлаачид тоон үзүүлэлтүүдийг тооцоонд ашиглахдаа төсөөллийн аргыг хэрэглэсэн ба гарсан үр дүнг бодитой хэмээн шууд дүгнэх боломжгүй байв.
Гэрээний Техник эдийн засгийн үндэслэл батлагдсан тул тус Төвөөс уг тооцоололд шаардагдах тоон үзүүлэлтүүдийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр дамжуулан авч тооцооллыг хийхэд өмнөх судалгааны дүнтэй адил үр дүн гарлаа. Тооцоог өмнөх судалгаанд хэрэглэсэн аргачлалын дагуу "Microsoft office, Excel 2007" программын функциональ томъёо бодолтын аргаар хийв. ТЭЗҮ дэх тоон үзүүлэлт бүрээр нарийвчлан тооцоолол хийх тохиолдолд хэт нүсэр, шууд ойлгоход бэрхшээлтэй үзүүлэлтүүд гарах тул хялбарчилж, энгийн ойлгомжтой болгох үүднээс төслийн хугацааны дунджаар тооцсон ерөнхий үзүүлэлтийг ашиглав.

<u>**Үндсэн үзүүлэлт:**</u>

1. Монгол улсын Засгийн газар нь төсөлд оруулах 34%-ийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээ Хөрөнгө оруулагч нөгөө талаасаа зээл хэлбэрээр авах болсон. **Энэ зээлийн хэмжээ–**2010 оноос эхлэн дараагийн 4 жилд Оюу Толгой төсөлд оруулах бодит хөрөнгө оруулалт нь татварыг оруулж тооцохгүйгээр 4.4 тэрбум ам.доллар болно. Үүнээс, Монгол улсын Засгийн газрын 34%-д оногдох нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь татварыг оруулж тооцоод ойролцоогоор **1.6 тэрбум орчим ам.доллар** болно.

2. **Дээрхи зээлийн жилийн хүү -** Хөрөнгө оруулалтын гэрээнд зээлийн хүүг 9.9%, дээр нь нэмэх инфляцийн тохиргоо хийнэ гэж тусгасан. Номиналь *(инфляц тооцсон)* хүүгийн хэмжээг ойролцоогоор **11%**-иар тооцсон.

3. **Монгол Улсын эзэмших 34%-д ноогдох жил бүрийн ноогдол ашгийн хэмжээ-** ТЭЗҮ тусгагдсан санхүүгийн загвар тооцоогоор Монгол улсын Засгийн газрын ногдол ашиг *(Dividend paid to Government)* нь төслийн нийт хугацаанд 11.329 тэрбум ам.доллар (*2010 оны долларын ханшаар*) байна. Энэ нь **жилд дунджаар 200 орчим сая ам.доллар гэсэн үг.**

UIH.MN СУДАЛГААНЫ САН

4. **Төслийн үргэлжлэх хугацааг эхний ээлжинд 30 жил байх** ба цаашдаа талууд тохиролцон 20, 20 жилээр сунгах боломжтой.

Өмнөх судалгаанд эдгээр тоон үзүүлэлтийг төсөөллийн аргаар гарган авч ашигласан бол энэ судалгаанд тус Тэвд албан ёсоор ирүүлсэн тоон үзүүлэлтийг ашиглан зээлийг хэдий хугацааны дотор төлж барагдуулах боломжтойг тооцоолоход ямар өөрчлөлт гарахыг үзье.

***<u>Зээлийг төлж барагдуулах хугацаа</u>***

Үүнийг дараах томъёогоор бодно:

**NPER (rate, pmt, pv)= Хугацаа** буюу NPER(11%, -200.000.000, 1.600.000.000)

**NPER-** төлбөр төлж дуусах хугацааг тодорхойлох функц

**Rate –** зээлийн хүүгийн хэмжээ - **11%**

**PMT-** жилд төлөх тогтмол төлбөр. Зээл ба хүүг 34%-д ноогдох ашгаас төлөх тул энэ үзүүлэлт **200.000.000** ам доллар. Бодолтод оруулахдаа төлбөрөөс хасагдах утгаар хасах тэмдэгтэй оруулна.

**PV-** Монгол улсад оногдох нийт үнэ буюу **1.6 тэрбум** ам доллар.




Энэхүү бодолтоос үзэхэд нийт зээлийг хүүгийн хамт **15** жилийн дараа төлж дуусахаар байна. Энэ нь 11 жилийн хугацаа шаардлагатай гэсэн үр дүн гарч байсан өмнөх судалгааны үр дүнтэй бараг адилхан байна. Гэвч энэ нөхцөл нь гэрээ байгуулсан жилээс эхлэн ногдол ашиг хуваарилах үед бодогдох нөхцөл юм.

Гэтэл ирүүлсэн ТЭЗҮ-ийн тоон үзүүлэлтээс харахад, Монгол улс 2022 оноос ногдол ашиг авч эхлэх юм. Ногдол ашгаасаа зээлээ хүүгийн хамт төлж эхлэхээр тооцвол 1,6 тэрбум ам долларыг 1 жилийн хүүг 11%-иар бодоход 176 сая ам.доллар болох юм. Ингээд 2022 он хүртэл 12 жилийн хугацаанд нийт зээл, хүү нийлээд 3.712.000.000 ам долларыг ногдол ашиг авч эхэлсэн үеэс төлж эхлэх болж байна. Ногдол ашиг авах хугацааг 2078 он хүртэл гэж тооцсон байсан. Үүний бодолтыг хийхэд дараах үр дүн гарч байна.

**<u>Нэг жилд төлөх төлбөрийн хэмжээ</u>**

Үүнийг дараах томъёогоор бодоход зээл ба хүүгийн нийлмэл төлбөрийн хэмжээ гарах ба мөн төслийн хугацааны хэдий үед нь хэр хэмжээтэй төлбөр төлөх боломжтойг давхар харуулах боломжтой юм.

**IPTM (rate, per, nper, pv)= Нэг жилд төлөх төлбөрийн хэмжээ** буюу IPTM (зээлийн хүү-11%, 1 жилийн үечлэл, нийт төлбөр хийх жилийн тоо-68, үндсэн төлбөр-3.712.000.000)

UIH.MN СУДАЛГААНЫ САН




Эндээс харахад, нэг жилд 408.320.000 ам долларыг төлөхөөр байгаа ба үүнийг жил бүр авах ногдол ашигтай (200.000.000) харьцуулахад 2 дахин их хэмжээтэй байна. Иймээс манай улс уг төслөөс ямар нэг үр ашиг хүртэх биш харин ч үүний зөрүү мөнгийг жил бүр төсвөөсөө гаргах хэрэгтэй болж байна.




UIH.MN СУДАЛГААНЫ САН

Харин ногдол ашгаа хүртэж болох наад захын хугацааг тооцож үзвэл зээлийн төлбөрөө 63 дахь жилээсээ төслийн хугацааны дунджаар тооцсон ногдол ашгаараа төлж чадахаар байна. Энэ нь Монгол улс гэрээний нийт 70 жилийн хугацаанд сүүлийн 5 жилдээ л ногдол ашиг авах боломжтой гэж үзэж болох боловч иргүүлсэн ТЭЗҮ-ийн тоон үзүүлэлтээр сүүлийн 5 жилийн ногдол ашгийн дундаж хэмжээ нь 48.400.000 ам доллар юм.

Эдгээр үр дүнгээс үзэхэд, төсөл дэх Монгол улсын хувь эзэмшил ба үүнтэй холбогдсон хөрөнгө оруулалтын зээл нь тус улсын эдийн засгийн хөгжилд тэр бүр үр нөлөөтэй байж чадахгүй болох нь харагдаж байна. Нөгөө талаас дахин сэргээгдэхгүй баялаг гэдэг утгаар нь авч үзвэл энэхүү гэрээнээс хохирол хүлээж байна гэж үзэж болох юм[100].

---

[100] УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн шинжээч Д.Мягмарцэрэн. ""Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ"-нээс Монгол улсын хүртэх үр ашиг". судалгаа. УБ., 2010.05.13

**2.12. Бусад асуудал**

***а/ Аудит хийлгэх, хяналт тавих***

*Шүүмжлэл:*

- *УИХ-ын гишүүн З.Энхболд "*Маргаан гарах тохиолдолд хөрөнгө оруулагч тал зохицуулах маш сайн хамгаалалт хийсэн байна. Хуулийн хэд хэдэн фирм ажиллаж, 30 жилийн дотор, эсвэл дараа шүүхэдвэл бид яах вэ, аль заалтыг зөрчвөл ямар замаар шийдэх вэ гэдгийг маш тодорхой оруулж өгсөн. Манайх энэ тал дээр дутуу. Ийм заалт гэрээнд тусгагдаагүй

*Санал:*

- УИХ-ын гишүүн Д.Ганхуяг, Д.Загджав "Хөрөнгө оруулалтын болон хайгуулын зардалд төрийн аудит хийлгэж, бодит зардлыг тогтоох ";
- УИХ-ын гишүүн Ч.Сайханбилэг "Хөрөнгө оруулалтын хэмжээнд олон улсын аудит хийлгэх";
- Эдийн засагч Н.Дашзэгвэ "Ерөнхий сайд ашгийн 55-77 хувийг Монголын тал авна гээд байгаа. Сангийн яам тооцоо хийсэн байлаа ч үүнийг шинжээчдийн баг хянах";
- УИХ-ын гишүүн З.Энхболд "Манайх гадаадын хуулийн компани хөлсөлж, гэрээний Англи хувилбарыг хянуулах хэрэгтэй";
- Д.Лхагважав "Гэрээнд маргаан гарвал Монгол улсын шүүх асуудлыг шийддэг байх ёстой";
- "Үнэн" сонин "Төсөл хэрэгжиж эхэлмэгц хяналтыг зэрэгцүүлж тавих";

***б/ Хариуцлагын баталгаа гаргах***

- Төслийг санхүүжүүлэх, үйлдвэр, дэд бүтэц барих, байгаль орчныг хамгаалах, уурхайг хаах зэрэг ажлыг зөвхөн Монголд бүртгэлтэй компани бус Рио Тинто, Айвенхоу компанид хариуцуулах;
- УИХ-ын гишүүн З.Энхболд " Гэрээг дэмжиж батлуулсан гишүүд гэрээ эрсдэлд орсон тохиолдолд хариуцлага хүлээх";
- "Зууны мэдээ" сонин "Гэрээ байгуулахад авилга өгсөн нь тогтоогдвол гэрээ шууд хүчингүй болно гэсэн заалтыг гэрээнд оруулах";
- "Зууны мэдээ" "Гэрээтэй холбоотой асуудлаар маргаан гарсан тохиолдолд хаана хандах нь тодорхойгүй байна";
- Др.проф.Г.Пүрэвбаатар "Байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг 15 жилээр тогтоож, жил бүрийн зардлыг /мөнгийг/ ЗГ-ын тусгай дансанд төвлөрүүлж, хөндлөнгийн компаниар нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх

***в/ Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийн талаар***

*Шүүмжлэл:*

- ТУЗ-д орох Монголын талын бүрэлдэхүүний тоо бага

*Санал:*

- УИХ-ын гишүүн Д.Одхүү, МАХН-ын "Уламжлал шинэчлэл, ардчилал, шударга ёс жигүүр" "Хувь нийлүүлэгчдийн гэрээнд ТУЗ-ийн 3/2 нь шийдвэр гаргах эрхтэй

UIH.MN СУДАЛГААНЫ САН

гэснийг хасах. Энэ нь төрөөс давсан эрхтэй заалт бөгөөд, түүнийг төрийн бодлогын хэмжээнд зөвшилцөх тухай өөрчилж төрийн бодлогын хэмжээнд зөвшилцөх тухай заалт оруулах";

- УИХ-ын гишүүн Ш.Сайхансамбуу "Монголын талаас 3, хөрөнгө оруулагч талаас 6 хүн байхаар заасныг өөрчилж 4:5 харьцаатай болгох";

- ТУЗ-д Монголын талаас төлөөлөх хүнийг 6 болгох, гишүүдийг өндөр шалгуураас авах, гишүүд улс төрөөс ангид буюу улс төрч бус хүмүүс байх;

***г/ Монголын талын ажлын байр, олгох цалин***

- С.Төмөр-Очир "Өндөр зэрэглэлийн мэргэжилтэн бэлтгэхийн тулд инженер техникийн мэргэжилтэн бэлтгэдэг сургууль болон бүх шатны сургалтын байгууллагыг дэлхийн өндөр хөгжилтэй орны түвшинд хүргэх";

- МАХН"-ын "Уламжлал шинэчлэл, ардчилал, шударга ёс жигүүр"-ийн ил захидалд "Оюутолгойн ордыг Монгол улс үндэсний боловсон хүчиндээ түшиглэн дангаараа ашиглах бүрэн боломжтой. Ингэж чадвал зэсээс салбарлаад бүх төрлийн кабель утас, радиоэлектроник, машины үйлдвэрлэлийн гэх мэт тодорхой салбар бий болж улмаар Монгол улсын хөгжил, ард түмний амьдралыг огцом дээшлүүлэх бодит боломж байсаар байна";

***д/. Гэрээний нээлттэй, ил тод байдлыг хангах***

- УИХ-ын гишүүн Д.Балдан-Очир "Ард түмэнд гэрээний төслийн зарим зүйл заалтыг мэдээлж, хэлэлцүүлэх";

- Д.Рэнцэнтавхай /Даяар Монгол Хөдөлгөөн/ "Гэрээний төслийн холбогдох зүйл заалтууд дээр иргэний хөдөлгөөнүүд, эрдэмтэн мэргэдийн санаа бодлыг авах нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, гэрээ байгуулах үйл явцын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох";

**Гурав. Шүүмжлэлт асуудлуудыг эх сурвалжаар ангилсан нь**

Дээрх шүүмжлэлт асуудлуудаас төрийн эзэмшлийн хувь, хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хүчингүй болгосон шийдвэр, ус ашиглалтын гэрээ, зэс хайлуулах үйлдвэр байгуулах, техник эдийн засгийн үндэслэлийг тойрсон шүүмжлэл зэргийг онцлон авч тухайн асуудлуудад УИХ-ын гишүүд, ИНБ, эрдэмтэн судлаачид, ХМХ зэргийг гол эх сурвалж болгон судлав. Эх сурвалжын дийлэнх буюу 105 нь ТЭЗҮ-гүйгээр Хөрөнгө оруулалтын гэрээг баталж хууль зөрчсөн, ТЭЗҮ нь ил тод биш гэсэн бол 63 эх сурвалж ашигт малтмалын орд ашиглахад Монголын төрийн эзэмших хувь бага гэж, 61 эх сурвалж Гэнэтийн ашгийн татварыг хүчингүй болгох асуудлаар "зөв", "буруу" гэсэн байр сууринаас ханджээ. Нэгдсэн дүнг Хүснэгт №1-д нэгтгэн үзүүллээ.

UILMN СУДАЛГААНЫ САН

**Шүүмжлэлт асуудлаархи  эх сурвалжуудын байр суурийг хүснэгтээр үзүүлэв. Хүснэгт №1**

| Шүүмжлэгдсэн гол асуудал | Хэвлэлийн нийтлэл, мэдээллийн эх сурвалж- сонин тус бүрээр | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ардын эрх | | | | Зууны мэдээ | | | | Монголын мэдээ | | | | Нийгмийн толь | | | | Өдрийн сонин | | | | Өнөөдөр | | | | Үндэсний шуудан | | | | Үнэн | | | |
| | УИХ | ИНБ | судлаач | ХМХ | УИХ | ИНБ | Судлаач | ХМХ | УИХ | ИНБ | Судлаач | ХМХ | УИХ | ИНБ | Судлаачид | ХМХ | УИХ | ИНБ | Судлаачид | ХМХ | УИХ | ИНБ | Судлаачид | ХМХ | УИХ | ИНБ | Судлаач | ХМХ | УИХ | ИНБ | Судлаач | ХМХ |
| Монголын төрийн эзэмшлийн хувь бага | 2 | 1 | - | 1 | 2 | 1 | - | 1 | 8 | 2 | 2 | 9 | 1 | 3 | - | - | 2 | 2 | 6 | 3 | - | - | - | 4 | 1 | 1 | 3 | - | 4 | 1 | 2 | 1 |
| Хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа урт | | 1 | - | - | - | * | - | - | - | 2 | 2 | 1 | 2 | 1 | 1 | 1 | - | 3 | 1 | 4 | 1 | - | - | 2 | 2 | 1 | - | 3 | - | 2 | - | - |
| Гэнэтийн ашгийн татварыг хүчингүй болгох | 4 | - | - | - | 4 | - | - | - | 7 | 2 | 1 | - | 4 | 1 | 2 | 2 | 5 | 3 | 3 | - | 2 | - | 2 | 1 | 2 | - | 2 | 2 | 8 | - | 2 | 2 |
| Ус ашиглах хугацаа хэтэрхий урт, байгаль орчинд сөргөөр нөлөөлнө | 2 | | 2 | | 2 | 2 | | | 1 | 1 | | 3 | 1 | 3 | - | - | - | - | - | - | 2 | 2 | 3 | - | - | 2 | 2 | 1 | 2 | - | - | 2 |
| Зэс хайлуулах үйлдвэр барих | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | 2 | - | 1 | - | 2 | 2 | 1 | - | 1 | 1 | - | - | 4 | - | 1 | - | - | - | - | - |
| ТЭЗҮ ил тод бус, хууль зөрчсөн | - | 2 | 2 | - | 10 | 11 | 13 | 38 | - | - | - | - | 2 | 1 | 2 | - | 2 | 4 | 4 | - | - | 2 | 1 | - | - | 1 | | 3 | 2 | 1 | 1 | 3 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Дөрөв. Дүгнэлт, санал зөвлөмж**

**3.1.Дүгнэлт**

Сонинуудын нийтлэл, мэдээлэлд контент-анализ хийсний эцэст доорхи дүгнэлтэнд хүрлээ. Дүгнэлтийн ерөнхий агуулга Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээний ил тод байдал, олон нийтийн оролцоо, эрх зүйн орчны зөрчилтэй байдал гэсэн хэдэн хэсэгт чиглэгдлээ.

- "Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль" нь Монгол улсын Үндсэн хуультай зөрчилддөг гэсэн шүүмжлэлийг ИНБ, эрдэмтэн судлаачид хийж, Энэхүү хуулийг Үндсэн хуультай нийцүүлэн өөрчлөхийг УИХ-д санал болгожээ.

- "Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төсөл, түүнийг хэлэлцэх явц нь эхнээсээ олон нийт, эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүд, ИНБ-д хаалттай /Зарим тохиолдолд УИХ, УИХ-ын гишүүдэд ч хаалттай гэж үзсэн эх сурвалж байв/, Засгийн газрын томилсон ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн нь "хуурамч гэрээ", "Монгол улсад хохирол учруулах гэрээ", "Гарын үсэг зурсан гэрээний эх хувь олдохгүй байна", "УИХ-ын гишүүд авилга авсан" гэх зэрэг маш их хардлага сэрдлэгийг нийгэмд төрүүлжээ.

- "Оюу толгой" ордыг ашиглах үйл явц, түүний хөрөнгө оруулалт, ялангуяа хөрөнгө оруулагчийг сонгох үйл явц олон жил /5-6 жил/ үргэлжилж, энэ хооронд Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль"-д хэд хэдэн зарчмын өөрчлөлт /лиценз олгох, эзэмших хувь, эзэмших хугацаа/ хийсэн нь олон нийт, эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүд, ИНБ-д ихээхэн хардлага төрүүлж, Засгийн газар, Хөрөнгө оруулагч хоёр гэрээг гарын үсэг зурж, ёсчилсон ч өнөөг хүртэл "УИХ гэрээг татан авч нийтээр дахин хэлэлцүүлэх, эрх зүйн орчин зөрчилтэй байхад ганц компанийн эрх ашигт нийцүүлэн Монгол улсад хохиролтой гэрээ байгуулж буйг эсэргүүцэж байна", "УИХ гэрээг цуцлах ёстой", "Гэрээний тодорхой асуудлаархи худлаа мэдээлэл, эрх бүхий субьектийн талаархи маргаантай асуудал зэргээс шалтгаалан Монгол улсад хохиролтой хүчин төгөлдөр бус гэрээ байгуулагдсан", "Монгол улсад ашиггүй тул асуудлыг хойшлуулж ашигтай нөхцөл байдал бүрдсэн үед ордыг ашиглах" гэсэн санал шүүмжлэл ИНБ, эрдэмтэн судлаачид, иргэд, зарим тохиолдолд УИХ-ын зарим гишүүдийн зүгээс ч гарсаар байна.

- УИХ "Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ"-г байгуулах эрх, байгуулахдаа юуг анхаарах тухай зарчмын үүргүүдийг тогтоолоор Засгийн газарт өгсөн ч тогтоолын зарим заалт нь өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй зарим хуулийн заалттай зөрчилдөж байсан нь хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагын хооронд маргаан үүсэх нөхцлийг бүрдүүлсэн байна. Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 5.5-д "Улсын төсвийн оролцоогүйгээр эрэл хайгуул хийж нөөцийг нь тогтоосон сртатегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно" хэмээн заажээ. УИХ-ын 2009 оны 07 сарын 16-ны өдрийн 57-р тогтоолд "Оюу толгой ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааны төрийн эзэмшлийн доод хэмжээг 34 хувиар тогтоосугай", УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоолын 2-р хавсралтад "Монголын талын эзэмшлийн 34 хувиас эхэлж, анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа 50 хувь болгох асуудлыг гэрээнд тусгах хувилбар"-ыг үндсэн зарчим, удирдлага болгох тухай ЗГ-т үүрэг өгч, улмаар Засгийн газар "Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ"-ний 1.6, 1.8-д "...Төр нь Хөрөнгө оруулагчийн энгийн хувьцааны 34 /гучин дөрөв/ хувийг өмчлөх" хэмээн заасан нь Гэрээ төрийн өмчлөлийн хувьд Ашигт

UH.MN ЦАХИМ НОМЫН САН

малтмалын хууль болон УИХ-ын тогтоол зөрчөөгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. УИХ-ын 40, 57-р тогтоолын агуулгыг зарим хэвлэл УИХ “34 гэсэн тоог эхлэх цэг болгоод цааш нь 50 хувь болго гэсэн хууль дээгүүр алхсан гэрээ хийх үүргийг УИХ нь ЗГ-таа өглөө”[101] хэмээн мэдээлжээ. Энэ нь УИХ хууль дээгүүр алхсан гэж үзэх үндэслэлгүй бөгөөд ”УИХ-ын тогтоолоор татварын хөнгөлөлт үзүүлэхгүй, нөгөөтэйгүүр 34 хувиа ав гэсэн чиглэл хоёр талд асуудлын хүрээг өргөжүүлж байгаа учраас хэлэлцээр амаргүй байна”[102], “Зохицуулалтын хувьд хүндрэлтэй байна. Учир нь анх гэрээг хууль хэлбэрээр батална гэж байсан. Гэтэл гэрээнд “хуульд зааснаас өөр зохицуулалт хийж болно” гэсэн цөөнгүй зүйл байсан. Одоо бүгдийг нь хуульд нийцүүлэн хийх ёстой учир хэлэлцээрийн явцад нэлээд хүндрэл гарч байна. Уг төслийг бүхэлд нь загвар дээр үндэслэн хийж байгаа. Тиймээс ямар нэгэн татвар нэмэгдэх, хасагдахтай холбогдсон зохицуулалт хийх шаардлагатай болж байна”[103] гэсэн ч ЗГ үүргээ биелүүлжээ.

- Гэрээг байгуулах явцад Засгийн газарт 1-рт, одоо байгаа хуульдаа нийцүүлж бүгдийг нь өөрчлөх, 2-рт, тодорхой хуулиудад нэмэлт оруулах гэсэн асуудал тулгарсан[104] нь ашигт малтмал ашиглах, ялангуяа стратегийн орд ашиглахтай холбогдсон эрх зүйн асуудлыг нэг мөр болгох шаардлагатайг харуулж байна.

- Гэрээнд татварын олон төрлийг тогтворжуулсан болон ашигт малтмалыг боловсруулах үйлдвэр барих эцсийн зорилго бүхий Гэнэтийн ашгийн татварын талаархи хуулийг хэрэгсэхгүй болгосон нь нийгмийн санаа бодлыг хоёр туйлд аваачжээ. Нэг хэсэг нь /энд төлөөлөв/ Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун “Уул уурхайн компаниудын нэг нь ч 68%-ийн татварыг дэмжээгүй. Энэ татвар бий болсноор олон улсын зах зээлд тухайн салбарын нэр хүнд буурсан. Хэдийгээр төсвийн орлогыг нэмэгдүүлсэн ч тухайн салбарыг хөгжихөд саад болсон” гэж байхад нөгөө хэсэг нь УИХ-ын гишүүн С.Бямбацогт “Гэнэтийн ашгийн татвараа авч эх орондоо эцсийн бүтээгдэхүүн боловсруулах ёстой. Гэнэтийн ашгийн татвар нь ашигт малтмалын үнэ өндөр байхад ахиу, унасан үед бага гэх зэргээр уян хатан байх боломжтой” зэргээр үзэж байна. Иймд татварын орчныг сайтар судалж, түүнийг аливаа нэг гэрээг дагаж өөрчлөх бус, гэрээ нь хуулийн дагуу хийгддэг байх эрх зүйн орчинг бүрдүүлэх нь хөрөнгө оруулагч төдийгүй улсын эдийн засагт хэрэгтэй юм.

- Засгийн газар “Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ”-г байгуулж, хөрөнгө оруулагчтай гарын үсэг зурахдаа ТЭЗҮ-ийг урьдчилан хэлэлцэж шийдвэрлээгүй нь “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”-ийн Хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулахдаа хавсаргах баримт бичиг буюу 30.1.1-д заасан “Эхний 5 жилд оруулах хөрөнгийн хэмжээ, хугацаа, үйлдвэрийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрөл, орд ашиглах арга, технологийн талаархи мэдээлэл, техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/” гэсэн заалтыг зөрчсөн үйлдэл болжээ. Өөрөөр хэлбэл, ТЭЗҮ-г хэлэлцэн баталж байж хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах үйл явц зөрчигджээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[101] “Оюутолгойн гэрээний төсөлд баримтлах зарим чиглэл өгчээ”. “Өнөөдөр” сонин. №18. 2009.08.01.
[102] Д.Зоригт “Хэлэлцээр амаргүй байгаа ч үр дүнд хүрэх талаар бүх алхмыг хийнэ”. “Үнэн”. №148. 2009.07.30
[103] “Оюутолгойн гэрээний төсөлд баримтлах зарим чиглэл өгчээ”. “Өнөөдөр” сонин. №18. 2009.08.01.
[104] Мөн тэнд

- Орд ашиглах техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийн талаархи шүүмжлэл их гарч байна. Шалтгаан нь “ТЭЗҮ гишүүдийн гар дээр ирээгүй. Гар дээр ирсэн бол хэлэлцэхэд илүү дөхөм байна”[105], “ТЭЗҮ-ийг хянаж батлаагүй байж гэрээ байгуулсан нь Ашигт малтмалын тухай хууль”-ийн тодорхой зүйл заалтыг зөрчсөн” гэсэн шүүмжлэл их гарч байна. Нэг ёсондоо хууль зөрчиж гэрээ байгуулсан гэх үндэслэлийн нэг нь ТЭЗҮ болж байна.

- Хөрөнгө оруулалтын хэмжээтэй холбоотой мэдээлэл олон янз, түүнийгээ дагаад шүүмжлэл, эсэргүүцэл маш их байна. “Хөрөнгө оруулалтын гэрээ анх орж ирэхдээ Оюу толгойн баялгийн нөөц улсын комисст бүртгэгдээгүй, батлагдаагүй байсан. Оюу толгойд хэдий хэрийн нөөц байна, хэдий хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай, хэр зэрэг ашигтай байх зэрэг нарийн тоо байхгүй. Ийм тоо баримтгүйгээр гэрээ хийсэн”[106] зэрэг шүүмжлэл УИХ-ын гишүүдээс зүгээс их гарчээ.

- Гэрээ батлагдсаны дараа ордын олборлох нийт зэсийн хэмжээний талаархи зөрүүтэй мэдээллүүд олон нийт, ИНБ-ын дунд төдийгүй УИХ-ын гишүүдийн дунд гарч байна. “Зууны мэдээ” зэрэг сонин “Гэрээ хүчин төгөлдөр бус. Ордыг сорчлон ашиглах гэж байна“, “Монгол улс ордын 17 хувийг эзэмшихээр болсон” хэмээсэн бол “Оюутолгойн ордын 45 сая тн зэсийн хэмжээ 19 сая тн болтлоо буурсан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлээд 45 сая тн зэсийн 25.3 саяыг нь үр ашигтай гэж үзсэн. Гэрээг батлах үед 42 сая тн олборлоно гэж ярьж байсан яав”[107] гэсэн эргэлзээ УИХ дотор гарсан байна. Энэ нь УИХ мэдээллээр дутуу хангагдсаны баримт гэж үзэж болно.

**Дээрх дүгнэлтүүдийг нэгтгэхэд,** Монгол улсын төр стратегийн ач холбогдолтой ордуудаа ашиглах бодлогод нухацтай хандаж, эрх зүйн орчноо улам боловсронгуй болгох шаардлагатай байна. “Ер нь стратегийн ордуудад ямар зарчмаар хандахыг томьёолж өгөх ёстой. Төрийн оролцоо ахиу байх, татварын болон бусад хөнгөлөлт үзүүлээд байх эсэхийг шийдэж өгөх нь зүйтэй. Энэ бүхнийг Ашигт малтмалын хуулиар баталгаажуулахыг ч үгүйсгэхгүй. Стратегийн ордуудаа ашиглах дараалал тогтоох ёстой”[108] юм байна.

**3.1. Санал, зөвлөмж:**

Энд хэвлэлийн нийтлэл мэдээлэлд олон давтагдсан, ИНБ, эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, УИХ-ын гишүүдийн дунд маргаан дэгдээж, тэр чинээгээрээ нийгмийн анхааралд өртсөн хэд хэдэн асуудлаархи зөрүүтэй санал, зөвлөмжийг багцлан оруулав.

**а/ Ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь**

- Монголын төр Ашигт малтмалын ордоос төрийн эзэмших хувийг 50 ба түүнээс дээш болгох, эрх зүйн орчныг өөрчлөх;

- Уул уурхайн оронд тухайн улс өндөр хувь эзэмшээд байх нь оновчтой бодлого бус. Тэр хэмжээгээр хөрөнгө оруулалтын эрсдэл, зардлыг даана. Эрсдлийг аль болох хөрөнгө оруулагчдад ногдуулаад улс өөрөө баталгаатай хэсгээ авах;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[105] УИХ-ын гишүүн Р.Раш. “Үнэн” сонин.
[106] УИХ-ын гишүүн Д.Балдан-Очир. “Үнэн” сонин
[107] УИХ-ын гишүүн Ж.Ганбямба. “Үндэсний шуудан” сонин
[108] УИХ-ын дарга Д.Дэмбэрэл. “Өнөөдөр” сонин. №199. 2009.08.31

- Үндэсний компаниуд корпораци байгуулж, өөрсдөө давуу эрхтэй хувьцаа эзэмших эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Уул уурхайн баялгийг үнэлдэг олон улсын туршлагыг судалсны үндсэн дээр ашигт малтмалын ордоо үнэлүүлж, Монгол улс хувь эзэмших боломжийг бүрдүүлэх эрх зүйн орчинг бий болгох

**б/ Гэрээний хэлбэр**

- Хөрөнгө оруулагч тал хөрөнгөө оруулаад, эрсдлээ өөрсдөө хүлээх, орлогынхоо дийлэнх хэсгийг Монгол улсад өгөх зарчмаар ажиллахын тулд гэрээг Бүтээгдэхүүн хуваах зарчмаар хийж, олборлох бүтээгдхүүний 70 хувийг Монгол улс авах;

- Олон улсын практикт төрийн өмч болох ашигт малтмалыг эзэмших ашиглах, захиран зарцуулах гэрээний эрх зүйн хэлбэр болох Концессын гэрээ хийх;

**в/ Хувьцааг арилжаалах**

- "Ашигт малтмалын ордыг ашиглаж байгаа компани нийт хувьцааныхаа 10 хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах" гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх;

- Монголчууд Канадад бүртгэлтэй Айвенхоу Майнз Инк компанийн хувьцаанаас бусад хөрөнгийн биржээр дамжуулан худалдан авах, эсвэл цаашдаа МХБ-д давхар листингээр бүртгүүлэх ажлыг зохион байгуулан ард олон нийтээрээ хувьцааг нь худалдан авах;

- Айвенхоу Майнз Инк компанийг Монголын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй болгох;

**г/. Орд ашиглах гэрээний хугацаа**

- Гэрээ байгуулах хугацааг 15 жил болгож, тав таван жилээр үр дүнг нь тооцох;

- 30 жилийн хугацаатай байгуулахын оронд нөөцийн тодорхой хувийг ашигласны дараа гэрээг шинэчлэх;

- Монгол улс хугацаанаас хамаарахгүйгээр 15-20 жилийн дараа эзэмших хувиа өсгөх боломжтой байх орчинг бүрдүүлэх;

**д/ Татварын орчин**

1. *Зарим барааны үнийн өсөлтийн татвар*

   - Хүчингүй болгохгүйгээр хувь хэмжээг бууруулах;
   - Гэнэтийн ашгийн татвар төлөх боломжгүй гэдгийг эдийн засгийн тооцоогоор харуулах;
   - Татварыг авч эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлвэр байгуулах;
   - Хүчингүй болгох;
   - Гэнэтийн ашгийн татвар нь гадаадын хөрөнгө оруулалтыг үргээж, МУ-ын эдийн засгийн шинэчлэл хөгжлийг хойш татаж болзошгүйг анхаарах;

2. *Бусад татвар*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэхгүйгээр татварын орчинг тогтвортой байлгах зарчим баримтлах;
- Татвараа шударгаар төл, байгаль орчноо нөхөн сэргээх гэсэн уул уурхайн бизнесийн сонгодог зарчмыг баримтлах;
- Шаталсан татвараа төл, олборлоод баяжмал болгон, түүнийгээ Монгол улсад өгөх ёстой гэсэн заалттай гэрээ байгуулах;
- ХОТ-ын хөнгөлөлтийг төслийн эхний үе шатанд, харин НӨАТ-ын буцаан авалтыг төслийн үргэлжлэх хугацааны турш эдлэх боломжтойг анхаарах;
- Гэрээ байгуулсны дараа татварын хуулиараа дамжуулан хяналт тавих тул татварын системээ шинэчлэх, татвараа зөв авах;
- Эрх зүйн орчны зөрчилтэй байдал нь Монгол улсад хохиролтой гэрээг байгуулах суурь болж байгаа тул Ашигт малтмалын тухай хуулийн 61-р зүйлд хөрөнгө оруулагч татварын таатай орчин эдлэх тухай Татварын хуульд байх заалтыг зургаан зүйлээр оруулсныг эргэн үзэж, хүчингүй болгох

**е/. Ус ашиглалт**

- Оюутолгойг онцлохгүйгээр өнөө мөрдөж буй Усны хуулийн дагуу 20 жилээр гэрээ хийх;
- Усны тухай хуулийн өөрчлөлтийг хүчингүй болгож шинэчлэх;
- Ордыг ашиглахад усны нөөц хүрэлцээтэй эсэх талаархи үнэлгээнд олон улсын шинжээчдийг оролцуулах;
- Гүний устай холбоотой байгаль орчны нөлөөллийг судлах;
- Үйлдвэрийнхээ ашигласан усыг цэвэршүүлээд хэрэглэх;
- Монгол улсын усны байгууллагууд дүгнэлт гаргуулж байх;

**ё/ Зэс хайлуулах үйлдвэр**

- Зэс хайлуулах үйлдвэрийг Монгол улс дангаараа эсвэл өндөр технологи бүхий гадныхантай хамтран байгуулах;
- Оюутолгойн зэсийн баяжмал доторх алт, мөнгийг олон улсын практикт байдаг нэвтэрсэн Толлингийн хэлэлцээрээр хайлуулах үйлдвэрээс алт зэсээ хайлшаар нь эргүүлэн авч Монгол банкинд тушаах ашигтай хувилбарыг гэрээний төсөлд тусгах;

**ж/ Техник эдийн засгийн үндэслэл**

- ТЭЗҮ-д нарийвчилсэн шинжилгээг хийх шинжээчдийн багт үндэсний шинжээчдийг оруулах;
- Уул уурхайн чиглэлээр олон жил ажилласан чадварлаг мэргэжилтнүүдээр баг бүрдүүлэн яаманд судалгааны институт бий болгох;
- Үйлдвэрийн оновчтой бүтэц, байгуулах хэлбэр, хүчин чадлыг зөв тодорхойлсны дараа орд ашиглах гэрээг байгуулах /зөвхөн үйлдвэрийн хөрөнгө оруулалт нь 2.5-2.7 тэрбум ам.доллароос хэтрэхгүй байх, гадаад дэд бүтцийг оруулбал 5 тэрбумаас хэтрэхгүй байх. Үйлдвэрийн үйл

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ажиллагаа жигдэрсэн үед төсөвт орох ашиг жилд доод тал нь 400-500 сая доллароос дээш байх нөхцлүүдэд л ордыг ашиглах/;

**з/ Аудит, хяналт**

- Хөрөнгө оруулалтын болон хайгуулын зардалд төрийн аудит хийлгэж, бодит зардлыг тогтоох;
- Хөрөнгө оруулалтын хэмжээнд олон улсын аудит хийлгэх;
- Шинжээчдийн баг хянах;
- Гадаадын хуулийн компани хөлсөлж, гэрээний Англи хувилбарыг хянуулах;
- Гэрээнд маргаан гарвал Монгол улсын шүүх асуудлыг шийддэг байх ёстой;
- Төсөл хэрэгжиж эхэлмэгц хяналтыг зэрэгцүүлж тавих;

**и/. Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/**

- Хувь нийлүүлэгчдийн гэрээнд ТУЗ-ийн 3/2 нь шийдвэр гаргах эрхтэй гэснийг хасах. Энэ нь төрөөс давсан эрхтэй заалт бөгөөд, түүнийг төрийн бодлогын хэмжээнд зөвшилцөх тухай өөрчилж төрийн бодлогын хэмжээнд зөвшилцөх тухай заалт оруулах;
- Монголын талаас 3, хөрөнгө оруулагч талаас 6 хүн байхаар заасныг өөрчилж 4:5 харьцаатай болгох;
- ТУЗ-д Монголын талаас төлөөлөх хүнийг 6 болгох, гишүүдийг өндөр шалгуураар авах, гишүүд улс төрөөс ангид буюу улс төрч бус хүмүүс байх;

**к/ Олон нийтийн оролцоо, ил тод, нээлттэй байдал**

- Гэрээний төслийн холбогдох зүйл заалтууд дээр иргэний хөдөлгөөнүүд, эрдэмтэн мэргэдийн санал, зөвлөмжийг авах, тусгах;
- Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Гэрээ байгуулах үйл явцын мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах;
- Олон нийтийг байнга мэдээллээр хангах зэрэг болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ДЭЛХИЙН БОЛОН БҮС НУТАГТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД БОЛОН УУЛ УУРХАЙ, АШИГТ МАЛТМАЛЫГ САЛБАРТ МОНГОЛ УЛСЫН БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО

*(Мэдээлэл-лавлагаа)*

*Д.Мягмарцэрэн*

Өнөөдөр дэлхийн аж үйлдвэрлэл, техник технологийн дэвшлийн эх сурвалж, түүхий эд болох ашигт малтмал үйлдвэрлэлийн салбарт тодорхой тулгамдсан асуудлууд үүсч эхэлсэн байна.

Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн зорилгоор ашиглаж эхэлсэн цаг хугацааны туршид хэд хэдэн удаа нийтлэг тулгамдсан асуудлууд үүсч байсан. Тухайлбал, нөөцийн хомсдол, болон түүхий эдийн үнийн өөрчлөлтийг дурдаж болно. Эдгээр бэрхшээлүүд нь тухайн цаг үедээ хүнд хэцүү асуудал тулгарсан мэт санагддаг байсан нь мэдээж хэрэг юм. Гэхдээ эдгээрийг өнөөдөр тулгараад байгаа бэрхшээлүүдтэй харьцуулан харахад хамаагүй хөнгөн гэж үзэж болох юм. Учир нь, дэлхий ертөнц бүхэлдээ судлагдаагүй байх үеийн нөөцийн хомсдол бол зөвхөн бүс нутгийн шинж чанартай байсан. Үүнтэй адил технологийн хязгаарлагдмал боломжтой үед алив нэг ашигт малтмалын үнэ ихээр өөрчлөгдөх үед нь түүнийг орлож чадах бүтээгдэхүүнийг шууд бий болгон ашиглах боломж хомс байсан.

## Нөөцийн хомсдол

Өнөөгийн нөхцөлд шинээр ашигт малтмалын нөөц илрүүлэн олох магадлал харьцангуй багассан ба улс төрийн болон бусад нийгмийн шалтгааны улмаас хаагдмал байсан улс орнуудад ховор тохиолдлоор шинээр ашигт малтмалын нөөц илэрч байна. Гэвч үүнийг шууд ашиглах боломж бас хязгаарлагдмал байгаа юм. Үүнд жишээ болгоход, саяхан Афганистанд АНУ-ын цэргийн албаныхан болон геологичид бараг нэг триллион ам.долларын баялаг бүхий орд байгааг илрүүлсэн байна. Тус улсын өнцөг булан бүрд төмөр, зэс, алтны маш их баялагтай ордууд байна гэж АНУ-ын Батлан хамгаалах департамент үзэж байна. Гэхдээ шинээр нээгдсэн энэ байгалийн баялгуудыг олборлож ашиглах нь амаргүй бөгөөд “Үүнийг тэр дор нь ашиглах боломжгүй” гэж АНУ-ын геологич Жак Медлин сануулж байна. Учир нь, Ордуудын байрлал алс бөглүү хязгаарт байгаа, тээвэр, дэд бүтцийн асуудал сул байгаа болон босогчид байсаар байгаа нь энэ ордуудыг ашиглах явдлыг хүндрүүлэх болно гэж Пентагон, Төрийн департаментын ажилтнууд үзэж байна.

Дэлхийн хэмжээнд тулгамдсан асуудал болж буй нөөцийн хомсдлын хамгийн хурц асуудал нь эрчим хүчний эх үүсвэрийн хомсдол юм. Төрөл бүрийн судалгаануудаас харахад дунджаар, газрын тосны нөөц 40 орчим жилийн дараа, байгалийн хий 70 орчим жилийн дараа хомсдож дуусна гэж эрдэмтэд тооцоолсон байдаг. Харин нүүрсний нөөц 170 орчим жилийн настай гэж үзсэн байна. Иймээс одоохондоо дэлхийн хамгийн урт хугацаанд ашиглах эрчим хүчний нөөц нь нүүрс. Үүнийг эдийн засгийн үр ашигтай аргаар хэрэглэж чадвал эрчим хvчний удаан эдэлгээтэй эх үүсвэр болж чадна. Дэлхий даяараа 5-6 тэрбум тонн нүүрс үйлдвэрлэж ашигладаг бололтой. Хэдийгээр цөмийн, дотоод шаталтын, сэргээгдэх зэрэг эрчим хүчний шинэ шинэ эх үүсвэр нээгдсээр буй боловч өнөөдөртөө нүүрс нь голлох үүрэг гүйцэтгэсээр байна.

Ази тивийн орнуудын хувьд нүүрсний нөөц, олборлолт, үүнийг дагасан үйлдвэрлэл харьцангуй их тул тэр хэрээр хэрэглээ өндөр байдаг. Харин нүүрсний хэрэглээ өндөр байх нь хүлэмжийн хий, дэлхийн дулааралд сөргөөр нөлөөлдөг байна. Иймээс Киотогийн протоколоор хөгжингүй улс орнуудын нүүрсний хэрэглээнд хязгаарлалт тавьдаг ба одоогоор буурай орнуудын хувьд энэ тал дээр шахалт үзүүлдэггүй. Гэвч нэгэнт байгаль

UIH.MN СУДАЛГААНЫ ТАН

орчинд сөргөөр нөлөөлж буй нь тодорхой учир цаашид энэ байдал өөрчлөгдөх нь мэдээж юм.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд ашигт малтмал олборлох үйл явц нь байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд үүнийг ор тас арилгах зогсоох боломжгүй учир аль ч улсын Засгийн газар нь сөрөг нөлөөг бууруулахын тулд дэвшилтэт технологи ашиглах, нөхөн сэргээлтийг чанарын өндөр түвшинд хийхийг шаардах замаар ашигт малтмал олборлогчдод шахалт үзүүлж хяналт тавьдаг.

Манай улс өнөөдөртөө ашигт малтмалын бүтээгдэхүүнээ зөвхөн Хятад улсад нийлүүлэх боломжтой байна. Цаашид зах зээлээ тэлэх бололцоог хичнээн нэмэгдүүллээ ч Ази тивийн орнууддаа, үүнээс Япон, Солонгос гэх мэт улсуудад л хүргэх боломжтой. Энэ бүс нутгийн зах зээлийн голлох нийлүүлэгчид нь Хятад, Австрали, Индонези, Энэтхэг зэрэг улсууд байна. Эдгээр улсууд хэдийгээр өөрийн дотоодын зах зээл дээр түүхий эдийн хангалттай хэмжээний эрэлттэй ч ашигт малтмалын нөөцийн хэмжээндээ түшиглэн гадаад зах зээлд бүтээгдэхүүн гаргадаг.

Гэвч ашигт малтмал нь нөхөн сэргээгддэггүй баялаг учраас цаашид гадаад зах зээл рүү гаргах бүтээгдэхүүнийхээ хэмжээг бууруулах хандлагатай байна.

Хятад улс уул уурхайн аюулгүй байдлыг хангах гэдэг шалтгаанаар ойрын 5 жилийн дотор 7000 орчим жижиг уурхайг хаах зорилт тавьсан. Үүний цаадах жинхэнэ шалтгаан нь стратегийн нөөц бүрдүүлэх гэсэн гол зорилго байж болох юм. Учир нь, 2008 онд коксжсон нүүрсний импортод 40 хувийн татвар ногдуулах шийдвэр гаргаж байсан. Тухайн үед Хятад дэлхийн коксжсон нүүрсний нийлүүлэлтийн тал хувийг гаргадаг байсан бол энэ хэмжээ эрс буурсан байна.

Энэ бүс нутгийн зах зээлийн гол нийлүүлэгчдийн нэг Австрали улс уул уурхайн компаниудад 40%-ийн татвар ноогдуулсан ба тодорхой эсэргүүцэлтэй тулгарсан учир шинээр томилогдсон Австралийн Ерөнхий сайд Жулиа Гиллард 40%-ийн татвар авах төлөвлөгөөг өөрчилж нүүрс болон төмрийн хүдрийн компаниудаас 30%-ийн татвар авах шийд гаргасан юм. Мөн үүний адил, бас нэг гол нийлүүлэгч болох Энэтхэг улс гангийн экспортын татвараа 20%-иар нэмэгдүүлээд байгаа юм. Энэ бүгдээс үзэхэд цаашид энэ зах зээл дээрх эрэлт ихээхэн өсч үүнийг дагасан түүхий эдийн үнийн өсөлт бий болох магадгүй юм.

**<u>Түүхий эдийн үнийн өөрчлөлт</u>**

Түүхий эдийн үнийн өсөлт нь ашигт малтмалын бүтээгдэхүүн олборлогч, экспортлогч орнууд, тухайлбал, манай улсын хувьд хэсэг хугацаанд ашигтай байж болох юм. Гэвч энэ нь өндөр үнэтэй түүхий эдийг орлох хямд үнэтэй бүтээгдэхүүн бий болгох нөхцлийг бүрдүүлдэг учир урт хугацааны туршид эсрэгээр эргэн өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг харин ч үнэгүйдүүлэх аюултай. Үүнд жишээ болгон, CTL-ийн түүхийг дурьдаж болох юм.

Олон улсын нэр томъёогоор нүүрсийг шингэрүүлэх Coal to liquid технологийг CTL гэж нэрлэдэг. Хатуу нүүрснээс петрохимийн шингэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг арга. Энэ дотроо нүүрсийг шууд буюу шууд бусаар шингэрүүлэх хоёр төрлийн технологитой.

1913 онд Германы эрдэмтэн Фредерих Бергиус нүүрснээс шингэн түлш гаргах технологийг анх нээж, үүнийхээ дагуу 1931 онд Нобелийн шагнал хүртэж байжээ. Харин 1925 онд мөн улсын Франц Фишер, Ханс Тропш нар хоёр дахь технологи буюу шууд бус аргаар нүүрсийг шингэрүүлж болохыг олж тогтоосон байна.

1930-аад онд Герман улсад дээрх хоёр технологийг өргөнөөр ашиглаж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд найман том үйлдвэр ашиглалтад оруулсан. Эдгээр үйлдвэр жилдээ дөрвөн сая тонн нүүрс устөрөгч үйлдвэрлэж байжээ. Харин дэлхийн II дайны дараа түүхий нефтийн үнэ асар хямд болсноос дээрх үйлдвэрүүдийг зогсоосон байна. Учир нь, энэ технологиор үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өртөг нь харьцангуй өндөр байдаг тул зах зээлд түүхий нефть хямд байх үед CTL технологи ашиггүй байдаг аж. Европ тив болон

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хойд Америкт нэг баррель нефтийн үнэ 60 доллараас давсан тохиолдолд нүүрс шингэрүүлэх үйлдвэрлэл эдийн засгийн хувьд ашигтай гэсэн тооцоотой байдаг гэнэ.

1973-1974 оны нефтийн хямралын үеэр ХБНГУ-ын Засгийн газар эрчим хүчний судалгааны чиглэлээр нүүрсийг хийжүүлэх, шингэрүүлэх нийт долоон загвар үйлдвэр барих шийдвэр гаргаж, 1977-1980 онд ашиглалтад оруулсан байна. Харин 1980 оноос жилдээ 22 сая тонн чулуун болон хүрэн нүүрс ашиглах 14 том үйлдвэр барихаар төлөвлөж байсан ч удалгүй нефтийн үнэ дахин буурснаас болж дээрх төлөвлөгөө хэрэгжээгүй гэнэ. Ингээд загвар болгож барьсан үйлдвэрүүд ч ээлж дараалан хаагдсаар, хамгийн сүүлд буюу 2004 онд Эссен хотод байсан өдөрт 200 кг тос гаргадаг үйлдвэрийг Хятадын Шинхуа группт өгчээ.

Тэгвэл сүүлийн жилүүдэд нефтийн нөөцийн хомсдолоос шалтгаалан үнэ нь өдөр бүр шахуу нэмэгдэж байгаа энэ цаг үед томоохон орнууд CTL технологийг нэвтрүүлэх гараагаа аль хэдийнэ эхэлжээ. АНУ өдөрт 18.000 баррель түлш гаргах үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийг ХБНГУ-ын "Uhde" компаниар хийлгэж байна.

**МОНГОЛ УЛСЫН ХУВЬД**

Манай улсын хувьд ашигт малтмалын нөөцөөр баялаг боловч түүнийгээ дотооддоо боловсруулах, ашиглах боломж хомс учир одоогоор гадаад зах зээл дээр гаргаж борлуулах тухай асуудал яригддаг.

Харин одоогоор энэ асуудал ажил хэрэг болох болоогүй байгаа ба цаашид үүнд тулгарч болох асуудлуудаас хамгийн анхаарал татаж буй зүйлс нь бүтээгдэхүүнээ гаргах боломж болох тээвэрлэлт юм. Үүнд тээвэрлэх маршрут, тээвэрлэлтийн үнэ, гарц зэрэг техник технологийн гэхээсээ илүү геополитикийн асуудлууд орно. Үүний дараа хэрхэн борлуулах тухай асуудал гарч ирнэ.

Манай улсын хувьд энэ зах зээлийн гол нийлүүлэгчдийн нэг байх боломжтой гэж зарим хүмүүс үздэг ч, өнөөдрийн бодит байдлаар энэ нь тийм ч үнэмшилтэй байх боломжгүй.

Учир нь олон улсын зах зээл дээр гаргах манай улсын ашигт малтмалын бүтээгдэхүүн гэдэг нь үндсэндээ Таван толгойн ордоос олборлох нүүрс юм. Бусад ашигт малтмалын нөөцүүд, түүнээс олох орлого нь улсын эдийн засагт шууд нөлөөлөхүйц хэмжээний их биш бөгөөд нүүрсээ борлуулах үндсэн зах зээл нь Хятад улс тул эдгээрийг тооцон энэхүү дүгнэлтийг хийсэн.

**<u>Тээвэрлэлт</u>**

Нүүрсний аж үйлдвэрлэлд олзворлолтоосоо илүү тээвэрлэлт нь чухал байдгаараа бусад ашигт малтмалаас ялгаатай. Энэ нь бүтээгдэхүүний овор хэмжээнээс болж буй хэрэг, зэс шиг баяжуулах, цэвэрлэх гэх мэтээр хэмжээг нь багасгах аргагүй, олзворлосон болгоноо тэр чигээр нь зөөнө. Иймээс тээвэрлэлтэнд хяналтаа тогтоох нь үндсэндээ тухайн ордод хяналтаа тогтоосноос ялгаагүй болдог.

Нөгөөтэйгүүр энэ ордын бүтээгдэхүүн зөвхөн Номхон далайн эрэг хүрч л байж үнэ цэнэтэй болно. Учир нь гол хэрэглэгч нь тэнд бий. Иймээс Тавантолгойн нүүрсийг тээвэрлэх нь олзворлохоосоо хавьгүй илүү ач холбогдолтой, илүү өртөгтэй, илүү хүнд юм.

ОХУ, Монголын хооронд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт хийхэд “Восточный”, “Ванино” боомтуудыг ашиглана хэмээн тохиролцсон. Энэ хоёр боомтын тухайд тээвэрлэлтийн өртөг нь харьцангуй ялгаа багатай юм. “Восточный” боомтын төмөр зам өвөлдөө хөлддөг сул талтай. Гэтэл “Ванино”-г ашиглавал тарифийн хөнгөлөлт эдлэх боломжтой. Эцсийн дүндээ өртгийн зөрүү бага гэж судлаачид тайлбарлаж байна. Нөгөө талаас Орос бол экспортлогч орон. Тиймээс тэнд ямар ч зах зээл байхгүй гэсэн үг. Тус улс жилд ойролцоогоор 300 сая тонн нүүрс олборлож, түүнийгээ Алс Дорнодын дээрх боомтуудаар Хятад, Япон, Өмнөд Солонгос руу нийлүүлдэг. Үүнээс өөрсдөө дангаараа зах

зээлээ ээгнэх боломжтой байтал яагаад заавал манай нүүрсийг нутаг дээгүүрээ тээвэрлэх сонирхолтой байгаа юм бэ гэсэн асуулт ургаж ирнэ. Энэ нь Хятадын өсөн нэмэгдэж буй эрэлт, тээвэрлэлтээс олж болох ихээхэн орлогын хэмжээтэй холбоотой байж болох юм. Нөгөө талаас Тавантолгойн орд газраас зөөвөрлөх нүүрсийг Хятад руу гаргах урсгалыг өөрийн хяналтад байлгах, Монголын эдийн засагт, тэр дундаа төмөр замын тээвэрлэлтийн салбарт Хятадын нөлөөллийг хязгаарлах стратегийн ашиг сонирхол бас байж болох юм. Ойролцоогоор 1.5 тэрбум ам.доллараар төмөр зам барьж, Монголын нүүрсийг өөрийн нутгаар тээвэрлэх нь төмөр замын ачааллаа бууруулахгүй, идэвхтэй үйл ажиллагаатай байлгахаас гадна магадгүй Хятадын эдийн засгийг түүхий эд, эрчим хүчний нөөцийн хувьд Оросоос хараат байлгах гэсэн цаад сонирхол байж болох талтайг зарим хүн онцолдог. Манай улсын хувьд нүүрсээ урагшаа, хойшоо хаашаа ч тээвэрлэсэн эцсийн эцэст Хятадын зах зээл рүү л ордог байна. Монгол, Хятад хоёр орны тухайд дамжин өнгөрөх тээвэрлэлтийн асуудлыг зохицуулах тухай тодотгосон 1991 оны хэлэлцээрээс өөр зүйл байхгүй. Тус хэлэлцээрт ч нарийн зүйлсийг тусгаагүй. Саяхан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Хятадад төрийн айлчлалаар очихдоо транзит тээврийн асуудлыг хөндсөн ч бас л тодорхойгүй шийдэлд хүрээгүй байна. Гэтэл Тавантолгойн нүүрсийг хилийн чанадад гаргахын тулд эн тэргүүнд транзит тээврийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

Хятад ба ОХУ-аас транзит тээврийн хөнгөлөлттэй үнэ авч тохиролцохгүйгээр Тавантолгойн бүтээгдэхүүн баялаг болохгүй. Хоёр хөршийн төмөр замын тээврийн сүлжээний графикт албан ёсоор ороогүй цагт нүүрс үнэ цэнтэй эд биш. Яг энэ гол асуудал дээр Засгийн газрын түвшинд яриа хэлэлцээр ямар нэг ахиц олоогүй байна. Шалтгаан нь, ОХУ ба БНХАУ Тавантолгойн сонгон шалгаруулалтаас операторын эрх авах үндсэн болзлоо өнөөх манай талын санал болгосон угтуулан тавих нөхцөлүүдээр эргүүлээд илэрхийлж байгаа юм. Хэрвээ Оросын компанийг сонгохгүй бол Алс Дорнодын уудам замаар Тавантолгойн нүүрсийг дотоодын тээврийнхээ тарифыг гурав дахин нугалсан өндөр үнээр зөөнө. Хятадын компани оператор болоогүй нөхцөлд тус улсын төмөр замын тээврийн маш их ачаалалтай графикт Тавантолгойн нүүрстэй вагон хэзээ ч нэвтэрч чадахгүй. Далайн боомт ашиглах боломжийг ч Монголын нүүрсэнд тийм амархан олгохгүй.

Иймээс тээвэрлэлтийн хувьд шийдэх хамгийн гол асуудлууд нь Тавантолгойн нүүрсний транзит тээврийн үнийг бууруулах буюу тогтвортой хямд байх эсэх, Тавантолгойн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд нэвтрүүлэх боомтуудын зөвшөөрөл авах тухай явдал юм. Үүнийг ойрын хугацаанд яаралтай шийдэхгүй орд ашиглалтын асуудал тодорхойгүй болох ч аюултай байна.

**Борлуулалт**

Өнөөдрийн байдлаар манайх Хятадын зах зээлд нүүрсээ гаргаж байна. Тэгвэл энэ зах зээл дээр манай улс нүүрсээ борлуулахад эрсдэл бий болох нөхцөлүүд бүрдээд байна.

2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэглээ 47%-иар өснө. Жил бүр 1.89%-иар их эрчим хүч зарцуулна гэсэн үг. Хятад, Энэтхэг зэрэг OECD-ийн гишүүн биш орнуудын хувьд жилийн өсөлт 3%-иас илүү байх аж. Хятад улс эрчим хүчний хэрэгцээгээрээ 2030 он гэхэд АНУ, ОХУ, Энэтхэг, Япон улсын дараа орох төлөвтэй байна. Тиймээс хятадууд ойрын ирээдүйд атомын цахилгаан станцынхаа тоог 12-оор нэмэгдүүлэхээр зорьж байна.

Хятадын Цөмийн эрчим хүчний корпораци Хятадын цөмийн хүчин чадлыг ашиглан эрчим хүчээ 2020 он гэхэд 5 дахин, 2030 он гэхэд дахин 3-4 дахин нэмэгдүүлнэ хэмээн зарлаж байна. Уг байгууллагын Дэд Ерөнхийлөгч Lui Xuehong 2007 онд явагдсан "Алтернатив эрчим хүчний Лондонгийн уулзалт" дээр ураны нийлүүлэлтийн асуудлаар Монгол түүнчлэн Намиби, Өмнөд Африк, Мозамбик, Ботсван, Чад болон Төв Африкийн БНУ-уудтай идэвхтэй хамтран ажиллахаа мэдэгджээ.

Цөмийн реакторууд барьж, ажиллагаанд оруулахад Хятад улс 52 тэрбум ам доллар зарцуулах төлөвтэй байна. Ингэснээр эрчим хүчний нүүрсийн хэрэглээ нь эрс

UILMN СУДАЛГААНЫ САН

багасах нь тодорхой юм.

Нүүрсний үйлдвэрлэл нь зах зээлийн үнэ ханшаас их хамааралтай, асар их хөрөнгө оруулалт, дэд бүтэц шаардсан эмзэг төсөл. Хятадын аварга зах зээл хажууд байнаа гэж ярьдаг. Гэтэл хятадууд өөрсдөө жилд ойролцоогоор 400 сая тонн коксжих нүүрс олборлож байгаа. Жилд мөн л 400 орчим сая тонн коксжих нүүрс хэрэглэдэг. Тэгэхээр манай нүүрсгүйгээр тэд амьдрахгүй, эдийн засаг нь уначихгүй гэдэг нь тодорхой. Хятадад дотоодын нөөцөөс гадна олон тооны боомттой учир гаднаас бас нүүрс экспортлох бололцоо тэдэнд бий. Ганцхан манайхаас хамаарахгүй гэдгийг маш сайн ойлгох ёстой. Хэрэгцээ өндөр байгаа цагт Австрали болоод бусад улсын үйлдвэрлэгчээс нийлүүлэлт хангалттай ирж л таарна.

Тиймээс үнэ ханш нь гайгүй байгаа дээр бид бүтээгдэхүүнээ борлуулж эхлэхгүй бол эргээд зардлаа нөхнө гэдэг тун ч амаргүй байх болно. Хамгийн болгоомжлох зүйл бол дэд бүтцэд их хөрөнгө хаячихаад хэдэн жил баталгаатай нүүрсээ авах вэ, үнэ нь ямар байх вэ гэдэг чинь уялдаатай, нарийн тооцож хөдлөхөөс аргагүй асуудал. Өнөөдөртөө сүүлийн 2-3 жилд коксжих нүүрсний ханш сайн байсан болохоор BHP, Мицуи гээд дэлхийн томчууд сонирхоод байна. Үргэлж ийм байхгүй гэдгийг бодож үзэх хэрэгтэй.

Хэрэв үнэ ханшийн таатай мөчлөгтэй уралдан бизнес хийж чадвал монголчууд мөнгө босгоно. Эрэлт хэрэгцээ нь хумигдсан үед яаж ч зүтгээд нэмэргүй. Нөгөө талаас, 20-30 жилийн дараа байдал ямар болохыг өнөөдөр хэлэхэд хэцүү юм. Өнөөдрийн хувьд бий болсон энэ тааламжтай нөхцөл байдлыг маш ухаалаг ашиглаж хөрш орнууд болон гуравдагч түнш нартайгаа хамтран эдийн засгаа эрчимтэй хөгжүүлж үндэсний аюулгүй байдлын баталгаагаа материаллаг гэж хэлж болох үндэс суурьтай болгож амжих хэрэгтэй байна. Эдийн засгаа хөгжүүлж, олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны интеграцид бүрэн эрхэт гишүүнээр орж байж манай орны эдийн засгийн аюулгүй байдлын олон улсын баталгаа бий болно. Эдийн засгийн аюулгүй байдал хангагдсанаар улс орны үндэсний аюулгүй байдал баталгаажна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# УИХ-Д ӨРГӨН БАРЬСАН “УТААГҮЙ УЛААНБААТАР” ХӨТӨЛБӨРИЙН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

*/Дүн шинжилгээ/*

*Ц.Норовдондог, Ч.Ононочимэг, Ц.Элбэгзаяа*

**Гарчиг**


**I. Оршил**

**II. Судалгаа, дүн шинжилгээ**

1/ “Хүний хөгжил сангийн тухай” хуульд нэмэлт оруулах, уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гаргах болон Улаанбаатар хотын өмчид бүртгэлтэй үндсэн хөрөнгийг барьцаалах замаар санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх хувилбарын талаар:

2/ Монгол Улсын төвлөрсөн төсвөөс хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжийн талаархи тооцоолол:

III. “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийн санхүүжилтийн таамаглал, тооцоонд үндэслэн гаргасан **дүгнэлт, зөвлөмж**


## УИХ-д өргөн барьсан “УТААГҮЙ УЛААНБААТАР” хөтөлбөрийн төсөлд тусгасан санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломж, хэрэгжүүлэх магадлалын талаархи судалгаа, дүн шинжилгээ

Нэг. Оршил

“Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийг **2010-2012** он, **2013-2016** онуудын хугацаанд **2** үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд **2010-2012** онд **8.8 триллион** төгрөг, **2013-2016** онд 9.3 триллион төгрөг, нийт **18.2 триллион** төгрөг шаардагдах тооцоог төсөлд тусгасан байна.

Тогтоолын төсөлд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт хөрөнгийн

- **92.7%** буюу **16.8 триллион** төгрөгийг “Хүний хөгжил сангийн тухай” хуульд нэмэлт оруулж, уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гаргах болон Улаанбаатар хотын өмчид бүртгэлтэй үндсэн хөрөнгийг барьцаалах замаар бүрдүүлэх санхүүжилтээс;
- **6.8%** буюу **1.2 триллион** төгрөгийг улсын төсвөөс;
- **0.5%** буюу **92.4 тэрбум** төгрөгийг зээл тусламжаар тус тус санхүүжүүлэхээр тооцсон байна

УИХ-ын 2008 оны 12 тоот тогтоолоор “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 2-р тэргүүлэх чиглэлд: 2007-2015 онд эдийн засгийн өсөлтийг дунджаар 14.0 хувиас доошгүй болгож, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 5000-аас доошгүй ам.долларт хүргэж, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үндэс суурийг тавих, 2016-2021 онд эдийн засгийн өсөлтийг дунджаар 12.0 хувиас доошгүй байлгаж, мэдлэгт суурилсан эдийн засгийг төлөвшүүлэн хөгжүүлж нэг хүнд ногдох ДНБ-ийг 12000-аас доошгүй ам.долларт хүргэх зорилтыг дэвшүүлсэн байна.

Энэхүү дэвшүүлсэн зорилтын хүрээнд Оюу толгойн зэс, алтны, Цагаан суврагын зэсийн, Таван толгойн нүүрсний, Асгатын мөнгөний, Чойр-Нялгын нүүрсний, Мардай, Гурванбулгийн ураны зэрэг томоохон стратегийн орд газруудыг ашиглаж эргэлтэнд оруулснаар манай улсын эдийн засгийн өсөлт харьцангуй өсч, эдийн засгийн эрчимтэй өсөлтийн үр дүнд ажлын байр олноор бий болж, 2015 онд хүн амын ядуурал 2 дахин буурна, ДНБ-ийг боловсруулах салбарын хувийн жин 4 дахин өсч, нарийн технологи

UIH.MN СУДАЛГААНЫ САН

нэвтрэн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар дээшлэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна.

"Утаагүй Улаанбаатар" хөтөлбөрийн төслийн санхүүжилтийн магадлалыг тооцохдоо судалгааны баг хөтөлбөрийн төсөлд тусгасан дараахи санхүүжилтийн эх үүсвэрүүдийн чиглэлүүдээр судалгаа, тооцоо хийв. Үүнд:

- Ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэн "Хүний хөгжил сангийн тухай" хуульд нэмэлт оруулах, уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гаргах болон Улаанбаатар хотын өмчид бүртгэлтэй үндсэн хөрөнгийг барьцаалах замаар санхүүжүүлэх нь боломжтой эсэх;
- Монгол Улсын нэгдсэн төсвөөс агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зориулан 2010-2016 онд 1.2 триллион төгрөгийг төсвөөс гаргах боломж бий эсэхэд бодит боломжид тулгуурлан таамаглал дэвшүүлж үр дүнг тооцох замаар гаргасан болно.

***Судалгааны арга зүй:***

Энэхүү судалгааны санхүүжилтийг тооцоолохдоо баримт бичиг задлан шинжлэх, таамаглал, прогноз дэвшүүлэх болон эконометрик тооцооны аргуудыг ашиглав.

**Хоёр. Судалгаа, дүн шинжилгээ**

**1/ "Хүний хөгжил сангийн тухай" хууль нэмэлт оруулах, уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гаргах болон Улаанбаатар хотын өмчид бүртгэлтэй үндсэн хөрөнгийг барьцаалах замаар бүрдүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх хувилбарын талаар:**

Засгийн газраас УИХ-д уг хөтөлбөрийг өргөн барихдаа "Хүний хөгжил сангийн тухай" хуулийн 17.5-д "Монгол Улсын иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, хүний хөгжлийг хангах зорилгоор дэд бүтцийг барьж байгуулахад сангаас хөрөнгө зарцуулж болно" гэсэн нэмэлтийг оруулахаар тогтоолын төсөлд тусгажээ. ХЭРЭВ САНГААС САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛ:

- ***"Хүний хөгжил сан"-д төвлөрөх орлого ямар байх вэ?***

Хүний хөгжил санд 2016 он хүртлэх хугацаанд стратегийн орд бүхий газраас орох орлогыг тооцохдоо 2009 онд УИХ-д "Эх орон эрдэнийн сангийн тухай" хуулийн төслийг өргөн барих үед "Эрдэнэс МГЛ" ХХК-наас УИХ-ын гишүүдэд хөрөнгийн эх үүсвэрийн тооцооны талаар тараасан танилцуулгаас авсан болно. Энэ танилцуулгад **2012** он хүртэл уг санд **1446.7** тэрбум төгрөг хуримтлуулах тооцоо гаргасан ба энэхүү тооцоонд нь стратегийн ач холбогдол бүхий доорхи 15 ордоос Засгийн газарт төвлөрөх орлогыг хасч тооцсон хэмээн тайлбарласан байна.

**Хүснэгт 1: Стратегийн ач холбогдол бүхий 15 орд газраас Эх орны эрдэнийн санд төвлөрөх орлого /2010 -2016 он/**

*/тэрбум төг/*

| № | Стратегийн орд газруудаас орох орлого | 2010 он | 2011 он | 2012 он | 2013 он | 2014 он | 2015 он | 2016 он |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Оюу толгой /Зэс, алт/ | - | - | - | 21.4 | 35.9 | 44.6 | 232.2 |
| 2 | Таван толгой /Нүүрс/ | 2.1 | 6.1 | 6.1 | 23.6 | 23.6 | 23.6 | 73.8 |
| 3 | Эрдэнэт /Зэс, молибдень/ | 65.1 | 112.3 | 113.3 | 114.4 | 108.3 | 108.3 | 108.3 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4** | Бороогийн орд /Алт/ | 6.3 | 6.5 | 6.8 | - | - | - | - |
| **5** | Төмөртэйн овоо /Цайр/ | 4.4 | 4.4 | 4.4 | 4.4 | 4.4 | 4.5 | 4.6 |
| **6** | Нарийн сухайт /Нүүрс/ | 1.3 | 1.3 | 1.3 | 1.4 | 1.4 | 2.2 | 2.3 |
| **7** | Багануур /Нүүрс/ | 0.5 | 0.5 | 0.5 | 0.5 | 0.6 | 0.6 | 0.6 |
| **8** | Шивээ – Овоо /Нүүрс/ | 0.1 | 0.1 | 0.1 | 0.9 | 1.7 | 19.8 | 21.7 |
| **9** | Цагаан суврага /Зэс/ | - | - | - | 20.1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| **10** | Бүрэнхаан /Фосфорит/ | - | - | - | - | - | - | - |
| **11** | Асгат /Мөнгө/ | - | - | - | 3.0 | 3.1 | 3.3 | 3.5 |
| **12** | Мардай /Уран/ | - | - | - | 2.2 | 2.3 | 2.5 | 2.6 |
| **13** | Дорнод /Уран/ | - | - | - | 2.2 | 2.3 | 2.5 | 2.6 |
| **14** | Гурванбулаг | - | - | - | 2.2 | 2.3 | 2.5 | 2.6 |
| **15** | Төмөртэй /Төмрийн хүдэр/ | - | - | - | 1.9 | 2.0 | 2.1 | 2.2 |
| **Нийт** | | **79.8** | **131.2** | **132.5** | **198.2** | **202.4** | **230.9** | **471.7** |

"Хүний хөгжил сан"-гаас 2012 он хүртэлх хугацаанд иргэн бүрт олгох 1.5 сая төгрөгийн 1.0 сая төгрөгийг бэлэн бусаар олгож, харин 500 мянган төгрөгийг бэлнээр олгохоор тооцож байгаа бөгөөд 2010 онд иргэн бүрт 120,0 мянган төгрөгийг бэлнээр өгөх, үлдсэн 380,0 мянган төгрөгийг 2011, 2012 онуудад тэнцүү хуваарилж олгохоор тооцвол уг сангаас 2012 он хүртэл нийт **1,4** триллион төгрөг шаардлагатай юм.

- **"Хүний хөгжил сан"-гаас "Утаагүй Улаанбаатар" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн тооцоолол, прогноз**

Хөтөлбөрийн санхүүжилтэнд шаардагдах 18.2 триллион төгрөгөөс 92.7% буюу 16.8 триллион төгрөгийн санхүүжилтийг "Хүний хөгжлийн сан"-гаас гаргахаар төсөлд тусгасан байх тул энэхүү тооцоололыг хийхдээ "Хүний хөгжлийн сан"-д ойрын ирээдүйд /2010-2016/ орохоор тооцож буй орлогын таамаглал, мөн уг сангаас зайлшгүй санхүүжүүлэхээр төлөвлөсөн иргэдэд олгох 1.5 сая төгрөгийн зарлага, хүн амын өсөлтийн прогноз зэрэг хүчин зүйлүүдийг тооцсоноор "Утаагүй Улаанбаатар" хөтөлбөрийн санхүүжилтэнд шаардагдах болон дутагдах хөрөнгийн хэмжээг тооцон гаргахад судалгааг чиглүүлсэн болно.

**Хүснэгт 2**

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| Он | ХХС-аас иргэн бүрт олгох 1.5 сая төгрөгийн төгрөгийг бэлнээр олгох хуваарь /мянган төг/ | Хүн амын тооны прогноз | "Хүний хөгжил сан"-аас иргэн бүрт хувь хишиг хүртээх нийт дүн /тэрбум төг/ | "Хүний хөгжил сан"-д уул уурхайн салбараас төвлөрөх хөрөнгийн хэмжээ /"Эрдэнэс МГЛ" ХХК-ийн тооцоолсноор/ | Утаагүй-УБ Хөтөлбөр хэрэгжүүлэхэд жил бүр шаардагдах хөрөнгийн хэмжээ /тэрбум төг/ | Утаагүй Улаанбаатар хөтөлбөрийг санхүүжүүлэхэд дутагдах хөрөнгийн хэмжээ 5-4 |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **2010** | 120,0 | 2 747,5 | 329,7 | 79,8 | 2 732,1 | -2 652,3 |
| **2011** | 190,0 | 2 784,6 | 529,1 | 131,2 | 2 547,7 | -2 416,5 |
| **2012** | 190,0 | 2 822,1 | 536,2 | 132,5 | 2 929,0 | -2 796,5 |
| **2013** | - | 2 860,1 | - | 198,2 | 2 481,1 | -2 282,9 |
| **2014** | - | 2 898,7 | - | 202,4 | 2 503,8 | -2 301,4 |
| **2015** | - | 2 937,7 | - | 230,9 | 2 693,7 | -2 462,8 |
| **2016** | - | 2 977,3 | - | 471,7 | 1 000,2 | -528,5 |
| **Нийт** | **500,0** | **-** | **1 395,0** | **1 446,7** | **16 887,5** | **- 15 440,8** |

"Хүний хөгжил сан"-гаас иргэн бүрт 1.5 сая төгрөгийг 2010-2012 онд олгоход шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоолоход хүн амын өсөлтийн экспоненциал загварыг ашиглан, эконометрик аргаар тооцоолов.

$$\text{Хүн амын тоо} = 2247.6 * e^{0.013*t}$$

Хугацааны түүхэн өгөгдөл ашигласан загвараас харахад Монгол улсын хүн ам 1995 оноос хойш жилд дунджаар 1,3 хувиар өссөн байна.[109] Энэхүү загварыг ашиглан хөтөлбөр хэрэгжих хугацаа буюу 2016 он хүртэл хүн амын тоо 2.9 сая болох тооцоо гаргав.

Зөвхөн 500.0 мянган төгрөгийг 2012 он хүртэл иргэдэд олгоход 1.39 триллион төгрөг шаардлагатай болох бөгөөд хэрвээ 1.5 сая төгрөг тараана гэвэл ойролцоогоор 4.2 триллион төгрөг шаардагдах тооцоо гарч байна. Гэтэл 2016 он хүртэл уг санд төвлөрүүлэхээр тооцсон орлого нь 1.4 триллион төгрөг байна. Үүнээс үзэхэд "Утаагүй Улаанбаатар" хөтөлбөрийг санхүүжүүлэлтэнд "Хүний хөгжил сан"-гаас 15.4 триллион төгрөгийг гаргах боломжгүй болох нь Хүснэгт 2-т хийсэн тооцооноос тодорхой байна.

Тэгвэл, 2-р хувилбар болох уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гаргах болон Улаанбаатар хотын өмчид бүртгэлтэй үндсэн хөрөнгийг барьцаалах замаар санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ? гэдэг нь эрх зүйн хувьд ч, эдийн засгийн хувьд ч агуулга нь тодорхой бус байна.

**2/ Монгол Улсын төвлөрсөн төсвөөс хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжийн талаархи тооцоолол:**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 18.2 триллион төгрөг нь манай улсын

109 -"Уул уурхайн орлогоос иргэдэд мөнгө тараах бодлогын хувилбарууд, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эерэг сөрөг үр дагаврын тооцоолол" Бодлогын судалгаа 2010 он УИХ-ын Тамгын газар Судалгааны төв

нэг жилийн төсвийг бараг 8 дахин /2009 онд МУ-ын нийт төсөв 2.3 триллион төгрөг/, нэг жилийн ДНБ-ийг 3 дахин нэмэгдүүлсэнтэй /2009 оны ДНБ 6.0 триллион төгрөг/ тэнцэхүйц хөрөнгө юм. Манай улсын эдийн засаг өсөлттэй байсан үе болох 2006-2008 онуудад ДНБ-ний өсөлт дунджаар 8.6-10.2 хувьтай, инфляцийн түвшин 6.2 -22.1% -тай байсан.

**Манай улсын ДНБ-ний өсөлтийг 2005-2009 оноор авч үзвэл**
*/оны үнээр/*




***Тайлбар:*** ** Урьдчилсан гүйцэтгэл*
***Эх сурвалж:*** *Үндэсний статистикийн хороо.*

Хөтөлбөрийн хүрээнд 2010-2016 онд хэрэгжүүлэх нийт санхүүжилт болох 18.2 триллион төгрөгөөс 6.8% буюу 1.2 триллион төгрөгийг төвлөрсөн төсвөөс гаргахаар төсөлд тусгажээ. Иймд төсвөөс гаргах 1.2 триллион төгрөгийг 2010-2016 онд хөтөлбөрийн санхүүжилтэнд шаардагдах хөрөнгийг 2006-2009 оны бодит гүйцэтгэлд тулгуурлан таамаглал байдлаар тооцов. Үүнд:

- Цаашид манай улсын эдийн засгийг харьцангуй тогтворжин, уул уурхайн бүтээгдэхүүнээс олох орлого нэмэгдэж, эдийн засаг сайжирна гэж үзвэл эдийн засгийн цэвэр өсөлт 2016 он гэхэд 15% болж, инфляцийн түвшин буурч 6.0% болох, ДНБ-ний нэрлэсэн өсөлт[110] жилд дунджаар 20% -аар өсөхөөр таамаглахад манай улсын ДНБ болон төсвийн зарлага хэрхэн өсөхийг тооцож үзлээ.

  Хүснэгт 4-т тооцсоноор, 2010-2016 онд эдийн засгийн нэрлэсэн өсөлтийг жилд дунджаар 20,0 хувьтай байна гэж үзвэл, өнгөрсөн жилүүдийн төсвийн гүйцэтгэлээс харахад манай улсын төсвийн зарлага ДНБ-ний 38,6 - 40,2%-ийг эзэлж байсан учраас төсвийн зарлага ойролцоогоор ДНБ-ны 40% орчимд байхаар тооцсон болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Хүснэгт 3: Улсын төсвөөс агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулах зардлын таамаглал**

| ***Он*** | ***ДНБ /оны*** | ***ДНБ-ний өсөлтий*** | ***Төсвийн зарлага*** | ***Төсвийн зарлагын*** | ***Агаарын бохирдолд*** | ***Төсвийн зарлага*** |
|---|---|---|---|---|---|---|

[110]-Нэрлэсэн өсөлт нь тухайн оны үнээрх ДНБ-ний өсөлт болон инфляцийн түвшингийн нийлбэрээр тодорхойлогдоно.

| | үнээр/ | н хувь | /тэрбум төг/ | өсөлтийн хувь | төсвөөс зарцуулах зардал /тэрбум төг/ | д эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2006** | 3715.0 | 33.7% | 1237.0 | 61.8% | 2.9 | 0,2% | Бодит |
| **2007** | 4599.5 | 23.8% | 1747.3 | 41.3% | 2.9 | 0,2% | |
| **2008** | 6130.3 | 33.3% | 2466.8 | 41.2% | 2.9 | 0,1% | |
| **2009** | 6055.8 | -1.2% | 2321.6 | -5.9% | 2.7 | 0,1% | |
| **2010** | 7267.0 | 20.0% | 3250.2 | 40.0% | 218.3 | 6.7% | Таамаглал |
| **2011** | 8720.4 | 20.0% | 4550.3 | 40.0% | 287.9 | 6.3% | |
| **2012** | 10464.4 | 20.0% | 6370.5 | 40.0% | 338.3 | 5.3% | |
| **2013** | 12557.3 | 20.0% | 8918.7 | 40.0% | 118.6 | 1.3% | |
| **2014** | 15068.8 | 20.0% | 12486.1 | 40.0% | 121.1 | 1.0% | |
| **2015** | 18082.5 | 20.0% | 17480.6 | 40.0% | 127.0 | 0.7% | |
| **2016** | 21699.0 | 20.0% | 24472.8 | 40.0% | 19.8 | 0,1% | |

**Тайлбар**

Тооцооноос үзэхэд, агаарын бохирдлыг бууруулахад зарцуулах зардал нь төсвийн зарлагын багаахан хувийг эзэлж байгаа хэдий ч манай улсын эдийн засгийн өсөлт, төсвийн орлого зарлага ямар байх нь тодорхойгүй учраас төсөвт нөлөөлөх нөлөөллийг урьдчилж тооцоолох боломжгүй байна.

**Гурав.“Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийн санхүүжилтийн таамаглал, тооцоонд үндэслэн гаргасан ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

1. “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөр батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд “Хүний хөгжил сангийн тухай” хуулийн 17.5-т нэмэлт оруулан энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилтийн 92.7 хувийг буюу 16.8 триллион төгрөгийг уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гаргах болон Улаанбаатар хотын өмчид бүртгэлтэй үндсэн хөрөнгийг барьцаалах замаар бүрдүүлэн санхүүжүүлэхээр тооцсон байна.

   Гэтэл “Хүний хөгжил сангийн тухай” хуулийн зорилт нь “...***ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор хүний хөгжил сан байгуулах***, түүнийг бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан байх бөгөөд хөрөнгө оруулалтын зориулалттай санхүүжилтийг гаргахаар тусгаагүй нь нийгмийн зориулалттай сан гэж ойлгогдож байна.

   Хэрэв хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийг “Хүний хөгжил сан”-аас гаргах тохиолдолд хуулийн үзэл баримтлалд өөрчлөлт оруулах асуудал гарна. Гэтэл дэлхий нийтийн практикаас үзэхэд, Засгийн газраас эх үүсвэрийг нь бүрдүүлдэг /ихэвчлэн уул уурхайн орлогоос/ тусгай зориулалтын хэд хэдэн төрлийн сан байж болох бөгөөд эдгээр сангуудын зориулалтыг тэр бүр өөрчилдөггүй байна. Тухайлбал, төсвийн тогтворжилтийг хангахад зориулсан Нөөцийн сан, Төсвийн тогтворжилтийн сан зэрэг сангууд байхаас гадна дэд бүтэц, бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх зориулалттай Хөгжлийн сан, Засгийн газрын хөрөнгийг өсгөх, гадаад дотоодын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулах зориулалттай Хөрөнгө

UIH.MN СУДАЛГААНЫ САН

оруулалтын сан зэрэг сангуудыг бий болгох боломжууд байна. */Энэ талаар тус төвөөс хэд хэдэн судалгааны тайланг өмнө нь гишүүдэд хүргүүлсэн болно/*

2. Тогтоолын төсөлд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог хавсаргасан боловч 2010-2016 он хүртэлх хугацаанд ашигт малтмал, уул уурхайн салбараас төвлөрөх орлого болон улсын төсөвт орох орлогын талаархи албан ёсны тооцоо, мэдээлэл байхгүй байна. Иймд бид судалгааны явцад 2010-2016 он хүртлэх таамаглалыг гаргахдаа УИХ-ын гишүүдэд “Эрдэнэс МГЛ” ХХК-наас ирүүлсэн “Хүний хөгжил сан”-гийн хуулийн төслийг боловсруулах болон хэлэлцэх явцад ашигласан албан бус мэдээлэлд үндэслэн гаргав.

   Монгол улс ойрын ирээдүйд уул уурхайн салбараас ихээхэн хэмжээний орлого олох бодит боломж хэрвээ байгаа бол Сангийн яам, Үндэсний хөгжлийн шинэтгэлийн хороо болон бусад холбогдох газруудаас урьдчилсан байдлаар хийсэн төсвийн орлогын прогноз, таамаглалыг албан ёсоор гаргаж эрх бүхий байгууллагад танилцуулах нь зүйтэй болов уу. Эс бөгөөс Монгол улсын нийт эдийн засгийн хүчин чадлаас давсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр УИХ-д өргөн барьж байгаа нь үндэслэлгүй, улмаар шийдвэр гаргасан тохиолдолд хэрэгжих боломжгүй байгаа нь төр засгийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

   Жишээ нь зөвхөн энэ хөтөлбөрөөс үзэхэд, 2009 оны эцэст Монгол улсын нийт эдийн засгийн хэмжээ буюу ДНБ 6.0 триллион, нийт төсвийн хэмжээ 2.3 триллион, нийт мөнгөний хэмжээ 4.5 триллион төгрөг байхад 6 жилийн дотор 18.0 триллион төгрөгийн санхүүжилт шаардагдах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр өргөн барьсан нь үндэслэл ,тооцоо муутай байна.

   Гэвч ач холбогдол, эрэмбэ дарааллаар нь ангилж үе шаттайгаар, урт хугацаанд хэрэгжүүлэх боломж байна гэж үзэж байна.

3. “Хүний хөгжил сан”-аас зарцуулах хөрөнгийн тооцоог гаргахдаа 2008-2012 оны УИХ-ын сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд иргэн бүрт олгох 1.5 сая төгрөгийн 1 сая төгрөгийг бэлэн бусаар, харин 500.0 мянган төгрөгийг бэлнээр олгоно гэж тооцож, үүнээс 2010 онд 120.0 мянган төгрөгийг олгож үлдсэн 380.0 мянган төгрөгийг 2011-2012 онд жил бүр 190.0 мянган төгрөгөөр олгохоор тооцсон.

   Зөвхөн 500.0 мянган төгрөгийг олгох тохиолдолд нийт 1.39 триллион төгрөг сангаас зарцуулах шаардлагатай бөгөөд харин уул уурхайн бүтээгдэхүүнээс уг санд 2016 он хүртэл 1.4 триллион төгрөг төвлөрөх тооцоо гарч байна. Үүнээс үзэхэд 2016 он хүртэл уг сангаас зөвхөн 500.0 мянган төгрөгийг иргэдэд олгох боломж харагдаж байна.

4. УИХ-ын 2007 оны “Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 46 дугаар тогтоолын 2-р хавсралтаар уг арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцож, шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг болгосон боловч уг тогтоолын хэрэгжилтийн талаархи мэдээлэл олдоогүй болно. Уг тогтоолын:

   – 2.8-д Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийслэлийн болон Засгийн газрын бонд гаргах асуудлыг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

   – 3 дугаар хэсэгт “Гэр хорооллын дэд бүтцийг бий болгох, орон сууцжуулах болон бусад үйл ажиллагаанд шаардагдах улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг 2007-2010 онуудад жилд 50.0 тэрбум төгрөгөөс багагүй байхаар тогтоож, жил бүрийн улсын төсөвт тусгахын зэрэгцээ хандивлагч

UIH.MN СУДАЛГААНЫ САН

орнууд, олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламж, хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх арга хэмжээ авах зэрэг чиглэлүүдийг өгсөн байна.

Гэвч 2007-2009 онуудад улсын төсвөөс агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр нийт дүнгээрээ 8.7 тэрбум төгрөгийг зарцуулсан[111] байх ба энэ нь манай улсын төсвийн зарлагын 0.1-0.2 хувийг эзэлж байна.

5. “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөрийн төсөлд дэвшүүлсэн зорилт нь Улаанбаатар хотыг төдийгүй улсын хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах зорилтуудыг тавьсан хэдий ч үйл ажилллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хувьд, Хувийн хэвшлийн салбарын санхүүжилтээр хийгдэх боломжтой ажлуудыг Улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан нь хөтөлбөрийн санхүүжилтийн дүнг ихээхэн нэмэгдүүлсэн байна. Иймд хөтөлбөрийн “Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлуудыг төрөөс зайлшгүй санхүүжүүлэх, төрөөс дэмжлэг үзүүлэх, хувийн хэвшлээс санхүүжүүлэх нь хэмээн санхүүжилтийн байдлаар нь ялгаж зааглан, дахин тооцоо хийх шаардлагатай байна.

Мөн хэрэгжүүлэх ажлуудыг эрэмбэ дарааллаар нь богино хугацааны хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэх бодит тооцоог гаргах нь зүйтэй байна. Төрийн зүгээс зөвхөн дэд бүтцийг байгуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэх, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх зэргээр оролцож болох ба бүтээн байгуулалтын ажлыг хувийн хэвшлийн хөрөнгөөр, бизнесийн үйл ажиллагааны зарчмаар хэрэгжүүлэх боломж байна гэж үзэж байна.

6. Тогтоолын төслийн танилцуулгад дурьдсан хамгийн АНХААРАЛ ТАТАЖ БУЙ АСУУДАЛ нь хөтөлбөрийн нийт санхүүжилтийн дийлэнхи хэсэг буюу 92.7 хувийг *уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гаргах болон Улаанбаатар хотын өмчид бүртгэлтэй үндсэн хөрөнгийг барьцаалах замаар санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр* тооцсон нь ойлгомжгүй бөгөөд уул уурхайн ордыг гадаадынханд барьцаалж зээл авах, эзэмшүүлэх, эсвэл нийслэлийн өмчийг барьцаалан бонд гаргах замаар зээл авах гэх мэтээр ойлгогдож байна.

Гэвч энэхүү асуудал нь Засгийн газрын өрийг нэмэгдүүлэх, эрх зүйн хувьд зөрчил үүсгэх зэрэг сөрөг үр дагавартай байж болох тул уг асуудлыг илүү тодорхой болгох, үндэслэл тооцоог нь сайтар гаргуулах шаардлагатай байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[111] - "Улаанбаатарын агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн судалгаануудад хийсэн дүн шинжилгээ" СТ-10/502 УИХ-ын ТГ-ын Судалгааны төв 2010 он

# УЛААНБААТАРЫН АГААРЫН БОХИРДОЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛИЙН СУДАЛГААНУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

*Ч.Базар, Р.Батсүх, Б.Мөнхцэцэг, Т.Мягмаржав, А.Пагма*

## Оршил

"Улаанбаатарын агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн судалгаануудад хийсэн дүн шинжилгээ" нь ЭМЯ, ЭМЯ-ны Эрүүл мэндийн нийгмийн хүрээлэн, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар, ШУА-ийн харьяа Гео-Экологийн хүрээлэн, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Агаарын чанарын алба, Дэлхийн банк, Нээлттэй Нийгэм Хүрээлэн, Жайкагийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар зэрэг 10-аад байгууллагуудын судалгаа, шинжилгээний болон төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар хийгдсэн болно. Агаарын бохирдлын эх үүсвэрүүд, түүний хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар 2000 оны дундуураас эхэлж хийгдсэн судалгаа, шинжилгээ, төслийн ажлууд их байдаг боловч тэдгээрийн тоон болон чанарын мэдээллүүд багагүй зөрүүтэй байдаг нь шинжилгээний явцад харагдлаа.

Бидний судалгааны баг Улаанбаатар хотын агаарын бохирдлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй бүрэн дүгнэлт гаргах зорилгоор Ус цаг уурын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн фонд, Нийслэлийн агаарын чанарын албанаас зохих мэдээллүүдийг авч нэг мөр ойлголтонд хүрэх зорилгоор 2000-2009 оны агаар дахь азотын хий болон хүхэрлэг хийн агууламжийг Монгол улсын стандарттай, түүнчлэн энэхүү хоёр хийн 2009 оны 12 дугаар сарын хэмжилтийн агууламжийг мөн стандарттай харьцуулж, үүний зэрэгцээ уг хоёр хийн хэмжээн дээр том ширхэглэгт тоосонцрын (PM 10) агууламжийг нэмж хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн коэффициентийг тооцон, хамаарлын харьцааг графикаар үзүүллээ.

Улаанбаатар хотын агаар дахь хийн нийлбэр хэмжээг / $NO_2$+ $SO_2$-ын + PM10 / Монгол стандарттай харьцуулсны зэрэгцээ (2009 оны 01-12 сар дуустал), агаарыг түгээмэл бохирдуулагчдаас азотын давхар исэл, хүхэрлэг хий, том ширхэглэгт тоосонцорын нийлбэр хэмжээг 2009 оны сар бүрийн хэмжилтийн дундажийг ашиглан хүний эрүүл мэндийн эрсдлийн индексийг хувиар илэрхийлэв.

Улаанбаатар хотын хэмжээнд "Монгол Улсыг хөгжүүлэх" сангаас тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулж хөрөнгө оруулалт хийн, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа аж ахуйн нэгжийн үйлдвэрлэж байгаа үртсэн түлшний 2, шахмал түлшний 4, хагас коксжуулсан түлшний 1, зуух түлшний хосолсон 1 түлшний утааны найрлагад НАЧА-наас хийсэн шинжилгээний дүнг, стандарт агууламжтай харьцуулан анализ хийж дүгнэлт гаргав. Эдгээр ААН-ийн авсан санхүүжилтийн хэмжээ, түлшний үйлдвэрлэл, борлуулалт зэргийг НАЧА-ны тайланд тодорхой тусгасан байсан тул зөвхөн утааны химийн найрлагыг судалгаанд авлаа.

Түлшний үйлдвэрүүдийн 2006-2009 онд авсан санхүүжилт болон гэрээний биелэлт, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зориулагдаж 2007-2009 онд улсын төсөвт батлагдсан төсөвт өртөгт судалгаа хийж, дүгнэлт гаргав.

Агаарын бохирдол түүнээс үүдэлтэй орчны бохирдол хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх байдлын ерөнхий ойлголт, нийслэлийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлж буй байдлын талаархи судалгаануудыг эмхтгэн нэг мөр ойлголт өгөхийг хичээв.

Агаарын бохирдлыг бууруулахын тулд дотоод, гадаад бүх боломжийг хослуулан ашиглах үр өгөөжийн талаархи эрдэмтэн, судлаачдын санал болгодог зүйлсийг тоймлохын хажуугаар, эрх зүйн орчинд зайлшгүй хийх өөрчлөлтүүдийг тусгав.

Энэ бүхний эцэст цаашид анхаарах зүйлсийг эрх зүй, эдийн засаг, нийгэм, хүний эрүүл

мэнд, агаарыг бохирдлыг бууруулах эх үүсвэр гэсэн ангилалд хуваан дор дор нь анхаарах зөвлөмжүүдийг гаргалаа. Түүнчлэн агаарын бохирдлыг арилгаж, багасгаж байгаа БНХАУ, Япон, ОХУ-ын туршлага, арга зүйг энэхүү судалгаанд оруулав.

## НЭГ. Агаарын найрлага, чанарын стандарт, Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэрүүд, өнөөгийн байдал

### 1.1. Агаарын химийн найрлага.

Задгай орчин дахь агаарын тогтмол найрлагыг хийн төлөвт орших азот $N_2$ 78%, хүчилтөрөгч $O_2$ 21%, үлдсэн хувийг нүүрсхүчлийн хий $CO_2$, инертийн хий бүрдүүлдэг. Хот, суурин газар нийгэмшилттэй холбоотойгоор үйлдвэр ахуйн нөхцлөөс төрөл бүрийн хийн төлөвт орших химийн нэгдлүүд агаарт дэгдэж агаарын найрлагыг өөрчилдөг. Эдгээр нь ихэвчлэн хатуу болон шингэн түлшний шаталтаас үүсэх хөө тортог тоос, хий, хүхэрлэг хий $SO_2$, азотын хий $NO_2$, нүүрстөрөгчийн дутуу исэл CO, озон $O_3$ юм. 2010 оны 1 дүгээр сард Харуулын станцийн хийсэн хэмжилтийн дүнгийн дунджаас харахад, **$S0_2$ хүхэрлэг хий 3,65 дахин их, $N0_2$ азотын давхар исэл 1,35 дахин их, PM 2.5 бага ширхэглэгт тоосонцор 3,56 дахин их, PM10 том ширхэглэгт тоосонцор 1,97 дахин их, CO-угаарын хий 0,56 дахин бага** байна. Баянзүрх дүүргийн Сансрын шатахуун түгээгүүр, Дарь-Эх, Чингэлтэй дүүргийн 32-ын тойрог гэх мэт цэгүүдээр бохирдол хамгийн их байна. Угаарын хийн хэмжээ бага байгаа нь стандарт хэмжээ 3мг/$м^3$ гэж өндөр тогтсонтой холбоотой.

### 1.2. Агаарын чанарын стандарт.

Дээрх хийн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хамгийн дээд хэмжээг агаарын чанарын индексээр үнэлж, түүний стандартыг тогтоодог. Агаарын чанар гэдэг нь орчны агаарын хэвийн болон өөрчлөгдсөн төлөв байдлын харьцааг хэлнэ. Манай улс 2007 онд батлагдсан MNS4585:2007 агаарын чанарын стандартад дээрхи хийнүүдийг хэмжилтийн дундаж хугацааны нарийвчлалтайгаар авч хоногийн болон жилийн дундаж стандартыг тогтоожээ. Нийслэлийн агаарын чанарын алба 6 дүүрэгт байрлуулсан агаарын чанарт байнгын шинжилгээ хийдэг суурин 6, явуулын 2 автомат хяналтын станц байрлуулан хоногт 24 цагийн хэмжилт хийж байна. Эдгээр суурин болон хөдөлгөөнт харуулын станцууд нь агаарыг бохирдуулагч 22 химийн бодисоос хүхэрлэг хий, азотын давхар исэл, угаарын хий, озон, тоос, тоосонцор гэсэн 6 бодисыг тухайлан хэмждэг. Эдгээр химийн нэгдлүүд ихэвчлэн хатуу ба шингэн түлшний шаталтаас үүсдэг байна. Улаанбаатар хотын хүүхдийн амьсгалын замын өвчлөл, агаарыг бохирдуулагч зарим хортой бодисын хамаарлыг харьцуулан судлахад нүүрс төрөгчийн дутуу исэл, хүхэрлэг ангидридтэй, азотын исэлтэй шууд, дунд зэргийн хамааралтай байхад уушигны хавдар үүсэх шалтгаанд азотын ислүүд 11.9%-ийг эзэлж байна. Хүхрийн давхар исэл (-0.293, p-0.0001), харьцангуй чийг (-0.232, p-0.0001), агаарын даралт (-0.223, p-0.0001) болон азотын давхар исэл (-0.188, p-0.0001) нь амьсгалын замын өвчлөлтэй шууд хамааралтай, харин дундаж температур салхины хурд амьсгалын замын өвчлөлтэй урвуу хамааралтай байгааг судлаачид тогтоожээ. Түүнчлэн Улаанбаатар хотын 0-16 насны хүүхдүүд багтраагаар өвчлөхөд нөлөөлж буй олон хүчин зүйлийн дотор тоосны үзүүлэх нөлөө 56.5 хувь байгааг илрүүлсэн байна[112]. Манай улсад жилдээ дунджаар 90.7 мянган хүн амьсгалын замын өвчнөөр өвчилж, эмчилгээнд ойролцоогоор 4.8 тэрбум төгрөг зарцуулсан тооцоо гарч байна.

### 1.3. Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэрүүд.

Улаанбаатар хотын агаар хүйтэн сэрүүний улиралд (9 сарын 15-наас 5 сарын 15)

[112] Судлаач Б.Бурмаа. УБ., 2001

ихээхэн бохирдолттой байгаа нь утаа тортог ихээр ялгаруулдаг хатуу (түүхий нүүрс, мод), шингэн түлшийг (бензин, дизелийн түлш) шатааж дулааны эх үүсвэрээ болгодог ***"145.000 гэр хорооллын айл өрх бохирдлын 50%, 137.000 тээврийн хэрэгсэл 20%, шороон зам баригдаж байгаа барилга байгууламж 14%, 1400 бага болон дунд оврийн нам даралтын халаалтын зуух 10 %, дулааны 3 цахилгаан станц 6%"*** [113] юм. Эдгээр эх үүсвэрүүд нь зөвхөн **1 жилд** шаталтын явцад **260,0 мянга гаруй тонн** хорт бодисыг **6 сая тонн** түүхий **нүүрс, 240 мянга гаруй** $м^3$ **мод** шатааж агаарт гаргаж байна. Мөн жилдээ **98.5 мянган тонн тоосонцор (PM10)** агаарт ялгарч байгаагийн **16.74 тонн** буюу 17%-ийг **нам даралтын зуух, 22.65 тонн** буюу 23%-ийг **гэр хорооллын айл өрхийн гар галлагаатай зуух**[114] ялгаруулж байгааг агаарын чанарын албаны станцын хэмжилтийн дүнгээс үндэслэн судалгааны байгууллагууд тогтоожээ. Хэмжилтийн дүнгээс үзэхэд нийслэлийн төвийн зургаан дүүргийн хороодын нутаг дэвсгэрт хийсэн агаарын чанарын үзүүлэлтүүд нь Монгол Улсын MNS 4585:2007 стандарт буюу "Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага" стандартыг хангахгүй байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдолд дээрхи химийн нэгдлүүдээс гадна дараах хүчин зүйлүүд ихээхэн нөлөө үзүүлж байгааг судалгаануудад дурьдсан байна. Үүнд:

1. ***Хотын газар зүйн байршил.*** Дөрвөн уулаар хүрээлэгдэн, голын дагуух хөндийд Улаанбаатар байрладаг нь агаарын урсгал хөдөлгөөнийг харьцангуй тогтуун /салхины дундаж хурд 1-2 м/секунд/ байлгаж, утаа тоос нүүж шилжих боломжгүйгээс агаараас хүнд жинтэй дээрхи химийн нэгдлүүд хүний өндрийн түвшинд тунарч тогтдог;

2. ***Үйлдвэр аж ахуйн газрууд.*** Салхины чиглэлийн дээд хэсэгт байх дулааны станц, үйлдвэрийн газрууд, дөрвөн уулын бэлээс эхлэн хотын төв хүртэл тархсан гэр хорооллын байрлал;

3. ***Хөрсний эвдрэл.*** Хийн төлөвт орших химийн нэгдлүүд $SO_2$, $NO_2$, $CO_2$ бороо цасны усанд уусч хүчил болон бууж ургамал, микро организмын өсөлтөд нөлөөлж, улмаар хөрсний эвдрэлийг бий болгодог.

4. ***Гэр хорооллын механик өсөлт.*** 2008 оны эцсийн статистик мэдээгээр хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн 80.4% нь гэр хороололд суурьшдаг бөгөөд одоо хотын нийт айл өрхийн 144.5 мянга нь (61.5%) гэр хороололд амьдарч байна[115];

5. ***Тээврийн хэрэгслийн өсөлт.*** 2007 онд 92706, 2008 онд 106848, 2009 онд 137 000 болсон нь тооны хувьд 14142 - 30152 буюу 13.2- 22% өссөн байна.

6. ***Бензиний хэрэглээ.*** Хар тугалга, кадми зэрэг хүнд металл ихээр ялгаруулдаг А76, А80 маркийн этил бензиний хэрэглээ маш их байна.

7. ***Хот цэцэрлэгжүүлэлт.*** Хотын ногоон байгууламж болон цардмал зам талбай бага, эл задгай баригдаж байгаа барилга байгууламж, тоосго, цемент, блокны үйлдвэр, голын сав дагуух элс хайрганы орд газруудын тоосжилт их нөлөөлдөг.

Нийслэлийн агаарын чанарын албаны суурин харуулуудын мэдээнээс үзэхэд, өвлийн улиралд бохирдлын хэмжээ автомашины хөдөлгөөний нягтрал ихсэх, гэр хорооллын айл өрхүүдийн галлагаатай давхцан 18 цагаас хойш эрчимтэй ихэсдэг ажээ. 2010 оны 1 дүгээр сарын агаарын чанарын хэмжилтүүдийн дундаж дүнг Монгол улсын стандарт болон

[113] Нийслэлийн агаарын чанарын албаны тайлан. УБ., 2009
[114] НАЧА-ны вэб сайт. 2010 оны 1 дүгээр сарын хэмжилтийн дундаж мэдээ
[115115]"Агаарын бохирдлыг бууруулах талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан". х9. УБ., 2009

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Европын стандарттай харьцуулан харуулав. (Хүснэгт 1-ийг үзнэ үү) Эндээс харахад, нарийн ширхэгт (PM2.5) болон том ширхэгт (PM10) тоосны хэмжээ Монгол улсын стандартаас (**PM2.5 –PM10) 3.56-1.97** дахин, Европ стандартаас (**PM2.5-PM10) 7.12-3.94** дахин их байна.

Түүнчлэн хүснэгт №1 дэх үзүүлэлтээр бол манай улсын одоо мөрдөж байгаа MNS4585:2007 агаарын чанарын стандарт нь Европын стандартаас (хүхэрлэг хийнээс бусад нь) 2 дахин өндөр тогтоогдсон байна. Агаарыг бохирдуулагч бүх эх үүсвэрүүд өнөө мөрдөж буй Монгол улсын стандартаас 1.35- 3.65 дахин их байна. Харин угаарын хийн стандартыг Европ стандартаас 3 дахин өндөр тогтоосон учир өнөөгийн бодит хэмжээ нь Монголынхоос 0.56 дахин бага, Европынхоос 1.69 дахин их үзүүлэлттэй гарчээ. Хүний эрүүл мэндэд нэн хортой энэхүү хийн стандартын хэмжээг багасгаж, бусад бохирдуулагчийн адил түвшинд тогтоох шаардлагатай гэдэг нь харьцуулалтаас харагдаж байна.

Үүний зэрэгцээ нийслэлийн агаарын бохирдолд бүрэн хэмжилт хийхийн тулд суурин харуулын цэгийн тоог нэмэгдүүлэх шаардлага гарч байна. Энэхүү суурин харуул нь 25000 хүний дунд 1 байх ёстой гэж үзвэл өнөөгийн байдлаар Улаанбаатар хотод 1.000.000 гаруй хүний тоотой харьцуулахад 40 гаруй суурин харуулыг торлосон маягаар байрлуулж байж үнэн бодит мэдээ гарахаар байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй бүрэн дүгнэлт гаргах зорилгоор Ус цаг уурын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн фонд, Нийслэлийн агаарын чанарын албанаас зохих мэдээллүүдийг авч нэг мөр ойлголтонд хүрэх зорилгоор 2000-2009 оны агаар дахь азотын хий болон хүхэрлэг хийн агууламжийг Монгол улсын стандарттай харьцуулан график №1-д, энэхүү хоёр хийн 2009 оны 12 дугаар сарын хэмжилтийн агууламжийг мөн стандарттай харьцуулж график №2-т, түүнчлэн уг хоёр хийн хэмжээн дээр том ширхэглэгт тоосонцрын (PM 10) агууламжийг нэмж хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн коэффициентийг тооцон хүснэгт №2, хамаарлын харьцааг график №4 тус бүр харуулан дор дор нь тайлбар хийлээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**1.4. Улаанбаатар хотын агаарыг хамгийн их бохирдуулагч, тэдгээрийн эх үүсвэр, бохирдлын хэмжээ, орчинд үзүүлэх нөлөөлөл**

**Хүснэгт №1**

| № | Бохирдуулагч | Юунаас хэрхэн үүсэх | Эх үүсвэр | Монгол стандарт | Европ стандарт | УБ хотод 2010. 01 сард /хоногт/ | Монгол болон Европ стандартыг харьцуулахад | Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Тоос , тортог PM 2.5-аас /нарийн ширхэгт тоос- 24 цаг/ | Хатуу түлш, бензин, дизелийн түлшний шаталт, хучилтгүй сул шороон зам, ой хээрийн түймэр, элс хайрганы орд , тоосго цемент блокны үйлдвэр, баригдаж буй барилга байгууламж | Салхи, автомашины үүсгэх тоосжилт, гар галлагаатай гэр хороолол, автомашин, дулааны станц, нам даралтын халаалтын | 0.050мг/м$^3$ | 0.025мг/м$^3$ | 0.178 мг/м$^3$ | 3.56-7.12 дахин их | Түүхий нүүрсний шаталтын эхний үед ялгардаг дэгдэмхий нэгдлүүд үнс,хөө тортогууд нь хотын гудамж талбайд бууж орчин болон албан байгууллага гэр орныг бохирдуулдаг. |
| | Тоос, үнс PM 10,0-аас Том ширхэгт тоос 24 цаг/ | | | 0.1 мг/м$^3$ | 0.05 мг/м$^3$ | 0.197 мг/м$^3$ | 1,97-3,94 дахин их | |
| 2. | Хүхэрлэг хий $SO_2$ | Хатуу түлш, бензин, дизелийн түлш, нефтийн гаралтай шатах тослох материалын шаталтаар, цаас болон металлургийн үйлдвэрийн явцад, ялангуяа манай нөхцөлд түүхий нүүрсний илчлэг ихтэй шаталтын дунд үүсдэг | Гар галлагаатай гэр хороолол, автомашин, дулааны станц, нам даралтын халаалтын зуух, галт уулын лав хайлах | 0.020 мг/м$^3$ | 0.125мг/м$^3$ | 0.073 мг/м$^3$ | 3.65-0.58 дахин их | Агаарын чийгийг багасгах, ус хөрсний эрдэсжилтийг ихэсгэх, ургийн бактерийг үхүүлж, ургамал болон микро-организмын өсөлтийг саатуулна, хүчиллэг бороо үүсгэх найрлагын бүрэлдхүүн хэсэг, агаарт тогтсон хүчиллэг аэреозол нь алсын харагдах байдлыг бууруулж хөшөө баримал болон байшингийн тоосго, чулуу төмөр хийцүүдийг идэж гэмтээнэ. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Азотын давхар исэл $NO_2$ | Хатуу түлш, бензин, дизелийн түлшний шаталтаар | Тээврийн хэрэгсэл, эрчим хүчний үйлдвэр, аянга цахилгаан | 0.040 мг/м$^3$ | 0.020 мг/м$^3$ | 0,054 мг/м$^3$ | 1.35-2,7 дахин их | Хүчиллэг бороо үүсгэх найрлагын гол хэсэг ургамал болон гол мөрөн, нуур цөөрмийн усны амьдралын орчинд хортой нөлөө үзүүлнэ. |
| | Нүүрстөрөгчийн дутуу исэл буюу угаарын хий | Байгалийн хий , нүүрс, бензин, дизелийн түлш, нефтийн гаралтай шатах тослох материалын дутуу шаталтаар үүснэ. Хот суурин газарт угаарын хийн бохирдлын 60 илүү хувийг автомашин ялгаруулдаг. | Түүхий нүүрс, түлшийг дутуу шатааж буй бүх зуух, тээврийн хэрэгсэл | 3мг/м$^3$ | 1мг/м$^3$ | 1.69 мг/м$^3$ | 0,56-1,69 дахин бага/их | Хөө тортогны бүрэлдхүүн хэсэг хүний эрүүл мэндэд нэн хортой |
| 5. | Озон $O_3$ | Агаар мандлын доод давхарга буюу газрын гадарга орчимд автомашин, цахилгаан станц, уурын зуух зэрэг эх үүсвэрүүдээс ялгардаг бохирдуулах бодисууд нь дулаан нарлаг өдрүүдэд урвалд орж муу озоныг үүсгэнэ. Зуны хурц нартай өдрүүдэд озоны бохирдол их байна | Тээврийн хэрэгсэл, цахилгаан станц уурын зуух Агаар дахь хлор үүсгэгчид /агаажуулагч, хөргөгч/ | 0.1мг/м$^3$ | 0.12 мг/м$^3$ | | | Агаарт озон бага хэмжээгээр агуулагдах нь агаар орчныг цэвэр байлгадаг боловч 0.002-0.02 мг/л-ээс хэтэрвэл хүн, амьтны амьсгалын замын эрхтнүүдийг цочроож хүн, амьтан, ургамалд хортой үйлчилгээ үзүүлдэг. |

1.5. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар исэл болон хүхэрлэг хийн хэмжээг Монгол улсын стандарттай жишсэн байдал (2000-2009 он)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**График №1**




*Тайлбар:* Графикаас харахад азотын давхар ислийн агууламж 2003, 2005, 2007, 2008 онуудад зөвшөөрөгдөх түвшингээс 1-6 мкг/$м^3$-аар илүү, Хүхэрлэг хийн хэмжээ 2002-2009 онд зөвшөөрөгдөх түвшингээс 1-10 мкг/$м^3$ байнга өсч байна.

1.6. 2009 онд жилийн туршид Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар исэл болон хүхэрлэг хийн хэмжээг Монгол улсын стандарттай жишсэн байдал (2009 оны 01 -12 сард)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**График№2**




*Тайлбар:* Азотын давхар ислийн агууламж 24 цагийн дунджаар 2009 онд зөвшөөрөгдөх хэмжээнээс 5.0 мкг/м$^3$ –аар илүү, хүхэрлэг хийн хэмжээ 1,2,3,11,12 саруудад зөвшөөрөгдөх хэмжээнээс 2,5-45,0 мкг/м $^3$- аар их байгаа нь өвлийн улиралд дулааны эх үүсвэр болсон түүхий нүүрсний хэрэглээ их байгаатай холбоотойгоор хүн амын эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх түвшинд хүрсэн байна.

**1.7. Улаанбаатар хотын агаар дахь хийн нийлбэр хэмжээг / $NO_2$+ $SO_2$-ын + PM10 / Монгол стандарттай харьцуулсан байдал (2009 оны 01 - 12 сар дуустал)**

Агаарыг түгээмэл бохирдуулагчдаас азотын давхар исэл, хүхэрлэг хий, том ширхэглэгт тоосонцорын нийлбэр хэмжээг 2009 оны сар бүрийн хэмжилтийн дундажыг ашиглан хүний эрүүл мэндийн эрсдлийн индексийг хувиар илэрхийлэв.

**Хүснэгт №2**

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт бохирдуулагч -ын нийлбэр $NO_2$ +$SO_2$** | 58 5 | 13 6 | 11 7,8 | 11 7,3 | 107, 8 | 62, 87 | 66, 16 | 53, 48 | 87, 04 | 137, 6 | 419,6 | 434, 1 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **+PM10** | | | | | | | | | | | | |
| **Зөвшөөрөгдөх түвшин** | 160 | 160 | 160 | 160 | 160 | 160 | 160 | 160 | 160 | 160 | 160 | 160 |
| **Эрүүл мэндийн индекс коэффициент-ээр** | 0,27 | 0,85 | 1,35 | 1,36 | 1,48 | 2,50 | 2,41 | 2,99 | 1,83 | 1,16 | 0,38 | 0,36 |
| **Эрүүл мэндийн индекс /хувиар/** | 27 % | 85 % | Эрүүл мэндэд нөлөөлөхгүй | | | | | | | | 38% | 36% |
| **Эрүүл мэндийн эрсдлийн индекс / хувиар/** | 73 % | 15 % | Эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй | | | | | | | | 62% | 64% |

**График № 3**




UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Тайлбар:* 2009 оны 1, 11, 12-р сарууддад бохирдуулагчдын нийлбэр нь ($NO_2$ + $SO_2$ + PM10) зөвшөөрөгдөх хэмжээнээс 319.6 - 425 мкг/$м^3$ –аар илүү байгаа тохиолдолд эрүүл мэндийн индексийг хувиар тооцвол 27-85% байх бөгөөд эрүүл мэндийн эрсдлийн индексээр авч үзвэл 15-73% байна. Эндээс агаар бохирдуулагч бодис зөвшөөрөгдөх хэмжээнээс 1мкг/$м^3$ илүү байх нь хүний эрүүл мэндийг 0,125%-иар хөнөөх бөгөөд өвлийн сарууддад нийтдээ 20-25 хувийн сөрөг нөлөө үзүүлэх магадлал байна.

**ХОЁР. Зуух болон түлшнээс үүдэлтэй агаарын бохирдлын тухай**

Шаталт нь түлш болон исэлдүүлэгчийн хооронд явж их хэмжээний дулаан ялгаруулдаг химийн урвал юм. Түүхий нүүрсний шаталт бүрэн гүйцэд явагддаггүй тул шаталтаас гарсан утаанд хөө тортог, $NO_2$, $SO_{2,}$ $H_2S$, PM 2.5-10 зэрэг нэгдлүүд их ялгардаг.

Улаанбаатар хотын хэмжээнд “Монгол Улсыг хөгжүүлэх” сангаас тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулж хөрөнгө оруулалт хийж, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа аж ахуйн нэгжийн үйлдвэрлэж буй үртсэн түлшний 2, шахмал түлшний 4, хагас коксжуулсан түлшний 1, зуух түлшний хосолсон 1 түлшний утааны найрлагад НАЧА-наас хийсэн шинжилгээний дүнг, стандарт агууламжтай харьцуулан анализ хийж дүгнэлт гаргав. Эдгээр ААН-ийн авсан санхүүжилтийн хэмжээ, түлшний үйлдвэрлэл, борлуулалт зэргийг НАЧА-ны тайланд тодорхой тусгасан байсан тул зөвхөн утааны химийн найрлагыг судалгаанд авав.

***2.1. Өндгөн шахмал түлшний үйлдвэрлэл.*** Өндгөн шахмал түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн түлшний чанарын үзүүлэлт, шаталтаар үүсч байгаа утааны химийн найрлагыг харьцуулан Хүснэгт № 3-д авч үзлээ.

**Хүснэгт № 3**

| № | Түлш үйлдвэр-лэгч | Угаарын хий /CO/ мг/м$^3$ | | | Азотын исэл /$NO_2$/ мг/м$^3$ | | | Хүхрийн исэл /$SO_3$/ мг/м$^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хэмжилт | | Зөрүү | Хэмжилт | | Зөрүү | Хэмжилт | | Зөрүү |
| 1. | “Говийн түлш “ХХК | 24401,32 | Стан-дарт 4000 | 6,01 дахин их | 499,77 | Стан-дарт 450 | -1,11 | 21,77 | Стандарт 800 | -36,76 |
| 2. | “Бурханы гал”ХХК | 12055,33 | | 3,01 дахин их | 993,24 | | 1,9 дахин их | 0 | | 0 |
| 3. | “Нэбис” ХХК | 25713,03 | | 6,42 дахин их | 625,90 | | 1,39 дахин их | 0 | | 0 |
| 4. | “Тану түлш” ХХК | 37499,10 | | 9,4 дахин их | 572,06 | | 1,27 дахин их | 4,44 | | -180,2 |
| | **Дундаж** | | | 6.21 дахин их | | | 1.52 дахин их | | | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Дүгнэлт:**

1. Судалгаанд авагдсан 4 аж ахуйн нэгжийн түлшний шаталтаас гарах нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ стандартаас 3.01-9.4 дахин их, азотын ислийнх 1.4-1.9 дахин их, хүхрийн ислийнх Говийн түлшний хувьд стандартаас 36.74 дахин бага, Бурханы гал, Нэбис ХХК –ийн түлшнээс хүхэрлэг хий ялгараагүй, Тану түлшнийх стандартаас 180.2 дахин бага байна.

2. Түлшний үйлдвэрүүдийн гэрээг 2009 оны 4 дүгээр сард дүгнэсэн бөгөөд олон удаагийн хэмжилтийн дүнгээр түлшний утаан дахь бохирдуулагч бодисын үзүүлэлт нь

стандартын шаардлага хангаагүй учир ААН-үүдэд дараахи шаардлага тавьж ажиллаж байгаа юм байна Үүнд:

- Үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийг боловсруулсан нүүрсээр орлуулах
- Түүхий нүүрсийг угааж баяжуулж хэрэглэх зэрэг болно.

***2.2. Үртсэн шахмал түлш.*** Үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд нь Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон, Булган аймгийн Хялгантад байрлаж байсан модны үйлдвэрийн хаягдал үртэс бөгөөд 7-10 жилийн нөөцтэй юм. Туслах материал ой үйлдвэрлэхэд гардаг мөчир бөгөөд хэрэглээний бус мод. Үртсэн шахмал түлш үйлдвэрлэдэг 2 аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн түлшний утаанд хийсэн шинжилгээг стандарттай харьцуулан Хүснэгт № 4-д үзүүлэв.

**Хүснэг № 4**

| № | Түлш үйлдвэрлэгч | Угаарын хий /CO/ мг/м$^3$ | | | Азотын исэл / $NO_2$ / мг/м$^3$ | | | Хүхрийн исэл/$SO_3$ / мг/м$^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хэмжилт | | Зөрүү | Хэмжилт | | Зөрүү | Хэмжилт | | Зөрүү |
| 1. | “Хүслэн өлзий” ХХК | 44353.9 | Стандарт 4000 | 11,08 Дахин их | 410.25 | Стан-дарт 450 | 1.09 дахин бага | Хүхэрлэг хий ялгараа-гүй | Стан-дарт 800 | |
| 2. | “Тара” ХХК | 43143.7 | | 10,8 Дахин их | 287.67 | | 1.56 дахин бага | | | |
| | **Дундаж** | | | 10.94 Дахин их | | | 1.03 Дахин бага | | | |

**Дүгнэлт**

1. Дээрх ААН-үүдийн түлшний шаталтаас гарах утааны нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ стандарт үзүүлэлтээс 10.94 дахин их, азотын ислүүдийн хэмжээ стандартаас 1.3 дахин бага, хүхрийн исэл ялгараагүй байна.

2. Үйлдвэрүүдийн үйл ажиллагааг авч үзвэл, үйлдвэрлэл эхлүүлэх зардал өндөр, тоног төхөөрөмж хоцрогдмол хүчин чадал бага, ойн нөөц ашиглалтанд сөрөг нөлөөтэй, гаргаж байгаа түлш нь Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***2.3. Хагас коксжуулсан түлш.*** “Төгрөг нуур” ХХК дунд температурын коксжуулсан нүүрсийг үйлдвэрлэдэг. Энэ түлш нь нүүрсийг дулааны аргаар боловсруулж, нүүрс дэх дэгдэмхий ба хорт бодисуудыг ялган цэвэрлэж утаагүй түлш буюу хагас коксжсон, байгаль орчинд ямарч хоргүйгээр шатдаг синтезийн хий, бусад дайвар бүтээгдэхүүнийг ялган авдаг бөгөөд энэхүү энгийн технологитой боловсруулалт нь ганц шаттай явагддаг. Шаталтын эцсийн бүтээгдэхүүнийг Хүснэг № 5-д үзүүлэв.

**Хүснэгт № 5**

| № | Түлш үйлдвэр-лэгч | Угаарын хий /CO/ мг/м$^3$ | | | Азотын исэл / $NO_2$ / мг/м$^3$ | | | Хүхрийн исэл/$SO_3$ / мг/м$^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хэмжилт | Стандарт | Зөрүү | Хэмжилт | Стандарт | Зөрүү | Хэмжилт | Стандарт | Зөрүү |
| 1. | "Төгрөг нуур" "Энержи" ХХК | 29875,84 | 4000 | 7,11 Дахин их | 625,8 | 450 | 1,39 Дахин их | Хий ялгараагүй | 800 | |

**Дүгнэлт:** Хагас коксжуулсан түлшийг шатаахад гарах утаан дахь нүүрсхүчлийн хий, азотын давхар исэл зэрэг нь стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа бөгөөд одоогийн олборлож байгаа нүүрсээр хагас коксжсон нүүрс үйлдвэрлэх боломжгүй байна. Мөн үйлдвэрлэл төлөвлөсөн хугацаандаа эхлээгүй түлш нийлүүлэх гэрээгээ биелүүлээгүй байна.

***2.4. Ёнтан зуух, түлшний үйлдвэр***

- Бүтээгдэхүүний түүхий эд нь нунтаг нүүрс 60-70%, шар шавар 15-20%, ус 5-10% юм. Түлш нь цилиндр хэлбэртэй бөгөөд диаметр нь 15 см, өндөр даралтаар шахаж нягтруулсан 3 кг орчим жинтэй, шаталтын хугацаа нь 4-6 цаг.
- Ахуйн хэрэглээний Ёнтан утаагүй зуух 4-5 ханатай гэрт тохирсон ба М6-102 маркийн зууханд 3 ширхэг Ёнтон шахмал түлш хэрэглэнэ.
- Их 5-6 ханатай гэрт тохирсон М6-203 маркийн зууханд 6 ш Ёнтан шахмал түлшийг 2 эгнээгээр хэрэглэнэ.
- 6, 7, 8 ханатай гэрт болон 1 өрөө жижиг байшинд М6-303 маркийн зууханд 9 ширхэг Ёнтан шахмал түлшийг 3 эгнээгээр цэнэглэнэ. Энэ зуухны шаталтын эцсийн бүтээгдхүүнийг Хүснэгт № 6-д үзүүлэв

**Хүснэгт №6**

| № | Түлш үйлдвэрлэгч | Угаарын хий CO мг/м$^3$ | | | Азотын исэл $NO_2$ мг/м$^3$ | | | Хүхрийн исэл $SO_3$ мг/м$^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хэмжилт | Стан-дарт | Зөрүү | Хэмжилт | Стан-дарт | Зөрүү | Хэмжилт | Стандарт | Зөрүү |
| 1. | "Сонжин Энержи" ХХК | 18215,92 | 4000 | 4.55 дахин их | 252.5 | 450 | 1.78 дахин бага | Хий ялгараа-гүй | 800 | |

**Дүгнэлт:**
1. Ёнтан түлшний утааны найрлага дахь нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ стандартаас **4.55 дахин** их байна.
2. Энэ түлш нь үнэ өндөртэй, чанарын хувьд цаашид сайжруулах шаардлагатай.

***2.5. "Шарын гол энерго" ХХК-ын коксжуулсан түлшний "Эко энержи" үйлдвэр***

Энэ үйлдвэр нь ердийн түүхий нүүрсийг 450-5500$^0$C-ийн хэмд дулааны аргаар боловсруулж хагас кокс гаргах ба энэ үед ялгарах азот, хүхэрлэг зэрэг хорт хийнүүдийг тусгай төхөөрөмжөөр цэвэрлэн, синтетик хий гарган авч эрчим хүч үйлдвэрлэхэд ашигладаг. Мөн хагас коксжуулсан нүүрсээ модны үртэс болон тосны цардуултай барьцалдуулан коксжуулсан утаагүй шахмал түлш үйлдвэрлэдэг. "Эко энержи" үйлдвэрийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

коксжуулсан нүүрс, үртэс+коксжуулсан нүүрсний шахмал түлшний шаталтын эцсийн бүтээгдхүүн утааны найрлыг Хүснэгт №7 –д харуулав.

**Хүснэгт №7**

| № | Түлш үйлдвэрлэгч | Угаарын хий /CO/ мг/м$^3$ | | | Азотын исэл / $NO_2$ / мг/м$^3$ | | | Хүхрийн исэл/$SO_3$ / мг/м$^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хэмжилт | | Зөрүү | Хэмжилт | | Зөрүү | Хэмжилт | | Зөрүү |
| 1. | “Шарын гол-энерго” ХХК Коксжуул-сан түлш | 3979 | Стан-дарт 4000 | Стандартад нийцсэн | 444 | Стан д-арт 450 | 0.98 Дахин бага | 441.9 | Стан д-арт 800 | 19.82 Дахин бага |
| 2. | “Эко энержи” ХХК Коксжуул-сан түлш+үртэс 50:50 | 3990 | | | 59,27 | | | 40.35 | | |

**Дүгнэлт:** Тус үйлдвэрийн туршилтаар үйлдвэрлэж байгаа 2 бүтээгдэхүүн болох коксжуулсан түлш, үртэс+ коксын шахмал түлшний утааны найрлаган дахь угаарын хий нь стандартын хэмжээнд, азотын ба хүхрийн ислийн хэмжээ нь Монгол улсын стандарт хэмжээнээс 0,98-19,82 дахин бага байгаа нь өмнө дурдсан түлшнүүдээс нилээд сайн чанартай болох нь шинжилгээнээс харагдаж байна.

**ГУРАВ. Нийслэлийн чанарын албаны судалгаанд хамрагдсан шахмал ба коксжсон түлшний үзүүлэлтүүдийг харьцуулсан судалгааны нэгдсэн дүгнэлт**

1. Одоогийн ажиллаж байгаа шахмал түлшнүүд /нүүрс+шавар/-ийн утаан дахь бохирдуулагч бодисууд болох ***нүүрстөрөгчийн дутуу ислийн* агууламж** стандарт хэмжээнээс ***3.01-10.94 дахин их***, ***азотын давхар ислийн* агууламж *1.27-1.9 дахин их, азотын давхар исэл 1.27-1.9 дахин их*** байгаа нь агаарын бохирдлыг бууруулах үндсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй байна.

2. Үртсэн шахмал түлш /модны үртэс+шавар+нүүрсний үртэс/-ний утаан дахь ***нүүрстөрөгчийн дутуу ислийн*** агууламж стандарт хэмжээнээс ***10.8-11.8 дахин их***, ***азотын давхар исэл*** стандартаас бага, ***хүхрийн исэл*** ялгаруулдаггүй боловч хоцрогдсон технологитой, түүхий эдийн нөөц хязгаарлагдмал тул өргөн хэрэглээнд хэрэглэхэд төдийлөн үр ашиг багатай.

3. Хагас коксжсон түлшний утаан дахь ***нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж*** стандарт хэмжээнээс ***7.11 дахин их***, ***азотын давхар ислийн*** агууламж ***1.39 дахин их***, ***хүхрийн исэл ялгаруулдаггүй***. Хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэхэд чулуун нүүрс бус коксждог хүрэн нүүрс ашиглах нь үр ашгийн хувьд илүү өндөр байна.

4. Ёнтан шахмал түлшний утаан дахь ***нүүрстөрөгчийн дутуу ислийн*** агууламж стандарт

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хэмжээнээс ***4.55 дахин их, азотын давхар ислийн агууламж стандарт хэмжээнээс бага, хүхрийн исэл ялгаруулдаггүй*** нь цаашид ахуйн хэрэгцээнд илүү тохиромжтой бөгөөд түүний түүхий эдийг илүү сайн цэвэршүүлж хэрэглэх зайлшгүй шаардлага байна.

5. “Эко энержи” үйлдвэрийн коксжуулсан нүүрс, үртэс+коксжуулсан нүүрсний шахмал түлшнээс бусад бүх түлшний утаан дахь ***угаарын хий*** буюу ***нүүрстөрөгчийн дутуу ислийн*** агууламж нь Монгол Улсын стандарт хэмжээнээс 3.01-10,94 дахин их байгаа нь агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөхгүй төдийгүй эдгээр хий нь тоос, тоосонцорын (хөө тортог хэлбэрээр) (50%)-ийг бүрдүүлдэгээрээ хүний эд эрхтэнийг (уушиг, зүрх, мэдрэлийн систем) гэмтээдэг маш хортой бодис юм.

6. Нийтэд нь нэгтгэн харахад, **Ёнтан зуух, түлшний хосолсон үйлдвэр, “Эко энержи” үйлдвэрийн** хийж байгаа түлшнүүдийн утаа нь стандарт хэмжээнд байгаа нь агаарын бохирдолд нөлөөлөхгүй гэж үзэх үндэстэй бөгөөд цаашид хөрөнгө оруулалтын хэлбэрээр дэмжих боломжтой байна.

**ДӨРӨВ. Түлшний үйлдвэрүүдийн 2006-2009 онд авсан санхүүжилт болон гэрээний биелэлт ( 2009 оны 4 сарын байдлаар)**

| № | ААН | Төсөв /сая,төг/ | Авсан санхүүжилт /сая,төг/ | Санхүү-жилтийн Хувь | Гэрээгээр нийлүүлэх түлш /тонн/ | Биелэлт | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | “Говийн түлш” ХХК | 95,0 сая | 85,273 сая | 89,7% | 19100 | 2841 | 14.8% |
| 2. | “Бурханы гал” ХХК | 80,0 сая | 80,0сая | 100% | 18500 | 9175 | 49,59% |
| 3. | “Тану түлш” ХХК | 135,0 сая | 135,0 сая | 100% | 25500 | 3791 | 14,8% |
| 4. | “Нэбис” ХХК | 118,0 сая | 106,44 сая | 90,2% | 19500 | 3871 | 19,8% |
| 5. | “Хялганат” ХХК | 160,0 сая | 144,0 сая | 90% | 2500т | 2540т | 101,6% |
| 6. | “Өлзийт төв” ХХК | 240,0 сая | 232,8 сая | 97% | 7000т | 3500т | 50% |
| 7. | “Тара” ХХК | 149,98 сая | 142,48 сая | 94,9% | 1500т | 128т | 8,5% |
| 8. | “Хүслэн олз” ХХК | 163,8 сая | 155,61 сая | 95% | 1200т | 110т | 9,1% |
| 9. | Ара суха” ХХК | 95,0 сая | 83,373 сая | 87,7% | 8100т | 815т | 10,6% |
| 10. | “Төгрөг нуур энержи” ХХК | 186,0 сая | 186 ,0сая | 100% | 3000т | 10т | 0,33% |
| ДҮН | | 1422,78 сая | 1,350,976 сая | 94,9% | 105900т | 26781т | 25,2% |

**Тайлбар:** 2006-2009 онд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд 8,7 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 2009 оны 11 дүгээр сарын байдлаар **6,278 тэрбум** төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Утаагүй түлш, зуух үйлдвэрлэхээр дээрх нэр бүхий 10 аж ахуйн нэгж **1000 350 976 (**Нэг тэрбум гурван зуун тавин сая, есөн зуун далан зургаан мянга) төгрөг авсан нь нийт зарсан мөнгөний **21.5%** болж байна. ААН-үүд нь төлөвлөгдсөн санхүүжилтээ бараг бүхлээр нь буюу **94.9%** авсан хирнээ түлш үйлдвэрлэх гэрээний биелэлт **25.2%** -тай байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**ТАВ. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зориулагдаж 2007-2009 онд улсын төсөвт батлагдсан төсөвт өртгийн судалгаа**

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Төсөл, Арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Төсөвт өртөг | Санхүүжүүлэх хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Түлш эрчим хүчний яам | Нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн гаргах Нүүрсний ордуудын судалгаа явуулах, сонголт хийх, утаагүй түлшний үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах | 2007 он | 300,0 сая төгрөг | 300,0 сая төгрөг |
| 2 | Нийслэлийн Засаг дарга | Агаарын бохирдол, утаагүй болгох төсөл, тохижилт, Цэцэрлэгжилт /Улаанбаатар/ | 2007 он | 120,0 сая төгрөг | 120,0 сая төгрөг |
| 3 | Нийслэлийн Засаг дарга | Шахмал түлш болон шахмал түлшний зуухны үйлдвэрлэлийг дэмжих | 2007 он | 500,0 сая төгрөг | 500,0 сая төгрөг |
| 4 | Барилга хот байгуулалтын сайд | Нийслэлийн гэр хорооллыг орон сууцны хороолол болгон дахин төлөвлөлт хийх, инженерийн шугам сүлжээ байгуулах | 2007 он | 626,5 сая төгрөг | 626,5 сая төгрөг |
| 5 | Нийслэлийн Засаг дарга | Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх арга хэмжээ | 2007 он | 2000,0 сая төгрөг | 2000,0 сая төгрөг |
| 6 | Байгаль орчин,аялал жуулчлалын сайд | Агаарын бохирдлыг судлах лабароторын тоног төхөөрөмж | 2008 он | 1223.0 сая төгрөг | 1223.0 сая төгрөг |
| 7 | Эрдэс, баялаг эрчим хүчний сайд | Нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн гаргах нүүрсний ордуудын судалгаа явуулах, сонголт хийх | 2007-2008 он | 300.0 сая төгрөг | 183.0 сая төгрөг |
| 8 | Нийслэлийн Засаг дарга | Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх | 2008 он | 3000.0 сая төгрөг | 3000.0 сая төгрөг |
| 9 | Нийслэлийн засаг дарга | Агаарын бохирдол, утаагүй болох төсөл хэрэгжүүлэх /Улаанбаатар хот/ | 2007-2008 он | 120.0 сая төгрөг | 60.0 сая төгрөг |
| 10 | Эрдэс баялаг, эрчим хүчний сайд | “ДСП-2” ТӨХК-ийг түшиглэн “Дулааны аргаар боловсруулсан утаагүй шахмал түлш | 2009 он | 1800.0 сая төгрөг | 1800.0 Сая төгрөг |

Тайлбар: 3 жилд нийт дүнгээр 8.7 тэрбум төгрөг төсөвлөжээ. Биелэлт ямар байгааг судалгааны баг гаргахад мэдээлэл дутсан учраас УИХ-ын ажлын хэсэг яамд тус бүрээс үр дүнгийн талаархи мэдээллийг авч, харьцуулалт хийх боломжтой юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**ЗУРГАА. Улаанбаатар хотын агаарын төлөв байдал, бохирдлын талаар хийсэн судалгаанууд**

✓ **Д-р. Проф. Ц.Адъясүрэн, Д.Түвдэндорж** нарын хийсэн "Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах асуудалд" судалгаа нь агаарын бохирдлын шалтгааныг:

- Хүн амын хэт механик өсөлт
- Орчныг бохирдуулагч эх үүсвэрүүдийн олшролт
- Газарзүйн зохисгүй байршил
- Цаг агаарын өвөрмөц онцлог
- Хот төлөвлөлтийн буруу бодлого
- Дулаан эрчим хүчний техник, технологийн хоцрогдол
- Нийгэм эдийн засгийн хангалтгүй бодлого зохицуулалт гэж тодорхойлжээ.

Энэхүү судалгаагаар агаарын бохирдлын гол эх үүсвэрүүдийг:

- Улаанбаатар хотод байрлаж буй цахилгаан станцууд
- 450 гаруй жижиг уурын зуух
- 133500 гаруй гэрийн зуух
- 79500 гаруй автомашинаас гарах утаа
- Элэгдэл эвдрэлд орсон газраас босох тоос гэж үзжээ.

Судлаачид агаарын бохирдолттой тэмцэхэд нийгмийн олон талын төлөөллийн оролцоо чухлыг голлон, дэлхийн улс орнуудын эрх зүй болон практикт хэрэглэж буй сайн туршлагыг 5 чиглэлд хуваан үзэж, Монгол улсад хэрэгжүүлж болохуйц арга гэдгийг тодорхойлжээ. Үүнд:

- Эрх зүйн хүрээнд шинэчлэл хийх
- Эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх
- Технологийн шинэчлэл хийх
- Иргэдийн боловсрол, танин мэдэх үйл ажиллагаа дээшлүүлэх
- Мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх зэрэг болно.

Түүнчлэн цаашид агаарын бохирдлыг бууруулах, бүр мөсөн арилгахад төр, засгийн хүрээнд хийх ажлыг дараахь байдлаар байдлаар томьёолон зөвлөмж болгожээ.

- Агаарын бохирдлын талаар баримтлаж байгаа одоогийн хууль тогтоомжинд нэмэлт өөрчлөлт хийх;
- Агаар бохирдуулагчдаас төлбөр авч, төлбөрийг санд хуримтлуулан агаарын бохирдлыг бууруулахад зарцуулах эрх зүйн үндсийг бий болгох;
- Цэвэр нүүрсний технологи нэвтрүүлэх
- Агаар, орчны бохирдлын талаар ард иргэдэд ухуулан таниулах, мэдээлэл сурталчилгаа явуулах
- Иргэд, бизнесийн байгууллагатай хамтран ажиллах
- Гэрийн болон барилгын дулааны алдагдлыг багасгах арга хэмжээг нэн даруй авах
- Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- Гадны хөгжилтэй орнууд болон манайхтай ижил төстэй нөхцөлд байсан бусад орнуудын агаарын бохирдлоо бууруулсан шилдэг технологийг нэвтрүүлэх
- Нийслэл хотын болон гэр хорооллын төлөвлөлтийг газрын бодлоготой уялдуулан дахин хийж, шинээр байршуулах зэрэг болно.

✓ **Проф. С.Буднямын** "Тээврийн хэрэгслийн үүдэлтэй агаарын бохирдлын үнэлгээний математик аргачлал" судалгаа нь авто тээврийн тоо, замын сүлжээний төлөв байдал, хотын хүн амын эрүүл мэнд гэсэн үзүүлэлтүүдийн харилцан үйлчлэлийн математик

UIH.MN СУДАЛГААНЫ САН

загварыг томъёолон, замын фондын хөгжлийн эрчимжилт нь хорт хийн гаралтын эрчимжилтийг багасгаж, автомашины ашиглалтын элэгдлийг багасгана гэсэн дүгнэлт гаргажээ.

- ✓ **М.Золжаргал, Ц.Мөнхбат, Б.Батмөнх** "Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн байдал" судалгаа нь 2000-2006 онд агаарыг бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоон өсөлт, тэдгээрээс гарч байгаа бохирдуулагч бодисуудыг он бүрээр харьцуулан авч үзжээ. Агаарын бохирдлын нэг шалтгаан нь хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн гэж үзжээ. 2000-2005 онд хүн амын механик өсөлт 29.5%-иар, шилжиж ирсэн хүн амын тоо 32.8%-иар өсч, нийслэлийн хүн ам 2000 онтой харьцуулахад 213.6 мянгаар нэмэгдсэн гэсэн тооцоо гаргажээ.

Энэхүү судалгаагаар агаарын бохирдлын гол эх үүсвэрүүдийг:

- Улаанбаатар хотод байрлаж буй гурван том цахилгаан станц
- 410 гаруй жижиг уурын зуух
- 133780 гаруй гэрийн зуух
- 79500 гаруй автомашинаас ялгарах утаа
- Элэгдэл эвдрэлд орсон газраас босох тоос
- Бусад эх үүсвэр (төвийн инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй ТҮЦ, павилон, ШТС, дугуй засвар, нефтийн агуулах, хогийн цэг, арьс ширний үйлдвэр, зам барилга угсралтыг гүйцэтгэж байгаа түр байр, төмрийн үйлдвэр, мөн аж ахуйн нэгж байгууллагын нүүрсээр халааж буй харуулын байр) гэжээ.

Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотод 5.2 сая тн нүүрснээс 719 мянган тонн $SO_2$, 573 мянган тонн $NO_2$ , 1,7 сая тонн СО зэрэг бохирдуулагч бодис гарч агаарыг бохирдуулж байна гэсэн тооцоо гаргажээ. Мөн 2006 онд Улаанбаатар хотод 240.7 мянган тонн бензин, 187,3 мянган тонн дизелийн түлш орж ирсэн бөгөөд эдгээрийн шаталтаас 89.7 мянган тонн хорт бодис ялгарч байгааг ч тооцжээ.
Судлаачид нийслэлийн агаарын бохирдлын шалтаг, шалтааныг судалсаны эцэст доорхи дүгнэлтэд хүрсэн байна. Үүнд:

- Нийслэлийн хүн ам шууд механикаар өсч байна. Орон сууц, гэр хороололд оршин суугчдыг 2000 оны тоог 2006 онтой харьцуулахад өмнө нь орон сууцанд оршин суугчдын эзлэх хувь 58.5% байсан бол 2006 онд гэр хороололд оршин суугчид 59%-ийг, орон сууцанд оршин суугчид 41%-ийг эзлэх болжээ. Эндээс гэр хороололд нүүж суурьшигсдын тоо харьцангуй өссөнийг харж болно.

- Улаанбаатар хотын хөдөлгөөнд оролцож байгаа автомашины 50 шахам хувь нь 11 жилээс дээш хугацаанд ашиглагдаж байна. 2005 оны байдлаар нийт үзлэгт хамрагдсан автомашины 36.0% нь утаагаар үзлэгт тэнцээгүй гэсэн дүн гарчээ.

- Улаанбаатар хотын агаарын чанарыг 4 суурин харуул дээр байнгын ажиглалтаар хяналт явуулж, агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар ислийн хоногийн дундаж агууламжийг тодорхойлж байгаа хангалтгүй бөгөөд цаашид харуулын тоог нэмэгдүүлж хамгийн багадаа 9 суурин харуултай болгох шаардлагатай.

- Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, агаарын бохирдлын менежментийн тогтолцоо, мониторингийн сүлжээг сайжруулах нь тулгамдсан асуудал болж байна гэжээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- ✓ **Д-р, Проф. Д.Дорж, С.Даваасүрэн, Д-р, Дэд проф. Ц.Даржаа, А.Алтангэрэл** нарын хийсэн “Улаанбаатар хотын агаарын бохирдлын судалгааны зарим үр дүнгээс” судалгаа нь Улаанбаатар хотын замын төв хэсгийн агаарт агуулагдах бохирдуулагч үндсэн хийнүүд болон зарим хүнд металлын агуулгыг тодорхойлон, ДЭМБ-ын агаарын чанарын стандарттай харьцуулан гаргажээ. Агаарын дээжийг 2005 оны 10 дугаар сараас 2006 оны 4 дүгээр сар хүртэл сард 2-3 удаагийн давтамжтайгаар авч, бохирдуулагч хийнүүдийн агуулгыг судалснаар дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

    - Жил ирэх тутам агаарын бохирдлын хэмжээ нэмэгдсээр (2000-2005 онд азотын хийн агуулга 30%, хүхэрлэг хийн агуулга бараг 2 дахин нэмэгдсэн) өвлийн улиралд MNS-4585-98-ийн хэмжээнээс хамгийн их давсан үзүүлэлтэд хүрч байна.
    - Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн агаар дахь хүнд металлын агуулгыг өвөл, хавар, намрын улиралд судалсан дүнгээр 1, 2, 9, 11 сард эрс ихэссэн, ДЭМБ-ын агаарын чанарын стандарт үзүүлэлтээс цайр 1.8 дахин, никель 5 дахин, кадми 2.5 дахин, зэс 9 дахин, кобальт 8 дахин их байна.

- ✓ **Д-р. Проф. Н.Түгжсүрэн, Р.Оюун н**арын хийсэн “Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээрх температурын тонгоруу үе давхарга ба хүйтэн агаарын тунарлын хөдлөл зүй” судалгаа нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээрх бохирдол бүхий тунаран тогтох хүйтэн агаар өдрийн цагуудад хамгийн их талбайг хамран тархдаг болохыг тогтоож, доорхи дүгнэлтийг хийжээ. Үүнд:
    - Улаанбаатар хотын дүүргүүд дотроос Налайхын орчинд бохирдсон хүйтэн агаарын тунарал хамгийн их хувийг эзэлж байна. Налайх дүүргийн нутаг дэвсгэр харьцангуй өндөрт байрлах тул өвлийн хүйтэн хүнд агаар доош гулсан бууж массаараа баруун, баруун хойш түрэн шилждэг хандлагатай юм.
    - Баянзүрх дүүргийн Гацуурт, Амгалангаас Маахуур толгой хүртэлх харьцангуй өргөн зурвас газарт Гацууртын зүгээс зүүнээс баруунд чиглэсэн хүйтэн урсгал давамгайлж байна. Гэхдээ урсгалын хурд харьцангуй бага тул тогтворшин тунах магадлал ихтэй юм. Өвлийн улиралд Монгол орны нутаг дээр Азийн эсрэг циклон ноёлж салхины хурд бага байдаг онцлог энд байдаг.
    - Сүхбаатар дүүргийн Баянбүрдээс Долоон буудал, Дамбадаржаа хүртэлх хэсэг, Чингэлтэй дүүргийн өмнөд хэсэг, Баянгол дүүргийн нутаг бүхэлдээ өмнөөс, баруун ба зүүн өмнөөс хойш, хойноос урагш чиглэсэн агаарын урсгалын оглтлолцол дээр буюу хүйтэн агаарын тунарлын бүсэд оршиж байна. УБ хотын энэ хэсэгт тунаран тогтох хүйтэн агаар Хан-Уул дүүргийн баруун ба өмнөд хилээс дээшлэн үргэлжлэх хүйтэн агаартай залгагдан тохойрч улмаар Гацуурт, Налайхын хүйтэн агаартай нийлэх хандлага тод ажиглагдаж байна. Гэхдээ температурын хувьд Налайх, Сонгино орчмын агаар мэдэгдэхүйц хүйтэн байгаа тул хоёр талын хүйтэн агаарын түрлэг УБ хотын төв рүү нум үүсгэн шахаж түрэх хандлагатай байна.
    - Партизаны хөндийн хойноос урагш чиглэн үргэлжилсэн хүйтэн агаарын дунд хэсгээс Сонгинохайрхан уулын араар зүүн тийш чиглэсэн хүйтэн агаар Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн хил орчмын агаартай нийлэх дүр зураг ажиглагдаж байна.
    - Дэлхийн Хиймэл дагуулын мэдээг боловсруулан агаарын бохирдлыг шуурхай үнэлэх, хянах системийг бий болгон практикт нэвтрүүлэх нь манай орны хувьд олон талын ихээхэн үр ашигтай юм” зэрэг болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- ✓ **Судлаач Т.Булганы** хийсэн “Улаанбаатар хотын агаарын чанарын мониторинг, төлөв байдлын судалгаа нь 2000-2006 онд агаарын чанарыг хүхэрлэг хий болон азотын хий, агаар дахь PM 2.5 тоосонцрын агууламжийг судалж, “Жилээс жилд эдгээр бохирдуулах бодисын агууламж ихэсч, агаарын чанарын стандартаас давж бохирдох тохиолдлын тоо өсч байгаа нь хүн амын эрүүл мэнд, хот орчмын экосистемд үзүүлэх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлж байна” гэсэн дүгнэлт хийжээ.

- ✓ **С.Мангал, Ү.Төмөрхуяг** нар “Улаанбаатар хотын ДЦС-2 ТӨХК-ийг түшиглэн Утаагүй түлшний үйлдвэр байгуулах боломж” судалгааны хүрээндээ ахуйн хэрэглээний утаагүй түлш, цахилгаан болон дулааны эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр байгуулах талаар судалгаа хийж төсөл бичжээ. Тус үйлдвэр нь жилд 540 мянган тонн нүүрс боловсруулан 216 мянган тонн утаагүй түлш, 432 сая $м^3$ коксын хийгээр уурын зуухыг ажиллуулж, 125,28 сая квт/цаг цахилгаан эрчим хүч, 123 мянган г/кал дулааны эрчим хүч үйлдвэрлэнэ. Үйлдвэрийн 7.568 сая төгрөгийн өртөгтэй босч, хөрөнгө оруулалтаа 5.6 жилд нөхөн, 1 тонн коксын үнийг 30 000 төгрөг гэж тооцжээ. Утаагүй түлшний үйлдвэртэй хосолсон дулааны цахилгаан станц нь утаагүй түлш, цахилгаан болон дулааны эрчим хүч гэсэн олон бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр нэг бүтээгдэхүүний өртгийг хямд байлгах нөхцлийг бүрдүүлдэг. Технологийн давуу талууд нь:

  - Үйлдвэрийн талбай бага
  - Ус бага зарцуулдаг (хөргөлт, угаалгын ус нь битүү эргэлттэй)
  - Үйлдвэрлэлийн ажиллагаа механикжсан, удирдлага нь автоматчилагдсан
  - Бага хугацаанд горимонд ордог учир асаах болон зогсоход саадгүй
  - Ашигт үйлийн коэффициент өндөр (85-95%)
  - Байгаль орчинг бохирдуулахгүй (Хий, шингэн, хатуу хаягдалгүй)
  - Хамгийн бага зардлаар цахилгаан дулаан үйлдвэрлэнэ.

Судлаачид судалсны эцэст “Өвлийн улиралд нийслэлийн агаарын бохирдлыг эрс бууруулах цорын ганц гарц нь “Утаагүй түлшний үйлдвэр” байгуулж, гэр хорооллын хэрэглэгчдийг утаагүй түлшээр хангахдаа хамгийн бага хөрөнгө оруулалтаар агаарын бохирдлыг шийдэж, нүүрсийг ашиглах тэргүүний технологийг Монголд улсад нэвтрүүлэх боломжтой” гэсэн дүгнэлтийг хийжээ.

- ✓ **Б.Наранбаатар, О.Гэрэлсүх** нар “Улаанбаатар хотыг экологийн тогтоцын дагуу бүсчлэн хөгжүүлэх нь” судалгаагаараа бохирдол нь байгаль орчинд илүү ихээр нөлөөлөхдөө агаарт, гадаргын усанд, хөрсөнд нөлөөлдөг гэж үзсэн байна. Эдгээрээс хамгийн өргөн цар хүрээг хамарч, хортой нөлөө үзүүлдэг нь агаарын бохирдол бөгөөд бусад бохирдлын эх үүсвэр нь болдог сөрөг чанартай ажээ. Агаарын бохирдол нь хүйтний улирал буюу 9-5 дугаар сарын хооронд идэвхиждэг нь дулаан үйлдвэрлэлтэй холбоотой юм. Судлаачид дулаан үйлдвэрлэгч 3 эх үүсвэрийн бохирдолд эзлэх хувь хэмжээг дараахи байлдаар тогтоожээ.

UB.MN СУДАЛГААНЫ САН

| Эх үүсвэр | Дулаан | Бохирдол |
|---|---|---|
| Дулааны цахилгаан станц | 80% | 10% |
| Жижиг дунд уурын зуух | 10% | |
| Гэр хороолол | 10% | 80% |

Судлаачид бохирдолд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг гадаад, (байгаль, газарзүйн орчин) дотоод (дулаан алдалт, түлш, зуух) гэж ангилан үзсэн бөгөөд “Гэрийн зуух болон түлш тэдгээрийн уялдаагүй байдал”, “Монгол гэр болон сууцны жижиг байшингийн дулааны алдагдал”, “Экологийн тогтоцод нийцээгүй хот байгуулалт” нь агаарын бохирдолд ихээхэн

хэмжээгээр нөлөөлж байна гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Түүнчлэн агаарын бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд дараахи арга замыг цогц байдлаар шийдэх нь илүү үр дүнтэй гэж үзэн доорхи зөвлөмжийг санал болгожээ. Үүнд:

- Зуухны бүрэн шатах процесс болон түлшний утаагүй байдлыг хамтад нь авч үзэх;
- Шөнийн цахилгаан ашиглах замаар дулаан үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, халдаг туурга, шал, цахилгаан тенн зэргийг хэрэглээнд нэвтрүүлэх мөн шингэн болон хийн түлш ашиглахыг дэмжих;
- Дулаан алдагдал багатай сонгодог гэр үйлдвэрлэх;
- Гэр хороололыг нүүлгэн шилжүүлж экологийн зөв байршилд оруулах (Гэр хорооллыг өөрсдийг нь барилгажуулах зорилгоор нүүлгэн шилжүүлэх, Шинэ гэр хороолол бий болгох зорилгоор шилжүүлэх) зэрэг болно.

✓ Дэлхийн банк, Азийн тогтвортой эрчим хүчний хөтөлбөр хамтран "Улаанбаатар хотын захын ядуу гэр хорооллуудын халаалт, зуухны судалгаа"-гаар Улаанбаатар хотын гэр хороолold 2007 оны 12 дугаар сард гэр хорооллын оршин суугчдаас хотын агаарын бохирдлын талаар санал асуулга авч, боловсруулалт хийжээ. Энэхүү судалгаа нилээд цогц, үндэслэл, дүгнэлт, зөвлөмж сайтай болжээ. Судалгааны зорилго нь гэр хорооллын айл өрхийн халаалтын түлшний хэрэглээ болон амьжиргааны зардлын талаар суурь мэдээлэл цуглуулж дүгнэлт гаргах, айл өрхийн хэрэглэж байгаа зуухны тоо хэмжээ, төрлийн талаар суурь мэдээлэл олж авах, зуухны талаарх санал бодол, сонголтыг судлах, хэрэглэж байгаа болон өөр төрлийн түлшний талаарх санал бодол, сонголтыг тандах, агаарын бохирдлын шалтгааны талаархи ойлголт санал бодлыг гаргаж ирэх, айл өрхүүд агаарын бохирдлын асуудлыг шийдэхэд хэр бэлэн байгаа талаар дүн шинжилгээ хийхэд чиглэгджээ. Судалгаагаар:

1. Агаарын бохирдлын шалтгааныг судалгаанд хамрагдагсдын 86% нь гэр хорооллын халаалтын зууханд шатааж буй түүхий нүүрс, 71% нь тээврийн хэрэгсэл, 66% нь цахилгаан станц, 61% нь хог хаягдал , 56 нь аж үйлдвэр , 42% нь тоос, 12% нь дэлхийн дулаарал гэж үзсэн байна.
2. Бохирдлыг бууруулах арга замыг судалгаанд хамрагсдын 96% нь гэр хороололд оршин суугчдыг байранд оруулах, 84% нүүрсний хэрэглээг багасгах, 71% нь халаалтанд цахилгаан хэрэглэх, 64% нь сайжруулсан зуух хэрэглэх, 58% нь автомашины тоо багасгах, 59% нь шахмал түлш хэрэглэх гэжээ.
3. Сууцны төрлийн хувьд тусдаа байшин 55820 ширхэг буюу 55,3%, гэр 43607 ширхэг буюу 43,2%, гэр ба тусдаа байшин 707 ширхэг буюу 0,7%, бусад 808 ширхэг буюу 0,8% гэсэн дүн мэдээ гарчээ.
4. Халаалтын зуухны төрлийн хувьд 43% нь гэрийн зуух, 39% нь ханан пийшинтэй байшин, 8% нь ханан пийшингүй байшин, 9% нь нийтийн халаалтанд холбогдсон, 0.8% нь бусад төрлийн зуух байна.
5. Түлшний төрлийн хувьд түүхий нүүрс, мод, нүүрсэн шахмал түлш, үртсэн шахмал түлш, солонгос шахмал түлш, хийн түлш, цахилгаан хэрэгсэл хэрэглэдэг бөгөөд эдгээрээс түүхий нүүрсний хэрэглээ их байгаа нь үнэ өртөг хямд байгаатай холбоотой гэж үзжээ. Түүнчлэн агаарын бохирдлыг бууруулахад чанартай зуух, цэвэр түлшний хосолмол байдлыг хэрэглэх нь чухлыг тэмдэглээд, хугацааны хувьд урт ба богино гэсэн хэлбэрээр шийдэх талаар зөвлөмж, дүгнэлт гаргажээ.

✓ **Нийслэлийн агаарын чанарын алба** "Улаанбаатар хотын агаарын чанарын төлөв байдал, агаарын бохирдлыг бууруулах талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайланд 2006-

UIH.MN СУДАЛГААНЫ САН

2009 онд хэрэгжүүлсэн төслүүдийн зардлын задаргаа, Улаанбаатар хотын агаарын чанарыг дүүрэг тус бүрт байрлуулсан суурин автомат 6 харуулын станцаас авсан хэмжилтийн дүн, автотээврийн яндангаас гарах утааны хэмжилтийн дүн, үртсэн болон нүүрсэн шахмал түлш, хагас коксжуулсан түлшний үйлдвэрүүдийн нэгдсэн танилцуулга, нам даралтын халаалтын зуухны талаар, “Утаагүй хороо” аяны тухай, Нийслэлийн Аудитийн газрын тайлан зэргийг багтаажээ.

- ✓ **2008 онд Дэлхийн банкнаас** эхлүүлсэн “Агаарын бохирдлын түвшин ба чанар эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тогтоох судалгаа” төсөл нь “Улаанбаатар хотын цэвэр агаар” хөтөлбөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулахад чиглэгдэж байна. Энэхүү төслийн хүрээнд “Улаанбаатар хотын агаарын бохирдол” судалгаа хийжээ. Түүнд 2008 оны 6 дугаар сараас 2009 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд хийсэн үйл ажиллагаа болон агаарын бохирдлын өнөөгийн байдалд хийсэн үнэлгээний үр дүнг багтаасан бөгөөд үнэлгээний ажлын явцад олж илрүүлсэн асуудлууд нь цаашид агаарын бохирдлыг бууруулах оновчтой арга хэмжээг сонгон авч хэрэгжүүлэхгүй бол өнөөгийн нөхцөл байдал нь илүү хүнд шатандаа байна гэдгийг танилцуулжээ. Судалгаагаар хотын агаарыг хамгийн ихээр бохирдуулагч нь 2.5-10 микроны хэмжээтэй тоос, тоосонцор (PM 2,5-10) гэж үзжээ. PM-ийн агууламжаар Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн их бохирдолтой хотын тоонд багтсан байна. Гол эх үүсвэрийн 50% нь гэр хорооллын түлш, түүхий нүүрсний утаан дахь угаарын хий, 50% нь гудамж замын гадаргуугаас ялгарч байгаа том ширхэгт тоос ажээ.

## ДОЛОО. Улаанбаатар хотын агаарын бохирдол ба хүн амын эрүүл мэнд

### *7.1. Агаарын бохирдол түүнээс үүдэлтэй орчны бохирдол хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх байдлын ерөнхий ойлголт, нийслэлийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлж буй байдал*

Агаарын бохирдлыг “Байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр эрүүл мэнд болон эдийн засагт хохирол үзүүлдэг атмосферийн агаарт ялгарч буй хатуу, шингэн хийн хольц юм”[116] гэж тодорхойлсон байдаг. Аж үйлдвэр хөгжихийн хэрээр агаарын бохирдол улам бүр нэмэгддэг. Иймээс ч аж үйлдвэржсэн өндөр хөгжилтэй орнуудад агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг авч байгаа ч түүнээс шалтгаалах сөрөг үр дагавар байсаар байна. (ДЭМБ 2000).

Дэлхий нийтийн болон бүс нутгийн хэмжээнд хүний эрүүл мэндэд нөлөөлж буй 10 эрсдэлт хүчин зүйлийн нэгэнд агаарын бохирдол ордог. ДЭМБ-ын мэдээлж байгаагаар өнөөдөр 1.5 тэрбум хүн эрүүл мэндэд муугаар нөлөөлөх бодисын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн агаараар амьсгалж, амьдарч байгааг тогтоожээ. Дэлхийд жилд 55 сая хүн нас барж байгаагийн 5% буюу 3 сая орчим нь агаарын бохирдлын улмаас болдог бөгөөд үүнд ойролцоогоор 1.4-6 сая америк доллар зарцуулдаг ажээ[117]. Бага насны хүүхдийн нас баралтын хамгийн түгээмэл тохиолдол нь амьсгалын дээд замын цочмог халдвар бөгөөд жил бүр амьсгалын замын өвчний улмаас эндэж буй таваас доош насны 5

[116] Koren H, 2005, Illustrated dictionary and research directory of Environmental and Occupational health, Second edition, pp 21-
34, CRC Press LLC, Boca Raton, Florida

[117] WHO, World Health Organization Fact Sheets. 2000. *Air pollution*. (online) http://www.who.int/inf-fs/en/fact187.html (18 March 2005 )



UIH.MN СУДАЛГААНЫ САН

сая хүүхдийн 3 сая (75.0%) нь уушигны үрэвслийн улмаас нас барж байна[118].

Олон улсад хийсэн судалгаагаар хүрээлэн буй орчны бохирдол нь хүн амын өвчлөлийг нэмэгдүүлэх, хүүхдийн бие махбодын өсөлт, хөгжилд сөргөөр нөлөөлж, дархлалын түвшинг бууруулдаг болохыг тогтоосон бөгөөд энэ нь дараахи өвчлөлийг бий болгодог байна. Үүнд:

**1. Өвчлөлийг нэмэгдүүлэх**

- Амьсгалын эрхтний эмгэг
- Цочмог ларингит, трахеит
- Архаг бронхит, тонзиллит, аденойдит, уушги, гуурсан хоолойн бөглөрөлтөт хэлбэрийн архаг үрэвсэл
- Харшлын эмгэг (багтраа, харшлын гаралтай ринит, арьсны эмгэг)
- Зүрх судасны өвчин (Зүрх судасны өвчний тархалт өндөр байх, зүрхний үйл ажиллагааны хямрал, дутагдал, төрөлхийн гажиг, зүрхний ишеми)
- Нүд, хамар, чихний үрэвсэл
- Удамшлын эмгэг, төрөлхийн гаж хөгжил
- Хавдар
- Нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө (үр хөврөл гэмтэх, дутуу төрөх)

**2. Бие махбодын өсөлт, хөгжилтөд сөрөг нөлөөлөх**

- Өндөр, жин, цээжний тойргийн хэвийн харьцаа алдагдах
- Таргалах
- Галбир өөрчлөгдөх зэргээр илэрнэ.

**3. Бие махбодын физиологийн хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөх**

- Уушгины үйл ажиллагаа
- Оюуны ажиллах чадвар
- Мэдрэхүй, хөдөлгөөний хурд
- Цусны даралт, судасны цохилтын тоо

**4. Дархлалын түвшинг бууруулах**

- Хэсэг газрын дархлааг бууруулах
- Биеийн ерөнхий эсэргүүцлийг сулруулах

Агаар бохирдуулагч бодис бүр хүний эрүүл мэндэд нөлөөлж, амьдралын чанарыг бууруулж, хүний дундаж наслалтад нөлөөлж байгааг тогтоосон байна. Агаарын бохирдлын улмаас үүсч буй эрүүл мэндийн зардлыг дэлхийн хэмжээнд авч үзвэл жилд 1 тэрбум ам.долларт хүрч, хөгжингүй улс орнуудад дотоодын нийт бүтээгдхүүний 2%, хөгжиж буй улсуудад ДНБ-ний 5-20%-ийг эзэлж байна гэсэн тооцоо гарсан байна.

**АГААРЫН БОХИРДЛЫН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ**

| Агаарын түгээмэл бохирдуулагчид | Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл | Гадаад орчны агаарт хяналт хийдэг байдал |
|---|---|---|

[118] Stansfield, S. Shepard, D. 1993. ACUTE RESPIRATORY INFECTION, Jameson D, Mosley W, Measham A, Bobadilla J, (eds.) *Disease control priorities in developing countries*, pp 67-90, Oxford



UILMN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| **Хүхэрлэг хий ($SO_2$)** | - Амьсгалын замын хамгаалах тогтолцоог алдагдуулна.<br>- Ханиалгах, нүд хорсгох, цээж хөндүүрлэх шинж тэмдэг илэрнэ.<br>- Багтраа өвчин<br>- Уушгины архаг өвчлөл үүсгэнэ. | **Байнга хяналт хийдэг** |
| **Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)** | - Зүрхний шигдээс болон бусад зүрхний өвчлөл<br>- Багтраа өвчин үүсэхэд нөлөөлнө<br>- Хүчилтөрөгчийн солилцоог алдагдуулан эд эрхтэнд гэмтэл учруулна<br>- Дутуу төрөлтийг нэмэгдүүлнэ.<br>- Ажлын чадвар бууруулна. | **Хяналт хийдэггүй** |
| **Азотын давхар исэл ($NO_2$)** | - Нүд, уушги, арьс, салст бүрхэвч, амьсгалын замын эд, эрхтнүүдийг гэмтээнэ.<br>- Гуурсан хоолойн багтраа,<br>- Уушгины хатгалгаа,<br>- Томуу, томуу төст өвчин,<br>- Зүрх судасны өвчлөл үүсэхэд шууднөлөөлнө.<br>- Амьсгалын замын архаг өвчлөлийг нэмэгдүүлнэ. | **Байнга хяналт хийдэг** |
| **Озон ($O_3$)** | − Амьсгалын замын болон зүрх судасны өвчлөл, нас баралт нэмэгдэнэ.<br>− Уушгины үйл ажиллагаа буурна. | **Хяналт хийдэггүй** |
| **Тоос (Нийт жигнэгдэгч бодис)** | − Уушги тоосжих өвчлөл үүсгэнэ. | **Тогтмол бус хяналт хийдэг** |
| **Том ширхэглэгт тоосонцор (PM10)**<br>**Нарийн ширхэглэгт тоосонцор (PM 2.5)** | - Амьсгалын замын эмгэг<br>- Арьс, элэг, уушгины зэрэг хавдар<br>- Зүрх судасны эмгэг<br>- Төрөл бүрийн удамшлын эмгэг үүсгэхэд нөлөөлдөг. | **Хяналт хийдэг** |
| **Хар тугалга (Pb)** | − Төв мэдрэлийн тогтолцооны эмгэг<br>− Цус багадалт<br>− Жирэмсэн эх, хүүхдэд сөргөөр нөлөөлж хүний биеийн ясанд удаан хугацаагаар хуримтлагдана.<br>- Хоолны дуршил буурна.<br>- Бөөрний хавдар үүсгэнэ.<br>- Дутуу төрөлт үүсгэх магадлалтай. | **Хяналт хийдэггүй** |
| **Бенз-а-пирен ($C_{20}H_{12}$)** | - Уушиг болон хоол боловсруулах замын хавдар | **Хяналт хийдэггүй** |

2005 онд Улаанбаатар хотод хийсэн гадаад орчны хар тугалгын бохирдлын судалгаагаар:

- Цусанд 0.064±0.013мг/л, хөрсөнд 41.7±3.29мг/кг, агаарт 0.0014±0.0001мг/м$^3$ байна.
- Стандарт хэмжээтэй харьцуулахад хөрсөнд 2.1, агаарт 1.4 дахин их, нийт хөрсний дээжний 90%-д нь 20мг/кг-аас дээш хэмжээгээр хар тугалга агуулагдаж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Судалгаанд хамрагдсан хүүхдийн цусан дах хар тугалгын агууламж стандарт (>=10 μg/dl) хэмжээнээс их байна.
- Агаар дахь хар тугалгын агууламж хүүхдийн цусны хар тугалгын агууламжид хүчтэй нөлөө үзүүлж байна.

Агаарын бохирдол нь хүний эрүүл мэндэд ерөнхийдөө 3 төрлийн сөрөг нөлөө үзүүлдэг ажээ.

1. *Хурц хордлогын хэлбэр.* Их хэмжээний хордуулах бодисын үйлчлэлийн нөлөөгөөр хурц хордлогонд орж, хордлогын шинж хурцаар илэрнэ.
2. *Архаг хордлого.* Удаан хугацаанд, түр завсарлагатайгаар хортой бодисуудад хордох, шинж тэмдэг аажим илэрдэг боловч уушиг, амьсгалын замын хүнд өвчний шалтгаан болдог.
3. *Хорт бодисуудын дам нөлөө*:
   А. Гонадотроп нөлөө буюу эрэгтэй, эмэгтэй хүний үржлийн эсийн түвшинд сөрөг нөлөөлж, нөхөн үржихүйн тогтолцоонд эмгэг өвчин үүсгэдэг. Энэ тухай баримтыг дор дурдсан болно.
   Б. Эмбриотроп нөлөө буюу урагийн хөгжилд гаж нөлөө үзүүлдэг.
   В. Мутаген нөлөө буюу хүний ДНК-д гаж нөлөө үзүүлж удамшлын эмгэг бий болгодог.
   Г. Онкоген нөлөө буюу хортой ба хоргүй хавдар бий болох нөхцөлийг бүрдүүлдэг.

Судлаачдын тогтоосноор агаарын бохирдол бага насны хүүхдүүд, өндөр настан хүмүүст илүү хор нөлөөтэй байна. Тухайлбал, 3-6 насны хүүхдүүдэд хамгийн их буюу 2.3 дахин, 60-аас дээш насныханд 1.6 дахин их сөргөөр нөлөөлж өвчлүүлдэг бол 20-39 насныханд хамгийн бага нөлөө үзүүлдэг ажээ[119]. Улаанбаатар хотын агаарыг бохирдуулах нийтлэг бохирдуулагч ($SO_2$, CO, $NO_2$)-аас гадна хар тугалга, бенз-а-пирен, диоксин гэх мэт өвөрмөц бохирдуулагчид хүн амын эрүүл мэндэд ноцтой нөлөөлөл үзүүлж байгаагаар судлаачид тогтоожээ. Улаанбаатар хотын агаарт хар тугалга 0.0014±0.0001 $мг/м^3$ хэмжээтэй байгаа нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс 4.6 дахин их гэсэн үзүүлэлт бөгөөд 7-14 насны 120 хүүхдийн цусанд хар тугалга тодорхойлоход эрэгтэй хүүхдэд 15.7±1.13 mg/dl, эмэгтэй хүүхдэд 17.4±1.82 mg/dl илэрчээ. Уг нь хүүхдийн цусан дахь норм нь 10 mg/dl-ээс ихгүй байх ёстой бөгөөд илүүдсэн тохиолдолд уур уцаартай болох, ой тогтоолт болон хичээлдээ муудах шинж тэмдэг илэрдэг ажээ. Хүүхдийн цусан дахь хар тугалгын агууламжинд хөрсний хар тугалга 17.4%-иар, агаарын хар тугалга 34.2%-иар тус тус нөлөөлж байгааг судлаачид тогтоожээ[120].

**Сүүлийн 5 жилд Улаанбаатар хотод 0-14 насны хүүхдийн дунд амьсгалын замын өвчний тархалтыг тогтоосон байдал (10000 хүүхэд)**

| № | Өвчлөлийн нэршил | 5 жилийн өвчлөл 10000 хүүхдэд |
|---|---|---|
| 1. | Амьсгалын замын нийт өвчлөл | 1384.7 |
| 2. | Төвөнх, хоолойн үрэвсэл | 112.4 |
| 3. | Гуурсан хоолойн үрэвсэл | 183.12 |
| 4. | Уушигны үрэвсэл | 304.7 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[119] Факторы, влияющие на здоровье и продолжительность жизни человека, www.austel.ru
[120] О.Байгаль, Б.Бурмаа нар, УБ., 2005

Амьсгалын замын өвчлөлд нүүрс төрөгчийн дутуу исэл (r=0.54, P=0.011), хүхэрлэг ангидрид (r=0.44, P=0.019), азотын исэл (r=0.34, P=0.013) тус тус дунд зэргийн шууд хамааралтай байна. Улаанбаатарт амьдарч байгаа хүүхдүүдийн гуурсан хоолойн өвчин аймгийн төвийн хүүхдүүдийнхээс 5.09-14.9 дахин илүү өвчлөлтэй байгааг тогтоосон байна. Зөвхөн Улаанбаатар хотод 2005 онд дүүргийн болон улсын клиникийн эмнэлгүүдэд 34600 хүн уушигны өвчнийг оношлуулах, эмчлүүлэхэд 2.4 тэр бум төгрөг зарцуулжээ.[121]

Сүүлийн 5 жилийн Улаанбаатар хотын тэргүүлэх 5 өвчлөлийн шалтгааныг авч үзвэл амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин, осол гэмтлийн шалтгаант өвчин тэргүүлж байна. 2008 онд 10000 хүн амд ногдох амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин 865.0, осол гэмтлийн шалтгаант өвчин 791.0, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин 824.1 байсныг 2004 онтой харьцуулахад 10-30 хувиар нэмэгджээ. Тухайлбал: 2004 онд 10000 хүн амд ногдох амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин 638.2 байсан бол 2008 онд энэ үзүүлэлт 865.0 болж 26.2 хувиар нэмэгдсэн байна. Мөн 2004 онд цусны эргэлтийн тогтолцооны өвчин 10000 хүн амд 435.9 байсан бол 2008 онд 640.8 болж, 31.9 хувиар өсчээ.




*Эх сурвалж: ЗГХА -ЭМГ, статистикийн алба, 2004 -2008 он*

**Тайлбар:** Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амдУлаанбаатар хот, 2004-2008 он. Эндээс харахад, нийслэл хотын хүн амын тэргүүлэх 5 өвчин сүүлийн жилүүдэд нэмэгдсэн хандлага ажиглагдаж байна.

Улаанбаатар хотын хүн амын амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл сүүлийн 5 жилд тогтвортой нэмэгджээ. 2004 онд нийт хүн амын 58432 нь амьсгалын эрхтэн тогтолцооны өвчний улмаас эмнэлэгт хандаж байсан бол 2008 онд 33902-оор өсч 92334 болжээ. Сүхбаатар, Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан харьцуулахад Баянзүрх дүүрэгт утааны тархалт нилээд ихэссэнээс зарим хороодод амьсгалын замын өвчний тархалт илт нэмэгдсэн байна.

**Дээрхээс дүгнэхэд:**

- Агаарын бохирдол нийслэлд амьдарч байгаа хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж, улмаар хүн амын эмзэг бүлэг болох бага насны хүүхэд,

[121] Н. Сайжаа. "Улаанбаатар хотын агаарын бохирдол хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөлөл, бохирдлоос сэргийлэх арга зам, зөвлөмж". УБ., 2010

өндөр настангууд илүү өртөж байгаагаас гадна бохирдсон агаартай орчинд олон жил амьдарсан хүн амын эрүүл мэнд, удмын санд алсын уршиг, эрсдэл үзүүлэх магадлал өндөр байна. Түүнчлэн эхийн хэвлийд бойжиж байгаа ургийн хөгжил, эрчүүдийн эр бэлгийн эсийн тоо цөөрөхөд хүртэл нөлөөлдгийг Барууны болон ОХУ, Азийн зарим улс орнуудад судалгаагаар тогтоожээ. Улаанбаатар хотод ч мөн энэ эрсдэл гарч болзошгүй тул эрчүүдийн үргүйдлийн шалтгааныг тогтоох судалгаа хийх шаардлагатай юм.

- Агаарын бохирдлын улмаас Улаанбаатар хотын хүүхдүүдэд зүрх судасны системийн функциональ үйл ажиллагааны өөрчлөлтүүд илэрч байна. Хүүхдүүдэд амьсгал, зүрх судасны үйл ажиллагааны сорил хийхэд уушгины амьдралын багтаамж багасах, артерийн бага даралтын хувьд хэвийн бус хариу урвал үзүүлэх, судасны цохилтын тоо цөөрч байгаа нь тогтоогджээ. Мөн Улаанбаатар хотын хүүхдүүдэд хийсэн зүрхний цахилгаан бичлэгийн дүнгээр эрүүл хүүхдүүдэд зүрхний булчингийн агшилт, цахилгаан дамжуулах чанар өөрчлөгдөж, зүрхний цохилт олшрох, цөөрөх зэрэг үйл ажиллагааны өөрчлөлтүүд илэрсэн бөгөөд үүнд эцэг эхийн боловсрол, өрхийн орлого, халдварт өвчнөөр өвчилсөн байдлаас гадна агаарын бохирдол нөлөөлж байгааг илрүүлжээ.
- Монгол улсын хэмжээнд нялхсын эндэгдлийн шалтгаанд төрөлхийн хөгжлийн гажиг (цаашид төрөлхийн гаж хөгжил гэх) -ийн эзлэх хувь жилээс жилд өсөх хандлагатай байна. Тухайлбал, 1997 онд эзлэх хувь 2.3%, 2002 онд 7.1 % байсан бол 2007 онд 12.4% болж өсчээ. Улаанбаатар хотод 1990-2004 онд ТГХ-тэй 341 хүүхэд төрж, 1000 амьд төрөлтөд 1.48 гаж хөгжилтэй нярай байсан бол 2004 онд 2.15 болж, 2005-2008 онд Улаанбаатар хотын хэмжээнд 88 399 эх төрснөөс 336 тохиолдол төрөлхийн хөгжлийн гажигтай байв. Нийслэлийн хэмжээнд нярайн дунд тохиолдох төрөлхийн гаж хөгжлийн тархалт 2005-2008 оны байдлаар 1000 амьд төрөлтөнд 3,78 болж өссөн байна[122]. Төрөлхийн гаж хөгжлийн хувьд зүрх судас, хоол боловсруулах, төв мэдрэлийн тогтолцооны төрөлхийн гажиг хөгжил илүүтэй тохиолдож байна. Цаашид хүүхдийг бие бүтцийн төдийгүй нийгмийн хувьд тахир дутуу болгодог ТГХ-ийн шалтгаанзүйн талаар хийх судалгаа, шинжилгээний ажлыг гүнзгийрүүлэх, шалтгааныг тогтоох лабораторийн чадавхийг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.
- Улаанбаатар хотын агаарыг бохирдуулах нийтлэг бохирдуулагч ($SO_2$, CO, $NO_2$)-аас гадна өвөрмөц бодисоор, тухайлбал хар тугалга, бенз-а-пирен, диоксин гэх мэт өвөрмөц бохирдуулагчид хүн амын эрүүл мэндэд ноцтой нөлөөлөл үзүүлдэг ч эдгээрийн хэмжээг тогтоох лаборатори манай улсад байхгүй байна.
- Хүн амьдралынхаа 90 орчим хувийг дотоод орчин буюу ажлын байр, гэрийн нөхцөлд өнгөрүүлдэг тул судлаачид дотоод орчны агаарын чанарт анхаарлаа илүү хандуулах болжээ. Манай оронд дотоод орчны агаарын бохирдлын түвшинг судлах, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тогтоох судалгаагаар гэр хорооллын айл өрхүүдийн дотоод орчны агаарын бохирдол хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгааг тогтоосон бөгөөд дотоод орчны агаарын чанарыг сайжруулах зайлшгүй шаардлагатайг зөвлөмж болгосон байна. Түүхий нүүрс болон Япон улсад боловсруулсан брикет туршсан өрхүүдийн гэрийн дотоод орчны агаарын чанар шахмал түлш, цахилгаан халаагуур болон сайжруулсан зуухтай өрхүүдээс харьцангуй муу байсан байна. Түлшний төрлүүд гадаад орчин төдийгүй гэрийн дотоод орчинд шууд нөлөөтэй болох нь батлагджээ.

[122] Н. Сайжаа. “Улаанбаатар хотын агаарын бохирдол хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөлөл, бохирдлоос сэргийлэх арга зам, зөвлөмж”. УБ., 2010

**7.2. Агаарын бохирдлыг хүний эрүүл мэндтэй холбон судалсан судалгаануудад хийсэн дүн шинжилгээ**

Эрүүл мэндийн яам 1990-ээд оноос агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тогтоох чиглэлээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) болон өөрийн орны эрдэм шинжилгээний байгууллагуудаар хэд хэдэн төсөлт ажлыг захиалан хэрэгжүүлсэн байна. Эдгээр судалгааны хүрээнд агаарын бохирдол (агаарын тоос, хүхэрлэг хий, азотын давхар исэл, хар тугалга, цаг уур)-ыг үүсгэгч эх үүсвэрүүд хүн ам, хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлж буй байдлыг судлан зохих дүгнэлт хийж, агаарын бохирдлыг бууруулах талаархи арга хэмжээний зөвлөмж боловсруулжээ.

- ✓ **Судлаач Б.Бурмаа (1998, 2001), Н.Сайжаа (1992, 2004)** нар хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжлийн үзүүлэлтүүд, дархлаанд нөлөөлөх байдлыг судалж үзэхэд 1998-2000 онд судалгаанд хамрагдсан нийслэлийн хүүхдүүдэд өсөлт, хөгжлийн хэвийн харьцаа алдагдаж, өндөр, жин нь нэмэгдэж, цээжний тойргийн хэмжээ багассан нь тогтоогджээ. Улаанбаатар хотын агаар дахь тоос, хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж нь хүүхдийн амьсгалын эрхтний өвчлөл, тухайлбал хүүхдийн гуурсан хоолойн цочмог болон архаг үрэвсэл, уушигны үрэвслийн нэг шалтгаан болж буйг судлан тогтоожээ.

- ✓ **Судлаач Ш.Энхцэцэг** Улаанбаатар хотын агаарын бохирдлын байдалд эрүүл ахуйн үнэлгээ өгч, хүүхдийн дархлааны зарим үзүүлэлт, хэвийн бичил биетийн байдалд хэрхэн нөлөөлж байгааг 2000 онд судлан тогтоожээ. Улаанбаатар хотын хүүхдүүдийн арьс, хамар, залгиурын салстаас илэрсэн бичил биетийн тоо, төрөл, эмгэг төрүүлэх шинж нь бохирдол багатай орчинд (Түнхэл) амьдардаг хүүхдүүдээс илүү байсан байна.(p 0.001/) Стафилококк нянгийн маннит задлах, сийвэн бүлэгнүүлэх, цус задлах, летитиназ, дезосирибонуклеаз, фибрионолизиний идэвхи зэрэг эмгэг төрүүлэх шинжүүдийг нарийвчлан судлахад Улаанбаатар хотын хүүхдүүдийн арьс, салстаас илэрсэн стафилококкийн омгийн эмгэг төрүүлэх чадвар статистик магадлал бүхий өндөр байв. Агаарын бохирдлоор ялгаатай орчинд амьдарч буй хүүхдүүдийн цусан дахь иммуноглоблин A,M,G-ийн түвшинг судалж үзэхэд бохирдол ихтэй орчны хүүхдүүд IgA түвшин статистик магадлал бүхий бага (p 0.05), IgM, IgG буурах хандлагатай байгааг судлаач тогтоожээ. Амьсгалын замын өвчлөлийн 24.9% нь хамгийн их болон бага температурын улмаас намрын улиралд үүсч байсан бол өвлийн улиралд энэ өвчлөлийн 13.3% нь салхины хурд, азотын давхар исэл болон харьцангуй чийгийн улмаас үүссэн байна. Тэгвэл зүрх судасны өвчлөлийн хувьд намар 8.7%, өвөл 8.3% нь хамгийн их, бага температурын улмаас үүсчээ.

- ✓ **Судлаач А.Энхжаргал** (2006) судалгаандаа агаарын бохирдлын хэмжээ болон цаг уурын хүчин зүйлсийн харилцан хамаарал хүн амын өвчлөлд хүчтэй нөлөөлж байна. Тухайлбал, харьцангуй чийг болон зүрх судасны тогтолцооны өвчлөл (-0.105, p-0.045) шууд дунд зэргийн хамааралтай байна. Судлаачдын хийсэн дүгнэлтээр агаарын бохирдол, зөвхөн амьсгалын замын өвчлөлд нөлөөлөөд зогсохгүй зүрх судасны өвчлөл, хавдрын өвчлөлд нөлөөлж байгааг тогтоосон байна. Хүүхдэд амьсгал, зүрх судасны үйл ажиллагааны сорил хийхэд уушигны амьдралын багтаамж багасах, артерийн бага даралтын хувьд хэвийн бус хариу урвал үзүүлэх, судасны цохилтын тоо цөөрч байгаа нь тогтоогдлоо. Мөн нийслэлийн (677) хүүхдүүдэд хийсэн зүрхний цахилгаан бичлэгийн дүнгээр эрүүл хүүхдүүдэд зүрхний булчингийн агшилт, цахилгаан дамжуулах чанар өөрчлөгдөж, зүрхний цохилт олшрох, цөөрөх зэрэг үйл ажиллагааны өөрчлөлтүүд илэрсэн бөгөөд үүнд эцэг, эхийн боловсрол, өрхийн орлого, халдварт өвчнөөр өвчилсөн байдлаас гадна, агаарын бохирдол нөлөөлж байгааг илрүүлжээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- ✓ **Г.Энхжаргал, Ш.Энхцэцэг** нарын (2001-2002**)** нэгэн агшны асуумж судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 77.8 хувьд амьсгалын замын өвчний ямар нэгэн эмгэг шинж тэмдэг илэрч байжээ. Түүнчлэн гэр буюу энгийн галлагаатай сууцанд амьдарч буй хүүхдүүдийн дундах амьсгалын замын өвчний шинж тэмдэг орон сууцанд байдаг хүүхдүүдийнхээс илүү илэрч байна. Түүнчлэн НЭМХ-ийн (2007) судалгааны дүнгээс харахад галладаг сууцны агаар дахь PM10 болон PM2.5-ын түвшин эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх хэмжээнд байгааг тогтоожээ.

- ✓ **Н.Сайжаа нар** (2006)-ын судалгаагаар Улаанбаатар хотод 2005 оны байдлаар амьсгалын замын өвчнөөр 37 орчим мянган хүн өвчилж 3 орчим тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд хотын агаарын бохирдлыг бууруулах ямар нэгэн арга хэмжээ авахгүй бол 2015 онд 42 орчим мянган хүн өвчилж, 5 орчим тэрбум төгрөг зарцуулах баримжаалсан тооцоо гарчээ. Энэ нь ирэх 10 жилд ойролцоогоор 42.7 орчим тэрбум төгрөг зарцуулна гэсэн үг. Харин урьдчилан сэргийлэх зардалд жилд дунджаар 1.1 тэрбум төгрөг зарцуулахад 10 жилд ойролцоогоор 10 орчим тэрбум төгрөг зарцуулснаар амьсгалын замын өвчлөл 20-25 хувиар буурч, 12.5 тэрбум төгрөг хэмнэх боломж байгааг судалгаанд тооцжээ. Улаанбаатар хотод ийнхүү амьсгалын замын өвчлөл өндөр байгаа нь хотын агаар дахь тоосны хэмжээ, хүхэрлэг хийн агууламжтай шууд хамааралтай байна. Тухайлбал Улаанбаатар хотын 0-16 насны хүүхдүүд багтраагаар өвчлөхөд нөлөөлж буй олон хүчин зүйлийн дотор тоосны үзүүлэх нөлөө 56.5 хувь байна.

- ✓ **О.Байгаль, Б.Бурмаа нар** (2005, 2006)-ын судалгаагаар агаарын бохирдол, зөвхөн амьсгалын замын өвчлөлд нөлөөлөөд зогсохгүй зүрх судасны өвчлөл, хавдрын өвчлөлд нөлөөлж байгааг тогтоосон байна**.** Улаанбаатар хотын агаарыг бохирдуулах нийтлэг бохирдуулагч ($SO_2$, CO, $NO_2$)-аас гадна өвөрмөц бодисоор тухайлбал хар тугалга, Бенз-а-пирен, диоксин гэх мэт өвөрмөц бохирдуулагчид хүн амын эрүүл мэндэд ноцтой зүрх судасны өвчин, харшил, уушигны багтраа, хавдар зэрэг өвчний тархалтыг нэмэгдүүлэх нөлөөлөл үзүүлдэг ажээ. Хүүхдийн цусан дахь хар тугалгын агууламжинд хөрсний хар тугалга 17.4%-иар, агаарын хар тугалга 34.2%-иар тус тус нөлөөлж байгааг судлаачид тогтоосон байна.

***Дээрхээс дүгнэхэд:*** Хотын хүн амын хэт нягтрал, газрын хөрс, усны бохирдол, цэвэрлэх байгууламж, хог хаягдлын цэгүүд болон хотын доторхи хог хаягдлын улмаас үүсч байгаа агаар дахь нянгийн хэмжээ ихэсч сүрьеэ болон амьсгалын замын халдварт өвчин үүсэх, дархлаа буурахтай холбоотой өвчин эмгэгүүд эрс нэмэгджээ. Агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөл сүүлийн жилүүдэд улам ихэсч байгаа нь хувь хүн, айл өрхийн төдийгүй улсын эдийн засагт маш их сөргөөр нөлөөлж байна. Судлаачдын тооцож байгаагаар хотын агаарын бохирдлыг бууруулах ямар нэгэн арга хэмжээ авахгүй бол 2015 онд 42 орчим мянган хүн өвчилж, 5 орчим тэрбум төгрөг зарцуулахаар байна. Харин урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд жилд дунджаар 1.1 тэрбум төгрөг, 10 жилд ойролцоогоор 10 орчим тэрбум төгрөг зарцуулснаар амьсгалын замын өвчлөл 20-25 хувиар буурч, 12.5 тэрбум төгрөг хэмнэх боломж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## НАЙМ. Агаарын бохирдлыг бууруулах эрх зүйн орчин

### 8.1. Эрх зүйн шинэчлэл хийхэд анхаарах асуудал

Агаарын бохирдлыг бууруулахын тулд дотоод, гадаад бүх боломжийг хослуулан ашиглах нь үр өгөөжтэй гэдгийг эрдэмтэн, судлаачид байнга санал болгодог.

1. ***Дотоод боломж:***
    - Агаар бохирдуулсны төлбөрийн сан

- Санхүүгийн дэмжлэг
- Татварын урамшуулал
- Хөрөнгө оруулалт

**Агаар бохирдуулсны төлбөрийн сан:** Энэ нь агаар бохирдуулсны төлбөрөөс бүрдэнэ. Энэ сангийн хөрөнгийн зориулалт нь агаарын бохирдыг бууруулах шинэ технологи нэвтрүүлэх, агаарын чанарын шинжилгээ хийх, судалгаа үнэлгээ хийх, иргэдэд шаардлагатай мэдлэг, мэдээлэл олгох зэрэг олон арга хэмжээнд чиглэгдэнэ. Санг захиран зарцуулах ажиллагааг иргэний нийгмийн байгууллага, бизнес эрхлэгчид, төрийн төлөөлөл тэнцүү оролцсон сангийн тусгай зөвлөл хариуцан гүйцэтгэх нь авилгалаас ангид байдаг механизм болдог ажээ.
**Санхүүгийн дэмжлэг гэдэг нь:** Томоохон компаниудад хорт утаа шүүх, цэвэрлэх байгууламж барих, дотоод мониторинг хийх, техник технологи шинэчлэхэд нь зориулж зээл олгож болно.
Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд дотооддоо агаарын бохирдлын хяналт-шинжилгээний байгууламж барих зорилгоор зээл олгож болно.
**Татварын урамшуулал гэдэг нь:** аж ахуйн нэгжүүдийн зүгээс өөрийнхөө бүтцэд мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн баг бүрдүүлэн агаарын бохирдлын талаар дотоод мониторинг хийж, хэмжилтийн мэдээгээ олон нийт болон агаарын чанарын албанд мэдээлж, стандартыг сахин зохих үр дүнтэй ажиллаж байгаа тохиолдолд үндэсний болон орон нутгийн татвараас хөнгөлөлт үзүүлж болдог.

***2. Гадаад боломж:***

- Цэвэр хөгжлийн механизм
- Нүүрс хүчлийн хийн арилжаа
- Технологи дамжуулах

**Цэвэр хөгжлийн механизм:** Энэ бол Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Китогийн протоколоор тохиролцсон механизм юм. Эрчим хүчний болон сэргээгдэх хэлбэр, нүүрсхүчлийн хий шингээх технологи нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй тэргүүний болон шинэлэг технологи нэвтрүүлэх, боловсруулах, өргөн хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор цэвэр хөгжлийн механизмын хүрээнд ялгаралтыг хязгаарлах ба бууруулах тоон үүргээ биелүүлэхэд нь туслах үүднээс ялгаруулалтын баталгаажсан бууралтыг хэрэглэж, хүлэмжийн хийг бууруулж байгаа орнуудад төсөл хэрэгжүүлэх боломжтой. Хөгжилтэй орнууд, хөгжиж буй орнуудад технологийн шинэчлэл хийх, хүлэмжийн хийгээ багасгахад нь туслах боломж гарч байгаа болно. Гэхдээ энэ чиглэлээр мэргэжлийн холбогдох байгууллагууд ихээхэн хэмжээний суурь судалгаа хийх шаардлагатай юм.
**Нүүрс хүчлийн хийн арилжаа:** Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Китогийн протоколын 1 дүгээр хавсралтад орсон тал нь үүргээ биелүүлэхэд харьцангуй бэрхшээлтэй байгаа мөн хавсралтад орсон өөр нэгэн улсад тооцоолсон хэмжээний дагуу хүлэмжийн хийн ялгаруулалтын тодорхой хэмжээг шилжүүлэхийг хэлнэ. Эдгээрээс гадна байгаль орчныг хамгаалах чиглэлээр хөрөнгө оруулах, санхүүгийн зээл тусламж үзүүлэх сонирхолтой олон улсын байгууллагууд, банк санхүүгийн байгууллага, бизнесийнхэний тусламж дэмжлэгийг авах нь чухал юм.
**Технологи дамжуулах нь:** Байгаль орчны болон сэргээгдэх эрчим хүч, эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хамтран ажиллах, технологи дамжуулах сонирхол бүхий гадаадын холбогдох байгууллагуудад хандах хэрэгтэй юм. Япон зэрэг орнуудад түүхий нүүрсийг өндөр температурт халааж хорт хийг нь арилгаад нүүрсээрээ брикет хийж ашиглаж байгаа нь өнөө үед шинэ дэвшилтэт технологид тооцогдож байна. Үүнийг манай оронд судалж

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ашиглах боломжтой юм.[123] Түүнчлэн агаарын бохирдлыг багасгах нэг хүчин зүйл бол шингээгчийг нэмэгдүүлэх асуудал юм. Энэ зорилгоор айл бүр мод тарьж бичил цэцэрлэг үүсгэх, нийслэл хотод усан сан, усан оргилуур, усан толио бий болгох нь хотын бичил уур амьсгалыг зөөлрүүлэхэд чухал ач холбогдолтой байх болно.

### 8.2. Монгол Улсын "Агаарын тухай" хуулийн зарим зүйл, заалтыг ОХУ-ын "Агаарыг хамгаалах тухай" Холбооны хуулийн зарим зүйл заалттай харьцуулсан байдал

| Хуульчилсан асуудал | Монгол Улсын "Агаарын тухай" хууль (1995 он) | ОХУ-ын "Агаарыг хамгаалах тухай" хууль (1999 он) |
|---|---|---|
| Хуульд тусгагдсан үндсэн ойлголт | Тухайн хуульд хэрэглэгдсэн үндсэн ойлголтуудыг тайлбарлаагүй байна. | Тухайн хуульд хэрэглэгдсэн агаар мандал, агаар бохирдуулагч хорт бодис, агаарын бохирдол, агаарыг хамгаалах зэрэг нийт 17 үндсэн ойлголтыг тайлбарласан. |
| Агаарыг хамгаалах ажлын удирдлага | Тус хуулийн II бүлэгт уг асуудлыг хуульчлахдаа зөвхөн Байгаль орчны асуудал, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд болон агаарын чанарын албаны чиг үүргийг тодорхойлсон. | Хуулийн II бүлэгт уг асуудлыг хуульчилсан ба энд юуны өмнө Агаарыг хамгаалах ажлын удирдлагын үндсэн зарчмуудыг тодорхойлсон байна. Түүнчлэн агаар хамгаалах ажилд төрийн байгууллагуудын болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын бүрэн эрхийг хуульчилжээ. |
| Агаар хамгаалах ажлын хяналт | Энэ талаар зүйл, заалт байхгүй. | Тус хуулийн V бүлэг энэ асуудалд бүхэлдээ зориулагдсан ба энд төрийн хяналт, үйлдвэрлэлийн хяналт, олон нийтийн хяналтын тухай, агаар хамгаалах ажлыг хянах үүрэг бүхий байгаль орчны байцаагч нарын эрх, үүргийг хуульчилсан. Тухайлбал, төрийн хяналт нь агаарыг хамгаалах талаар тогтоосон стандарт, норм, шаардлагын биелэлтэнд хяналт тавих, агаар хамгаалах холбооны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, бусад хуулиар тогтоосон шаардлагыг сахиулах, үйлдвэрлэлийн хяналт нь агаар бохирдуулах эх үүсвэр бүхий үйлдвэрлэл эрхэлдэг хуулийн этгээд, аж ахуйн нэгж нь экологийн албыг ажиллуулах буюу агаарын бохирдолд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг ажиллуулна. Олон нийтийн хяналтыг ОХУ-ын "Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай" болон "Олон нийтийн байгууллагын тухай" хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ гэжээ. |

[123] Др.проф.Ц.Адъяасүрэн."Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах асуудалд". УБ., 2007



UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| Агаар хамгаалах ажлын эдийн засгийн механизм | Хуулийн 19 дүгээр зүйлд агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг болон агаарыг савлах, бусад аргаар үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр төлнө.<br>Төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх журмыг хуулиар тогтооно гэж заасан боловч агаарын төлбөрийн тухай хууль өнөөг хүртэл батлагдаагүй байна. | Тус хуулийн VI бүлгийн 28 дугээр зүйлд агаар бохирдуулсны төлөө хувь хүн болон хуулийн этгээдээс ОХУ-ын зохих хуулийн дагуу төлбөр төлөхийг хуульчилсан байна. Эдгээр төлбөрийг экологийн төлбөр гэж нэрлэдэг ба "Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай" Холбооны хууль болон ОХУ-ын Засгийн газрын 344 дүгээр тогтоолоор төлөх журам, хэмжээг тогтоосон байна. |
| Агаар хамгаалах ажилд иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагууд ын эрх, үүрэг | Энэ талаар зүйл, заалт байхгүй. | Тус хуулийн VII бүлэгт агаар хамгаалах ажилд иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагуудын эрхийг хуульчилжээ. Үүнд агаарын бохирдол, түүний эх сурвалжийн талаар мэдээлэх, агаар хамгаалах үйл ажиллагаанд оролцох, санхүүжүүлэх, агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй аж ахуйн болон бусад үйл ажиллагааны талаархи болон агаар хамгаалах хөтөлбөрийн хэлэлцүүлэгт оролцох, саналаа дэвшүүлэх, агаарын бохирдлын улмаас эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон бол шүүхэд гомдол гаргах эрхтэйг хуульчилжээ.<br>Түүнчлэн хуулиар тогтоосон журмын дагуу олон нийтийн байгууллагын төлөөлөгчид агаар бохирдуулж буй байгууллага, аж ахуйн нэгжийн орчинд нэвтрэх эрхтэй байна. Мөн агаар бохирдуулах эх үүсвэр бүхий суурин болон хөдөлгөөнт үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн үүргийг 13 зүйлээр хуульчилжээ. |

**Тайлбар:** Энэхүү харьцуулалтад агаарын чанарын хяналт, мэдээлэл, агаарыг хамгаалах арга хэмжээний талаархи аль, аль хуулинд нь байгаа түгээмэл заалтуудыг оруулаагүй болно.

**8.3. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хууль эрх зүйн болон бусад хүрээнд хийгдсэн ажлууд болон цаашид анхаарах асуудал**

| № | Асуудал | Хууль, эрх зүйн болон бусад хүрээнд хийгдсэн ажил | Эрх зүйн хүрээ болон Засгийн газар, засаг захиргааны хүрээнд цаашид анхаарах асуудал |
|---|---|---|---|
| 1. | Дулааны цахилгаан станцуудыг дотоод | - Агаарын чанарын **MNS4585-2007** | Стандартыг мөрдүүлэх, |

| | | | |
|---|---|---|---|
| | хяналт шинжилгээний хэрэгсэл, утаа болон бохирдуулагч бодис шүүх тоног төхөөрөмжөөр хангах станцуудаас агаарт гаргах хаягдлын зөвшөөрөгдөх хэмжээний стандартыг шинэчлэн тогтоож, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | - Агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ. Техникийн шаардлага **MNS5885-2008**<br>- Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга MNS5919-2008 зэрэг стандартуудыг шинээр болон шинэчлэн батлуулсан | мөрдөөгүй тохиолдолд торгууль хүлээдэг болон бохирдуулагч эх үүсвэрийн хувьд төлбөр төлдөг байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх |
| | | "Агаарын чанарыг индексээр үнэлэх, мэдээлэх журам" | |
| | | Цахилгаан станцуудад Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэв. | - Станцуудаас ялгарсан үнсийг барилгын материал болгон ашиглах,<br>- Хуурай үнсний талбайг усан бүрхүүлтэй болгох<br>- Дотоод хяналтын лабораторитой байх |
| 2 | Авто тээврийн хэрэгслээс ялгарах утааны бохирдлыг бууруулах үе шаттай арга хэмжээ авах, эхний ээлжинд нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшинд шилжүүлэх, шатахуун бага зарцуулдаг болон эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй түлш хэрэглэдэг автомашины хэрэглээг дэмжих, стандартын шаардлага хангаагүй автомашин эзэмшигчдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, шатахууны чанарыг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчинг | Утаа их ялгаруулдаг автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон насжилтаас хамааруулан автотээврийн хэрэгслийн онцгой албан татварыг тогтоох зэрэг хөшүүргийн механизм хэрэглэхэд чиглэсэн эрх зүйн орчин бүрдүүлэх хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан /Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон агаарын төлбөрийн тухай хуулийн хамт/ | Агаарыг бохирдуулагч бүрээс төлбөр авах, зөрчсөн тохиолдолд торгууль авдаг эрх зүйн үндсийг бүрдүүлэх |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | боловсронгуй болгох, автомашины ашиглагдсан хуучин дугуйг импортоор оруулахыг хориглох, хотын төв болон гэр хорооллыг холбосон замыг хатуу хучилттай болгох арга хэмжээ авах | | |
| | | Хийн түлшээр ажилладаг болон дизель, бензин хөдөлгүүрт шүүр тавьсан тээврийн хэрэгсэлд “Экотэмдэг” олгох журмыг баталжээ | Энэ чиглэлээрхи ажлыг эрчимжүүлэх, үр дүнг нь тооцох, тавиагүй тохиолдолд торгох журам зэрэг эрх зүйн үндсийг бий болгох |
| | | Бензин хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013- 2009, Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014 - 2009 зэрэг стандартыг боловсруулан мөрдөж байна. | Журмын хэрэгжилт болон стандартад мониторинг хийж, агаарын бохирдлыг бууруулахад үр нөлөөтэй байвал цаашид машин нэг бүрт хэрэглэх, хэрэглээгүй тохиолдолд хариуцлага тооцох |
| 3. | Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн хувийн хэвшил, ИНБ-ын санал санаачилга, дэвшилтэт технологи боловсруулах, үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагаанд татварын болон санхүүгийн бодитой дэмжлэг үзүүлэх, хотын ногоон байгууламжийг өргөтгөж, хог хаягдлын менежментийг сайжруулах | 2009 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Байгаль хамгаалах нийгэмлэгээс зохион бүтээсэн NMGHB- 8 маркын 75 ширхэг зуухыг оруулж ирэн БЗД 9-р хорооны 75 айлд туршиж БХС-гаас 10 100,000 (10 сая 100 мянга) төгрөг гаргасан. Мөн дээрхи зуухнаас 100 ширхэгийг буцалтгүй тусламжаар оруулж ирсэн | Хуульд агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн үйл ажиллагааг төлөвлөх, мониторинг хийхэд иргэд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах чиглэлээр тусгах Хяналтын болон үйл ажиллагааны зарим хэлбэрийг ТББ-аар гүйцэтгүүлэх чиглэлээр хуульчлах |
| | | БХС-гаас 30 сая төгрөг гарган гал өдөөгчийг турших тендер зарласан | Энэ чиглэлээр бодитой ажил хийгдсэнгүй. |
| 4. | Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны чадавхийг бэхжүүлэх, хяналт шинжилгээ, судалгааны нэгдсэн | Улаанбаатар хотын агаарыг бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулж, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг БХС-аас хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн гүйцэтгэж | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | сүлжээг өргөжүүлэх, агаарын бохирдлыг хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх болон лабораторын багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх | байна. | |
| | | 2009 онд Агаарын бохирдлыг 6 үзүүлэлтээр хэмжилт хийх чанарын хяналтын 4 суурин, 1 явуулын станц, толгой компьютер бүхий иж бүрэн хяналт, шинжилгээний сүлжээний тоног төхөөрөмжийг Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр авах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан, одоо уг төхөөрөмжүүдийг хүлээн авах бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | Цаашид суурин болон хяналтын станцын тоог олшруулж, шинжилгээний үр дүн бүрд тохирсон арга хэмжээг тухай бүрт нь авч байх |
| | | БОС-ын 2008 оны улсын төсвийн багцад 1.2 тэрбум төгрөг тусгуулан Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны чанарыг бэхжүүлэх хяналт-шинжилгээ, судалгааны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, лабораторийн багаж төхөөрөмжний нийлүүлэлт бүрэн хийгдэж суурилуулан ашиглалтанд оруулсан | |
| 5. | Улаанбаатар хотын агаарын бохирдол ихтэй тодорхой хэсэгт эрсдлийн үнэлгээ хийсний үндсэн дээр Нийслэл рүү чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах талаар холбогдох арга хэмжээ авах | Агаарын бохирдлын талаархи суурь мэдээллийг өргөжүүлэх, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, агаарын бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, ухамсрыг дээшлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх зорилгоор “Улаанбаатар хотын агаарын чанарын мониторинг болон агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг тогтоох нь” төслийг Дэлхийн Банкны санхүүжилтээр 2008 оны 6-р сараас хэрэгжүүлж эхэлжээ. | - Агаар бохирдуулагч эх үүсвэрээс ялгарч буй хорт бодисууд нь тодорхой өвчлөлийг бий болгох шалтгаан болж буй гэдгийг олон улс болон Монгол орны хэмжээнд судалж, мэргэжилтнүүд дүгнэлтээ гаргасныг харгалзаж, агаарын бохирдлыг бууруулах ажлыг цогцоор нь хийх<br>- Иргэдийн энэ талаархи мэдлэгийг өргөжүүлснээр урьдчилан сэргийлэх болон бохирдлыг бууруулахад |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | | | тэдний хүч чадлыг ашиглах зорилгоор дунд сургуулийн болон их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт энэ чиглэлийн хичээлийг оруулах |
| 6. | Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, иргэдийн санал, мэдээллийг хүлээн авах, бохирдлын хор уршиг, сөрөг үр дагаврыг арилгах, шинэ дэвшилтэт технологийн ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр сурталчлах, энэ чиглэлээр явуулах сургалт, судалгааны ажлыг эрчимжүүлэх | Агаарын чанарын мэргэжлийн албанаас орчин үеийн дэвшилтэт техник, технологийг сурталчлах, багаж тоног төхөөрөмжин дээр ажиллаж сургах зорилгоор хөдөө орон нутгийн лабораторын эрхлэгчдэд зориулсан сургалт, семинарыг 2008 онд зохион байгуулсан. | -Бохирдуулагч бүрээс төлбөр авах хуулийг даруй баталж, тэрхүү төлбөрөөр сан байгуулж, түүний хөрөнгийн тодорхой хэсгийг иргэдэд боловсрол олгох болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахад зориулах |

**ЕС. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр амжилт олсон зарим орны арга барил**

**9.1. Бээжингийн агаарын бохирдлыг бууруулсан арга хэмжээнүүд.** Тус хотод хүхэр багатай сайн чанарын нүүрс түлэхийг зөвшөөрдөг ч ихэнх оршин суугч байгалийн хийгээр халаалтаа авдаг учраас энэ хотын агаарын бохирдол үүсгэгч гол шалтгаан нь аж үйлдвэр болон автомашины утаа болж байна. Туршлага болохуйц нэг арга байгаа нь агаарын бохирдол үүсгэгч нэг бүрийг нарийвчлан гаргаж, аль дүүрэгт юунаас болж агаар их хэмжээгээр бохирдож байгааг тооцдог цогц судалгаатай болсны үндсэн дээр хариу арга хэмжээнүүдийг шуурхай авч эхэлжээ. Нэг нь нөгөөтэйгээ уялдсан олон жижиг арга хэмжээнүүд багц болохоороо үр дүн нь ч богино хугацаанд гардгийг Бээжингийн туршлага харуулж байна.
Бээжинд 1998 оноос хойш агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр дараахи арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- Бээжингийн оршин суугчдын 98 хувь төвлөрсөн халаалтад холбогдсон нь нүүрсний хэрэглээг огцом бууруулжээ.
- Жилийн 365 хоногийг агаарын чанараар нь сайн, дунд , муу зэрэг гэсэн гурван ангиллаар гаргадаг болсон байна. 1998 онд агаарын чанар хангахгүй өдрийн тоо **141** байсан бол өнгөрсөн онд ийм өдрийн тоо **8** болтлоо буурчээ.
- Бээжин хотын хувьд Европын стандартыг хэрэгжүүлж буй бөгөөд агаарын бохирдлыг үүсгэгч хүчин зүйл бүрээр ажил хариуцсан албадыг бий болгожээ.
- Агаарын чанарыг өдөр бүрээр гаргасны үр дүнд тухайн өдөр гадуур гарах нь эрүүл мэндэд хохирол учруулах эсэх талаар өндөр настан, хүүхэд, эмэгтэйчүүдэд тогтмол мэдээлэл өгдөг.
- Бээжин хотын төвөөс үйлдвэрийн газруудыг нүүлгэн шилжүүлсэн нь агаарын бохирдлыг огцом бууруулжээ.
- Шинэ машин худалдаж авбал БОХГ-аас заавал зөвшөөрөл авдаг. Европын IV стандартад нийцэхгүй бол замын хөдөлгөөнд оролцох эрхийг нь хязгаарлажээ.
- Автомашинд агаарт хэдий хэмжээний бохирдол үүсгэж байгаагаар нь зэрэглэл тогтоон, цэнхэр өнгөтэй дугаартай машин хор нөлөөгүй, шар өнгөтэй бол бохирдуулж байгаа

UIH.MN СУДАЛГААНЫ САН

гэж ойлгохоор тэмдэгжүүлжээ. Энэ нь үйлчлүүлэгчид ямар өнгөтэй машин сонгохоо мэдэх учраас хуучин машин зах зээлээс аяндаа шахагдах бодлого юм.

- Даваа гаригаас Баасан гариг хүртэлх ажлын ачаалалтай өдрүүдэд машины дугаарын сүүлийн тоо нь 1 эсвэл 6 байвал Даваа гаригт, 2 эсвэл 7 байвал Мягмар гаригт гэх мэтээр нийтийн хөдөлгөөнд оролцохыг нь зохицуулсан журам мөрдөж байна.
- Хуучин машин нь шинэ машинаас 10 дахин их агаарыг бохирдуулдаг тул хуучин машинаас татгалзах хөдөлгөөнийг өрнүүлдэг.
- Барилга барих явцад үүсэх тоосжилтыг багасгах зорилгоор тусгай битүүмжилсэн орчинд үйл ажиллагаа явуулах, сул шороог түр хугацаагаар хатуу хучилттай болгож, чийгшүүлж зүлэгжүүлсний дараа барилга барих зөвшөөрөл олгодог.
- Барьж буй барилга байгууламж дээр ажиллаж байгаа машин техник гадагш гарахын өмнө дугуйгаа угаах, эс биелүүлбэл торгох журам мөрдүүлж байна.

Хуучин машинаа хаявал урамшуулал олгох БНХАУ-ын Засгийн газрын бодлого эрх зүйн хүрээнд зохицуулагдаж, шинэ хууль батлагджээ. Хэрвээ тухайн хэрэглэгч хуучин машинаасаа татгалзвал түүнд Засгийн газраас шинэ машин худалдан авахад нь зориулж тодорхой хэмжээний мөнгөн урамшуулал олгодог болжээ.

**9.2. БНХАУ-ын Фузянь мужийн Сямэн хотын туршлага.** Тус хот цэвэр агаар, цэмцгэр байдлаараа улсдаа 4 дүгээрт ордог.

- Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлыг бүрэн хяналтандаа авсан арга нь химийн ямар элементээс агаар бохирдож байгаа /хийн бохирдлын гарал үүсэл, бүтэц, хувь хэмжээ/-г нарийвчлан судалж, үйлдвэр аж ахуй, барилга байгууламж, нийтийн тээврийн хэрэгсэл зэрэгт тохирсон арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсэнд оршино.
- Хөрсний болон агаар мандлын бохирдлын зааг ялгааг гаргаж, эрчим хүчний жижиг дунд үйлдвэрийг бүрмөсөн хааж, 4 компанид үйл ажиллагаа явуулах эрх олгосноор цахилгаан станц болон аж үйлдвэрээс гарах утааг арилгаж чаджээ.
- Ногоон байгууламж, зүлэгжүүлэлт тогтмол хийдэг иргэн, айл өрх, албан байгууллагуудад урамшуулал өгдөг.
- Ажил хариуцсан албан хаагч агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр санаачлагагүй ажилласан тохиолдолд албан тушаалын зэрэг дэвийг нь бууруулдаг.
- LED технологийг гудамжны гэрэлтүүлэг, цахилгаан эх үүсвэрт ашиглахаас гадна байшингийн дээврийг зүлэгжүүлэхэд ашиглаж байгаа нь агаарын бохирдлыг мэдэгдэхүйц бууруулж байна.
- Агаарын бохирдолтой тэмцэх чиглэлээр иргэдийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч бага, дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт энэ чиглэлийн хичээл оруулдаг.
- Бохирдуулагч эх үүсвэрүүдэд торгууль хүлээлгэдэг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**9.3. Токиогийн агаарын бохирдолтой тэмцдэг аргууд:**

- Токио хотын хэмжээнд цэцэрлэгжүүлэлтийн тусгай дүрэм гаргаж иргэддээ мөрдүүлжээ. Нийт цэцэрлэгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын 80 хувийг дүүргийн захиргаад даадаг учраас иргэд энэ ажилд оролцох их дуртай байдаг аж. 100 метр.кв талбайтай газарт хүүхдийн тоглох тоглоомтой, олон нийтийн цэцэрлэг байгуулахад 30 мянган иен буюу 450 мянга орчим төгрөг зарцуулдаг.
- Зам болгон дээр утаа шүүх тусгай аппарат байршуулан, үйлдвэрүүдэд утаа шүүдэг тусгай технологи бүхий төхөөрөмж байрлуулдаг.

- Хог хаягдлийг иргэн, айл өрх, албан байгууллагууд шатдаг, шатдаггүй, цаас, хуванцар, шил зэргээр нь ангилан ялгадаг. Ангилж хаяагүй тохиолдолд торгууль хүлээдэг журамтай.
- Хог хаягдлийнхаа 10 орчим хувийг дахин ашигладаг. Тухайлбал, саяхан үйлдвэрлэлд нэгэн шинэ технологи нэвтрүүлсэн нь киноны шилийг бутлан, барилгын материалд хэрэглэсэн нь жилд 3000 тн элс хэмнэх үр ашигтай ажээ.

Жичид нь тэмдэглэхэд, Японы Засгийн газраас Монгол улсад хэрэгжүүлж буй “Хатуу хог хаягдлын менежментын төсөл”, “ Зуух, түлш хосолсон технологи” нь агаарын бохирдлыг бууруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа бөгөөд цаашид ч тус улсын ЗГ-аас Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах боломжийг Монголын талтай хамтран судлах хүсэлтэй гэдгээ илэрхийлсэн байдаг.[124]

**9.4. ОХУ-ын агаарын бохирдолтой тэмцэж буй арга:**

- ОХУ агаарын бохирдолтыг бууруулах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй техник, технологи, тоног төхөөрөмж зохион бүтээж нэвтрүүлэхийг онцгойлон үзэж байна. Дулаан, цахилгаан үйлдвэрлэдэг эрчим хүчний эх үүсвэрүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах зорилгоор түлш эрчим хүчний хэмнэлттэй, сүүлийн үеийн дэвшилтэт технологи бичил цахилгаан станц. Орос улс бага, дунд чадлын эрчим хүчний эх үүсвэрүүдийн 10 хувийг ойрын жилүүдэд бичил цахилгаан станц (БЦС) -аар шинэчлэх хөтөлбөр хэрэгжүүлж байна. БЦС нь нэг квт цахилгаан эрчим хүчийг 140-160 гр.жишмэл.түлш/кв-аар үйлдвэрлэдэг нь одоогийн Улаанбаатар хот болон бусад томоохон газрын цахилгаан станцтай харьцуулбал 3-4 дахин бага, автомат, хэмжүүрийн системтэй, цөөхөн орон тоогоор хараат бусаар эдийн засгийн бие даасан хэлбэрээр ажиллуулах боломжтой юм. Энгийн үгээр тайлбарлавал, 1 сая кв цахилгааныг БЦС-аар үйлдвэрлэхэд 140 мян.тн жишмэл түлш зарцуулж байхад одоогийн том станцууд 520-560 мян.тн жишмэл түлш зарцуулж агаарын бохирдлыг 3 дахин нэмэгдүүлдэг гэсэн үг[125]. БЦС-ыг шинээр барих хөрөнгө оруулалт нь нь том станцтай харьцуулбал 4-5 дахин бага, дотоодын хувийн компаниудын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд хялбар, хугацааны хувьд 4-5 сарын дотор барих боломжтой. БЦС-д цахилгаан дулаан дамжуулах хоолой, трансформатор, дэд станц, өргөх насос зэрэг олон тоноглол шаардлагагүй учир хямд үнэтэй цахилгаан дулааныг үйлдвэрлэдэг. Захиргааны дамжлагыг хэмнэснээр цахилгаан, дулааны үнийг 2 дахин багасгадаг. БЦС-аас цахилгаан, дулаан үйлдвэрлэх даралт 1.6-1.7 Мпа, температур 2500 цельсийн градус учир түлшний аль ч төрлөөр ажиллуулахад агаарын бохирдолтыг багасгаж чадна.

**АРАВ. Цаашид ямар арга хэмжээ авах талаархи санал, зөвлөмж**

**10.1. Эрх зүйн чиглэлээр:**

- Аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүргийг тодорхой тусгах
- Байгаль орчны бохирдолгүй үйл ажиллагаа болон технологи нэвтрүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг урамшуулдаг механизм бий болгох
- Бохирдуулагч нь төлөх зарчмийн дагуу хариуцлага тооцож, төлбөр авах
- Агаар бохирдуулсаныхаа төлөө төлөх төлбөрийг тусгай санд төвлөрүүлж, түүний хөрөнгийг агаарын бохирдлыг бууруулахад ашиглах

[124] Монгол, Японы хамтарсан мэдэгдэл. УБ., 2007
[125] Монгол улсын зөвлөх инженер Л.Гэндэнсүрэн. “Эхлээд үнсний аюулыг устгаж, дараа нь утаатай тэмцье”. “Өнөөлөр”. №056. УБ., 2007



UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Бохирдлын зөвшөөрлийн системийг хуульчлан тогтоох

**10.2. Агаарыг бохирдуулагч эх үүсвэрүүдийг багасгах чиглэлээр:**

- Улаанбаатар хотыг хүрээлэн буй уулуудыг сэтлэх замаар багасгах
- Улаанбаатар хот болон суурин газруудад бичил цахилгаан станц барих, түүнийг хөрөнгө оруулалтаар дэмжих
- Агаарын бохирдлыг тогтмол хянаж байх явуулын лабораториудын тоог нэмэгдүүлэх
- Шинээр төлөвлөгдөж байгаа цахилгаан станц, уурын зуухны эрүүл ахуйн экспертиз хийх
- Улаанбаатар хотын байгуулалт, хөгжлийн төлөвлөгөөнд эрүүл ахуйн экспертиз хийх
- Үнс, нүүрсийг эргүүлэн ашиглаж барилгын ба хар замын материал үйлдвэрлэх үйлдвэрийг дэмжих
- Нүүрс тээвэрлэх, овоолох явцад түүнийг мазут болон нефтийн шаараар хучдаг технологийг нэвтрүүлэх
- Гэр хорооллын ариун цэвэр эрүүл ахуйн стандартын шаардлага боловсруулах
- Хотын төлөвлөлтөд гэр хорооллын ба амины орон сууцны байршлыг зөв тодорхойлж, агааржилт сайтай хотын агаарын урсгалд бага нөлөөлөх газарт сонгон байршуулах
- Утаагүй зуух, хаягдалгүй түлшний үйлдвэрлэлийн тендэрийг шударга явуулж, шалгарагсдад татвар болон бусад төрлийн хөнгөлөлт үзүүлэх
- Агаар бохирдуулагч үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг хотоос зайдуу салхины дор байрлуулах /автобааз, цахилгаан станц, хими ба нефтийн хадгалалт, бохирын цэвэрлэгээний байгууламж/
- Автомашины хорт утааны хяналт бий болгох
- Этилжүүлсэн бензин хэрэглэхийг хориглох
- Нийтийн тээврийн хэрэгсэлд агаар бага бохирдуулах унааг нэвтрүүлэх (нарны, хийн, цахилгаан хөдөлгүүртэй)
- Хог боловсруулах үйлдвэр байгуулах
- Хотыг зүлэгжүүлэх, ойжуулах
- Нарны коллектор, нарны яндан, нарны концентратор зэрэг байгууламжуудыг УБ хотод бий болгож, агаарыг тогтмол цэвэрлэх төслүүдийг хэрэгжүүлэх

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**10.3. Эрүүл мэндийн чиглэлээр :**

**А/ Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, сэргийлэх багц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. Үүнд:**

- Хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөхөд (дугуй, явган явах г.м.) чиглэсэн үйл ажиллагаа явуулах
- Хүн амд агаар, орчны бохирдлын хор уршиг, түүнээс сэргийлэх арга замын талаар мэдээлэл, сурталчилгаа (радио, телевизээр тогтмол, үнэгүй) тогтмол хийх
- Хүн ам, хүүхдийн дархлалын түвшинг сайжруулах талаар мэдлэг, ойлголт өгөх, зохих арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,
- Агаар бохирдуулагч эх үүсвэр, этгээдүүд, татварын орлогын зохих хувийг хүүхдийг хамгаалах, эрүүлжүүлэхэд зарцуулах механизм бүрдүүлэх,
- Хүүхдийг амралт, зусланд өргөнөөр хамруулан амруулах, амралтын зардлыг хөнгөлөх,
- Агаар, орчны бохирдолтой холбоотой үүсэх өвчин, эмгэгийн оношлогоо, эмчилгээний талаар эмч, мэргэжилтний мэдлэгийг дээшлүүлэх

**Б/ Агаар, орчны бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн судалгааг өргөжүүлэх, гүнзгийрүүлэх**

- Агаарын бохирдлын судалгааны чадавхийг дээшлүүлэх (эрүүл мэндэд хортой олон бохирдуулагчийг тодорхойлж чадахгүй байгаа), бохирдолтын талаар үнэн бодит мэдээллээр шийдвэр гаргагчдыг хангах,
- Агаарын бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг судлах орчин үеийн өндөр мэдрэмжтэй багаж тоног төхөөрөмжийг судалгаанд нэвтрүүлэх
- Судалгааны ажлын санхүүжилтыг нэмэгдүүлэх
- Судалгааны түвшинг дээшлүүлэх, улмаар хүн амын эрүүл мэндийн байдлыг илүү бодитой зөв үнэлэх, авах арга хэмжээг тодруулахад чиглэсэн чанартай нотолгоог бий болгох

**10.4. Эдийн засгийн арга хэмжээ**

- Импортын бодлого буюу хар тугалга агуулсан бензин, хуучин автомашин зэргийг гаднаас оруулахыг хориглох
- Татварын бодлого
- Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд төлбөр ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжилтийг оновчтой зохион байгуулах
- Байгаль орчны сан бий болгох, зарцуулалтыг ил тод тайлагнах, хянах механизмыг бий болгох

**10.5. Нийгмийн арга хэмжээ:**

- Улаанбаатар хотод хүн амын төвлөрөлтийг сааруулах, шилжин суурьшилтыг багасгах ойрын болон хэтийн бодлого, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх
- Хот чиглэсэн нүүдлийг багасгах
- Хөдөөд дэд бүтцийг сайжруулах
- Хөдөөд ажлын байр бий болгох, өргөжүүлэх

**10.6. Агаар бохирдуулагч эх үүсвэр, үйл ажиллагааг лицензжүүлэх**

- Эх үүсвэр бүрт хаягдлын хэмжээг тогтоох, хянах
- Агаарын чанарын хяналт, тандалт, загварчлал
- Агаарын мэдээллийн сан бий болгох
- Гудамж, замын хөдөлгөөний зохицуулалт (хэт ачааллын үед төвийн бизнес дүүргүүдэд замын хөдөлгөөнийг хязгаарлах, автомашины хаягдал утаа шаардлага хангасныг гэрчлэх наадаг сертификат, явган зорчигч, дугуйн зам төлөвлөх гм)
- Хот, зам төлөвлөлт. Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд байгаль орчин, эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн, судлаачдын дэмжлэг, туслалцааг өргөн ашиглах
- Айл өрх, үйлдвэрлэл, зам тээвэрт цэвэр, хор багатай түлш хэрэглэх
- Эрчим хүчийг хэмнэх, хэрэглээг багасгах
- Хот сууринд халаалт, эрчим хүчний зориулалтаар ашиглах түлш шатахууны чанарыг сайжруулах, коксжуулж шахсан нүүрс, цэвэр бензин шатахуун, хийн түлш болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах боломжийг судалж нэвтрүүлэх
- Хөрснөөс үүсэх агаарын бохирдлыг бууруулахын тулд хотыг зүлэгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэхүү арга хэмжээнд зориулсан төсөвт зардлыг нэмэх, гүйцэтгэлийн хяналтыг тавих, ил тод тайлагнах, энэхүү үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах зэрэг болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

# УИХ-ДӨРГӨН БАРЬСАН "УТААГҮЙ УЛААНБААТАР" ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨЛД ХИЙСЭН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

*Г.Алтан-Оч/Ph.D/, Ч.Базар/Ph.D/,*
*Б.Мөнхцэцэг, Б.Ариунжаргал*

**АГУУЛГА**

1. Оршил
2. Орон сууцжуулах чиглэлээр
3. Тоосжилтийг бууруулах, ногоон байгууламжийн чиглэлээр
4. Гэр хорооллын дулаан хангамжийн чиглэлээр
5. Автозам, автомашины шатахууны чиглэлээр
6. Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж

**Судалгааны зорилго:** Хөтөлбөрийн төсөлд тусгасан арга хэмжээнүүдийн санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэх магадлалтай уялдуулан эрэмблэх, дүн шинжилгээ хийх

**Судалсан байдал:** Хөтөлбөрийн төсөл, хэрэгжүүлэх арга хэмшээний жагсаалт, төсвийн задаргаа зэрэг бичиг баримтуудыг задлан шинжлэх, агаарын бохирдлыг бууруулахад узуулэх нөлөөг нь судлах, тогтоох, дүгнэлт зөвлөмж гаргах

## 0. ОРШИЛ

УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч С.Бямбацолын 2010.04.21 болон 30-ны өдрүүдэд ирүүлсэн захиалгын дагуу уг судалгааг тус төвийн Дэд бүтэц болон Эдийн засгийн бодит салбарын судалгааны багийн 4 судлаач хамтран хийж гүйцэтгэлээ.

Уг хөтөлбөр нь хэдийгээр 2010-2016 оны хооронд нийт 7 жилийн хугацаанд, харьцангуй богино хугацаанд хийхээр төлөвлөсөн арга хэмжээнүүд байвч хэтэрхий цар хүрээ нь өргөн, ангилж ялгахад түвэгтэй байв. Тухайлбал, "Утаагүй Улаанбаатар" нэртэй боловч "нийслэл рүү чиглэсэн хүн амын шилжилт, суурьшлыг сааруулах, зогсоох, хотын төвлөрлийг буруулах зорилгоор аймаг, бүсийн тулгуур төв, суурин цогцоор хөгжүүлэх" зорилт тавин орон нутгийг бүхэлд нь хамруулж хөтөлбөрийн хүрээг хэт томруулсан байна. Иймд хөтөлбөрийн төсөлд тусгасан арга хэмжээнүүдийг дараахь 4 чиглэлд хамааруулан судалгааг явууллаа. Үүнд:

1. Гэр хорооллыг орон сууцны хороолол болгон өөрчлөх (Алтан-Оч)
2. Тоосжилтыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх (Базар)
3. Гэр хорооллын дулаам хангамж, түүхий нүүрсний хэрэглээ (Мөнхцэцэг)
4. Автозам, автомашины утааны бохирдлыг бууруулах (Ариунжаргал)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Судалгааны баг дээрх 4 чиглэлээр хөтөлбөрт хэрэгжүүлэххээр тусгасан арга хэмжээнүүдийг нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад шууд нөлөөлж чадах эсэх, нөлөөлөх ач холбогдлын байдлаар нь эрэмблэх оролдлого хийв.

## 1. ОРОН СУУЦЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Хөтөлбөрийн практик шаардлагад "Улаанбаатар хотын агаарын бохирдлыг үүсгэгч хүчин зүйл нь гэр хорооплын 145,000 айл өрхийн зуух, 1,400 нам даралтын уурын зуух" хэмээн тодорхойлсон байна. Агаарын бохирдлын нэг томоохон эх үүсвэр болох тоосонцорт эдгээр зуухнаас гарч буй утааны бохирдлын эзлэх хувийн жин 47[3]/3 буюу бараг тэн хагас нь

байдаг. Иймээс эдгээр зууханд хэрэглэгддэг түлш болох түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, утааны шүүлтүүр ашиглах замаар агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авах нь хамгийн үр дүнтэй гэж үзэж байна. Үүний тулд цахилгаан, хийн болон бусад эх үүсвэртэй экологийн цэвэр дулаан хангамжийн шийдлийг илүүтэй нэвтрүүлэхэд татаас олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэлбэрээр төрөөс хөхүүлэн дэмжих тогтолцоог бий болгох нь зүйтэй.

Мөн орон сууцжуулах замаар гэр хорооллын айл өрхийг цөөлж тодорхой үр дүнд хүрнэ. Гэвч уг хөтөлбөрийн үзэл баримтлалд "цаашид гэр, жижиг байшин бүхий хорооллыг хотын захад **нүүлгэн шилжүүлэх...**" хэмээн тусгасан байгаа нь цаг үеэ олоогүй, хөрөнгө хүч үр ашиггүй зарах муу талтай. Харин одоо мөрдөгдөж байгаа хөтөлбөр, Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу хотын төвийн бүсээс эхлэн үе шаттайгаар, аажимдаа орон сууцжуулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй. Орон сууцны үнэ өртөг харьцангүй өндөр, орон сууцны зээл-моргежийн зах зээл хөгжөөгүй, үл хөдлөх хөрөнгийн зах зээл сул байгаа нь гэр хорооллыг орон сууцжуулахад ихээхэн цаг хугацаа шаардлагатай[126] байгааг харуулж байна.

Гэр хорооллын гэрийн дулаалгын ашигт үйлийн итгэлцүүр үндэсний стандартаас 4 дахин, байшингийн хувьд 2 дахин бага байгаагаас[1] үзэхэд, эдгээр сууцны дулаан хадгалах чадварыг сайжруулахгүйгээр халаалтын асуудлыг шийдэх нь эдийн засгийн хувьд алдагдалтай гэдэг нь харагдаж байна. Иймд гэр болон жижиг байшингийн дулаалгын технологийг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

Автозамын сүлжээнд ойр, ахуйн үйлчилгээний шугам бүхий хотын дунд хэсгийн гэр хорооллын хувьд, хамтран хямд төсөр байшин барих сонирхоп ихтэй[1] байдаг тул энэ бүсэд хамтын байр, түрээсийн орон сууц барих төсөл хэрэгжүүлэх нь зүйтэй. Ингэхдээ хэд хэдэн байшингуудын дунд халаалтын бичил систем байгуулах замаар дулаан хангамжийн асуудлыг шийдэх нь илүү үр ашигтай юм.

## 2. ТООСЖИЛТЫГ БУУРУУЛАХ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР

**Тоосжилтын талаархи ерөнхий мэдээпэл:**

• УБ хотын агаарын бохирдол дахь хүхэрлэг хийн /$S0_2$/ хэмжээ нь олон улсын стандартад заагдсанаас их байгаа ч хэмжээ болон нөлөөллийн зэрэглэлээр тоосонцор РМ нь хамгийн их анхаарал татсан асуудал болж байна. РМ-ийн агууламжаар УБ хот нь дэлхийн хамгийн их бохирдолтой хотын тоонд багтжээ.[1]

• Тоосонцор нь /ихэнх нь 10 болон 2.5 микроноос бага хэмжээтэй тоос бол удаах нь хүхэрлэг хий $SO_2$, азотым давхар исэл $NO_2$-nay ялгаруулалтаас үүссэн тоосонцор /хүний амьсгалаар дамжин эрүүл мэндэд нь сөрөг нөлөө үзүүлж байна.

• Агаарын бохирдлын хэмжээг жилээр нь гаргахад 40 хувь нь агаарын хий, 60 хувь нь тоос, тоосонцор байдаг аж. Агаар дахь тоос тоосонцорын хэмжээ 10 мк-оос бага байх ёстой атал манайд 2006 онд 141, 2007 онд 157, 2008 онд 279 гэхчилэн байнга нэмэгдэж байна.

• УБ хотын агаарын бохирдол ихтэй нэг хэсэг газар /МУИС-ийн цэг/-ын $PM_{10}$ агууламж жилийн дундаж хэмжээний 50 хүртэл хувийг гудамж, замын гадаргуугаас ялгарч буй том ширхэглэгт тоос бүрдүүлж байна.

• УБ хотын хамгийи их агаарын бохирдолтой газруудад хийсэн хэмжилтийн үр дүнгээс харахад $PM_{10}$ агууламжийн жилийн дундаж нь Монгоп улсын болон олон улсын чанарын стандартаас 2-10 дахин их байна. $PM_{2,5}$ агууламжид хийсэн хэмжилт харьцангүй бага байгаа ч агууламжийн хэмжээ агаарын чанарын стандартаас давсан байна.

UIH.MN

[1] Дэлхийн банк. “Улаанбаатар хотын агаарын бохирдол-нөхцөл байдал, бохирдлыг бууруулах арга хэмжээний үр ашгийг үнэлэх судалгааны ажил” УБ, 2009.10 сар

• 10 микроноос доош хэмжээтэй тоос стандарт хэмжээнээсээ 2.8-5.8 дахин их байна. Харин 2.5 микроноос бага хэмжээтэй тоосонцор нь жилийн дундажаар байх ёстой хэмжээнээсээ хоёр дахин их өсөлттэй байна.

**Агаарыг бохирдуулагч эх үүсвэрүүд**

1. Гэр хорооллын бүсүүд дэх айл өрхийн хэрэглээний зуух
2. Хүнсний дэлгүүр болон мухлагуудын хэрэглээний зуух
3. Цахилгаан станцууд
4. Уурын зуухнууд
5. Тээврийн хэрэгслүүд
6. Агаарт хийсч байдаг тоосонцорууд /тээврийн болон тээврийн бус/
7. Барилгын үйлдвэрлэлээс гарах тоос тоосонцор
8. Хог хаягдал, түүнийг шатааснаас үүсэх тоосонцор гэх мэт

**Тоос, тоосонцорыг багасгах арга хэрэгслүүд**

- Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах
- Ногоон байгууламж буюу хотыг цэцэрлэгжүүлэх
- Цардмал замын тоосыг сорох, чийгшүүлэх
- Шороон замыг асфальтжуулэх
- Хог хаягдлын зөв менежмент явуулах
- Барилга байгууламжаас үүсэх тоосонцорыг багасгах орчин үеийн технологийг хэрэглэх
- Хариуцлага буюу бохирдуулагч бүрээс төлбөр авах

**Ногоон бүс буюу хотыг цэцэрлэгжүүлэх**

Хотын агаар хуурай, тортог ихтэй тул маш их хэмжээний мод тарьж, ногоон бүс бий болгох их шаардлагатай юм. Дэлхий ертөнцийн хүчилтөрөгчийн хийн давхаргыг 3.5 тэрбум жилийн хугацаанд зөвхөн ногоон ургамал л үүсгэсэн байдаг. Энэ үүднээс үзвэл Улаанбаатар хотын амин сүнс нь ногоон байгууламж юм.

Эрдэмтэн, судлаачдын тооцоолсноор ой мод, ногоон байгууламж нь:

- Зөвхөн 1 га-д тарьсан мод сөөг нь 18 сая шоо метр агаарыг цэвэршүүлдэг;
- Утаа униарын 30-35 хувийг өөртөө шингээдэг,
- Өвлийн улиралд навч шилмүүсгүй болсон үедээ ч агаарын бохирдлыг 40 хувь хүртэл багасгадаг,
- Дуу чимээг тэр дундаа навчит мод техникийн болон бусад дуу чимээний 25 хүртэлх хувийг замхруулдаг.
- Навчит мод тоос шорооны 21-76 хувь хүртэл өөртөө барьдаг;
- Хэт халалт болон хөрөлтийг 2-3 хэмээр бууруулдаг.
- Хот суурин газарт бичил уур амьсгал бий болгодог,
- Хөрсөнд шингэж агаарын чийгшилтийг 4-7 хувь ихэсгэдэг,
- Нарны хэт төөнөлтийг 10-15 дахин багасгадаг,

**“Утаагүй Улаанбаатар" хөтөлбөрт тусгагдсан байдал:**

***Нэг. Ногоон байгууламж, цэцэрлэгжилтийн талаар***

Хөтөлбөрийн 3.2.5-д хотын тоос хог хаягдлыг багасгах, утаа тоосыг шингээн саармагжуулагч гол арга хэрэгсэл болсон мод, зүлэг, ногоон байгууламжийн нэг хүнд ноогдох хэмжээг 20м$^3$ хүртэл нэмэгдүүлэх”, 3.3.7-д "Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл" хөтөлбөр хэрэгжүүлэх гэж тусгажээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### 1.1. Дүн шинжилгээ

Өнөөдөр Улаанбаатар хотод нэг хүнд 3.2м$^3$ цэцэрлэгжсэн талбай оногдож байгаа нь бусад хотуудын жишгээс 5-6 дахин доогуур үзүүлэлт юм. Хөтөлбөрт нэг хүнд ноогдох хэмжээг 20м$^3$ хүртэл нэмэгдүүлнэ гэсэн нь стандартыг мөрдөх гэсэн оновчтой зорилт юм. Энэ зорилтын хүрээнд 2010-2012 онд /Нэгдүгээр үе шат/ гэр хорооллын 2300 га нийтийн эзэмшлийн 1200 га талбайг зүлэгжүүлж ойжуулахын тулд хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвөөс 2.107.0 сая төгрөг зарцуулах, хэрэгжүүлэгчээр Ойн газар, НЗДТГ ажиллахаар тусгажээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацаа 2013-2016 онд эвдрэлд орсон эзэнгүй орхигдсон 230 га газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх" ээр тусгажээ. Үүнд нийт 7.964.0 сая төгрөг төсөвлөгдсөн бөгөөд эх үүсвэр нь улсын төсөв, хэрэгжүүлэгч нь Ойн газар, НЗДТГ байх юм.

Хөтөлбөр дотор "Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл" хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд бүх төлөвлөгдсөн ажлыг 2 үе шатны хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр /47.344.0 сая/ хийхээр тусгажээ.

### 1.2. Анхаарах асуудал:

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигладаг аж ахуйн нэгж, байгууллагаар жил бүр олборлосон талбайд нь техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг нийт 230га газарт хийхээр төлөвлөсөн боловч хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой тусгаж өгөөгүй байна.
- Улаанбаатарын хотын аж ахуйн нэгж байгууллагуудын орчныг цэцэрлэгжүүлэх ажлыг нийт 600га-д хийхдээ хөрөнгийн эх үүсвэр болох 1,200 0 сая төгрөгийг улсын төсвөөс гаргаж, хэрэгжүүлэгчээр НЗДТГ ажиллана гэжээ. Энд аж ахуйн нэгжийн орчныг яагаад улсын төсвөөс санхүүжүүлэн цэцэрлэгжүүлэх вэ? гэсэн асуулт гарч байна.
- Туул, Сэлбэ голын эхэнд мод тарих ажлыг хоёр янзаар төлөвлөн оруулжээ. Нэг дэх нь Улаанбаатар хотын тоосжилтыг бууруулах чиглэлээр нийт 25га газарт **110,0 сая** төгрөгөөр навчит мод тарих, хоёр дахь нь "Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл" хөтөлбөрийн хүрээнд Туул, Сэлбэ, Улиастай, Дунд голын дагуу "ногоон бүс байгуулах" гээд хичнээн га газарт гэдгээ нарийвчлан төлөвлөөгүй байж нийт 10.000 0 сая төгрөгийг улсын төсвөөс гаргахаар тусгажээ. Эндээс Туул, Сэлбэ голын эхэнд мод тарих ойжуулах ажил нь хоёр тусдаа төлөвлөгдөж, тусгагдсан байдал ажиглагдана.
- Улаанбаатар хотод томоохон цэцэрлэгт хүрээлэн бий болгох зорилт тавьсан ч хөрөнгийн эх үүсвэр нь мөн л улсын төсвөөс гаргахаар тусгагджээ.
- Хөтөлбөрийн "Ногоон бүс бий болгох цэцэрлэгжүүлэх" бодлого нь нийслэлийн иргэд, ИНБ-ийн оролцоог огт тооцоогүй, санхүүжилт болон хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь улсын төсвөөс гаргаж, төрийн байгууллага хариуцан хийх чиглэлээр тусгасан нь өрөөсгөл болсон байна.
- Иргэд, айл өрх хашаандаа, орон сууцанд амьдрагсад орчиндоо мод тарих ажлыг хөхүүлэн дэмжих, энэ чиглэлийн сургалт явуулах, гэгээрүүлэх ажлыг огт тусгаагүй байна.

### 1.3. Санал зөвлөмж:

- Улаанбаатар хотын тоосжилтыг бууруулах чиглэлээр хийх ажил, "Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл" гэсэн тус тусдаа төлөвлөгдөн, төсөвлөгдсөн ажлуудыг нэгтгэх
- Ногоон байгууламж бий болгох цэцэрлэгжүүлэх ажлын хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвөөс гаргахаар тусгагдсан байгааг эргэж нягтлах. Тухайлбал:

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Улаанбаатарын хотын аж ахуйн нэгж, байгууллагуудын орчныг цэцэрлэжүүлэх ажлыг улсын төсвөөс хөрөнгийн эх үүсвэрийг гаргах гэдгийг тухайн аж ахуйн нэгж хариуцах гэж өөрчлөн тэдгээрийн нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигладаг аж ахуйн нэгж, байгууллагаар жил бүр олборлосон талбайд нь техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг нийт 230га газарт хийхээр төлөвлөснийг эзэнтэй болгох,
- Цэцэрлэгт хүрээлэнг түүх соёл, амралт жуулчлал, танин мэдэхүйн чиглэлээр цогцоор нь хөгжүүлэх зорилт тавьж гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих замаар цогцолборууд бий болгох,
- Хөтөлбөрийн "Ногоон бүс бий болгох цэцэрлэгжүүлэх" дэд хөтелбөрт нийслэлийн иргэд, ИНБ-ийн оролцоог огт тооцоогүй, санхүүжилт болон хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь улсын төсвөөс гаргаж, төрийн байгууллага хариуцан хийх чиглэлээр тусгасныг өөрчлөх, иргэд, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн оролцоог бий болгох.
- Иргэд, айл өрх хашаандаа, орон сууцанд амьдрагсад орчиндоо мод тарих ажлыг хөхүүлэн дэмжих, энэ чиглэлийн сургалт явуулах, гэгээрүүлэх,
- Дэлхийн банкны судалгааны багийнхан цаашид агаарын бохирдлыг бууруулахын тулд иргэдийг татан оролцуулж өөрсдийн дадал зуршлаа өөрчлөхийг уриалахыг чухалчилж байлаа. Нийгмийн ихэнхи хэсэг тэр дундаа ядуус Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад идэвхитэй оролцогчид болгох учиртайг онцолж байгаа.
- Янз бүрийн судалгаагаар сүүлийн жилүүдэд тоосжилт нь хотын хүн амын эрүүл мэндэд асар их аюул учруулж байна гэсэн дүгнэлт гаргажээ. Тоосжилт, агаарын бохирдол нэмэгдэх тусам хүүхдүүдийн дунд тохиолдох амьсгалын хурц үрэвслийн тоо нэмэгддэг гэсэн тооцоо ч байдаг. Тийм учраас орчиндоо эрүүл амьдрахын ач холбогдлыг сурталчилан гэгээрүүлэх, танин мэдүүлэх чиглэлийн ажлыг эрчимтэй хийж, хувь хүн, айл өрхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх
- Нийгмийн ухамсарын болон амжиргааны түвшин доогуур байгаа өнөөгийн нөхцөлд хашаандаа, орчиндоо мод тарьж, зүлэгжүүлж байгаа иргэд, айл өрхийг урамшуулах. 2006-2007 онд 520 айлд хувиараа мод, сөөг таригчид, орчноо цэцэрлэгжүүлэгчдийг 67.0 сая төгрөг урамшуулсан нь чухал арга хэмжээ болсон. Цаашдаа зөвхөн хашаа хороог биш Туул, Сэлбэ голын сав ойжуулалтын, мод үржүүлгийн газрыг ч ингэж урамшуулах хөшүүрэг хэрэглэж болно.

***Хоёр. Цардмал замын тоосыг сорох, чийгшүүлэх***

<u>Хөтөлбөрт тусгагдсан байдал;</u> Хөтөлбөрийн 5.5.4-д "Хөрсний усаар ногоон байгууламж услах болон явган хүний зам чийгшүүлэх систем бий болгох", 5.5.3-д "Автозамын өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг зориулалтын машин техникээр гүйцэтгүүлдэг замын тоосыг соруулдаг болох" гэж тус тус тусгажээ.

**2.1. Дүн шинжилгээ:**

Хамгийн хямд өртөгтэй, манай нөхцөлд тохирсон арга бол цардмал замд чийгтэй цэвэрлэгээ хийх бөгөөд уг үйл ажиллагааг хөтөлбөрт ерөнхийлөн тусгасан боловч хэрэгжүүлэх төлөвлөгөө болон санхүүгийн эх үүсвэрийн талаар огт дурьдаагүй байна.

***2.2.Санал зөвлөмж:***

- Хөрсний усаар явган хүний зам чийгшүүлэх систем бий болгохыг дэмжих
- Замын тоосыг сорж авах, чийгтэй цэвэрлэгээ хийх үйлчилгээ бүхий техникийн паркийг шинэчлэх

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Гурав. Шороон замыг асфальтжуулах талаар**

*Хөтөлбөрт тусгагдсан байдал*: Хотын төв замуудын дагуух ногоон замын орчныг эко хавтангаар бүрэх зүлэгжүүлэх" гэсэн зорилт төлөвлөжээ.

*3.1. Дүн шинжилгээ:* Энэ чиглэлд хичнээн га газрыг зүлэгжүүлэх тухай тодорхой төлөвлөөгүй боловч НЗДТГ-аас 1.200.0 сая төгрөг төсөвлөжээ.

*3.2. Анхаарах зүйлс:*
Асфальт нь хүлэмжийн хийг дэгдээхэд нөлөөлдгийг Японччууд судалгаагаар тогтоосон. Токиод газар амьсгалах боломжиig асфальт хааж байна гэсэн эрдэмтдийн судалгааг анхаарахад илүүдэхгүй.

**Дөрөв. Хог хаягдлын зөв менежмент явуулах**

*Хөтөлбөрт тусгагдсан байдал:* Уг баримт бичгийн 5 5.5-д "Хур хогийг бүрэн цэвэрлүүлж зайлуулж дуусгах", "Барилгын хог хаягдлын зориулалтын цэг бий болгох" гэжээ.

4.1. Дүн шинжилгээ:

Хур хогийг бүрэн цэвэрлүүлж, зайлуулж дуусгах тусгай менежментээр хийгдэх ажил юм. Ялангуяа хур хогийг зайлуулах ажилд төсөв мөнгө шаардагдана. Тухайлбал 2010 оны улсын төсөвт Засгийн Газраас Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий зэрэг 7 аймгийн хур хогийг нэгдсэн журмаар цэвэрлэх, тээвэрлэх, устгах зэрэгт нэг аймагт 150 сая нийт 1.030.0 сая төгрөг төсөвлөж оруулж ирсэн боловч эдийи засгийн хямрал нэрээр батлаагүй аж. Уг хөтөлбөрт хур хог хуримтлагдсан 140 га газрыг цэвэрлэхдээ 600.0 сая төгрөг төсөвлөж түүнийг нийслэлийн төсвөөс гаргахаар тусгажээ.

Барилгын хог хаягдлыг ангилан ялгах, бутлах техник тоног төхөөрөмжийг худалдан авах, барилгын хог хаягдлын цэг бий болгохдоо 1.800.0 сая төгрөгийг нийслэлийн төсвөөс гаргахаар хөтөлбөрт тусгасан нь оновчтой юм. Өнөөдөр барилгын үйлдвэрлэл нь хувийн хэвшлийн бизнес бөгөөд хог хаягдлаа байгаль орчин болон хүний эрүүл аюулгүй орчин ээлтэйгээр зохицуулах нь тэдний нийгмийн хариуцлагын асуудал болж байна. Тийм учраас энэхүү санхүүгийн эх үүсвэрийг барилгын үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж өөрсдөө зохицуулах бөгөөд харин хяналтын ажлыг төрийн зохих шатны байгууллагууд ИНБ, иргэд хийх нь зохистой.

***4.3. Санал, зөвлөмж:***

- Манай улсад хог хаягдлын зохистой менежментийн бодлого хэрэгжүүлэх нь чухал байна. Тухайлбал: хог хаягдлыг нэгдсэн журмаар цэвэрлэх байгууламж бий болгох, хогийг ангилж сортлон, ялзардаг, хөрсөнд шингэдэг хэсгүүдийг нь ялгаж булшлах, үйлдвэрийн аргаар боловсруулах хэсгийг ялгах, хог хаях нэгдсэн цэгүүд бий болгох
- Айл, өрхөөс ялангуяа гэр хорооллын айл өрхөөс авах хогны давтамжийг нэмэгдүүлж хуримтлал бий болохоос сэргийлэх. Үүний тулд хог цуглуулах станцын хүчин чадлыг нэмэгдүүлэхийг хөтөлбөрт тусгах
- Барилгын хог хаягдлыг ангилан ялгах, бутлах техник тоног төхөөрөмжийг худалдан авах, барилгын хог хаягдлын цэг бий болгох ажлыг улсын төсвөөс бус хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийх
- Гэр хорооллоос үүсч буй үнсийг дахин боловсруулж, зориулалтын дагуу барилгын материалд хэрэглэхийг дэмжих

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Дүгнэлт:**

Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх чиглэлээр хийх ажлуудыг тухайлбал хоёр үе шатны хугацаанд 3725 га талбайг зүлэгжүүлэж, ойжуулахын тулд нийт 3.836.0 сая төгрөгийн эх үүсвэрийг "Шинэ Улаанбаатар-Ногоон нийслэл" хөтөлбөрийг улсын төсвийн хөрөнгөөр /47.344.0 сая/ хийх, Улаанбаатар хотын аж ахуйн нэгж байгууллагуудын орчныг цэцэрлэгжүүлэх ажлыг нийт 600 га-д хийхдээ хөрөнгийн эх үүсвэр болох 1,200,0 сая төгрөгийг улсын төсвөөс гаргаж, хэрэгжүүлэгчээр НЗДТГ ажиллана гэх зэргээр ихэнхи ажлыг улсын болон нийслэлийн төсвөөр хийхээр төлөвлөн төсөвлөсөн нь анхаарал татаж байна. Энэхүү ажилд иргэд ИНБ, аж ахуйн нэгжийн идэвхитэй оролцоог чухалчилж, гадны төсөл хөтөлбөрийг ч үр ашигтай зарцуулах боломжтой.

## III. ГЭР ХОРООЛЛЫН ДУЛААН ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР

*Гэр хорооллын түүхий нүүрсний хэрэглээг бууруулах тухайд:*

Газар бүрт тархсан байршил дулааны нягтрал бага одоогийн гэр болон гар галлагаатай хувийн жижиг орон сууцанд оршин суугчдын хувьд төвлөрсөн халаалтын системд холбоход зардал өндөр гарч байгаа бөгөөд цаашид одоогийн хэрэглэж байгаа пийшин зуухаа үргэлжлүүлэн хэрэглэхээс өөр хувилбар байхгүй учир түүхий нүүрсний хэрэглээ борлуулалтыг бүрэн хязгаарлаж гэрийн дулаалгыг сайжруулах, дулааны алдагдал багатай зуух хэрэглэх, хий болон утаагүй цэвэр түлшийг /коксжуулсэн, хагас коксжуулсан үртсэн, брикетэн/ хэрэглэх явдал юм. Үүний тулд жилийн турш Улаанбаатар хотод түүхий нүүрсний хэрэглээ борлуулалтыг хязгаарлаж хагас коксжуулсан брикетан болон үртсэн түлшний үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтыг төсвийн болон төсөл хөтөлбөрөөр санхүүжүүлж шинээр барих буюу байгаа үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр "Утаагүй Улаанбаатар" хөтөлбөрт тусгажээ. 2010 оны байдлаар Улаанбаатар хотод 145.000 айл өрх байгаа нь агаарын бохирдлын 50%-ийг үүсэж байгааг судалгааны байгууллагууд тогтоожээ.

Манай орны нөхцөлд түүхий нүүрсний хэрэглээг халах арга нь:

- Утаа багатай цэвэр түлш сайжруулсан зуухны хэрэглээг өргөжүүлэх
- Цахилгаан болон хийн халаагуураар дулааны хэрэгцээг хангах явдал юм.

Хөтөлбөрийн 5.4.1-д...., гэр хорооллын 145.000 өрхийг боловсруулсан, утаа багатай түлшээр хангах эорилгоор жилд 600.000 тонн утаа багатай түлш үйлдвэрлэх хүчин чадлыг бий болгоход дэмжлэг үзүүлэх.

Энэ нь нэг өрхөд 4.1 тн түлш ноогдохоор байгаа бөгөөд /600.000 тн: 145000=4,13 тн/ хөтөлбөрийн задаргаанд нэг өрхөд түлшийг 2,5 тн-оор тооцсоноос харвал 2012 он гэхэд нийт утаагүй түлшний 75% буюу 453.750 тн үйлдвэрлэхээр тооцоо хийсэн байна. Хөтөлбөрийн эхний шатанд үйлдвэрлэх боломжтой цэвэр түлшний хэмжээг НАЧА (Нийслэлийн агаарын чанарын алба/-аас авсан мэдээллийг үндэслэн хөтөлбөрт тусгасан хэмжээтэй харьцуулсан байдлыг Хүснэгт № 1-д харуулав.

UILMN СУДАЛГААНЫ САН

Хүснэгт №1

| № | Он | Хагас коксжсон нүүрс /тн, хувь/ | | Үртсэн ба шахмал нүүрсэн түлш /тн, хувь/ | | Нийлбэр /тн, хувь/ | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хөтөлбөр | Боломж | Хөтөлбөр | Боломж | Хөтөлбөр | Боломж |
| 1 | 2010 | 5500 айл*2,5тн=13,750/ | 51.814 /11.4/ | 8000 айл*2,5тн=20.0 | 32.710 /7/ | 33.750 /7/ | 85.564 /19.7/ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3/ | | 00 /4.4/ | | | |
| 2 | 2011 | 40.000 айл*2,5тн=100.000 /22/ | 57.000 /13/ | 8000 айл*2,5тн=20.000 /4.4/ | 35.760 /8/ | 120.000 /26/ | 92.760 /20/ |
| 3 | 2012 | 112.000 айл*2,5тн=280.000 /61.7/ | 57.000 /13/ | 8000 айл*2,5тн=20.000 /4.4/ | 35.760 /8/ | 300.000 /66/ | 92.760 /20/ |
| 4 | Дүн | 157.500 айл*2,5тн=393.750 /86.7/ | 164.814 /36.7/ | 24.000 айл*2,5тн=60.000 /13.2/ | 104.230 /23/ | 453.750 | 271.084 /59.7/ |

Хагас коксжсон нүүрс нь илчлэг ихтэй, утаан дахь хорт бодисын хэмжээ нь  стандартад нийцэж байгаа нь хамгийн тохиромжтой цэвэр түлш болно.

Өнөөгийн байдлаар жилд хагас коксжсон нүүрсний үйлдвэрлэл нийт цэвэр түлшний /500000 тн/ 51814 тн буюу 8,64%, хөтөлбөрт тусгасан тооцооны /453750 тн/ 51814 тн буюу 11,4%-ийг үйлдвэрлэх боломжтой гэж үйлдвэрлэгч Шарын гол энерго, НАКО зэрэг ХХК-ууд НАЧА-д урьдчилсан мэдээ ирүүлжээ.

Хөтөлбөрт тусгагдснаар 2010-2012 онд үйлдвэрлэх цэвэр түлшний /453750 тн/ 393750 тк Буюу 86.7 хувь хагас коксжсон түлш гэсэн хэдий ч боломжтой хүчин чадал нь энэ хугацаанд 164614 тн буюу 35.7 хувь байгаа нь үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна. Шарын гол энерго, НАКО зэрэг 3-4 үйлдвэрүүдийн хүчин чадлыг жилд 100-150 мянган тн түлш үйлдвэрлэхээр нэмэгдүүлэх, үнийг түүхий нүүрсээс бага буюу адил хэмжээнд тогтоох талаар төрөөс онцгойлон анхаарч дэмжлэг үзүүлвэл цэвэр түлшний хэрэгцээ үндсэндээ хангагдахаар байна.

- ✓ *ДЭМБ-ын асуулга судалгааны дүнгээс харахад олонхи өрх түлшээ сонгож авахдаа юуны өмнө үнэ илчлэг чанарыг харгалздаг бөгөөд нүүрснээс өөр түлш санал болгоход нийт өрхийн 54,4 хувь нь нүүрснээс бага үнэтэй бол, 41,6 хувь нь нүүрстэй адил үнэтэйг сонгоно гээд, мөн шахмал болон үртсэн түлшний дулаан үүсгэх чанэа муу, хэрэглэхэд төвөгтэй, асалт удаан, бутарч хог болдог, олдоц муу[127] гэжээ.*

Мөн НАЧА -ны 2009 оны тайланд тусгагдсан эх сурвалжид дурдснаар:
"Шахмал нүүрсэн түлш үйлдвэрлэгч 4 аж ахуйн нэгжийн /**Говийн түлш,  Нэбис, Бурхан гал, Тану түлш**/ түлшний шаталтаас гарах нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ **стандартаас 3.01-9.4 дахин их, азотын ислийнх 1.4-1.9 дахин их**, Үртсэн түлшний ААН-үүдийн түлшний шаталтаас гарах утааны **нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ стандарт үзүүлэлтээс 10.94 дахин их,** энэ 2 төрлийн нүүрсийг үйлдвэрлэдэг арван ААН-үүд нь 2006-2009 онд **1000 350 976** (Нэг тэрбум гурван зуун тавин сая, есөн зуун далан зургаан мянга) төгрөгийн санхүүжилтээ бараг бүхлээр нь буюу **94.9%** авсан хирнээ түлш үйлдвэрлэх гэрээний биелэлт **25.2%** -тай байгаа, хагас коксжуулсан түлшний "Төгрөг нуур" ХХК-ны үйлдвэрлэсэн дунд температурын коксжуулсан нүүрсийг шатаахад гарах утааны нүүрсхүчлийн хий, азотын давхар исэл зэрэг нь стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа, түлш нийлүүлэх гэрээгээ 2009 оны 4 дүгээр сарын байдлаар **3000 тн түлш нийлүүлэхээс 10 тн үйлдвэрлэж** гэрээний биелэлт **0,33 хувийн биелүүлэлттэй**[128] байгаа хирнээ **2010-2012 он дуустал жил бүр 15600 тн үйлдвэрлэхээр** урьдчилсан мэдээ ирүүлсэн байна.

[2] ДЭМБ, ЭМЯ, НЭМХ “Дотоод орчны агаарын санар” 2008, хуудас 58
[3] “Агаарын бохирдлыг арилгах талаар хийгдсэн судалгаануудын тойм” УИХТГ-ын судалгааны төв

Цаашид эдгээр ААН-үүд түлшний чанараа сайжруулж, өмнөх авсан санхүүжилтэндээ түлш үйлдвэрлэх гэрээгээ нөхөн биелүүлэх эсвэл агаар бохирдуулагч хорт бодис ихтэй түлшний үйлдвэрлэлийг зогсоож авсан санхүүжилтийг төлүүлэх талаар санхүүжилт олгосон болон холбогдох байгууллага анхаарах нь зүйтэй.

"Найдвартай цахилнгааны эх үүсвэртэй төрөөс цахилгааны үнийн тодорхой хөнгөлөлт үзүүлж, цахилгааны хэмнэлттэй тоолууртай бол гэр хорооллын дулааны эх үүсвэрийг цахилгаанаар шийдвэрлэхэд бэлэн” гэж ЭМЯ, ДЭМБ, НЭМХ-ийн судалгаанд хамрагдагсдын 63.1 хувь үзжээ.

**Дүгнэлт**

- Гэр хорооллын хөгжлийг газар төлөвлөлтийн бодлоготой уялдуулан шинэчлэх
- Утааг багасгах чиглэлээр Олон улсын байгууллагуудаас хэрэгжиж байгаа утаагүй түлш, сайжруулсан зуух, зуух түлшний хосолсон хэлбэр зэрэг төсөл, хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулж хамтын ажиллагааг дээшлүүлэх
- Олон нийт иргэдийн зүгээс агаарын бохирдлыг бууруулалад хэрхэн яаж оролцох арга эамыг тодорхойлох
- Хийн болон цахилгаан халаагуурын үнэ, импортыг дэмжих

## IV. АВТОЗАМ, АВТОМАШИНЫ ШАТАХУУНЫ ЧИГЛЭЛЭЭР

### *Авто машины утаанаас үүсэж байгаа агаарын бохирдол*

Нийслэлийн агаарын бохирдлын багагүй хувийг эзэлдэг нэг томоохон эх үүсвэр нь автомашинаас гарах утаа. Гэр хороололын утаа өвөлдөө агаарын бохирдлын дийлэнх нь болдог ч авто тээврийн хэрэгслээс олон төрлийн хорт блдис бүхий утаа 24 цаг, 365 хоногийн турш гарч, хотын агаарыг бохирдуулж байдаг .

НҮБ-аас хүн амын эрүүл мэндэд хамгийн хортой гэж тогтоосон арван бодисын дотор автомашины хөдөлгүүрийн утаагаар ялгаран гардаг нүүрстөрөгчийн исэл нь хортой чанараараа цацраг идэвхит бодисын дараа 2-рт, мөн азотын исэл 4-рт оржээ. Нүүрстөрөгчийн исэл нь бензин хөдөлгүүрт автомашинаас, харин азотын исэл нь дизель хөдөлгүүрт автомашинаас гардаг. Эрдэмтдийн хийсэн судалгааны дүнгээс харахад агаарын бохирдуулагч нүүрстөрөгчийн ислийн дөнгөж 10 орчим хувийг суурин эх үүсвэр /гэр хроолол, уурын зуух/, харин 90 гаруй хувийг хөдөлгөөнт эх үүсвэр (автомашин) гаргадаг юм байна. Түүнчлэн агаар дахь нүүрс-устөрөгч, азотын ислийн 50 хувь нь мөн л автомашинаас гардаг байна.

Уурын зуух болон гэрийн утаа нь дээшээ тэнгэрт олгойдож, агаарт цацагддаг, салхитай үед бол 25 хүртэл км-т туугдаж зөөгдөнө. Харин автомашины утаагаар ялгарах хорт бодис нь хүний амьсгалах түвшинд (20-30 см-т) хаягддаг учраас хамгийн хор хөнөөлтэй байдаг. Ялангуяа өвлийн улиралд хүйтэний хэмээс хамаарч агаар нягтарсан байдаг учир машины утаа дээшээ хөөрч чаддаггүй, орчиндоо бөөгнөрч байдаг.

**Замын цагдаагийн газрын мэдээллээр Улаанбаатарт 240.000 автомашин хөдөлгөөнд оролцож байна. Үүний 30.000-40.000 нь дулаан гаражаар хангагддаг гэсэн тойм тооцоо байдаг. Царцсан автомашин хэвийн үеэсээ хамгийн багаар бодоход 10 дахин их хортой утаа ялгаруулдаг гэж үзвэл дулаан гаражгүй 200.000 антомашин нь 2.000.000 автомашины утаатай тэнцэхүйц хэмжээний утаа, тортог ялгаруулж байна**

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**гэж тооцоолсон байна.**[129]

Автомашины утаа хүний амьсгалах түвшинд цацагддаг бөгөөд амьсгалын замын цочмог болон архаг өвчин, харшлын эмгэг үүсгэх, элэг, бөөр, уушгийг гэмтээх, зүрх судас, мэдрэл сэтгэхүйн эрхтнүүдийн үйл ажиллагааг алдагдуулах, амьсгал боох, ядрах бие сульдах, хорт хавдар үүсгэх, хүүхдийн өсөлт зогсоох гэх мэт үйлчилгээний нүүрстөрөгчийн дутуу болон давхар исэл, хүхэрлэг хий, хөө тортог, хар тугалга, кадми, альдегид бенз /о/пирен диоксин зэрэг 260 гаруй төрлийн хорт бодис агаарт ялгаруулдагийг эрдэмтэд судлан тогтоосон байна.
Автомашины хөдөлгүүр албадан сул ажиллахад, хөдөлгүүр тормослох үед хүүрстөрөгчийн хэмжээ олон дахин ихэсдэг бөгөөд бинзений ууршилт, хөдөлгүүрийн тэвшнээс гарах дутуу шатсан нүүрстөрөгч бүхий хий нь төв мэдрэлийн системийг мансууруулах буюу амьсгалын замын салст эрхтнүүдийг цочрооно. Хөө тортог нь хүний амьсгалын замыг бохирдуулахаас гадна хамар, уушигны архаг өвчин үүсгэх ба хорт хавдар үүсгэгч бодисын дамжуулагч нь болдог. Автомашины хөдөлгүүрийн цилиндр, поршингийн хэсэг элэгдсэн, царцсан, хөдөлгүүрийн тосны зарцуулалт ихэссэн үед утаан дахь бенкпирэн хэдэн арав дахин ихэсдэг бөгөөд энэ нь амьсгалын замаар дамжин хүний бие махбодид хуримтлагдаж, улмаар хорт хавдар үүсгэх аюултай. */10,000 хүнд ноогдох хорт хавдрын өвчлөлийн тоогоор манай улс дэлхийд эхний 10-т орж байна/*

***АВТОЗАМ***

Хотын авто зам, замын уулзвар гарцууд ачааллаа даахгүй байнга түгжрэл үүсч байгаа, замын засвар арчлалтын ажлын чанар хангалтгүй зэргээс хөдөлгөөний хурд багасч замын уулзварууд дээр автомашин удаан хугацаагаар асаалттай зогссоноос шатахуун үргүй зарцуулж энэ асалтаас агаарт их хэмжээний хорт хий ялгарал тархах, цаг хугацаа алдах зэрэг сөрөг нөлөөлөл улам бүр өсч байна. Ер нь хотын дотор суудлын автомашин 30 км/цагааас багагүй хурдтай явбал хорт хийн ялгаралт харьцангуй бага гэж үздэг бөгөөд 1998 онд Япон улсын PCI компанийн хийсэн судалгаагаар гол гудамжинд автомашины дундаж хурд 24.1 км/цаг гарч байсан бол өнөөгийн байдлаар энэ хурд эрс буурч хотын ихэнхи замд 10-20 км/цагаас хэтэрхээ больжээ. Түүнчлэн баруун 4 зам, 25 дугаар эмийн сан, Багшийн их сургуулийн өмнөх, “Барс” хүнсний зах, хүнсний нэгдүгээр дэлгүүр зэрэг төв замын уулзваруудад нэвтрүүлэх чадвар нь 9.2-25.3 хувиар буурч 400-1760 автомашиныг саатуулж байна. Мөн замын чанар, нэвтрүүлэх чадвар муу, нарийн зэргээс шалтгаалан бөглөрөл үүсэж байна.
Бөглөрлийн улмаас үүсэх бохирдлыг энгийн томьёоллоор тодорхойлж болдог байна. Автомашины одоогийн хөдөлгүүрийн тахир гол нэг минутад дунджаар 1000-2500 литр, 1 цагт 60-150 мянган литр, 1 өдөрт 1-1,5 литр сая, түүнээс их ч агаарыг бохирдуулдаг байна. Нийслэлд одоогийн байдлаар 100.000 гаруй автомашин замын хөдөлгөөнд орж байна гэвэл 1 өдөрт дунджаар 105*106 бусад, 100 тэрбум агаарыг, нэг жилд 36*1011 литр агаар мандлыг бохирдуулж байна.

**САНАЛ ЗӨВЛӨМЖ**

- Замыг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэх, түүний арчлалтын ажлыг сайжруулах.
- Бөглөрөл их үүсдэг газруудад дүүжин зам, нүхэн гарцыг нэмэгдүүлэх.

[4]2009 оны Замын цагдаагийн газрын мэдээлэл

- ❖ Унадаг дугуйгаар зорчигчдын хувийг нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан замыг сонголт, судалгааны үндсэн дээр тавих
- ❖ Хотын доторх замуудыг хатуу хучилттай болгох,
- ❖ Улаанбаатар хотод метро тавих,

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ




*Улаанбаатар хотын нийт автомашины 78 хувь нь 10-аас дээш жилийн насжилттай, экологи, хөдөлгөөний аюулгүй байдлын стандартын зөвшөөрөгдөх хэмжээг хангаж чадахгүй болсон, ашиглалтын зардал өндөржсөн, хямд үнээр зарагдсан, импортоор оруулж ирсэн автомашинууд байна. Шинэ буюу 3 жил хүртэл ашиглагдсан автомашин нийт тээврийн хэрэгслийн дөнгөж 4,0 хувийг эзэлж байна.*[5]

Тээврийн хэрэгслийн өсөлт 2007 онд 92706, 2008 онд 106848, 2009 онд 137000 болсон нь тооны хувьд 14142-30152 буюу 13.2-22% өссөн байна.

Улаанбаатар хотын агаарын чанарт хийсэн тандалт судалгаагаар автомашины яндангаас агаарт хаягдах утааны хэмжээ нь агаарын бохирдлын 20 орчим хувийг эзэлж байгаа нь тогтоогджээ. Улаанбаатарт 2009 оны 11 дүгээр сарын 18-ны байдлаар 137118 автомашин үзлэг оношлогоонд орсны 74.6% нь суудлын, 18.6% нь ачааны, 5.5% нь автобус, 0,1% нь цистерин болон тусгай зориулалтын машин бүртгэгдсэн байна. Дээрхи тээврийн хэрэгслүүдийг шатахууны төрлөөр авч үзвэл бензин-98019 буюу 71.5%, дизель-38878 буюу 28.5%, бусад 221 буюу0,1% болж байна.

**САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

- ➢ Агаар бохирдуулсны төлбөр авах,
- ➢ Монгол улсын хилээр үйлдвэрлэгдсэнээс хойш 5-аас дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэл оруулж ирэхийг хориглох, гааль дээр утаанд нь хэмжилт хийх,
- ➢ 5-аас дээш жилийн насжилттай автомашины татварыг нэмэх аргаар зохицуулалт хийх,
- ➢ Импортын автомашины техникийн байдалд тавих хяналтыг боловсронгуй болгох.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН, ТЭДГЭЭРИЙН АГУУЛАХ САВ, АЧИЖ БУУЛГАХ, ТЭЭВЭРЛЭХ ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТҮГЭЭХ СТАНЦ**

Өнөөдөр манай улс хар тугалгатай бензин, дизелийн түлш хэрэглэж байна. Гэтэл дэлхийн олон улс хар тугалгатай түлш хэрэглэснээс татгалзаад олон жил болж байна. Мөн газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах, ачиж буулгах, тээвэрлэх, түгээх технологи үйл ажиллагааны явцад уршилт үүсч агаар бохирдуулж байна.

ОХУ, Казакстан, БНХАУ зэрэг улсууд нв хар тугалганы 0.15 г/дм$^3$-ээс ихгүй хар тугалганы

хольцтой этилт бензин, мөн 0.013 г/дм$^3$-ээс хар тугалганы хольцтой буюу этилгүй, чанаржуулсан бензин үйлдвэрлэж байна. Гэтэл газрын тосны бүтээгдэхүүний худалдаа эрхлэгч компаниуд нь үнэ хямдтай этилт бензиныг оруулж ирж байгаа нь хотын агаарыг хар тугалгаар бохирдуулах гол шалтгаан болж байгаа юм.

Манай улсын зах зээлд автобензин, дизелийн түлшний стандартад шатахуун дахь хүхрийн хэмжээг тухайлбал автобензинд 0.01%, дизелийн түлшинд 0.2% гэж заасан норм хэмжээтэй байдаг байтал энэ хэмжээнээс хэд дахин их буюу 0.4% хүртэл хүхрийн агууламжтай автобензин, дизелийн түлшийг хэрэглэж байна.

Одоогоор импортын газрын тосны бүтээгдэхүүний чанарт тавих хяналтын тогтолцоо бүрэлдээгүй, үүнээс шалтгаадан холбогдох арга хэмжээ авах боломжгүй байгаагаас агаарт жилд дунджаар 2000 орчим тонн хүхэр хаягдаж байгаа юм. Үүнээс гадна манай улсын жилд хэрэглэж буй 550 мянган тонн автобензин, дизелийн түлшний хэрэглээ нь 1000 орчим тн нүүрсхүчлийн ислийг ислийг үүсгэж байгаа тооцоо байдаг.
Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалтын явцад жилд дунджаар 25 тонн, хүлээн авах, ачиж буулгахад 140 тонн, түгээхэд 277 тонн тус тус алдагддаг байна.

**Санал, зөвлөмж**

- Төсөлд импортын авто-шатахууны чанарын хяналтын талаар дурьдагдаагүй байна. Хадгалалт, ачих буулгах, түгээх явц дахь хяналтын системийг нарийн зохион байгуулан ажиллуулах,
- Импортоор оруулж ирж байгаа бензин болон түлшний чанарт хяналт тавих,
- Этилжүүлсэн бензин хэрэглэхийг хориглох,

## ШИНГЭРҮҮЛСЭН ХИЙН ТҮЛШ

Хийн түлш нь бүрэн шаталттай, байгаль орчинд гарах бохирдол бензинээс 30-50 хувиар бага хэмжээгээр ялгардаг. Түүнчлэн хийн түлшний октан тоо нь 105-120 учир бензинээс илүү чанартай бөгөөд автомашины моторын элэгдлийг хоёр дахин багасгаж, моторын тос солих хугацааг уртасгадаг болохыг мэргэжилтнүүд тогтоожээ. Хийн түлш (газ) нь бензинийг бодвол бүрэн шаталт явагддат төдийгүй АИ92-оом 300 төгрөгийн хямд, АИ95-аас илүү шаталт сайн байдаг байна. Хийн түлш хэрэглэснээр агаарын бохирдол бууруулах, эдийн засгийн хувьд хэмнэлттэй зэрэг давуу талтай байна. */Шингэрүүлсэн хийн түлш хэрэглэснээр бензинд зарцуулдаг байсан мөнгөнөөсөө өдөрт 4200 төгрөг, сард 126000 төгрөг, жилд 1.5 сая төгрөгийн хэмнэлтийг тооцоолж болно./*

Аюулгүй ажиллагааны дүрэм, холбогдох стандартыг мөрдөж, журмын дагуу ажиллавал ямарч эрсдэлгүй. Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн 40 хувийг шингэрүүлсэн нефтийн хийд шилжүүлэхэд автомашинаас гарч буй СО-нйн хэмжээг 80 гаруй хувиар, NO2-ын хэмжээг 21.0-23.0 хувиар буурна гэсэн тооцоо байдаг байна.

Дэлхийн хэмжээнд хийсэн судалгаагаар хүний биед хортой элементүүд машины яндангаас, тэр тусмаа олон жил ашигласан хуучин машинаас гардаг нь тогтоогдсон. Тиймээс улс орнууд нилээд хэдэн жилийн өмнөөс хар тугалга ашигласан бензинийг ашиглах, ипортлох, үйлдвэрлэхийг хориглох шийдвэр гаргаад байгаа. Зарим улс орны төрөөс нэгдсэн бодлого гаргаж тэмцэж байна. Үүнээс дурьдвал Филипин, Малайз, АНУ, Сингапур зэрэг улс хар тугалга агуулсан түлш хэрэглэхийг бүрэн зогсоож чадсан байна. Тавааc дээш жил ашигласан машин импортлохгүй байх, байгаль экологид хор нөлөөгүй машины татварыг тэглэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж үр дүнгээ өгчээ. Үүнийг Монголд хэрэгжүүлж болох юм.

UILMN СУДАЛГААНЫ САН

**Санал, зөвлөмж**

- Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын нэг автомашиныг хийн түлшинд шилжүүлснээр жилд ялгарах хорт бодисын хэмжээг 100 кг-р буюу 65%-иар бууруулж чадна. *Хийн түлшийг автомашины банкнаас бензин шиг юулж авна гэсэн ойлголт байдаггүй учир байгууллага шатахууны зардлаа хянах боломжтой болно.*
- Шингэрүүлсэн хийн түлшээр ажилладаг тээврийн хэрэгслийн гаалиар оруулж ирэх албан татвараас бүрэн чөлөөлөх,
- Шингэрүүлсэн түлшээр ажилладаг машины албан татварыг 30%-иар чөлөөлснөөр төсвийн орлогын бүрдүүлэлт багасахгүй. Нэг машин жилдээ бензин болон шингэрүүлсэн хийн хэрэглээний зөрүүгээс 1.5 сая төгрөгтэй тэнцэх валютыг хэмнэж байгаа,
- Төсөлд цагдаа болон түргэний тэргийг хийд шилжүүлэхээр тусгагдсан байгаа. Цагдаа, түргэний машин нь хурд, хүч их шаардагдсан албанд хэрэглэгддэг. *Хийд шилжүүлэхэд хүч муу болох, хүйтний улиралд доголдох зэрэг эрсдлийг тооцон шингэрүүлсэн хийн түлшинд шилжүүлэхийг түдгэлзүүлэх* саналыг гаргаж байна.

**БИОЭТАНОЛ**

Дэлхий нийтээрээ бензинийг орлох бүтээгдэхүүнээр байгаль орчинд халгүй, дахин сэргээгддэг хямд эрчим хүчний эх үүсвэр болох биоэтанолыг сонгож, ялангуяа сүүлийн жилүүдэд автомашины хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлж, хэрэглээ болон үйлдвэрлэлийг нь жилээс жилд эрчимтэйгээр улам сайжруулж байна. Этанолыг ихэвчлэн чихрийн нишинг, манжин, эрдэнэшиш мэтийн ургамлыг ферментацид оруулан нийлэгжүүлэх замаар гаргаж авдаг. Сүүлийн гурван жилд дэлхийн эрчим хүчний хомсдол нь этанолыг түргэн ургадаг олон наст ургамал, өвс, тэрчлэн хотын хог хаягдал, химийн болон феллюлоз цаасны үйлдвэрийн хаягдлаас гарган авах өндөр үр ашигтай технологийг бий болгосон байна.

Манай улс экологийи цэвэр бүтээгдэхүүн биоэтанол бензинийг "Петровис" ХХК болон "Оргил Ойл" ХХК-ууд хамтран Нийслэлийн агаарын чанарын албаны дэмжлэгтэйгээр автомашины хэрэглээнд ЭКО-92 нэрээр нэвтрүүлж хэрэглэж байгаа. Этанол бүхий бензины стандартыг 2008 онд Стандарчлал хэмжэл зүйн үндэсний төсвөөс "Албадмал асаалттай автомашины хөдөлгүүрт зориулсан моторын этанолт түлш" MNS GOST R 52201:2008 стандартыг батлан гаргасан бөгөөд ЭКО-92 бензин нь энэхүү стандартын бүх үзүүлэлтийг хангаад зогсохгүй зарим үзүүлэлтээр давуу байна. ЭКО-92 бензиний хэрэглээтэй уялдан түлшний этанол дагасан бусад салбарууд хөгжиж эхлэн бүрэн боломжтой юм.

Биоэтанол бүхий ЭКО-92 бензин нь бидний хэрэглэж байгаа автобензинүүдээс нилээд хэдэн үзүүлэлтээр давуу талтай нь тус бензинийг турших явцад батлагдсан байна. Тухайлбал: Энгийн бензинтэй харьцуулахад автомашин улам хүчтэй, хурдтай болж, хөдөлгүүрийн инжектор, свечи, карбюратор, тэжээлийн систем, клапан, шатах камерын бохирдлыг багасгаж, элэгдлийг бууруулж, хөө тортог, нагар үүсэхээс сэргийлж, автомашины хөдөлгүүрийн ашиглагдах хугацааг ч уртасгах боломжтой төдийгүй шатахууны зарцуулалтыг тодорхой хэмжээгээр бууруудсан үзүүлэлт гарсан байна. Биоэтанол нь ямарч утаа тортоггүй шатдаг учраас биоэтанол бүхий ЭКО-92 бензинийг ашиглах үед автомашины яндангаас ялгарах утаа, хүүрс хүчлийн дутуу исэлийн хэмжээ 30-40%-аар буурдаг нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагджээ.

Дэлхийд үйлдвэрлэгдэж байгаа бүх автомашин бензин дээр 10-15 хувь этанолыг нэмээд үр ашигтай ажиллах боломжтой юм. Америкийн гурван муж улсад 10 хувийн этанол нэмсэн бензинийг борлуулж байна. 2007 оны дөрвөн сард Швед улсад 5.76 хувь этанолыг бензинд

UIH.MN СУДАЛГААНЫ САН

заавал нэмэх хөтөлбөр батлагджээ. Хятад болон япон улсад бензинд этанолыг заавал нэмдэг болсон байна.

***Биоэтанолын ач холбогдол***

Этанол нь хүлэмсийн хий, уурын зуухны болон автомашины утаа, хорт бодисыг агаар мандалд цацагдан тархахыг багасгадаг. Энэ нь зорчих замаас жил тутам нэг сая автомашин алга болсонтой адил гэсэн үг юм. Этанол нь биологийн задралд ордог бөгөөд байгалийн усан системийг бохирдуулдаггүй байна. Ашигт малтмал буюу нүүрс, нефть гэх мэт нь үүсэн бий болохын тулд хэдэн сая жил шаарддаг байхад этанол нь дахин сэргээгддэг нөөц байдаг.

Этанолийг шинэ автомашинд хэрэглэсэн ч гэсэн нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг бүхэл бүтэн 30 хувиар бууруулдаг байна. Түүнчлэн этанол нь бензин дэх үнэрт нүүрс устөрөгчийн хэмжээг бууруулснаар хоёрдогч тоосонцор үүсэн бий болохоос сэргийлдэг байна. Бензин ба этанолийн хольцтой түлш нь өнгөр үүсгэлтийг багасгаж, автомашины хөдөлгүүр дэх хорт бодисын хэмжээг бууруулан, цэвэршүүлж, түүний зохист ажиллагааг хангадаг байна.

Биоэтанол бүхий ЭКО-92 бензинийг хэрэглэхдээ хөдөлгүүрийн эд ангийг өөрчлөх, нэмэлт тоноглол тавих шаардлага байхгүй. ЭКО-92 нь химийн найрлагын хувьд өөр ч ашиглалтын шинж чанарын үзүүлэлтүүд нь Аи-92-тай адил учир Аи-92 бензин хэрэглэдэг бүх төрлийн автомашинд шууд л хэрэглэнэ. Урьд нь Аи-92-оор явж байсан, шатахууны үлдэгдэлтэй зэрэг нь ямар ч нөлөөгүй. Харин шатахууны бак хэт бохирдолттой тохиолдолд цэвэрлэх шаардлага гардаг байна.

***Биоэтанол бензины гадаад орнуудын хэрэглээ***

| Улсууд | Хувь | Он |
|---|---|---|
| ЕХ | 5 75% | 2008 |
| Хятад | 5% | 2010 |
| Бразип | 2% | 2003 |
| | 5% | 2013 |
| Энэтхэг | 5% | 2010 |
| Тайланд | 10% | 2010 |
| Англи | 10% | 2010 |
| АНУ | 5% | 2010 |
| | 30% | 2030 |
| Япон | 5% | 2010 |

*10 хувийн этанолын холимог нь бензинийг бодвол хүлэмжийн хий ялгаруулалтыг 12-19 хувиар багасгадаг байна. Жишээ нь, АНУ этанолыг хэрэглэснээр хүлэмжийн хийн ялгаруулалтыг ойролцоогоор долоон сая тонноор багасгадаг бөгөөд энэ нь нэг сая автомашины жилд гаргах утаатай тэнцэнэ гэсэн үг юм.*

*Этанолоор шинэтгэн баяжигдсан бензин нь АНУ-д худалдаалагдаж байгаа автомашины нийт түлшний 30 орчим хувийг эзэлдэг байна. АНУ-ын бүх л томоохон автомашин үйлдвэрлэгчид бензин ба этанолын хольц хэрэглэхийг сайшаан дэмждэг. Мотоцикль, цаснаа явагч, дүүжин мотор үйлдвэрлэгчид бүгдээрээ эдгээр тээврийн хэрэгсэлд зориулагдсан хөдөлгүүрийн бензинд 10 хувь хүртлэх этанол хэрэглэхийг зөвшөөрдөг байна.*

Сүүлийн жилүүдэд ялангуяа АНУ, Бразил, Англи, Герман, Франц, Итали, Полыш, Швед, Канад, Ирланд, Австрали, Хятад, Япон, Энэтхэг, Тайланд, Казакстан, Саудын Араб зэрэг дэлхийн 30 гаруй оронд өргөнөөр хэрэглэж байна. Тэдний талаар товчхон өгүүлбэл: 2006 оны хавраас эхлэн их гүрнүүдийн дотроос хамгийн түрүүнд Бразил улс нефть импортлохоос татгалзсан байна. Одоо Бразилийн автомашины паркийн 70% нь түлшний этанол агуулсан бензинийг үндсэн шатахуунаа болгон ашиглаж байгаа бөгөөд этанолын үйлдвэрлэл, ашиглалт, экспортоороо өнөөдрийг хүртэл дэлхийд тэргүүлсээр ирсэн байна.

Түлшний этанол Бразил улсыг эрчим хүчний хараат бус улс болох боломжтой болгосон байна. Энэ туршлагыг Швед улс 2020 он гэхэд бүрэн хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөн эрчимтэй ажиллаж байна. Харин Америкийн нэгдсэн улсын одоогийн удирдлагууд түлшний этанолыг үндэсний үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл болгон зарласнаар үйлдвэрлэл нь хурдацтайгаар хөгжиж байна.

Япон улсад түлшний этанолын түүхий эдийг тариалах газар нутаг бага тул жил бүр Бразил улсаас 1,8 сая тн түлшний этанолыг импортолдог ба энэ жилээс хэрэглээг 3 дахин нэмж 6 сая тн болгоод байна. Мөн Казахстан улсын нефтийн батлагдсан нөөц 44 жил хүрэлцээтэй гэж тооцогддог ч Казахстаны удирдлагууд нефтийн бүтээгдэхүүний дотоод хэрэгцээнийхээ 30%-г л этанолоор орлуулснаар уул геологийн нэмэгдэл зардал гаргалгүйгээр уг хугацааг 80 жил хүртэл нэмэгдүүлэх боломжтой гэж тоцоолон түлшний этанолын үндэсний хөтөлбөр боловсруулжээ. Бусад нефтьтэй орнууд ч гэсэн бодлогоо өөрчилцгөөж байна. Дэлхийд батлагдсан нефьтийн хамгийн их нөөц Саудын Арабд байдаг. Гэтэл тэнд ч гэсэн түлшний этанолын үйлдвэрлэлийг эхлүүлсэн байна.

**Санал, зөвлөмж**

- Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор эх орны түүхий эдэд тулгуурласан бензинийг хэрэглээнд нэвтрүүлэх нь маш өндөр ач холбогдолтой юм.
- Манай орны хувьд бусад улсуудтай адил этанол гарган авахдаа хүнсний үйлдвэрийн хаягдал, зэрлэг ургамал зэргийг ашиглахаас гадна хүнсний бус зориулалтаар төрөл бүрийн ургамал тариалан шатахууны зориулалтаар ашиглаж эхэлбэл шатахуун нийлүүлэлт нэмэгдэх боломж нээгдэнэ.
- Манай нөхцөлд \хүйтэн сэрүүний гэдэг утгаараа\ биоэтанолыг хэрэглэхэд хүндрэлтэй асуудал гарч болох юм. Учир нь биоэтагол ус шингээж авдаг. Хэрвээ манай түгээн цэнэглэх системийн чанар муу, дамжуулах хоолой нь хуучин, гангууд нь цоорхойтой, ёроолдоо устай бол хүндрэлтэй асуудал гарч болох талтай.

**БИОДИЗЕЛЬ**

Биодизель түлш нь экологийн нэн цэвэр бүтээгдэхүүн бөгөөд эдийн засгийн хувьд ач холбогдол өндөрр байдаг. Биодизель түлшийг дан ганц рапсын тосноос биш бүх төрлийн тосны ургамлын үр болон амьтны өөх тосноос хүртэл гарган авч болдог. Биодизель түлшийг гарган авахад ургамлын тосыг 130-135 фарнгейтийн дулааны хэмд халааж есөн кг ургамлын тосон дээр нэг кг метанол хийж холимгийг урвалд оруулах замаар тосон дахь глицеринийг ялган биодизель түлшийг үйлдвэрлэдэг байна. Биодизелийг хөдөлгүүрт ямар нэгэн өөрчлөлт хийлгүйгээр хэрэглэж болно. Гэхдээ ердийн солярктой 20:80 гэсэн харьцаагаар хольж Б20 түлш (20% биодизель) болгон хэрэглэхийг зөвлөдөг байна.

Европын холбоо нийт хэрэглээнд эзлэх биотүлшний хэмжээг 2010 он гэхэд 5.75 хувьд хүргэх зорилго тавьжээ. Европын орнуудын дотроос Герман улс биодизель, биоэтанолын үйлдвэрлэлээр тэргүүлж жилд 2.05 сая тн биодизель, 1.95 сая тн биоэтанолыг үйлдвэрлэж байна. АНУ-д жилд 20 тэрбум литр биодизель үйлдвэрлэх хүчин чадалтай 112 үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгаа бөгөөд 2012 он гэхэд 45 тэрбум литр биодизель түлш үйлдвэрлэхээр төлөвлөжээ. Дэлхийн зах зээл дээр шар буурцгийн, наран цэцгийн маалингын, дал модны наргилын, чидүн жимсний тосыг ихэвчлэн худалдаалж буй боловч эдгээрээс рапсын тосыг голдуу биодизель үйлдвэрлэхэд ашигладаг. Биодизель түлш хийхэд шаардагддаг метанол, этанолыг эрдэнэшиш, үр тарианаас гарган авч болно.

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүд нийт тариалангийн



UILMN СУДАЛГААНЫ САН

талбайнхаа 10-20 орчим хувьд нь рапс тариалж хураан авсан ургацаараа биодизель түлш үйлдвэрлэн дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж болох юм. 1000 га талбайд үр тарианы ургамал тариалдаг аж ахуй 200 га-д рапс тариалж нэг га-аас дунджаар нэг тн рапс хурааж авбал нийт 200 тн ургац авах болно. Энгийн технологиор нэг тн рапсын үрээс 350 кг тос гарган авдаг бөгөөд энэ нь 320 орчим кг биодизель, 30 кг глицерин болох бөгөөд үлдэх хэсэг буюу шаар нь тэжээлийн нэгж өндөртэй уургаар баялаг малын тэжээл болдог. 1000 га талбайд тариалалт хийж үйлдвэрлэл явуулдаг аж ахуй жилд 75-80 орчим тн дизель түлш хэрэглэдэг бол 200 тн рапсын үрээс 70 тн биодизель түлш, 6-7 тн глицерин, 120 гаруй тн сайн чанарын тэжээл үйлдвэрлэж дотоодын хэрэгцээгээ хангахын зэрэгцээ эилд дунджаар 80-90 сая төгрөгийн имплотын дизель түлшийг хэмнэх боломж бүрдэнэ[130].

Рапсыг дотооддоо тариалж тос гаргахад л өөрийн өртөг нэг литр нь 600 төгрөг болох бөгөөд нэг литр биодизель түлш нь 750 орчим төгрөг байх урьдчилсан тооцоо гарч байна. Рапсыг 200 мянган га хүртэл талбайд тариалж нэг га-аас нэг тн ургац хурааж аваад түүгээрээ биодизель түлш үйлдвэрлэсэн тохиолдолд 80 орчим тэрбум төгрөгийн импортын дизель түлшийг хэмнэх боломжтой юм[131].
Манай орны хувьд зарим нэг газар тариалангийи компани, аж ахуйн нэгжүүд рапс тариалж байгаа боловч ургацаа маш хямдаар ямар ч боловсруулалт хийлгүй урд хөршид худалдаж байгаа тал дээр анхаарал тавин татварын бодлогоор зохицуулах шаардлагатай.

**Санал, зөвлөмж**

- Түлшний этанол, Эко бензин нь байгаль орчин, машин техникт эерэг сайн нөлөөтэй, дахин сэргээгддэг нөөцөөс үйлдвэрлэдэг, үнэ өрсөлдөхүйц зэрэг олон давуу талтай учир **тодорхой хувиар** автобензинд нэмж хэрэглэж байхаар хуульчлах нь зүйтэй.
- Хөдөө аж ахуйд дизель түлшийг "БИОДИЗЕЛЬ" түлшээр орлуулснаар газар тариалангийн үйлдвэрлэлийн зардал, бүтээгдэхүүний өөрийн өртөг буурч, улмаар экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, хүн амын хүнсний хангамж, эрүүл ахуй дээшлэнэ.

**ДҮГНЭЛТ**

Хотын дотор суудлын автомашин 30 км/цагаас багагүй хурдтай явбал хорт хийн ялгаралт харьцангуй бага байдаг гэсэн судалгаа байдаг. Өнөөгийн байдлаар замын бөглөрлөөс хурд эрс буурч хотын ихэнхи замд 10-20 км\цагаас хэтрэхээ больсон нь агаарыг ихээр бохирдуулж байна. Замыг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэх, түүний арчлалтын ажлыг сайжруулах шаардагатай. Бөглөрөл ихээр үүсэж байгаа газруудад давхар гүүрэн зам тавих. Автомашины зорчилтыг бууруулах хамгийн зохистой бодлого нь хувийн автомашинаас нийтийн тээвэрт шилжүүлэх арга юм. Улаанбаатар хотод метроны сүлжээтэй болох талаар судалж, ойрын хугацаанд хэрэгжүүлэх,

Монгол улсын хилээр үйлдвэрлэгдсэнээс хойш 5-аас дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэл оруулж ирэхийг хориглох, гааль дээр утаанд нь хэмжилт хийх.

Төсөлд автомашин хийгээр цэцэгдэх станц 15-ыг байгуулахад 3.825.0 сая төгрөг зээлээр зарцуулахаар төсөвлөсөн байгаа. Ингэж бэлнээр их хөрөнгө мөнгө зарцуулахын оронд татварын бодлогоор зохицуулах нь зүйтэй.

- Хийн түлшээр ажилладаг автомашины татварыг 30%-р бууруулж, дизель болон бензинээр ажилладаг тээврийн хэрэгслийн албан татварыг тодорхой хувиар нэмэх. Хийн түлшээр ажилладаг машины албан татварыг 30%-иар чөлөөлснөөр

[130] Б.Мөнхбат-Монгол улсын зөвлөх инженер, техникийн ухааны доктор
[131] Б.Даваацэрэн\Ph.D\, Петровис ХХК-ийн чанар технологи хариуцсан ахлах мэргэжилтэн

төсвийн орлогын бүрдүүлэлт багасахгүй. Нэг машин жилдээ бензин болон шингэрүүлсэн хийн хэрэглээний зөрүүнээс 1.5 сая төгрөгтэй тэнцэх вальютыг хэмнэж байгаа.

- Хийн түлшээр ажилдадаг тээврийн хэрэгслийн гаалиар оруулж ирэх албан татвараас бүрэн чөлөөлөх,
- Эко буюу байгальд ээлтэй биоэтанол, биодизель түлшний үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэхдээ энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулагчдыг татварын бодлогоор дэмжих,
- Цахилгаан тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

Төсөлд цагдаа болон түргэний тэргийг хийд шилжүүлэхээр тусгагдсан байгаа. Цагдаа, түргэний машин нь хурд, хүч их шаардагдсан албанд хэрэглэгддэг. *Хийд шилжүүлэхэд хүч муу болох, хүйтний улиралд доголдох зэрэг эрсдлийг тооцон шингэрүүлсэн хийн түлшинд шилжүүлэхийг түдгэлзүүлэх* саналыг гаргаж байна.
Хөдөө аж ахуйд дизель түлшийг "биодизель" түлшээр орлуулснаар газар тариалангийн үйлдвэрлэлийн зардал, бүтээгдэхүүний өөрийн өртөг буурч улмаар экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, хүн амын хүнсний хангамж эрүүл ахуй дээшилнэ.

## V. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Агаарын бохирдлыг бууруулахад шууд хамаарахгүй, ач холбогдол багатай дараахь арга хэмжээнүүдийг уг хөтөлбөрөөс хасах. Үүнд:
   a. 5.1.3. Газар хөдлөлийн бичил мужлалыг шинэчлэн тогтоож мөрдүүлэх.
   b. 5.1.34. Барааны болон автомашины захыг хотын зах руу нүүлгэх.
   c. 5.4.6. Гал ноцоогчийн зохистой хувилбарыг сонгон хэрэглээнд нэвтрүүлэх.
   d. 5.5.2. Оршуулгын газруудыг тохижуулах төсөл хэрэгжүүлэх.
   e. 5.6.4. Автомашины хийгээр цэнэглэх 15 станц шинээр байгуулах.
   f. 5.6.6. Нефтийн хий, био-этанол, биодизель түлшний үйлдвэрлэлийг дэмжих.
   g. Цагдаа болон түргэн тусламжийн автомашиныг хийн хөдөлгүүртэй болгох.

2. Агаарын бохирдлыг бууруулахад ач холбогдол багатай боловч хөрөнгө санхүүгийн боломжийг харгалзан хэрэгжүүлж болохуйц дараахь арга хэмжээнүүдийн хэрэгжүүлэх цаг хугацааг хойшлуулах. Үүнд:
   a. 5.1.10. Орон сууцны хорооллын одоогийн байршлын зураглал хийх, ... нэмэлт хөрөнгө оруулалтыг хязгаарлах арга хэмжээг авах;
   b. 5.1.20. Төв цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийх;
   c. 5.1.21 ба 5.1.35. "Харгиа" цэвэрлэх байгууламжид засвар шинэчлэл хийх, иж бүрэн техникийн шинэчлэл хийх;

3. Агаарын бохирдлыг бууруулахад ач холбогдол бүхий дараахь арга хэмжээнүүдийг хөтөлбөрт нэмж тусгах. Үүнд:
   a) Гэр, жижиг байшингийн дулааны хангамжийн зориулалтаар цахилгаан эрчим хүч ашиглахад гарах зардлыг бууруулах зорилгоор үнэ тарифт хөнгөлөлт үзүүлэх, эрчим хүч үйлдвэрлэгчид татаас олгох, хийн эх үүсвэрийн дулааны хангамжийн техник төхөөрөмжийн импортод татварын дэмжлэг үзүүлэх.
   b) Улаанбаатарын нийтийн тээврийн ихэнхи зорчигчийг зөөх хүчин чадал бүхий газар доогуурх метро маягийн болон ил, цуваа хэлбэрийн цахилгаан тээврийн сүлжээ байгуулах.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

c) Автомашины хий, биоэтанол, биодизель түлшний **хэрэглээг** дэмжих. Хийн хөдөлгүүртэй автомашины импортын гаалийн татварыг чөлөөлөх (одоо цахилгаан хөдөлгүүртэй бол чөөлөлөгддөг). Хийн болон цахилгаан хөдөлгүүртэй автомашины жилийн татварын хэмжээг тодорхой хувиар хөнгөлөх, дизель хөдөлгүүртэй бол тодорхой хувиар нэмэгдүүлэх боломжтой.

d) Эрчим хүчний 5 дахь эх үүсвэрийг барихдаа экологид ээлтэй Атомын цахилгаан станцын хувилбарыг судлах.

4. Төрийн дэмжлэгийг татварын хөнгөлөлт, татаас хэлбэрээр үзүүлэх. Төрийн шууд санхүүжилтийн хөрөнгө оруулалтаас аль болох зайлсхийх нь зүйтэй. Төрийн дэмжлэг шууд хувийн бизнесийг биш, харин нийтийн хэрэглээг дэмжихэд чиглэсэн байвал зохино.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН